MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

тухай хууль"-ийн дагуу нэг хувьцаа эзэмшигчтэй компанийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч нь өөрөө хэрэгжүүлэх зохицуулалттай тул Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг эрх олгогдсоны дагуу Сангийн яам хэрэгжүүлж буй бөгөөд Сангийн яам нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", "Компанийн тухай хууль" болон Компанийн дүрэмд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг болно.

1.5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ТАНИЛЦУУЛГА

1.5.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 6. Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний танилцуулга

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
Солонгын Тулга 2021 оноос эхлэн Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга *Боловсрол:* 2017-2019: Төрийн удирдлага, магистр, Корнелийн Их сургууль, Америкийн Нэгдсэн Улс 2007-2011: Олон улсын хуульч, Дипломатч, бакалавр, Гадаад Харилцааны Их сургууль, Бүгд Найрамдах Хятад Ард Улс *Ажлын туршлага:* 2013-2021: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт Мэргэжилтэн, Ахлах мэргэжилтэн, Шинжээч 2011-2013: Сангийн яамны Зээл тусламжийн бодлого, хамтын ажиллагааны газарт Мэргэжилтэн
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд
Даваагийн Баянзул 2001 оноос одоог хүртэл Монголбанкны Ахлах эдийн засагч, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал, Эрсдэлийн удирдлагын газрын албаны захирал *Боловсрол:* 2005-2006: Олон улсын хөгжлийн эдийн засаг, магистр, Австралийн Үндэсний Их сургууль, Австрали Улс 1995-1999: Банк санхүүч, Банкны эдийн засагч, бакалавр, СЭЗДС, Монгол Улс *Ажлын туршлага:* 2001 онд: Монголбанкны Ахлах эдийн засагч, 1999-2001: "Анод Банк" ХХК-ийн Эдийн засагч

ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ТҮЦК" ХХК
InvesCore
САРИЛ
6317839
1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Доржийн Энхбаатар

2020 оноос эхлэн Санхүүгийн Зохицуулах Хорооны Захиргаа удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Боловсрол:

2006: Бизнесийн удирдлага, магистр, Латробэ Их сургууль, Австрали Улс

1984-1989: Түүхч, бакалавр, Эрхүүгийн Их сургууль, Оросын Холбооны Улс

Ажлын туршлага:

2000-2016: "Зотол Групп" ХХК-ийн Ерөнхий захирал

1994-2000: "Зотол Уул Трейд" ХХК-ийн Ерөнхий захирал

1990-1993: Лениний музейд Зохион байгуулагч

1989-1990: Сүхбаатар аймгийн Намын хорооны зохион байгуулагч

Мижиддоржийн Санжаадорж

2022 оноос эхлэн Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Боловсрол:

2009-2011: Төрийн удирдлага, магистр, Стейр Их сургууль, Америкийн Нэгдсэн Улс

2003-2007: Менежмент, Бизнесийн удирдлага, бакалавр, МУИС-ийн Эдийн Засгийн сургууль, Монгол Улс

Ажлын туршлага:

2018-2022: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга

2013-2018: Сангийн яамны Гэрээт ажилтан, Мэргэжилтэн

2007-2009: "Моннис" ХХК-ийн Төслийн менежер

Лувсаншаравын Наранчимэг

2018 оноос эхлэн Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр тооцооны хэлтсийн дарга

Боловсрол:

2018-2020: Эдийн засгийн ухаан, магистр, Сайтамагийн Их сургууль, Япон Улс

2010-2012: Англи хэлний орчуулагч, бакалавр, Хүмүүнлэгийн Ухааны Их сургууль, Монгол Улс

2001-2005: Нягтлан бодох бүртгэл, бакалавр, СЭЗДС, Монгол Улс

Ажлын туршлага:

2013-2018: Сангийн яамны Төрийн сангийн газрын Ахлах мэргэжилтэн

2005-2013: Сангийн яамны Төрийн сангийн газрын Мэргэжилтэн

Чулуунбаатарын Дондогмаа

2021 оноос эхлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Засгийн газрын Ахлах референт

Боловсрол:

2020-2022: Хууль зүй, магистр, ХУИС-ийн харьяа Билиг Их сургууль, Монгол Улс

1998-2003: Эрх зүйч, бакалавр, МУИС-ийн Хууль Зүйн сургууль, Монгол Улс

Ажлын туршлага:

2021: Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд Ахлах референт

2015-2021: Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Засгийн газрын референт, Засгийн газрын ахлах референт

2008-2015: Хууль зүй дотоод хэргийн яаманд Мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн

2004-2008: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт Хяналт шалгалтын байцаагч

2003-2004: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт Оператор-бичээч

MONGOLIAN STOCK EXCHANGE

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020698 2011006
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд

Аюушсүрэнгийн Батпүрэв

2021 оноос эхлэн "Ашит Ассет Менежмент" ХХК-ийн Гүйцэтгэх захирал

Боловсрол:

2012-2013: Эдийн засаг, магистр, Сиднейн Их сургууль, Австрали Улс

1999-2004: Бизнесийн удирдлага, бакалавр, СЭЗДС, Монгол Улс

Ажлын туршлага:

2018-2021: "Скайтел Групп" ХХК-ийн Стратеги төлөвлөлтийн албаны захирал

2017-2018: "Петровис Групп" Маркетинг эрхэлсэн захирал

2014-2016: Санхүүгийн Зохицуулах Хороонд Газрын захирал

2013-2014: Гадаад харилцааны яамд Сайдын зөвлөх

2010-2012: "Юнител" ХХК-ийн Хэлтсийн менежер

Рэнцэндоржийн Гандиймаа

2002 оноос Монголын Үндэсний Радио Олон Нийтийн Телевиз (цаашид "МҮОНРТ" гэх)-ийн Эдийн засгийн сэтгүүлч, Монголын мэдээ сувгийн Гүйцэтгэх захирал

Боловсрол:

2007-2011: Сэтгүүлзүй, магистр, Бээжингийн Их сургууль, Бүгд Найрамдах Хятад Ард Улс

2000-2001: Бизнесийн менежер, магистр, Удирдлагын Академи, Монгол Улс

1995-2000: бакалавр, Гази Их сургууль, Турк Улс

Ажлын туршлага:

2002 онд: МҮОНРТ-ийн Эдийн засгийн сэтгүүлч,

Амаржаргалын Анар

2020 оноос эхлэн СЭЗИС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн

Боловсрол:

2006-2010: Эдийн засгийн ухаан, бакалавр, Клородагийн Их сургууль, Америкийн Нэгдсэн Улс

Ажлын туршлага:

2017-2020: "Мик ОССК" ХХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал

2015-2016: "Амаржаргал Сан"-гийн Гүйцэтгэх захирал

2013-2015: "Скай Лакть" ХХК-ийн Үйл ажиллагаа эрхэлсэн захирал

2011-2013: "Хас Банк" ХХК-ийн Эрсдэлийн бодлогын мэргэжилтэн

Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга

Гантөмөрийн Мөнхзул

2022 оноос "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга

Боловсрол:

2008-2010: Бизнесийн удирдлага, магистр, Виржиниагийн Олон Улсын Их сургууль, Америкийн Нэгдсэн Улс

2004-2008: Бизнесийн удирдлага, бакалавр, МУИС, Монгол Улс

Ажлын туршлага:

2022 оноос эхлэн Дэлхийн Банкны Төслийн зөвлөх

2018-2022: Азийн Хөгжлийн Банканд Төслийн зөвлөх

2016-2017: Дэлхийн Банканд зөвлөх

2013-2016: Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын Гэрээт ажилтан

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

MONGOLIAN STOCK EXCHANGE

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
9020020699 3071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore Capital
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

1.5.2. Гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүн

Зураг 1. Үнэт цаас гаргагчийн удирдлагын багийн танилцуулга



Хангайн **АЛТАЙ**

Гүйцэтгэх захирал

2016 оноос "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал

Боловсрол:

2018-2020: Бизнесийн удирдлага, магистр, СЭЗДС, Монгол Улс

1999-2004: Эрх зүйч, бакалавр, МУИС-ийн Хууль Зүйн сургууль, Монгол Улс

Ажлын туршлага:

2015-2016: "Би Би Энержи" ХХК-ийн Монгол дахь төлөөлөгч

2011-2014: "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал

2010-2011: "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Тэргүүн дэд захирал

2010-2012: Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдын ажлын алба, Ерөнхий сайдын зөвлөх

2007-2010: Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайдын шадар туслах

2004-2007: "Бороо Гоулд" ХХК-ийн Засгийн газартай харилцах ажилтан



Нинжийн **ДӨЛ-ЭРДЭНЭ**

Захиргаа, санхүүгийн газрын захирал

2017 оноос "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Захиргаа, санхүүгийн газрын захирал

Боловсрол:

2012-2019: Бизнесийн удирдлага, докторант, Хятадын Соёлын Их сургууль, Тайвань

2002-2004: Бизнесийн удирдлага, магистр, СЭЗДС, Монгол Улс

1995-1999: Санхүүч-Эдийн засагч-Мэдээлэл зүйч мэргэжлээр Эдийн засгийн ухааны бакалавр, МУИС-ЭЗС, Монгол Улс

Ажлын туршлага:

2014-2016: "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга, Дотоод аудитор

2011-2012: "Эм Си Эс Холдинг" ХХК-ийн Санхүүгийн менежер

2002-2011: "Чингис Хаан Банк" ХХК-ийн Хөрөнгө зохицуулалт, эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал

2001-2002: "Тээвэр Хөгжлийн Банк" ХХК-ийн Эдийн засагч

1999-2001: МУИС-Лицей сургуулийн Компьютерын багш



Тамираагийн **ХАШ-ЭРДЭНЭ**

Бизнес хөгжлийн газрын захирал

2021 оноос "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Дэд захирал

2022 оноос "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Бизнес хөгжлийн газрын захирал

Боловсрол:

2019-2022: Эрх зүйн бакалавр, МУИС-ийн Хууль Зүйн сургууль, Монгол Улс

2001-2005: Олон улсын эдийн засгийн харилцаа, бакалавр, РУДН, Оросын Холбооны Улс

Ажлын туршлага:

2021: Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлого хариуцсан зөвлөх

2018-2021: Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн бодлогын зөвлөл ажлын албаны дарга

2017-2018: Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Ерөнхий сайдын Олон нийттэй харилцах бодлого хариуцсан орон тооны бус зөвлөх

2012-2017: "Монгол Медиа Корпораци" ХХК-ийн Газрын захирал



Анагийн **МӨНХБАЯСГАЛАН**

Хяналт, зохицуулалтын газрын захирал

2017 оноос "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Хяналт, зохицуулалтын газрын захирал

Боловсрол:

1994-1999: Бизнесийн удирдлага, бакалавр, Парисын 9 дүгээр Их сургууль, Франц Улс

1999-2000: Төрийн удирдлага, магистр, Парисын 9 дүгээр Их сургууль, Франц Улс

Ажлын туршлага:

2015-2017: Сангийн яамны Газрын дарга

2006-2015: "Худалдаа Хөгжлийн Банк" ХХК-ийн газрын захирал

2005-2006: Үйлдвэрлэл худалдааны яамны мэргэжилтэн

2004-2005: СЭЗДС-ийн Бизнес удирдлагын тэнхимийн Бизнесийн удирдлагын багш

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12



Ивановын **ЖАВХЛАН**

Үйл ажиллагааны газрын захирал

2020 оноос "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Үйл ажиллагааны газрын захирал

Боловсрол:

2016: Санхүүгийн удирдлага, магистр, Мельбурн Их сургууль, Австрали Улс

2005-2009: Олон улсын эдийн засгийн харилцаа, бакалавр, МУИС-ОУХС, Монгол Улс

Ажлын туршлага:

2017-2020: "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Зах зээлийн хөгжлийн албаны Ахлах мэргэжилтэн

2011-2015: "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Бүртгэлийн албаны мэргэжилтэн, Ахлах мэргэжилтэн



Саандар **АЛТАННАМАР**

Ерөнхий нягтлан бодогч

2019 оноос "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Ерөнхий нягтлан бодогч

Боловсрол:

1994-2000: Радио холбооны инженер, бакалавр, ШУТИС-ХМТС, Монгол Улс

2002-2005: Нягтлан бодогч, бакалавр, МБДС, Монгол Улс

Ажлын туршлага:

2018-2019: Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургуулийн Ерөнхий нягтлан бодогч

2017-2018: Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Ахлах нягтлан бодогч

2008-2017: Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нягтлан бодогч, Эдийн засагч

ХӨРӨНГИЙН БИРЖ
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020899 ДТД 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
САРИЙН
6317839 ДТД 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12

1.6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж баталгаажуулсан "Монголын Хөрөнгийн Бирж Төрийн Өмчит Хувьцаат Компанийн Дүрэм" (цаашид "Дүрэм" гэх)-ээр зохицуулагдсан засаглалын бүтэц зохион байгуулалтын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Аливаа компанийн дүрэмд тухайн компанийн засаглалын бүтэц, зохион байгуулалт, засаглалыг хэрэгжүүлэгчдийн бүрэн эрх, шийдвэрлэх асуудлын хүрээ хязгаартай холбогдсон суурь харилцааг зохицуулсан байдаг тул Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолын дагуу нэмэлт өөрчлөлт оруулж батлагдсан Дүрмийг үндэслэвэлкомпанийн засаглалын бүтэц зохион байгуулалтыг дараах байдлаар тогтоож өгсөн байна. Үүнд:

Хүснэгт 7. Үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц

Компанийн эрх барих дээд байгууллага	Хувьцаа эзэмшигчдийн хурал
Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага	Төлөөлөн удирдах зөвлөл
Гүйцэтгэх удирдлага	Гүйцэтгэх захирал

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Схем 1. Үнэт цаас гаргагчийн засаглалын тогтолцоо, Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

1.6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал

Үнэт цаас гаргагчийн Дүрэмд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд хурлын бүрэн эрхийг Монгол Улсын төрийг төлөөлж эрх олгогдсон төрийн захиргааны төв байгууллага буюу ерөнхий чиг үүргийн яам болох Сангийн яам хэрэгжүүлж байна. Сангийн яам нь Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн "Монголын Хөрөнгийн Биржийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 152 дугаар тогтоолоор эрх олгогдсоны дагуу "Компанийн тухай хууль"-д заасан Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэгчээр томилогдсон болно. Хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэгч нь "Компанийн тухай хууль"-ийн 62.1 дэх хэсэгт заасны дагуу зөвхөн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудал болон Үнэт цаас гаргагчийн Дүрэмд тусгайлан заагдсан асуудлуудыг шийдвэрлэж бүрэн эрхээ хэрэгжүүлж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй бөгөөд ээлжит хурлыг Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) санхүүгийн жил дууссанаас хойш 4 (дөрөв) сарын дотор зарлан хуралдуулдаг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг шаардлага гарсан тохиолдолд Үнэт цаас гаргагчийн ТУЗ зарлан хуралдуулж хууль тогтоомж, Үнэт цаас гаргагчийн Дүрэмд шийдвэрлэхээр заасан асуудлуудыг шийдвэрлэдэг.

1.6.2. Төлөөлөн удирдах зөвлөл

Үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн жишгийг дагаж мөрдөх, засаглалын тулгуур зарчмуудыг үйл ажиллагаандаа хэвшүүлэх, компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, хэвийн тогтвортой, мэргэшсэн байдлаар удирдан зохион байгуулах зорилгоор ТУЗ, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулсан болно. Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт эрх барих байгууллага нь ТУЗ байна. Үнэт цаас гаргагчийн Дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгож, чөлөөлөх бөгөөд ТУЗ нь 9 (ес) гишүүнтэй байх ба тэдгээрийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь хараат бус гишүүн байхаар тусгагдсан.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь "Компанийн тухай хууль"-ийн 75, 76 дугаар зүйлүүдэд заагдсан бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах, ТУЗ-ийн үйл ажиллагааны болон Үнэт цаас гаргагчийн засаглалын дотоод журмыг батлах, Үнэт цаас гаргагчийн үндсэн чиглэлд хамаарах журам, заавар батлах, брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийг гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах, Үнэт цаас гаргагчийн шинээр худалдаж авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах, компанийн өрийн

хэрэгсэл гаргах гэх мэт Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулдаг хөрөнгийн зах зээлийн салбарын онцлог байдлыг харгалзан тусгайлсан зохицуулалтуудыг тусгасан.

Үнэт цаас гаргагч нь ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах "Компанийн тухай хууль"-д заасан шаардлагаас гадна тусгайлсан бүрэн эрхийг ТУЗ-ийн хараат бус гишүүнд олгосон зохицуулалтыг Дүрэмдээ тусгаж өгснөөрөө онцлогтой юм. Тухайлбал:

- ✓ ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Үнэт цаас гаргагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;

- ✓ Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, Хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх;

- ✓ Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт хийх талаар санал боловсруулах;

- ✓ Гүйцэтгэх удирдлагын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулахад хяналт тавих.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэмэлтээр бүрэн эрх олгосон явдал нь Үнэт цаас гаргагчийн засаглалын тогтолцоо тэр дундаа ТУЗ-ийн үйл ажиллагаанд хараат бус гишүүний үүрэг оролцоо, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шийдвэр гаргалтын нөлөө, өргөн хүрээтэй байгааг илтгэж байна. ТУЗ-ийн хараат бус гишүүний ТУЗ-д нөлөөлөх нөлөөлөл, компанийн үйл ажиллагааны шийдвэр гаргалтад оролцох оролцоо өндөр байхын хэрээр ТУЗ-ийн үйл ажиллагаа цаашлаад компанийн засаглалын тогтолцоонд эерэг нөлөөг бодитоор үзүүлдэг билээ.

1.6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

ТУЗ-ийн дэргэд дор дурдсан хороод байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Аудитын хороо;

2. Цалин урамшууллын хороо;

3. Нэр дэвшүүлэх хороо.

Хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрэлдэх бөгөөд түүний 2/3 (гуравны хоёр) нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байхаар зохицуулагдсан нь "Компанийн засаглалын кодекс"-ийн зарчимтай нийцэж буй юм. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тус тусын хариуцах асуудал, чиг үүргийн хүрээнд дүгнэлт гаргаж, ТУЗ-ийн хуралд танилцуулах, шийдвэр гаргуулах үүрэгтэй зохион байгуулалтын бүтцүүд юм.

1. Аудитын хороо

Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд Аудитын хороо нь дор дурдсан чиглэлээр дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна. Үүнд:

- ✓ Үнэт цаас гаргагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
- ✓ Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, ТУЗ-д танилцуулах;
- ✓ Аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
- ✓ Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- ✓ Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
- ✓ Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

2. Нэр дэвшүүлэх хороо

- ✓ ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

СЭХ
6022 сар 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

- ✓ ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүдийн хувьд шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- ✓ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- ✓ ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх;
- ✓ Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- ✓ ТУЗ-ийн гишүүдээс бусад Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
- ✓ Бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 (гурав) жилийн хугацаанд аливаа хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүн байх эрхгүй этгээдийн нэрийг дэвшүүлэхээс татгалзах.

3. *Цалин урамшууллын хороо*

- ✓ ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- ✓ ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтнуудад олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
- ✓ Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

1.6.4. Гүйцэтгэх удирдлага

Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх удирдлагыг "Компанийн тухай хууль" болон Дүрэмд заасны дагуу хувь хүн хэрэгжүүлж буй бөгөөд тус этгээд нь Гүйцэтгэх захирал байна. Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирлаар Хангай овогтой Алтай томилогдон ажиллаж байна. Гүйцэтгэх захирал Х.Алтай нь 2016 оноос эхлэн Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн тогтоолын дагуу томилогдон бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Х.Алтай нь Монгол Улсын Засгийн газар болон олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудад олон жил ажиллаж байсан туршлагатай ба өдгөө 6 (зургаа) дахь жилдээ Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071090
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн хувьд Гүйцэтгэх захирлаар ажиллах этгээдэд тусгайлан шалгуурыг тавьж Дүрэмдээ тусгасан болно. Үүнд:

- ✓ Менежментийн ур чадвартай, энэ чиглэлээр дээд боловсролтой, олон улсын байгууллагуудтай харилцаж байсан, удирдах ажлыг 2 (хоёр)-оос доошгүй жил хашиж удирдлагын зохих дадлага туршлага хуримтлуулсан, удирдлагын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг байх;
- ✓ Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;
- ✓ Ял шийтгэлгүй байх;
- ✓ Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

Дүрэмд заасан Хувьцаа эзэмшигч, ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороод болон Гүйцэтгэх захирлын бүрэн эрх, тэдгээртэй холбогдсон бусад харилцааг зохицуулсан зохицуулалтууд нь Монгол Улсын "Компанийн тухай хууль", "Компанийн засаглалын кодекс" зэрэг баримт бичигт хэрхэн нийцэж буйг хуулийн дүгнэлттэй танилцаж дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.

1.6.5. Компанийн хяналтын тогтолцоо

Компанийн засаглалын хэвийн тогтвортой байдал, компанийн үйл ажиллагааг үр ашигтай, эрсдэлгүй байлгах зорилгын хүрээнд Хувьцаа эзэмшигч, ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороод зэрэг эрх бүхий байгууллагууд нь хууль тогтоомж болон Дүрэмд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн дотоод үйл ажиллагаа, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг. Тус эрх бүхий байгууллагуудаас гадна компанийн хяналтын тогтолцооны хамрах хүрээ, давтамж, хяналтын чиглэлээс хамааран тусгайлсан эрх бүхий этгээдүүд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд дотоодын болон хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. *Өмчлөгчийн хяналт*

Өмчлөгчийн хяналтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төрийн эрх бүхий этгээд болон Үнэт цаас гаргагчийн Дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо хэрэгжүүлдэг. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байхаар Дүрэмд тусгагдсан нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд тавигдах хяналтыг хэрэгжүүлэх механизмд чухал нөлөөтэй арга хэлбэр юм. Аудитын хороо нь Үнэт цаас гаргагчийн Дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, Үнэт цаас гаргагчийн удирдлагын

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган үйл ажиллагаагаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнадаг.

2. Дотоод хяналт

ТУЗ-өөс баталсан Үнэт цаас гаргагчийн дотоод бүтэц зохион байгуулалтын баримт бичигт заасны дагуу ТУЗ-ийн дэргэд Дотоод аудитын албыг зохион байгуулсан байх ба ТУЗ-ийн томилсон Дотоод аудитор нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж, санхүүгийн гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, Дүрэм, журам, Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-ийн хурлын шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, шийдвэрийн биелэлтийг хангуулж ажилладаг болно. Дотоод аудитор нь үйл ажиллагааны шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, Үнэт цаас гаргагчийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжөөр Гүйцэтгэх захирлыг хангах, ТУЗ-д шаардлагатай мэдээллийг мэдээлэх үүргийг хүлээсэн эрх бүхий этгээд байна.

Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоо нь Гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмаар зохицуулагддаг ба газар, алба, бусад зохион байгуулалтын бүтэц бүр ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу шат дараалсан дотоод хяналтыг өдөр тутамдаа хэрэгжүүлдэг. Үндсэн үйл ажиллагааны хяналт нь Гүйцэтгэх захирлын тушаалаар 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр батлагдсан Үнэт цаас гаргагчийн дотоод хяналт шалгалтын журмаар зохицуулагддаг. Дотоод хяналтын ажилтан, холбогдох мэргэжилтэнд Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийн дагуу ажиллах чадвартай, зохион байгуулалт, санхүү бүртгэл болон эрх зүйн мэдлэг туршлагатай ажилтан байх шалгуур тавигдсан байдаг.

3. Хөндлөнгийн хяналт

Үнэт цаас гаргагчийн хөндлөнгийн хяналтыг мэргэшсэн аудитын байгууллага хэрэгжүүлдэг. Аудитын байгууллагыг ТУЗ сонгож холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөндлөнгийн хяналтыг гүйцэтгүүлдэг.

Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Сангийн яам болон ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороод нь хууль тогтоомж, Дүрэм, журмаар олгогдсон тус тусын бүрэн эрхийн хүрээнд засаглал, удирдлагын хяналтыг хэрэгжүүлдэг бол дотоод болон хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэгчдийн үйл ажиллагаа нь Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг хамарч үйл ажиллагааны хэвийн тогтвортой байдал, хууль эрх зүй, санхүүгийн хувьд үүсэж болох аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, хяналтын чиг үүргийг гүйцэтгэж байдгаараа онцлогтой юм.

1.6.6. "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилт

2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны 145 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс" нь компанийн засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, жишиг туршлагуудыг нэвтрүүлэх, компани болоод хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, компанийн үр ашигт, урт хугацааны хэвийн тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд компанийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлэх механизм, оролцогч эрх бүхий этгээдүүдийн зохион байгуулалт, тэдгээрийн зохистой харилцаатай холбогдсон асуудлуудыг зохицуулсан баримт бичиг юм. Компанийн засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн жишиг зарчмууд, сайн туршлагуудыг нэвтрүүлснээр тухайн компанийн үнэлгээ, нэр хүнд өсөх, санхүүгийн хувьд үр ашигтай ажиллах, засаглалын хувьд урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах зэрэг компанийн соёлын төлөвшил, санхүү, хууль эрх зүйн асуудлуудад чухал ач холбогдол бүхий нөлөө үзүүлдэг.

Үнэт цаас гаргагч нь компанийн хэлбэрийн хувьд хувьцаат компани бөгөөд Үнэт цаас гаргагч нь "Компанийн засаглалын кодекс"-т заагдсан зарчим хэм хэмжээг үйл ажиллагаандаа хэвшүүлж, сайн засаглалын хүлээн зөвшөөрөгдсөн жишгийг дагаж мөрдөх талаар анхаарч үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний нэг томоохон хүчин зүйл нь Үнэт цаас гаргагчийн 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар гаргасан "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайлан юм. Тус тайлангаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны хүрээнд "Компанийн засаглалын кодекс"-т тусгагдсан 9 (ес) зарчим, 36 (гучин зургаа) асуулгууд хэрхэн хэрэгжиж буйг үнэлэн гаргасан бөгөөд тайлангийн үр дүнд Үнэт цаас гаргагч нь "Компанийн засаглалын кодекс" дахь зохицуулалтуудын хэрэгжилтийг 92 хувийн биелэлттэйгээр хангасан байна. Энэ нь Монголын Хөрөнгийн Биржийн 3 дугаар ангилалд багтдаг */Үнэт цаасыг нийтэд нээлттэй санал болгон арилжаалахаас өмнөх ангилал/* компанийн хувьд "Компанийн засаглалын кодекс"-ийн зарчмууд хэрхэн хэрэгжиж буйг харуулсан томоохон үзүүлэлт юм. Үнэт цаас гаргагч нь нэмэлт хувьцаагаа нийтэд санал болгон гаргаж Монголын Хөрөнгийн Биржийн 1 дүгээр ангилалд бүртгэгдсэн тохиолдолд "Компанийн засаглалын кодекс"-ийн зарчмуудыг бүрэн дүүрэн дагаж мөрдөх тусгайлсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

1.7. ЗАСАГЛАЛЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ

Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа нийтэд санал болгон нэмж гаргаж, Санхүүгийн Зохицуулах Хорооноос үнэт цаасыг бүртгэх зөвшөөрөл гарч, хувьцаагаа амжилттай арилжаалсны дараа хувьцаа эзэмшигчдийн анхны хурлаар батлуулахаар төлөвлөн "Монголын Хөрөнгийн Бирж нээлттэй хувьцаат компанийн дүрмийн төсөл"

(цаашид "Дүрмийн төсөл" гэх)-ийг боловсруулсан ба тус Дүрмийн төслийг Хувьцаа эзэмшигчдийн анхны хурлаар хэлэлцүүлэхийг зөвшөөрч Үнэт цаас гаргагчийн ТУЗ 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 35 тоот тогтоолоор сайшаан баталгаажуулсан. Дүрмийн төслийг Үнэт цаас гаргагчид хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлж буй Хуулийн зөвлөх хянасан. Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн анхны хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн Үнэт цаас гаргагчийн шинэчилсэн Дүрмийн төсөл нь "Компанийн тухай хууль", "Компанийн засаглалын кодекс"-ийн жишиг зарчмууд, нээлттэй хувьцаат компанийн дүрэмд заавал тусгах зохицуулалтууд, нэмж хувьцаагаа нийтэд нээлттэй санал болгон гаргасантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг нэмэгдүүлэх, хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах, компанийн хяналтын механизмыг сайжруулахтай холбогдсон зохицуулалтуудыг тусгахыг зорилтоо болгосон баримт бичиг юм. Аливаа компанийн дүрэм нь тухайн компанийн үүсгэн байгуулагдах үндсэн баримт бичигт тооцогддог бөгөөд дүрмээр компанийн засаглалыг хэрэгжүүлэгчид, эрх бүхий байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, тэдгээрийн хоорондын харилцаа, бүрэн эрхтэй холбогдсон суурь зохицуулалтуудыг тусгадаг голлох баримт бичигт тооцогддог тул Үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авахаар төлөвлөж буй хөрөнгө оруулагчийг хувьцаа эзэмшигчийн компанийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, шийдвэр гаргалтад нөлөөлөх боломж бололцоо, Хувьцаа эзэмшигчийн эрхийн хамгаалалтыг хэрхэн хангаж хамгаалахаар зохицуулагдсан талаар Дүрмийн төсөлтэй сайтар танилцаж мэдээлэл авахыг зөвлөж байна.

Нийтэд хувьцаагаа нээлттэй санал болгон гаргахын үндсэн ач холбогдлуудын нэг нь компанийн хувьцааг эзэмшиж буй олон нийт нь эзэмшиж буй хувьцааны саналын эрхээр дамжуулан тухайн компанийн үйл ажиллагаа, эрх бүхий албан тушаалтнуудад хяналт тавих, түүний үр дүнд компанийн хяналтын механизм сайжрах, үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод, засаглалын хувьд зохистой, урт хугацаанд тогтвортой оршин тогтнох суурь нөхцөл бүрдэх зэрэг томоохон ач холбогдолтой юм. Иймд Үнэт цаас гаргагчийн нэмж хувьцаагаа нээлттэй санал болгон гаргасны дараах хувьцаа эзэмшигчдийн анхны хурлаар хэлэлцүүлж батлахаар төлөвлөөд буй Дүрмийн төсөл дэх Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, шийдвэрлэх асуудал, хувьцаа эзэмшигчдийн эрх, ашгийг хамгаалах хамгаалалт, хяналтын тогтолцоог хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбогдсон онцлох зохицуулалтуудын талаар дараах байдлаар тусгав. Үүнд:

1.7.1. Компанийн болон Хувьцаа эзэмшигчийн хүлээх хариуцлага

- ✓ Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ;

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

- ✓ Компани нь Хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй;
- ✓ Компанийн хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр эрсдэл, хариуцлага хүлээнэ.

1.7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний бүрэн эрх

Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. Ээлжит хурлыг ТУЗ нь "Компанийн тухай хууль"-д заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 (дөрөв) сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна. Үнэт цаас гаргагчийн шинэчлэн батлагдах Дүрмийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлуудыг дор дурдсаны дагуу байхаар тусгаж өгсөн байна.

1. *Компанийн үүсгэн байгуулах үндсэн баримт бичигтэй холбогдсон асуудлын хүрээнд шийдвэрлэх асуудал*

- ✓ Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- ✓ Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

2. *Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон асуудлын хүрээнд шийдвэрлэх асуудал*

- ✓ Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах;
- ✓ Компанийн хэлбэрийг өөрчлөх;
- ✓ Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох.

3. *ТУЗ-тэй холбогдсон асуудлын хүрээнд шийдвэрлэх асуудал*

- ✓ ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- ✓ ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд "Компанийн тухай хууль"-ийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;
- ✓ ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд "Компанийн тухай хууль"-ийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭЛ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭЛ-02

- ✓ Компанийн Дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- ✓ ТУЗ-ийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

4. *Компанийн хувьцаа, бусад үнэт цаастай холбогдсон асуудлын хүрээнд шийдвэрлэх асуудал*

- ✓ "Компанийн тухай хууль"-ийн 38 дугаар зүйлд заасны дагуу Хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;
- ✓ Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
- ✓ Компанийн хувьцааг хуваах буюу нэгтгэх;
- ✓ Хуульд заасны дагуу Компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;
- ✓ Хувьцаагаа үнэт цаасны хадгаламжийн байгууллагын бүртгэлээс хасуулах асуудал;
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад.

5. *Компанийн үйл ажиллагааатай холбогдсон асуудлын хүрээнд шийдвэрлэх асуудал*

- ✓ Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн "Компанийн тухай хууль"-ийн 96 дугаар зүйлд заасны дагуу гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Дүрмийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг саналын хуудсаар болон цахим хэлбэрээр явуулж болохоор заасан байна. Саналын хуудсаар санал авах эсэх асуудлыг ТУЗ шийдвэрлэх бөгөөд саналын хуудас ашиглан санал авах тохиолдолд саналын хуудсанд Хувьцаа эзэмшигч нь шийдвэр гаргахад шаардлагатай бүхий л мэдээллийг агуулсан байхаар зохицуулсан. Мөн тусгай программ, эсхүл мэдээллийн технологийн компанитай хамтарч цахимаар санал авах ажиллагааг зохион байгуулж болно. Энэ тохиолдолд саналыг цахимаар зохион байгуулахтай холбоотой мэдээллийн хэвийн найдвартай, аюулгүй байдлыг хангаж, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр, үнэн зөв илэрхийлэх боломжтой

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
20020699 2074196
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317639 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-03

программыг хариуцах этгээдтэй гэрээ байгуулж ажиллуулах боломжтой байхаар тусгасан.

1.7.3. Төлөөлөн удирдах зөвлөл, түүний бүрэн эрх

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байх бөгөөд ТУЗ нь нийт 9 (ес) гишүүнтэй, үүнээс 3 (гурав) хараат бус гишүүн байна. ТУЗ нь 1 (нэг) жилийн хугацаатайгаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх бөгөөд ТУЗ-ийг улируулан хэдэн ч удаа сонгож болохоор зохицуулсан. ТУЗ нь "Компанийн тухай хууль"-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх ба ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг ТУЗ батлан гаргана. ТУЗ нь улиралд 1 (нэг) удаа хуралдах бөгөөд Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх хорооны санал санаачилгаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно. ТУЗ өөрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой ТУЗ-ийн харьяа 4 (дөрөв) хороодтой, ТУЗ-ийн өдөр тутмын дотоод үйл ажиллагааг хариуцаж Хувьцаа эзэмшигчдийн хурал, Гүйцэтгэх удирдлагатай харилцах харилцааны уялдаа холбоог хангах үүрэгтэй ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай байна. Үнэт цаас гаргагчийн Дүрмийн төсөлд заасны дагуу ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, ТУЗ болон тэдгээртэй адилтгах албан тушаалтнууд нь эрх бүхий албан тушаалтнуудад хамаарч байна.

1.7.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

1. *Эрсдэл /Комплаенс/-ийн удирдлагын хороо*

ТУЗ-ийн дэргэд шинээр эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтэд нөлөө бүхий хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороо байгуулагдахаар төлөвлөгдсөн байна. Тус хороо нь дор дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын орчныг тодорхойлох;
- ✓ Компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг оновчтой удирдан чиглүүлэх;
- ✓ Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэл, эрсдэлийн түвшинд хяналт тавих.

2. *Аудитын хороо*

- ✓ Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх ба тус хороо нь Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071098
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

стандартад нийцүүлэх, дотоод хяналтын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

- ✓ Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;
- ✓ Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;
- ✓ Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;
- ✓ Компанийн Дүрэмд заасан болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

3. Нэр дэвшүүлэх хороо

- ✓ Компанийн залгамж холбооны бодлогыг боловсруулах, үйл ажиллагаандаа чанд мөрдөж, хэрэгжүүлэх;
- ✓ Компанийн ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
- ✓ ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд Дүрэм болон "Компанийн тухай хууль"-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- ✓ Компанийн залгамж холбооны бодлогын дагуу ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагад нэр дэвших боломжтой этгээдийн судалгаа хийх, нөөцөд бүртгэх, бэлтгэх, шаардлагатай бол сонгон шалгаруулалт хийх, Хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;
- ✓ ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
- ✓ Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;
- ✓ ТУЗ-ийн гишүүнээс бусад Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд Гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

- ✓ "Компанийн тухай хууль"-ийн 59.5 дахь хэсэгт заасан үндэслэлээр ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 (гурав) жилийн хугацаанд тухайн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг ТУЗ-ийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах.

4. *Цалин урамшууллын хороо*

- ✓ Компанийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- ✓ ТУЗ болон Гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
- ✓ Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон Компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа, хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалттай холбогдсон суурь харилцааг шинэчлэн батлагдах Дүрмийн төсөлд зохицуулсан ба бусад нарийвчилсан харилцаатай холбоотой зохицуулалтуудыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу нарийвчлан зохицуулахаар тусгасан болно.

1.7.5. Гүйцэтгэх удирдлага

Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал нь "Компанийн тухай хууль", Компанийн Дүрэм, ТУЗ-тэй байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасан бүрэн эрхийн хүрээнд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана. Гүйцэтгэх захирал нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байхыг шаардах бөгөөд дор дурдсан нэмэлт шаардлага шалгуурыг Дүрмийн төсөлд тусгайлан зааж өгсөн байна.

- ✓ Банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, санхүүгийн салбарт 5 (тав)-аас доошгүй жил эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай;
- ✓ Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;
- ✓ Төрийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;
- ✓ Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;

✓ Хууль тогтоомж, гэрээнд заасан бусад шаардлага.

1.7.6. Дотоод хяналт

Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд ТУЗ өөрийн дэргэдэх Аудитын хороогоор дамжуулан дотоод хяналтыг хэрэгжүүлэх ба Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд дотоод хяналтыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооноос санал болгосноор Гүйцэтгэх захирлын томилсон Дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ. Дотоод хяналтын алба нь Компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тус алба нь Гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна. Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хуралдаанаар Дотоод хяналтын албаны мэдээлэл, шалгалтын дүнг улирал бүр хэлэлцэн, холбогдох арга хэмжээг авч байх ба Дотоод хяналтын албаны ажилтан нь Компанийн албан хаагчдын ажлын байранд хяналт шалгалт хийх зорилгоор хэдийд ч нэвтрэх эрхтэй байхаар зохицуулагдсан.

1.7.7. Хөндлөнгийн аудит

ТУЗ нь Компанийн санхүүгийн тайланг шалгаж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож ажиллуулна. Аудитын шалгалт нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн жилийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, эсвэл нийт хувьцааны 10 (арав)-аас дээш хувийг эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийж болохоор тус тус зохицуулсан байна. Аудитын компани болон түүний аудитор нь Үнэт цаас гаргагч болон түүний эрх бүхий албан тушаалтнуудтай аливаа байдлаар холбоо хамааралгүй, нэгдмэл сонирхолгүй этгээд байна.

1.8. БҮТЦИЙН ХОРОО, ГАЗАР, АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагч нь ТУЗ-ийн 2022 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 12 дугаартай “Компанийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн батлах тухай” тогтоолоор батлагдсан бүтэц бүрэлдэхүүний дагуу зохион байгуулагдаж үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд тодорхой асуудлыг харьяалан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ТУЗ-ийн дэргэдэх 1 (нэг) алба, Гүйцэтгэх захирлын дэргэдэх газар нэгжийн харьяаны бус үнэт цаасны бүртгэлийн асуудал хариуцсан 1 (нэг) хороо, хууль зүйн асуудал хариуцсан 1 (нэг) алба болон Гүйцэтгэх захирлын харьяаны 4 (дөрөв) газар, тэдгээрийн харьяа мэргэшсэн зохион байгуулалтын 10

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

(арав) албатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. ТУЗ болон Гүйцэтгэх захирлын харьяа газар болон албаны бүтэц зохион байгуулалт нь дор дурдсаны дагуу байна.

Схем 2. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Газар. *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны стратеги бодлого, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилго, зорилтын хүрээнд тодорхой чиглэлийн асуудлуудыг хуваарилагдсан ажил үүргийн хамрах хүрээ, хариуцах асуудал, оногдсон чиг үүргийн дагуу хариуцаж хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий үндсэн зохион байгуулалтын бүтэц юм.*

Алба. *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратеги бодлого, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилго, зорилтын хүрээнд тусгайлсан үйл ажиллагааг харьяалах асуудлын хүрээнд мэргэжлийн хүрээнд шийдвэрлэх, хэрэгжүүлэх, хариуцах чиг үүрэг бүхий зохион байгуулалтын харьяа мэргэшсэн бүтэц юм.*

1.8.1. Дотоод аудитын алба

Дотоод аудитын алба нь Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн харьяа бүтэц бөгөөд нийт 2 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж буй, Гүйцэтгэх захирлаас хараат бус бие даасан бүтэц юм. Тус алба нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны хэвийн тогтвортой байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн зохицуулалттай этгээдийн хувиар хүлээх үүрэг, хариуцлагын хэрэгжилт, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа хууль тогтоомж, дотоод дүрэм, журмын дагуу хэвийн явагдаж буй эсэхэд хяналт тавих, дүн

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2070096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02

шинжилгээ хийх, Гүйцэтгэх удирдлага, түүний харьяа дотоод бүтэц зохион байгуулалтын газар, албаны үйл ажиллагаанд хяналт тавих, түүний үр дүнд гарсан тайлан дүгнэлтийг ТУЗ-д танилцуулан, гарсан шийдвэрийг холбогдох этгээдэд заавар, зөвлөмж хэлбэрээр хүргүүлэх, түүнтэй холбогдсон шаардлагатай арга хэмжээг авах чиг үүрэг бүхий алба юм. Гүйцэтгэх захирлын зүгээс газар, алба, нэгжийн ажлын байр тус бүрээр шат дараалсан хяналтын тогтолцоотой үндсэн үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлэх Дотоод хяналт, шалгалтын журмыг баталж, энэхүү хяналтын үйл ажиллагаа, түүний үр дүнг Гүйцэтгэх захирлын дэргэдэх Захирлуудын зөвлөлийн хуралдаанаар тухай бүрд хэлэлцэн, холбогдох арга хэмжээг авч ажиллахаар зохицуулсан байдаг.

1.8.2. Үнэт цаасны бүртгэлийн хороо

Үнэт цаасны бүртгэлийн хороо нь Гүйцэтгэх захирлын харьяа байнгын ажиллагаатай бүтэц бөгөөд Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан үнэт цаас гаргаж буй үнэт цаас гаргагчдын үнэт цаасыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу бүртгэхтэй холбогдуулан бүрдүүлбэрт хяналт тавих, бүрдүүлбэрийн шаардлага хангуулах, үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад санал болгон арилжаалахтай холбоотой магадлан шалгалт дүн шинжилгээ хийх, үнэт цаасны бүртгэлтэй холбогдсон мэдээлэл, дүгнэлтийг гарган эрх бүхий этгээдэд танилцуулж шийдвэрлүүлэх эрх бүхий бүтэц юм.

1.8.3. Хуулийн алба

Хуулийн алба нь Гүйцэтгэх захирлын харьяа бүтэц бөгөөд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд дагаж мөрдөгдөж буй хууль тогтоомж, дотоод дүрэм журмын хэрэгжилт, нийцлийг хангах, төрийн эрх бүхий байгууллагуудаас батлан гаргасан аливаа шийдвэрийн биелэлтийг хариуцах, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хууль эрх зүйн хяналтыг хэрэгжүүлэх, аливаа хууль эрх зүйн холбогдолтой баримт бичгүүдийг боловсруулах, хянах, хэрэгжилтэд хяналт тавих, хууль зүйн заавар зөвлөмжөөр ажилтнуудыг хангах болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хууль эрх зүйн хувьд үүсэж болох аливаа эрсдэлийг тооцох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилладаг алба юм.

1.8.4. Захиргаа, Санхүүгийн газар

Захиргаа, Санхүүгийн газар нь Захиргааны болон Санхүүгийн гэсэн 2 (хоёр) харьяа албатайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тус газар нь компанийн санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлтэй холбогдсон бүхий л үйл ажиллагаа, хүний нөөц, архив, бичиг хэрэг болон Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хариуцах зохион байгуулалтын бүтэц юм.

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

1. Санхүүгийн алба

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн зорилт, төлөвлөгөө, төсвийг тодорхойлон боловсруулах, гүйцэтгэлийг хянах, үйл ажиллагаанд баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх, санхүү, аж ахуйн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн асуудалд хяналт тавих, тэдгээрийг жишиг стандартын дагуу хөтлөх, санхүүгийн гүйлгээнүүд буюу орлого, зарлагын бүртгэл хийх, хяналт тавих, хөрөнгө, хангамжийн ашиглалт, зарцуулалт, мөнгөн хөрөнгийн урсгалыг удирдах, хянах, санхүүгийн тайлан, холбогдох тодруулга мэдээллүүдийг боловсруулж тайлагнах, татварын тайлан, бүртгэл, нийгмийн даатгал, бусад тооцоонуудыг бэлтгэн боловсруулж холбогдох этгээдэд тайлагнах, Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн үйлчилгээ, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцоолж эрх бүхий этгээдэд тайлагнах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

2. Захиргааны алба

Үнэт цаас гаргагчийн урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд хүний нөөцийн нэгдсэн удирдлага, бодлого, стратеги, менежмент, ажилтнуудын сургалт хөгжлийг дэмжих, сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих, ажилтнуудын хөдөлмөр эрхлэлтийн харилцааны хэвийн байдал, хөдөлмөрлөх таатай нөхцөлийг бүрдүүлж, эрх ашгийг хамгаалах, бусад газар харьяа албуудын хэвийн тасралтгүй үйл ажиллагаа явуулахтай холбогдсон асуудалд дэмжлэг туслалцаа үзүүлэх болон байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад чиглэсэн захиргааны болон үйлчилгээний асуудлуудыг хариуцдаг алба юм.

1.8.5. Үйл ажиллагааны газар

Үйл ажиллагааны газар нь Арилжааны болон Мэдээлэл, технологийн гэсэн 2 (хоёр) харьяа албатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагааны газар нь Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа болох арилжааны үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд тогтоосон горим журмын дагуу зохион байгуулах, түүнд шаардлагатай программ, системийн хэвийн, аюулгүй, найдвартай байдлыг хангах асуудлыг хариуцдаг зохион байгуулалтын бүтэц юм.

1. Арилжааны алба

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын хувьд үндсэн үйл ажиллагаа болох үнэт цаасны арилжааг хэвийн тогтвортой, тасралтгүй, ил тод, шударгаар зохион байгуулах, арилжааны үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг тооцох, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон асуудлуудыг хариуцдаг алба юм.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2. Мэдээлэл технологийн алба

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын хувьд энэхүү алба нь үнэт цаасны зах зээл дэх санхүүгийн хэрэгслүүд системээр дамжин арилжаалагдахад шаардлагатай зохион байгуулалтыг хийх, арилжаа явагдахад шаардлагатай дэд бүтэц, программ, хангамжийн найдвартай ажиллагаа, шаардлагатай нэмэлт хөгжүүлэлтийг хийх, үнэт цаасны арилжаа хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлэхэд хяналт тавьж ажилладаг.

1.8.6. Бизнес, Хөгжлийн газар

Бизнес, Хөгжлийн газар нь Зах зээлийн хөгжлийн алба болон Маркетинг, олон нийттэй харилцах гэсэн 2 (хоёр) харьяа албатайгаар үйл ажиллагаа явуулж байна. Тус газар нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын төлөв байдал, олон улсын чиг хандлагад тулгуурлан Үнэт цаас гаргагчийн стратеги, бизнес төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажилладаг зохион байгуулалтын бүтэц юм.

1. Зах зээлийн хөгжлийн алба

Үнэт цаасны зах зээлийн салбарын хөгжлийн чиг хандлага, цаашдын төлөв байдлыг шинжлэн судалж Үнэт цаас гаргагчийн урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөө, стратеги бодлого чиглэлийг тодорхойлох, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэлт, түүнд шаардлагатай судалгаа шинжилгээг гүйцэтгэж дүн шинжилгээ хийх, Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны бодлого чиглэлийг үнэт цаасны салбарын цаашдын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан тодорхойлж боловсруулах, гадаадын болон дотоодын байгууллагуудтай харилцах стратегийн түншлэл, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилладаг алба юм.

2. Маркетинг олон нийттэй харилцах алба

Үнэт цаас гаргагчийн олон нийт, бусад эрх бүхий байгууллагуудтай харилцах ажиллагааг хариуцах, зах зээл дэх бүтээгдэхүүн үйлчилгээ болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах, түгээх, хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээлийн тухай мэдээ мэдээллээр хангах, олон нийтэд чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах, Монголын Хөрөнгийн Биржээс баримтлах маркетингийн бодлого чиглэлийг тодорхойлж, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж, хариуцах үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхэд бусад газар, албуудтай хамтран үйл ажиллагааныхаа уялдаа холбоог хангаж, тэдгээрт дэмжлэг үзүүлж ажилладаг алба юм.

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

1.8.7. Хяналт, зохицуулалтын газар

Хяналт, зохицуулалтын газар нь Хяналт шинжилгээ болон Бүртгэлийн гэсэн 2 (хоёр) харьяа албатайгаар үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа болох үнэт цаасны арилжаанд хяналт тавих, арилжаа хэвийн горимоор хийгдэхэд хяналт тавих, бүртгэлтэй гишүүнчлэлийн байгууллагууд, үнэт цаас гаргагч болон тэдгээрийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой асуудалд дүрэм, журмаар тогтоосон үүрэг хариуцлагыг биелүүлэхэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бүтэц юм.

1. Хяналт шинжилгээний алба

Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд арилжааны хэвийн, найдвартай, тасалдалгүй явагдахтай холбогдсон бүхий л асуудалд хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж, арилжаа явагдах процедурын үйл ажиллагаанд магадлан шалгалт, дүн шинжилгээ хийх, гишүүн үнэт цаасны компаниуд болон үнэт цаас гаргагчдын дүрэм, журам, Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээ хэлцлээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх асуудалд хяналт тавьж, үүргийн биелэлтийг хангуулахад тогтмол хяналтыг тавьж ажилладаг алба юм.

2. Бүртгэлийн алба

Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан үнэт цаасаа санал болгон гаргахаар бүртгүүлэх аливаа үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг холбогдох хууль тогтоомж, дотоод журмын дагуу бүртгэх, бүрдүүлбэрийн шаардлагыг хангуулах, хяналтыг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, журмын шаардлагуудыг хэрэгжүүлэх, бүртгэлтэй үнэт цаас гаргагчдын хууль тогтоомж, бүртгэлийн гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, шаардлага тавих, хяналтыг хэрэгжүүлэх, тайлан мэдээллийг эрх бүхий байгууллага, олон нийтэд хүргэх зэрэг үйл ажиллагааг хариуцаж ажилладаг алба юм.

MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317039 1119277128
УЛААНБААТАР ХОТ

MONGOLIAN
STOCK EXCHANGE

II

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

2.1. Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал

2.2. Үнэт цаас гаргагчийн ололт, амжилт

2.3. Хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагууд

2.4. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай

2.5. Үнэт цаас гаргагчийн санаачилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ

2.6. Үнэт цаас гаргагчийн тогтвортой хөгжлийн бодлого

2.7. Үнэт цаас гаргагчийн систем, түүний аюулгүй байдал

2.8. Тусгай зөвшөөрлийн тухай

2.9. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хэрэгжиж буй бодлого, журмууд

2.10. Үнэт цаас гаргагчийн хэлцлүүд

2.11. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлага

2.12. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээ

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

Схем 3. Үнэт цаас гаргагчийн Алсын хараа, Эрхэм зорилго, Стратегийн зорилго

АЛСЫН ХАРАА

Ил тод, нээлттэй зах зээлийн тогтолцоог бэхжүүлж, санхүүгийн төрөлжсөн хэрэгслүүд бүхий хөрвөх чадвар сайтай, бүс нутагт өрсөлдөхүйц Хөрөнгийн Бирж болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгөөр зуучлан хүргэж, үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжил дэвшилд бодит хувь нэмэр оруулна.

СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

- Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд бодит хувь нэмэр оруулна;
- Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсад таниулна;
- Дижитал шилжилтэд түүчээлнэ.

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

СЗХ
он сар өдөр
2022 12 12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

2.1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ

Схем 4. Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал

01 1991 — Үүсгэн байгуулагдав.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын "Өмч хувьчлалын хөтөлбөр"-ийн хүрээнд Засгийн газрын 22 дугаар тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан.

05 1991 — "Өмч хувьчлах тухай хууль"-ийн төсөл батлагдав.

Монгол Улсын Бага Хурал уг хуулийг баталснаар хувийн өмчтэй холбоотой иргэний эрхийг хүлээн зөвшөөрсөн.

02 1992 — Анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулав.

475 улсын үйлдвэрийн нийт 17.4 тэрбум төгрөгийн дүн бүхий хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулсан.

09 1994 — "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль" батлагдсанаар "Үнэт Цаасны Хороо" байгуулагдав.

Энэ нь өнөөгийн Санхүүгийн Зохицуулах Хороо байгуулагдах үндэс суурь болсон.

08 1995 — Хоёрдогч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулав.

Монголын Хөрөнгийн Биржийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулж байсан 29 брокерийн компаниудыг хувьчилж, хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьчлагдсан компаниудын хувьцааг хоёрдогч зах зээл дээр арилжаалсан.

08 1995 — ТОП-75 индексийг тооцоолж эхлэв.

Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 75 компанийн үнэт цаасыг сонгон, үнэт цаасны арилжааны өдөр бүрийн эцэст ТОП-75 индексийг тооцож эхлэв.

10 1996 — Анхны Засгийн газрын бондын арилжааг зохион байгуулав.

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар анхны бондыг гаргаснаар бондын арилжааны эхлэл тавигдсан.

10 1998 — "Евро Азийн Хөрөнгийн Биржүүдийн Холбоо"-нд гишүүнээр элсэв.

Олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах боломжууд нээгдсэн.

06 2001 — Анхны компанийн өрийн хэрэгслийг бүртгэж, арилжааг зохион байгуулав.

"Барилга Корпораци" ХХК-ийн "Шинэ зуун - 210" нэртэй 210,000 ширхэг компанийн бондыг арилжаалсан.

2002 — "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль" шинэчлэгдэн батлагдав.

Тус шинэчлэлээр хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг тодотгон тодорхойлж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн дараагийн шат эхлэв.

12 2002 — Анхны олон улсын хамтын ажиллагааг эхлүүлэв.

Тайваний Хөрөнгийн Биржтэй хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.

01 2003 — ТОП-20 индексийг тооцоолж эхлэв.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн гол үзүүлэлтүүдийг Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журмын дагуу тооцож эхлэв.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ

Үргэлжлэлийг дараагийн хуудсанд үзнэ үү
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

03 2003 Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв байгуулагдав.

Монгол Улсын Засгийн газрын 72 дугаар тогтоол, Төрийн Өмчийн Хорооны 598 дугаар тогтоолоор Монголын Хөрөнгийн Биржийн бүтцээс Төлбөр тооцоо, хадгаламжийн албаны үйл ажиллагааг тусгаарлан үйл ажиллагааг дагнан эрхлэх 100 хувь төрийн өмчит бие даасан компани бий болсон.

2005 Хонг Конгын Хөрөнгийн Биржтэй хамтран ажиллах санамж бичиг гарын үсэг зурав.

05 2005 Анхны компанийн нийтэд санал болгосон хувьцааны /IPO/ арилжааг амжилттай зохион байгуулав.

800 сая төгрөгийн үнийн дүн бүхий 1 сая ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож амжилттай арилжаалсан.

10 2005 Сургалтын төвийг Монголын Хөрөнгийн Биржийн дэргэд үүсгэн байгуулав.

Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох зорилгоор Монголын Хөрөнгийн Биржийн дэргэд сургалтын төв байгуулав. Өнөөгийн байдлаар 15,000 хүн тус сургалтад хамрагдсан байна.

01 2006 Санхүүгийн Зохицуулах Хороо үүсгэн байгуулагдав.

Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг нэгдмэл удирдлагаар хангах, нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх буюу төрийн зохицуулагч байгууллагын чиг үүргийг өргөтгөх хэрэгцээ шаардлага үүссэн.

06 2006 Солонгос, Турк, Сингапурын Хөрөнгийн Биржүүдтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулав.

2007 Хөрөнгө оруулагчийн мөнгөн гүйлгээг зөвхөн арилжааны банкин дахь нэрийн дансаар нь дамжуулах зарчимд шилжсэн.

05 2008 "Ази, Номхон Далайн Орнуудын Хөрөнгийн Биржүүдийн Холбоо"-ны гишүүнээр элсэв

Тус холбоо нь 19 гишүүн оронтой ба Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулж буй нэр хүндтэй байгууллага юм.

2008 "Блүүмбэрг" агентлагт мэдээлэл борлуулах гэрээ байгуулав.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн талаарх мэдээллийг олон улсад илүү нээлттэй, ил тод, түргэн шуурхай түгээх боломж нээгдэж, гадаадын хөрөнгө оруулагчид нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн.

03 2009 Москвагийн Банк Хооронд Валютын биржтэй хамтран ажиллах санамж бичиг гарын үсэг зурав.

Гадаад харилцааг өргөжүүлэх ажлын хүрээнд үндсэн 3 чиглэлээр хамтран ажиллахаар болсон.

04 2011 "Ажлын мастер гэрээ"-г байгуулав.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилгоор "Лондонгийн Хөрөнгийн Биржүүд Групп"-тэй стратегийн түншлэлийн 3 жилийн хугацаатай гэрээг байгуулсан.

07 2012 "Миллениум Ай Ти" цогц системийг нэвтрүүлэв.

"Лондонгийн Хөрөнгийн Биржүүд Групп"-ийн охин компани "Миллениум Ай Ти"-ийн боловсруулсан, 20 гаруй улсын 30 гаруй Хөрөнгийн Биржийн үйл ажиллагаанд ашиглагддаг арилжаа, төлбөр тооцоо, хадгаламж, хяналтын цогц систем юм.

СТХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

08 2012 — Financial Times Stock Exchange (FTSE) Russel индекс.

Financial Times Stock Exchange (FTSE) Russel-ийн "Хөгжиж буй зах зээл" ангиллын "Ажиглалтын жагсаалт"-нд багтав.

04 2013 — Брокерууд өдөр тутмын арилжаанд өөрийн оффисоос оролцох боломжтой болсон.

"Милленниум Ай Ти" цогц системийн давуу талуудын нэг болох зайнаас арилжаанд оролцох технологийн шийдэл, дэд бүтцийг бэлэн болгож брокерууд тус тусын оффисоос өдөр тутмын арилжаанд оролцох болсон.

05 2013 — "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга батлагдав.

Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчин олон улсын сайн туршлагын дагуу шинэчлэгдэх нөхцөл бүрдсэн.

10 2013 — "Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль" батлагдав.

Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгосон.

12 2015 — Монголын Хөрөнгийн Бирж нь Өөрийгөө зохицуулах байгууллага статустай болов.

Санхүүгийн Зохицуулах Хорооны ээлжит бус хуралдаанаар "Өөрийгөө зохицуулах байгууллага"-р бүртгэх шийдвэр гарсан.

2017 — Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэдэх Тогтвортой Хөгжилд Чиглэсэн Хөрөнгийн Биржүүдийн Холбооны гишүүнээр элсэв.

Байгаль орчин, нийгэм, засаглалын ил тод байдал, тайлагналын стандартыг Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэхээр зорьж байна.

04 2018 — Хамгийн анхны гадаадын үнэт цаасыг давхар бүртгэв.

Канад Улсын Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг компанийн үнэт цаасыг давхар бүртгэж, III-р ангилалдаа оруулсан.

12 2018 — Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны дүн түүхэн дээд амжилтад хүрэв.

210 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хувьцаа Монголын Хөрөнгийн Бирж дээр нэг өдөрт арилжаалагдсан нь үүсгэн байгуулагдсанаас хойших 27 жилийн хугацааны түүхэн дээд үзүүлэлт болсон.

03 2020 — Үнэт цаасны төлбөр тооцооны T+2 горимыг амжилттай нэвтрүүлэв.

"Төлбөрийн эсрэг Нийлүүлэлт" зарчим нэвтэрсэн нь зах зээлд оролцогчдын арилжааны шимтгэл, зардлыг бууруулж, зах зээлийн хөрвөх чадвар сайжрах, гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчид үнэт цаасны арилжаанд оролцоход таатай нөхцөлийг бүрдүүлэхэд түлхэц болсон.

08 2020 — Анхны хаалттай хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх бүртгэгдэв.

4.75 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

01 2021 — Анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжааг зохион байгуулав.

"Инвескор Актив ТЗК" ХХК-ийн 4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг амжилттай арилжаалсан. Захиалга нь нийлүүлэлтээсээ 3.3 дахин давж биелсэн.

01 2021 — Давхар бүртгэлтэй үнэт цаасны бирж хоорондын хөрвүүлэлт амжилттай хийгдэв.

Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Монгол компанийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 200 гаруй тэрбум төгрөгөөр өсөв.

Үргэлжлэлийг дараагийн хуудсанд үзнэ үү

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаасны танилцуулга
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

01 2021 — Хөрөнгийн зах зээлийн түүхэн үзвэрийн танхимыг байгуулав.

Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсэж, Монголын Хөрөнгийн Бирж байгуулагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан биржийн үйл ажиллагаатай холбоотой түүхэн үзмэрүүдээс бүрдсэн үзвэрийн танхимыг байгуулав.

03 2021 — Хамгийн өндөр дүн бүхий компанийн бондын арилжааг зохион байгуулав.

600 тэрбум төгрөг хүртэлх дүн бүхий компанийн өрийн хэрэгслийг амжилттай арилжаалсан.

06 2021 — Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Шанхайн Хөрөнгийн Биржтэй хамтын ажиллагаа эхлүүлэв.

Уг бирж нь Дэлхийн ТОП-5 Хөрөнгийн Биржийн нэг юм.

09 2022 — "FTSE Russell"-ийн "Хөгжиж буй зах зээл" ангиллын шалгуурыг хангав.

"FTSE Russell" Групп нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг 2023 оны 9-р сараас тус ангилалд оруулахыг зөвшөөрсөн.

12 2022 — Хамгийн их захиалга авсан IPO-ийн арилжааг зохион байгуулав.

Хамгийн өндөр дүнтэй, хамгийн олон хөрөнгө оруулагч оролцсон "Голомт Банк" ХК-ийн анхдагч арилжаанд 21,821 хөрөнгө оруулагчаас 174,841,778,685 төгрөгийн үнийн дүн бүхий захиалга ирсэн.

СЭХ
БҮРТГЭВ
№ 91

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2.2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОЛОЛТ, АМЖИЛТ

Үнэт цаас гаргагч нь өнгөрсөн 31 жилийн хугацаанд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түүчээлэн, үргэлж шинийг санаачлагч, нэвтрүүлэгч байсаар ирсэн ба хөрөнгийн зах зээлийн тогтвортой өсөлт, үйл ажиллагааны үзүүлэлтээрээ тэргүүлж дотоод, гадаадын нэр хүндтэй байгууллагуудын шагналын эзнээр тодорсоор ирсэн.

Схем 5. Үнэт цаас гаргагчийн ололт, амжилтууд

2012

The Best Innovation
Bloomberg TV Mongolia Awards

"БлүүмбэргТелевиз" жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг, Бизнесийн шилдгүүдийг шалгаруулдаг "Bloomberg TV Mongolia Awads" арга хэмжээнээс "The Best Innovation 2012" шагналыг хүртэв. Дотоодын хөрөнгийн зах зээлд "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн нэвтрүүлэн нутагшуулсан "Милленниум Ай Ти" систем нь оны шилдэг шинэчлэлийн ажил хэмээн дүгнэгдсэн.

2014

Авлигаас ангид, Сайн засаглалын Сайн санаачилга
Монгол Улсын Авлигатай Тэмцэх Газар

Монгол Улсын Авлигатай Тэмцэх Газраас "Авлигаас ангид, Сайн засаглалын Сайн санаачилга" өргөмжлөл хүртсэн.

Үнэт цаас гаргагч нь авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, ажилтны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах ажлыг амжилттай хэрэгжүүлж ажилласан.

2018

Арилжааны шилдэг систем
Waters Rankings Awards

Их Британи Улсын санхүүгийн зах зээлийн мэдээлэл технологийн тэргүүлэгч сэтгүүлүүдийн нэг болох "Waters" сэтгүүлээс 16 дахь жилдээ зохион байгуулагдсан "Waters Rankings Awards 2018" арга хэмжээний үеэр "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн ашигладаг "Millennium Exchange" системийг "Арилжааны шилдэг систем"-ээр тодруулсан.

2020

Шилдэг Байгууллага
Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар

"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК нь төрийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлж, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний үүргээ хангалттай сайн биелүүлсэн тул Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газраас "Шилдэг Байгууллага"-р шалгарч, "Өргөмжлөл"-өөр шагнагдсан.

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020699
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
6317839
1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022.12.14
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2.3. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

Хөрөнгийн зах зээл нь нь хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагч болон зохицуулалттай этгээдүүдийн хоорондын харилцаан дээр тулгуурлаж үнэт цаас болон үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжих зах зээлийг хэлдэг ба үүнд зохицуулалттай этгээдүүдийн үйл ажиллагаа өндөр ач холбогдолтой байдаг байна. "Үнэт цаасны зах зээлийн хууль"-ийн дагуу дараах төрлийн үйл ажиллагааг зохицуулалттай үйл ажиллагаа гэж хэлнэ:

1. Үнэт цаасны брокерийн;
2. Үнэт цаасны дилерийн;
3. Үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн;
4. Үнэт цаасны итгэмжлэн удирдах;
5. Андеррайтерийн;
6. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн;
7. Үнэт цаасны арилжааны тооцооны;
8. Үнэт цаасны арилжааны төлбөрийн;
9. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн;
10. Кастодианы;
11. Үнэт цаасны арилжаа эрхлэх;
12. Хөрөнгө оруулалтын сангийн;
13. Хөрөнгө оруулалтын менежментийн;
14. Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох;
15. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх;
16. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх;
17. Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2074096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Хөрөнгийн зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хороо олгодог ба дараах ерөнхий зураглалын дагуу хөрөнгийн зах зээлийн харилцаа үүсдэг.

Схем 6. Хөрөнгийн зах зээлийн оролцогч байгууллагууд



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

2.3.1. Хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллага

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллага нь Санхүүгийн Зохицуулах Хороо бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх бүхий төрийн байгууллага юм. Санхүүгийн Зохицуулах Хороо нь бүрэн эрхийнхээ хүрээнд дүрэм, журам, заавар баталж, хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай шалгуур үзүүлэлт, бусад хэм хэмжээг тогтоох, санхүүгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих, шалгах, үйлчилгээтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, Санхүүгийн Зохицуулах Хорооны ажилтны ёс зүйн дүрмийг баталж, хэрэгжилтэд хяналт тавих зэрэг бүрэн эрхүүдийг хэрэгжүүлдэг. Мөн Санхүүгийн Зохицуулах Хороо нь Монголбанк, санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (Монгол Улсын Сангийн яам)-тай санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, уг зах зээлийг хөгжүүлэх, зохицуулах, хяналт тавих чиглэлээр өөр хоорондоо уялдсан үйл ажиллагаа явуулах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор хамтран ажилладаг.

2.3.2. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд

Банкны салбарт системийн нөлөө бүхий банкнууд гэсэн тодорхойлолт байдаг бол хөрөнгийн зах зээлд тус тодорхойлолтыг дэд бүтцийн байгууллагуудад ашиглах боломжтой. Дэд бүтцийн байгууллагууд нь хөрөнгийн зах зээлийн салшгүй нэг хэсэг бөгөөд эдийн засгийн эргүл тогтолцоог бүрдүүлэх өндөр ач холбогдолтой ба мөнгөн урсгалыг үр ашигтай хуваарилахад өөрсдийн үүргээ биелүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмждэг билээ. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудад үнэт цаасны арилжаа эрхлэх, өмчлөх эрхийн бүртгэлийн, арилжааны тооцооны, төлбөрийн, төвлөрсөн хадгаламжийн, кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллагууд хамаардаг.

1. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага

Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагааг Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлдэг бөгөөд тус үйл ажиллагаа эрхэлж байгаа хоёр байгууллагын нэг нь "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК билээ. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага нь арилжааг ил тод, шударга, алдаагүй зохион байгуулахын тул арилжааг явуулах дэд бүтцийн найдвартай байдлыг хангаж ажиллах, арилжааг зохих журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, хийгдсэн арилжааны мэдээллийг нийтэд мэдээлэх зэрэг үүрэг хүлээж ажилладаг.

СЗХ
2022 -12- 14
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2. Үнэт цаасны арилжааны тооцооны буюу клирингийн байгууллага

Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа гэдэг нь арилжаанд оролцогч талуудын гэрээ, хэлцлийн дагуу төлбөл зохих төлбөрийг тооцоолж, арилжааны төлбөрийн эрсдэлийг хаах, эрсдэлийг шинжилж, бууруулах үйл ажиллагааг хэлнэ. Тус үйл ажиллагааг олон улсад Төвлөрсөн Клирингийн Байгууллага буюу Central Counterparty Clearing House (CCP) эрхэлдэг бөгөөд бүх арилжаанд оролцогч талуудыг нөгөө талын эрсдэлээс хамгаалах үүрэг гүйцэтгэдэг. Нөгөө талын эрсдэл гэдэг нь counterparty risk гэгддэг бөгөөд аливаа арилжаа, хэлцэлд орсон нөгөө тал нь төлбөрийн үүргээ биелүүлэхгүй байх эрсдэлийг хэлдэг ба CCP нь тус эрсдэлээс хамгаалж, бүх арилжааны хэлцэлд нэгдсэн ганц л "нөгөө тал" болдог. Монгол Улсын хувьд "Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв" ХХК нь үнэт цаасны арилжаанд оролцогч талуудын гэрээ, хэлцлийн дагуу төлбөл зохих төлбөрийг гэрээ тус бүрээр болон нэгдсэн байдлаар тодорхойлж, санхүүгийн бүртгэл, тооцооллыг гүйцэтгэдэг. Монголын Хөрөнгийн Биржийн гишүүнчлэлтэй үнэт цаасны компаниуд "Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв" ХХК-д клирингийн гишүүнээр элсэж, өөрсдийн харилцагчийн арилжааны мөнгөн төлбөр болон үнэт цаасны шилжүүлгийн гүйлгээг гүйцэтгүүлдэг. Клирингийн гишүүд нь дараах төрөлтэй байдаг байна.

Хүснэгт 8. Клирингийн гишүүдийн төрөл

Клирингийн ерөнхий гишүүн (General Clearing Member)	Өөрийн харилцагчийн болон клирингийн бус гишүүний мөнгөн төлбөр болон үнэт цаасны шилжүүлгийн үүргийг клирингийн төвийн өмнө хүлээнэ.
Клирингийн шууд гишүүн (Direct Clearing Member)	Зөвхөн өөрийн харилцагчийн мөнгөн төлбөр болон үнэт цаасны шилжүүлгийн үүргийг клирингийн төвийн өмнө хүлээнэ.
Клирингийн бус гишүүн (Non-Clearing Member)	Зөвхөн өөрийн харилцагчийн мөнгөн төлбөр болон үнэт цаасны шилжүүлгийн үүргийг клирингийн ерөнхий гишүүний өмнө хүлээнэ.

Эх сурвалж: "Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв" ХХК-ийн цахим хуудас

Монгол Улс 2012 оноос "FTSE Russell" Группийн "Хөгжиж буй зах зээл" буюу "Frontier market"-ийн ангиллын Ажиглалтын жагсаалтад орсон боловч "Хөгжиж буй зах зээл"-ийн ангилалд орох шаардлагыг хангаж чадалгүй байсаар 2017 онд хасагдсан байдаг. Тус ангилалд багтах нь гадаадын хөрөнгө оруулагчдыг татах чухал нөхцөл гэж олон улсад үздэг бөгөөд үүнийг хангах гол шаардлага нь Төлбөрийн эсрэг Нийлүүлэлт буюу DvP /Delivery versus Payment/, T+2 төлбөр тооцооны горимд шилжсэн байх гэж үздэг билээ.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СӨХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2018 онд Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо болон "Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв" ХХК нь хөрөнгийн зах зээлийн бусад дэд бүтцийн байгууллагуудтай хамтран шинэ төлбөр тооцооны горимд шилжих ажлын бэлтгэлийг гүйцэтгэж, 2020 оны 3 дугаар сарын 31-нд дээрх системд амжилттай шилжсэн. Ийнхүү 2020 он хүртэл хөрөнгийн зах зээл дээрх төлбөр тооцооны үндсэн арга нь зуун хувь урьдчилсан төлбөр хийх зарчим дээр суурилж байсан бол төлбөрийн эсрэг нийлүүлэлт, Т+2 төлбөр тооцооны горимд шилжсэнээр "Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв" ХХК-ийн үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх үүрэгт өөрчлөлт орж, "Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв" ХХК нь үнэт цаасны клирингийн үйл ажиллагааг, үнэт цаасны төлбөрийн үүргийг "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК нь тус тус гүйцэтгэх болов. "Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв" ХХК нь "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 43 дугаар зүйлийн дагуу арилжаанд оролцогч талуудын үнэт цаас болон мөнгөн төлбөрийн үүргийг гэрээ бүрээр, мөн нэгдсэн дүнгээр тодорхойлох, тэрхүү төлбөрийн үүрэг бүрэн биелэгдэхтэй холбоотой болзошгүй эрсдэлийг удирдах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх болсон.

3. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

Улс орон бүрд үнэт цаасны эцсийн хадгалалт нэгдсэн байдлаар хийгддэг ба энэхүү үйл ажиллагааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа гэж нэрлэдэг. Монгол Улсад мөн адил, "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн дагуу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн нэг хуулийн этгээдэд олгодог. "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК тус үйл ажиллагааг эрхэлдэг бөгөөд үнэт цаас гаргагч компани болон бусад оролцогчидтой байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасыг хадгалах, үнэт цаас өмчлөгчийн бүртгэл хөтлөх үйл ажиллагааг эрхлэх, биржийн болон биржийн бус арилжааны өмчлөх эрхийг баталгаажуулах, мөн үнэт цаасны төлбөрийн үйл ажиллагааг зохион байгуулах эрх бүхий өөрийгөө зохицуулагч зуун хувь төрийн өмчит хуулийн этгээд юм.

"Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК анх 1991 онд Монголын Хөрөнгийн Биржид "Төлбөр тооцоо хадгаламжийн алба" нэртэйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн гэж тооцож болох ба тус алба нь хувьцааг хөрөнгө оруулалтын эрхийн бичиг хэлбэрээр арилжаалж эхлэхэд төлбөр тооцоо гүйцэтгэх үүргийг эрхэлдэг байсан.

2002 онд "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийг шинэчлэн баталснаар хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг тодотгон тодорхойлж, Засгийн газрын 2003 оны 72 дугаар тогтоол, Төрийн өмчийн хорооны 598 дугаар тогтоолоор "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн бүтцээс Төлбөр тооцоо, хадгаламжийн албыг

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071896
УЛААНБААТАР

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
САРТАС
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

тусгаарлан салгаж, хөрөнгийн зах зээлийн үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааг дагнан эрхлэх зуун хувь төрийн өмчит бие даасан компанийг үүсгэн байгуулсан. 2016 оны 4 дүгээр сарын 15-нд Засгийн газрын 147 тоот тогтоолын дагуу тус байгууллагыг "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК, "Арилжааны Төлбөр Тооцоо" ХХК болгон хуваасан.

2.3.3. Хөрөнгийн зах зээлийн оролцогч зохицуулалттай этгээдүүд

1. Үнэт цаасны компани

1991 оны 6 дугаар сарын 26-ны өдрөөс Монголын Хөрөнгийн Бирж нь үнэт цаас, хөрөнгийн зах зээлийн түргэвчилсэн сургалтыг 2 сарын хугацаанд зохион байгуулж, сургалтад тэнцсэн мэргэжилтнүүдийг үнэт цаас, хөрөнгийн зах зээлд ажиллахыг зөвшөөрч, Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн үнэт цаасны компанийг засаг захиргаагаар багцлан 21 аймаг тус бүрд нэг, нийслэл Улаанбаатар хотод 8 компани байгуулахаар шийдвэрлэж, анхны 29 брокерийн пүүс /одоогийн нэршлээр үнэт цаасны компаниуд/-ийг байгуулсан түүхтэй.

Брокерийн пүүсүүдэд Өмч хувьчлалын эрхийн бичгийг баталгаажуулах үүргээс гадна нэг талаас иргэд үнэт цаасаа зуучлуулан бэлэн мөнгийг эргэлтэд оруулж ашиг хүртэх, нөгөө талаас пүүсүүд иргэдийн хөрөнгийг зах зээлд арилжаалан хөдөлгөөнд оруулж амилуулах өндөр хариуцлагатай үндсэн арилжаа 1995 оноос 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл нийт 206,787 удаагийн хэлцлээр 5.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 4,236,706,482 ширхэг үнэт цаасыг арилжаалсан байна.

Монголын Хөрөнгийн Биржийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр байгуулагдсан 29 брокерийн пүүсийг 1995 онд Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын тогтоолоор хувьчилснаас хойш төр засгийн бодлого шийдвэр, эдийн засгийн хүндрэл зэргээс хамааран гишүүн компанийн тоо нэмэгдэж, хасагдсаар Үнэт цаасны танилцуулга боловсруулах үеийн байдлаар 52 (тавин хоёр) гишүүн үнэт цаасны компани үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж байна.

"Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-нд зааснаар брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд үнэт цаасны дилерийн, андеррайтерийн, үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг хавсран эрхлэх боломжтой гэж заасан байдаг.

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12

Хүснэгт 9. Үнэт цаасны компаниудын үйл ажиллагааны төрөл, үйлчилгээний төрөл тайлбар

Үйлчилгээний нэр	Үйлчилгээний тайлбар
Брокерийн үйлчилгээ	Үнэт цаасны зах зээл дээр бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах үйл ажиллагаа.
Дилер	Үнэт цаасны зах зээл дээр ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах, арилжих үйл ажиллагаа.
Андеррайтерийн үйлчилгээ	Аж ахуйн нэгж болон засгийн газраас шинээр гаргасан үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх, үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад санал болгох үнийг тодорхойлох, өөрийн харилцагчид үнэт цаасыг танилцуулах, шаардлагатай бүх хүчин чармайлтыг гаргаж худалдах ажлыг зохион байгуулах, үнэт цаасны зарагдаагүй үлдсэн хэсгийг худалдан авах амлалттайгаар бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн худалдан авах ажиллагаа.
Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ	Олон нийтэд танилцуулагдсан мэдээлэл дээр үндэслэн судалгаа, шинжилгээг гүйцэтгэх, харилцагчид үнэт цаасыг худалдах, худалдан авах үнэ, нөхцөл, хугацааны талаар мэргэжлийн зөвлөгөөг төлбөртэйгөөр үзүүлэх үйлчилгээ.

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

2. Брокерийн үйл ажиллагаа

Харилцагчийн хөрөнгөөр, түүний нэрийн өмнөөс, түүний даалгавраар үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааг үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа гэдэг. Брокерийн үйл ажиллагааг хуулиар тодорхой шалгуур, шаардлагыг хангасан Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн үнэт цаасны компаниуд эрхлэх боломжтой. Брокерийн үйлчилгээ үзүүлэх гишүүн үнэт цаасны компани нь хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо болон харьяалах хөрөнгийн бирж, үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоо, хадгаламжийн байгууллага зэрэг гишүүнчлэл бүхий өөрийгөө зохицуулах байгууллагуудаас батлагдсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх үүрэгтэй байдаг.

3. Дилерийн үйл ажиллагаа

Хөрөнгийн зах зээл дээр ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах, арилжих ажиллагааг дилерийн үйл ажиллагаа гэнэ. Дилерийн үйл ажиллагааны хүрээнд дилер нь өөрийн эрсдэл даах чадварт тохирох үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдах, худалдан авах ба бусдын нэрийн өмнөөс, бусдад зуучлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Дилерүүд нь үнэт цаасны үнийг тогтоох, үнэт цаасны эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хадгалахад чухал үүрэгтэй. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Монголын Хөрөнгийн Биржид 39 (гучин ес) үнэт цаасны компани дилерийн тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
3020020699
2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он сар өдөр
2022 12 14
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

4. Андеррайтерийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагчтай хийсэн гэрээний үндсэн дээр үнэт цаасыг олон нийтэд (хаалттай хүрээнд санал болгох бол мэргэжлийн хөрөнгө оруулагчдад) санал болгон хөрөнгө оруулалт татахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, анхдагч зах зээлд худалдагдаагүй үлдсэн үнэт цаасыг андеррайтерийн гэрээнд заасан хэмжээгээр, тохиролцсон үнээр худалдаж авах зэрэг ажиллагааг гүйцэтгэдэг. Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх журам болон андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний стандарт нөхцөлийг Санхүүгийн Зохицуулах Хороо тогтоодог. Андеррайтерийн үйлчилгээг дор дурдсан хэлбэрээр үзүүлж болно. Үүнд:

- ✓ Үнэт цаасны танилцуулга бэлтгэхэд зөвлөгөө өгөх, үнэт цаасыг санал болгох үнийг тодорхойлох;
- ✓ Өөрийн харилцагчид үнэт цаасыг танилцуулах, худалдах ажлыг зохион байгуулах;
- ✓ Үнэт цаас гаргагчийн хувьцааг хөрөнгө оруулагчдад санал болгосны дараа худалдаагүй үлдсэн хэсгийг гэрээгээр тохиролцсон үнээр бүхэлд нь эсвэл хэсэгчлэн худалдан авах баталгаа гаргах, гэрээний үүргээр худалдан авах;
- ✓ Хөрөнгө оруулагчдад тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлтыг гаргах;
- ✓ Гэрээнд заасан бусад нөхцөл.

Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах үеийн байдлаар 18 (арван найм) үнэт цаасны компани андеррайтерийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

5. Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ

Үнэт цаас гаргагчийн нийтэд танилцуулагдсан мэдээлэл дээр үндэслэн судалгаа, шинжилгээг гүйцэтгэх, харилцагчид үнэт цаасыг худалдах, худалдан авах үнэ, нөхцөл, хугацааны талаар мэргэжлийн зөвлөгөөг төлбөртэйгөөр өгөх ажиллагааг хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ гэнэ. Үнэт цаасны компани нь өөрийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор судалгаа, шинжилгээ хийсэн, хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад зориулан судалгаа, шинжилгээ хийх эсвэл нийтийн хэрэгцээнд зориулан буюу шинжлэх ухааны зорилгоор судалгаа, шинжилгээ хийж, дүнг нийтэд мэдээлсэн бол үүнийг хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхэлсэн гэж үзэхгүй. Үнэт цаасны танилцуулга бэлтгэгдэх үеийн байдлаар хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөл авч,

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
2021096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлсэн 16 (арван зургаа) үнэт цаасны компани байна.

6. Кастодианы үйл ажиллагаа

Үнэт цаас эзэмшигчийн өмчлөл дэх үнэт цаасыг хадгалах, үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх бусад эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйлчилгээг үзүүлэх ажиллагааг кастодианы үйл ажиллагаа гэнэ. Олон улсад тухайн үйл ажиллагааг кастодиан банкнууд эрхэлдэг ба хөрөнгө оруулагчдын үнэт цаасны данс хөтлөлт, төлбөр тооцоог кастодиан банкнууд гүйцэтгэж, кастодиан банкнууд нь төвлөрсөн хадгаламжийн төв дээр нэгдсэн байдлаар харилцагчдынхаа үнэт цаасаа хадгалуулдаг. Хөрөнгө оруулагчдын үнэт цаасыг нэгдсэн байдлаар хадгалах үнэт цаасны дансыг номинал данс гэж нэрлэдэг ба төлбөр тооцооны хувьд хялбар, гадаадын хөрөнгө оруулалт, сангуудын хувьд данс нээхэд зөвхөн кастодиан банкнуудаар дамжиж, процессыг хөнгөвчлөх эрэг нөлөөтэй байдаг.

2013 онд "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга батлагдаж, улмаар 2014 оны 7 дугаар сарын 3-нд Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хорооны хамтран баталсан Кастодианы тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журамд нийцүүлэн арилжааны банкнууд кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчин бүрдэв. 2014 оны 8 дугаар сараас эхлэн Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон кастодианы үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу "Голомт Банк" ХК, "Худалдаа Хөгжлийн Банк" ХХК болон "Хаан Банк" ХХК-ууд кастодианы үйл ажиллагаа эрхэлж байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй кастодиан банкнууд олон улсын үнэт цаасны зах зээл дэх үйл ажиллагаагаа тэлж, олон улсын томоохон төвлөрсөн хадгаламжийн төвүүд, кастодиан банкнуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, үнэт цаасны данс нээж, дотоодын харилцагчдын олон улсын хөрөнгийн захаас худалдан авсан бүх төрлийн үнэт цаасыг найдвартай хадгалах, төлбөр тооцоо, тайлагналын үйлчилгээ үзүүлэх болсон байна.

7. Үнэт цаасны итгэмжлэн удирдах үйлчилгээ

Итгэмжлэгч харилцагчийн үнэт цаас, түүнтэй холбоотой хөрөнгийн өмчлөх эрхийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан хязгаарын хүрээнд хэрэгжүүлэх үйлчилгээг үнэт цаасны итгэмжлэн удирдах үйлчилгээ гэдэг. Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах үеийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооноос уг үйлчилгээний тусгай зөвшөөрлийг 7 (долоо) байгууллага авсан байна.

MONGOLIAN STOCK EXCHANGE

ХӨРӨНГИЙН БИРЖ
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020695
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
1119277128
УЛААНБААТАР ХОТ

8. Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа

Энэхүү үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь Санхүүгийн Зохицуулах Хорооны тодорхойлсон зохих нөхцөл, шаардлагыг хангасан, хөрөнгийн зах зээл дэх тодорхой төрлийн санхүүгийн хэрэгсэлд дүн шинжилгээ хийж, тэдгээрийн чанар, эрсдэл, өгөөж зэрэг үзүүлэлтээр зэрэглэл тогтоох хөндлөнгийн, хараат бус ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байна. Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах үеийн байдлаар 1 (нэг) байгууллага нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос тус үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг авч, үйл ажиллагаа явуулж байна.

9. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйлчилгээ

Хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйлчилгээ гэж "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн дагуу Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлсний үндсэн дээр хөрөнгийн зах зээлд оролцогчдод гэрээний үндсэн дээр хууль зүйн зөвлөгөө үзүүлэх, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг хянаж, дүгнэлт гаргах этгээдийг хэлнэ.

10. Үнэт цаасны зах зээлд оролцогчид үзүүлэх хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ

Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх гэж "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн дагуу Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлсний үндсэн дээр хөрөнгийн зах зээлд оролцогчдод гэрээний үндсэн дээр хөрөнгийн үнэлгээ болон бизнесийн үнэлгээ гүйцэтгэх этгээдийг хэлнэ.

11. Үнэт цаасны зах зээлд оролцогчид үзүүлэх аудитын үйлчилгээ

Аудитын үйлчилгээ гэж "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн дагуу Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлсний үндсэн дээр хөрөнгийн зах зээлд оролцогчдод гэрээний үндсэн дээр аудитын үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад туссан санхүүгийн мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг хянаж, дүгнэлт гаргах тусгай зөвшөөрөл бүхий этгээд юм.

2.3.4. Хөрөнгө оруулагчид

Хувь хүн, аж ахуйн нэгж Монголын Хөрөнгийн Биржийн арилжаанд чөлөөтэй оролцох боломжтой ба үнэт цаасны дансаа өөрийн сонгосон үнэт цаасны компаниар дамжуулан "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК-д нээлгэн хувьцаа, бонд болон бусад үнэт цаасыг худалдан авах, худалдах боломжтой. 2022 оны байдлаар "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК -д нийт 2.5 сая буюу нийт хүн амын 75 хувь нь данс эзэмшигчээр бүртгүүлсэн байна

СӨХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2.3.5. Үнэт цаас гаргагчид

Санхүүжилт татах зориулалттайгаар үнэт цаасаа нийтэд санал болгон гаргах этгээдийг үнэт цаас гаргагч гэж нэрлэдэг ба үнэт цаас гаргах этгээдүүд нь Засгийн газар, аймаг, нийслэл, компани байна. Үнэт цаас гаргах үйл явц нь хямд өртөг бүхий урт болон богино хугацаатай, гадаад болон дотоод эх үүсвэрээс өөрийн хэрэгцээ шаардлагад зориулсан санхүүжилтийг татахыг хэлнэ.

"Үнэт цаасны тухай хууль"-д Засгийн газар, хуулийн этгээд болох компани нь тус улсын нутаг дэвсгэрт, эсхүл гадаад улсын нутаг дэвсгэрт үнэт цаасыг нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд худалдахаар гаргаж болно гэж заасан байдаг. Нөгөөтээгүүр, гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үнэт цаасыг Монгол Улсын нутаг дэвсгэрт тогтоосон журмын дагуу арилжиж болдог. Үнэт цаасны чанар нь үнэт цаас гаргагчийн нэр хүнд, үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүдээр тодорхойлогддог.

Үнэт цаас гаргагч компани хувьцаагаа анх удаа нийтэд нээлттэй санал болгон худалдахыг IPO гэж нэрлэдэг ба ингэхдээ тухайн компани нь хөрөнгө оруулагчдаас санхүүжилт татан төвлөрүүлж, өөрийн хөрөнгөө нэмэгдүүлдэг байна. Энэхүү арилжаа хийгдэх талбарыг анхдагч зах зээл гэж нэрлэдэг бол нийтэд санал болгосон үнэт цаасыг хөрөнгө оруулагчид хооронд арилжаалах талбарыг хоёрдогч зах зээл гэдэг.

Үнэт цаас гаргагч нь гаргаж буй үнэт цаасаа нээлттэй болон хаалттай хүрээнд гаргаж болно. Нээлттэй хүрээнд гаргаж буй үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлдэг бол хаалттай хүрээнд гаргаж буй үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Бирж эсвэл "Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ-аар дамжуулан гаргаж болно. Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл, төлбөр тооцоог "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК гүйцэтгэдэг байна.

2.3.6. Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

"Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ нь брокер, дилерийн компаниудын санаачлагчаар 1995 онд үүсгэн байгуулагдаж, 1995 оны 7 дугаар сарын 8-нд анхдугаар хурлаа хийн Холбооны дүрмээ хэлэлцэн баталж, Удирдах Зөвлөлийг сонгож үйл ажиллагаагаа эхлүүлсэн. "Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ нь үнэт цаасны зах зээлийн ажил, үйлчилгээг олон улсын жишигт хүргэн хөгжүүлэх, гишүүн байгууллагуудын нийтлэг эрх ашиг, тогтвортой ажил үйлчилгээ, нэгдсэн үзэл бодлогыг хамгаалах үндсэн зорилго бүхий төрийн бус байгууллага юм. "Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ нь 2015 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос хүлээн зөвшөөрөгдсөн Монгол Улсын

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020699 6071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

үнэт цаасны зах зээл дэх анхны өөрийгөө зохицуулах байгууллага ба өдгөө үйл ажиллагаагаа улам өргөжүүлэн ажиллаж байна.

"Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ нь хууль болон дүрэмд заасан үндсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах үндсэн бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- ✓ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр төрийн байгууллагад санал оруулах, хууль тогтоомж, дүрэм, журмын төсөлд санал өгөх;
- ✓ Мэргэжлийн сургалт явуулах, давтан сургах, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх олгох, эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;
- ✓ Гишүүдийнхээ үйл ажиллагаанд баримтлах нийтлэг журам, мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, заавар, зөвлөмжийг хороонд танилцуулснаар баталж, хэрэгжилтийг хангуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад хувь нэмрээ оруулах;
- ✓ Гишүүний ёс зүйтэй холбоотой гомдол, маргааныг шийдвэрлэх;
- ✓ Гишүүдийн үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийж, тэдгээрт зэрэглэл тогтоох, нийтэд мэдээлэх;
- ✓ Өөрийн дүрэм, журмаар тогтоосон хүрээнд гишүүдийнхээ үйл ажиллагааг шалгах, зөрчлийг арилгуулах талаар үүрэг өгөх, зөрчлийн хэмжээнээс хамаарч мэргэжлийн гишүүн байгууллагын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг хороонд оруулах, холбогдох байгууллагад зөрчлийн талаар мэдээлэх;
- ✓ Гишүүдийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- ✓ Гишүүдээ чадавхжуулах, мэргэжлийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах;
- ✓ Хууль болон дүрэмд заасан бусад.

Түүнчлэн, "Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ нь өөрийн дотоод дүрэм, журмыг боловсруулж гишүүн байгууллагуудад хэвшүүлэх, мэргэжлийн ёс зүйн стандартыг тогтоож түүнийг нийт мэргэжилтнүүдэд дагаж мөрдүүлэх, өөрийн гишүүн байгууллагуудад зохих хяналт тавьж ажиллах, сургалт зохион байгуулж мэргэшлийн эрх олгох, хөрөнгийн зах зээлийн оролцогч

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЗХ
БҮРТГЭВ
№ 91

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 12 12
БҮРТГЭВ-02

байгууллагуудын нягт хамтын ажиллагааг дэмжиж ажиллах, хөрөнгийн зах зээлийн эрх зүйн зохицуулалтын талаар санал өгч оролцогч талуудтай хамтран ажиллах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

2.4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

"Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-аар арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасны зах зээлд хувьцаа, компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хадгаламжийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, варрант, засгийн газрын бонд, аймаг, нийслэлийн бонд, үнэт цаас болон бараа бүтээгдэхүүнд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх, арилжааг зохион байгуулах, тооцооны үйл ажиллагаа эрхлэх, тогтоосон журмын дагуу үнэт цаасны арилжаа зохион байгуулах зорилгоор тодорхой эд хөрөнгийг төлбөртэй ашиглуулах, болон хууль тогтоомж болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон журамд заасан бусад үйл ажиллагааг эрхэлж болно гэж заасан байдаг.

Монголын Хөрөнгийн Бирж нь анх 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 22 дугаар тоот тогтоолоор улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, цаашид хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилготой үүсгэн байгуулагдсан. 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны хуралдаанаар Монголын Хөрөнгийн Биржид Өөрийгөө зохицуулах байгууллагын статус олгосон. Үнэт цаас гаргагч нь өнгөрсөн хугацаанд хурдацтай өсөж, салбартаа шинэлэг, шуурхай үйлчилгээ болон дэвшилтэт технологийг нэвтрүүлж, бүртгэлтэй компаниудын санхүүжилтийн эх үүсвэрийг хямд өртөгтэйгөөр зуучлахад дэмжлэг үзүүлж, хөрөнгийн зах зээлийн сонгодог хувилбарыг бий болгон төлөвшүүлэх замаар эдийн засгийн хөгжил дэвшилд бодит хувь нэмэр оруулсаар байна.

Үнэт цаас гаргагч нь "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэдэг. Үүнд:

- ✓ Хувьцаа, өрийн хэрэгсэл, Засгийн газрын үнэт цаас, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон бусад үнэт цаасыг бүртгэх;
- ✓ Бүртгэлийн шалгуур болон ангиллыг тогтоох;
- ✓ Бүртгэсэн үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг ил тод, шударга явуулах;
- ✓ Арилжаанд хяналт тавих, арилжааны эргэлтийг нэмэгдүүлэх нөхцөл, орчныг бүрдүүлэх;

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
1119277128
УЛААНБААТАР ХОТ

2022 -12- 12

- ✓ Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авсан Үнэт цаасны компанийг гишүүнээр элсүүлэх, арилжаанд оролцох нөхцөлөөр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, хариуцлага ногдуулах;

- ✓ Арилжааны дэд бүтэц, систем, техник программ хангамжийн найдвартай, аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангах;

- ✓ Дотоодын болон олон улсын мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн мэдээ, мэдээллийг нийлүүлэх, зах зээлийг сурталчлах;

- ✓ Олон нийтийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх сургалт, төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах зэрэг зах зээл дахь харилцаа холбоо, түншлэл, нээлттэй үйл ажиллагааг дэмжих цогц арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж ажилладаг.

Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх үеийн байдлаар Монгол Улсын санхүүгийн зах зээл нь банкны зах зээл, даатгалын зах зээл, хөрөнгийн зах зээл гэх үндсэн дэд салбаруудаас бүрдэж байна. Үнэт цаасны буюу хөрөнгийн зах зээл нь эдийн засаг, санхүүгийн зах зээлийн салшгүй нэг хэсэг бөгөөд эдийн засгийн хөгжилд өндөр хувь нэмэртэй байдаг. Жишээ нь, банкны зах зээл агших, зээл олголт хумигдах, зээлийн санхүүжилтийн өртөг өсөх үед аж ахуйн нэгжүүд нь хөрөнгийн зах зээл дээр хувьцаа, бонд эсвэл үүсмэл хэрэгсэл ашиглан шаардлагатай санхүүжилтээ бүрдүүлэх боломжтой байдаг. Хөрөнгө оруулагчдад мөн адил санхүүгийн хуримтлалаа банканд хадгаламж хэлбэрээр бүрдүүлэхээс гадна хувьцаа, бонд хэлбэрээр хөрөнгө оруулж, өгөөж болон эрсдэлээ төрөлжүүлэх сонголтуудыг бий болгодог.

Монголын Хөрөнгийн Бирж нь эдийн засгийн хөгжилд өндөр хувь нэмэр оруулах, эдийн засгийн орчныг сайжруулахад чухал дэд бүтцийн үүргийг гүйцэтгэдэг гэдгээрээ хөрөнгө оруулагчдын, аж ахуйн нэгжүүдийн, хувьцаа эзэмшигчдийн болон олон нийтийн өмнө өндөр хариуцлагатайгаар үйл ажиллагаа явуулж, үнэт зүйлсээ тодорхойлон ажилладаг билээ.

Зах зээлийг идэвхжүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр санал санаачилга гарган ажилласны үр дүнд 2018 - 2021 онуудад хамгийн анхны үнэт цаасны давхар бүртгэлийг хийж, хамгийн анхны хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бүртгэж, хамгийн анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжааг зохион байгуулж, зохицуулалтын орчноо улам сайжруулсаар байна.

Монголын Хөрөнгийн Бирж нь цахим шилжилтийг дэмжин ажиллаж, урт хугацаандаа өрсөлдөөний давуу талыг бүрдүүлэхийн тул арилжаа, төлбөр тооцоо,

хадгаламж, хяналтын цогц системээ төлбөр тооцооны Т+2 горим, "Төлбөрийн эсрэг нийлүүлэлт" зарчмыг хөрөнгийн зах зээлд Санхүүгийн Зохицуулах Хороо болон бусад дэд бүтцийн байгууллагуудтай хамтран амжилттай нэвтрүүлж чадсан.

Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг үндсэн хоёр үзүүлэлтээр хэмжиж болдог ба эхнийх нь хөрөнгийн зах зээлийн үнэлгээг Дотоодын нийт бүтээгдэхүүн (цаашид "ДНБ" гэх)-д харьцуулсан харьцаа, хоёр дахь нь зах зээлийн үнэлгээнд арилжааны дүнгийн эзлэх хувь буюу хөрвөх чадвар юм.

Эхний үзүүлэлтээр "FTSE Russell"-ийн "Frontier" буюу "Хөгжиж буй зах зээл"-ийн ангилалд багтдаг улс орнуудыг жагсааж үзвэл Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг аль шатанд явж буйг харж болохоор байна.

График 1. "FTSE Russel"-ийн "Хөгжиж буй зах зээл"-ийн ангилал дахь улсуудын Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ба дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа

Хувь, 2021 он



Эх сурвалж: Дэлхийн Банкны "Хөрөнгийн зах зээлийн судалгаа", 2021 он

Монголын Хөрөнгийн Биржийн үйл ажиллагааг бүртгэлтэй хувьцаат компаниудын зах зээлийн үнэлгээ, арилжааны хэлцлийн тоо болон дүн, нийт бүртгэгдсэн үнэт цаасны тоо, гишүүн үнэт цаасны компаниудын тоо, болон зах зээлийн үнэлгээний өсөлтөөр хэмжиж болно. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн тус үзүүлэлтүүдийн тухай **Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл** бүлэгтэй танилцаж, дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Монголын Хөрөнгийн Биржийн үйл ажиллагааг 4 үндсэн төрөлд хуваадаг:

- ✓ Арилжаа зохион байгуулах үйлчилгээ: Үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг зохион байгуулах, үнэт цаас бүртгэх, арилжаанд оролцогч гишүүн үнэт цаасны компаниудыг бүртгэх зэрэг үйл ажиллагаа;

- ✓ Арилжааны өгөгдлийн сангийн мэдээлэл нийлүүлэх үйлчилгээ: Санхүүгийн мэдээллийн терминалууд болох Блүүмбэрг, Рефинитив (хуучнаар Томсон Ройтерс), Эксченж Дата Интернэйшнл болон дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчид, Үнэт цаасны компаниудад мэдээлэл нийлүүлэх үйлчилгээ;

- ✓ Мэдээлэл олон нийтэд хүргэх: Бүртгэлтэй компаниудын санхүүгийн, үйл ажиллагааны мэдээлэл, зах зээлийн үнэлгээ, индекс тооцоолж нийтэд мэдээлэхээс гадна хөрөнгийн зах зээлийн тойм мэдээлэл, арилжааны үр дүн, тайлангуудыг тогтмол олон нийтэд өөрийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслүүдээр Монгол, Англи хэл дээр хүргэх үйл ажиллагаа;

- ✓ Хөрөнгийн зах зээлийн тухай сургалтын үйл ажиллагаа: Хөрөнгийн зах зээлийн тухай мэдлэг олгох сургалтыг танхимаар болон цахимаар явуулах, олон нийтэд хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгохоор мэргэжлийн, боловсролын байгууллагуудтай хамтарч ажиллах зэрэг үйл ажиллагаа эрхэлж байна.

2.4.1. Арилжаа зохион байгуулах үйлчилгээ

2018 оноос 2022 оны эхний хагас жилийн хугацаанд 2,099.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжааг Монголын Хөрөнгийн Бирж зохион байгуулсан. Үүнээс 51.0 хувийг буюу 1,070 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий анхдагч зах зээлийн арилжаа, 49.0 хувийг буюу 1,029.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хоёрдогч зах зээлийн арилжаа бүрдүүлсэн байна. Тус хугацаанд компанийн бондын арилжаа 1,156.5 тэрбум төгрөгт хүрч, нийт арилжааны 55.1 хувийг эзлэх болсон байна. Нийт 816.0 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийсэн нь нийт арилжааны 38.9 хувийг эзэлж байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь анх 2021 онд зах зээлд нэвтэрсэн ба нийт арилжааны 2.9 хувь буюу 62.2 тэрбум төгрөгийн арилжааг эзэлсэн. Харин, хөрөнгө оруулалтын сан нь анх 2020 онд зах зээлд нэвтэрч, нийт арилжааны 3.1 хувийг эзэлж, дээрх хугацаанд 64.2 тэрбум төгрөгийн арилжаа явагдав. 2014-2020 онуудад явагдсан Засгийн газрын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 1,667.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд Олон Улсын Валютын Сангаас Монгол Улсад хэрэгжүүлсэн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд гадаад зээллэг авахыг улирлын шалгуур үзүүлэлтийн дагуу хориглосонтой холбоотойгоор 2017 оны 10 дугаар сараас хойш Засгийн газрын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй болно.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
9020020699
УЛААНБААТАР ХОТ
“ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК” ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

График 2. Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалагдсан үнэт цаасны төрөл ангилал, нийт арилжаанд эзлэх хувь

Хувь, 2018 – 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Дээрх арилжааг Монголын Хөрөнгийн Бирж зохион байгуулж, хяналт тавьж ажилласнаар арилжааны шимтгэлийн, хураамжийн орлогыг бүрдүүлдэг:

- ✓ Үнэт цаас гаргагч талаас бүрдүүлэх:
  - Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл хүлээн авах, хянах хураамж;
  - Үнэт цаас бүртгэх хураамж;
  - Анхдагч зах зээлд үнэт цаас худалдсаны шимтгэл;
  - Жилийн үйлчилгээний хөлс.
- ✓ Хөрөнгө оруулагч талаас бүрдүүлэх:
  - Худалдан авсан, худалдсаны арилжааны шимтгэл.
- ✓ Үнэт цаасны компаниудаас бүрдүүлэх:
  - Элсэлтийн хураамж;
  - Гишүүнчлэлийн улирлын тогтмол хөлс;
  - Арилжааны системд нэвтрэх эрх ашигласны хөлс.

ХӨРӨНГИЙН БИРЖ
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 91

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-03

Үнэт цаас гаргагч компаниуд үнэт цаасаа Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлж хямд өртөгтэй, их хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлэх боломжтой. Мөн компанийн засаглалын сайн тогтолцоо, чадварлаг боловсон хүчин, сайн удирдлагын баг бүрдсэнээр хөрөнгө оруулагчдад танигдах, цаашлаад зах зээлийн үнэлгээ эсвэл зээлжих зэрэглэл нь нэмэгдэх нөхцөлүүд бүрддэг.

Монголын Хөрөнгийн Бирж нь аливаа үнэт цаасыг бүртгэхдээ Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу, тодорхой шалгууртайгаар бүртгэдэг. Үнэт цаас гаргахтай холбоотой үе шатуудыг доорх схемээр харуулав.

Схем 7. Үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржид гаргах үе шат



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч компаниуд төлөх үнэт цаас бүртгүүлэх үйлчилгээний хөлс нь Монголын Хөрөнгийн Бирж дээрх I, II, III дугаар ангиллуудын алинд нь бүртгүүлэхээс хамаардаг ба нэмж үнэт цаас гаргах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, үнэт цаасаа бүртгэлээс хасуулахад мөн үйлчилгээний хөлс төлдөг байна. Мөн компанийн зах зээлийн үнэлгээнээс хамаарч жилийн үйлчилгээний хөлс төлдөг.

2005 оноос хойш 26 компани Монголын Хөрөнгийн Биржид шинээр бүртгүүлсэн бол дунд хугацаанд шинээр бүртгүүлэх компаниуд улам нэмэгдэх төлөвтэй байна. Монголын Хөрөнгийн Биржээр төрийн өмчит компаниудын хувьцааг нийтэд нээлттэй худалдах, олон нийтийн хяналтад шилжүүлэх төрийн өмчит хуулийн этгээдүүдийн жагсаалтыг баталсан. Монголын Хөрөнгийн Биржид 100 хувь төрийн өмчит 17 компани, төрийн өмчийн оролцоотой 10 компани бүртгэлтэй байгаа. Мөн

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 № 2074096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 № 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

арилжааны банкнуудыг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулж, хувьцааг нь нийтэд санал болгох тухай хуулийн төсөл 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар нийт 2 банк Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлж, хувьцаагаа нээлттэй арилжаалсан байна.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар 2005 оноос хойш нийт 31 компани Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгох буюу IPO хийж, нийт 258.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг анхдагч зах зээлээс татан төвлөрүүлсэн ба Монголын Хөрөнгийн Бирж нь аливаа саатал, алдаагүйгээр арилжааг амжилттай зохион байгуулсан. Тус хугацаанд нэмж хувьцаа гаргах замаар хөрөнгө татан төвлөрүүлэх арилжааг давхардсан тоогоор 12 компани 13 удаагийн арилжаагаар нийт 64.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлсэн байна. Компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааны хувьд давхардсан тоогоор 18 компани 92 удаагийн арилжаагаар нийт 829.4 тэрбум төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлсэн. Ийнхүү Монголын Хөрөнгийн Бирж нь өнгөрсөн 31 жилд нийт 71 шинэ үнэт цаас, 1.2 их наяд төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхэд оролцсон байна.

Гишүүн үнэт цаасны компаниудыг зохицуулахын хүрээнд Монголын Хөрөнгийн Бирж нь арилжаанд оролцох эрхийг олгох, сэргээх, хязгаарлах, цуцлах, гишүүнээр элсүүлэхэд үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, дунд хугацааны бизнес төлөвлөгөө, өөрийн хөрөнгийн зохистой хэмжээнд тодорхой шалгууруудыг тодорхойлж ажилладаг. Түүнчлэн, Үнэт цаасны компаниуд нь ёс зүйтэй мэргэжлийн өндөр түвшинд ажиллахыг баталсан баталгаа, программ хангамж, дотоод үйл ажиллагаандаа дагаж мөрдөх журмуудыг боловсруулсан эсэхийг харгалзаж, өндөр шалгууруар гишүүдээ бүртгэдэг.

Үнэт цаасны компаниуд нь арилжаанд оролцохын тул Монголын Хөрөнгийн Биржийн дээрх гишүүнчлэлийг шалгууруудыг хангасан байх шаардлагатай ба Үнэт цаас гаргагчид элсэлтийн хураамж, гишүүнээр элссэний дараа гишүүнчлэлийн улирлын тогтмол хөлс, арилжааны системд нэвтрэх эрх ашигласны хөлс мөн төлдөг байна.

СЭХ БҮРТГЭВ №91
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2022-12-12 БҮРТГЭВ-02

Схем 8. Үнэт цаасны компани Монголын Хөрөнгийн Биржийн гишүүнээр элсэх үйл явц

Монголын Хөрөнгийн Биржид хүсэлт гаргана	Холбогдох баримтуудыг илгээнэ Шаардлага хангасан тохиолдолд Монголын Хөрөнгийн Бирж нь дүгнэлтийг гаргаж Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлнэ
Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авна	Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа"-ны тусгай зөвшөөрлийг авна
Гишүүнээр элсүүлэх шийдвэр	Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ийн хурлаас гишүүнээр элсүүлэх тухай шийдвэр гарна
Гишүүнчлэлийн гэрээг байгуулна	Гишүүнчлэлийн хураамжийг төлснөөр гэрээ хийгдэж, гишүүн болно

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

2.4.2. Арилжааны өгөгдлийн сангийн мэдээлэл нийлүүлэх үйлчилгээ

Монголын Хөрөнгийн Бирж нь бусад олон улсын биржүүдийн жишгээр гадаадын болон дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагч, судлаач, шинжээчдэд зориулж Блүүмбэрг, Рефинитив зэрэг мэдээллийн терминалуудад тогтмол арилжааны өгөгдлийн сангийн мэдээлэл нийлүүлдэг ба ийнхүү мэдээлэл нийлүүлсний хураамжийг тус мэдээллийн терминалын үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудаас бүрдүүлдэг байна.

Мөн гишүүн үнэт цаасны компаниуд болон бусад оролцогчдод арилжааны дэлгэрэнгүй мэдээллийг тухай бүр, захиалгын сангийн дэлгэрэнгүй мэдээллүүдийг 2 хүртэл минутын хоцрогдолтойгоор нийлүүлдэг бол сүүлд нэвтрүүлсэн FAST протоколын дагуу бодит цагийн горимоор ч мөн тухайн мэдээллүүдийг нийлүүлж ажилладаг билээ.

Мөн хөрөнгө оруулагчдад арилжааны жигнэсэн дундаж ханшийн, 6 сар болон 52 долоо хоногийн дундаж ханш, арилжааны болон ханшийн товч мэдээг тодорхой хураамжтайгаар гаргаж өгч ажилладаг.

ХӨРӨНГИЙН БИРЖ МОНГОЛЫН STOCK EXCHANGE 9020020699 2071096 УЛААНБААТАР
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

СӨХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2.4.3. Мэдээлэл олон нийтэд хүргэх үйлчилгээ

Монголын Хөрөнгийн Бирж нь өдөр тутмын арилжааны мэдээ, үр дүн, тайлан, Засгийн газрын үнэт цаасны арилжааны мэдээ, индексүүдийн өөрчлөлтүүдийг тогтмол тооцоолж, мэдээлэхээс гадна цахим сонин, тайлан зэрэг цогц товхимлуудыг бэлтгэдэг. Мөн бүртгэлтэй хувьцаат компаниудын засаглал болон өөрчлөлтүүдийн тухай, санхүүгийн үзүүлэлтүүд, шийдвэр, ногдол ашиг хуваарилах төлөвлөгөө зэрэг Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын олон нийтэд мэдэгдэх шаардлагатай мэдээллүүдийг тогтмол бүрдүүлж, хөрөнгө оруулагчид болон зах зээлд оролцогч талуудад нээлттэй, ойлгомжтой хэлбэрээр түгээдэг. Түүнчлэн, гишүүн үнэт цаасны компаниудын ерөнхий танилцуулга, санхүүгийн үзүүлэлтүүд, арилжааны идэвх, зөрчил гэх мэт мэдээллүүдийг цахим хуудсандаа байршуулж, өөрчлөлт гарсан тухай бүр шинэчилдэг байна.

Монголын Хөрөнгийн Бирж нь гишүүн үнэт цаасны компаниуд болон бүртгэсэн хувьцаат компаниудын мэдээллийг өөрийн цахим хуудсандаа байршуулж, тогтмол шинэчлэн олон нийтэд хүртээмжтэй байдлаар хүргэхэд тайлагналын стандартыг тогтоосон байдаг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар гишүүнчлэлтэй холбоотой 3 журам, 4 заавар маягтууд байна.

Схем 9. Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудын нийтэд нээлттэй мэдээллүүд



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

2.4.4. Хөрөнгийн зах зээлийн тухай сургалтын үйл ажиллагаа

Монголын Хөрөнгийн Бирж нь үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг танхимаар болон цахимаар явуулдаг ба хөрөнгийн зах зээлд

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
9020020699 2071016
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 13
БҮРТГЭВ-02

ажиллах мэргэжлийн боловсон хүчний эрэлт, хэрэгцээг хангах, олон нийтэд үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох замаар үнэт цаасны зах зээлийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулдаг. Тус сургалт нь 2005 оноос эхлэн тогтмол зохион байгуулагдсан бөгөөд 17 жилийн хугацаанд нийт 15,000 хөрөнгийн зах зээлд сонирхолтой хувь хүн, хөрөнгө оруулагчдыг сургалтад хамруулсан амжилттай байна. Цаашид энэхүү үйл ажиллагааг улам тэлж, өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд **Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө** хэсгээс дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана уу.

2.5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНААЧИЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

2.5.1. ТОП-20 индексийг тооцож эхэлсэн нь

1995 оны 8 дугаар сарын 28-нд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй, зах зээлийн үнэлгээ өндөртэй 75 үнэт цаасыг сонгон ТОП-75 индексийг анхлан тооцож эхэлсэн. Харин 2003 оноос зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэх 20 компанийн үзүүлэлтээс бүрдэх ТОП-20 индексийг тооцох болсон. Үнэт цаас гаргагчийн Үнэт цаасны индекс тооцох журмын дагуу Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй бүх компанийг зах зээлийн үнэлгээ, арилжааны өдрийн дундаж гүйлгээ гэсэн 2 үзүүлэлтээр ранк тогтоож ангилах ба жил бүрийн ажлын эхний 10 өдөрт багтаан ТОП-20 индексийн багцыг шинэчлэн тогтоодог байна.

2022 оны 11 дүгээр сарын байдлаар ТОП-20 индексэд дараах компаниуд бүртгэлтэй байна.

Хүснэгт 10. ТОП-20 индексийн багцын бүрдүүлэлт

№	Симбол	Компанийн нэр	Зах зээлийн үнэлгээ	Үйл ажиллагааны чиглэл
1	APU	"АПУ" ХК	1,493.5	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
2	AIC	"Ард Даатгал" ХК	18.8	Албан журмын нийгмийн даатгалаас бусад даатгал, давхар даатгал, тэтгэврийн санхүүжилтийн үйл ажиллагаа
3	ADB	"Ард Кредит ББСБ" ХК	26.7	Санхүүгийн бусад үйл ажиллагаа
4	AARD	"Ард Санхүүгийн Нэгдэл" ХК	95.5	Санхүүгийн бусад үйл ажиллагаа
5	BDS	"Би Ди Сек" ХК	19.2	Санхүүгийн бусад үйл ажиллагаа
6	BODI	"Бодь Даатгал" ХК	29.7	Албан журмын нийгмийн даатгалаас бусад даатгал, давхар даатгал, тэтгэврийн санхүүжилтийн үйл ажиллагаа
7	GOV	"Говь" ХК	190.1	Нэхмэлийн үйлдвэрлэл
8	NEH	"Дархан Нэхий" ХК	19.8	Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
9	INV	"Инвескор ББСБ" ХК	349.0	Санхүүгийн бусад үйл ажиллагаа
10	LEND	"ЛэндМН ББСБ" ХК	21.8	Санхүүгийн бусад үйл ажиллагаа

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
6317839
1119277128
УЛААНБААТАР ХОТ

11	MNDL	"Мандал Даатгал" ХК	46.2	Албан журмын нийгмийн даатгалаас бусад даатгал, давхар даатгал, тэтгэврийн санхүүжилтийн үйл ажиллагаа
12	MMX	"Махимпекс" ХК	14.4	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
13	MNP	"Монгол Шуудан" ХК	86.4	Шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа
14	MFC	"Монос Хүнс" ХК	38.0	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
15	SUU	"Сүү" ХК	159.5	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
16	TTL	"Таван Толгой" ХК	431.9	Чулуун, хүрэн нүүрс олборлолт
17	TCK	"Талх Чихэр" ХК	31.7	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
18	TUM	"Түмэн Шувуут" ХК	60.5	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
19	UID	"Улсын Их Дэлгүүр" ХК	146.8	Машин, мотоциклээс бусад барааны жижиглэн худалдаа
20	ERDN	"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК	231.5	Металлын хүдэр олборлолт

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн цахим хуудас

График 3. ТОП-20 индекс, зах зээлийн үнэлгээ

Индекс, тэрбум төгрөг, 2003 оны 1 дүгээр сар - 2022 оны 12 дугаар сар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2003 оноос хойш ТОП-20 индекс нь тогтмол өсөлт үзүүлж ирсэн ба 2022 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 33,326.1 нэгжид хүрсэн байна. ТОП-20 индексийн багцын бүрдүүлэлтэд байгаа компаниудын зах зээлийн үнэлгээ 2022 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 3.4 их наяд төгрөг ба Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээний (5.4 их наяд төгрөгийн) 64.1 хувийг бүрдүүлж байна. Онцлон тодруулахад, ТОП-20 индексийн багцад багтаж буй "АПУ" ХК нь хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 28.8 хувийг дангаараа бүрдүүлдэг юм. ТОП-20 индексийн өөрчлөлтөөр тухайн индексэд орж буй 20 компанийн хувьцааны үнийн өсөлт, бууралтын өөрчлөлтийг харах ба 2003 оны 1 дүгээр сарын үзүүлэлттэй харьцуулахад ТОП-20 индекс нь 2022 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 3,671.3 хувиар өссөн нь Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн өсөлтийг

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

харуулж байна. ТОП-20 индекс нь 2003 оноос хойш жилд дунджаар 2.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2.5.2. Давхар бүртгэлийн журмыг баталсан нь

2017 онд Монголын Хөрөнгийн Биржийн санаачилгаар үнэт цаасны давхар бүртгэлийн харилцааг зохицуулсан Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журмын төслийг боловсруулсан ба уг журам нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар батлагдсан байна. Дээрх журамтай нийцүүлэн Монголын Хөрөнгийн Биржээс үнэт цаасны давхар бүртгэлийг зохицуулах Үнэт цаасны бүртгэлийн журмыг шинэчлэн боловсруулж 2018 оны 2 дугаар сараас эхлэн мөрдөж эхэлсэн байна. Иймхүү хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, олон компаниудад давхар бүртгэлийн ач холбогдол, боломжийг сурталчилсны үндсэн дээр Канад Улсын Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй "Erdene Resource Development Corporation"-ийн үнэт цаасыг 2018 онд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэсэн нь хамгийн анхны давхар бүртгэлийг хэрэгжүүлсэн үйл явдал болсон.

2.5.3. MSE A болон MSE B индексүүдийг тооцож эхэлсэн нь

Монголын Хөрөнгийн Бирж нь биржийн бүртгэлийн I болон II ангиллын компаниудын үнэт цаасны үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлэх MSE A болон MSE B индексүүдийг 2018 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлэн тооцож эхэлсэн ба эдгээр индексүүдийг арилжааны программыг ашиглан арилжаа явагдсан өдөр бүр тооцдог.

Бүтцийн хувьд MSE A индексийн сагсанд Монголын Хөрөнгийн Биржийн бүртгэлийн I ангилалд багтсан компаниудын үнэт цаас орох ба бүртгэлийн I ангилалд дараах шалгуурыг хангасан компаниуд бүртгэгдэж байна. Үүнд:

- ✓ 10 тэрбум төгрөгөөс доошгүй зах зээлийн үнэлгээтэй;
- ✓ Сүүлийн жилд 5 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний борлуулалтын орлоготой эсхүл 1 тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай ажилласан;
- ✓ Нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх, эсхүл тухайн компанийн хувьцааны хагас жилд арилжигдсан үнийн дүн нь Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалагдсан хувьцааны нийт арилжааны үнийн дүнгийн 5 хувиас доошгүй хувь байх.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071996
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭЛ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭЛ-02

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар MSE A индексийн багцыг дээрх шалгууруудыг хангаж, бүртгэлтэй компаниудын I ангилалд бүртгэгдсэн дараах 21 компани бүрдүүлж байна.

Хүснэгт 11. MSE A индексийн багцын бүрдүүлэлт

№	Симбол	Компанийн нэр	№	Симбол	Компанийн нэр
1	APU	"АПУ" ХК	12	MNDL	"Мандал Даатгал" ХК
2	AIC	"Ард Даатгал" ХК	13	MMX	"Махимпекс" ХК
3	ADB	"Ард Кредит ББСБ" ХК	14	MIK	"Мик Холдинг" ХК
4	ARD	"Ард Санхүүгийн Нэгдэл" ХК	15	MNP	"Монгол Шуудан" ХК
5	BDS	"Би Ди Сек" ХК	16	MFC	"Монос Хүнс" ХК
6	BOGD	"Богд Банк" ХК	17	SUU	"Сүү" ХК
7	BODI	"Бодь Даатгал" ХК	18	TTL	"Таван Толгой" ХК
8	GOV	"Говь" ХК	19	TCK	"Талх Чихэр" ХК
9	NEH	"Дархан Нэхий" ХК	20	SBM	"Төрийн Банк" ХК
10	INV	"Инвескор ББСБ" ХК	21	TUM	"Түмэн Шувуут" ХК
11	LEND	"ЛэндМН ББСБ" ХК			

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн цахим хуудас

MSE B индексийн бүтцийн хувьд Монголын Хөрөнгийн Биржийн бүртгэлийн II ангилалд багтсан компаниудын үнэт цаас орох ба бүртгэлийн II ангилалд дараах шалгуурыг хангасан компаниуд бүртгэгдэж байна. Үүнд:

- ✓ 1 тэрбум төгрөгөөс доошгүй зах зээлийн үнэлгээтэй;
- ✓ 100 сая төгрөгөөс доошгүй хэмжээний цэвэр ашигтай;
- ✓ Нийт хувьцааны 25 хувиас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон байх.

Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах үеийн байдлаар MSE B индексийн багцыг дараах 45 компани бүрдүүлж байна.

Хүснэгт 12. MSE B индексийн багцын бүрдүүлэлт

№	Симбол	Компанийн нэр	№	Симбол	Компанийн нэр
1	ADL	"Адуун Чулуун" ХК	24	MCH	"Монголын Цахилгаан Холбоо" ХК
2	ITLS	"Айтүүлс" ХК	25	MIB	"Мониинжбар" ХК
3	EER	"Ариг Гал" ХК	26	NXE	"Нэхээсгүй Эдлэл" ХК
4	ATR	"Атар-Өргөө" ХК	27	RMC	"Ремикон" ХК
5	BAN	"Багануур" ХК	28	SEND	"Сэндли ББСБ" ХК
6	BNG	"Баянгол Зочид Буудал" ХК	29	CUMN	"Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
9020020698 № 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 № 1119277128
УЛААНБААТАР ХОТ

7	BTG	"Баянтээг" ХК	30	VIK	"Тандэм Инвэст ББСБ" ХК
8	BEU	"Бэрх Уул" ХК	31	TAH	"Тахь-ко" ХК
9	GHC	"Ган Хийц" ХК	32	TEX	"Техник Импорт" ХК
10	HRM	"Гермес Центр" ХК	33	BUK	"УБ-БҮК" ХК
11	GTL	"Гутал" ХК	34	UBH	"Улаанбаатар Хивс" ХК
12	DZG	"Дархан Зочид Буудал" ХК	35	UID	"Улсын Их Дэлгүүр" ХК
13	DES	"Дорнод Худалдаа" ХК	36	MDR	"Фронтиер Лэнд Групп" ХК
14	JTB	"Женко Тур Бюро" ХК	37	HBO	"Хай Би Ойл" ХК
15	SUL	Жуулчин Дюти Фрий ХК	38	HSR	"Хасу-Мандал" ХК
16	BUN	"Крипто Үндэстэн" ХК	39	ADU	"Хөвсгөл Алтан Дуулга" ХК
17	MIE	"Материалимпекс" ХК	40	SHG	"Шарын Гол" ХК
18	BDL	"Могойн Гол" ХК	41	SHV	"Шивээ Овоо" ХК
19	MBW	"Монгол Базальт" ХК	42	ETR	"Э-Транс Ложистикс" ХК
20	MDIC	"Монгол Даатгал" ХК	43	ERDN	"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК
21	MNH	"Монгол Нэхмэл" ХК	44	AMT	"Эрдэнэс Сольюшинс" ХК
22	UYN	"Монгол Савхи" ХК	45	BOE	"Эрчим Баян Өлгий" ХК
23	MSH	"Монгол Шилтгээн" ХК			

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн цахим хуудас

График 4. MSE A болон MSE B индекс

Индекс, 2008 оны 1 дүгээр сар - 2022 оны 10 дугаар сар



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн цахим хуудас

MSE A болон MSE B индексүүдээр тухайн индекс тооцох багцад орсон үнэт цааснуудын үнийн ерөнхий өөрчлөлтийг харах ба 2018 оны 1 дүгээр сараас 2021 оны 2 дугаар сар хүртэл тус хоёр индекс нь буурсан үзүүлэлттэй байсан бол 2021 оны 2 дугаар сараас тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2.5.4. "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга, "Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль" батлагдсан нь

Хөрөнгийн зах зээлийн хууль эрх зүйн орчныг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд 2011 оноос "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга, "Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль"-ийг шинээр боловсруулах ажил эхэлсэн ба энэхүү хуулиудыг боловсруулахад олон улсын сайн туршлагуудыг харьцуулан судалж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн дараагийн жилүүдийн алсын харааг тодорхойлон, зах зээлийг хөгжүүлэхэд шаардагдаж буй хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх санал зөвлөмж гаргахад Монголын Хөрөнгийн Биржийн удирдлага болон хамт олны үүрэг оролцоо чухал байсан. Иймхүү хуулийн шинэчлэн найруулгад дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- ✓ Үнэт цаасны давхар бүртгэл буюу гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй байгаа үнэт цаасыг дотоодын хөрөнгийн биржид давхар бүртгүүлэн арилжих, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд нээлттэй арилжих, мөн одоогоор хараахан нэвтрээгүй байгаа ч хадгаламжийн бичиг, үүсмэл үнэт цаасны олон төрлүүдийг арилжих суурь тавигдсан.

- ✓ Үнэт цаасны зах зээлд оролцогчдод тавигдах шаардлагыг тодорхой тусгаж, "тохиромжтой этгээд" гэдэг ойлголтыг хуульд тусгаснаар зах зээлийн удирдлагын ёс зүйн болон мэргэжлийн түвшнийг нэмэгдүүлэх үндэслэл болсон. Мөн "Өөрийгөө зохицуулах байгууллага"-ын тухай ойлголтыг нэвтрүүлж, хөрөнгийн зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, зохицуулалтын зөв хандлагыг бий болгох, хяналт шалгалтын тогтолцоог бий болгох боломж бүрдсэн.

2.5.5. Хийсвэр арилжааны системийг нэвтрүүлсэн нь

Монголын Хөрөнгийн Бирж нь иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоог нэмэгдүүлэх, зах зээлийн мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор 2018 онд хийсвэр арилжааны систем буюу Orderbook системийг нэвтрүүлсэн. Тус системийг ашиглан хөрөнгө оруулагчид үнэ төлбөргүйгээр үнэт цаас авах, зарах захиалгын түвшнийг харах, зах зээлийн индексүүдийн өөрчлөлтийг бодит цагийн горимоор илүү нарийвчилсан байдлаар харахаас гадна хийсвэр мөнгөөр арилжаанд орж, хөрөнгө оруулалтын ашиг, алдагдлаа өдөр бүрийн арилжааны үр дүнгээр хянах боломжтой юм. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үед тус системд 3,150 харилцагч бүртгүүлэн арилжаанд оролцож байна.

2.5.6. "Ногоон сум" реалити шоуг зохион байгуулсан нь

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020699
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Иргэд, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн мэдлэгийг нэмэгдүүлэх болон хувьцаа, бондын арилжаанд хэрхэн оролцох тухай мэдээллийг олон нийтэд богино хугацаанд сонирхолтой, үр дүнтэйгээр хүргэх зорилготой Монголын Хөрөнгийн Бирж нь МҮОНРТ-тэй хамтран "Ногоон сум" реалити шоуг зохион байгуулж, 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс 2018 оны 2 дугаар сарын 5-ны өдрийг хүртэл орон даяар нэвтрүүлсэн байна. Уг реалити шоу нэвтрүүлэгт хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцож байгаагүй олон нийтийн төлөөлөл болох 5 оролцогч оролцсон бөгөөд мэргэжлийн зөвлөх байгууллагуудаас зөвлөгөө авсны үндсэн дээр нийт 5 сая төгрөгөөр Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй үнэт цаас худалдан авч оролцсон юм. Нэвтрүүлэг нь тус бүр 40 минут үргэлжлэх 7 удаагийн дугаараас бүрдсэн бөгөөд нэвтрүүлгийн эцэст хөрөнгө оруулалтын багцаа хоёр сар гаруйн хугацаанд 64.4 хувиар өсгөсөн оролцогч ялагчаар тодорсон. Тус реалити шоуны үр дүнд ард иргэдэд хөрөнгийн зах зээлийн тухай тодорхой хэмжээний мэдлэгийг олгож, үнэт цаасны арилжаанд оролцох сонирхлыг нэмэгдүүлж, иргэдийн үнэт цаасны арилжаанд оролцох идэвхэд нэлээд ахиц дэвшил гарсан.

2.5.7. Ханшийн лавлагааны үйлчилгээг цахимжуулсан нь

Монголын Хөрөнгийн Биржийн арилжааны гишүүд нь өөрсдийн арилжааны терминалаас харилцагчдын үнэт цаасны эзэмшлийн лавлагааг авах боломжтой. Үүнээс гадна өв залгамжлах гэрчилгээгээр үнэт цаас шилжүүлэх хүсэлт гаргасан иргэдэд үнэт цаасны ханшийн лавлагааг гаргаж өгөх үйлчилгээг 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс "Гэрэгэ Системс" ХХК-ийн Гэрэгэ киоскоор дамжуулан олгож эхэлсэн. Гэрэгэ киоск нь татвар, тээвэр, шүүх, харилцаа холбоо, эрүүл мэнд, даатгалтай холбоотой төрийн болон хувийн байгууллагуудын 30 гаруй төрлийн үйлчилгээг үзүүлэн, улсын хэмжээнд 147 байршилд ажиллаж байна. 2021 оны байдлаар 258 иргэн, 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар 215 иргэн Гэрэгэ киоскоор үнэт цаасны ханшийн лавлагааны мэдээлэл авах үйлчилгээ авсан байна.

2.5.8. Компанийн засаглалын үнэлгээ гүйцэтгэх болсон нь

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс" дагуу хувьцаат компаниудын үйл ажиллагаанд дагаж мөрдүүлэх, кодексийн хэрэгжилттэй холбогдох тайланг кодексийн хавсралтад заасан маягтын дагуу хүлээн авч, нэгтгэн, олон нийтэд мэдээлэх, кодексийн хэрэгжилтийн тайлангийн үнэлгээнээс хамаарч үнэт цаасны бүртгэлийн ангилалд өөрчлөлт оруулах ажлыг Монголын Хөрөнгийн Биржид үүрэг болгосон. Уг ажлын хүрээнд Монголын Хөрөнгийн Бирж нь "Компанийн засаглалын кодексийг үнэлэх аргачлал"-ыг шинэчлэн баталсан ба 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн бүртгэлтэй компаниуд нь уг шинэчилсэн

"Компанийн засаглалын кодекс"-ийг дагаж мөрдөн, хэрэгжилтийн тайланг Монголын Хөрөнгийн Биржийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн А/58 тоот тушаалын 1 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу үнэлж, жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Монголын Хөрөнгийн Биржид тайлагнаж байна. Үнэт цаас гаргагч нь 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 47 компанийн тайлан, нотлох баримтад үндэслэн үнэлгээ хийж, тайланг олон нийтэд танилцуулж, "Компанийн засаглалын кодекс" болон "Байгаль орчин, нийгэм, засаглалын тогтвортой байдлын тайлагнал, аргачлал" сэдвүүдээр сургалт зохион байгуулж, бүртгэлтэй компаниудад "Компанийн засаглалын кодекс"-ийн тухай заавар зөвлөмж хүргүүлж ажиллаж байна.

2.5.9. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх болон Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэн арилжих болсон нь

Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалагдах боломжтой санхүүгийн хэрэгсэл, бүтээгдэхүүнүүдийн тоо төрөлжиж, хөрөнгө оруулалтын сантай холбоотой зохицуулалтыг бий болгож, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлснээр дотоодын аж ахуйн нэгжүүд болоод хувь хүмүүс, цаашлаад гадаадын хөрөнгө оруулагчдад өөрсдийн хөрөнгийг санхүүгийн мэргэшсэн байгууллагаар дамжуулан хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд ашиглах боломж нээгдсэн юм. Түүнчлэн хөрөнгийн зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагч бий болох, улмаар уг зах зээлийн хөгжлийг дэмжих, хурдасгах замаар санхүүгийн зах зээлийн тэнцвэрт тогтолцоо бүрэлдэхэд дэмжлэг болсон гэж үзэж байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас арилжигдаж эхэлснээр банк, санхүүгийн байгууллагуудад хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжилтийн шинэ суваг нээгдэх, иргэдэд тогтмол хугацаат хүүгийн орлого бүхий эрсдэл харьцангуй багатай хөрөнгө оруулалтын шинэ бүтээгдэхүүн санал болгох боломж бүрдсэн юм. Учир нь олон улсын жишигт банк, санхүүгийн байгууллагууд активаа багцлан үнэт цаасжуулж, хөрөнгийн зах зээлд худалдан санхүүжилт татах замаар эрсдэлээ хуваалцах нь түгээмэл байдаг.

2.5.10. Монголын Хөрөнгийн Биржийн шинээр хөгжүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ

- ✓ Exchange Trade Fund /ETF/ буюу биржээр арилжаалдаг сангийн журмын боловсруулалт;
- ✓ Хадгаламжийн бичгийн бүртгэл, арилжаа;
- ✓ Хөрөнгө оруулагчдад зориулсан аппликэйшн;

✓ Түүхий эдийн спот арилжаа.

Үнэт цаас гаргагчийн Монголын хөрөнгийн зах зээлд шинээр нэвтрүүлэхээр зорьж ажиллаж буй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй **Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги** бүлгээс танилцана уу.

2.6. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Монгол Улс нь "Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт", "Алсын хараа-2050" зэрэг бодлогын хүрээнд 2030 он гэхэд хүлэмжийн хийг 22.7 хувиар бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, амьдралын чанар, хүний хөгжлийг сайжруулж, чанартай боловсрол, сайн засаглалыг бий болгох замаар тогтвортой хөгжлийг хангах зорилт тавьсан билээ.

Төр засгийн зүгээс баримталж буй дээрх бодлогын хүрээнд Монголын Хөрөнгийн Бирж нь хувийн хэвшлийн томоохон төлөөлөл болсон үнэт цаас гаргагч болон гишүүн үнэт цаасны компаниудын үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зорилгуудад нийцүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх замаар дотоодын хөрөнгийн зах зээлийг олон улсын стандартад нийцүүлж, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилгуудыг хангахад онцгой чухал үүрэгтэйгээр оролцох бодлого баримталж байна.

Дэлхий даяар хөрөнгө оруулагчдын хувьд тогтвортой хөгжлийн асуудал нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад гол шалгуур болж буй тул хөрөнгийн зах зээлд ESG буюу Байгаль орчин, нийгэм, засаглал (цаашид "БОНЗ" гэх)-ын үзүүлэлт, ил тод байдлын стандартыг нэвтрүүлэх нь зайлшгүй хийх шаардлагатай ажил юм. Зарим олон улсын судалгаагаар ESG зарчмуудыг мөрдөж буй судалгаанд хамрагдсан компаниудын 88 хувийнх нь үйл ажиллагааны үр ашиг сайжирсан, 80 хувийнх нь хувьцааны ханшинд эерэг нөлөө үзүүлсэн, 90 хувийнх нь санхүүжилтийн зардал буурсан үр дүнг харуулсан байна[1]. Мөн Маккинзигийн ESG зарчмуудыг мөрддөг компаниудын хувьцааны үнэ ханшинд үзүүлсэн нөлөөллийн талаарх 2,000 гаруй

[1]https://www.jhinvestments.com/viewpoints/esg/strong-esg-practices-offer-advantages
[2]https://www.mckinsey.com/~/media/McKinsey/Business%20Functions/Strategy%20and%20Corporate%20Finance/Our%20Insights/Five%20ways%20that%20ESG%20creates%20value/Five-ways-that-ESG-creates-value.ashx

судалгаанд ESG practice компаниудын 63 хувийнх нь хувьцааны өгөөжид эергээр нөлөөлсөн байна.[2]

Монголын Хөрөнгийн Бирж нь 2017 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид "НҮБ" гэх)-ын харьяа байгууллагуудын дэргэдэх "Тогтвортой хөрөнгийн бирж санаачилга"-д элссэн. Үүний хүрээнд тодорхой ажлууд хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал:

2.6.1. Бүртгэлийн журамд өөрчлөлт оруулж, ногоон төслүүдийг бүртгэлийн шалгууруас чөлөөлөх, хөнгөлөх болсон

Одоогийн мөрдөгдөж буй Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журамд Тогтвортой хөгжлийн зорилгуудад нийцсэн үйл ажиллагаа явуулдаг (үүнд ногоон бонд хамаарна) компани үнэт цаас гаргах тохиолдолд үнэт цаасны бүртгэлийн хураамжийг **20 хүртэл хувиар хөнгөлөх**, бүртгэлийн I, II дугаар ангиллын **шалгууруас хөнгөлөх, чөлөөлөх** тухай зохицуулалтыг 2018 онд тусгасан байдаг.

2022 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ийн 9 тоот тогтоолоор Үнэт цаасны бүртгэлийн журамд нэмэлт өөрчлөлт оруулж, НҮБ-аас тодорхойлсон тогтвортой хөгжлийн зорилгуудад чиглэсэн үйл ажиллагааны дотоодын, эсхүл олон улсын ангилал, тодорхойлолт буюу "Тогтвортой хөгжлийн таксономи"-д нийцсэн болон Монгол Улсын "Ногоон таксономи", эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу "ногоон", байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг санхүүжүүлэх тохиолдолд I, II дугаар ангиллын шалгууруас хөнгөлөх, эсвэл чөлөөлөх боломжтой болсон. Түүнчлэн эдгээр зорилгоор үнэт цаас гаргаж бүртгүүлэх тохиолдолд үнэт цаасыг бүртгэх үйлчилгээний хөлсийг тодорхой хувиар хөнгөлөх болсон.

"Ногоон таксономи" нь хүлэмжийн хий, агаар орчны бохирдлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлт бөгөөд банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид энэхүү таксономийг ногоон зээл, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлохдоо ашиглах боломжтой юм. Монгол Улсын "Ногоон таксономи"-ийг 2019 онд баталсан бөгөөд 2021 онд шинэчлэн батлагдсан Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам болон Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журамд мөн адил Ногоон бонд, "Ногоон таксоном"-ийн тухай тодорхой заалтууд тусгагдсан.

2.6.2. БОНЗ (ESG), тогтвортой тайлагналын стандарт удирдамж

2021 онд Үнэт цаас гаргагч нь "Тогтвортой хөрөнгийн бирж" төслийг НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, Олон Улсын Санхүүгийн Корпорац (цаашид "ОУСК" гэх), ТоС Холбоо зэрэг байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн бөгөөд үүний хүрээнд 2022 онд БОНЗ (ESG), тогтвортой тайлагналын стандарт удирдамжийг боловсруулж батлуулсан. БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын стандарт удирдамж нь Монгол Улсын нөхцөл байдал болон олон улсын Парисын хэлэлцээр, Алсын хараа-2050 зорилтуудтай бүрэн нийцсэн, бүртгэлтэй хувьцаат компаниуд мөрдөх, хэрэгжүүлэхэд ойлгомжтой тайлбарлагдсан удирдамж юм. Уг удирдамжийг Үнэт цаас гаргагч нь ТоС Холбоотой хамтран боловсруулсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос сайшаан баталсан болно.

НҮБ-ын Тогтвортой хөрөнгийн биржүүдийн санаачилгын гишүүн 130 биржүүдээс 67 нь БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж боловсруулан нийтэлсэн байна. Олон нийтэд танигдсан Нью-Йоркийн Хөрөнгийн Бирж, Лондонгийн Хөрөнгийн Биржүүд нь мөн адил удирдамжийг 2020, 2021 онуудад тус тус боловсруулан баталж, Тогтвортой хөрөнгийн биржүүдийн санаачилгын платформ дээр нийтэлсэн байдаг.

"Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журмын төсөл"-ийг батлуулснаар компаниудын ил тод байдлыг сайжруулах, мэдээлэл хүргэх процессыг хялбаршуулах, олон нийтэд түргэн шуурхай хүргэх зохицуулалт сайжирч байгаагаас гадна ESG буюу БОНЗ-ын тайлагналын стандартыг зах зээлд нэвтрүүлсэн.

Аж ахуйн нэгжүүд өөрсдийн санаачилгаар БОНЗ-ын бодлого нэвтрүүлэх, хүрээлэн буй орчин ба нийгмийн хөгжилд эерэг нөлөөлөл бүтээх нь түгээмэл болсон хэдий ч уг хүчин чармайлтаа тогтмол тайлагнах нь ховор байна. 2021 онд хийгдсэн судалгаагаар Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй, судалгаанд хамрагдсан 42 компанийн 13 хувь нь БОНЗ-ын үзүүлэлтээ олон нийтэд мэдээлж байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан компаниуд байгаль орчин, нийгэм, засаглалд үзүүлж буй нөлөөллөө хэмжих удирдамжаар хангаж, чадавхыг нь бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлбэл БОНЗ, тогтвортой байдлын тайлагналыг олон улсын стандартын дагуу боловсруулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

Үнэт цаас гаргагч нь БОНЗ, Тогтвортой байдлын тайлан боловсруулах удирдамждаа зөвхөн нэг стандартыг мөрдлөг болгохгүй, зөвхөн нэг оролцогч бүлэгт төвлөрч тайлагнахгүй байхыг зөвлөсөн. 2022 оны байдлаар олон улсад хамгийн түгээмэл ашиглагдаж буй стандартууд нь Тайлагналын Олон Улсын Санаачилга (цаашид "ТОУС/GRI" гэх) болон Тогтвортой Байдлын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын зөвлөл (SASB)-ийн стандартууд байна. ТОУС-ын онцлог нь 2022 оны 3 дугаар сараас эхлэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх) болон ТОУС-ын ил тод байдлыг уялдуулах, аж ахуйн нэгжүүд зөвхөн

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

санхүүгийн байдлаа бус БОНЗ-ын үзүүлэлтүүдээ стандартын дагуу тайлагнахыг дэмжих зорилготой ба ТОУС байгууллага нь хөрөнгийн зах зээлийн сангуудтай олон талт стандартыг уялдуулах хамтын ажиллагааны гэрээ байгуулаад байгаа юм.

2.6.3. Үнэт цаас гаргагчийн БОНЗ-ын бодлого, тогтвортой хөгжлийн хүрээнд цаашид хийж гүйцэтгэх ажлууд

Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд дараах үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж, холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн:

1. *Монголын хөрөнгийн зах зээлд БОНЗ-ын тайлагналын стандартыг хэрэгжүүлэх*

Энэ ажлын хүрээнд зах зээлийн зохицуулалт, шаардлага, хэрэгжилтийг сайжруулах, хөрөнгө оруулагчдад зориулсан цахим сувгууд, БОНЗ-ын дата бааз үүсгэх, зах зээлд оролцогчдыг чадавхжуулах, БОНЗ-ын үлгэр жишээ шилдэг практикуудыг танилцуулах, урамшуулах зэрэг ажлыг хийнэ.

2. *Тогтвортой хөгжлийн санхүүжилтийн ангилал үүсгэж, үр дүнгийн хэмжилтийн систем нэвтрүүлэх*

Энэ чиглэлд тогтвортой хөгжлийн зорилттой нийцэх үнэт цаас гаргагчдын ангиллыг бий болгох, энэхүү зорилттой нийцэх төслийн санхүүжилтийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх (анхны Тогтвортой хөгжлийн зорилтын бонд гаргах зэрэг), төслийн үр дүнг хэмжиж, олон нийтэд танилцуулах зэрэг ажлууд багтана.

3. *Тогтвортой хөгжлийн зорилтуудын нөлөөллийн стандартыг нэвтрүүлэх*

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхдээ үнэт цаас гаргагчид болон хөрөнгө оруулалтын сангуудтай зөвлөлдөж, туршиж үзсэний үндсэн дээр бүртгэлийн журам болон тайлагналын холбогдох журмуудад шаардлагатай өөрчлөлтүүдийг тусгаж, үр дүнг хэмжих стандартыг нэвтрүүлэх хөшүүргийг бий болгох зэрэг ажлуудыг хийнэ.

4. *Тогтвортой хөгжлийн индекс үүсгэх*

Тогтвортой хөгжлийн индекс үүсгэх, тооцох аргачлал боловсруулж, холбогдох журам, дүрэм, баримт бичгүүдэд өөрчлөлт оруулах, Монголын Хөрөнгийн Биржийн арилжааны системд индексийг нэвтрүүлж, индексэд орох хувьцаат компаниудын жагсаалт үүсгэн зах зээлд нэвтрүүлэх, хөрөнгө удирдах эрх бүхий этгээдүүд ижил төстэй индекс үүсгэх хөшүүрэг бий болгох, дэмжиж уриалах болно.

MONGOLIAN STOCK EXCHANGE

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

5. Жендерийн тэгш байдлыг эрхэмлэх

Жендерийн асуудлуудыг хөндөх, нөхцөл байдлыг сайжруулах талаар аж ахуйн нэгжүүдэд зориулсан жишиг дүрэм, журам, аргачлал боловсруулж нэвтрүүлэх, Бүртгэлийн журам болон бусад шаардлагатай дүрэм, журамд жендерийн тэгш байдлыг эрхэмлэх заалтууд тусгах зэрэг ажлуудыг хийнэ.

Үнэт цаас гаргагч нь дээр дурдсан ажлуудаас 2023 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна:

- ✓ Олон улсын 130 гишүүн Хөрөнгийн Бирж бүхий НҮБ-ийн хөтөлбөр болох Тогтвортой хөрөнгийн бирж санаачилга болон бусад олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, олон улсын шилдэг практикуудыг Монгол Улсад нэвтрүүлэх;
- ✓ GRI буюу Тайлагналын Олон Улсын Санаачилгын стандартын дагуу тайлан бэлтгэх, аргачлал боловсруулах, хянах сургалтад өөрийн мэргэжилтнүүдийг хамруулж, цаашид бүртгэлтэй хувьцаат компаниуд, хөрөнгө оруулагчид болон гишүүн үнэт цаасны компаниудад ТОУС-ын дагуу тайлагнасан БОНЗ-ын тайланг хэрхэн боловсруулах тухай зааж сургахад бэлтгэн чадваржуулах;
- ✓ Тогтвортой санхүүжилт хариуцсан нэгж байгуулж, БОНЗ, Тогтвортой хөгжлийн зорилтуудын гүйцэтгэлд хяналт тавин, салбарт оролцогчдыг дэмжиж ажиллах;
- ✓ БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж, аргачлалыг нарийвчлан сайжруулж, тогтмол мөрдөж тайлагнадаг болох зэрэг ажлуудыг хийнэ.

2.7. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН СИСТЕМ, ТҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн зах зээлийн арилжаа зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг зохион байгуулах, үнэт цаасны арилжаа, бүртгэлтэй компани, гишүүн үнэт цаасны компаниудын үйл ажиллагаанд хяналт тавих, зах зээлийн оролцогчдыг мэдээ, мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагааг явуулах цогц системийн тогтолцоог бий болгосон.

Монголын Хөрөнгийн Бирж нь олон улсын стандартад нийцсэн мэдээлэл, технологийн цогц дэд бүтцийг бүрэн бүрдүүлснээс гадна мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангахад ихээхэн анхаарч ажилладаг. Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа ISO/IEC17799:2005, ISO27001:2013,

MONGOLIAN STOCK EXCHANGE

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ 02

ISO/IEC38500:2015 стандартуудын дагуу боловсруулагдсан Монголын Хөрөнгийн Биржийн Мэдээллийн технологийн цогц журмыг мөрдөж, хяналт тавьж ажилладаг. Тухайлбал, Монголын Хөрөнгийн Бирж нь олон улсын стандартын дагуу мэдээлэл технологийн үндсэн болон нөөц төвтэй бөгөөд цахилгааны тасалдлын үед ажиллах нөөц цахилгаан генератортай, мэдээллийн нууцлалын баталгааг олон улсын стандартын дагуу хангаж ажилладаг.

Монголын Хөрөнгийн Биржийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй "Миллениум Ай Ти" систем нь ISO9001:2008 олон улсын чанарын стандартад нийцсэн бөгөөд системийн тусламж үйлчилгээг "Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп"-ийн охин компани болох "Миллениум Ай Ти" компаниас 24/7 цагийн хугацаанд үзүүлдэг. Гэрээний нөхцөлд тус системийн тасралтгүй ажиллагааны доод хязгаарыг 99.6 хувиар тогтоосон байдаг.

MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020699 2001096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Схем 10. Монголын Хөрөнгийн Биржийн мэдээлэл технологийн бүтцийн зураглал



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

1. "Милленниум Ай Ти" системийг нэвтрүүлсэн нь

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 79 дүгээр тогтоол, 2010 оны 11 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 86, 115 дугаар тогтоолуудын дагуу Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор Төрийн өмчийн хороо "Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп"-ийг стратегийн түншээр сонгож 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдөр "Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп" болон Төрийн өмчийн хорооны хооронд

СӨХ
БҮРТГЭЛ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12

"Стратеги хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулсан. Дээрх гэрээний үндсэн дээр "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль" болон хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, техник технологийг шинэчлэх, боловсон хүчнийг чадваржуулах, хөрөнгийн зах зээлийн бүтэц зохион байгуулалт, засаглалыг сайжруулах зорилгоор 2011 оны 4 дүгээр сарын 7-нд стратеги хамтын ажиллагааны "Ажлын мастер гэрээ"-г 3 жилийн хугацаатай байгуулан шинэчлэлийн ажлыг эхлүүлсэн.

Тус гэрээний дагуу олон улсын стандарт бүхий техник, технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд "Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп" нь өөрийн охин компани болох "Милленниум Ай Ти" компанийн хөгжүүлсэн, өөрсдийн үйл ажиллагаандаа ашигладаг арилжаа, төлбөр тооцоо, хадгаламж, хяналтын "Милленниум Ай Ти" цогц системийг санал болгосон. Уг систем Монголын зах зээлд зохимжтой эсэх талаар хөндлөнгийн судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулж улмаар 2011 оны 6 дугаар сараас эхлэн системийн танилцуулга, сургалт, туршилтыг эрчимтэй зохион байгуулсны үндсэн дээр 2012 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн энэхүү системийг Монголын хөрөнгийн зах зээлд ашиглаж эхэлсэн байна.

2. *"Милленниум Ай Ти" систем тухай*

"Милленниум Ай Ти" системийг Лондонгийн хөрөнгийн бирж, Италийн Хөрөнгийн Бирж, Сингапурын Хөрөнгийн Бирж, Энэтхэгийн Хөрөнгийн Бирж, Филлиппиний Хөрөнгийн Бирж, Катарын Хөрөнгийн Бирж зэрэг дэлхийн 20 гаруй улсын 30 гаруй хөрөнгийн бирж болон бусад санхүүгийн байгууллагууд ашигладаг бөгөөд олон улсын ISO 9001:2008 болон ISO 27001:2015 чанарын сертификатуудыг авсан, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг өндөр түвшинд хангасан арилжааны цогц систем юм.

Тус систем нь үнэт цаасны компаниудад төдийгүй хөрөнгө оруулагчдад онлайнаар арилжаанд оролцох боломжийг олгодог нь үнэт цаасны ханшийн өөрчлөлт секундээр өөрчлөгддөг онцлогтой хөрөнгийн зах зээлийн хувьд оролцогчдын шударга, жигд оролцоог хангахад хамгийн чухал үзүүлэлт болдог бөгөөд энэ нь хөрөнгийн зах зээлийг цахимжуулах, улмаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Тухайлбал, 2022 оны 11 дүгээр сарын байдлаар нийт арилжаанд оролцогчдын 95-аас дээш хувь нь гар утасны аппликэйшн ашиглан онлайнаар шууд арилжаанд оролцож байна.

Арилжааны систем нь хувьцаа, Засгийн газрын үнэт цаас, компанийн бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон хөрөнгө оруулалтын сангийн нэгж

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020699 207096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

эрхийн бүртгэл гэх мэт үнэт цааснуудын параметрийг хэрэглэгчээс тодорхойлох боломжтой, зах зээлийн үнэлгээ болон индексүүдийн үнэлгээг бодит цагийг горимоор тооцоолох, www.mse.mn веб сайтаар дамжуулан зах зээлийн оролцогчдод хүргэх, зах зээлийн тухайн үеийн төлөв байдлаас шалтгаалж эрсдэлийг тооцох боломжуудтай. Мөн хөрөнгө оруулагчид болон үнэт цаасны компаниудын захиалгыг “fill or kill”, “iceberg” гэх мэт 20 төрлийн захиалгын нөхцөлөөр гүйцэтгүүлэх, 1 секундэд 50,000 захиалгыг биелүүлэх хурдтай, шаардлагатай тохиолдолд хүчин чадлаа хэсэгчлэн өргөтгөх боломжоор хангагдсан, зах зээлийн үнэлгээ болон ханшийн мэдээллийг бодит цагийн горимоор харуулах боломжоор хангагдсан. Түүнчлэн, зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын системүүд бодит цагийн горимоор мэдээлэл солилцох, зохицуулагч байгууллагууд нь бодит цагийн горимоор зах зээлийн хяналтыг хийх боломжийг олгосон систем юм.

3. “Милленниум Ай Ти” системийг ашиглаж буй байгууллагууд

Зураг 2. “Милленниум Ай Ти” системийн тархалт



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

4. “Милленниум Ай Ти” цогц системийн давуу талууд

“Милленниум Ай Ти” систем нь зах зээлийн дэд бүтцийн байгууллагууд болон оролцогч талуудын хэрэгцээг хангах цогц систем бөгөөд дараах дэд системүүдтэй.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Хүснэгт 13. "Милленниум Ай Ти" системийн хэрэглээ

Системийн хэрэглэгчид	Системийн нэр	Функц
Монголын Хөрөнгийн Бирж буюу арилжаа эрхлэх байгууллага	Millennium Exchange	Арилжаагаа зохион байгуулах, захиалга нийцүүлэх
Үнэт цаасны компаниуд болон хөрөнгө оруулагчид	Millennium Trader	Харилцагчдын захиалгыг бодит цагийн горимоор харах, оруулах
Төвлөрсөн хадгаламжийн төв, клирингийн байгууллага, кастодиан банк болон төлбөр гүйцэтгэгч банкнууд	Millennium CSD	✓ Харилцагчдын хувьцааны дансыг нээх хүсэлтийг цахимаар илгээх; ✓ Үнэт цаасны компаниуд дансны мэдээллийг цахимаар хүлээн авах; ✓ Үнэт цаасны дансны мэдээллийг "ХУР" системээр дамжуулан автоматаар шалгах; ✓ Данс багцаар нээх.
Зохицуулагч байгууллагууд	Millennium Surveillance	Зах зээлийн хяналтыг бодит цагийн горимоор хэрэгжүүлэх

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

"Милленниум Ай Ти" системийг нэвтрүүлснээр хөрөнгийн зах зээлд дараах боломжууд нээгдсэн. Үүнд:

- ✓ Хөрөнгийн зах зээлийн төлбөр тооцоонд ашиглагддаг барьцаа, төлбөрийн баталгааны сан байгуулах;
- ✓ Үнэт цаасны мөнгөн төлбөр тооцоог арилжааны банкаар дамжуулан гүйцэтгүүлэх;
- ✓ Зах зээлийн нээлтийн ханшийг "дуудлага арилжаагаар" тодорхойлох, зах зээлийн гэнэтийн огцом өсөлт бууралтыг дуудлага арилжаагаар буюу системээр тэнцвэржүүлдэг нөхцөл бүрдүүлэх;
- ✓ Өмнө нь хэрэгждэг байсан "нөхцөлт захиалга" болон "зах зээлийн захиалга" гэсэн гэсэн захиалгын төрлийг 20 гаруй төрөлтэй болгосон;
- ✓ Зах зээлд төлбөр тооцооны дараа төлбөрт Т+2 горим гэх мэт олон улсын нийтлэг зарчмуудыг нэвтрүүлэх үндэс суурь бүрэлдсэн;
- ✓ Багцын арилжаа, арилжааны тендер саналын захиалгыг тусдаа сангаар явуулах;
- ✓ "Төлбөрийн эсрэг нийлүүлэлт" зарчим болон дараа төлбөрт төлбөр тооцооны горимтой холбоотой эрсдэлийн удирдлагын механизм нэвтрүүлсэн;

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ТЭХК
9020020699
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

- ✓ Үнэт цаасны кастодианы үйлчилгээ болон үнэт цаасны номинал болон бенефициар өмчлөлийн ялгааг гаргаж, боломжуудыг нээснээр арилжааны дараах үйл ажиллагаа /post-trade/ буюу төлбөр тооцоо, хадгаламжийн ажиллагааг бүрэн шинэчилсэн;
- ✓ Анхан шатны баримтыг цахим хэлбэрээр хадгалах зэрэг боломжууд бүрдсэн.

***5.** Үндсэн цахим хуудас **www.mse.mn** тухай*

Үнэт цаас гаргагч нь "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-аар хүлээсэн мэдээлэх чиг үүргээ өөрийн цахим хуудсаар мэдээлж хэрэгжүүлдэг бол цахим хуудас нь бүртгэлтэй компани болон гишүүдийг хууль, журмаар хүлээсэн мэдээллийн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангадаг.

Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд өдөрт дунджаар 900 гаруй хүн ханддаг ба цахим хуудсаараа дараах мэдээллийг цаг алдалгүй, түргэн шуурхай хүргэдэг. Үүнд:

Схем 11. Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсанд байршсан мэдээллүүд

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020699 9071016
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277123
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .12. 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

1 Хувьцаа болон бусад үнэт цааснуудын мэдээллүүд

- Үнэт цаасны танилцуулга;
- Үнэт цаасны ханшийн мэдээ;
- Үнэт цаасны арилжааны тоо ширхэг болон үнийн дүн.

2 Бүртгэлтэй компаниудын мэдээллүүд

- Бүртгэлтэй компанийн ангилал;
- Бүртгэлтэй компанийн ерөнхий мэдээлэл;
- Үйл ажиллагааны тайлан;
- Компанийн засаглалын үнэлгээний тайлан;
- Санхүүгийн тайлан болон санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд;
- Эрх бүхий албан тушаалтан болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар болон хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон ТУЗ-ийн шийдвэрүүд;
- Үнэт цаас гаргагчтай холбоотой хийгдсэн судалгаанууд;
- Үнэт цаастай холбоотой бусад мэдээллүүд.

3 Арилжааны мэдээ болон тайлангууд

4 Индексийн мэдээ болон индексийн багцыг бүрдүүлж буй компаниудын мэдээллүүд

5 Гишүүн үнэт цаасны компаниудын мэдээллүүд

- Гишүүн үнэт цаасны компаниудын бүртгэл, хаягийн мэдээлэл;
- Үнэт цаасны компаниудын үйл ажиллагааны чиглэл;
- Үнэт цаасны компаниудын арилжааны идэвх;
- Үнэт цаасны компаниудын зохицуулалт, арга хэмжээнүүд;
- Үнэт цаасны компаниудын холбоотой тайлан, судалгаанууд;
- Шинээр гишүүнээр элсэх хүсэлттэй холбоотой мэдээллүүд;
- Үнэт цаастай холбоотой бусад мэдээллүүд.

6 Хууль, журам, заавар, аргачлалууд

7 Хөрөнгийн зах зээлийн тухай танин мэдэхүйн мэдээллүүд

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

6. *"Милленниум Ай Ти" системийн дэд системүүд*

issuer.mse.mn

Цахим хуудасны дэд систем буюу Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй бүх хувьцаат компаниуд өөрийн бүртгэлийн эрхээр хандалт хийж, өөрийн байгууллагын шаардлагатай өгөгдөл мэдээллийг хууль журмын хүрээнд нээлттэйгээр зохих хугацаанд шинээр оруулах, өөрчлөлт тусгах үүрэг бүхий ажиллагаатай вэб хуудас юм.

members.mse.mn

Цахим хуудасны дэд систем буюу Монголын Хөрөнгийн Биржид гишүүнчлэлтэй бүх үнэт цаасны компаниуд хандалт хийж, хууль журмаар хүлээсэн өгөгдөл мэдээллийг тогтмол шинэчлэн, бүртгэл үүсгэх, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглагддаг болно.

Orderbook буюу демо арилжааны систем

Монголын Хөрөнгийн Бирж нь иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх, хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор 2018 онд демо буюу хийсвэр арилжааны системийг нэвтрүүлсэн ба одоогоор 3,150 харилцагч бүртгүүлсэн байна.

Зураг 3. Үнэт цаас гаргагчийн Демо арилжааны системийн нэвтрэх хуудас



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Тайлангийн систем

Монголын Хөрөнгийн Бирж нь хоёрдогч зах зээлийн арилжаатай холбоотой бүх төрлийн тайлан мэдээлэл боловсруулах зорилготой "Милленниум Ай Ти" системээс файл оруулах, үндсэн цахим хуудасны өгөгдлийн сантай шууд холболттойгоор өгөгдөл солилцож тайлан боловсруулах үүрэг бүхий тайлангийн системийг Монголын Хөрөнгийн Бирж дотооддоо хөгжүүлсэн ба 2017 оноос хойш тасралтгүй ашиглаж байна.

Анхдагч зах зээлийн IPO систем

"IPO систем" буюу анхдагч зах зээлийн арилжааны системийг Үнэт цаас гаргагч нь 2018 онд зах зээлд амжилттай нэвтрүүлсэн. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцохдоо "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК болон үнэт цаасны компаниуд өөрсдийн онлайн системийг www.ipo.mse.mn вэб хуудаст холболт хийлгэснээр анхдагч зах зээлийн арилжаанд онлайнаар оролцох бүрэн боломжтой.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь уг системээр дамжуулан хувьцаа, өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг санхүүгийн хэрэгслүүдийг тогтоосон үнээр, захиалгын бүртгэл, дуудлага арилжааны зэрэг арилжааны арга хэлбэрүүдээр санал болгон арилжиж, олон нийтээс нийт 1.5 их наяд төгрөгийн хөрөнгийг татан төвлөрүүлсэн байна.

Комекс систем

Нүүрс болон уул уурхайн бусад түүхий эдийг цахимаар нээлттэй арилжаалах зорилгоор Монголын Хөрөнгийн Бирж нь дотооддоо Commodity exchange буюу КОМЕКС системийг шинээр хөгжүүлээд байна. Нүүрсний арилжааг холбогдох журмын дагуу брокергүйгээр зохион байгуулахтай холбоотойгоор арилжаанд оролцогч гадаад, дотоодын иргэд, аж ахуйн нэгжүүдийг системд хэрэглэгчээр бүртгэх алхмыг ойлгомжтой байдлаар хөгжүүлсэн бөгөөд ашигт малтмалын чанарын стандарт, нийлүүлэлт, төлбөрийн нөхцөлүүдийг худалдан авагчдад Монгол, Англи хэл дээр мэдээлэх, дуудлага арилжааг олон төрлийн арга хэлбэрээр, нарийвчилсан нөхцөлүүдээр явуулах давуу талуудтай.

2.8. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ

БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 22 дугаар "Өмч хувьчлалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" тогтоолоор Монголын Хөрөнгийн Биржийн захиргаа байгуулагдаж, захирлаар Найдансүрэн

MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
ХӨРӨНГИЙН
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
САРТАЛ
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 сар 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ 02

овогтой Золжаргал томилогдож байсан түүхтэй. Тус тогтоолын дагуу Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагдах эрх зүйн суурь нөхцөл бүрдэж, үүсгэн байгуулагдсан цагаас хойш үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагааг тасралтгүй явуулж байна. 1994 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Их хурлаас үнэт цаасны зах зээлийн эрх зүйн харилцааг зохицуулах зорилгоор батлагдсан үнэт цаасны зах зээлийн салбарын анхны хууль болох "Үнэт цаасны тухай хууль"-д "Хөрөнгийн бирж" хэмээх нэр томьёог тодорхойлж зохицуулж байсан.

Тус зохицуулалтад 1996 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд тус өөрчлөлтийн дагуу "Хөрөнгийн бирж" хэмээх тодорхойлолтыг "Үнэт цаасны худалдаа, арилжаа, түүнтэй холбоотой үйлчилгээ явуулах зорилго бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээд" хэмээн тодорхойлж байсан. 1994 оны "Үнэт цаасны тухай хууль"-ийн дагуу Хөрөнгийн биржид Үнэт цаасны хороо (одоогийн Санхүүгийн Зохицуулах Хороо) үйл ажиллагаа явуулах эрхийн зөвшөөрөл олгохоор зохицуулж өгсөн тэр үеэс эхлэн Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа хэмээн албан ёсоор тооцогдох болсон гэж үзэх үндэстэй юм.

1994 оны "Үнэт цаасны тухай хууль" болон 1996 оны нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийн хүрээнд Үнэт цаасны хорооны 1996 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 58 дугаар тогтоол, 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 80 дугаартай "Хөрөнгийн бирж хувьцаат компанид тусгай зөвшөөрөл олгох тухай" тогтоолуудын дагуу салбарын эрх зүйн орчны өөрчлөлт, шинэчлэлтэй холбоотойгоор Монголын Хөрөнгийн Биржид үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгож байсан.

Үүний дараагаар Санхүүгийн Зохицуулах Хорооны 2006 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор Үнэт цаас гаргагчид "үнэт цаасны зах зээл дээр үнэт цаасны арилжааны үйл ажиллагаа эрхлэх" гэсэн агуулгаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулах эрхийг гэрчилсэн одоогийн 330/01 дугаартай тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгосон. Дээрх үйл явдлуудыг дүгнэвэл Монголын Хөрөнгийн Бирж нь үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа буюу тусгай зөвшөөрөл шаардагдах үндсэн 1 (нэг) чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй болно. Үүний зэрэгцээ Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор Үнэт цаас гаргагчийг үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллагаар бүртгэсэн.

Өөрийгөө зохицуулах байгууллага гэдэг нь хөрөнгийн зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд болон мэргэжлийн үнэмлэх авсан мэргэжилтнүүдээс бүрдсэн гишүүнчлэлтэй, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, гишүүдийнхээ

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020698 5077096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317639 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СӨХ ... БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 -12- 12 БҮРТГЭСЭН ...

чадавхыг дээшлүүлэх, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий байгууллагыг хэлдэг. Үнэт цаас гаргагч нь энэхүү Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах үеийн байдлаар нийт 52 (тавин хоёр) байгууллагыг гишүүнээр элсүүлсэн байх ба гишүүн байгууллагуудын хувьд эдлэх эрх, үүрэг, хариуцлага, гишүүнчлэлтэй өөрийгөө зохицуулах байгууллагад шаардагдах харилцааг зохицуулсан 7 (долоо) журам батлан мөрдүүлэн хяналт тавин ажиллаж байна. Энэ утгаараа Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны зах зээлийн өөрийгөө зохицуулагч байгууллагын статус бүхий зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд юм.

2.9. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЖИЖ БУЙ БОДЛОГО, ЖУРМУУД

2.9.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаандаа дагаж мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүд

1. *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нийтлэг дагаж мөрдөгдөж буй хуулиуд*

Монгол Улсын "Иргэний хууль", "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", "Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль", "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль", "Компанийн тухай хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", "Хөрөнгө оруулалтын тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Татварын ерөнхий хууль", "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль", "Нийгмийн даатгалын тухай хууль", "Байгууллагын нууцын тухай хууль", "Авлигын эсрэг хууль", "Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль", "Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль", "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль" болон тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актуудыг дагаж мөрдөн ажиллаж байна.

2. *Үнэт цаасны зах зээлд арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулахтай холбоотой дүрэм журмууд*

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллага болох Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан үнэт цаасыг бүртгэх, арилжаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан журмуудыг дагаж мөрдөж байна. Өөрийгөө зохицуулах байгууллагын хүрээнд олон нийтэд нээлттэй үнэт цаас бүртгүүлэх, арилжаалахтай холбогдсон харилцаанд Санхүүгийн Зохицуулах Хороотой хамтран хяналт тавьж,

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК 9020020699 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore САРИЙН 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

тухайн харилцаанд дагаж мөрдөгдөх нарийвчилсан журмуудыг хуульд нийцүүлэн батлан мөрдүүлдэг. Энэ хүрээнд "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлд заасан санхүүгийн хэрэгсэл тус бүрийг бүртгэх, арилжаалахтай холбогдсон харилцааг зохицуулсан дүрэм, журмыг дагаж мөрдөж байна.

2.9.2. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм журмууд

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулж буй хүчин төгөлдөр 48 (дөчин найм) дүрэм, журам, заавар, аргачлал хэрэгжиж байгаа ба эдгээрээс голлох журмуудыг танилцуулбал:

1. *Өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дотоод журмууд:* Гишүүнчлэлийн журам, Хяналт, шалгалтын журам, Гишүүн компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар, хууль тогтоомжийн хүрээнд Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрсөн бусад журмууд.

2. *Үнэт цаас гаргагчийн засаглалын харилцаанд хамаарах эрх зүйн баримт бичгүүд:* Үнэт цаас гаргагчийн Дүрэм, ТУЗ-ийн ажиллах журам, ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журам, Ногдол ашгийн бодлого, Эрсдэлийн удирдлагын бодлого, Цалин урамшууллын хорооны дүрэм.

3. *Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүд:* Хөдөлмөрийн дотоод журам, Ажилтны ёс зүйн дүрэм, Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шалгах журам, Хүний нөөцийн бодлогын баримт бичиг, Оюутан дадлагажуулах журам.

4. *Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой эрх зүйн баримт бичгүүд:* Дотоод хяналт шалгалтын журам, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр.

5. *Үйл ажиллагаатай холбоотой бусад журмууд:* Нууцын журам, Бараа материал, ажил үйлчилгээ худалдан авах, ашиглах үйл ажиллагааны журам, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам, Архивын үйл ажиллагааны журам, Албан хэрэг хөтлөлтийн журам, Иргэн, албан байгууллагаас гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх заавар, Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрэм.

Үнэт цаас гаргагч нь нэмж хувьцаагаа нийтэд нээлттэй санал болгон арилжаалах ажиллагаа амжилттай болсны дараа дор дурдсан дүрэм журмыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлж, батлуулахаар төлөвлөсөн ба эдгээр дүрэм, журмын төслийг Хуулийн зөвлөх хянаж, Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар тогтоолоор сайшаасан байна.

- ✓ "Монголын Хөрөнгийн Бирж" нээлттэй хувьцаат компанийн Дүрмийн төсөл;

Үнэт цаас гаргагч нь дээр дурдсан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дараа зохион байгуулагдах ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр дор дурдсан компанийн засаглалын харилцаанд хамаарах бодлого, журмын төслүүдийг Хуулийн зөвлөхөд хянуулж, ТУЗ-ийн тогтоолын дагуу сайшаан баталсан байна. Үүнд:

- ✓ Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын төсөл;
- ✓ Залгамж халааны бодлогын төсөл;
- ✓ Мэдээллийн үйл ажиллагааны журмын төсөл;
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын төсөл;
- ✓ Сонирхлын зөрчлийг зохицуулах журмын төсөл;
- ✓ Шүгэл үлээх журмын төсөл.

Хуулийн зөвлөхийн хянасан Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд дагаж мөрдөгдөж буй дүрэм, журам, зааврууд болон Үнэт цаас гаргагч нэмж хувьцаагаа нийтэд нээлттэй санал болгон гаргаж амжилттай арилжаалсны дараах хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулахаар төлөвлөөд буй дүрэм, журмуудын хууль тогтоомжийн нийцлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хуулийн дүгнэлтээс танилцан мэдэх боломжтой болохыг мэдэгдэж байна.

2.10. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХЭЛЦЛҮҮД

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 (гурав) жилийн хугацаанд бусадтай байгуулсан их хэмжээний, сонирхлын зөрчилтэй, хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш үнийн дүнтэй гэрээ хэлцлийн талаарх мэдээллийг Хуулийн зөвлөхийн Хуулийн дүгнэлтийг үндэслэн хураангуй байдлаар тусгав. Хуулийн зөвлөх нь сүүлийн 3 (гурав) жилийн хугацаа гэдэгт 2019 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хугацааг хамруулан авч үзсэн байна. Энэхүү бүлэгт Үнэт цаас гаргагчийн хэлцлүүдийн зөвхөн голлох ач холбогдол бүхий мэдээлэл гэж тооцсон хураангуй хэсгийг тусгасан бөгөөд гэрээ хэлцлүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, хууль тогтоомжид нийцсэн эсэх, хууль тогтоомжид заасан журмын дагуу байгуулагдсан эсэх тухай дэлгэрэнгүй мэдээллийг Хуулийн дүгнэлттэй танилцаж авах боломжтой юм.

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
УЛААНБААТАР ХС
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

2.10.1. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 (гурав) жилийн хугацаанд хийсэн их хэмжээний хэлцэл

"Компанийн тухай хууль"-ийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)" болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор хуульчилж заасан. "Компанийн тухай хууль"-ийн 87 дугаар зүйлд тодорхойлогдсон их хэмжээний хэлцэлд тооцогдох өндөр үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээг байгуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн байдал, үйл ажиллагаанд томоохон ач холбогдол бүхий нөлөө үзүүлдэг тул "Компанийн тухай хууль"-ийн 88 дугаар зүйлийн дагуу их хэмжээний хэлцлийг байгуулахад холбогдох этгээдийн зөвшөөрлийг заавал авсан байхыг шаарддагаараа онцлог хэлцэл юм.

Хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 (гурав) жилийн балансын активыг тогтоохдоо Үнэт цаас гаргагчийн аудитын компаниар баталгаажсан санхүүгийн тайланг үндэслэн, доорх байдлаар тооцсон байна.

Хүснэгт 14. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 (гурав) жилийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцлийн тухай мэдээлэл, 2019 – 2022 он

№	Санхүүгийн тайлан/ хэлцлийн хугацаа	Тухайн жилийн балансын активын дүн, төгрөгөөр	Тухайн жилийн балансын активын 25 хувьтай тэнцэх дүн, төгрөгөөр
1	2018 оны жилийн эцэс (2019 оны хэлцэл)	4,551,963,207,430	1,137,990,801,860
2	2019 оны жилийн эцэс (2020 оны хэлцэл)	3,787,255,243,540	946,813,810,890
3	2020 оны жилийн эцэс (2021 оны хэлцэл)	3,458,327,881,340	864,581,970,340
4	2021 оны жилийн эцэс (2022 оны хэлцэл)	5,378,573,759,480	1,344,643,439,870

Эх сурвалж: "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН-ийн Хуулийн дүгнэлт

Хуулийн дүгнэлтийг үндэслэхэд Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 (гурав) жилийн тасалбар болгон тооцсон хугацаанд "Компанийн тухай хууль"-ийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцэлд тооцогдох аливаа гэрээ, хэлцэл байгуулаагүй байна.

2.10.2. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 (гурав) жилийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл

СӨХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Хуулийн дүгнэлтэд тусгагдсаныг үндэслэвэл Хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагчийн 2019-2022 оны хоорондох хугацааны сонирхлын зөрчилтэйд тооцогдох гэрээ хэлцлийн талаар магадлан шалгасан байна. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг Монгол Улсын Засгийн газраас эрх олгогдсоны дагуу Сангийн яам хэрэгжүүлж байгаагийн хувьд Сангийн яамны хувьцааг нь эзэмшдэг 5 (тав) компанитай Монголын Хөрөнгийн Биржийн байгуулсан гэрээ хэлцлүүдийг магадлан шалгасан байна. Хуулийн дүгнэлтэд тусгагдсаны дагуу Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 (гурав) жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэйд тооцогдох нийт 14 (арван дөрөв) гэрээ хэлцэл байгуулсныг Хуулийн зөвлөх магадлан шалгасан байна. Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 (гурав) жилийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчилтэйд тооцогдох гэрээ хэлцлүүдийн хэрэгжилт, төлөв байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хуулийн дүгнэлттэй танилцаж авах боломжтой.

2.10.3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцлүүд

"Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"ийн 10.5.7 дахь заалтад заасны дагуу Үнэт цаасны танилцуулгад заавал тусгагдах мэдээллийн шаардлагад тухайн үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай асуудал багтсан байдаг. Энэ хүрээнд Хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 (гурав) жилийн тасалбар болгон тогтоосон хугацаан дахь хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцлийн талаар магадлан шалгаж, Хуулийн дүгнэлтдээ тусгасан байна. Сүүлийн 3 (гурав) жилийн хугацаанд Үнэт цаас гаргагч нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээндээ 1 (нэг) удаа өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байх ба хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн байдлыг үндэслэн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний дүнг дор дурдсаны дагуу тооцсон байна.

ХӨРӨНГИЙН
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 12 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 12 12
БҮРТГЭВ-02

Хүснэгт 15. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ хэлцлийн тухай мэдээлэл, 2019 – 2022 он

№	/Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа/	2019.11.01 - 2022.10. 31
1	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн, төгрөгөөр	23,130,593,600
2	Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувьтай тэнцэх дүн, төгрөгөөр	1,156,529,680
3	Нийт байгуулсан гэрээ	0
4	Хэрэгжиж байгаа гэрээ	0

Эх сурвалж: "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН-ийн Хуулийн дүгнэлт

Хуулийн дүгнэлтийг үндэслэхэд Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 (гурав) жилийн хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн аливаа гэрээ хэлцэл байгуулаагүй байна.

2.11. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүд нь үйл ажиллагаа явуулдаг салбар, зах зээл, эрхэлдэг үйл ажиллагааны чиглэл, бизнесийн онцлог, дотоод болон гадаад хүчин зүйлүүдээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. Үнэт цаас гаргагч нь үндсэн үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлүүдийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах зорилгоор эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон дүрэм, журам, бодлогын баримт бичгүүдийг батлуулан, компанийн өдөр тутмын үйл ажиллагаа болон шийдвэр гаргалтад хэрэгжүүлэн ажилладаг. Эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон дүрэм, журам, бодлогын баримт бичгүүдээс гадна Үнэт цаас гаргагчаас баталсан зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой бусад бүхий л журам, заавар нь тухайн зохицуулж буй харилцаанд үүсэж болох аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг. Иймд, Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын бодлого нь дан ганц тусгайлсан бодлого журмаар бус Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны бүхий л харилцааг хамарсан баримт бичгүүдэд тусгалаа олж, цогц байдлаар хэрэгжиж буй юм.

2.11.1. Эрсдэлийн удирдлагын бодлого

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд үүсэж болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж буй голлох баримт бичиг нь Үнэт цаас гаргагчийн "Эрсдэлийн удирдлагын бодлого" юм. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс баталсан тус бодлогын баримт бичиг нь компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, стратеги зорилтыг хэрэгжүүлэх, урт хугацааны өсөлт, бизнесийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор эрсдэлийн удирдлагын бүтэц зохион байгуулалт,

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
8917833 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-12-12
БҮРТГЭВ-02

үндсэн зарчмууд, эрсдэлийг удирдах арга хэрэгслүүдийг тодорхойлсон баримт бичиг юм.

Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын процесс нь дор дурдсан ерөнхий зураглалын дагуу явагддаг.

Схем 12. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын зураглал



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн хүчин зүйлсийг харгалзан, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн хамрах хүрээ болон гадаад, дотоод нөхцөл байдлыг тодорхойлж, эрсдэлийн шинж чанар, эх үүсвэр, шалтгаан, үүсэж болзошгүй үр дагаврыг тогтоон, түүнийг илрүүлэх, илрүүлсний үндсэн дээр тухайн эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлж, бодитоор үүссэн эрсдэлийг бууруулахад чиглэсэн зохих арга хэмжээг авах, хяналт тавих, эрсдэлийн удирдлагын хамгаалалтын түвшин бүрд холбогдох эрх бүхий этгээдэд тайлагнах зэрэг процедурын ажиллагааг тогтмол хэрэгжүүлдэг.

ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СӨХ
БҮРТГЭЛ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Схем 13. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь Компанийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд удирдлагын ерөнхий хяналтыг хэрэгжүүлдэг ба эрсдэлийн удирдлагын өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлэгч нь Дотоод аудитын алба, Гүйцэтгэх захирал байна. Компанийн дотоод бүтэц зохион байгуулалтын хувьд Гүйцэтгэх захирлын харьяа хороо, газар, алба, нэгж бүр өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг, холбогдох журам зааврыг дагаж мөрддөг. Өөрөөр хэлбэл, эрсдэлийн удирдлага, хяналт нь дээрээс доош, гүйцэтгэл, тайлагнал нь доороос дээш бүтэцтэй байна.

Үнэт цаас гаргагчийн Эрсдэлийн удирдлагын бодлогод заасны дагуу эрсдэлийн удирдлагыг дор дурдсаны дагуу хамгаалалтын 3 (гурав) түвшинд хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨЖ
МОНГОЛЫН
9020020099
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Хүснэгт 16. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын хамгаалалтын түвшин, тэдгээрийн чиг үүрэг

Хамгаалалтын 1 дүгээр түвшин	
Хариуцах этгээд	Бүх алба, нэгжүүд
1 дүгээр түвшинд хэрэгжүүлэх чиг үүрэг	✓ Хариуцаж буй үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг тодорхойлох, үнэлэх; ✓ Өдөр тутмын үйл ажиллагааны эрсдэлийг хянах, бууруулах арга хэмжээ авч ажиллах; ✓ Эрх бүхий этгээдэд тайлагнах;
Хамгаалалтын 2 дугаар түвшин	
Хариуцах этгээд	Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх удирдлагын баг, Дотоод аудитын алба
2 дугаар түвшинд хэрэгжүүлэх чиг үүрэг	✓ Хамгаалалтын 1 дүгээр түвшний хүрээний эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, үйл явцад мониторинг хийх, зааавар, зөвлөмж өгөх; ✓ Эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой тайлан, төлөвлөгөө боловсруулах; ✓ Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ авах; ✓ Эрсдэлийн удирдлагатай холбоотой бодлого, журам, зааврыг шинэчлэн боловсруулах;
Хамгаалалтын 3 дугаар түвшин	
Хариуцах этгээд	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо
3 дугаар түвшинд хэрэгжүүлэх чиг үүрэг	✓ Эрсдэлийн удирдлагын бодлого, холбогдох журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих; ✓ Эрсдэлийн удирдлагын хамгаалалтын 1 болон 2 дугаар түвшний эрсдэлийг удирдах үйл ажиллагааг үнэлж, дүгнэх; ✓ Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах бодлогыг тодорхойлж, заавар удирдамж өгөх; ✓ ТУЗ-д үйл ажиллагаагаа тайлагнаж, хувьцаа эзэмшигчдэд эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтийн талаар мэдээлэл өгөх;

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Эрсдэлийг тодорхойлж тогтоох, үнэлэх, удирдах, хянах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хороод, Дотоод аудитын алба, Гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтан болон бусад бүх ажилтнууд түвшин бүрдээ оролцоотой байж, бодлогын хэрэгжилт бүрэн хангагдахад хариуцлага хүлээн ажилладаг.

MONGOLIAN STOCK EXCHANGE
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 -12- 14
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ 02

Эрсдэлийн удирдлагын бодлогод заасны дагуу Үнэт цаас гаргагчид материаллаг болон материаллаг бус нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийн хүчин зүйлүүдийг дор дурдсаны дагуу 6 (зургаа) чиглэлээр төрөлжүүлэн ангилсан байна.

Хүснэгт 17. Үнэт цаас гаргагчид материаллаг болон материаллаг бус нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийн төрлүүдийн ангилал ба тайлбар

Эрсдэлийн төрлүүдийн ангилал	Эрсдэлийн төрлүүдийн хамрах хүрээ
Стратегийн эрсдэл	Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, эдийн засгийн төлөв байдал, зах зээлийн өрсөлдөөн, хууль эрх зүй, улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан бизнесийн хэтийн хөгжил, гүйцэтгэл, стратегийг хэрэгжүүлэхэд материаллаг сөрөг нөлөө үзүүлэхүйц эрсдэлүүдийг ойлгоно.
Үйл ажиллагааны эрсдэл	Үнэт цаас гаргагчийн дотоод үйл ажиллагаанд үүсэж болзошгүй процедурын алдаа дутагдал, мэдээллийн технологи, программ хангамж, системийн хүчин чадал, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлүүд, бусад гадаад хүчин зүйлүүдийн нөлөөний улмаас үйлчилгээ үзүүлэх боломжгүй байдалд хүрэх, Үнэт цаас гаргагчийн нэр хүндэд учирч болох эрсдэлүүд багтана.
Санхүүгийн эрсдэл	Зах зээлийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал, ханш, хүү, инфляцын огцом өөрчлөлтөөс үүдэн орлого болон хөрөнгийн хэмжээнд үүсэж болзошгүй эрсдэлүүд, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс алдагдал хүлээх эрсдэл, төлбөрийн чадвараа алдах эрсдэл, хөрвөх чадварын эрсдэлүүд.
Мэдээллийн аюулгүй байдал, технологийн эрсдэл	Компьютер, программ хангамжид зөвшөөрөлгүй хандах, ашиглах, тасалдуулах, өөрчлөх, мэдээлэл задруулах, халдлага үйлдэх, өгөгдөл болон систем устгагдсаны улмаас үйлчилгээ үзүүлэх боломжгүй байдалд хүрэх, тэдгээрээс үүдэн үүсэж болох хохирол, хор уршиг, санхүүгийн алдагдал болон нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлж болох эрсдэлүүд.
Хууль эрх зүйн эрсдэл	Хууль тогтоомж, дотоод дүрэм, журам, бусадтай байгуулагдсан гэрээ хэлцлээр хүлээсэн үүрэг хариуцлагаа зөрчих, тэдгээрийг дагаж мөрдөөгүйгээс үүдэн хохирол, хор уршиг учрах, алдагдал хүлээх эрсдэлүүд.
Хяналт зохицуулалтын эрсдэл	Үнэт цаасны зах зээл дэх үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллагын үүргээ хэрэгжүүлээгүйгээс үүсэх эрсдэлүүд.

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч нь дээр дурдсан эрсдэлийн төрөл тус бүрээр эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг ба эдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах чиглэлд авах арга хэмжээг эрсдэлийн удирдлагын бодлогодоо ерөнхийлөн зааж өгсөн байдаг. Үүний дагуу эрсдэлийн төрөл, хүчин зүйл, чиглэл тус бүрээр эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой дүрэм журам, хөтөлбөр, бодлогын баримт бичгүүдийг батлан, хэрэгжүүлж ажилладаг. Тэдгээрээс голлох үүрэгтэй зарим журам заавар, баримт бичгийг дор танилцуулж байна.

2.11.2. Дотоод хяналт шалгалтын журам

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж буй эсэх, аливаа шийдвэр, Гүйцэтгэх захирлын тушаал, газар, алба, нэгжийн удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, дотоод хяналтын систем болон үйл ажиллагааны хяналтын үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэхэд Гүйцэтгэх удирдлагад туслалцаа үзүүлэх зорилгоор Дотоод хяналт шалгалтын журмыг 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 167 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан. Дотоод хяналт шалгалт нь төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн гэсэн хэлбэрүүдтэй бөгөөд тус ажиллагааг Дотоод хяналтын ажилтан хэрэгжүүлж байна. Дотоод хяналт шалгалт нь дор дурдсан хамрах хүрээтэйгээр Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж байна. Үүнд:

- ✓ Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гэрээ хэлцлийн хэрэгжилтийн байдал;
- ✓ Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх;
- ✓ Гүйцэтгэх захирал, захирлуудын зөвлөлөөс гарсан тушаал, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;
- ✓ Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдал болон түүнийг тодорхойлох, хэмжих, ангилах арга замыг шалган тогтоох;
- ✓ Дотоод хяналт шалгалтыг хөндлөнгийн аудитын үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;
- ✓ Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа дахь программ, системүүд нь журам, заавар, бодлого, төлөвлөгөө, горимын дагуу ажиллаж байгаа эсэхийг шалгаж баталгаажуулах;

СӨХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

- ✓ Үнэт цаас гаргагчийн үзүүлж буй ажил, үйлчилгээний чанарын байдалд хяналт шалгалт хийх;
- ✓ Үнэт цаас гаргагчийн удирдлагын дотоод үйл ажиллагаанд ашиглагдах ажлын гүйцэтгэлийн үнэлгээний программ дахь хяналтын хэлтсийн мэдээлэл дээр тулгуурласан газар, алба, нэгжүүдийн ажлын төлөвлөгөөний биелэлт;
- ✓ Үйл ажиллагааны сар, улирал, жилийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэл болон гүйцэтгэлд үнэлэлт өгсөн удирдлагын үнэлэлт дүгнэлтэд хяналт тавих;
- ✓ Мэдээлэл, техник, технологийн системийн төлөвлөлт, боловсруулалт, хэрэгжилтийн байдлын хүрээнд тухайн системд тавигдаж буй хяналт нь хангалттай эсэх, системийг хэрэгжүүлэхээс өмнө зохих туршилт хийгдсэн эсэх, тухайн системийг холбогдох баримт бичгээр баримтжуулах, систем нь хэрэглэгчийн шаардлагыг хангаж байгааг баталгаажуулах зэрэгт мэргэжлийн санал зөвлөмжийг удирдлагад өгөх;
- ✓ Үнэт цаас гаргагчийн өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх;
- ✓ Үнэт цаас гаргагчийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж буй эсэхэд үнэлгээ хийж, илүү хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах боломжийг тодорхойлох, энэ тухай санал зөвлөмжийг эрх бүхий этгээдэд өгөх;
- ✓ Үнэт цаас гаргагчийн ажилтнуудын хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлт, ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих;
- ✓ Дотоод хяналт шалгалтын удирдамж, төлөвлөгөөнд тусгагдсан бусад асуудал.

Дотоод хяналт шалгалт нь олон үе шат бүхий өндөр давтамжтай хийгддэг ажиллагаа бөгөөд тухайн ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Дотоод хяналтын ажилтан нь Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захиралд холбогдох тайлан мэдээлэл, хяналт шалгалтын үр дүнг тайлагнаж ажилладаг. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа нь эрсдэлийг тооцох, үнэлэх, хяналт шалгалт хийх, түүний үр дүнд үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилго, зорилтыг агуулж, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны бүхий л чиглэлийг хамруулсан байх ба Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа болох арилжаа эрхлэх үйл ажиллагааны онцлог байдлыг тусгасан арилжааны систем, дэд бүтэц, программ

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
9917839 ᠳ.1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 12 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-12-12
БҮРТГЭВ-02

хангамж, тэдгээрийн найдвартай байдлыг хангахад чиглэгдсэн өргөн цар хүрээг хамарч байна.

2.11.3. Мэдээллийн технологийн цогц журам

Үнэт цаас гаргагчийн мэдээлэл, технологийн үйл ажиллагаанд холбогдуулан хэрэгжих бодлого, хэм хэмжээний хэрэгжилтийг хангахад зайлшгүй шаардлагатай мэдээллийн технологийн арга хэрэгсэл, компьютер, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн ашиглалт, тэдгээрийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдалд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Мэдээлэл технологийн цогц журмыг 2015 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 261 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаалаар баталсан. Тус журмын үзэл баримтлал болох мэдээлэл технологийн бодлого нь мэдээллийн технологийн одоо болон ирээдүйд нээгдэх боломжид тулгуурлан мэдээллийн технологийн шинэ дэвшилтэт арга хэрэгслийг ашиглах замаар Монголын Хөрөнгийн Биржийн үндсэн үйл ажиллагааг дэмжиж, үр ашгийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон улсын стандартад нийцсэн мэдээллийн технологийн оновчтой, цогц шийдлийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна. Тус багц журмаар мэдээлэл технологийн харилцаанд үүсэж болох эрсдэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажиллагааг программ хангамж болон системийн үйл ажиллагаа, сүлжээний удирдлага, түүний зохицуулалт, мэдээллийн аюулгүй байдлын зохицуулалт, виртуал орчин дахь нийтлэг зохицуулалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зохицуулалт, сүлжээний хяналт, хэрэглэгчдийн мэдээллийн технологийн талаар баримтлах бодлого, зарчим зэрэг өргөн хүрээнд хамруулан авч үзсэн байна. Тус журамд мэдээллийн технологи, программ хангамж, систем, техник технологитой харилцах журам, тэдгээрийн бүртгэл, шинэчлэхэд баримтлах бодлого, зарчим, тохиргоо, аюулгүй ажиллагааг хангах горим, журмын хэрэгжилтэд хяналт тавьж буй ажилтнуудын нийтлэг хүлээх үүрэг, хариуцлагыг журмын хамрах хүрээтэй нийцүүлэн өргөн хүрээнд тусгаж өгсөн байна. Багц журмын хэрэгжилтийн хамрах хүрээ, үйлчлэх чиглэл, журмын бодлогын үзэл баримтлал нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд үүсэж болох мэдээлэл, техник технологи, программ хангамжтай холбоотой үүсэж болох аливаа эрсдэлийг тооцож, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор журмын хэрэгжилтийг хангуулах үүрэг хүлээсэн этгээдүүдийн бүхий л үйлдэл, үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан байна.

2.11.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр

Үнэт цаас гаргагч нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-ийн 4.1.5 дахь заалтад заасны дагуу үнэт цаасны зах зээлд оролцогч

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК МОНГОЛЫН
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 51

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

мэргэжлийн байгууллагын хувьд Монгол банкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн Зохицуулах Хороо зэрэг төрийн эрх бүхий байгууллагуудад холбогдох тайлан мэдээллийг мэдээлэх үүрэгтэй этгээдэд тооцогддог. Мэдээлэх үүрэгтэй этгээд гэдэг нь үйл ажиллагаандаа "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-ийг хэрэгжүүлж биелүүлэх, холбогдох тайлан мэдээллийг төрийн эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээнд тооцогдох гүйлгээний тайлан мэдээллийг Монгол банкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанд мэдэгдэх болон хууль тогтоомжид заасан бусад үүрэг хариуцлагыг хүлээсэн этгээд юм. Тус хуулийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан дотоод хяналтын хөтөлбөрийг заавал баталж мөрдүүлэх үүрэг хүлээсний дагуу Үнэт цаас гаргагч нь "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр" (цаашид "Дотоод хяналтын хөтөлбөр" гэх)-ийг баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэхүү хөтөлбөр нь Эрсдэлийн удирдлагын бодлогод заасан хууль эрх зүйн эрсдэлийг удирдах арга хэрэгслүүдийн нэг бөгөөд тус хөтөлбөрийн хэрэгжилтэд дотоод хяналтын ажилтан хяналт тавьж, биелэлтийг хангаж ажиллан, үйл ажиллагааныхаа тайлан, мэдээллийг Гүйцэтгэх захиралд тухай бүр тайлагнан ажилладаг. Гүйцэтгэх захирал нь эрсдэлийн хамгаалалтын 2 дугаар шугамын үүрэг хариуцлагын дагуу эрсдэлийг чиглүүлэгчийн үүргийг гүйцэтгэж, үйл ажиллагаагаа Үнэт цаас гаргагчийн Эрсдэлийн удирдлагын хороонд танилцуулдаг.

"Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль" болон "Дотоод хяналтын хөтөлбөр"-ийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд нь хууль тогтоомжид тусгайлан заагдсан эрсдэлийн хүчин зүйлүүдийг харгалзаж, өөрийн үйл ажиллагаанд мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй байдал, түүнд хамаарах аливаа эрсдэлийг тооцох, эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэх, тэдгээрийг журамлан мөрдүүлэх үүрэг хүлээдэг. "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-д зааснаар мөнгө угаах чиглэлээр үүсэж болзошгүй эрсдэлүүдийг дор дурдсаны дагуу ангилсан байдаг. Үүнд:

- ✓ Харилцагчийн эрсдэл;
- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамаарч үүсэх эрсдэл;
- ✓ Бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчид хүргэх арга, хэлбэрээс хамаарч үүсэх эрсдэл;

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

- ✓ Газар зүйн байршлаас хамаарч үүсэх эрсдэл;

Үнэт цаас гаргагч нь дээрх эрсдэлийн хүчин зүйлүүдийг харгалзаж, эрсдэлийг үнэлэх, тогтоох, удирдах, хянах, хөрөнгө, орлого, гүйлгээний гарал үүслийг тогтоох, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг мэдээлэхтэй холбогдсон процедур ажиллагааны зохицуулалтуудыг Дотоод хяналтын хөтөлбөртөө тусгаж, мөрдөн ажиллаж буй нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд энэ чиглэлээр баримтлах эрсдэлийн удирдлагын бодлого хэрэгжиж, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон гэмт хэрэг үйлдэгдэх, гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус хөрөнгө, орлого зах зээлийн эргэлтэд орох зэргээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

2.12. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

Үнэт цаас гаргагч нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитыг "Кэй Пи Эм Жи Аудит" ХХК-аар, 2019 оны аудитыг "Грант Торнтон Аудит" ХХК-аар, 2020, 2021 онуудыг "Үндэсний Аудитын Газар"-аар, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн аудитыг "Грант Торнтон Аудит" ХХК-аар тус тус хийж гүйцэтгүүлсэн байна.

Аудитын компанийн дүгнэлтээр, Монголын Хөрөнгийн Биржийн 2022 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад (цаашид "СТОУС" гэх) нийцүүлэн Сангийн яамнаас батлан гаргасан аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, түүний нэмэлт тайлбар тодруулгыг бэлтгэх заавар журам, аргачлалын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Хүснэгт 18. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайлан
Сая төгрөг, 2018-2021 он, 2022 оны эхний хагас жил

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН	2018	2019	2020	2021	2022-II
ХӨРӨНГӨ					
Эргэлтийн хөрөнгө					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	830.39	953.43	554.59	2,729.36	2,511.88
Дансны авлага	299.46	49.65	84.13	97.26	66.72
Бараа материал	26.34	24.57	24.95	26.57	33.05
Урьдчилж төлсөн зардал тооцоо	16.95	8.34	8.92	7.67	6.16
Бусад эргэлтийн хөрөнгө	13.16	13.16	13.16	13.16	13.16
Эргэлтийн хөрөнгийн дүн	**1,187.29**	**1,050.52**	**685.75**	**2,874.02**	**2,630.97**
Эргэлтийн бус хөрөнгө					
Үндсэн хөрөнгө	2,172.00	2,083.73	2,210.71	2,102.23	5,580.75

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
8317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-93

Биет бус хөрөнгө	1,192.67	653.01	561.87	382.34	17,898.75
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**3,364.67**	**2,736.74**	**2,772.58**	**2,484.57**	23,479.49
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**4,551.96**	**3,787.26**	**3,458.33**	**5,358.59**	26,110.46
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ					
Богино хугацаат өр төлбөр					
Дансны өглөг	1,052.00	1,541.42	2,122.93	926.82	39.92
Цалингийн өглөг	35.97	0.08	-		
Татварын өр	15.69	13.54	9.54		
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	9.41	-	-	-	
Урьдчилж орсон орлого	1.14	9.76	11.92	14.25	192.81
Бусад богино хугацаат өр төлбөр	100.41	40.16	60.98	-	
Хойшлогдсон татварын өр					2,142.37
Богино хугацаат өр төлбөрийн дүн	**1,214.62**	**1,604.97**	**2,205.37**	**941.07**	2,375.10
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	**1,214.62**	**1,604.97**	**2,205.37**	**941.07**	**2,375.10**
Эздийн өмч					
Хувь нийлүүлсэн хөрөнгө	23,130.59	23,130.59	23,130.59	23,130.59	23,130.59
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12.36	12.36	12.36	12.36	18,883.20
Эздийн өмчийн бусад хэсэг	446.32	446.32	446.32	446.32	446.32
Хуримтлагдсан ашиг	(20,251.94)	(21,406.99)	(22,336.32)	(19,171.76)	(18,724.76)
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	**3,337.34**	**2,182.29**	**1,252.96**	**4,417.52**	**23,735.36**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	**4,551.96**	**3,787.26**	**3,458.33**	**5,358.59**	**26,110.46**

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
9020020699
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СӨХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Хүснэгт 19. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан

Сая төгрөг, 2018-2021 он, 2022 оны эхний хагас жил

ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2018	2019	2020	2021	2022-II
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	**1,656.95**	**1,474.67**	**1,100.10**	**5,483.08**	**1,474.50**
Хувьцааны арилжааны шимтгэл	984.36	791.17	356.17	2,598.93	954.64
Бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны шимтгэлийн орлого	2.82	0.79	43.89	949.17	3.39
Хураамжийн орлого	516.97	487.40	487.95	1,233.75	406.41
Бусад орлого	152.81	195.31	212.09	701.23	110.06
Борлуулалтын өртөг	-	-	-	-	-
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	**1,656.95**	**1,474.67**	**1,100.10**	**5,483.08**	**1,474.50**
Хүүгийн орлого	94.61	69.08	20.00	19.30	-
Бусад орлого	37.89	5.44	4.56	-	-
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал[2]	2,935.49	2,605.00	2,088.55	2,169.31	1,018.72
Цалингийн зардал	793.80	809.12	784.61	823.77	613.49
"Милленниум Ай Ти" системийн ашиглалтын зардал	1,211	805	699	938.09	38
Элэгдэл, хорогдлын зардал	631.26	737.02	410.65	239.66	131.97
Маркетингийн зардал	38.27	36.35	11.93	2.08	22.14
Бусад үйл ажиллагааны зардал	261.43	217.38	182.71	165.70	213.36
Гадаад валютын ханшийн зөрүү олз (гарз)	(30.30)	(33.15)	(59.24)	18.60	44.88
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	1.15	-	-	-
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	**(1,259.39)**	**(1,148.16)**	**(1,035.81)**	**3,352.29**	**500.66**
Орлогын татварын зардал	9.44	6.89	1.99	168.19	53.66

[2] Ерөнхий ба удирдлагын зардлын задаргааг хөрөнгө оруулагчдад ойлгомжтой байлгах үүднээс аудитлагдсан санхүүгийн тайлангийн тодруулга хэсэг дахь зардлын төрлүүдээр ангилж харуулсан болно.

MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
САРИЛС
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)	**(1,259.84)**	**(1,155.05)**	**(1,037.79)**	**3,184.10**	**447.00**

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлан

Сая төгрөг, 2018-2021 он, 2022 оны эхний хагас жил

	2018	2019	2020	2021	2022-II
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн	**1,635.52**	**1,880.61**	**1,194.53**	**5,699.77**	**1,648.94**
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,343.45	1,344.36	1,021.52	4,951.95	1,612.52
Даатгалын нөхөрөөс хүлээн авсан мөнгө	18.93	1.42	4.66	10.90	1.12
Бусад мөнгөн орлого	273.14	534.83	168.35	736.92	35.30
Мөнгөн зарлагын дүн	**1,652.25**	**1,648.66**	**1,263.06**	**3,427.31**	**1,755.00**
Ажилчдад төлсөн	596.81	660.02	611.48	585.16	442.40
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	166.12	166.47	181.23	182.33	126.71
Бараа материал худалдан авахад төлсөн	48.93	40.98	22.17	23.29	20.74
Ашиглалтын зардалд төлсөн	71.41	89.71	44.48	46.95	33.18
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл	8.25	10.17	5.56	8.12	3.04
Татварын байгууллагад төлсөн	184.98	280.38	162.77	348.44	317.83
Даатгалын төлбөрт төлсөн	0.55	-	-	-	-
Бусад мөнгөн зарлага	**575.20**	**400.93**	**235.36**	**2,233.02**	**8,11.10**
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(16.73)**	**231.96**	**(68.53)**	**2,272.46**	**(106.06)**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн	**0.17**	**0.17**	**1.12**	**19.30**	**-**
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-	1.00	-	-
Хүлээн авсан хүүгийн орлого	0.17	0.17	0.12	19.30	-
Мөнгөн зарлагын дүн	**459.94**	**109.08**	**331.43**	**116.98**	**156.52**
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	459.94	16.09	331.43	116.98	156.52
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	92.99	-	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(459.77)**	**(108.91)**	**(330.31)**	**(97.68)**	**(156.52)**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Мөнгөн орлогын дүн	-	-	-	-	-
Мөнгөн зарлагын дүн	-	-	-	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-	-	-	-
Валютын ханшийн зөрүү	-	-	-	-	**45.10**
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(476.50)**	**123.04**	**(398.84)**	**2,174.77**	**(217.48)**

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ ... БҮРТГЭЛ ... МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ... 2022 -12- 12 БҮРТГЭЛ-02

МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	1,306.88	830.39	953.43	554.59	2,729.36
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	830.39	953.43	554.59	2,729.36	2,511.88

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

Хүснэгт 21. Үнэт цаас гаргагчийн өмчийн өөрчлөлтийн тайлан

Сая төгрөг, 2018-2021 он, 2022 оны эхний хагас жил

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018.01.01	**21,884.00**	**12.36**	**1,692.92**	**(18,992.09)**	**4,597.18**
Хуримтлагдсан ашиг	-	-	-	(1,259.84)	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(1,246.59)	-	-
2018.12.31	**23,130.59**	**12.36**	**446.32**	**(20,251.94)**	**3,337.34**
Хуримтлагдсан ашиг	-	-	-	(1,155.05)	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	108.46	-
2019.12.31	**23,130.59**	**12.36**	**446.32**	**(21,406.99)**	**2,290.75**
Хуримтлагдсан ашиг	-	-	-	(1,037.79)	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
2020.12.31	**23,130.59**	**12.36**	**446.32**	**(22,336.32)**	**1,252.96**
Хуримтлагдсан ашиг	-	-	-	3,184.55	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
2021.12.31	**23,130.59**	**12.36**	**446.32**	**(19,151.77)**	**4,437.50**
Хуримтлагдсан ашиг	-	-	-	447.91	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
2022.06.30	**23,130.59**	**18,883.20**	**446.32**	**(18,724.76)**	**23,735.36**

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК ... УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК ... InvesCore CAPITAL ... УЛААНБААТАР ХОТ

2.12.1. Санхүү байдлын тайлан, шинжилгээ

1. Нийт хөрөнгө (актив)

График 5. Нийт хөрөнгө, түүний бүтэц

Сая төгрөг, 2018 - 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн 2018 оноос 2021 оны түүхэн дундаж дүн нь 4.3 тэрбум төгрөг байсан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар эргэлтийн бус хөрөнгөнд дахин үнэлгээ хийлгэсэнтэй холбоотойгоор 2021 оны жилийн эцэстэй харьцуулахад нийт хөрөнгө 387.3 хувиар өсөж, 26.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хөндлөнгийн Үнэлгээний компани 2022 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар хөрөнгийн үнэлгээ хийж, Барилга газрын хамт 15.5 тэрбум төгрөг, программ хангамжийг 7.3 тэрбум төгрөг болон бусад эргэлтийн бус хөрөнгийг 0.6 тэрбум төгрөгөөр тус тус үнэлсэн ба нийтдээ 18.9 тэрбум төгрөгөөр дахин үнэлснээр тус эргэлтийн бус хөрөнгө өссөн байна.

2022 -12- 12
БУРТГЭВ-02

График 6. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн хөрөнгийн бүтэц

Сая төгрөг, 2018 - 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт хөрөнгийн 10.1 хувийг эргэлтийн хөрөнгө, 89.9 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө нь 2018 оноос 2020 он хүртэлх хугацаанд буурч 3.5 тэрбум төгрөгт хүрсэн нь үнэт цаасны арилжааны шимтгэлийн орлого жил тутам буурсантай, арилжааны системийн лицензийн хорогдуулалт болон жил бүрийн ашиглалтын зардалтай холбоотой. Тухайлбал, хувьцааны арилжааны шимтгэл өмнөх онтой харьцуулахад 2019 онд 20 орчим хувиар, 2020 онд 55 хувиар тус тус буурсан байна.

Харин 2020 оноос 2022 онуудад нийт хөрөнгийн хэмжээ жилд дунджаар 220.5 хувийн өсөлт үзүүлж, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 26.1 тэрбум төгрөгт хүрсэн нь Үнэт цаас гаргагч эргэлтийн бус хөрөнгөдөө дахин үнэлгээ хийлгүүлсэн, нөгөө талаас ашигт ажиллагаа сайжирсантай холбоотой байна. Энэ хугацаанд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 2020 онтой харьцуулахад 1.96 тэрбум төгрөгөөр өссөн байна.

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

График 7. Эргэлтийн хөрөнгө, түүний бүтэц

Сая төгрөг, 2018-2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

Эргэлтийн хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2.6 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй байгаагаас 95.5 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, 3.8 хувь буюу 99.8 сая төгрөгийг дансны авлага болон бараа материал бүрдүүлж байгаа бол үлдсэн 0.7 хувь буюу 19.3 сая төгрөгийг бусад эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагааны орлогоо мөнгөн хөрөнгөөр бүрдүүлдэг ба хөрөнгө оруулалтыг ТУЗ-ийн шийдвэрээр хийдэг онцлогтой тул мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь эргэлтийн хөрөнгийн ихэнх хувийг бүрдүүлж байна. Үнэт цаас гаргагчийн дансны авлагыг гишүүн болон бүртгэлтэй компаниудаас авах хураамж бүрдүүлдэг ба дансны авлага нь жилд дунджаар 7.7 хувиар буурсан байна (дансны авлагын жилийн нийлмэл бууралт нь 31.3 хувьтай байна).

График 8. Үнэт цаас гаргагчийн нийт эргэлтийн бус хөрөнгө, түүний бүтэц

Сая төгрөг, 2018 – 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

2022 оны эхний хагас жилийн байдлаар Үнэт цаас гаргагчийн үндсэн хөрөнгө болон программ хангамж /биет болон биет бус хөрөнгө/ нь 23.5 тэрбум төгрөг байна. Үүнээс 21.0 хувь (4.9 тэрбум төгрөг)-ийг нь Улаанбаатар хотын төвд байрлах Монголын Хөрөнгийн Биржийн барилга бүрдүүлж байгаа ба Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь тус хөрөнгийн эзэмшлийн гэрчилгээгүй байна.[3] Үнэт цаас гаргагч хувьцаагаа олон нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат компани болсноор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тус барилгыг Үнэт цаас гаргагчийн өмчлөлд бүртгүүлэхийг зөвшөөрч, холбогдох арга хэмжээ авах чиглэлийг албан ёсоор мэдэгдсэн байна.

Мөн эргэлтийн бус хөрөнгийн 17.9 тэрбум төгрөг (76.2 хувь)-ийг биет бус хөрөнгө буюу "Милленниум Ай Ти" арилжааны цогц систем (7. 3 тэрбум төгрөг) ба газар эзэмших эрх (10.47 тэрбум төгрөг) бүрдүүлж байна.

[3] Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг Монгол Улсын "Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай" хуульд заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх журмыг батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд ажлын хэсэг ажиллаж байгаа ба уг журам батлагдсаны дараа "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн эзэмшилд байгаа төрийн өмчийн хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлэх боломжтой болохоор байна.

2. Эх үүсвэрийн бүтэц

Санхүүгийн тайлангийн өр төлбөр ба эздийн өмч хэсэг нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрийн бүтцийг харуулдаг. Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн бүтцээс харвал эздийн өмч буюу хувьцаа эзэмшигчийн хөрөнгө дийлэнх хэсгийг голчлон бүрдүүлж байна.

График 10. Эх үүсвэрийн бүтэц

Сая төгрөг, хувь, 2018 - 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

2018 оноос 2021 оны түүхэн дунджаар нийт эх үүсвэрийн 62.4 хувийг эздийн өмч, 36.4 хувийг дансны өглөг ба бусад өглөг, 1.4 хувийг бусад богино хугацаат өр төлбөрүүд эзэлж байна. Үнэт цаас гаргагч нь 2012 онд "Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп"-ийн бүтээгдэхүүн болох "Милленниум Ай Ти" арилжааны системийг авч суурилуулан нэвтрүүлсэн. Тус системийн ашиглалтын төлбөрийг дансны өглөгт бүртгэж, гэрээний дүнгээр төлдөг байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт эх үүсвэрийн 90.9 хувийг эздийн өмч, 8.2 хувийг үндсэн хөрөнгийн үнэлгээ болон элэгдлийн зардлаас үүссэн хасагдах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын өр , үлдсэн 0.9 хувийг бусад богино хугацаат өр төлбөр тус тус бүрдүүлж байна. Иймхүү нийт хөрөнгийн дийлэнх хэсгийг эздийн өмч бүрдүүлж байгаа нь Үнэт цаас гаргагч нь өрийн дарамтгүй, санхүүгийн тогтвортой байдал өндөртэй байгааг илтгэж байна.

3. Эздийн өмч

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Монгол Улсын Засгийн газраас эрх олгосны дагуу Монгол Улсын Сангийн яам хэрэгжүүлж байна. Үнэт цаас

СӨХ
2022 оны 12 сар 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12

гаргагчийн өөрийн хөрөнгө нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар 23.1 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 18.7 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдал, 446.3 сая төгрөгийн эздийн өмчийн бусад хэсэг, эргэлтийн бус хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэнтэй холбоотойгоор 18.9 тэрбум төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээс бүрдэж байна.

График 9. Эздийн өмчийн бүтэц
Сая төгрөг, 2018-2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

4. Хуримтлагдсан алдагдлын бүртгэлийн тухай

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч нь Монголын Хөрөнгийн Биржид хөрөнгө шилжүүлэх, санхүүжилт олгох зэргээр "Милленниум Ай Ти" арилжааны системийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлж байсан ба 2015 онд "Кэй Пи Эм Жи Аудит" ХХК-аар санхүүгийн тайланд аудит хийлгэхдээ "Милленниум Ай Ти" арилжааны системийн санхүүжилтийг Үнэт цаас гаргагчийн балансын бүртгэлд тусгах шаардлагатай хэмээн үзэж, хувьцаа эзэмшигчдийн бусад өмчийг 20.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, нөгөө талаас хуримтлагдсан ашгийг "Милленниум Ай Ти" арилжааны системийн хорогдуулсан дүнгээр бууруулсан нь Монголын Хөрөнгийн Бирж-ийн хуримтлагдсан алдагдлыг 16.7 тэрбум төгрөгт хүргэсэн. Үнэт цаас гаргагч нь жил бүрийн үйл ажиллагааны ашиг, алдагдлаар "Милленниум Ай Ти" арилжааны системийн санхүүжилтийн зардлыг нөхөж байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
1119277128
УЛААНБААТАР ХОТ

5. Санхүүгийн байдлын тайлангийн голлох харьцаанууд

Хүснэгт 22. Хөрвөх чадварын харьцаа
2018 - 2021 он, 2022 оны эхний хагас жил

	2018	2019	2020	2021	2022-II
Эргэлтийн харьцаа	0.98	0.65	0.31	3.05	1.11
Өрийн харьцаа	0.27	0.42	0.64	0.17	0.09
Авлагын эргэц	5.53	29.70	13.08	56.39	22.10

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн тооцоолол

Компани бүрийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч төрөл бүрийн санхүүгийн харьцаа үзүүлэлтээр санхүүгийн тайланг шинжилж болно. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны хувьд доорх үзүүлэлтийг голчлон авч үзлээ.

Эргэлтийн харьцаа нь 1 (нэг)-ээс их байх тусам сайн ба богино хугацааны өр төлбөрийг эргэлтийн хөрөнгөөр хэдэн удаа барагдуулах чадвартай байгааг илтгэдэг. Үнэт цаас гаргагчийн эргэлтийн харьцаа 2018-2020 онуудад хангалттай хэмжээнд биш байсан бол 2021 оноос эхлэн нэмэгдсээр 2022 оны эхний хагас жилийн байдлаар 1.11 байгаа нь богино хугацаат өр төлбөрийг эргэлтийн хөрөнгөөр 1 удаа хангалттай барагдуулах чадвартай болсон буюу хөрвөх чадварын удирдлагыг сайжруулахад чиглэн ажиллаж буйг илтгэж байна.

Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгөд эзлэх өр төлбөрийн хэмжээ жил тутам буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт хөрөнгийн 9.1 хувийг л эзэлж байгаа нь өр төлбөрийн дарамтгүй үйл ажиллагаа явуулж байгааг илтгэж байна.

Үнэт цаас гаргагчийн дансны авлагыг бүртгэлтэй болон гишүүн компаниудаас авах авлагууд эзэлдэг ба 2018 оноос авлагын эргэц сайжирч, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 22.10 болсон байгаа нь авлагаа илүү хурдан хугацаанд цуглуулж, бүртгэлтэй болон гишүүн компаниуд хариуцлагатай болж байгааг илтгэж байна.

2.12.2. Орлогын тайлан, шинжилгээ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлогыг үндсэн эх үүсвэрээр нь ангилбал:

- ✓ Арилжааны шимтгэлийн орлого: Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн авах, зарах захиалгын арилжааны үнийн дүнгээс тодорхой хувиар шимтгэлийн орлого олдог. Үүнд:

СЗХ
БҮРТГЭВ
№ 91

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-ОЗ

- Хувьцааны арилжааны шимтгэл;
- Компанийн бонд арилжааны шимтгэл;
- Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны шимтгэл;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжааны шимтгэл;

✓ Хураамж, үйлчилгээний орлого: Үнэт цаас гаргагч нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалах үнэт цаасыг бүртгүүлэх өргөдлийг хүлээн авах, хянаж бүртгэх үйлчилгээний хөлс, бүртгэлтэй компаниуд болон үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй гишүүнүүдээс жилийн үйлчилгээний хөлс авах зэргээр хураамж, үйлчилгээний орлогоо бүрдүүлдэг байна.

✓ Бусад үйл ажиллагааны орлого: Үнэт цаас гаргагчийн бусад үйл ажиллагааны орлогын эх үүсвэрийг гадаад болон дотоодын байгууллагуудад мэдээлэл нийлүүлэх, маркетингийн багцын үйлчилгээ, Хөрөнгө оруулагчид, Үнэт цаас гаргагчид, Үнэт цаас гаргах сонирхолтой байгууллагуудад сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөх, "Милленниум Ай Ти" систем ашиглалтын орлогоос тус тус бүрдүүлдэг байна.

1. *Борлуулалтын орлого*

График 10. Борлуулалтын орлого
Сая төгрөг, 2018 - 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

ХӨРӨНГИЙН
УЛААНБААТАР ХС
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч нь 10 гаруй нэр төрлийн үйлчилгээнээс борлуулалтын орлогоо бүрдүүлдэг бөгөөд үүнээс хамгийн өндөр буюу түүхэн дунджаар нийт борлуулалтын 50.0 хувийг хувьцааны арилжааны шимтгэлийн орлого бүрдүүлж байна. Хөрөнгийн зах зээлийн идэвхжил, эдийн засгийн нөхцөл байдлаас Үнэт цаас гаргагчийн орлого ихээхэн хамааралтай ба 2021 онд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буюу Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудын үнэлгээ 5.9 их наяд төгрөгт хүрч, нийт 1.4 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас арилжаалагдсанаас 74.1 хувийг компанийн бонд, 21.6 хувийг хувьцааны арилжаа тус тус бүрдүүлжээ. Үүнтэй холбоотойгоор 2021 онд нийт борлуулалтын орлого 5.48 тэрбум төгрөгт хүрсэн ба энэ нь 2018 онтой харьцуулахад 231.0 хувиар өссөн үзүүлэлт юм.

График 11. Борлуулалтын орлогын бүтэц

Сая төгрөг, хувь, 2018 - 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

2022 оны эхний хагас жилийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 1.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан ба үүний 64.7 хувийг хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааны шимтгэлийн орлого, 31.5 хувийг терминал ашигласантай холбоотой хураамж, бүртгэлийн үйлчилгээ болон бүртгэлтэй компаниудын жилийн хураамж, 5.8 хувийг бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны шимтгэлийн орлого, 12.6 хувийг бусад (сургалт, мэдээлэл үйлчилгээ, гишүүнчлэл) орлого тус тус бүрдүүлж байна.

2. Ерөнхий ба удирдлагын зардал

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардал нь ерөнхий ба удирдлагын зардал болон бусад зардлуудаас бүрддэг ба нийт үйл ажиллагааны зардал жил бүр тогтмол буурсан эерэг үзүүлэлттэй байна.

График 12. Нийт зардлын бүтэц

Сая төгрөг, 2018-2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

Үнэт цаас гаргагчийн ерөнхий ба удирдлагын зардлыг доорх 4 төрөлд ангилж үзэж болно:

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл
- ✓ Систем, программ хангамж ашиглалтын зардал
- ✓ Элэгдэл, хорогдлын зардал
- ✓ Бусад зардал

Ерөнхий ба удирдлагын зардалд ажилтнуудын цалин, нийгмийн даатгалын шимтгэл, хуулийн дагуу төлж буй бүх төрлийн татвар, хураамж, төлбөр, томилолт, бичиг хэрэг, шуудан холбоо, мэргэжлийн үйлчилгээ, сургалт, барилга байгууламжийн урсгал засвар, элэгдэл хорогдлын зардал, цэвэрлэгээ үйлчилгээ, шатахуун, соёлын арга хэмжээ, зар сурталчилгаа, болон мэдээллийн технологийн зардал зэрэг зардлууд багтдаг. Зардлын бүтцийг харвал, түүхэн дундаж үзүүлэлтээр нийт зардлын 30.5 хувийг "Миллениум Ай Ти" системтэй холбоотой зардал, 38.8 хувийг ажилчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 18.7 хувийг элэгдэл хорогдлын зардал, 1.1 хувийг маркетингийн зардал, үлдсэн 10.9 хувийг бусад үйл ажиллагааны зардал бүрдүүлж байна.

График 13. Ерөнхий удирдлагын зардлын бүтэц

Сая төгрөг, 2018 - 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

2022 оны эхний хагас жилийн байдлаар "Миллениум Ай Ти" системийн ашиглалтын зардал өмнөх оны жилийн эцсийн гүйцэтгэлтэй харьцуулахад 756.2 сая төгрөгөөр буурч, 37.8 сая төгрөгт хүрсэн нь "Миллениум Ай Ти" системийн өмнөх гэрээ дууссан, сунгах ажил хийгдэж байгаатай холбоотой байна. Уг системтэй холбоотой төлбөрийг гэрээний дагуу жил бүр "Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп"-ийн охин компани болох "Милленниум Ай Ти" компанид төлдөг байна.

3. Цэвэр ашиг

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого нь хөрөнгийн зах зээлийн идэвхжил, эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг бөгөөд 2021 онд цэвэр ашиг 3.1 тэрбум төгрөгт хүрч, 58.1 хувийн цэвэр ашгийн ахиуцтай ажилласан байна. 2018-2020 онуудад борлуулалтын орлого буурсан, "Милленниум Ай Ти" системтэй холбоотой тогтмол зардлууд, элэгдэл, хорогдлын зардлууд өндөр байсан нь цэвэр ашгийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байсан. Нийт борлуулалтын орлого 2019 онд өмнөх оноос 11.0 хувиар, 2020 онд 25.4 хувиар тус тус буурсан. Үнэт цаас гаргагч нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар 447.0 сая төгрөгийн ашигтай ажиллаж, цэвэр ашгийн ахиуц 30.3 хувьд хүрсэн байна.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

График 14. Цэвэр ашиг

Сая төгрөг, 2018 - 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

4. Элэгдэл, хорогдол, хүү, татварын өмнөх ашиг

Үнэт цаас гаргагч нь үндсэн хөрөнгө болон программ хангамжтай холбоотой жил бүр дунджаар 430.1 сая төгрөгийн элэгдэл, хорогдлын зардал бүртгэдэг бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлогоор программ хангамжийн лицензийн ашиглалтын хугацааг лицензийн хүчинтэй байх хугацааны дагуу хорогдуулж тооцдог байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

График 15. Элэгдэл, хорогдол, хүү, татварын өмнөх ашиг
Сая төгрөг, 2018 - 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

2018-2020 онуудад Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлого нь бусад онуудтай харьцуулахад бага байсан нь алдагдалтай ажиллахад хүргэсэн боловч 2021 онд зээлийн хүүг бууруулах стратеги болон цар тахлын үеийн эдийн засгийг сэргээх, эрчимжүүлэх бодлогын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд үйл ажиллагаа нь идэвхжиж, 3.4 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны ашигтай ажилласан байна

Хүснэгт 21. Ашигт ажиллагааны харьцаа
Хувь, 2018-2021 он, 2022 оны эхний хагас жил

	2018	2019	2020	2021	2022-II
Цэвэр ашгийн ахиуц	-76.0%	-78.3%	-94.3%	58.1%	30.3%
Ерөнхий ба удирдлагын зардал, орлогын харьцаа	1.77	1.77	1.90	0.22	0.67
Нийт хөрөнгийн өгөө	-26.5%	-27.7%	-28.6%	72.1%	2.8%
Эздийн өмчийн өгөөж	-31.8%	-41.9%	-60.4%	111.9%	3.2%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

Үнэт цаас гаргагч алдагдалтай ажиллаж байсантай холбоотойгоор 2018 оноос 2020 онуудад цэвэр ашгийн ахиуц, нийт болон эздийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт сөрөг утгатай байна. Энэ нь арилжааны систем ашиглалтын тогтмол зардал болон элэгдэл хорогдлын зардал өндөр байгаатай холбоотой ашигт ажиллагааны үзүүлэлтүүд хангалтгүй байсантай холбоотой. Харин сүүлийн 2 жилийн хугацаанд борлуулалтын орлого нэмэгдэж 2021 онд 58.1 хувийн цэвэр ашгийн ахиуц, 72.1 хувийн нийт хөрөнгийн өгөөж, 111.9 хувийн эздийн өмчийн

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

өгөөжтэй байсан нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа өргөжиж, гүйцэтгэл сайжирсныг илтгэж байна.

Харин 2022 оны эхний хагас жилийн байдлаар ашигт ажиллагааны үзүүлэлтүүд буурсан үзүүлэлттэй байгаад өмнөх оны мөн үетэй харьцуулахад борлуулалтын орлого буурсан; эргэлтийн бус хөрөнгөнд дахин үнэлгээ хийсэнтэй холбоотойгоор элэгдэл, хорогдлын зардал өмнөх онуудтай харьцуулахад нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Үнэт цаас гаргагчийн 2022 оны эхний хагас жилийн нийт хөрөнгийн болон эздийн өмчийн өгөөж харгалзан тус тус 2.8 хувь, 3.2 хувьтай байгаа нь үйл ажиллагааг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаатай холбоотой.

Ерөнхий ба удирдлагын зардал, орлогын харьцаа нь Үнэт цаас гаргагчийн 1 төгрөгийн борлуулалтын орлогод зарцуулж буй зардлын хэмжээг илэрхийлдэг бөгөөд жил тутам буурч, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 0.67 төгрөгт хүрсэн нь зардлын удирдлага сайжирч байгааг илэрхийлж байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ⁂ 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ⁂ 1119277128
УЛААНБААТАР ХОТ



III

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

3.1. Дэлхийн эдийн засгийн төлөв байдал

3.2. Олон улсын хөрөнгийн биржүүдийн үйл ажиллагаа

3.3. Монгол улсын эдийн засаг ба хөрөнгийн зах зээлийн төлөв

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СӨХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12

3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

3.1. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

3.1.1. Дэлхийн эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн төлөв байдал

2021 онд дэлхийн улс орнууд мөнгөний зөөлөн бодлогоос хатуу бодлого руу шилжиж, эрэлтийн гаралтай үнийн өсөлтийг хязгаарлах бодлогыг эхлүүлсэн. Цар тахлын хөл хорио, хязгаарлалтын дэглэм суларч, эдийн засгийн хэвийн үйл ажиллагаа аажмаар сэргэх хандлагатай байгаа ч сэргэлтийн хурд нь олон улсын харилцааны хурцадмал байдал, Бүгд Найрамдах Хятад Ард Улс (цаашид "БНХАУ" гэх)-ын "Тэг Ковид" бодлого болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хүндрэлтэй байдал, Европын орнуудад үүсээд буй эрчим хүчний хямрал зэргээс шууд хамаарна. Үүнтэй холбоотойгоор дунд хугацаанд дэлхий дахинд тодорхой бус байдал нэмэгдэхээр байна.

Иймд олон улсын санхүүгийн байгууллагууд 2022 оны сүүлээр дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг шинэчилж, дахин бууруулсан. Тухайлбал, Олон Улсын Валютын Сангийн 2022 оны 10 дугаар сарын шинэчилсэн төсөөллөөр дэлхийн улс орнуудын 2023 оны эдийн засгийн өсөлтийг өмнөх төсөөллөөс бууруулсан билээ. Үйлдвэрлэлийн өртөг нэмэгдэж, тээвэр логистикийн хүндрэлүүд үүссэнээр нийлүүлэлтийн тасалдал үүссэн нь дэлхийн инфляцын түвшин өсөх гол хүчин зүйл болсон. Эдгээр асуудлуудтай холбоотой тодорхой бус байдал хэвээр үргэлжилснээр дэлхийн улс орнуудын инфляц тогтворжих хугацаа нь хойшлогдох эрсдэлтэй байна. Төв Банкнууд мөнгөний бодлогоо шат дараатай чангаруулснаар дэлхийн эдийн засгийн өсөлт дунд хугацаанд удаашрах төлөвтэй байна. Энэхүү нөхцөл байдалд дараах улс орнуудын бодлого, авч буй арга хэмжээнүүд өндөр нөлөөтэй байна. Үүнд:

1. *Бүгд Найрамдах Хятад Ард Улс*

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт үл хөдлөх салбараас өндөр хамааралтай байсаар ирсэн. Үл хөдлөх салбарын өсөлт нь сүүлийн жилүүдэд удааширч байгаа нь БНХАУ-ын дотоодын зах зээлд төдийгүй олон улсын хөрөнгийн зах зээлд нөлөөлж байна.

БНХАУ-ын эдийн засгийн 2022 оны төсөөллийг Олон Улсын Валютын Сан 3.2 хувь, Дэлхийн Банк 2.8 хувь, Азийн Хөгжлийн Банк 3.3 хувь байхаар тус тус бууруулсан бол 2023 оны эдийн засгийн өсөлтийг Дэлхийн Банк 4.5 хувь, Олон Улсын Валютын Сан 4.4 хувь байна гэж тооцоолсон. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2023 онд Ази, Номхон Далайн Бүс Нутгийн улсуудын дундаж өсөлтөөс доогуур түвшинд орохоор байгаа нь сүүлийн 30 жилд тохиолдоогүй үйл явдал болох төлөвтэй байна гэж Дэлхийн Банк онцолсон байна.

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ
9020020699
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277120
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12

2021 оны байдлаар БНХАУ-ын эдийн засаг дэлхийн эдийн засгийн 18.8 хувийг эзэлж, эдийн засгийн хэмжээгээрээ дэлхийд 2 дугаарт жагсаж, дэлхийн эдийн засагт томоохон байр суурийг эзэлж байна.[4] Тус улс нь дэлхийн хамгийн томоохон үйлдвэрлэгч, мөн хэрэглэгч орны нэг ба нүүрсний хэрэглээгээрээ дэлхийд 1 дүгээрт эрэмбэлэгдэж, дэлхийн төмрийн хүдрийн хэрэглээний 70 хувийг, зэсийн хэрэглээний 52 хувийг тус тус эзэлсэн байна. Тус улсын гадаад худалдааны түншүүдээс Монгол Улс нь 2021 онд БНХАУ-ын нүүрсний импортын 5 хувийг нийлүүлсэн.[5] Цар тахлаас үүдсэн хилийн боомтуудын хүндрэлтэй холбоотойгоор Монгол Улсын нүүрсний экспорт буурсан боловч 2022 оны 8 дугаар сарын байдлаар БНХАУ-ын нүүрсний импортын 35 хувийг Монгол Улс хангасан байна.[6]

БНХАУ-ын Засгийн газар нүүрсний эрэлтийг хангах зорилгоор 2021 болон 2022 онуудад дотооддоо олборлолтоо 300 сая тонноор нэмэгдүүлсэн. Иймхүү БНХАУ-ын Засгийн газар дотоодын нүүрсний нийлүүлэлтээ цаашид зохистой хэмжээнд барих төлөвтэй байгаа нь нүүрсний үнийг огцом унахаас сэргийлж буй явдал юм. 2022 оноос хойш дунд хугацаанд нүүрсний үнэ буурах төлөвтэй байгаа боловч 2020 оны үнийн түвшнээс дээш түвшинд хадгалагдах таамаглалыг олон улсын судалгааны байгууллагууд гаргасан байна. Нүүрснээс гадна дэлхийн түүхий эдийн зах зээл дээрх гол бүтээгдэхүүнүүд болох зэс, төмрийн хүдрийн үнэ 2023 онд мөн буурах төлөвтэй ч дунд хугацаандаа өснө гэж Дэлхийн Банк тооцоолсон байна.[7]

2. Евро бүс

2022 оны 10 дугаар сард Олон Улсын Валютын Сан нь 2023 оны Евро бүсийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 2.8 хувиас 0.5 хувь болгож бууруулсан. Эрчим хүчний үнэ, үйлдвэрлэлийн өртгийн өсөлттэй холбоотойгоор Евро бүсийн эдийн засгийн өсөлт саарах төлөвтэй байна. 2022 оны 10 дугаар сарын байдлаар Евро бүсийн ДНБ-ий өсөлт мөн оны өмнөх үеэс 1.8 хувиар буурсан.[8] Евро бүсийн инфляцын түвшин мөн 2022 оны 10 дугаар сард 10.6 хувь болж, түүхэн дээд түвшинд хүрэв. Эрчим хүч болон хүнсний үнэ өсөхийн зэрэгцээ сүүлийн саруудад эрэлтээс үүдэлтэй инфляц нэмэгдэж, улмаар үнийн өсөлт эрчимжсэн. Тодруулбал, Евро бүсийн ажилгүйдлийн түвшин 2022 оны 8 дугаар сард 6.6 хувь буюу сүүлийн 25 жилийн хамгийн бага түвшинд хүрсэн. Улмаар өрхийн хэрэглээ нэмэгдэж эрэлтээс үүдэлтэй инфляцыг өдөөсөн байна. Үүнээс гадна, еврогийн ам.доллартой

---

[4]China's gdp accounts for percent of the world economy 2022 - Search (bing.com)
[5]https://montsame.mn/mn/read/281415
[6]https://gmk.center/en/news/coking-coal-imports-to-china-increased-by-25-5-y-y-in-january-august-2022/
[7]https://www.worldbank.org/en/news/press-release/2022/10/26/commodity-markets-outlook
[8]https://www.euro-area-statistics.org/inflation-rates?cr=eur&lg=en

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

харьцах ханш сүүлийн 20 жилийн доод түвшинд хүрсэн. Еврогийн ханшийн сулралтай холбоотойгоор тус бүсэд импортлогдсон барааны инфляц эрчимжих хандлагатай болж, Евро бүсийн Төв Банкнууд инфляцыг бууруулах зорилготойгоор бодлогын хүүгийн түвшнээ шат дараатай өсгөсөөр байна.

3. Америкийн Нэгдсэн Улс

Америкийн Нэгдсэн Улс (цаашид "АНУ" гэх)-ын инфляцын түвшин 2022 оны 10 дугаар сард 8 хувьд хүрч, өмнөх сараас 0.2 нэгж хувиар буурсан ч тус улсын инфляцын зорилтот түвшнээс өндөр хэвээр байна. Инфляцын түвшин буурснаар тус улсын ажилгүйдлийн түвшин 3.8 хувь болж, сүүлийн 50 жилийн хамгийн бага түвшиндээ хүрэв. Ажилгүйдлийн түвшин буурч, эдийн засаг халалттай байгаа энэ үед эрэлтээс үүдэлтэй инфляц нэмэгдэх хүлээлттэй гэж АНУ-ын Холбооны Нөөцийн сангаас үзэж байна.

АНУ-ын S&P500 индекс 2022 оны эхэн үеэс 2022 оны эхний хагас жил хүртэл 20 орчим хувиар унаснаар Их Хямралаас хойших хамгийн их уналттай хагас жил болов. Сүүлийн 10 гаруй жил өсөлттэй байсан технологийн салбарын хувьцааны ханшнууд 2022 оны эхэн үеэс тасралтгүй унасан юм. Тухайлбал, Nasdaq-100 индекс 30 гаруй хувь, Dow Jones индекс 15.9 хувиар унаж, технологийн компаниудын үнэлгээ 5.4 их наяд ам.долларoор буурсан байна.

График 16. Америкийн Нэгдсэн Улсын S&P500 индексийн өөрчлөлт

Жил, хувь, 1933 - 2022 оны 10 дугаар сар



Эх сурвалж: "Stifel" Хөрөнгө Оруулалтын Банк, 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр

Улс орнууд инфляцыг бууруулахын тулд бодлогын хүүгээ өсгөх нь компаниудын хувьцааны үнэлгээг бууруулах хандлагатай байдаг. Дэлхийн хэмжээнд инфляц

СЗХ
2022.12.14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -12- 12

өндөр байгаа энэ үед хөрөнгө оруулагчид эрсдэл багатай хөрөнгө оруулалтыг илүү сонирхож, хөрөнгөө өсгөхөөс илүүтэйгээр хөрөнгөө хамгаалах хандлагатай болдог байна. Ийм тохиолдолд хөрөнгө оруулагчид хөрөнгийнхөө үнэ цэнийг инфляцаас хамгаалахын тулд "defensive stock" буюу "хамгаалалтын" хувьцаанууд", Засгийн газрын бондууд, мөн алтыг хөрөнгө оруулалтын хэрэгслээрээ сонгох нь илүү түгээмэл болдог. 2022 оны хувьд хувьцаа болон бонд хоёул сөрөг өгөөжтэй байсан ховор тохиолдол болсон юм.

График 17. Америкийн Нэгдсэн Улсын бонд болон хувьцааны өгөөж
Хувь, 1926 – 2022 он



Эх сурвалж: "Stifel" Хөрөнгө Оруулалтын Банк

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
0917839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 -12- 12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

3.1.2. Олон улсын хөрөнгийн зах зээл

2021 онд дэлхийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 120.4 их наяд ам.долларт хүрснээр 2000 оноос хойш 291.5 хувиар, жилд дунджаар 6.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар хөгжингүй улсуудын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2000 оноос 59.5 их наяд ам.доллароор буюу нийт 209.7 хувиар өссөн. 2000 онд хөгжингүй орнуудын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь дэлхийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 92.3 хувийг эзэлдэг байсан бол 2000 оноос хойш хөгжиж буй улс орнуудын санхүүгийн зах зээл идэвхжиж, хөгжингүй улс орнуудын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь 2021 онд нийт зах зээлийн 73.0 хувийг бүрдүүлэх болсон байна. Хөгжиж буй орнуудын зах зээлийн үнэлгээ нь 2000 оноос 2021 он хүртэлх хугацаанд 30.1 их наяд ам.доллароор буюу 1,269.1 хувиар өссөн ба дэлхийн хөрөнгийн зах зээлд эзлэх хувь нь нэг хувиас 27.0 хувь болж өссөн юм.

График 18. Дэлхийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ
Их наяд ам.доллар, 2000–2021 он



Эх сурвалж: Дэлхийн Биржүүдийн Холбоо, 2021 он

Дэлхийн хөрөнгийн зах зээлийн өсөлтөд Ази, Номхон Далайн бүсийн хөгжиж буй орнуудын зах зээлийн өсөлт голлох нөлөө үзүүлсэн юм. Дэлхийн нийт 55,100 хувьцаат компаниудын 57.3 хувь нь Ази, Номхон Далайн бүс нутагт бүртгэлтэй байдаг байна. Ази, Номхон Далайн бүсийн нийт хувьцаат компаниудын 37.5 хувийг БНХАУ-д бүртгэлтэй хувьцаат компаниуд эзэлдэг.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
9020020699 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
8577813 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭЛ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

График 19. Дэлхийн бүртгэлтэй хувьцаат компаниудын тоо
Нэгж, 2000 – 2021 он



Эх сурвалж: Дэлхийн Биржүүдийн Холбоо, 2021 он

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Азийн бүс нутаг нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг биржийн тоогоороо тэргүүлж байна. Дэлхийн хэмжээнд нийт 282 Хөрөнгийн Бирж үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс Европын бүсэд 37 улс 56 биржтэй, Америк тивийн 38 улс орон 68 биржтэй, Африк тивийн 29 улс оронд 40 биржтэй, Номхон далайн 21 улс 21 биржтэй байна. Азийн бүс нутагт нийт 44 улс орнуудын 97 Хөрөнгийн Бирж үйл ажиллагаа эрхэлж байна.

Үндэсний томоохон хөрөнгийн биржүүд нь үнэт цаасны арилжаа зохион байгуулахаас гадна тухайн улс орны эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын итгэлийг өндөр түвшинд байлгах давхар үүрэгтэй ажилладаг. Эдгээр биржүүд нь олон нийтэд нээлттэй хувьцаагаа арилжаалах хүсэлтэй компаниудад хууль, аудит, засаглал, санхүүгийн зах зээлийн тухай шаардлагатай мэдээллүүдийг хүргэдэг. Үүнээс гадна биржүүд нь олон нийтэд нээлттэй компаниудыг биелүүлэх шаардлага, дагаж мөрдөх дүрэм журмаар хангаж, улмаар тус компаниудын чиглүүлэгч нь болж ажилладаг байна.

Дэлхийн хөрөнгийн биржүүдийн хөгжлийг тодорхойлогч, томоохон биржүүдийн дийлэнх нь нээлттэй хувьцаат компанийн бүтэцтэй байдаг. Зарим тохиолдолд хэд хэдэн биржийг, төлбөр тооцооны байгууллагын хамт нэгтгэн групп компанийн хэлбэрт өөрчлөн байгуулж, группийн толгой компанийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болгосон байна. Олон улсын жишигт хөрөнгийн биржийн хувьцааг хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулдаг хөрөнгийн удирдлагын компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд болон брокер, дилерийн компаниуд эзэмших нь элбэг.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
9020020699
2071006
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
1119277129
УЛААНБААТАР ХОТ

2022 -12- 12

2021 оноос хойш олон улсын хөрөнгийн биржүүд БОНЗ-ын тогтвортой хөгжлийн бодлогуудыг хангахад анхаарал хандуулах нь түгээмэл болсон. Дэлхийн Биржүүдийн Холбооноос жил бүр нийтэлдэг Тогтвортой хөгжлийн тайлангаас харвал хөгжингүй болон хөгжиж буй зах зээлүүдийн хөрөнгийн биржүүд тогтвортой байдлын зорилтуудыг хангаж ажиллах нь нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй гарсан байна. Өөрөөр хэлбэл, Тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцүүлсэн бодлого баримтлах хөрөнгийн биржийн тоо нэмэгдээд зогсохгүй, хэрэгжсэн зорилтууд ч нэмэгдсэн юм.

График 20. Тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийн хувь

Хувь, 2020 – 2021 он



Эх сурвалж: Дэлхийн Биржүүдийн Холбоо, Тогтвортой хөгжлийн тайлан, 2021 он

Ногоон бонд нь хамгийн эрэлттэй БОНЗ-ын бүтээгдэхүүн хэвээр байгаа ч үүнээс гадна маш олон "ногоон" бүтээгдэхүүн нэмэгдсэн байна. Дэлхийн Биржүүдийн Холбоо нь тус зорилтуудын хүрээнд "Тогтвортой хөрөнгийн бирж санаачилга"-тай хамтран ажилладаг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар "Тогтвортой хөрөнгийн бирж санаачилга"-д 130 хөрөнгийн бирж гишүүнээр бүртгэлтэй байна. "Тогтвортой хөрөнгийн бирж санаачилга" нь 5 жил дараалан "Компанийн нийгмийн хариуцлагын тайлан"-г нийтэлж, 2021 оны 2 дугаар сард хүлэмжийн хийний ялгарлыг бууруулах зорилтот бондын эхний багцыг эхлүүлсэн байна. Үүнээс гадна БОНЗ-д тулгуурласан индексүүдийг нэвтрүүлээд байгаа юм.

3.2. Олон улсын хөрөнгийн биржүүдийн үйл ажиллагаа

3.2.1. Хөгжингүй улсуудын хөрөнгийн биржүүдийн үйл ажиллагаа

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277123
УЛААНБААТАР ХОТ

Хөгжингүй зах зээл буюу "Developed market" гэх ангилалд нэг хүнд ногдох ДНБ өндөртэй, аж үйлдвэрлэлийн түвшин болоод дэд бүтцийн хөгжлөөрөө тэргүүлэх эдийн засгийн өндөр хөгжилтэй улс орнууд хамаардаг.

Хөгжингүй улс орнуудын эдийн засгийн өсөлтөд санхүүгийн зах зээлийн үүрэг оролцоо чухал бөгөөд голлох үүргийг гүйцэтгэдэг. Учир нь тэдгээр улс орнуудын хувьд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь ДНБ-ийн зуугаас дээш хувийг эзэлдэг гэсэн тоо баримт байдаг.[9]

Олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоолол, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон байгууллагууд өөрсдийн тогтоосон шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд дэлхийн хөрөнгийн зах зээлүүдийг үнэлэн ангилал тогтоодог. Энэ чиглэлээр дэлхийд тэргүүлэгч байгууллагуудын нэг болох Их Британийн "FTSE Russell" Групп нь олон улсын хөрөнгийн зах зээлийг дараах 4 үндсэн зэрэглэлээр ангилдаг:

- ✓ Өндөр Хөгжсөн буюу "Developed";
- ✓ Хөгжсөн буюу "Advanced Emerging";
- ✓ Үсрэнгүй хөгжиж буй буюу "Secondary Emerging";
- ✓ Хөгжиж буй буюу "Frontier".

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар "Developed" болон "Advanced Emerging" зах зээлийн ангилалд 35 улс багтаж байна. Эдгээр улсуудаас АНУ-ын хөрөнгийн зах зээл дэлхийн хамгийн том хөрөнгийн зах зээлд зүй ёсоор тооцоогддог. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар АНУ-ын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 51 их наяд ам.доллар байсан ба дэлхийн хөрөнгийн зах зээлийн 46.2 хувийг бүрдүүлж байна. АНУ-ын хөрөнгийн зах зээл нь сүүлийн 10 жилийн хугацаанд дэлхийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 37.4 хувийг дунджаар эзэлж байсан бол 2012 онд хамгийн доод түвшин буюу 32.9 хувьд хүрч байв.

[9]https://economictimes.indiatimes.com/markets/stocks/news/high-m-cap/gdp-not-a-worry-for-many-with-growth-strong/articleshow/89333702.cms?from=mdr

СЭХ
БҮРТГЭВ

2022 -12- 12
БҮРТГЭВ-02

График 21. Дэлхийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ
Улс, эзлэх хувь, 2022 оны 3 дугаар улирал



Эх сурвалж: Америкийн Нэгдсэн Улсын Үнэт цаас, санхүүгийн зах зээлийн холбоо

3.2.2. Хөгжиж буй улсуудын хөрөнгийн зах зээл

Эдийн засгийн хөгжлийн түвшнээр Хөгжиж буй буюу "Frontier" ангилалд хамаарах улсуудын хувьд эдийн засгийн үйлдвэрлэлийн гарц бага, нэг хүнд ногдох ДНБ болон аж үйлдвэрлэлийн түвшин харьцангуй доогуур, санхүүгийн зах зээл бүрэн хөгжөөгүй ч ирээдүйд хөгжих бүрэн боломжтой улсууд багтдаг.

Улс орнуудын эдийн засаг илүү боловсронгуй болж, өргөжин, тэлэхийн хирээр зах зээлийн өгөөж буурах хандлагатай байх бөгөөд үүний зэрэгцээ хямд буюу бага өртөгтэй, урт хугацаат санхүүжилтийн эрэлт хэрэгцээ нэмэгддэг байна. Иймээс хөгжиж буй улс орнуудын хувьд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, хөгжлийг эрчимжүүлэх нь өндөр ач холбогдолтой байдаг.

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 -12- 14
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

График 22. Зарим улсуудын компанийн санхүүжилтийн бүтэц
Хувь, 2021 он



Эх сурвалж: Америкийн Нэгдсэн Улсын Үнэт цаас, санхүүгийн зах зээлийн холбоо

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар "FTSE Russell"-ийн "Frontier" болон "Secondary Emerging" зах зээлийн ангилалд 43 улс багтаж байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээл 2022 оны 9 дүгээр сард "Frontier" буюу Хөгжиж буй зах зээлийн ангилалд орсон 29 дэх улс болсон. Үсрэнгүй хөгжиж буй улсуудын зах зээлийн томоохон төлөөлөл нь БНХАУ-ын хөрөнгийн зах зээл бөгөөд 2022 оны 10 дугаар сарын байдлаар тус улсын хөрөнгийн зах зээл дэлхийн хөрөнгийн зах зээлийн 10.6 хувийг эзэлдэг байна. БНХАУ-д 3 хөрөнгийн бирж үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөгжиж буй зарим улс орнуудын хувьд, ялангуяа Азийн улс орнууд хөрөнгийн зах зээлээ хөгжүүлэх, эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн оновчтой хэдэн хэдэн арга хэмжээ байдаг. Тухайлбал, 1997 оны санхүүгийн хямралын үед Азийн ихэнх улс орнууд хөрөнгийн зах зээл, тэр дундаа бондын зах зээлийг эрчимжүүлэх чиглэлээр оновчтой арга хэмжээ авсан. Үр дүнд нь аж ахуйн нэгжүүд болон эдийн засаг нь банкны салбараас хэт хамааралтай байх нь багасаж, хөрөнгийн зах зээл нь мөн идэвхэжжээ.

Мөн хөгжиж буй зарим улс орнууд төрийн өмч хувьчлалыг хөрөнгийн зах зээлээр дамжуулан хэрэгжүүлсэн нь зах зээлийн хөгжилд онцлохуйц эерэг нөлөө үзүүлсэн байдаг. Тухайлбал, Сингапур, Бүгд Найрамдах Солонгос Улсын хөрөнгийн биржүүд маш олон тооны төрийн өмчит компаниудын үнэт цаасыг арилжаалсан ба үр дүнд нь хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэж, төрийн өмчит компанийг хувьчилсан тохиолдол бүрд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь дунджаар даруй 170 хувиар өсөж байжээ. Эдгээр улсуудын туршлагаас харахад гол төлөв эрчим хүчний болон санхүүгийн салбарын төрийн өмчит компаниудын хувьчлал амжилттай явагдаж,

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН БИРЖ ТӨХК
9020020699 ☎ 3071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭЛ
№ 61

2022 -12- 12

тэдгээр улсуудыг MSCI Хөгжиж буй зах зээлийн индексийн жагсаалтад ороход чухал нөлөө үзүүлсэн байна.

Түүнчлэн төрийн өмчийн хувьчлал нь улс орнуудын төсвийн орлого, баялгийн хуваарилалтад чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Тухайлбал, Польш Улс 1990-2019 онуудын хооронд 28 гаруй тэрбум ам.доллар, Бразил Улс 20 тэрбум ам.доллар, Тайван 18 тэрбум ам.долларыг төсвийн орлогод төрийн өмч хувьчлалаар дамжуулан төвлөрүүлсэн байдаг. Төрийн өмчит компаниудын хувьчлалууд дунджаар ДНБ-ийн 1 хувийг бүрдүүлж байсан байна.[10]

3.2.3. Дэлхийн хөрөнгийн биржүүдийн туршлагууд

1. "Frontier" зах зээл

Казахстаны Хөрөнгийн Бирж

Казахстаны Хөрөнгийн Бирж нь 1993 онд үүсгэн байгуулагдсан.

Казахстан Улс өөрсдийн эдийн засгийг олон улсад илүү нээлттэй болгож, олон улсын худалдаа, арилжааг либералчилснаар Дэлхийн Банкны "Бизнес Эрхлэх Индекс"-д эзлэх байраа 2007 онд ахиулж чадсан. Гэсэн хэдий ч төрийн өмчит компаниуд олонтой, үнийн хяналт өндөртэй байсантай холбоотойгоор тус улсын олон улсад өрсөлдөх чадвар харьцангуй доогуур байсан. 2013 онд Казахстан Улсын төрийн өмчит томоохон компаниудын хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгож, Казахстаны Хөрөнгийн Биржээр дамжуулан арилжаалсан байдаг. Төрийн өмчит компаниудыг олон нийтийн эзэмшилд оруулснаар тус компаниудын санхүүгийн сахилга бат, ил тод байдал, засаглал сайжирч, улмаар үйл ажиллагаа нь тогтворжиход түлхэц болсон. Тус үйл явдал нь Казахстаны хөрөнгийн зах зээлийг идэвхжүүлж, хувьцааны төвлөрлийг сааруулж, эдийн засгийн үр ашигт байдлыг нэмэгдүүлсэн эерэг нөлөө үзүүлсэн билээ.

Төрийн өмчит компаниудын хувьцааг арилжаалснаар Казахстаны Хөрөнгийн Биржийн хөрвөх чадвар нэмэгдэж, Казахстаны үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхолтой мэргэжлийн хөрөнгө оруулагчдын тоо болон төрөл нэмэгдсэн.

Казахстан Улсын түүхэн жишээнээс үзэхэд, системийн нөлөө бүхий компаниудыг хувьчилж, олон нийтээс хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж, үйл ажиллагаа болон

[10]https://documents1.worldbank.org/curated/en/984431624443117178/pdf/Listing-State-Owned-Enterprises-in-Emerging-and-Developing-Economies-Lessons-Learned-from-30-Years-of-Success-and-Failure.pdf

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

засаглалыг нь сайжруулснаар улсын төсвийг илүү үр ашигтай зарцуулах боломж бүрдсэн байна. Улмаар улсын төсвийг нийтэд хувьцаагаа гаргах боломжгүй, зах зээлд эзлэх хэмжээ бага жижиг дунд бизнесүүдийг дэмжих хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглүүлсэн байна.

Казахстаны Хөрөнгийн Бирж нь зах зээлийн мэдээ, мэдээллийг сайжруулах чиглэлд ихээхэн анхаарч ажиллаж ирсэн бөгөөд 2017 оноос хойш хөрөнгийн зах зээлийн тухай мэдлэгийг олон нийтэд түгээх зорилгоор хөрөнгө оруулалтын талаар 20 гаруй төрлийн сургалт зохион байгуулсан байна. Үүнээс гадна тус бирж нь Казахстан Улсын 13 их сургуультай хамтын ажиллагааг хэрэгжүүлж, хамтын ажиллагааны хүрээндээ их сургуулийн багш нар болон оюутнуудад хөрөнгийн зах зээлийн тухай лекц, сургалтуудыг тогтмол зохион байгуулж иржээ. Сургалтуудыг хөрөнгийн зах зээлийн салбарын шилдэг мэргэжилтнүүд, Казахстаны Хөрөнгийн Биржийн ажилтнууд удирдан явуулдгаараа онцлогтой. Оюутнууд сургалтад хамрагдсанаар хөрөнгийн зах зээлд оролцогч байгууллагуудад дадлага хийх, ажиллах боломжтой болдог байна.

Тус бирж нь хөрөнгийн зах зээлийн талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхээс гадна хөрөнгийн зах зээлд оролцох сэдлийг төрүүлэх, зах зээлд оролцогчдыг идэвхжүүлэх үүднээс тодорхой арга хэмжээ авч ажиллаж иржээ. Тухайлбал, Казахстаны Хөрөнгийн бирж нь дунд болон ахлах ангийн сурагчид, их сургуулийн оюутнуудын дунд “Exchange Simulator” олимпиад зохион байгуулж ирсэн ба 2008 оноос хойш 80 гаруй их сургуулийн 7,500 гаруй оюутан, сурагчид тус олимпиадад Казахстан болон Казахстаны хөрш улсуудаас амжилттай оролцсон юм.

Мөн хөрөнгийн зах зээлийг сонирхдог, арилжаа хийх хүсэл сонирхолтой иргэдийн дунд Казахстаны Хөрөнгийн Биржийн нэрэмжит уралдааныг зохион байгуулдаг ба уралдаанд оролцогчид өөрсдийн үнэт цаасны дансаараа дамжуулан KASE Индексэд багтдаг компаниудын хувьцаанд хөрөнгө оруулан өгөөжөөрөө өрсөлддөг байна. 2016 оноос хойш тус уралдаанд 3,700 гаруй иргэн оролцсон.

2021 оны байдлаар 1.6 сая орчим жижиг буюу хувь хөрөнгө оруулагчид 1-ээс доошгүй удаа арилжаанд оролцсон байна. Казахстаны Хөрөнгийн Бирж дээр 2,964 хувьцаа, 385 биржээр арилжаалагддаг сан буюу Exchange Traded Fund, 302 бонд, 48 хадгаламжийн бичиг болон хадгаламжийн сертификатууд нийт 3,297 үнэт цаас бүртгэлтэй байна.

Казахстаны Хөрөнгийн Бирж нь хөрвөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд 2022-2024 онуудад дараах стратегийн зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлэхийг зорьж байна. Үүнд:

- ✓ БОНЗ-д тулгуурласан бүтээгдэхүүнүүд, гадаад үнэт цаас ба БОНЗ багцууд, биржээр арилжаалагддаг сан (ETF) багцын бүтээгдэхүүнүүдийг төрөлжүүлэх;
- ✓ Олон улсын биржүүд дээр арилжаагдаж буй үнэт цааснуудын арилжааг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх;
- ✓ Жижиг, дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжиж хөрөнгийн зах зээлд хөл тавихад урамшуулалтай хөтөлбөрийг бий болгож, гарааны бизнесүүдийг дэмжих өөрсдийн нэрэмжит хөтөлбөрийг зохион байгуулах.

Болгарын Хөрөнгийн Бирж

BULGARIAN STOCK EXCHANGE

Болгарын Хөрөнгийн Бирж нь 1995 онд Болгар Улсын 5 хөрөнгийн биржийг нэгтгэснээр үүсгэн байгуулагдсан. Болгар Улсад үйл ажиллагаа явуулж буй цор ганц Хөрөнгийн Бирж бөгөөд 1996 оноос эхлэн тус улсын төрийн өмчит компаниудыг хувьчлах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Хувьчлалын хөтөлбөрийн хүрээнд төрийн өмчит 1,000 гаруй компани нээлттэй компани болсон түүхтэй. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар Болгар Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь ДНБ-ийн 19.4 хувийг эзэлж байна.

Болгарын Хөрөнгийн Бирж нь 2000 оноос SOFIX индекс, 2005 оноос арилжааны идэвхээр тэргүүлэх компаниудаас бүрдсэн BG40, 2007 оноос өндөр орлоготой 30 компаниас бүрдсэн BG TR30, болон үл хөдлөх хөрөнгийн салбарын BG REIT индексүүдийг тус тус тооцоолж эхэлсэн. Тус бирж нь бүтээгдэхүүнүүдээ тогтмол төрөлжүүлж, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах санхүүгийн хэрэгслүүдийг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлдэг байна.

2000 онд Болгарын Хөрөнгийн Бирж нь "NASDAQ" арилжааны системд суурилсан, арилжааны системийг хөгжүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Мөн 2003 онд интернэтэд суурилсан бодит цагийн горимоор арилжаа хийх боломжтой арилжааны аппликэйшнийг нэвтрүүлсэн байна. Үүнээс гадна, тус бирж нь Болгарын Санхүүгийн Зохицуулах Хороо, Төвлөрсөн Хадгаламжийн Төвтэй хамтарч үнэт цаас гаргагчдын мэдээллийг олон нийтэд мэдээлэх нэгдсэн мэдээллийн системийг албан ёсоор нэвтрүүлсэн байна.

Болгарын Хөрөнгийн Бирж нь Европ, олон улсын томоохон байгууллагуудтай харилцаа холбоогоо өргөжүүлж, 2007 оноос Европын Үнэт Цаасны Биржүүдийн Холбооны (FESE - Federation of European Securities Exchanges) гишүүнээр элсэн орсон юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

Болгарын Хөрөнгийн Биржийн санал болгож буй зарим бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдээс дурдвал:

- ✓ Хөрөнгийн зах зээлтэй холбоотой бүх төрлийн мэдээ;
- ✓ Бүртгэлтэй компаниудын үнэт цаас, индексүүд дээр техник шинжилгээ хийх зориулалтын талбар;
- ✓ Хөрөнгө оруулалтын шинжээчдийн бэлтгэсэн тайлан, мэдээлэл, зар сурталчилгаатай танилцах, олон нийттэй харьцах боломжийг олгодог "X3 News" мэдээллийн үйлчилгээ;
- ✓ Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүүжүүлэх зорилготойгоор MFE BSE буюу жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих хамтын сан зэрэг олон нийтэд хүртээмжтэй санаачилгууд байна.

2. *"Secondary Emerging" зах зээл*

Шеньжэнийн Хөрөнгийн бирж

深圳证券交易所
SHENZHEN
STOCK EXCHANGE

Шеньжэнийн Хөрөнгийн Бирж нь БНХАУ-ын Үнэт Цаасны Зохицуулах Хорооны шууд удирдлага доор үйл ажиллагаагаа явуулдаг. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар 1,507 хувьцаат компани уг бирж дээр бүртгэлтэй байна. Тус бирж дээр төрийн өмчит компаниудын хувьцааг түлхүү арилжаалдаг. Арилжаалагдаж буй хувьцаа нь A, B гэсэн хоёр төрөлтэй бөгөөд A хувьцааг юаниар, B хувьцааг гадаад валютаар арилжаалдаг. Шеньжэнийн Хөрөнгийн Биржийн гол индекс болох "SZSE" багц индекс нь бирж дээрх хөрвөх чадвар өндөр, хамгийн том 500 компанийн А төрлийн хувьцаанаас бүрддэг билээ.

2016 оны 8 дугаар сарын 16-ны өдөр БНХАУ-ын Үнэт Цаасны Зохицуулах Хороо болон Хонг Конгийн Үнэт Цаас, Фьючерсийн Хороо нь "Шеньжэн - Хонг Конг Stock Connect хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зөвшөөрлийг Шеньжэнийн Хөрөнгийн Биржид олгосон. Тус хөтөлбөр хэрэгжсэнээр БНХАУ-ын хөрөнгө оруулагчид Хонг Конгд бүртгэлтэй компаниудад хөрөнгө оруулах боломжтой болж, гадаадын хөрөнгө оруулагчдад Хонг Конгийн Хөрөнгийн Биржээр дамжуулан Хятадын А төрлийн хувьцааг тодорхой хязгаарлалтын хүрээнд худалдан авах нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд БНХАУ-ын хөрөнгийн зах зээлд нэвтрэхэд тулгардаг байсан хүндрэлийг арилгаж, 1,500 гаруй Хятад компанид хөрөнгө оруулах боломжтой болсон.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2017 онд Шеньжэнийн Хөрөнгийн Бирж болон Люксембургийн Хөрөнгийн Биржүүд хамтран "ногоон" индексийг нэвтрүүлсэн. Тус индексийг байгаль орчинд ээлтэй ногоон төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан бондуудыг төрөлжүүлэх, тэдгээрийн үр ашгийг хэмжих үүднээс тооцоолж эхэлсэн. Улмаар БОНЗ-ын зорилтуудыг хамарсан, ногоон үйлдвэрлэлийг дэмжсэн 30 "ногоон" индексийг зах зээлд нэвтрүүлсэн байдаг. Шеньжэнийн Хөрөнгийн Биржийн зах зээлийн үнэлгээ нь 2020 онд 3.4 их наяд ам.доллар байсан бол 2022 онд 4.2 их наяд долларт хүрсэн байна.

Пакистаны Хөрөнгийн Бирж

2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр тухайн үед Пакистан Улсад үйл ажиллагаа явуулж байсан 3 бирж нэгдэж одоогийн Пакистаны Хөрөнгийн Бирж бий болжээ. Нэгтгэлд хамрагдсан биржүүдийн нэг болох Karachi Stock Exchange нь 1946 оны 9 дүгээр сарын 18-нд үүсгэн байгуулагдаж, 1949 оны 3 дугаар сарын 10-нд албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхлүүлсэн байна. Харин нэгтгэлийн дараагийн биржүүд болох Лахорын Бирж нь 1970 оны 10 дугаар сард Лахор хотод мужийн нийслэл хотын үнэт цаасны арилжаа явуулахаар байгуулагдсан бол Исламабадын Хөрөнгийн Бирж нь Пакистаны хойд нутгийн хөрөнгө оруулагчдад үйлчлэх зорилгоор байгуулагдаж байжээ. 2012 онд Пакистаны Засгийн газар нь "Хөрөнгийн биржийн тухай хууль"-ийг баталсан байдаг. 2022 оны хагас жилийн байдлаар Пакистан Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь улсын ДНБ-ийн 10.4 хувийг эзэлдэг ба "FTSE Russel"-ийн "Secondary Emerging" зах зээлийн ангилалд багтаж байна.

Пакистан Улсын Хөрөнгийн Бирж нь үнэт цаас гаргагчдад зориулсан олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг ба тэр дундаа жижиг, дунд үйлдвэрлэл, гарааны бизнесүүдийг дэмжих, мэргэжлийн хөрөнгө оруулагчдын урт хугацаат хөрөнгө оруулалтыг жижиг, дунд болон гарааны бизнесүүд рүү чиглүүлэхэд анхаарч ажилладаг байна. Үнэт цаас гаргагчдын мэдээллийн ил тод байдлыг хангахын тул "Corporate announcement feed" системээр дамжуулан бодит цагийн горимоор мэдээлэл түгээх боломжийг нээжээ. Пакистан Улсын Хөрөнгийн Биржийн зүгээс БОНЗ-ын шаардлагуудын тухай төлбөртэй болон төлбөргүй сургалтууд зохион байгуулж, аж ахуй нэгжүүдийн удирдлагуудын засаглалын тухай сургалтуудад хамруулж, тухайн жилд БОНЗ-ын бодлогын хүрээнд хэрэгжүүлэх хамгийн бага шалгуурыг тодорхойлж, олон нийтэд цахим хуудсаар дамжуулан түгээдэг байна. Мөн шинээр үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлтэй компаниудыг бүртгэлийн явц, хууль эрх зүйн орчин, болон бусад шаардлагатай мэдээллээр ханган зөвлөгөө өгч, гарын авлагууд бэлдэж хүргүүлдэг байна. Аж ахуйн нэгжүүдийг идэвхжүүлэх, дэмжих

ХӨРӨНГИЙН БИРЖ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

үүднээс тухайн жилийн үйл ажиллагаа, санхүү, БОНЗ-ын бодлого болон засаглалын гүйцэтгэлээр эрэмбэлэн шалгаруулж, шагнах ажлыг хэрэгжүүлдэг.

Тус бирж нь бүртгэлтэй компаниудыг үнэт цаасны ангилал болон тодорхой шалгууруудын дагуу ангилан шинэ индексүүд үүсгэж тооцоолдог. Жишээлбэл, банк, төрийн өмчит компаниуд болон жижиг дунд үйлдвэрийн компаниудаас бүрдэх эдийн засгийн салбарын индексүүд, хөрвөх чадвар хамгийн өндөр компаниуд, ногдол ашиг тогтмол тараадаг 20 компани, сүүлийн 1 сар ашигтай ажилласан компаниуд зэрэг шинж чанаруудад суурилсан индексүүд болон олон улсын индексүүдэд суурилсан индексүүд зэргийг тооцоолдог байна.[11] Мөн зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор зах зээл үүсгэгчийн тогтолцоог нэвтрүүлсэн байна.

Пакистаны Хөрөнгийн Бирж нь хөрөнгө оруулагчдад зориулсан олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг. Хөрөнгө оруулагчдад зориулсан цахим болон танхимын сургалтуудыг тогтмол зохион байгуулж, хөрөнгө оруулагчдад зориулсан гарын авлага, хөрөнгө оруулалтын эрсдэл, үр ашиг болон хөрөнгө оруулагчдын эрх, үүргийн талаар мэдээ мэдээлэл зэргийг бэлтгэн цахим хуудсаараа тогтмол түгээдэг байна. Мөн хөрөнгийн зах зээлийн талаар судалгааны ажлууд, гадаад, дотоод зах зээлийн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан Англи болон Пакистан хэлээр түгээдэг. Зах зээлийг сонирхогч ард иргэд, их дээд сургуулийн оюутнуудын дунд Үүсмэл санхүүгийн хэрэгслийн виртуал тэмцээн (Derivatives Virtual Trading Challenge)-ийг тогтмол зохион байгуулдаг нь иргэдийг хөрөнгийн зах зээлд идэвхтэй оролцоход эерэг нөлөө үзүүлдэг байна.

Түүнчлэн, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах сан (Centralized Consumer Protection Compensation Fund)-г үүсгэн байгуулсан бөгөөд энэхүү сан нь хөрөнгө оруулагчдын санал, гомдлыг цахим хуудсаар хүлээн авч, шийдвэрлэх ажлыг гүйцэтгэдэг байна.

[11] https://www.borsaistanbul.com/en/sayfa/2329/spoic-comcec-50-shariah-index

СЗХ
2022 -12- 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -12- 12
БҮРТГЭВ-02

3. *"Developed" зах зээл*

Туркийн Хөрөнгийн Бирж

Турк Улсын Хөрөнгийн Бирж нь 1985 онд анх үүсгэн байгуулагдсанаас хойш хурдацтай хөгжиж, "FTSE Russel"-ийн "Advanced Emerging" ангилалд багтах болсон. Тус бирж нь арилжаалагдах бүтээгдэхүүний нэр төрөл, үзүүлэх үйлчилгээний чанар болоод шинэлэг байдалд ихээхэн анхаарч ажилладаг. Тодруулбал, тус бирж нь нээлттэй, хаалттай хүрээнд гаргасан бонд, евробонд, хувьцаа, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, индексэд суурилсан бүтээгдэхүүн, гадаад валют, засгийн газрын үнэт цаас, үнэт металл болон эрчим хүчид суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг зохион байгуулдаг. Улсын эдийн засгийн онцлогоос хамаарч үнэт металл, алт, алмазын бүтээгдэхүүнд суурилсан үнэт цаас гаргаж, бүртгэн, арилжаалах, зээлэх боломжтой байна. Мэдээллийн терминал, өгөгдлийн сангийн байгууллагуудад зах зээлийн мэдээ, үнэт цаасны ханш, индекс, зах зээлийн оролцогчид болон бүртгэлтэй компаниудын талаар мэдээ мэдээллийг мэдээллийн терминал, өгөгдлийн сангийн байгууллагуудад төлбөртэй нийлүүлэн борлуулах үйлчилгээг үзүүлдэг байна.

2013 онд Турк Улс алт, дериватив болон үнэт цаасны биржүүдээ нэгтгэж, Борса Истанбул Биржийг бий болгосон. 2019-2021 оны стратеги төлөвлөгөөгөөр үйл ажиллагааны үр ашгийг сайжруулж, хөрөнгийн зах зээлийн бусад оролцогч талуудтай үр ашигтай харилцаа холбоо тогтоох чиглэлд илүү анхаарч, цаашид бүс нутгийн санхүүгийн төв болох томоохон зорилгыг тодорхойлсон байна. Уг зорилгын хүрээнд олон төрлийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлж, дэд бүтцээ сайжруулах ажлуудыг шат дараатайгаар хийж байна. Бусад оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд хамтран ажиллах олон улсын биржүүд болон түншүүдийн тоог нэмэгдүүлэх, тэдэнтэй хамтын ажиллагаагаа сайжруулахаас гадна хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх зорилтуудыг хэрэгжүүлж байна. Одоогийн байдлаар тус бирж нь Лондонгийн Хөрөнгийн Бирж, LCH.Clearnet, Исламын Хөгжлийн Банк, Египет Улсын Хөрөнгийн Бирж, NASDAQ болон Төв Азийн орнуудын хөрөнгийн биржүүдтэй стратегийн хүрээнд хамтран ажиллаж байна.

Турк Улсын Хөрөнгийн Бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Клирингийн төв, кастодиан банкнууд нь нэгдэн группийн бүтцээр ажиллах болсон нь үйл ажиллагаагаа сайжруулж, зардлаа бууруулж илүү үр ашигтай ажиллахад тус болсон байна.

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭЛ
№ 01

2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Нью-Йоркийн Хөрөнгийн Бирж

1800-аад оны эхэн үед Нью-Йоркын Хөрөнгийн Бирж нь засгийн газрын бонд, банкны хувьцааг арилжаалж, өргөжин тэлсэн бөгөөд Дэлхийн хоёр дугаар дайнаас хойш зах зээлийн үнэлгээгээр дэлхийн хамгийн том хөрөнгийн биржээр тооцогдсон хэвээр байна. АНУ-ын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь 2022 оны 10 дугаар сарын байдлаар 22.1 их наяд ам.долларт хүрсэн.

Нью-Йоркийн Хөрөнгийн Бирж нь "Intercontinental Exchange Inc" компанийн охин компани юм. "Intercontinental Exchange Inc" нь нээлттэй хувьцаат компани бөгөөд компанийн хувьцааны 47.4 хувийг хамтын хөрөнгө оруулалтын сангууд, 43.8 хувийг бусад мэргэжлийн хөрөнгө оруулагчид, үлдсэн 1.8 хувийг хувь хүмүүс эзэмшиж байна. Хувьцаа эзэмшигчдийн бүтцийг харвал хамгийн том 10 хувьцаа эзэмшигчид нь томоохон хөрөнгө оруулалтын сангуудын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлдэг, хөрөнгө оруулалтын зөвлөх, хөрөнгийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байгууллагууд байна. Ийнхүү хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид нь хөрөнгийн биржийн хувьцаа эзэмшигчид болсноор арилжааны эргэлт, идэвхийг өндөр түвшинд хүргэх зорилтуудыг тавьж, хөрөнгийн зах зээлийн урт хугацааны тогтвортой, үр ашигтай ажиллагааг хангахад хамтран ажиллах сонирхлыг нэмэгдүүлдэг.

Хүснэгт 22. Нью-Йоркийн Хөрөнгийн Биржийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигч	Эзэмшлийн хувь	Үйл ажиллагааны чиглэл
The Vanguard Group, Inc.	7.26%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
BlackRock Fund Advisors	4.48%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
SSgA Funds Management, Inc.	4.18%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
SSgA Funds Management, Inc.	4.18%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
Capital Research & Management	3.96%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
Magellan Asset Management Ltd.	3.89%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
Capital Research & Management	3.43%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
Magellan Asset Management Ltd.	3.89%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
Capital Research & Management	3.43%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
T. Rowe Price Associates, Inc.	2.69%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Lazard Asset Management LLC	2.52%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
Morgan Stanley Investment Management	1.91%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Биржийн "Хүртээмжтэй хөрөнгийн зах зээл" ном

Японы Хөрөнгийн Бирж

"Japan Exchange Group" нь Токиогийн Хөрөнгийн Бирж, Осакагийн Хөрөнгийн Бирж, Токиогийн Түүхий Эдийн Бирж, Үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага зэрэг хэд хэдэн компаниас бүрдсэн группийн толгой компани юм. Тус групп нь нээлттэй хувьцаат компани бөгөөд нийт хувьцааны 28.5 хувийг санхүүгийн байгууллагууд, 23.6 хувийг үнэт цаасны компаниуд, 41.3 хувийг гадаад болон бусад хөрөнгө оруулагчид эзэмшдэг бол үлдсэн 3.6 хувийг жижиг буюу хувь хөрөнгө оруулагчид болон Японы бусад компаниуд тус тус эзэмшдэг байна.

Тус группийн хамгийн том 10 хувьцаа эзэмшигчид нь кастодиан банк, хөрөнгө оруулалтын сан болон хөрөнгийн менежментийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд байна.

Хүснэгт 23. Японы Хөрөнгийн Биржийн хамгийн том 10 хувьцаа эзэмшигчид

Хувьцаа эзэмшигч	Эзэмшлийн хувь	Үйл ажиллагааны чиглэл
The Master Trust Bank Of Japan, Ltd.	6.11%	Кастодиан банкны, хөрөнгө оруулалтын сан
Japan Trustee Services Bank, Ltd.	4.38%	Кастодиан банкны, хөрөнгө оруулалтын сан
Smbc Nikko Securities Inc.	3.59%	Хөрөнгө оруулалт санхүүгийн цогц үйлчилгээ
Japan Trustee Services Bank, Ltd.	2.72%	Кастодиан банкны, хөрөнгө оруулалтын сан
Northern Trust Co.	2.69%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
The Bank Of New York	2.45%	Хөрөнгө оруулалтын банк
Japan Trustee Services Bank, Ltd.	2.15%	Кастодиан банкны, хөрөнгө оруулалтын сан
Jp Morgan Chase Bank	1.76%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
State Street Client Omnibus Account	1.43%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
Mufg Bank, Ltd.	1.41%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Биржийн "Хүртээмжтэй хөрөнгийн зах зээл" ном

Японы Хөрөнгийн Бирж нь Япон Улсын, олон улсын, ногдол ашиг, тогтвортой байдлын, таваарын болон үл хөдлөх хөрөнгийн индексүүд, бонд, хувьцааны опцион, үнэт металл, газрын тос, эрчим хүчний спот, фьючерсийн арилжаа, автомашины

СЗХ
2022 .12. 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

дугуйны резиний фьючерс, болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний арилжааг зохион байгуулдаг байна.

Хонг Конгийн Хөрөнгийн Бирж

Хонг Конгийн Хөрөнгийн бирж нь зах зээлийн үнэлгээгээр дэлхийд тав дугаарт эрэмбэлэгддэг, Азийн 3 дахь том хөрөнгийн бирж юм. Тус бирж дээр нийт 2,538 компани бүртгэлтэй байна.

Хонг Конгийн Хөрөнгийн Биржийг "Hong Kong Exchange and Clearing Limited" гэх толгой компани эзэмшдэг бөгөөд тус компани нь Хонг Конгийн Фьючерсийн Бирж, Хонг Конгийн Төлбөр Тооцооны төв зэрэг компаниудыг мөн эзэмшдэг байна. "Hong Kong Exchange and Clearing Limited" нь нээлттэй хувьцаат компани юм.

Хонг Конгийн Хөрөнгийн Биржийн хамгийн том 10 хувьцаа эзэмшигчдийн дунд төрийн ганц байгууллага байдаг бөгөөд бусад нь хөрөнгийн менежмент, хөрөнгө оруулалтын зөвлөх, хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд байдаг байна.

Хүснэгт 24. Хонг Конгийн Хөрөнгийн Биржийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигч	Эзэмшлийн хувь	Үйл ажиллагааны чиглэл
Government of Hong Kong Special Administrative Region	5.90%	Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага
State Street Global Advisors Asia Ltd.	3.03%	Хөрөнгийн менежмент
Thornburg Investment Management, Inc.	2.85%	Хөрөнгийн менежмент
Horizon Kinetics Asset Management LLC	2.70%	Хөрөнгийн менежмент
The Vanguard Group, Inc.	2.32%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
Capital Research & Management Co. (World Investors)	1.83%	Хөрөнгө оруулалтын зөвлөх, хөрөнгийн менежмент
Baillie Gifford & Co.	1.70%	Хөрөнгийн менежмент
Invesco Advisers, Inc.	1.68%	Хөрөнгө оруулалтын зөвлөх, хөрөнгийн менежмент
JPMorgan Investment Management, Inc.	1.55%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент
E Fund Management Co., Ltd.	1.52%	Хөрөнгө оруулалтын банк, хөрөнгийн менежмент

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Биржийн "Хүртээмжтэй хөрөнгийн зах зээл" ном, 2021 он

ХӨРӨНГИЙН БИРЖ
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ш.д. 2011096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ш.д. 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СӨХ
он 03 сар 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ

3.3. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ БА ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ

3.3.1. Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал

1. Дотоодын нийт бүтээгдэхүүн

2021 онд Монгол Улсын экспортын үндсэн түүхий эдүүдийн үнэ өссөн хэдий ч уул уурхайн салбарын нийлүүлэлт буурсан. Үүнд гадаад худалдааны хязгаарлалт, геополитикийн хурцадмал нөхцөл байдал, БНХАУ-ын "Тэг Ковид" бодлого, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн уналт зэргийн улмаас гадаад эрэлт саарсан нь нөлөөлсөн байна.

2022 оны дундаас эхлэн хилийн боомтууд дээрх хязгаарлалт суларч, нүүрсний тээвэрлэлт сэргэж байгаатай холбоотойгоор 2021 онд уналттай байсан уул уурхайн салбар өссөн үзүүлэлттэй байна. Түүнчлэн улс орнуудын цар тахлын эсрэг хөл хорионы дэглэм суларч, дотоод эрэлт сэргэсний үр дүнд худалдаа, үйлчилгээний зарим салбаруудын идэвхжил нэмэгдсэн. Ингэснээр уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн. Мөн цаг агаарын таатай нөхцөл байдалтай уялдан малын зүй бус хорогдол бага, мал төллөлтийн явц сайн байснаар хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн байна.

График 23. Монгол Улсын бодит Дотоодын Нийт бүтээгдэхүүний өсөлт
Хувь, 2018 – 2021 он, 2022 – 2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан, 2022 оны 10 дугаар сар

Олон Улсын Валютын Сангийн таамаглалаар Монгол Улсын эдийн засаг 2023-2027 онуудад дунджаар 4.8 хувийн өсөлт үзүүлэх төлөвтэй байна.

ХӨРӨНГИЙН
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277129
УЛААНБААТАР ХОТ

Гадаад худалдаа

2018 оноос 2021 он хүртэл гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 24.9 хувиар буюу 3,209 сая ам.долларoор өсөж, 16,096 сая ам.долларт хүрсэн. Үүнд, нийт экспорт 31.9 хувиар буюу 2,235 сая ам.долларoор, импорт 16.6 хувиар буюу 974 сая ам.долларoор өссөн нь нөлөөлсөн байна. Тус хугацаанд гадаад худалдааны тэнцэл 2,399 сая ам.долларын эерэг тэнцэлтэй гарсан байна. 2021 онд газрын тосноос бусад түүхий эдийн экспортын биет хэмжээ буурсан ч уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотойгоор экспортын орлого 22 хувиар нэмэгдсэн.

График 24. Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл
Хувь, 2018 – 2021 он, 2022 – 2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан, 2022 оны 10 дугаар сар,
Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо

2022 оны хагас жилийн байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 9,256 сая ам.долларт хүрэв. Үүнд, нийт экспорт 5,308 сая ам.доллар, импорт 3,948 сая ам.доллар байна. Тайлант хугацаанд гадаад худалдааны тэнцэл 1,360 сая ам.долларын эерэг тэнцэлтэй гарсан. Нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ өсөж, импортын үнийн индекс 19.2 хувиар нэмэгдсэн хэдий ч нөгөө талаас нүүрсний экспортын үнэ 33.0 хувиар өссөн нь худалдааны нөхцөл сайжрахад голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хилийн хязгаарлалтууд суларснаар, Оюу Толгойн ил уурхайн үйлдвэрлэлийн агууламж сэргэн, далд уурхайн үйлдвэрлэл 2023 оны сүүл үеэс жигдэрч эхэлбэл экспортын орлогыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлөх төлөвтэй байна.

СЗХ
БҮРТГЭЛ
БҮРТГЭВ-02

Инфляц

2021 онд Монгол Улсын инфляц 14.8 хувьд хүрсэн ба энэхүү огцом өсөлтөд шатахууны үнийн өсөлт, импортын бараа бүтээгдэхүүний саатал, тээвэрлэлтийн салбар дахь үнийн нэмэгдэл, хорио болон бусад хүндрэлүүд голлох нөлөө үзүүлсэн. Дотоодын хэрэглээний 60 гаруй хувийг импортоор авдаг Монгол Улсын хувьд импортын барааны тасалдлаас үүдэж барилгын материал болон бусад бараа бүтээгдэхүүнүүдийн үнэ хурдацтай өссөн.

2022 оны хагас жилийн байдлаар инфляц 16 хувь болж өссөн нь гадаад улсуудын геополитикийн нөхцөл байдал, гадаад худалдааны тогтворгүй байдал, хориг арга хэмжээнүүд зэрэг хүчин зүйлүүдээс үүдсэн. Шинжээчид инфляцын түвшинг 2023 оныг дуустал Монголбанкны зорилтот интервалаас давсан хэвээр байна хэмээн таамаглаж байна. Махны үйлдвэрлэл нэмэгдэж, дэлхийн зах зээл дээр хүнс, эрчим хүчний үнэ буурч, Монгол Улс Оросын Холбооны Улсаас газрын тосны бүтээгдэхүүнийг хямдралтай үнээр авах тохиролцоонд хүрсэн зэрэг нь инфляцыг бууруулах боломжтой байна.

График 25. Монгол Улсын инфляц

Хэрэглээний үнийн индексээр тооцсон, хувь, 2018 – 2021 он, 2022 – 2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Олон Улсын Валютын Сан, 2022 оны 10 дугаар сар

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2021 онд жилийн дүнгээр 222 сая ам.долларын алдагдалтай гарсан. Энэ нь хил гаалийн хязгаарлалт, тээвэр логистикийн асуудалтай холбоотойгоор нүүрс болон үндсэн түүхий эдүүдийн экспорт зорилтот дүндээ хүрээгүйтэй холбоотой. 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр урсгал дансны алдагдал 81.8 хувиар өсөж, 1,978 сая ам.долларт хүрснээр төлбөрийн тэнцлийн нийт алдагдал өмнөх оноос 836 сая ам.долларoop өсөж, 1,058 сая ам.долларт хүрсэн.

График 26. Монгол Улсын төлбөрийн тэнцэл

Ам.доллар, 2018 – 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Монголбанкны "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл"

Гадаад өр

2022 оны эхний хагас жилд Монгол Улсын Засгийн газрын гадаад өр өмнөх оны мөн үеэс 408.6 сая ам.долларoop буурч, 8,062.6 сая ам.доллар болсон нь олон улсын зах зээлд арилжаалсан зарим бондын үндсэн төлбөрийг төлсөнтэй холбоотой. Монголбанкны гадаад өр 2022 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 244.7 сая ам.долларoop өсөж, 2,483.4 сая ам.долларт хүрсэн байна.

2023-2024 онуудад бондын эргэн төлөлтүүд хийгдэхээр хүлээгдэж байна. Тухайлбал, "Чингис" бондын үлдэгдэл 138 орчим сая ам.доллар, "Гэрэгэ" бондын үлдэгдэл 533 орчим сая ам.доллар, "Сэргэн мандалт" евробондын үлдэгдэл 500 сая ам.доллар, "Самурай" бондын үлдэгдэл 235 сая ам.доллар, "Хуралдай" бондын үлдэгдэл 600 сая ам.доллар, Хятадын Ардын Банктай хийсэн своп хэлцэл зэрэг

СЭХ
2022 12 14
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ

төлбөрүүд 2023, 2024 онуудад төлөгдөх хуваарьтай байна. "Самурай" бондоос бусад өр, төлбөрүүдийг гадаад бонд, зээлээр дахин санхүүжүүлэх ба санхүүжилтийн эрсдэл үүсэх тохиолдолд ДНБ-д эзлэх Засгийн газрын өрийн хэмжээ 60.7 хувиас 65.0 хувьд хүрэхээр байгаа нь Засгийн газрын өрийн таазанд тулах нөхцөлийг үүсгэж болзошгүй байна.

Хүснэгт 25. Монгол Улсын үндсэн бондын санхүүжилтүүдийн тухай мэдээлэл, 2022 оны 3 дугаар улирлын байдлаар

Үнэт цаас гаргагч	Бонд	Валют	ISIN дугаар	Дуусах огноо	Үндсэн төлбөрийн үлдэгдэл	Купоны хэмжээ
Монгол Улсын Засгийн Газар	Mongolia 17/24 (Хуралдай)	ам.дол-лар	USY6142N AA64	2024/03/09	600 сая	8.75 хувь
	Mongolia 17/23 (Гэрэгэ)	ам.дол-лар	USY6142N AB48	2023/05/01	533 сая	5.63 хувь
	Mongolia 20/26 (Номад)	ам.дол-лар	USY6142N AC21	2026/04/07	600 сая	5.13 хувь
	Mongolia 12/22 (Чингис)	ам.дол-лар	US60937G AB23	2022/12/05	138 сая	5.13 хувь
	Mongolia 21/27 (Century)	ам.дол-лар	USY6142N AF51	2027/07/07	500 сая	3.5 хувь
	Mongolia 21/31 (Century)	ам.дол-лар	USY6142N AE86	2031/07/07	500 сая	4.45 хувь
Монгол Улсын Хөгжлийн банк	DBM' 23 (Самурай)	япон иен		2023/12/25	30 тэрбум	1.52 хувь
	DBM 18/23 (Сэргэн мандалт)	ам.дол-лар	USY2056P AA40	2023/10/23	500 сая	7.25 хувь
МИК ОССК	MGMTGE 21/24 (Бөртэ)	ам.дол-лар	USY6142G AB96	2024/02/08	250 сая	8.85 хувь

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 Ш. 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ... 7128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Монголиан Майнинг Корпорэйшн	ММС' 19/24	ам.дол-лар	USG61759 AA70	2024/04 /15	440 сая	9.25 хувь

Эх сурвалж: Монголбанкны "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл"

Бодлогын хүү, Мөнгөний нийлүүлэлт

Монголбанк 2020 оноос эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор бодлогын хүүг үе шаттайгаар бууруулж, 6 хувьд хүргэсэн боловч гадаад орчинд бий болсон өөрчлөлт, түүнтэй холбоотой логистикийн хүндрэлээс үүдсэн зардлын шалтгаантай хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляцын түвшин 2021 оны эцэст улсын хэмжээнд 11.2 хувь болон нэмэгдсэн. Иймд Монголбанк нь инфляцыг бууруулах зорилготойгоор бодлогын хүүг 2022 оны 1 дүгээр сарын 31-нд 0.5 нэгж хувиар, 3 дугаар сарын 24-нд 2.5 нэгж хувиар, 6 дугаар сарын 22-нд 1 нэгж хувиар, 9 дүгээр сарын 20-нд 2 нэгж хувиар тус тус нэмэгдүүлэн 12 хувьд хүргэсэн.

Хүснэгт 26. Монголбанкны бодлогын хүү

Хувь, 2018 оны 3 дугаар сараас 2022 оны 6 дугаар сар



Эх сурвалж: Монголбанкны цахим хуудас

Дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдлын улмаас эдийн засгийн үйлдвэрлэл буурч, инфляц өндөр түвшинд хүрсэн. АНУ-ын "Холбооны Нөөцийн сан" инфляцын өсөлтийг бууруулах зорилгоор 2022 оны 3 дугаар сараас эхлэн бодлогын хүүгээ 2.97 нэгж хувиар өсгөв.

Монголбанк бодлогын хүүг 2020 оны 11 дүгээр сард 6 хувь болгон бууруулсантай холбоотойгоор мөнгөний нийлүүлэлт (М2 мөнгө) 2021 онд өмнөх оны мөн үеэс 15 хувиар өсөж, 27.9 их наяд төгрөгт хүрч байсан. М2 мөнгөний жилийн өсөлтийн 9.1

ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
Үнэт цаас гаргагч
Андеррайтер
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

2022 -12- 12

нэгж хувийг төгрөгийн харилцах, 6.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 1.5 нэгж хувийг гадаад валютын харилцах, 0.4 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, 2.8 нэгж хувийг гадаад валютын хадгаламж тус тус бүрдүүлж байв.

Монголбанк бодлогын хүүг 2022 оны 6 дугаар сарын 22-нд 10 хувь болгон нэмэгдүүлсэн, мөн төлбөрийн тэнцлийн алдагдал өсөж, банкны системийн гадаад цэвэр актив буурсантай холбоотойгоор мөнгөний нийлүүлэлт (М2 мөнгө) 2022 оны хагас жилийн байдлаар өмнөх оноос 0.9 хувиар буурч, 27.6 их наяд төгрөгт хүрсэн байв.

График 27. Мөнгөний нийлүүлэлт

Их наяд төгрөг, 2018 – 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо

Ирэх онд төсвийн төлөв чангарахаар байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг бууруулж болзошгүй байна. Монгол Улсын санхүүгийн систем тогтвортой хэвээр байх хэдий ч эмзэг байдал нэмэгдэхийг Олон Улсын Валютын Сан онцолсон байна.

Гадаад валютын нөөц

2021 оны 12 дугаар сард гадаад валютын нөөц 4,366.1 сая ам.долларт хүрсэн хэдий ч 2022 оны 1 дүгээр сараас бууран 2022 оны эхний хагас жилийн байдлаар 3,097.3 ам.доллар болсон. Үүнд экспортын орлого багассан болон Монголбанк валютын ханшийг тогтвортой байлгахын тулд интервенц их хэмжээгээр гүйцэтгэсэн нь нөлөөлсөн байна. Үүнээс гадна төлбөрийн тэнцэл алдагдалтай, гадаад өрийн өндөр дүнтэй эргэн төлөлт хийгдэх хугацаатай байгаатай холбоотойгоор гадаад валютын нөөц буурч 2022 оны эцэст 2.5 тэрбум ам.доллар

СЗХ
2022.12.14
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

орчим хүрч, 2023-2024 онуудад импортын хэрэгцээг хангах боломжгүй түвшинд хүрэх эрсдэлтэй байна.

Хүснэгт 27. Гадаад валютын албан нөөцийн өөрчлөлт

Хувь, 2021 оны сүүлийн хагас жил – 2022 оны эхний хагас жил

Гадаад валютын албан нөөцийн	2021						
	6	7	8	9	10	11	12
Сарын өөрчлөлт	-3.0%	-3.3%	-3.1%	-5.7%	0.5%	-0.9%	4.8%
Оны эхнээс өөрчлөлт	4.4%	0.9%	-2.2%	-7.8%	-7.3%	-8.1%	-3.7%
Жилийн өөрчлөлт	33.1%	26.4%	21.4%	13.1%	12.8%	7.6%	-3.7%
Гадаад валютын албан нөөцийн	**2022**						
	6	7	8	9	10	11	12
Сарын өөрчлөлт	-9.6%	-6.6%	-9.9%	-0.1%	-5.7%	-0.9%	-9.6%
Оны эхнээс өөрчлөлт	-9.6%	-15.6%	-24.0%	-24.1%	-28.4%	-29.1%	-9.6%
Жилийн өөрчлөлт	-9.7%	-18.4%	-30.5%	-32.2%	-35.9%	-34.5%	-9.7%

Эх сурвалж: Монголбанкны статистик мэдээ

График 28. Гадаа валютын албан нөөц

Сая ам.доллар, сар, 2021 оны сүүлийн хагас жил – 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Монголбанкны статистик мэдээ

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СӨХ
БҮРТГЭЛ
№ 01

2022 -12- 12
БҮРТГЭЛ-02

Зээл болон хадгаламжийн хүү

Шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жинлэсэн дундаж жилийн хүү 2018 онд 14 хувьтай байсан бол 2021 он хүртэл 5.8 нэгж хувиар буурч, 8.3 хувьд хүрсэн. 2022 оны хагас жилийн байдлаар жилийн эхэн үетэй харьцуулахад 1.5 нэгж хувиар өсөж, 9.7 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.

Валютын хадгаламжийн жинлэсэн жилийн дундаж хүү 2018 онд 6.7 хувь байсан бол 2021 он хүртэл 0.5 нэгж хувиар буурч, 6.2 хувь болов. Тус үзүүлэлт 2022 оны эхний хагас жилд 4.0 нэгж хувиар буурч, 2.2 хувь болсон.

Шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2018 онд 16.4 хувьтай байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 2.7 нэгж хувиар буурч, 13.8 хувь болсон. 2022 оны эхний хагас жилд тус үзүүлэлт 0.4 нэгж хувиар өсөж, 14.2 хувьд хүрсэн байна.

Валютын зээлийн жигнэсэн дундаж хүү 2018 онд 10.8 хувь байсан бол 2021 он хүртэл 0.2 нэгж хувиар буурч, 9.1 хувь болсон бол 2022 оны эхний хагас жилд 0.2 нэгж хувиар буурч, 8.9 хувьд хүрсэн байна. Энэ нь 2018 оны валютын зээлийн хүүгийн түвшинтэй ижил түвшинд хүрсэн үзүүлэлт билээ.

Ам.доллартой харьцах төгрөгийн ханш 2022 оны эхээс хагас жил хүртэл 10 орчим хувиар чангарсан. 2022 оны эхний хагас жилийн байдлаар валютын хадгаламжийн хүү 2.2 хувь болж, төгрөгийн эсрэг гадаад валютын ханш 10 орчим

График 29. Жинлэсэн дундаж хүү

Хувь, 2018 – 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Монголбанкны статистик мэдээ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ МОНГОЛЫН
9020020699 2070096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
9317639 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СӨХ
БҮРТГЭВ
№ 91

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ №02

хувиар чангарснаар валютын хадгаламжийн дундаж өгөөж 12.2 хувь болсон. Иймхүү төгрөгийн хадгаламжийн хүүгээс валютын хадгаламжийн хүү өндөр болсноор төгрөгийн хадгаламж 8.3 хувиар буурч, харин валютын хадгаламж 13.9 хувиар нэмэгдсэн байна.

3.3.2. Монгол улсын хөрөнгийн зах зээлийн төлөв байдал

2022 оны байдлаар Монголын хөрөнгийн зах зээл дээр үнэт цаасны арилжаа зохион байгуулахаар "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК, "Улаанбаатар Үнэт Цаасны Бирж" ХК болон "Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ үйл ажиллагаа явуулж байна.

"Улаанбаатар Үнэт Цаасны Бирж" ХК нь 2015 оны 5 дугаар сарын 1-ний өдөр "Үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа" эрхлэх зөвшөөрөлтэйгөөр үүсгэн байгуулагдсан хаалттай хувьцаат компани юм. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар тус биржид 1.9 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээ бүхий 1 хувьцаат компани бүртгэлтэй байна. "Улаанбаатар Үнэт Цаасны Бирж" ХК нь 22 гишүүн үнэт цаасны компанитай ажиллаж байна.

"Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ нь брокер, дилерийн компаниудын санаачилгаар, сайн дурын үндсэн дээр 1995 оны 7 дугаар сард үүсгэн байгуулагдсан, төрөөс хараат бус Өөрийгөө зохицуулах байгууллага юм. "Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ нь биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах зөвшөөрөлтэй. Санхүүгийн Зохицуулах Хорооны 12 дугаар сарын 9-ний өдрийн 995 дугаар тогтоолоор Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журмыг баталснаас хойш 672 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасыг биржийн бус зах зээл дээр бүртгэсэн. Үүнээс 427 тэрбумыг 2021 онд татан төвлөрүүлсэн байна.

Үнэт цаас гаргагч нь 1991 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байгаа, Монголын хөрөнгийн зах зээл дээр хамгийн арвин туршлагатай арилжаа эрхлэх болон өөрийгөө зохицуулах дэд бүтцийн байгууллага юм.

Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүнүүдээ төрөлжүүлсээр Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар 183 хувьцаат компанийн хувьцаа, 21 компанийн өрийн хэрэгсэл, 2 хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, 5 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн арилжааг идэвхтэй зохион байгуулан ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь 2022-2023 онуудад системийн нөлөө бүхий арилжааны банкнууд болон төрийн өмчит компаниудын хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалах ажлуудыг зохион байгуулахаар ажиллаж байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СӨХ
БҮРТГЭЛ
№ 01

2022 -12- 12

2022 оны эхний хагас жилийн байдлаар Монголын Хөрөнгийн Биржид албан ёсоор идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 52 гишүүн үнэт цаасны компани, 181 хувьцаат компани бүртгэлтэй байна.

1. Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

2022 оны эхний хагас жилийн байдлаар "Улаанбаатар Үнэт Цаасны Бирж" ХК-д нэг компани бүртгэлтэй байгаа бөгөөд уг Биржийн арилжааны идэвх нь Үнэт цаас гаргагчийнхтай харьцуулахад бага байна. Харин, "Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо" ӨЗБ-д бүртгэлтэй хувьцаат компани байхгүй байна. Тиймээс, энэхүү Үнэт цаасны танилцуулгад Монголын Хөрөнгийн зах зээлийн үнэлгээг тооцоолоход зөвхөн Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэлгээг ашиглав.

- ✓ Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ = Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын зах зээлийн үнэлгээний дүн
- ✓ $\text{Хөрвөх чадвар} = \frac{\text{Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүн}}{\text{Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын зах зээлийн үнэлгээний дүн}}$

2020 оны байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ нь 3.0 их наяд төгрөгөөр хэмжигдэж байсан бол 2021 онд өмнөх оны мөн үеэс 97.5 хувиар өсөж, 5.9 их наяд төгрөгт хүрсэн юм. Үүнд хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 50 гаруй хувийг эзэлдэг томоохон хувьцаат компаниудын үнэлгээ 130 хувиар нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна. Тус компаниуд дундаас хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхэлдэг компани, уул уурхайн компаниудын хувьцааны өсөлт тэргүүлсэн. Түүнчлэн "Банкны тухай хууль"-ийн шинэчлэлийн хүрээнд 2022 оны хоёр дугаар хагас жид 2 банкны IPO амжилттай хэрэгжиж, анхдагч зах зээлээс татан төвлөрүүлэх зорилтот дүнгээ даван биелүүлсэн.

Хүснэгт 28. Монголын хөрөнгийн зах зээлийн голлох үзүүлэлтүүд

Тайлбар	Хэмжих нэгж	Үзүүлэлт				
		2018	2019	2020	2021	2022 оны эхний хагас жил
Зах ээлийн үнэлгээ	их наяд төгрөг	2.50	2.69	3.03	5.98	4.84
Зах зээлийн үнэлгээ ба Дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа	хувь	7.70%	7.11%	8.08%	13.73%	11.72%

ХӨРӨНГИЙН МОНГОЛЫН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СӨХ
2022 12 14
БҮРТГЭЛ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-09

Хөрвөх чадвар буюу хоёрдогч зах зээлийн арилжааны дүн, зах зээлийн үнэлгээний харьцаа	хувь	7.14%	3.39%	1.60%	3.85%	2.35%
Арилжааны дүн	тэрбум төгрөг	244.14	143.20	65.33	1,414.20	275.93
Хувьцаа	*хувь*	*86.02%*	*93.23%*	*82.47%*	*21.56%*	*41.20%*
Компанийн өрийн хэрэгсэл	*хувь*	*0.26%*	-	*8.87%*	*74.12%*	*36.93%*
Хөрөнгө оруулалтын сангийн нэгжийн эрх	*хувь*	-	-	*7.76%*	*4.02%*	*0.85%*
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	*хувь*	-	-	-	*0.30%*	*21.01%*
Засгийн газрын үнэт цаас	*хувь*	*13.72%*	*6.77%*	*0.90%*	-	-
Бүртгэлтэй хувьцаат компаниудын тоо	ширхэг	305	314	315	314	314
Бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудын тоо	ширхэг	216	199	192	179	181
Гишүүн Үнэт цаасны компаниудын тоо	ширхэг	53	55	54	55	58
Нийт үнэт цаасны дансны тоо	ширхэг	1,304,366	1,828,005	2,386,103	2,429,002	2,435,229
ТОП-20 ханш	индекс	20,826	10,090	19,285.80	44,411.60	32,795.68
MSE A ханш	индекс	8,512	9,532	91,122.01	15,482.77	12,384.65
MSE B ханш	индекс	7,480	9,122	7,581.13	12,202.56	11,450.93
P/B харьцаа (салбарын дундаж)	үржвэр			1.7	2.5	
P/E харьцаа (салбарын дундаж)	үржвэр			174.7	163.1	
Ногдол ашгийн өгөөж (салбарын дундаж)	хувь			3.4%	1.5%	
Үнэт цаасны компаниудын	тэрбум төгрөг	85.40	88.89	112.36	115.38	179.50

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2. Үнэт цаасны арилжаа

Монгол Улсын Засгийн газар Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг эрчимжүүлэх, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан арилжаалах шийдвэрийг гаргасан. Энэхүү бодлогын шийдвэрийн нөлөөгөөр Монголын хөрөнгийн зах зээлийн арилжааны эргэлт 2017 онд 773 тэрбум төгрөг болон нэмэгдэж, түүхэн дээд цэгтээ хүрч байв.

Гэвч "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд Олон Улсын Валютын Сангаас Монгол Улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийн дагуу Засгийн газрын үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржээр арилжаалахыг хязгаарлаж, Ковид-19 цар тахлын нөлөөгөөр иргэдийн хэрэглээ, хөрөнгө оруулалтын хандлагад өөрчлөлт орсонтой холбоотойгоор үнэт цаас гаргагчдын үйл ажиллагааны ашиг орлого буурч, компаниудын үнэт цаас гаргах ажиллагаа хойшлогдож, улмаар эдийн засгийн үйлдвэрлэл буурсан зэргээс шалтгаалан 2018-2020 онуудын хооронд Монголын Хөрөнгийн Биржийн нийт арилжааны эргэлт 244 тэрбум төгрөгөөс 65 тэрбум төгрөг болж 73.4 хувиар огцом буурсан юм.

2021 онд арилжааны нийт эргэлт 1.4 их наяд төгрөгт хүрсэн. Энэхүү огцом өсөлтөд "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн группэд хамаарах компаниудын хувьцааны арилжааны өсөлт, "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн бонд, "АПУ" ХК-ийн ханшийн өсөлт голлох нөлөөллийг үзүүлэв.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ ... БҮРТГЭЛ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-12-12 БҮРТГЭВ-02

График 30. Монголын Хөрөнгийн Биржийн арилжааны эргэлт

Тэрбум төгрөг, 2017-2021 он, 2022 оны эхний хагас жил



	2017	2018	2019	2020	2021	2022 эхний хагас жил
Засгийн газрын үнэт цаас	772.5	33.5	9.7	0.6	0	0
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	0	0	0	0	4.2	58.0
Хамтын сан	0	0	0	5.1	56.8	2.3
Компанийн бонд	10.2	0.6	0.0	5.8	1048.2	101.9
Хувьцаа	76.4	210.0	133.5	53.9	304.9	113.7
Арилжааны дүн	859.2	244.1	143.2	65.3	1414.2	275.9

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны зах зээлийн тойм", 2017-2022 он

Монголын Хөрөнгийн Биржид арилжаалагдах бүтээгдэхүүнүүдийн төрөл нэмэгдэж, Ковид-19 цар тахлын үеийн эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн банкны салбарын хувьд бүх төрлийн хугацаагүй хадгаламжид хүү тооцохгүй болгох, ипотекийн эргэн төлөлтийг хойшлуулах болон бусад олон төрлийн бодлогын хэмжээний үр дүнд зах зээл сэргэн 2021 онд арилжааны хэмжээ нэмэгдсэн байна.

Түүнчлэн, давхар бүртгэлтэй үнэт цаасны бирж хоорондын хөрвүүлэлтийг Монголын Хөрөнгийн Бирж нь амжилттай гүйцэтгэсэн. Үр дүнд нь "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК-ийн нийт хувьцааг бүртгэж, тус компанийн хувьцаа Монголын Хөрөнгийн Бирж болон Торонтогийн Хөрөнгийн Бирж хооронд хөрвөн арилжаалагдах боломж бүрдсэн ба хөрвүүлгийг 2021 оны 1 дүгээр сард амжилттай зохион байгуулав. Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Канад Улсаас гадна нийт 24 улсын 26 Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компанийн үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Бирж дээр гаргах боломжтой байна.

Хүснэгт 29. Монгол Улсад үнэт цаас гаргаж болох гадаадын үнэт цаас гаргагчийн бүртгүүлсэн арилжаа эрхлэх байгууллагын жагсаалт

Д/д	Арилжаа эрхлэх байгууллагын нэр		Харьяалах улсын нэр
1	Австралийн Үнэт Цаасны Бирж	/Australian Securities Exchange/	Австрали Улс
2	Венын Хөрөнгийн Бирж	/Wiener Börse/	Австри Улс
3	Нью-Йоркийн Хөрөнгийн Бирж	/The New York Stock Exchange/	Америкийн Нэгдсэн Улс
4	Насдак Хөрөнгийн Бирж	/Nasdaq/	

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК MONGOLIAN STOCK EXCHANGE 9020020690 2071096 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 1119277128 УЛААНБААТАР ХОТ

5	Брюсселийн Хөрөнгийн Бирж	/Euronext Brussels/	Бельги Улс
6	Солонгосын Хөрөнгийн Бирж	/Korea Exchange/	Бүгд Найрамдах Солонгос Улс
7	Хонг Конгын Хөрөнгийн Бирж	/The Stock Exchange of Hong Kong/	Хонг Конг
8	Франкфуртын Хөрөнгийн Бирж	/Deutsche Böurse/	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
9	Амстердамын Хөрөнгийн Бирж	/Euronext Amsterdam/	Голланд Улс
10	Копенгагены Хөрөнгийн Бирж	/Nasdaq Copenhagen/	Дани Улс
11	Тель-Авивын Хөрөнгийн Бирж	/Tel-Aviv stock exchange/	Израил Улс
12	Ирландын Хөрөнгийн Бирж	/Irish stock exchange/	Ирланд Улс
13	Мадридын Хөрөнгийн Бирж	/Bolsa de Madrid/	Испани Улс
14	Италийн Хөрөнгийн Бирж	/Borsa Italiana/	Итали Улс
15	Лондонгийн Хөрөнгийн Бирж	/London Stock Exchange/	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
16	Шинэ Зеландын Хөрөнгийн Бирж	/New Zealand Stock Exchange/	Шинэ Зеланд Улс
17	Стокгольмын Хөрөнгийн Бирж	/Nasdaq Stockholm/	Швед Улс
18	Швейцарын Хөрөнгийн Бирж	/SIX Swiss Exchange/	Швейцар Улс
19	Торонтогийн Хөрөнгийн Бирж	/Toronto Stock Exchange/	Канад Улс
20	Торонтогийн Венчур Бирж	/Toronto venture exchange/	
21	Ослогийн Хөрөнгийн Бирж	/Oslo Børs/	Норвег Улс
22	Лисабоны Хөрөнгийн Бирж	/Euronext Lisbon/	Португали Улс
23	Сингапурын Хөрөнгийн Бирж	/Singapore Exchange/	Сингапур Улс
24	Хельсинкийн Хөрөнгийн Бирж	/Nasdaq Helsinki/	Финлянд Улс
25	Парисын Хөрөнгийн Бирж	/Euronext Paris/	Бүгд Найрамдах Франц Улс
26	Токиогийн Хөрөнгийн Бирж	/Tokyo stock exchange/	Япон Улс

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас

3. Шинэ үнэт цаас

Монголын Хөрөнгийн Биржид 2021 онд нийт 9 шинэ бүтээгдэхүүн бүртгэгдэж, олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдаас 846.2 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн нь төрийн өмч хувьчлалаас хойших хамгийн олон үнэт цаас бүртгэгдсэн түүхэн жил болсон байна.

"Банкны тухай хууль"-ийн шинэчлэлийн хүрээнд арилжааны банкнуудаас хамгийн эхний банк хувьцаагаа олон нийтэд санал болгон зорилтот хөрөнгөө анхдагч зах зээлээс амжилттай татан төвлөрүүлсэн. Түүнчлэн, хамгийн анхны давхар бүртгэлтэй компани нэмж хувьцаа гаргасан бол Байгаль, нийгэм, засаглалын

үнэлгээг хийлгэсэн анхны компани Монголын Хөрөнгийн Биржид хувьцаагаа бүртгүүлсэн байна.

Мөн 2021 онд стратегийн ач холбогдол бүхий төмөр зам, нүүрс баяжуулах үйлдвэр, дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалт зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилготой, санхүүгийн зах зээл дээрх хамгийн өндөр үнийн дүн бүхий төгрөгийн болон ам.долларын нийт 2 их наяд хүртэлх төгрөгийн дэд бүтцийн бондыг Монголын Хөрөнгийн Бирж бүртгэсэн бөгөөд үүнээс 692.6 сая төгрөгийн үнэ бүхий төгрөгийн болон ам.долларын бондыг олон нийтэд санал болгон арилжаалсан байна.

2019 онд Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам батлагдсанаар олон улсын биржүүдэд түгээмэл арилжигддаг уг бүтээгдэхүүн Монголын хөрөнгийн зах зээлд цоо шинээр нэвтрэх боломжтой болсон. Үүний дараа хамтын хаалттай 2 сан Монголын Хөрөнгийн Биржид нэгж эрхээ бүртгүүлэн амжилттай арилжаалагдсан байна. Сангуудын зах зээлийн үнэлгээ нь 2021 оны эцэст 59 тэрбум төгрөгт хүрэв.

Монголын Хөрөнгийн Бирж нь банк, санхүүгийн байгууллагууд активаа багцлан үнэт цаасжуулж, хөрөнгийн зах зээлд худалдан санхүүжилт татдаг олон улсын жишгийг дотоодын зах зээлд нэвтрүүлэх, нөгөө талаас иргэдэд тогтмол хугацаат хүүгийн орлого олох эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл санал болгох зорилгоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмыг 2020 онд боловсруулан баталсан. Энэ хүрээнд хамгийн анхны нээлттэй Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 2021 онд бүртгэн арилжаалсан байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар нийт 5 Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэж, 79 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлээд байна.

4. Зах зээлийн үнэлгээ ба индекс

2022 оны эхний хагас жилийн байдлаар 181 хувьцаат компани 3 ангилалд бүртгэлтэй байна.

Хүснэгт 30. Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын ерөнхий мэдээлэл

Ангилал	Бүртгэлтэй компаниудын онцлог	Компанийн тоо
I ангилал	Нэр хүндтэй, зах зээлийн үнэлгээ өндөр, тогтвортой үйл ажиллагаа явуулж, 1 тэрбум төгрөгөөс доошгүй ашигтай эсхүл 5 тэрбум төгрөгөөс доошгүй орлоготой ажилладаг, 25 хувиас дээш хувийг олон нийтэд санал болгосон томоохон компаниуд	20

СЗХ БҮРТГЭЛ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭЛ-02

II ангилал	1 тэрбум төгрөгөөс доошгүй зах зээлийн үнэлгээтэй, 100 сая төгрөгөөс доошгүй ашигтай, 25 хувиас доошгүй хувийг олон нийтэд санал болгосон компаниуд	45
III ангилал	Эрсдэл өндөртэй, шинэлэг санаа бүхий, бизнесийн мөчлөгийн өсөлтийн үе шатанд буй жижиг, дунд хэлбэрийн компани, эсхүл уул уурхайн компаниуд	116

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас

2020 онд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудын зах зээлийн үнэлгээ нь 3.0 их наяд төгрөгөөр хэмжигдэж байсан бол 2021 онд өмнөх оны мөн үеэс 97.5 хувиар өсөж, 5.9 их наяд төгрөгт хүрсэн. Энэхүү өсөлтөд зах зээлийн үнэлгээний 50 гаруй хувийг эзэлдэг томоохон компаниудын үнэлгээ 130 гаруй хувиар нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2021 онд өмнөх оноос 5.6 нэгж хувиар нэмэгдэн 13.7 хувьд хүрсэн. Олон улсын хөрөнгийн зах зээлтэй харьцуулбал, энэхүү үзүүлэлт нь Вьетнам, Индонези, БНХАУ болон Чили Улсуудын хувьд 68.6 хувь, 46.9 хувь, 83.0 хувь, 73.0 хувь байна. Монголын хөрөнгийн зах зээлийг бусад улс орнууд болон дэлхийн дундажтай харьцуулан доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 31. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

Монгол Улс	Зүүн Ази, Номхон далайн бүс нутаг (хөгжингүй улсуудаас бусад)	Европ Төв Азийн бүс нутаг (хөгжингүй улсуудаас бусад)	Дэлхийн дундаж
13.7%	82.0%	37.9%	133.8%

Эх сурвалж: World Federation to Exchange database, Дэлхийн банк, 2021 он

Хүснэгт 32. Олон улсын Хөрөнгийн Биржүүдийн зарим үзүүлэлтүүд

Ангилал	Улс	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, 2021он, ам. доллар	Зах зээлийн үнэлгээ, тэрбум ам.доллар	Дотоодын нийт бүтээгдэхүүнд зах зээлийн үнэлгээний эзлэх хувь
Фронтиер / Хөгжиж буй	Болгар	11,635	6.7	29.9%
	Эстони	27,281	5.8	16.5%
	Латви	20,642	0.9	2.5%
	Литва	23,433	5.8	9.1%
	Палестин	3,664	4.4	24.4%
	Монгол	4,657	2.0	13.7%
Хоёрдогч хөгжиж буй	Исланд	68,384	18.9	76.3%
	Пакистан	1,538	43.3	14.5%
	Филиппин	3,549	0.3	93.2%
	Румын	14,862	52.3	19.4%

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

	Арабын Нэгдсэн Эмират Улс	36,285	543.2	133.6%
Хөгжингүй	Австрали	59,934	1,889.5	119.5%
	Бельги	51,768	405.3	71.3%
	Канад	52,051	3,307.1	169.5%
	Дани	67,803	703.9	184.7%
	Финланд	53,983	385.3	135.4%
	Франц	43,519	3,616.3	127.8%
	Герман	50,802	2,501.5	61.9%
	Хонг Конг	49,661	5,419.8	1,135.7%
	Ирланд	99,152	176.0	36.5%
	Израил	51,430	384.4	76.7%
	Итали	35,551	870.1	43.2%
	Япон	39,285	6,538.3	139.1%
	Нидерланд	58,061	1,686.5	174.0%
	Шинэ Зеланд	48,802	132.2	62.4%
	Норвег	89,203	428.2	91.4%
	Польш	17,841	323.3	50.0%
	Португал	24,262	92.0	37.9%
	Сингапур	72,794	652.6	168.2%
	Швед	60,239	1,369.6	227.5%
	Их Британи	47,334	3,329.6	108.3%
	Америкийн нэгдсэн Улс	69,288	53,366.4	139.4%
Өндөр хөгжингүй	Бразил	7,519	812.5	54.9%
	Грек	20,277	74.0	36.0%
	Малайз	11,371	406.9	110.0%
	Мексик	9,926	487.8	38.1%
	Өмнөд Африк	6,994	1,286.8	331.0%

Эх сурвалж: "CEIC" судалгааны байгууллага, 2021 он

Зах зээлийн ерөнхий чиг хандлагыг ТОП-20 индекс, үнэт цаасны бүртгэлийн I ба II ангилалд багтдаг компаниудын зах зээлийн үнэлгээнд суурилсан MSE A болон MSE B индексүүдийг тооцон харуулдаг байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12

ТОП-20 индексийн өгөөжийн стандарт хазайлт 2021 онд 1.7 хувьд хүрч өссөн нь хөрөнгийн зах зээлийн идэвхжил өндөр буйг илтгэж байна.

График 31. ТОП-20 индексийн өгөөжийн стандарт хазайлт

Хувь, 2018 – 2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас

Тухайлбал, 2022 оны эхний хагас жилийн байдлаар ТОП-20 индексэд багтах компаниудын үнэлгээ нийт хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 85.9 хувийг, тэдгээрийн хувьцааны арилжаа нийт хувьцааны арилжааны 77.6 хувийг тус тус эзэлж байна. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд хамгийн өндөр буюу 1.7 их наяд төгрөгийн үнэлгээтэй ба хөрөнгийн зах зээлийн үнэлгээний 35.9 хувийг дангаар бүрдүүлж байна.

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

5. *Зах зээлийн хөрвөх чадвар*

2021 оны байдлаар Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудын хувьцааны хөрвөх чадвар буюу арилжааны хэмжээ зах зээлийн үнэлгээний харьцаа өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4 нэгж хувиар өсөж, 3.9 хувьд хүрсэн. Уг үзүүлэлт нь хөгжингүй болон хөгжиж буй улсуудын дундажтай харьцуулахад бага байна.

График 32. Олон улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварын үзүүлэлтүүд
Хувь, 2021 он



Эх сурвалж: Дэлхийн Биржүүдийн Холбоо, Дэлхийн Банк, 2021 он

Хувьцааны хөрвөх чадвар дэлхийн дунджаас 26 дахин бага байгаа хэдий ч зах зээл хөгжихийн хэрээр нэмэгдэж байна.

Монголын Хөрөнгийн Биржид бүртгэгдэх компаниудын тоо нэмэгдэж, арилжаалагдах бүтээгдэхүүн жил тутам төрөлжиж, зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаа идэвхэжсэнээр арилжааны идэвх сайжирсан. Ингэснээр хувьцааны хөрвөх чадвар ирэх жилүүдэд нэмэгдэх бүрэн боломжтой байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

График 33. Монголын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар

Хувь, 2018 оны 1 дүгээр улирал – 2022 оны эхний хагас жилийн байдлаар



Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлийн тойм"

2021 оны эцэст хөрөнгө оруулагчдын 95 орчим хувь нь цахимаар арилжаанд оролцох болсон нь хөрөнгийн зах зээлийн хүртээмжтэй байдал нэмэгдэж байгааг илэрхийлэхийн сацуу зах зээлийн хөрвөх чадвар сайжрахад нөлөөлсөн байна.

6. Хөрөнгө оруулагчдын бүтэц

График 34. Үнэт цаасны дансны бүтэц

Тоо ширхэг, 2018-2021 он

	2018	2019	2020	2021
Дотоод аж ахуйн нэгж	2,712	2,771	2,867	2,977
Дотоод иргэн	1,299,259	1,822,574	2,380,539	2,423,277
Нийт хүн амд эзлэх хувь	40.1%	55.3%	70.9%	71.1%
Гадаад аж ахуйн нэгж	193	459	460	466
Гадаад иргэн	2,202	2,201	2,237	2,282
Нийт	**1,304,366**	**1,828,005**	**2,386,103**	**2,429,002**

Эх сурвалж: "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК-д нээгдсэн дансны судалгаа

"Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК-д 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 2,977 дотоод аж ахуйн нэгж, 2,463,277 дотоод иргэдийн үнэт цаасны данс бүртгэлтэй байна. Дотоодын иргэдийн дансны тоо 2018 оноос 2019 онтой харьцуулахад 40.1 хувиар өсөж, нийт хүн амын 55.3 хувь нь үнэт цаасны данстай

ХӨРӨНГИЙН БИРЖ
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭЛ
№ 01

2022 -12- 12

болсон байна. Улсын Их Хурлаас 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс өмнө төрсөн Монгол Улсын нийт иргэдэд "Эрдэнэс Тавантолгой" компанийн 1,072 ширхэг хувьцааг үнэ төлбөргүй эзэмшүүлэх шийдвэрийг гаргасантай холбогдуулан хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид "Эрдэнэс Таван Толгой" ХК-тай хамтран 12 аймаг, 30 сумдад "Эрдэнэс Тавантолгой" компанийн үйл ажиллагаа, нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөн үнэт цаасны талаарх сургалтуудыг зохион байгуулж, 15,000 гаруй иргэдийг хамруулсан нь энэхүү өсөлтөд нөлөөлсөн.

MONGOLIAN STOCK EXCHANGE

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

График 35. 2005 оноос хойш хувьцаагаа анх удаа олон нийтэд нээлттэй санал болгосон компаниудын тухай мэдээлэл

Татан төвлөрүүлсэн дүн, тэрбум төгрөг, 2005 - 2022 он



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас

Зах зээл идэвхжин үнэт цаас гаргах компаниудын тоо олшрон хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгосон нь иргэдэд данс нээлгэх, хөрөнгийн зах зээлд оролцох хөшүүрэг болсон. 2019 оноос хойш 2 жилийн хугацаанд үнэт цаасны данс эзэмшиж буй хүний тоо нийт хүн амын 71 гаруй хувийг эзэлдэг болж, 33 хувиар өссөн юм. Үнэт цаасны Т+2 төлбөр тооцооны горимыг нэвтрүүлж, бүтээгдэхүүний төрөл нэмэгдэж, гадаад хамтын ажиллагаа сайжирч, үнэт цаасны бирж хоорондын хөрвүүлэлт амжилттай болсон зэрэгтэй холбоотойгоор дотоод, гадаад хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдсэн. Улмаар 2021 оны эцэст гадаад аж ахуй нэгжүүдийн дансны тоо 2018 онтой харьцуулахад 2.4 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 33. Олон Улсын Хөрөнгийн Биржүүдийн голлох үзүүлэлтүүд

Биржийн нэр	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, 2021	"FTSE Russel" ангилал	Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зах зээлийн үнэлгээ	Арилжааны дүн	Зах зээлийн үнэлгээнд эзлэх арилжааны дүн	Валютын ханш (2021.12.31)
	ам. доллар		тэрбум ам.доллар	хувь	тэрбум ам.доллар	хувь	валют
Болгарын Хөрөнгийн Бирж	11,635.0	фронтиер	16.4	20.5%	0.464	2.82%	0.5791
Дубайн санхүүгийн зах	36,284.6	хоёрдогч хөгжиж буй	142.3	22.2%	19.680	13.83%	0.2722
Наиробын Үнэт Цаасны Бирж	2,236.0	фронтиер	15.7	14.2%	8.783	56.02%	0.0088
Нигериагийн Хөрөнгийн Бирж	594.9	фронтиер	115.4	12.6%	0.009	0.01%	0.0024
Пакистаны Хөрөнгийн Бирж	1,537.9	хоёрдогч хөгжиж буй	31.3	14.9%	0.024	0.08%	0.0057
Монголын Хөрөнгийн Бирж	4,534.9	фронтиер	2.1	13.7%	0.494	23.65%	0.0003

Эх сурвалж: Үнэлгээний компани, шинжээчийн тооцоолол



IV

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ

4.1. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө

4.2. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ

4.1. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь ил тод, нээлттэй зах зээлийн тогтолцоог бэхжүүлж, санхүүгийн төрөлжсөн хэрэгслүүд бүхий хөрвөх чадвар сайтай, бүс нутагт өрсөлдөхүйц хөрөнгийн бирж болох алсын хараатайгаар ажиллаж байна. Монголын Хөрөнгийн Биржийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөний стратегийн зорилго нь "Үнэт цаас гаргагчид, хөрөнгө оруулагчдын тэргүүн сонголт болж, тогтвортой өсөлтийг бий болгосноор 2027 оны эцэст зах зээлийн үнэлгээг Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувьд, хувьцааны арилжааны үнийн дүнгийн нийт зах зээлийн үнэлгээнд эзлэх хэмжээ (turnover ratio)-г 10 хувьд хүргэх" юм.

Төр засгаас хэрэгжүүлж буй хөрөнгийн зах зээлийг дэмжих бодлогын хүрээнд 2021 онд "Банкны тухай хууль"-ийн нэмэлт өөрчлөлт батлагдаж, стратегийн нөлөө бүхий 5 том банк Монголын Хөрөнгийн Бирж дээр үнэт цаасаа бүртгүүлэх, нийтэд хувьцаагаа анх удаа санал болгож олон нийтийн компани болох ажлуудаа эхлүүлж, зарим арилжааны банкнууд Монголын Хөрөнгийн Бирж дээр амжилттай хувьцаагаа арилжаалж эхэлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 тоот тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", Улсын Их Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 244 дүгээр тогтоолуудын дагуу төрийн өмчит компаниуд, тэр дундаа "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийг олон нийтийн нээлттэй хувьцаат компани болгох үйл ажиллагаа хэрэгжиж эхэлсэн нь Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэгдэх компаниудын тоо, арилжааны идэвх, зах зээлийн үнэлгээг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Хөрөнгийн зах зээлийг дэмжих татварын бодлогын хүрээнд 2023 оны Улсын төсвийн тухай хууль болон дагалдах хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтөөр хөрөнгө оруулалтын санг орлогын албан татвараас чөлөөлөх, шинээр үнэт цаас гаргах компаниудын хувьцаагаа олон нийтэд анх удаа нээлттэйгээр санал болгохтой холбоотой зардлуудыг 20 хувь нэмэгдүүлэн татвар ногдох орлогоос хасаж тооцох, гадаадын хөрөнгө оруулагчдын төлөх татварын ялгаатай байдлыг арилгах зэрэг томоохон хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэхээр болсон нь хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Монголын Хөрөнгийн Бирж нь стратегийн зорилгодоо хүрэхийн тулд дараах хоёр асуудлыг харгалзаж үзсэн. Үүнд:

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071996
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

1. Аж ахуйн нэгж, байгууллагууд урт хугацаат, хямд өртөгтэй санхүүжилтийн эх үүсвэр татан төвлөрүүлэх замаар зах зээлд харьцангуй хямд бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох, үйл ажиллагааны тогтвортой өсөлтийг бий болгох, олон нийтэд ил тод, нээлттэйгээр үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагааны үр ашгаа нэмэгдүүлэх, засаглалаа сайжруулснаар эдийн засагт үзүүлэх бодит хувь нэмэр нь нэмэгдэнэ. Иймхүү аж ахуйн нэгжүүдэд арилжааны банкнуудын зээлээс гадна санхүүжилтийн бусад боломжуудыг санал болгож, түүнд дэмжлэг үзүүлэхийн тулд Монголын Хөрөнгийн Бирж нь холбогдох зохицуулалтын орчныг илүү сайжруулж, "Үнэт цаас гаргагчийн тэргүүн сонголт болох" стратегийн зорилго тавин ажиллаж байна.

2. Хувь хүн, өрх гэрүүд урт хугацаанд хөрөнгийн хуримтлал бий болгож, санхүү эдийн засгийн хувьд тогтвортой, чинээлэг болсноор нийгмийн дундаж давхарга тэлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нөхцөл бүрдэнэ. Үүний тулд хуримтлалаа өгөөжтэй, эрсдэл багатай хөрөнгөнд оруулах, эрсдэлээ удирдах боломжийг бий болгох шаардлагатай бөгөөд үүнд Монголын Хөрөнгийн Бирж тус хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлж, "Хөрөнгө оруулагчийн тэргүүн сонголт болох" стратегийн зорилт тавин ажиллаж байна.

Тус стратегийн зорилгууд нь Монголын Хөрөнгийн Бирж нь зөвхөн Монгол Улсад бус бүс нутгийн хэмжээнд хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчдыг татахуйц зах зээлийг бий болгож, бүс нутагтаа өрсөлдөхүйц хөрөнгийн бирж болох алсын хараанд нийцэж байгаа юм.

Үүний хүрээнд Монголын Хөрөнгийн Бирж нь дараах үндсэн зорилтуудын дагуу ирээдүйн 5 жилийн төлөвлөгөөг боловсруулсан байна.

4.1.1. Үнэт цаас гаргагчдын тэргүүн сонголт болох

Үнэт цаас гаргах компаниудад эх үүсвэр татах таатай орчин бүрдүүлэхийн хүрээнд Монголын Хөрөнгийн Бирж нь зохицуулалтын орчныг сайжруулах, санхүүжилт татан төвлөрүүлэх, төрөлжсөн шинэ бүтээгдэхүүнүүдтэй хөрвөх чадвартай зах зээл болох, мэргэжлийн туслалцаа, зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлууд хийхээр төлөвлөж байна.

Системийн нөлөө бүхий банкнууд болон төрийн өмчит компаниуд Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат компаниуд болсноор Монголын Хөрөнгийн Бирж дээрх бүртгэлтэй компаниудын зах зээлийн үнэлгээ хамгийн багадаа 10 их наяд төгрөг буюу 2021 оны байдлаарх зах зээлийн үнэлгээнээс 2 дахин өсөхөөр байна.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Зохицуулалтын орчин

Монголын Хөрөнгийн Бирж нь Үнэт цаасны бүртгэлийн журмыг шинэчлэн, үнэт цаас гаргах процессыг илүү хялбар, ойлгомжтой болгож, мэдээлэл солилцох үйл явцыг бүрэн цахимжуулахаар төлөвлөж байна.

Мөн гарааны болон жижиг, дунд бизнесүүдийг дэмжихийн тулд олон улсын бусад биржүүдийн жишгийн дагуу шалгуур, шаардлага багатай туслах зах үүсгэж, хялбаршуулсан журмаар үнэт цаасыг бүртгэх боломжийг шинээр нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх хүрээнд биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сан, үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжаалах, Монгол Улсын хадгаламжийн бичиг (depository receipt) бүртгэх, банкнаас гаргасан хадгаламжийн сертификат биржээр арилжаалах, түүхий эдийн спот, фьючерс гэрээг арилжих боломжуудыг бий болгох зохицуулалтуудыг шинээр хийх төлөвлөгөөтэй байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа

Монгол Улсын Засгийн газрын "Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 тоот тогтоолд заасны дагуу уул уурхайн биржийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгосны үндсэнд экспортод гаргах ашигт малтмалыг биржээр дамжуулан цахим нээлттэй дуудлага худалдаагаар худалдах ажлыг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан нэвтрүүлэх ажил тусгагдсан.

Энэхүү ажлын хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хороо, "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК зэрэг байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн тушаалаар байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хүрээнд "Уул уурхайн биржийн тухай хууль" батлагдаж, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэл уул уурхайн бүтээгдэхүүнийг цахимаар арилжаалах харилцааг зохицуулах "Экспортын нүүрсийг цахимаар нээлттэй арилжих журам"-ын төслийг боловсруулж, 2022 оны 12 дугаар сард батлуулахаар ажиллаж байна. Журам батлагдсанаар 2023 оны 1 дүгээр сараас эхлэн "Эрдэнэс Тавантолгой" ХК болон "Энержи Ресурс" ХХК-ийн экспортод гаргах нүүрсийг цахимаар арилжаалж эхлэх юм.

Монголын Хөрөнгийн Бирж нь нүүрсний спот арилжааг 2023 оноос, уул уурхайн бусад түүхий эдэд суурилсан фьючерс гэрээг 2024 оноос эхлэн арилжаална. Нүүрсний экспорт нь Монгол Улсын гадаад худалдааны эргэлтийн 30 хувийг эзэлдэг, эдийн засгийн өндөр ач холбогдолтой салбар юм. 2022 оны байдлаар

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

2022 -12- 12

экспортод нийт 23 орчим сая тонн нүүрс гарснаас "Эрдэнэс Тавантолгой" ХК дангаараа 9 сая орчим тонн нүүрсийг экспортолсон байна.

Дотооддоо олборлосон нүүрсийг нээлттэй зах зээлээр дамжуулан арилжаалснаар үнэ зах зээлийн зарчмаар ил тод тогтож, улмаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой болох юм. Түүнчлэн хилийн нэвтрүүлэх чадамжаас үл хамааран биржээр арилжаалагдсан нүүрсний тээвэрлэлтийг хилээр саадгүй нэвтрүүлэх нөхцөлийг бий болгохоор Засгийн газрын зүгээс анхааран ажиллаж байна. Монголын Хөрөнгийн Бирж нь одоогийн дэд бүтцээ үр ашигтай ашиглаж, арилжааг мэргэжлийн түвшинд, тасралтгүй зохион байгуулах бүрэн боломжтой байна.

Олон улсын жишиг

Олон улсын жишигт хөрөнгийн биржүүд үнэт цаасnаас гадна түүхий эд, түүнд суурилсан үүсмэл үнэт цаасны арилжааг хавсран эрхэлдэг бөгөөд Дэлхийн хөрөнгийн биржүүдийн холбооны гишүүн биржүүдийн судалгаанд доорх биржүүд түүхий эдийн спот болон фьючерс, опционы арилжааг явуулж байна.

Хүснэгт 34. Олон улсын хөрөнгийн бирж дэх түүхий эд, түүнд суурилсан үүсмэл үнэт цаасны арилжааны жишээ

Хөрөнгийн биржийн нэр	Арилжаалдаг бүтээгдэхүүн	Арилжааны төрөл
B3 SA Brasil Bolsa Balcao	Үнэт цаас, түүхий эд	Спот, фьючерс, опцион
ICE Futures Canada	Үнэт цаас, түүхий эд	Спот, фьючерс, опцион
ICE Futures US	Үнэт цаас, түүхий эд	Спот, фьючерс, опцион
Asia Pacific		
Australian Securities Exchange	Үнэт цаас, түүхий эд	Фьючерс, опцион
Bursa Malaysia	Үнэт цаас, түүхий эд	Фьючерс
Hong Kong Exchanges and Clearing	Үнэт цаас, түүхий эд	Фьючерс
Singapore Exchange	Үнэт цаас, түүхий эд	Фьючерс, опцион
New Zealand's Exchange Limited	Үнэт цаас, түүхий эд	Фьючерс, опцион
The Stock Exchange of Thailand	Үнэт цаас, түүхий эд	Фьючерс, опцион
Korea Stock Exchange	Үнэт цаас, түүхий эд	Спот, фьючерс, опцион
Europe - Middle East – Africa		
Borsa Istanbul	Үнэт цаас, түүхий эд	Спот, фьючерс, опцион
Deutsche Börse AG	Үнэт цаас, түүхий эд	Спот, фьючерс, опцион

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

Euronext	Үнэт цаас, түүхий эд	Фьючерс, опцион
Johannesburg Stock Exchange	Үнэт цаас, түүхий эд	Фьючерс, опцион
Moscow Exchange	Үнэт цаас, түүхий эд	Спот, фьючерс, опцион
NASDAQ Nordic Exchanges	Үнэт цаас, түүхий эд	Фьючерс, опцион

Эх сурвалж: Дэлхийн хөрөнгийн биржүүдийн холбооны судалгаа

Ийнхүү, ашигт малтмалын экспортын орлогыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 5 төрлийн санхүүгийн хэрэгслийн арилжааг 31 жилийн турш амжилттай зохион байгуулж ирсэн туршлагатай, арилжааг найдвартай, тасалдалгүй явуулах олон улсын стандартыг хангасан дэд бүтэцтэй Монголын Хөрөнгийн Биржид түшиглэн ашигт малтмалыг нээлттэй, ил тод, шударга зарчмаар худалдан борлуулах уул уурхайн биржийн тогтолцоог бий болгох нь төсвийн зардлыг хэмнэх, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой билээ.

Засгийн газрын үнэт цаас

Засгийн газрын үнэт цаасыг тасралтгүй арилжаалснаар нээлттэй зах зээлийн жишиг өгөөжийн муруйг тодорхойлох боломжтой болно. Засгийн газрын үнэт цаасны өгөөжийн муруй нь шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тооцох, зах зээлийн эрсдэлийг ойлгох зэрэгт ашиглагддаг. Өнгөрсөн хугацаанд Монголын Хөрөнгийн Биржийн анхдагч зах зээлийн арилжаагаар 7 хоногоос 5 жил хүртэлх төрөл бүрийн хугацаатай, нийт 2.1 их наяд төгрөг буюу нийт арилжааны үнийн дүнгийн 60 орчим хувьтай тэнцэх Засгийн газрын үнэт цаасыг арилжаалсан хэдий ч 2017 оноос хойш Засгийн газрын үнэт цаас шинээр зах зээл дээр арилжаалагдаагүй учир зах зээлд жишиг өгөөжийн муруй бий болох нөхцөл хангагдаагүй.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолын дагуу баталсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2022-2025 оны стратегийн бичиг баримт”-д зааснаар цаашид Засгийн газрын дотоод өрийн санхүүжилтийн эх үүсвэрийг нээлттэй зах зээлээр дамжуулан бүрдүүлэх бодлогын шийдвэрийг гаргаад байгаа бөгөөд үүний хүрээнд Сангийн яам 2023-2027 онд 12.3 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий Засгийн газрын үнэт цаасыг гаргахаар төлөвлөөд байна.

Засгийн газрын үнэт цаас нь дотоодын хөрөнгийн зах зээлийн гол бүтээгдэхүүний нэг байсаар ирсэн бөгөөд Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах гадаадын хөрөнгө оруулагчдын тоог нэмэгдүүлэх онцгой ач холбогдолтой бүтээгдэхүүн юм. Тухайлбал, 2016 онд нийт гадаадын хөрөнгө оруулагчдын нийт арилжаанд эзлэх хувь 2 хувь байсан бол 2016-2017 онд Засгийн газрын үнэт цаас

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
“ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК” ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12

идэвхтэй арилжаалдаг байсантай холбоотойгоор 2018 онд гадаадын хөрөнгө оруулагчдын эзлэх хувь 40 хувь болж нэмэгдсэн байдаг. [12]

Ийнхүү эрсдэлгүй, хүүгийн орлогын татваргүй Засгийн газрын үнэт цаасыг нээлттэй зах зээл дээр арилжаалах нь гадаадын хөрөнгө оруулалтыг дотоодын зах зээлд татах таатай нөхцөл бүрдүүлж, зах зээлийг идэвхжүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах ач холбогдолтой юм. Монголын Хөрөнгийн Бирж нь Засгийн газрын үнэт цаасны арилжааг түргэн шуурхай, үр ашигтайгаар зохион байгуулна.

Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын нээлттэй сан

Биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын нээлттэй сан буюу Exchange Trade Fund /ETF/ нь хувьцаа, бонд, түүхий эд зэрэг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулах замаар төрөлжсөн багцыг үүсгэдэг.

Олон улсын зах зээлд уг төрлийн сангийн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын багцаа илүү хялбар байдлаар, хямд өртөгтэйгөөр бүрдүүлэх боломжтой байдаг бөгөөд нэгж эрхээ худалдсан тохиолдолд татвараас чөлөөлөгддөг онцлогтой. Биржээр арилжаалагддаг тул энэ төрлийн нэгж эрхийн хөрвөх чадвар өндөртэй байдаг ба хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээний шимтгэл, хураамж нь бусад хамтын сангуудыг бодвол хямд байдаг тул мэргэжлийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг татдаг хэрэгслүүдийн нэг болдог байна.[13]

Сүүлийн жилүүдэд олон улсын санхүүгийн зах зээлд биржээр арилжаалагддаг санд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ огцом өсөж, хөрөнгө оруулалтын голлох хэлбэрүүдийн нэг болоод байна.

---

[12] "Монголын Үнэт Цаасны Клирингийн Төв" ХХК-ийн тайлан, 2016-2019
[13] http://www.frc.mn/a/2792

MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2009.12.04 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

График 36. Олон улсын Биржээр арилжаалагдах хөрөнгө оруулалтын нээлттэй сангийн зах зээл



Огноо	Биржээр арилжаалагдах сангуудын хөрөнгө (их наяд ам.доллар)	Биржээр арилжаалагдах бүтээгдэхүүнүүдийн хөрөнгө (их наяд ам.доллар)	Биржээр арилжаалагдах бүтээгдэхүүнүүд (тоо)	Биржээр арилжаалагдах сангууд (тоо)
2003	212	6	11	291
2004	310	9	12	337
2005	417	9	14	453
2006	580	23	31	727
2007	807	50	65	1,187
2008	716	58	141	1,618
2009	1,041	117	147	1,967
2010	1,313	165	197	2,476
2011	1,355	171	276	3,027
2012	1,754	195	286	3,336
2013	2,254	144	277	3,609
2014	2,643	141	285	3,984
2015	2,870	123	275	4,454
2016	3,397	151	264	4,845
2017	4,690	149	279	5,320
2018	4,683	132	240	6,531
2019	6,194	169	246	6,983
2020	7,736	255	174	7,435
2021	10,021	247	177	8,550
2022-10	8,651	215	170	9,387

Эх сурвалж: "ETFGI" судалгааны компани, 2022 оны 10 дугаар сар

Монголын Хөрөнгийн Биржийн зүгээс арилжаалагдаж буй бүтээгдэхүүний төрлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах хэрэгслийг зах зээлд

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020609 207.1096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

бий болгохоор Хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмыг боловсруулсан бөгөөд 2022 онд багтаан Санхүүгийн Зохицуулах Хороогоор батламжлуулан 2023 оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Энэхүү журмын дагуу сангийн хөрөнгө оруулалтын хэрэгсэл нь дотоодын болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрсөн гадаад улсын бирж дээр идэвхтэй арилжаалагддаг, үнэт цаасны индексийн багцыг бүрдүүлдэг хувьцаа, өрийн хэрэгсэл болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн хэрэгслүүд байх юм. Тухайлбал, Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс, гадаад зах зээл дээр өргөнөөр ашиглагддаг S&P 500 индекс, FTSE Russell 100 зэрэг индексүүд, Засгийн газрын үнэт цаас, компанийн бонд болон хувьцаанд суурилсан биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрхийг гарган Монголын Хөрөнгийн Биржээр арилжих боломж бүрдэнэ.

Монгол Улсын хадгаламжийн бичиг

Монгол Улсын хадгаламжийн бичиг буюу Mongolian Depository Receipt (MDR) нь гадаад улсын бирж дээр арилжаалагдаж буй үнэт цаасаар баталгаажиж Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээр гаргасан үнэт цаас бөгөөд хадгаламжийн бичиг эзэмшигч нь тухайн суурь үнэт цаас эзэмшигчтэй ижил эрх, үүрэгтэй байдаг. Энэхүү хадгаламжийн бичиг нь гадаад улсын биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын хувьд Монголын Хөрөнгийн Биржид үнэт цаасаа бүртгүүлэх нэг хэлбэр болдог бол дотоодын хөрөнгө оруулагчдын хувьд гадаад улсын биржид бүртгэлтэй компанийн үнэт цаасыг шууд бусаар эзэмшин өгөөж хүртэх боломжийг бий болгох юм.

Хадгаламжийн бичиг нь гадаадын бирж дээр арилжаа хийхгүйгээр, дотоодын дундын зуучлагчаар дамжуулан гадаадын бирж дээр бүртгэлтэй үнэт цаасыг худалдан авах, эзэмших боломжийг олгодог онцлогтой тул өөр зах зээлүүдэд хөрөнгө оруулан багцаа төрөлжүүлэх арга хэрэгсэл болохоос гадна хямд өртөгтэй, арилжаа хийх шимтгэл, зардлыг бууруулах ач холбогдолтой.

Уг санхүүгийн хэрэгслийн олон улсын зах зээлийг авч үзвэл, тухайлбал 2021 онд хөгжиж буй зах зээл дээр нийт 23.3 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний санхүүжилтийг хадгаламжийн бичиг хэлбэрээр татан төвлөрүүлсэн байна. Харин хөгжингүй улс орнуудын хувьд энэхүү үзүүлэлт 12.1 тэрбум ам.доллар байв.

График 37. Олон улсын хадгаламжийн бичгээр төвлөрүүлсэн дүн

Ам.доллар, 2020 – 2021 он



Эх сурвалж: "Bloomberg", IPREO, Depositary Data Interchange

Олон улсын зах зээлд түгээмэл арилжаалагддаг энэхүү хэрэгслийг дотоодын зах зээлд нэвтрүүлэх үүднээс Монголын Хөрөнгийн Бирж нь Монгол Улсын хадгаламжийн бичгийн бүртгэлийн журмыг боловсруулсан бөгөөд 2023 оноос эхлэн нэвтрүүлэхээр төлөвлөөд байна. Энэхүү журам хэрэгжиж эхэлснээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг, гадаад улсын бирж дээр бүртгэлтэй, нийт 10.2 тэрбум ам.долларын зах зээлийн үнэлгээ бүхий 16 компаниас гадна гадаадын нэр хүнд бүхий компаниуд Монголын Хөрөнгийн Бирж дээр хадгаламжийн бичиг гаргах замаар бүртгүүлэх боломжтой болно.

Үүсмэл санхүүгийн хэрэгсэл

Фьючерс, опцион зэрэг үүсмэл санхүүгийн хэрэгслүүд нь хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын эрсдэлээ удирдах боломжийг олгодог. Бага дүнгээр хөрөнгө оруулан өндөр өгөөж хүртэх, эрсдэлээ удирдах боломжтой тул үүсмэл санхүүгийн хэрэгслүүд нь эрсдэлээ удирдах хэрэгцээ шаардлага ихтэй гадаадын хөрөнгө оруулагчид болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дотоодын зах зээлд татах, тэдгээрийн арилжааны идэвхийг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй юм.

Монголын Хөрөнгийн Бирж нь 2024 оноос уул уурхайн түүхий эд болон ТОП-20 индексэд суурилсан фьючерсийг арилжаалахаар төлөвлөн үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны зохицуулалт болон системийн бэлэн байдлыг хангахаар ажиллаж байна.

Брокероор дамжуулан гаргах хадгаламжийн сертификат

Брокероор дамжуулан гаргах хадгаламжийн сертификат буюу "Brokered certificate of deposit" нь арилжааны банкны уламжлалт хадгаламжийн сертификатаас хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжигддагаараа онцлогтой юм. Уламжлалт хадгаламжийн сертификатыг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд хүүгийн торгууль ногдуулдгаас гадна өөр эзэмшигчид шилжүүлэх, худалдахад хүндрэлтэй байдаг бол бирж болон биржийн бус зах зээлд брокероор дамжуулан гаргах хадгаламжийн сертификатыг чөлөөтэй арилжаалж, худалдах боломжтой байдаг.

СЗХ
2022.12.14 едер
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-12-12
БҮРТГЭВ-02

Хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын зүгээс энэхүү бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нэвтрүүлэхээр "Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн төсөлд холбогдох зохицуулалтыг тусган Улсын Их Хурлаар батлуулахаар ажиллаж байна. Эрх зүйн орчин бүрдсэн тохиолдолд тус бүтээгдэхүүнийг Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалах боломжийг бүрдүүлж, арилжааг зохион байгуулснаар хөрөнгө оруулагчдад шинэ бүтээгдэхүүний сонголт нэмэгдэж, арилжааны банкнууд хадгаламжийн сертификатаа нээлттэй зах зээлээр дамжуулан гаргах боломжтой болно.

Токенжуулсан үнэт цаас

Токенжуулсан үнэт цаасны арилжаа нь хувьцаа, бонд, зэрэг үнэт цаасны виртуал хэлбэрийг блокчэйн технологиор дамжуулах арилжаалахыг хэлдэг. Дэлхийн дийлэнх улсад энэхүү арилжааг үнэт цаасны хуулиар зохицуулж байна. Тухайлбал, АНУ, Их Британи, Хонконг зэрэг зах зээлүүдэд токенжуулсан үнэт цаас нь үнэт цаасны хуулийн шаардлагыг хангасан байхыг шаардаж байна. Түүнчлэн 2021 онд Холбооны Нэгдсэн Герман Улс "Цахим Үнэт цаасны тухай хууль", Лихтенштейн Улс "Блокчейний тухай хууль"-ийг тус тус баталж, тусдаа хуулийн зохицуулалттай болсон байна.

Үнэт цаасыг токенжуулан гаргах нь зардлыг бууруулах, технологийн давуу талыг ашиглан төлбөрийг агшин зуур хийх зэргээр үр ашигт байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байдаг. Монгол Улсын хувьд блокчейн технологид суурилсан токенжуулсан үнэт цаасыг арилжаалах хууль, эрх зүйн орчин бүрдэх үе шатандаа явж байгаа бөгөөд Монголын Хөрөнгийн Бирж нь энэхүү дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүнийг зохицуулалттай зах зээлд нэвтрүүлэх боломжийг бий болгож, Сэндбокс зохицуулалтын орчинд турших замаар зах зээлд нэвтрүүлэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Үнэт цаас гаргагчдын тоог нэмэгдүүлэх

2023 оны "Төсвийн тухай хууль"-ийн дагуу компанийн IPO хийх зардлыг тухайн жилийн татвар ногдох орлогоос хасаж тооцохоор болсон нь аж ахуйн нэгжүүд IPO буюу хувьцаагаа нийтэд анх удаа санал болгох ажиллагаанд түлхэц болох юм. Түүнчлэн Монголын Хөрөнгийн Бирж нь "Зээлийн хүүг бууруулах үндэсний стратеги"-ийн хүрээнд 2022 онд үнэт цаас гаргагчийн төлөх шимтгэл хураамжийг 50-75 хүртэл хувиар бууруулсан нь үнэт цаас гаргагчдад хувьцаагаа олон нийтэд санал болгоход томоохон дэмжлэг болж байна.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржийн 2020 оны шилдэг 50 аж ахуйн нэгжүүдийн дунд хийсэн хамтарсан судалгаагаар 15 компани "ойрын хугацаанд" үйл

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6917839 ☎1119277128
УЛААНБААТАР ХОТ

ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай санхүүжилтээ хөрөнгийн зах зээлээр дамжуулан татах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэвэл дунд хугацаанд Монгол Улсын ТОП 100-д тооцогддог аж ахуйн нэгжүүдээс жил тутам 1 (нэг)-ээс доошгүй компани Монголын Хөрөнгийн Бирж дээр үнэт цаасаа бүртгүүлэх боломжтой байна.

Мөн "Ашигт малтмалын тухай хууль"-ийн 5.6 дахь заалтын дагуу гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшдэг компаниуд, "Банкны тухай хууль"-ийн дагуу системийн нөлөө бүхий банкнууд, болон "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-д багтсан төрийн өмчит компаниуд хувьцаагаа олон нийтэд санал болгон арилжихаар байна.

Олон улсын зах зээлд хөрөнгийн биржүүд эрсдэл өндөртэй боловч өсөх ирээдүйтэй гарааны бизнес эрхлэгчдийн үнэт цаасыг хялбаршуулсан журмаар бүртгэж, зөвхөн мэргэжлийн хөрөнгө оруулагчид болон тодорхой хөрөнгийн шаардлага хангасан, эрсдэл даах чадвартай хувь хүмүүсийн хүрээнд санал болгон худалдах боломжийг олгодог. Энэхүү сайн жишгийг дотоодын зах зээлд нутагшуулснаар үнэт цаас гаргагчид богино хугацаанд харьцангуй хямд зардлаар хөрөнгө татан төвлөрүүлэх, цаашид нээлттэй, олон нийтийн компани болж, үндсэн самбарт үнэт цаасаа бүртгүүлэхэд бэлтгэгдэх боломжтой болох юм. Энэ хүрээнд олон улсын туршлагын дагуу өсөх ирээдүйтэй гарааны бизнесийг дэмжин бойжуулах, хялбар арга хэлбэрээр бүртгэлд хамруулах туслах захыг бий болгох ажлыг хэрэгжүүлэх үүднээс "Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл"-д уг боломжийг бий болгох зохицуулалтыг тусган батлуулахаар ажиллаж байна.

2018 онд Монголбанкнаас хийсэн "Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал" түүвэр судалгааны тайланд судалгаанд хамрагдсан жижиг дунд аж ахуйн нэгжийн 50 гаруй хувь нь зээлийн нөхцөл хатуу, зээл авах нөхцөл хангаагүй зэрэг шалтгаанаар гадаад санхүүжилтэд хамрагдаагүй байна. Үүнээс гадна Жайка олон улсын байгууллага болон Mongolian Marketing Consulting Group (MMCG) үндэсний судалгааны компанийн хамтран хийсэн "Монгол Елсын Стартапын экосистемийн суурь судалгаа"-нд хөрөнгө оруулалт татахад бэрхшээл тулгардаг талаар дурдсан.

Ийнхүү Үнэт цаас гаргагч нь 2023-2027 онуудад нийт 100 орчим үнэт цаасыг шинээр бүртгэн арилжаалах төсөөллийг хийгээд байна.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

График 38. 2023-2027 онуудад хийгдэх IPO-нуудын ирээдүйн төсөөлөл

Их наяд төгрөг, тоо нэгж, 2023 – 2027 он



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаасыг олон нийтэд санал болгоход мэргэжлийн туслалцаа, зөвлөх үйлчилгээ үзүүлэх

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ихэнх аж ахуйн нэгжүүд шаардлагатай санхүүжилтээ банкнаас зээл авах байдлаар шийдвэрлэдэг бөгөөд компанийн бонд, хувьцаа нийтэд санал болгож эх үүсвэр татахад хүндрэлтэй, зардал өндөр гэсэн ойлголттой, эсвэл тийм сонголт б айдаг гэдгийг огт мэдэхгүй, мэдээлэлгүй байна[14].

Монголын Хөрөнгийн Бирж нь үнэт цаас гаргахаар сонирхож буй компаниудад мэдээлэл зөвлөгөө өгөх арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг бөгөөд үүний хүрээнд 2022 онд "IPO Mongolia" арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Цаашид энэхүү үйл ажиллагааны цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс үнэт цаас гаргагчдад мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгөх хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байна.

Гадаад улсын туршлагаас харахад хөрөнгийн биржүүд нь аж ахуйн нэгжүүддээ нээлттэй хувьцаат компани болох давуу талуудыг ойлгуулах, хувьцаагаа нийтэд санал болгох бэлтгэл ажилд нь зөвлөгөө өгөх, сургалт, семинар зохион байгуулах болон бусад олон төрлийн дэмжлэг, туслалцаа үзүүлдэг билээ. Монголын Хөрөнгийн Бирж нь энэхүү жишгийн дагуу үнэт цаас гаргах сонирхолтой

[14] СЗХ, МХБ, МҮХАҮТ-ын хамтарсан судалгаа, 2022

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

компаниудад үнэт цаас бүртгүүлэх талаар ойлголт өгөх сургалт семинар хийх, үнэт цаас бүртгүүлсний дараах тогтмол биелүүлэх үүрэг, компанийн засаглал, БОНЗ-ын сургалтуудыг зохион байгуулах зэрэг үнэт цаас гаргагчдад зориулсан цогц хөтөлбөр боловсруулах төлөвлөгөөтэй байна.

4.1.2. Хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулагчдын тэргүүн сонголт болох

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдад урт хугацаанд хөрөнгөө эрсдэл багатайгаар өсгөх боломжоор хангагдсан, эрх ашиг нь зохих түвшинд хамгаалагдсан орчин бүрдүүлэх хүрээнд үнэт цаас гаргагчдаас ирүүлэх мэдээллийг нэгдсэн стандартын дагуу, ил тод, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэдэг тогтолцоог бүрдүүлэх, одоо байгаа бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулах, зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, олон нийт, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна.

1. Зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулах

Хөрөнгө оруулагчид эзэмшиж буй хувьцаагаа хүссэн үедээ зах зээлийн үнээр худалдан борлуулах боломжтой эсэх нь зах зээлийн хөрвөх чадвараас хамаардаг. Зах зээлийн хөрвөх чадвар нь хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа, зах зээлийн үнэлгээний харьцаагаар илэрхийлэгддэг ба энэхүү үзүүлэлт өндөр байх тусам тухайн зах зээл хөрвөх чадвар өндөртэй, аливаа өндөр дүнтэй арилжааны тухайн үнэт цаасны зах зээлийн үнэд үзүүлэх нөлөө нь бага байх магадлалыг илэрхийлдэг.

- ✓ 2022 оны 9 дүгээр сард олон улсын хэмжээнд хөрөнгийн зах зээлийн индексийн тооцоо, судалгааны чиглэлээр тэргүүлэгч Их Британийн **"FTSE Russell" Групп Монголын хөрөнгийн зах зээлийг "Frontier"** зах зээлийн ангилалд оруулахыг зөвшөөрсөн билээ. Энэхүү үйл явдлын үр дүнд тус байгууллагаас тооцон гаргадаг индексийг дагаж хөрөнгө оруулалт хийдэг, тус индексийн бүрэлдэхүүнд багтсан үнэт цаасанд хөрөнгө оруулдаг хөрөнгө оруулалтын сангууд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй тус индексийн бүрэлдэхүүнд багтсан компанийн хувьцаанд хөрөнгө оруулах эхлэл тавигдаж байгаа тул цаашид хоёрдогч зах зээлийн арилжаа идэвхжих хүлээлттэй байна. "FTSE Russell" групп 2023 оны 6 дугаар сард Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниуд "Frontier" индексийн шалгуур хангах эсэхэд үнэлгээ хийж, шалгуур хангасан компаниудыг 2023 оны 9 дүгээр сард индексийн бүрэлдэхүүнд оруулах юм. Монголын Хөрөнгийн Бирж нь тус байгууллагаас тавих шалгуурыг хангахад бүртгэлтэй компаниудад мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэн ажиллахаар төлөвлөөд байна.

СЭХ
ЗАРЛ. ИДР 14 ӨДӨР
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

Түүнчлэн **"MSCI Frontier"** зах зээлийн ангилалд орохоор төлөвлөн ажиллаж байна.

- ✓ Сүүлийн жилүүдэд олон улсын зах зээлд хөрөнгө оруулалтын сангууд **Байгаль орчин, нийгэм болон засаглалын зарчмуудыг хэрэгжүүлдэг компаниудын гаргасан** тогтвортой санхүүжилтийн зарчмуудад нийцсэн хувьцаа, бонд, болон индексэд хөрөнгө оруулах хандлага ихсэж, энэ хэрээр хариуцлагатай хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэж байна. 2022 онд батлагдсан Монголын Хөрөнгийн Биржийн "Бүртгэлтэй компаниудаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам"-аар БОНЗ-ын тайлагналын стандартыг баталсан бөгөөд үүний дагуу бүртгэлтэй компаниуд сайн дурын үндсэн дээр тайлан гаргаж ирүүлэхээр зохицуулсан. Иймд гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг татаж, арилжааны идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор БОНЗ-ын зарчмын ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг бүртгэлтэй компаниудад ухуулан таниулах сургалт, семинарыг тогтмол зохион байгуулж, БОНЗ-ын зарчмуудыг хэрэгжүүлдэг компаниудын тоог нэмэгдүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Энэ хүрээнд бүртгэлтэй компаниудыг БОНЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байдлаар эрэмбэлэн жагсааж, сурталчлах, зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Цаашид дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр "БОНЗ индекс"-ийг тооцоолох боломж бүрдэхээр байна.

- ✓ Монголын Хөрөнгийн Бирж нь Монголын хөрөнгийн зах зээлийн "Frontier" ангиллыг ахиулж, "Secondary Emerging" ангилалд оруулах ажлуудаа эхлүүлэхээр ажиллаж байна. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээ, болон short-sell/богино арилжааг зах зээлд нэвтрүүлсэн байх нь уг зах зээлийн ангилалд тавигддаг гол шалгуур тул тус ангиллын шалгуурыг хангахад шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

- ✓ Монголын Хөрөнгийн Бирж 2022 онд Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах, шинэ үнэт цаасны үнийг тогтворжуулах үүрэг бүхий зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааг зах зээлд шинээр нэвтрүүлж, түүний үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу зохицуулахаар **"Зах зээл үүсгэгчийн журам"**-ыг баталсан. Энэхүү журмын дагуу тодорхой шаардлага хангасан Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн үнэт цаасны компани тодорхой үнэт цаасны "Market maker" буюу зах зээл үүсгэгчийн үүрэг гүйцэтгэж, тухайн үнэт цаасны хөрвөх чадварыг хангах зорилгоор худалдах, худалдан авах захиалгыг нэгэн зэрэг системд оруулж, биелүүлэх үүрэгтэйгээр зах зээлд оролцох юм. Монголын Хөрөнгийн Бирж нь зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулах үүднээс энэхүү үйл ажиллагааг дэмжиж, зах зээлд хэрэгжүүлнэ.

ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХО
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL

СӨХ
БҮРТГЭЛ
№ 01
2022 -12- 12

- ✓ Гадаадын хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлэх зорилгоор "Remote broker" тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн үндсийг тавин гадаадын биржийн гишүүн үнэт цаасны компаниудыг үе шаттайгаар Монголын Хөрөнгийн Биржийн гишүүнээр элсүүлж, тухайн үнэт цаасны компаниудын хөрөнгө оруулагчид Монголын Хөрөнгийн Бирж дээр чөлөөтэй хөрөнгө оруулах боломжийг бүрдүүлж, арилжааны идэвхийг нэмэгдүүлэхээр судалж байна.

- ✓ Бүс нутагтаа өрсөлдөхүйц бирж болох алсын харааны хүрээнд бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, **Stock Connect, Bond Connect хөтөлбөрүүдийг** гадаадын биржүүдтэй хамтран хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд Азийн болон бусад хөгжиж буй улс орнуудын биржүүдтэй хамтран ажиллаж, үнэт цаасыг бирж хооронд чөлөөтэй арилжаалах боломжийг бий болгох чиглэлээр судалгаа хийж байна. Тухайлбал, Солонгосын Хөрөнгийн Биржтэй Stock Connect хөтөлбөр хэрэгжүүлсэн тохиолдолд Солонгосын Хөрөнгийн Бирж дээр арилжаалдаг хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж дээр арилжаалж байгаа мэт арилжаалах, Солонгосын Хөрөнгийн Биржийн хөрөнгө оруулагч өөрийн ашигладаг платформоо ашиглаж Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй хувьцаанд хөрөнгө оруулах боломжтой болно.

Дээрх арга хэмжээнүүд хэрэгжиж, нээлттэй компаниуд олширч, одоо бүртгэлтэй байгаа компаниудын үйл ажиллагаа өргөжин сайжирснаар арилжааны идэвх нэмэгдэж, хоёрдогч зах зээлийн арилжаа 2021 онд 217 тэрбум төгрөг буюу зах зээлийн үнэлгээний 3.6 хувь болон нэмэгдэж, 2027 онд 2.45 их наяд төгрөг буюу зах зээлийн үнэлгээний 10.0 хувьд хүрэх бүрэн боломжтой байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
1119277128
УЛААНБААТАР ХОТ

2022 -12- 12

График 39. Монголын Хөрөнгийн Биржийн хөрвөх чадвар, хоёрдогч арилжааны төсөөлөл

Тэрбум төгрөг, хувь, 2023 – 2027 он



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

1. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах

Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах дараах томоохон ажлуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна. Үүнд:

- ✓ **“Хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах сан”** буюу “Investor Protection Fund” байгуулах: Олон улсын биржүүд энэ төрлийн санг бүртгэлтэй компаниуд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд хөрөнгө оруулагчдын ногдол хувийг тус сангаас олгож, эрх ашгийг нь хамгаалах зорилгоор байгуулдаг.

- ✓ **“Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зөвлөл”**-ийг Монголын Хөрөнгийн Биржийн дэргэд байгуулах: Тус зөвлөлийг байгуулж, хөрөнгө оруулагчдын гомдол, саналыг цахим хэлбэрээр хүлээн авахын зэрэгцээ аюулгүй “шүгэл үлээх механизм”-ыг бий болгох замаар хөрөнгө оруулагчдын, тэр тундаа жижиг хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах арга хэрэгслийг бий болгоно.

- ✓ **Компанийн засаглал** сайжирснаар хөрөнгө оруулагчдын эрсдэл бууран компани урт хугацаанд тогтвортой хөгжихөд чухал ач холбогдолтой бөгөөд компанийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, үр ашигтай ажиллах боломж бүрддэг. Иймд Монголын Хөрөнгийн Бирж нь 2022 оноос эхлэн бүртгэлтэй компаниудын засаглалыг “Компанийн засаглалын кодекс”-ийн дагуу үнэлэн дүгнэлт гаргаж, олон нийтэд мэдээлэх, хангалтгүй үнэлгээтэй компаниудад

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020699 2079096
УЛААНБААТАР ХОТ
“ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК” ХХК
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 оны 12 сар 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭСЭН

засаглалын шаардлагыг хангах талаар шаардлага хүргүүлэх, сургалт семинар зохион байгуулах зэргээр бүртгэлтэй компаниудынхаа засаглалыг сайжруулахаар ажиллана. Компаниуд БОНЗ-ын зарчмуудыг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэн тайлан мэдээлэл ирүүлэх, олон нийтэд тайлагнах зохицуулалттай байгаа боловч цаашид ач холбогдлыг таниулан сурталчлах замаар уг зарчмуудыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэхийг уриална. Мөн бүртгэлтэй компаниуд сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлээ хууль, журамд заасан хугацаанд олон нийт, хөрөнгө оруулагчдад мэдээлж байх шаардлагыг тавьж ажиллана.

- ✓ Хувьцааны төвлөрөл ихтэй зах зээлийн хувьд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг **хөрөнгө оруулалтын сангуудын** оролцоогоор дамжуулан хамгаалах боломжтой байдаг. Сангийн менежер нь жижиг хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцон тэдний эрх ашигт нь нийцсэн санал өгөн шийдвэр гаргалтад нөлөөлөх боломжтой байдаг. Зах зээлд гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчид, ялангуяа гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчид нэмэгдэхийн хэрээр компанийн засаглал сайжрах эерэг нөлөөтэй байдаг. Иймээс Монголын Хөрөнгийн Бирж нь хөрөнгө оруулалтын сан, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг дэмжих бодлого баримтална.

Хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх хүрээнд мэдээллийн тэнцвэргүй байдлыг арилгах, бүртгэлтэй компаниудын хууль, журамд заасан хугацаанд тайлан, мэдээллээ Монголын Хөрөнгийн Биржид ирүүлэн олон нийтэд мэдээлэх үүргийг хангуулж ажиллана. Тус мэдээллийг нэгдсэн стандарттай болгож, ил тод, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх тогтолцоог бүрдүүлэхэд Монголын Хөрөнгийн Бирж анхааран ажиллаж байна. Үүнд:

- ✓ **Үнэт цаас гаргагчдын тайлагналын нэгдсэн стандартыг** бий болгохоор "Тайлагналын нэгдсэн цахим систем"-ийг хөгжүүлж, зах зээлд нэвтрүүлэхээр төлөвлөөд байна.
- ✓ **Өдөр тутмын мэдээ, мэдээллийг нийтлэх стандартыг** сайжруулж, мэдээллийг Англи Монгол хэлээр түргэн шуурхай мэдээлэн, мэдээлэл тэнцвэртэй, хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- ✓ **Зах зээлийн өгөгдөл мэдээллийг олон улсын мэдээллийн агентлаг, дата вендор, терминалуудад нийлүүлэх** ажлыг эрчимжүүлж ажиллах ба энэ хүрээнд өгөгдөл мэдээлэлд боловсруулалт хийн мэдээллийг төрөлжүүлж, өргөн хүрээнд ажиллахаар төлөвлөж байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨҮК
МОНГОЛЫН
9020020698 № 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2. *Олон нийтийн хөрөнгийн зах зээлийн талаар мэдлэгийг дээшлүүлэх*

Банкнуудын IPO хийхтэй холбоотойгоор 2022 онд KPMG олон улсын байгууллагын хийсэн "Хөрөнгийн зах зээлийн багтаамж тодорхойлох судалгаа"-гаар олон нийт хөрөнгийн зах зээл, үнэт цаасны тухай мэдлэг хомс байгаа тухай үр дүн гарсан байна. Түүнчлэн иргэд зах зээлийн талаар мэдлэгээ сайжруулан хөрөнгийн зах зээлд оролцох сонирхолтой байгаагаа уг судалгаанд илэрхийлсэн байна. Иймд олон нийтийг мэдээллээр хангах ажиллагааг эрчимжүүлэхээр төлөвлөсөн.

- ✓ Их дээд сургууль, болон ахлах сургуулиудтай хамтран ажиллаж, оюутнууд, ахлах ангийн сурагчдын хүрээнд **Биржийн нэрэмжит тэмцээн, уралдаануудыг** зохион байгуулж, олон нийтийн хөрөнгийн зах зээлийн тухай ойлголт, мэдлэгийг сайжруулна. Тухайлбал, Казахстаны Хөрөнгийн Бирж энэ төрлийн тэмцээн, уралдааныг тогтмол зохион байгуулан 2008 оноос хойш нийт 80 орчим их сургуулийн 7,500 оюутан хамруулж байсан бол 2016 оноос нийт 3,700 орчим жижиг хөрөнгө оруулагчдыг мөн хамруулах болсноор олон нийтийн хөрөнгийн зах зээлийн оролцоо нэмэгдсэн байна.

- ✓ Хөрөнгийн зах зээлийн сургалтын төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, хөрөнгө оруулах сонирхолтой хувь хүмүүст анхан, дунд шатны сургалтууд тогтмол явуулах төлөвлөгөөтэй байна. Мөн хөрөнгийн зах зээлийн тухай контент боловсруулж, мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд тогтмол хүргэж байхаар төлөвлөсөн байна.

- ✓ Гадаад, дотоодод **Монголын хөрөнгийн зах зээлийг таниулах, сурталчлах** форум, аяныг тогтмол зохион байгуулна. Тухайлбал, олон улсын хөрөнгийн зах зээлийн томоохон арга хэмжээнүүдэд оролцож, зах зээлийн бусад оролцогчид болон хамтын ажиллагаатай гадаадын биржүүдтэй хамтран Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг таниулан сурталчлах "Mongolia Capital Market Day" арга хэмжээг жил бүр тогтмол зохион байгуулахаар төлөвлөж байна.

- ✓ **Цахим хуудсаа** шинэчлэн, рэбрэндинг хийж олон нийтэд илүү хүртээмжтэй, ашиглахад хялбар мэдээллийн сувагтай болохоор ажиллаж байна.

4.1.3. Тогтвортой өсөлтийг бий болгох

Үнэт цаас гаргах компаниуд болон хөрөнгө оруулагчдад найдвартай, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж, хөрөнгө оруулалт болон санхүүжилтийн таатай орчин бүрдүүлэхийн тулд Монголын Хөрөнгийн Бирж урт хугацаанд тогтвортой өсөлттэй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр Монголын Хөрөнгийн Биржийн чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх төслийг 2022 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэхүү төслийн хүрээнд олон улсад тэргүүлэх аудит, зөвлөх үйлчилгээний компани болох Эрнст Янг компани Монголын Хөрөнгийн Биржийн дунд хугацааны бизнес хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, байгууллагын чадавхыг дээшлүүлэх, олон улсын хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллах юм.

1. Жишиг нээлттэй компани болно

Монголын Хөрөнгийн Бирж нь 2022 онд компанийн үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах замаар нээлттэй компани болж, өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэн, санхүүгийн чадавхыг дээшлүүлж, жишиг нээлттэй компани болно.

2. Системийн байнгын шинэчлэлийг хэрэгжүүлнэ

Аливаа хөрөнгийн бирж нь арилжааг тасалдалгүй, алдаагүй явуулахын тулд техник, технологийн найдвартай байдлыг хангаж ажиллах шаардлагатай байдаг. Үүний тулд Үнэт цаас гаргагч нь олон улсын стандартын дагуу үндсэн системд шаардлагатай шинэчлэлүүдийг тогтмол хийнэ.

3. Хүний нөөцийн бодлогыг шинэчилж, ажилтнуудын тэргүүн сонголт болно

Үйл ажиллагаа идэвхжиж, хөгжил дэвшил гарахын хэрээр үр ашигтай байдлыг хангах, үйл ажиллагааны зорилго зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлж, оновчтой зохион байгуулах нь хамгийн чухал нөлөөтэй юм. Иймд Үнэт цаас гаргагч нь ажилчдаа дэмжсэн бодлого хэрэгжүүлж, “Ажил горилогчдын тэргүүн сонголт болох” зорилгыг дэвшүүлээд байна. Энэ хүрээнд Хүний нөөцийн бодлогын шинэчлэл, соёлын судалгааг жил тутам хийж, ажлын байрны нөхцөлийг сайжруулж, эрүүл, аюулгүй орчин бий болгохоос гадна цалингийн хэмжээг зах зээлд өрсөлдөхүйц хэмжээнд хүргэж, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ.

4. Дотоод үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулна

Үнэт цаас гаргагч нь үндсэн үйл ажиллагааны бизнесийн процессыг сайжруулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Технологийн дэвшлийг дотоод үйл

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12

ажиллагаандаа нэвтрүүлэн ашиглаж газар, албадын мэдээлэл солилцоо түргэсгэн, шийдвэр гаргах үйл явцыг хурдасгана.

5. Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулна

Компани нь үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтод үндэслэн бүтэц, зохион байгуулалтыг шинэчилж, оновчтой болгоно.

6. Байгууллагын үйл ажиллагаанд БОНЗ-ын зарчмуудыг хэрэгжүүлнэ

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандаа БОНЗ-ын зарчмыг хэрэгжүүлж, тогтолцоог дагаж мөрдөнө. Энэ хүрээнд Байгаль, нийгэм, засаглалын үнэлгээг 2023 онд багтаан хийлгэнэ.

7. Байгууллагын ашигт ажиллагааг нэмэгдүүлнэ

Үнэт цаас гаргагч нь байгууллагын урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах бизнесийн загварыг бий болгоно. Дунд хугацаанд арилжааны шимтгэлийн хэмжээг үе шаттай бууруулан, дата мэдээллийн төрлийг нэмэгдүүлж, зөвлөгөө өгөх үйлчилгээг шинээр бий болгохоос гадна үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлэн орлогын сегментийг төрөлжүүлэх замаар байгууллагын ашигт ажиллагааг нэмэгдүүлнэ.

MONGOLIAN STOCK EXCHANGE

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277129
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 .12. 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

4.2. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны санхүүгийн төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь цаашдын стратегийн зорилго, зорилтоо тодорхойлон, төрийн бодлого, макро эдийн засгийн орчин, нөхцөл байдлын шинжилгээнд үндэслэн 2023-2027 оны дунд хугацааны санхүүгийн төсөөллөө боловсруулсан.

Үнэт цаас гаргагч нь санхүүгийн төсөөлөлд багтсан санхүүгийн мэдээллийг бэлтгэсэн бөгөөд энэхүү мэдээлэлтэй холбоотой хариуцлагыг хүлээнэ. Мөн, энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан ирээдүйн төсөөллүүд нь таамаглал, үнэлгээнд суурилсан бөгөөд Хөрөнгө оруулагч нь тухайн төсөөлөл биелэх боломжтой эсэхэд өөрөө үнэлгээ хийж шийдвэрээ гаргах ёстой. Санхүүгийн тайланд "Грант Торнтон Аудит" ХХК аудитын компани аудит гүйцэтгэсэн бөгөөд ирээдүйн төсөөлөл, таамаглалуудтай холбоотойгоор ямар нэг аудит, нягтлах ажил болон аливаа ажилбар хийж гүйцэтгээгүй. Тиймээс, энэхүү танилцуулгад багтсан санхүүгийн ирээдүйн төсөөлөл, таамаглалуудтай холбоотойгоор ямар нэгэн дүгнэлт гаргаагүй.

Хөндлөнгийн үнэлгээний компани болох "Гэрэгэ Эстимэйт" ХХК нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээг гүйцэтгэхдээ санхүүгийн төсөөллийг өөрийн аргачлалаар боловсруулсан учир Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын төсөөллөөс зөрөх болохыг анхаарна уу.

Хүснэгт 35. Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын төсөөлөл
Сая төгрөг, 2021 оны гүйцэтгэл, 2022 – 2027 оны төсөөлөл

Үзүүлэлт	2021	2022*	2023*	2024*	2025*	2026*	2027*
ХӨРӨНГӨ							
Эргэлтийн хөрөнгө							
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,729.36	2,557.49	4,376.80	5,456.14	7,986.08	9,028.24	8,271.69
БХХО	-	-	1,651.62	2,147.51	3,732.09	4,913.57	6,759.49
Дансны авлага	97.26	73.39	798.24	774.85	1,082.40	1,211.36	1,419.50
Бараа материал	26.57	28.03	93.49	82.27	94.92	94.74	92.46
Урьдчилж төлсөн зардал тооцоо	7.67	301.46	287.97	253.42	223.01	196.25	172.70
Бусад эргэлтийн хөрөнгө	13.16	13.16	-	-	-	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	2,874.02	2,973.53	7,208.13	8,714.19	13,118.49	15,444.15	16,715.82
Эргэлтийн бус хөрөнгө							
Үндсэн хөрөнгө	2,102.23	5,415.13	11,109.59	12,450.5	11,960.59	11,474.48	11,444.31
Биет бус хөрөнгө	382.34	17,141.65	19,554.34	18,196.7	16,789.13	16,114.22	14,706.62

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020899 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 -12- 14
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-	1,651.62	1,464.21	2,332.56	2,834.75	6,035.26
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**2,484.57**	**22,556.78**	**32,315.56**	**32,111.50**	**31,082.28**	**30,423.46**	**32,186.19**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**5,358.59**	**25,530.31**	**39,523.69**	**40,825.6**	**44,200.77**	**45,867.61**	**48,902.01**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			-	-	-	-	-
Богино хугацаат өр төлбөр	-	-	-	-	-	-	-
Дансны болон бусад өглөг	926.82	21.67	126.23	161.03	314.28	312.58	396.50
Урьдчилж орсон орлого	14.25	0.19	50.68	64.48	82.04	104.38	132.80
Хойшлогдсон татварын өр	-	2,050.10	1,875.26	1,700.43	1,525.59	1,350.76	1,175.93
Богино хугацаат өр төлбөрийн дүн	941.07	2,071.96	2,052.18	1,925.94	1,921.92	1,767.72	1,705.23
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	**941.07**	**2,071.96**	**2,052.18**	**1,925.94**	**1,921.92**	**1,767.72**	**1,705.23**
Эздийн өмч	-	-	-	-	-	-	-
Хувь нийлүүлсэн хөрөнгө	23,130.59	23,130.59	35,046.35	35,046.35	35,046.35	35,046.35	35,046.35
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12.36	18,794.73	18,619.89	18,445.06	18,270.23	18,095.39	17,920.56
Эздийн өмчийн бусад хэсэг	446.32	446.32	446.32	446.32	446.32	446.32	446.32
Хуримтлагдсан ашиг	(19,171.76)	(18,913.29)	(16,641.06)	(15,037.99)	(11,484.05)	(9,488.18)	(6,216.45)
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	**4,417.52**	**23,458.36**	**37,471.51**	**38,899.7**	**42,278.85**	**44,099.89**	**47,196.78**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	**5,358.59**	**25,530.31**	**39,523.69**	**40,825.6**	**44,200.77**	**45,867.61**	**48,902.01**

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

Хүснэгт 36. Үнэт цаас гаргагчийн орлогын төсөөлөл

Сая төгрөг, 2021 оны гүйцэтгэл, 2022 – 2027 оны төсөөлөл

Үзүүлэлт	2021	2022*	2023*	2024*	2025*	2026*	2027*
Үйл ажиллагааны орлого	**5,483.08**	**4,986.72**	**9,634.84**	**10,368.47**	**14,105.42**	**14,390.84**	**16,460.18**
Арилжааны шимтгэл	**3,548.11**	**2,626.34**	**6,666.10**	**7,643.31**	**11,098.86**	**10,991.55**	**12,834.39**
Хувьцааны арилжааны шимтгэл	2,598.93	2,446.04	3,703.23	4,426.35	7,212.59	6,224.03	7,169.62
ЗГҮЦ-ны арилжаа	-	-	1,590.42	1,550.14	1,729.70	1,835.21	1,947.16

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
9020020690 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 12 сар 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭСЭН 02

Бонд, ХБҮЦ, ХОС арилжааны шимтгэл	949.18	180.31	269.53	475.24	869.79	1,542.62	2,216.76
Бусад үнэт цаасны арилжаа	-	-	1,102.93	1,191.59	1,286.77	1,389.69	1,500.84
Хураамж үйлчилгээний орлого	**1,233.75**	**2,077.07**	**2,292.26**	**1,741.80**	**1,738.48**	**1,786.95**	**1,697.13**
Бүртгэлийн хураамж, үйлчилгээний хөлс	-	1,942.91	2,126.58	1,562.50	1,537.62	1,574.53	1,473.15
Гишүүнчлэлийн хураамж, үйлчилгээний хөлс	-	134.16	165.68	179.30	200.86	212.42	223.98
Бусад үйл ажиллагааны орлого	**701.23**	**283.31**	**676.48**	**983.35**	**1,268.09**	**1,612.34**	**1,928.67**
Мэдээлэл нийлүүлэх үйлчилгээ	-	200.51	258.42	583.40	851.83	1,113.03	1,410.46
МІТ ашиглалтын орлого	-	9.73	180.60	195.05	210.66	227.51	245.71
Бусад ажил үйлчилгээ	-	73.07	237.45	204.90	205.60	271.80	272.50
Борлуулалтын өртөг	-	-	-	-	-	-	-
Нийт ашиг (алдагдал)	**5,483.08**	**4,986.72**	**9,634.84**	**10,368.47**	**14,105.42**	**14,390.84**	**16,460.18**
Үйл ажиллагааны зардал	**2,168.69**	**4,671.06**	**7,110.14**	**7,147.91**	**7,819.79**	**8,139.26**	**8,530.16**
Цалин түүнтэй холбогдох зардал	823.77	1,320.68	2,350.51	2,530.57	2,781.01	3,003.49	3,243.77
МІТ ашиглалтын зардал	938.09	844.19	1,463.95	1,284.07	1,386.80	1,497.74	1,617.56
Үйл ажиллагааны бусад зардал	167.17	1,365.89	1,277.25	1,285.22	1,584.43	1,494.33	1,535.74
Элэгдлийн зардал	239.66	1,140.30	2,018.43	2,048.05	2,067.56	2,143.71	2,133.10
Үйл ажиллагааны ашиг, алдагдал	**3,314.39**	**315.66**	**2,524.70**	**3,220.56**	**6,285.62**	**6,251.58**	**7,930.01**
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	37.91	-	-	-	-	-	-
Татварын өмнөх ашиг	**3,352.29**	**315.66**	**2,524.70**	**3,220.56**	**6,285.62**	**6,251.58**	**7,930.01**
Орлогын албан татвар	168.19	31.57	252.47	355.14	1,121.41	1,112.90	1,532.50
Цэвэр ашиг	**3,184.10**	**284.09**	**2,272.23**	**2,865.42**	**5,164.22**	**5,138.69**	**6,397.51**

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ХХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

2022 -12- 12

4.2.1. Үйл ажиллагааны орлогын төсөөлөл

Санхүүгийн тайлангийн шинжилгээнд дурдсанчлан Үнэт цаас гаргагчийн түүхэн борлуулалтын орлого нь үнэт цаасны арилжааны шимтгэл, гишүүнчлэлийн болон бүртгэлийн хураамж, үйлчилгээний хөлс, бусад үйл ажиллагааны орлого зэрэг 10 гаруй нэр төрлийн орлогоос бүрддэг ба хөрөнгийн зах зээлийн идэвхжил, эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай байна.

Иймд Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны санхүүгийн төсөөллийг гаргахад Монгол Улсын ДНБ-ий хэмжээ болон эдийн засгийн цаашдын өсөлт чухал ач холбогдолтой байна.

График 40. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хөрөнгийн зах зээлийн үнэлгээний хувийн гүйцэтгэл ба төсөөлөл

Хувь, 2018-2022 оны гүйцэтгэл, 2023-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

Монгол улсын ДНБ-д эзлэх хөрөнгийн зах зээлийн үнэлгээний хэмжээ нь 2018 онд 7.7 хувьтай байсан бол 2022 оны эхний хагас жилийн байдлаар 11.7 хувьтай болж өссөн үзүүлэлттэй байна. Монголын хөрөнгийн зах зээлийг ирэх жилүүдэд өсөх хандлагатай байгаа бөгөөд Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд 2027 оны эцэст хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ДНБ-ийн 25 хувьд хүрнэ гэж төсөөлсөн байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020698
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ТЦК" ХХК
6317839
9119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлогыг үндсэн эх үүсвэрээр нь ангилбал:

1. Арилжааны шимтгэлийн орлого

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн авах, зарах захиалгын арилжааны үнийн дүнгээс тодорхой хувиар шимтгэлийн орлого олдог. Үүнд:

- ✓ Хувьцааны арилжааны шимтгэл;
- ✓ Компанийн бондын арилжааны шимтгэл;
- ✓ Засгийн газрын үнэт цаасны арилжааны шимтгэл;
- ✓ Бусад үнэт цаасны арилжааны шимтгэлүүд /Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бусад үнэт цаас/

Дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй үнэт цааснуудын арилжааны хөрвөх чадвар буюу нийт зах зээлийн үнэлгээнд эзлэх үнэт цаасны арилжааны үнийн дүнгийн хэмжээ 2027 онд 10 хувьд хүрнэ гэсэн төсөөлөлтэй байна.

График 41. Монголын хөрөнгийн зах зээлийн арилжааны хөрвөх чадварын гүйцэтгэл ба төсөөлөл

Хувь, 2018-2022 оны гүйцэтгэл, 2023-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

2018 оноос 2022 оны гуравдугаар улирал дуусталх хугацаанд арилжааны хөрвөх чадварын дундаж түвшин 4 орчим хувьтай байна. 2018 онд арилжааны хөрвөх чадварын түвшин 8.5 хувь буюу дээрх хугацааны дунджаас өндөр байсан нь тухайн тайлант хугацаанд "Лэндмн ББСБ" ХК, "Монгол Базальт" ХК, "Мандал даатгал" ХК, "Ард даатгал" ХК зэрэг компаниуд Монголын Хөрөнгийн Биржид

ХӨРӨНГИЙН
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 91

2022 -12- 12

бүртгүүлж, олон нийтэд анх удаагаа хувьцаагаа санал болгосон, "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК, "Хөвсгөл Алтандуулга" ХК, "Цемент шохой" ХК зэрэг компаниуд нэмэлт хувьцаа гаргасантай холбоотойгоор хувьцааны арилжааны идэвх сайжирч, 2017 онтой харьцуулахад хувьцааны арилжааны үнийн дүн 133.6 тэрбум төгрөгөөр өсөж, 210 тэрбум төгрөгт хүрсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд төрийн өмчит компаниудыг үе шаттайгаар олон нийтийн компани болгохоор шийдвэрлэсэн, 2020 онд "Банкны тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт оруулан 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор банкны системийн нөлөө бүхий томоохон банкнуудыг олон нийтэд нээлттэй компани болохоор хуульчилсан зэрэг нь арилжааны хөрвөх чадварыг цаашид нэмэгдүүлэхэд томоохон нөлөө үзүүлэхээр байна.

График 42. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлогын үнийн дүнгийн төсөөлөл

Хувь, 2018-2021 оны гүйцэтгэл, 2022-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

Засгийн газрын үнэт цаасны арилжаа нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд чухал нөлөөтэй. Засгийн газрын үнэт цаасны өгөөжийн муруйг бий болгосноор хөрөнгийн зах зээлд эрсдэлгүй үнэт цаасны жишиг хүү тогтох ач холбогдолтой. Монгол Улсын Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт "Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна" гэсэн зорилтыг дэвшүүлсэн байдаг. Тус үйл ажиллагааг Монгол Улсын Сангийн яамнаас дотоодод гаргах Засгийн газрын үнэт цаасны арилжааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан хийх төлөвлөгөөтэй байгаа тул Үнэт цаас гаргагчийн цаашдын орлогын төсөөлөлд тусгагдаж, 2023-2027 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу жилд дунджаар 1.73 тэрбум төгрөгийн арилжааны шимтгэлийн орлогыг бүрдүүлэх төсөөлөлтэй байна.

2021 оны жилийн эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 5.5 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан бол цаашид жилд дунджаар 27.0 хувийн жилийн дундаж нийлмэл өсөлттэй ажилласнаар 2027 онд 16.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлэх төсөөлөлтэй байна.

Үнэт цаас гаргагч нь хувьцаа, бусад үнэт цаасны арилжааны шимтгэлийн орлого болон бүртгэл, гишүүнчлэлийн хураамжийн орлогыг төсөөлөхдөө одоогийн бүртгэлтэй компаниуд 2023-2027 онуудад хүлээгдэж буй томоохон банкнууд, төрийн өмчит компаниудын олон нийтэд хувьцаагаа санал болгох үйл ажиллагаа болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас Монгол Улсын шилдэг 100 аж ахуй нэгж байгууллагуудын дунд хийсэн судалгааны үр дүнд үндэслэн холбогдох тооцооллыг хийсэн байна.

Үнэт цаас гаргагчийн бусад үнэт цаасны арилжааны шимтгэлийн орлогод ирээдүйд арилжаалахаар төсөөлж буй биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрх, уул уурхайн бүтээгдэхүүний спот, фьючерс гэрээний арилжаа, уламжлалт болон таваарын зах зээлд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн арилжааны орлого зэрэг бүрдүүлэхээр төсөөлж байна.

Мөн дунд хугацааны гадаад болон дотоодын байгууллагуудад мэдээлэл нийлүүлэх, маркетингийн багцын үйлчилгээ, хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчид болон үнэт цаас гаргах сонирхолтой байгууллагуудад сургалт зохион байгуулах, зөвлөгөө өгөхтэй холбоотойгоор 2022-2027 онуудад дунджаар 1.1 тэрбум төгрөгийн бусад үйл ажиллагааны орлоготой ажиллахаар төсөөлсөн байна.

График 43. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлогын бүтцийн төсөөлөл

Хувь, 2018-2021 оны гүйцэтгэл, 2022-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын бүтцээр авч үзвэл 2021 онд үйл ажиллагааны орлогын 47.4 хувийг хувьцааны арилжааны шимтгэлийн орлого, 22.5 хувийг бүртгэлийн болон гишүүнчлэлийн хураамж, 17.3 хувийг бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны шимтгэлийн орлого, 12.8 хувийг бусад үйл ажиллагааны орлого тус тус бүрдүүлж байсан.

2023-2027 оны дунд хугацааны төсөөллийн дунджаар нийт борлуулалтын орлогын 44.7 хувийг хувьцааны арилжааны шимтгэл, Засгийн газрын үнэт цаасны арилжааны шимтгэл 11.4 хувийг, бүртгэл болон гишүүнчлэлийн хураамж, үйлчилгээний хөлс 19.5 хувийг, бонд болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны шимтгэл 6.9 хувийг, бусад арилжааны шимтгэл 8.5 хувийг, үлдсэн 9.0 хувийг бусад үйл ажиллагааны орлогууд тус тус бүрдүүлэхээр төсөөлсөн байна.

СӨХ
БҮРТГЭВ
№ 01
2022 -12- 17
БҮРТГЭВ-02

2. Үйл ажиллагааны зардлын төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардал 2021 онд 2.2 тэрбум төгрөг байсан бол цаашид жилд дунджаар 112.3 хувийн нийлмэл өсөлт үзүүлж 2027 онд 8.5 тэрбум төгрөгт хүрэхээр төсөөлсөн байна.

График 44. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны зардлын төсөөлөл

Хувь, 2018-2022 оны гүйцэтгэл, 2023-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

Энэ нь Үнэт цаас гаргагчийн тодорхойлсон стратегийн хүрээнд оролцогч талуудын эрх ашиг, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах замаар үйл ажиллагаагаа өргөжүүлж, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, цаашид мэдээллийг ил тод, хүртээмжтэй байдлаар түгээх, олон нийтэд хөрөнгийн зах зээлийг таниулан сурталчлах, системийн шинэчлэл тогтмол хийх, ашигт ажиллагаагаа сайжруулж компанийн тогтвортой өсөлтийг хангахтай холбоотой байна.

2022-2027 онуудын дунджаар нийт үйл ажиллагааны зардлын 34.5 хувийг цалин түүнтэй холбоотой зардал, 18.6 хувийг "Милленниум Ай Ти" MIT системийн ашиглалтын зардал, 20.3 хувийг үйл ажиллагааны бусад зардал, 26.5 хувийг элэгдлийн зардал тус тус бүрдүүлэхээр байна. Эдгээрээс элэгдлийн зардлын хэмжээ их байгаа нь Үнэт цаас гаргагч нь 2022 онд өөрийн эзэмшиж буй биет бус болон үндсэн хөрөнгүүдэд дахин үнэлгээ хийж хөрөнгийн үнэлгээ нэмэгдсэнтэй холбоотойгоор тухайн тайлант жилд харгалзах элэгдлийн зардал өндөр байгуулагдаж буйтай холбоотой байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

2022 -12- 12
БҮРТГЭВ-02

3. Ашигт ажиллагааны үзүүлэлтүүдийн төсөөлөл

График 45. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл

Сая төгрөг, хувь, 2018-2022 оны гүйцэтгэл, 2023-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь 2021 онд 3.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бол 2022 оны жилийн эцсийн байдлаар 284.1 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төсөөлсөн байна. Ийнхүү цэвэр ашиг буурахад 2022 онд үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгүүдийг дахин үнэлсэнтэй холбоотойгоор тайлант хугацаанд элэгдэл, хорогдлын зардал өндөр гарсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна. 2023 оноос цэвэр ашгийн хэмжээ жилд дунджаар 29.5 хувийн жилийн дундаж нийлмэл өсөлтөөр өсөж, 2027 онд 6.4 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна.

Цаашдын таван жилийн дунджаар цэвэр ашгийн ахиуцыг 32.3 хувьтай байхаар төсөөлсөн ба 2021 оны цэвэр ашгийн ахиуцтай харьцуулахад 1.8 дахин бага үзүүлэлт юм.

ХӨРӨНГИЙН
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
УЛААНБААТАР ХОТ

2022 -12- 12

4. Нийт хөрөнгө

График 46. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн бүтцийн төсөөлөл

Сая төгрөг, 2021 он, 2022-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

Үнэт цаас гаргагчийн төсөөллөөр 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгө 25.5 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. 2022 оны эцсээр хувьцаагаа нийтэд нээлттэй санал болсноор хувь нийлүүлсэн хөрөнгө 2023 оны эхээр нэмэгдэнэ гэж төсөөлсөн ба 2023 оноос нийт хөрөнгө жилд дунджаар 5.5 хувиар өсөж, 2027 оны эцэст 48.9 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. Үүнээс эргэлтийн хөрөнгө жилд дунджаар 24.3 хувиар өсөж, 2027 онд нийт хөрөнгийн 34.2 хувийг эзлэх бол эргэлтийн бус хөрөнгө нь нийт хөрөнгийн 65.8 хувийг эзлэх төсөөлөлтэй байна.

График 47. Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгийн бүтцийн төсөөлөл

Сая төгрөг, 2021 он, 2022-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

2023-2027 онуудад Үнэт цаас гаргагчийн нийт эргэлтийн хөрөнгө жилд дунджаар 24.3 хувиар өсөж, 2027 оны эцэст 16.7 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна. Үүнээс мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь жилд дунджаар 18.9 хувиар өсөж нийт хөрөнгийн 16.9 хувийг, богино хугацаат хөрөнгө оруулалт жилд дунджаар 43.3 хувиар өсөж нийт хөрөнгийн 13.8 хувийг бүрдүүлэхээр байна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлого цаашид нэмэгдэж буйтай холбоотойгоор мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө өсөж, үүний зарим хэсгээр богино хугацаат хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн байна. Түүнчлэн, борлуулалтын орлогын өсөлтийг дагаж дансны авлага өсөх хандлагатай байна.

График 48. Үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгийн бүтцийн төсөөлөл

Сая төгрөг, 2021 он, 2022-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь 2022 онд хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэнтэй холбоотойгоор эргэлтийн бус хөрөнгийн дүн оны эцэст өмнөх оны мөн үеэс 800.6 хувиар өсөж, 22.6 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. 2023-2027 онуудын дунджаар нийт эргэлтийн бус хөрөнгийн 34.8 хувийг үндсэн хөрөнгө, 65.2 хувийг биет бус хөрөнгө тус тус бүрдүүлэхээр байна.

5. Эх үүсвэр

График 49. Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн бүтцийн төсөөлөл

Сая төгрөг, 2021 он, 2022-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

СЭХ
2022 оны 12 сар 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2022 -12- 12

Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн төсөөллийг харвал 2022 онд нийт эх үүсвэр нь өмнөх оноос 374.7 хувиар өсөж, 25.5 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. Энэ нь 2022 онд хийлгэсэн эргэлтийн бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлтэй холбоотой. Нийтэд хувьцаагаа арилжаалж, хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдсэний дараа буюу 2023 оноос 2027 он хүртэл эх үүсвэр жилд дунджаар 5.5 хувиар өсөж 48.9 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байна. Үүний 96.5 хувийг эздийн өмч бүрдүүлж байгаа нь урт хугацаанд Үнэт цаас гаргагч нь өрийн дарамт багатай үйл ажиллагаа явуулахаар байгааг илтгэж байна.

График 50. Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн бүтцийн төсөөлөл

Сая ам.доллар, 2021 он, 2022-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

Эздийн өмч нь 2023-2027 онуудад жилд дунджаар 6.0 хувиар өсөж, 47.2 тэрбум төгрөгт хүрэх төлөвлөгөөтэй байгаа ба Үнэт цаас гаргагч нь бизнес төлөвлөгөөний дагуу жил бүр үйл ажиллагаагаа санхүүжүүлэх, 2024 оноос ногдол ашиг тараах төсөөлөлтэй байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл нь 2022 онд өмнөх оноос 18.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба энэхүү өсөлт нь барилга байгууламжийг 4.9 тэрбум, газар эзэмших эрхийг 10.6 тэрбум төгрөг, программ хангамжийг 7.3 тэрбум төгрөгөөр тус тус үнэлсэнтэй холбоотой юм. Харин хувь нийлүүлсэн хөрөнгө нь Үнэт цаас гаргагчийн хувьцаагаа нийтэд санал болгон арилжаалснаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээгээр өсөж байгаа бол жил бүрийн цэвэр ашгийн хэмжээгээр хуримтлагдсан алдагдал нь тогтмол буурах төсөөлөлтэй байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

2022 -12- 12
БҮРТГЭВ-02

6. Харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

Хүснэгт 37. Ашигт ажиллагааны харьцаа

Нэгж, хувь, 2018-2021 он, 2022 оны эхний хагас жил

	2021	2022*	2023*	2024*	2025*	2026*	2027*
Цэвэр ашгийн ахиуц	58.1%	5.7%	23.6%	27.6%	36.6%	35.7%	38.9%
Ерөнхий ба удирдлагын зардал, орлогын харьцаа	0.40	0.94	0.74	0.69	0.55	0.57	0.52
Нийт хөрөнгийн өгөөж	72.2%	2.2%	11.5%	14.0%	23.4%	22.4%	26.2%
Эздийн өмчийн өгөөж	112.3%	2.5%	12.3%	14.8%	24.5%	23.4%	27.2%

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь 2022-2027 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд цаашдын тогтвортой өсөлтийг хангаж, ашигт ажиллагааны түвшнийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн ба цаашдын төсөөллүүдийн дунджаар цэвэр ашгийн ахиуц 28.0 хувьтай, нийт хөрөнгийн өгөөж 16.6 хувьтай байх төсөөлөлтэй байна.

Компанийн зарлага, орлогын харьцаа нь ашигт ажиллагааг илэрхийлэх гол үзүүлэлтүүдийн нэг бөгөөд тайлант хугацаанд нэгж үйл ажиллагааны орлого олоход хэдий хэмжээний зардал гаргаж байгааг илэрхийлдэг. Үнэт цаас гаргагчийн тус үзүүлэлт нь үйл ажиллагаа өргөжүүлэх, нөгөө талаас үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотойгоор тайлант хугацаанд элэгдэл, хорогдлын зардал их байгаагаас 2022 онд 0.94 нэгж , 2023 онд 0.74 нэгж буюу өндөр байх төсөөлөлтэй байна. Ийнхүү 2024 оноос тус үзүүлэлт нь жил тутам буурсаар 2027 онд 0.52 нэгж болж буурах эерэг үзүүлэлттэй байна.

7. Эздийн өмчийн өгөөж ба Ду-Понт шинжилгээ

Хүснэгт 38. Ду-Понт шинжилгээ

Нэгж, хувь, 2021 он, 2022-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

2021 онд Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн өгөөж нь 111.9 хувь байгаа нь тайлант хугацаанд Ковид-19 цар тахлын үед засгийн газраас эдийн засгийг дэмжих бодлого барьсан нь зах зээл дэх зээлийн хүүгийн түвшнийг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн ба энэ нь хөрөнгийн зах зээл идэвхэжсэнээр цэвэр ашиг болон нийт хөрөнгийн эргэц нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

2022-2027 онуудад дунджаар эздийн өмчийн өгөөж 17.4 хувьтай байх төсөөлөлтэй байна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч эздийн өмчийн үржүүлэгч нь 1-тэй дүйцэхүйц байгаа нь санхүүгийн хөшүүрэг харьцангуй багатайгаар үйл ажиллагаа явуулж байгааг илтгэж байна. Ийнхүү цаашдын эздийн өмчийн өгөөжийн өсөлтөд компанийн хөрөнгийн ашиглалт болон ашигт ажиллагаа сайжирч байгаа нь эерэг нөлөөлөл үзүүлэхээр байна.

MONGOLIAN
STOCK EXCHANGE

V

ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

5.1. Нийтэд санал болгох үнэт цаасны тухай

5.2. Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл

5.3. Үнэт цаас гарган татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

5.4. Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг

5.5. Ногдол ашгийн бодлого, төсөөлөл

5.6. Үнэ тогтворжуулах хөтөлбөр

5.7. Анхдагч зах зээлд байршуулах төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ
БҮРТГЭВ
№ 91

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

5. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

5.1. НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

Үнэт цаас гаргагч нь "Компанийн тухай хууль"-ийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 38 дугаар зүйлийн 38.8, 42 дугаар зүйлийн 42.4, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, "Үнэт цаасны зах зээлийн тухайн хууль" -ийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Их хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 336 дугаар тогтоол, "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Дүрмийн холбогдох хэсэг, 2022 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын "Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай" 01 тоот тогтоолын шийдвэрт үндэслэн нийт гаргасан хувьцааны 34 хувьтай тэнцэх 119,157,603 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Хүснэгт 39. Нийтэд санал болгож буй үнэт цаасны тухай

Үнэт цаас гаргагч	"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК
Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
Нийт эргэлтэд гаргасан энгийн хувьцааны тоо ширхэг	231,305,936 ширхэг
Нийтэд санал болгох эзэмшлийн хувь	34%
Анхдагч зах зээлд санал болгох үнэ	100 төгрөг
Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг	119,157,603
Нийтэд санал болгосны дараах хувьцааны тоо ширхэг	350,463,539
Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох нөхцөл	Нэмж гаргах хувьцааны 90 хүртэлх хувь буюу 107,241,842 ширхэг хүртэлх энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох; Нэг стратегийн хөрөнгө оруулагчид нийт эзэмшлийн 5 хүртэл хувь буюу хамгийн ихдээ 17,523,176 ширхэг энгийн хувьцааг санал болгох; Стратегийн хөрөнгө оруулагчид хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд тусгаарлах
Жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад санал болгох нөхцөл	Үлдсэн хэсэг буюу 10 ба түүнээс дээш хувийг хувь тэнцүүлэн хуваарилах нөхцөлөөр
Татан төвлөрүүлэх дүн	11,915,760,300 төгрөг
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Техник технологийн шинэчлэл, сайжруулалт, үйл ажиллагааны цахимжуулалт, сургалт үйлчилгээний төв
Хувьцааг арилжаалах арга	Тогтоосон үнийн арга

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

MONGOLIAN STOCK EXCHANGE

ХӨРӨНГИЙН БИРЖ МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

5.1.1. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 231,305,936 (хоёр зуун гучин нэгэн сая, гурван зуун таван мянга, есөн зуун гучин зургаа) ширхэг энгийн хувьцаатай бөгөөд нэмж 119,157,603 (нэг зуун арван есөн сая, нэг зуун тавин долоон мянга, зургаан зуун гурав) ширхэг энгийн хувьцаа буюу нийтэд санал болгосны дараах нийт хувьцааны 34 хувьтай тэнцэх энгийн хувьцааг нийтэд нээлттэй санал болгон арилжаална. Хувьцаа нэмж гарган нийтэд нээлттэй санал болгон арилжаалсны дараа Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн бүтэц нь доорх байдлаар өөрчлөгдөнө.

Хүснэгт 40. Үнэт цаас гаргагчийн хувь эзэмшлийн бүтэц

	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
Хувьцаа эзэмшигч	**Эзэмшиж буй хувьцааны тоо**	**Эзэмшлийн хувь**	**Нэмж хувьцаа гаргасны дараа**	**Эзэмшлийн хувь**
	Ширхэг	Хувь	Ширхэг	Хувь
Төрийг төлөөлж хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Сангийн яам	231,305,936	100%	231,305,936	66%
Олон нийт	-	-	119,157,603	34%
Нийт	**231,305,936**	**100%**	350,463,539	**100%**

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн үнэлгээний тайлан

5.2. НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий хөндлөнгийн үнэлгээний компани болох "Гэрэгэ Эстимэйт" ХХК (цаашид "Үнэлгээний компани" гэх) нь Үнэт цаас гаргагчийн нэмж хувьцаагаа нийтэд санал болгох үйл ажиллагаатай холбоотойгоор Монголын Хөрөнгийн Биржийн нийт хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолсон ба үр дүнг 2022 оны 12 дугаар сарын 7-ний өдөр хараат бус бизнесийн үнэлгээний тайлангаар хүргүүлсэн.

Үнэлгээний компани нь Үнэлгээний Олон Улсын Стандарт болон "Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль" болон бусад холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу зах зээлийн үнэ цэнийн суурийг сонгож, Үнэт цаас гаргагчийн

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

2022 -12- 12
БҮРТГЭВ-02

бизнесийг зах зээлийн харьцуулалтын, орлогын болон хөрөнгөд суурилсан хандлагын аргуудаар үнэлсэн.

5.2.1. Хөрөнгөд суурилсан үнэлгээ

Хөрөнгөд суурилсан үнэлгээний хандлагын аргаар үнэлгээг хийхдээ тухайн байгууллагын өмчлөл, эзэмшилд буй хөрөнгө нь тухайн хөрөнгийн нөхөгдөх үнэ цэнтэй тэнцүү байна гэсэн суурь зарчимд үндэслэдэг. Хөрөнгөд суурилсан хандлагын аргыг ашиглан бизнесийн үнэлгээг хийхдээ зах зээлийн үнэ цэнд суурилсан нийт хөрөнгө болон нийт өр төлбөрийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох замаар тохируулсан цэвэр хөрөнгийг тооцоолдог болно.

Уг үнэлгээний аргын хүрээнд Үнэлгээний компанийн тайланг үндэслэвэл Үнэт цаас гаргагчийн цэвэр хөрөнгө нь үнэлгээний өдрийн байдлаар 23.7 тэрбум төгрөг байна.

Хөрөнгөд суурилсан үнэлгээний хандлагын аргаар тодорхойлсон үнэлгээ нь тухайн бизнесийн орлого олох чадварыг харгалзан үздэггүй тул тасралтгүй байх төсөөллөөр бизнесийн үнэлгээ хийж байгаа тохиолдолд энэхүү аргыг бизнесийн үнэлгээнд ашиглахад тохиромжгүй гэж Үнэлгээний компани үзсэн.

5.2.2. Зах зээлийн харьцуулалтын аргын үнэлгээ

Зах зээлийн харьцуулалтын арга нь үнэ цэний үзүүлэлтийг гаргахын тулд үнэлж буй компанитай ижил буюу төсөөтэй, жишиг компанийн талаарх мэдээллийг ашигладаг. Энэхүү аргыг зөвхөн үнэлж буй компани нь харьцуулагдах жишиг компаниудтай хангалттай адил төстэй байх тохиолдолд ач холбогдол бүхий харьцуулалт хийх зорилгоор ашиглана.

Үнэлгээний компани нь бусад улс орнуудын хөрөнгийн биржүүд дээр хийсэн судалгааны үндсэн дээр харьцуулах биржүүдэд Болгарын Хөрөнгийн Бирж, Дубайн Санхүүгийн Зах, Наиробын Үнэт Цаасны Бирж, Нигерийн Хөрөнгийн Бирж болон Пакистаны Хөрөнгийн Биржийг авч үзсэн. Харьцуулсан биржүүдийн Үнэ/Цэвэр ашгийн дундаж харьцаа (Р/Е) нь 18.1, Үнэ/Цэвэр эздийн өмчийн дундаж харьцаа (Р/В) нь 1.5 байхаар гарч байна. Эдгээр үзүүлэлтүүдийг ашиглан Үнэт цаас гаргагчийн үнэ цэнийг баримжаалан тооцоолоход Р/Е харьцаагаар 38.2 тэрбум төгрөг, шинэ мөнгө орж ирэхээс өмнөх Р/В харьцаагаар 35.6 тэрбум төгрөг байх үр дүн гарч байна.

СЗХ
2022 .12сар 4 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

5.2.3. Орлогын хандлагын аргын үнэлгээ

Орлогын хандлагын аргаар бизнесийн үнэ цэнийг тодорхойлоход ирээдүйд орж ирэх мөнгөн урсгал, ашигт ажиллагаанд үндэслэн ирээдүйд олох орлогын өнөөгийн үнэ цэнийн нийлбэрийг тооцдог.

Үнэлгээний компани нь Орлогын хандлагын Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга, тодруулбал Эздийн өмчийн чөлөөт мөнгөн урсгал (Free Cash Flow to Firm)-ын загварыг ашиглан тооцоолсон. Үнэлгээний компани нь тус хандлагаар бизнесийн үнэ цэнийг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 36,753,598,659 (гучин зургаан тэрбум, долоон зуун тавин гурван сая, таван зуун ерэн найман мянга, зургаан зуун тавин ес) төгрөг байхаар тооцоолсон байна.

5.2.4. Үнэлгээний үр дүн

Үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлог, бизнесийн өнөөгийн нөхцөл байдал, үнэлгээний ажлын зорилготой уялдуулан үнэлгээний эцсийн үр дүнг орлогын хандлагаар хийж гүйцэтгэсэн үр дүнгээр дүгнэсэн болно.

Хүснэгт 41. Бизнесийн үнэлгээний үр дүн

Үнэлгээний хандлага	Үнэлгээний арга	Бизнесийн үнэ цэн, сая төгрөгөөр
Зах зээлийн харьцуулалтын хандлага	Үржүүлэгчийн арга	35,507.7-38,176.7
Орлогын хандлага	Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга	36,753.6
Хөрөнгөд суурилсан хандлага	Цэвэр хөрөнгийн үнэлгээний арга	23,686.0
Эцсийн үнэлгээ		36,753.6

Эх сурвалж: "Гэрэгэ Эстимэйт"-ийн Үнэлгээний тайлан

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 231,305,936 (хоёр зуун гучин нэгэн сая, гурван зуун таван мянга, есөн зуун гучин зургаа)ширхэг энгийн хувьцаатай байгаа бөгөөд нийтэд санал болгон арилжаалах 119,157,603 (нэг зуун арван есөн сая, нэг зуун тавин долоон мянга, зургаан зуун гурав) ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаснаар нийт 350,463,539 (гурван зуун тавин сая, дөрвөн зуун жаран гурван мянга, таван зуун гучин ес) ширхэг энгийн хувьцаатай болно.

Үнэлгээний компаниас тооцоолсон бизнес үнэлгээний үр дүнгээр нэгж энгийн хувьцааны зах зээлийн үнэ цэн 104.87 (нэг зуун дөрөв зууны наян долоо) төгрөг байхаар тогтоогдсон байх ба Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 оны 12 сар 14 өдөр
БҮРТГЭВ
№ 51

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

сарын 7-ны өдрийн хурлын 37 тоот тогтоолоор нэгж хувьцааны үнийг 100.0 (нэг зуу) төгрөгөөр нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

5.3. ҮНЭТ ЦААС ГАРГАН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь нийтэд нэгж бүрийн 100.0 (нэг зуу) төгрөгийн үнэтэй 119,157,603 (нэг зуун арван есөн сая, нэг зуун тавин долоон мянга, зургаан зуун гурав) ширхэг энгийн хувьцаа санал болгох замаар нийт 11,915,760,300 (арван нэгэн тэрбум, есөн зуун арван таван сая, долоон зуун жаран мянга, гурван зуу) төгрөгийг татан төвлөрүүлнэ.

Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт 42. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

№	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	
1	Арилжааны системийн сайжруулалт	63.7%
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	10.7%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	6.1%
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	19.5%
	Нийт	**100.0%**

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг дээрх байдлаар, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, найдвартай тасралтгүй ажиллагааг хангаж, үр ашгийг нэмэгдүүлэх байдлаар зарцуулахаар Үнэт цаас гаргагч төлөвлөсөн байна. Арилжааны системийн сайжруулалтын хүрээнд одоо ашиглаж буй арилжааны системийн шинэчлэл, түүхий эдийн болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны модуль, анхдагч зах зээлийн системийн шинэчлэл болон сайжруулалт хийж, шинэ бүтээгдэхүүн арилжаалах боломжийг нэмэгдүүлж, мөн одоо арилжаалж буй бүтээгдэхүүний арилжааны хурд, найдвартай байдлыг нэмэгдүүлэхээр төсөөлсөн байна. Мэдээлэл технологийн системийн аюулгүй байдалд сервер, сүлжээ, нөөц мэдээллийн сангийн хөрөнгө оруулалт зэрэг хөрөнгө оруулалтууд төлөвлөгдсөн бол үйл ажиллагааны цахимжуулалтын хүрээнд нэгтгэлийн систем, арилжааны тайлангийн систем болон бүртгэлтэй хувьцаат компаниудын тайлагналын систем болон үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор цахимжуулах ажлууд хийхээр төлөвлөгдсөн байна. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад заасны дагуу зарцуулах бөгөөд өөр байдлаар зарцуулахгүй болно. Олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж, Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлснээр бий болох бизнесийн өсөлт, үр өгөөжийг Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө (Бүлэг

MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2022 -12- 14 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2022 -12- 12 БҮРТГЭВ-02

4), Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны санхүүгийн төсөөлөл (Бүлэг 4) хэсэгтэй танилцаж дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

5.4. ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

5.4.1. Хувьцаа эзэмшигчийн эрх

- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах үед хууль тогтоомжид заасан шаардлагатай баримт бичигтэй танилцах, мэдээлэл авах бололцоогоор хангагдах;
- ✓ ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн бол эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах;
- ✓ Үнэт цаас гаргагчийг татан буулгах үед "Компанийн тухай хууль"-ийн 28 дугаар зүйлд заасны дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- ✓ "Компанийн тухай хууль"-ийн 38 дугаар зүйл болон Үнэт цаас гаргагчийн Дүрэмд заасны дагуу Үнэт цаас гаргагчаас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах;
- ✓ Үнэт цаас гаргагчийн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Үнэт цаас гаргагчийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэлтэй танилцах;
- ✓ Хууль тогтоомж болон Үнэт цаас гаргагчийн Дүрмээр тогтоосон бусад эрх;

5.4.2. Хувьцаа эзэмшигчийн үүрэг

- ✓ Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа үнэт цаасны тоог Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх;
- ✓ Хувьцаа эзэмшигч нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр эрсдэл, хариуцлага хүлээх;
- ✓ Хувьцаа эзэмшигч нь Үнэт цаас гаргагчийн эд хөрөнгө, ажил хэргийн нэр хүндэд гэм хор, хор уршиг, хохирол учруулж болзошгүй аливаа үйлдэл хийхгүй байх;
- ✓ Нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшсэн бол өмчлөх эрх үүссэнээс ажлын 3 хоногийн дотор компанид бичгээр мэдэгдэх;
- ✓ Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК 9020020698 2011096 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 9111927123 УЛААНБААТАР ХОТ

5.5. НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО, ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагч нь хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах, ногдол ашиг олгох нөхцөл, журам, ногдол ашиг хуваарилах асуудлыг Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, түүнийг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 29 дүгээр тогтоолын дагуу "Монголын Хөрөнгийн Бирж" төрийн өмчит хувьцаат компанийн "ногдол ашгийн бодлого" баримт бичгийг батлан гаргасан.

Ногдол ашгийн бодлогод заасны дагуу Үнэт цаас гаргагч нь энгийн хувьцаанд ногдох ногдол ашгийг дор дурдсан нөхцөлүүдэд олгохоор тогтоосон байна. Үүнд:

- ✓ Тухайн санхүүгийн жилд Үнэт цаас гаргагч нь ашигтай ажилласан байх;
- ✓ Ногдол ашиг төлсний дараа Үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадвартай байх;
- ✓ Ногдол ашиг төлсний дараа Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь "Компанийн тухай хууль"-ийн 30.5 дахь хэсэгт заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;
- ✓ Үнэт цаас гаргагч нь эргүүлэн худалдаж авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх;

Үнэт цаас гаргагчийн жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан дахь цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтад зарцуулах дүнг хасаад үлдэх хэсгээс ногдол ашиг хуваарилах тухай заасан байна.Үнэт цаас гаргагчийн Ногдол ашгийн бодлогод заасны дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 (тавь) хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэнэ. ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилах шийдвэрийг гаргасан тохиолдолд тус шийдвэрт нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг төлөх хугацаа, ногдол ашиг төлөх хэлбэр, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдөр болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байхаар зохицуулсан байна. Үнэт цаас гаргагч нь ногдол ашгийг бэлэн мөнгө болон хууль тогтоомжид заасан бусад хэлбэрээр хуваарилж болохоор зохицуулсан.

Үнэт цаас гаргагч нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд тус шийдвэрийн талаар нийтэд мэдээлнэ. Үнэт цаас гаргагч нь ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт заасан хугацааны дотор ногдол ашгийг хуваарилж олгоно. Хэрэв ногдол ашгийг хугацаанд нь олгоогүй тохиолдолд хугацаа хожимдуулсан хоног

СЭХ БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 -12- 12 БИРЖИЙН ГИШҮҮН

тутамд төлбөл зохих үнийн дүнгийн тодорхой хувиар алданги хувьцаа эзэмшигчид төлөхөөр зохицуулсан байна.

5.6. ҮНЭ ТОГТВОРЖУУЛАХ ХӨТӨЛБӨР

Үндсэн андеррайтер "Инвескор Капитал ҮЦК" ХХК нь туслах андеррайтеруудын хамт Үнэт цаас гаргагчийн гаргасан хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн хэт өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 6 (зургаа) сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг хоёрдогч зах зээлийн арилжаанаас худалдаж авах буюу хувьцааны үнийг тогтворжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсан. Энэхүү үйл ажиллагааг дараах нөхцөлтэйгөөр явуулах бөгөөд хөтөлбөрийг Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 8 дугаар зүйлд заасан зохицуулалтуудад нийцүүлэн хэрэгжүүлнэ.

Хүснэгт 43. Үнэт цаас гаргагчийн хувьцаанд үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл

№	Нөхцөл	Хязгаарлалт
1	Үнэ тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх үнийн дүн	200,000,000 (хоёр зуун сая) хүртэлх төгрөгийн үнийн дүнгээр хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
2	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа	Хөтөлбөрийн үйл ажиллагааг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 6 (зургаа) сарын хугацаанд гүйцэтгэнэ.
3	Үнэ тогтворжуулах нөхцөл	Нэгж хувьцааны үнэ анх гаргасан үнээс 15 (арван тав) хувь болон түүнээс дээш хэмжээнд буурсан үед үнэ тогтворжуулах нөхцөл үүссэн гэж үзнэ.

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

Хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх зардал нь Үнэт цаас гаргагчийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөс суутгагдахгүй бөгөөд Хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөр нэрийн дор "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 80 дугаар зүйлд заасан хэлбэрээр зах зээлийг урвуулан ашиглахгүй, хууль тогтоомжийн дагуу ажиллагааг явуулах бөгөөд түүнийгээ батлан талууд холбогдох баримт бичгүүдээр энэ тухай баталгаажуулсан болно.

Түүнчлэн Андеррайтер, зах зээл үүсгэгч нь Үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагаа дууссан өдрөөс хойш тогтворжуулалтын чиглэлээр хийсэн гүйлгээний тайланг ажлын 3 (гурав) өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК MONGOLIAN STOCK EXCHANGE 9020020699 2071096 УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL 6317839 1119277128 УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

5.7. АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журамд заасны дагуу зохион байгуулагдана.

Үнэт цаас гаргагчийн 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн ТУЗ-ийн 37 тоот тогтоолын дагуу нийтэд санал болгох хувьцааны нэгжийн үнийг 100.0 (нэг зуу) төгрөгөөр тогтоосон бөгөөд Арилжаа эрхлэх байгууллага буюу Монголын Хөрөнгийн Биржийн анхдагч зах зээлийн арилжааны "ТОГТООСОН ҮНИЙН АРГА"-ыг ашиглан нийтэд нээлттэй арилжаална.

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгож буй 119,157,603 (нэг зуун арван есөн сая, нэг зуун тавин долоон мянга, зургаан зуун гурав) ширхэг энгийн хувьцааг олон нийтэд танилцуулах үйл ажиллагааг Арилжаа эрхлэх байгууллага болон Санхүүгийн Зохицуулах Хороо үнэт цаасыг бүртгэсэн өдрөөс хойш ажлын 10 (арав) өдрийн дотор, анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 (арав) өдрийн дотор хүлээн авна.

Схем 14. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө



Эх үүсвэр: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

5.7.1. Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгүүлэх хүсэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Арилжаа эрхлэх байгууллага (энэ тохиолдолд

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ 03

Монголын Хөрөнгийн Бирж)-д нэгэн зэрэг гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

5.7.2. Үнэт цаасыг нийтэд танилцуулах аян

Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, арилжаалах зөвшөөрөл гарсны дараа үнэт цаасыг нийтэд санал болгон танилцуулах аяныг зохион байгуулна. Үүнд хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч, олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга уулзалт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэт цаасыг танилцуулах мэдээ мэдээлэл зэрэг нь багтана.

5.7.3. Анхдагч зах зээлийн арилжааны захиалга хүлээн авах

Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлэх хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын 3 (гурав)-аас доошгүй өдрийн өмнө Санхүүгийн Зохицуулах Хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэж, анхдагч зах зээлийн захиалгыг эхлүүлнэ. Стратегийн хөрөнгө оруулагчдаас анхдагч зах зээлийн захиалгыг Үнэт цаас гаргагчийн андеррайтерууд, олон нийтээс анхдагч зах зээлийн захиалгыг Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан тус тус авна.

5.7.4. Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт хийх

Үнэт цаасны анхдагч зах зээлийн хуваарилалт хийх үйл ажиллагааг Андеррайтер нь Үнэт цаас гаргагчтай зөвшилцөн, Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам, Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын дагуу гүйцэтгэнэ. Үнэт цаас гаргагч нь нийтэд тогтоосон үнийн аргаар үнэт цаасыг санал болгоно.

- ✓ Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны анхдагч арилжааны журам"-ын 3.3 дахь заалтыг үндэслэн, жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын 500 ширхэг хүртэлх хувьцааны захиалга бүрэн биелнэ.
- ✓ Хөрөнгө оруулагчдаас хүлээн авсан хувьцааны нийт захиалгын тоо нь нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны тооноос илүү байх тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглан хуваарилалт хийх бөгөөд Стратегийн хөрөнгө оруулагчдын худалдан авахаар өгсөн захиалгыг хувь тэнцүүлэх хуваарилалтад оруулахгүй болно.
- ✓ Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь зөвшилцөж нийтэд хуваарилах үнэт цаасны худалдан авах захиалгын бүрэн биелэх нөхцөл бүхий хэмжээг тогтоож болох бөгөөд энэ талаар Арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга эхлэхээс өмнө Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

- ✓ Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалтын төлөвлөгөөг арилжааны захиалга эхлэхээс өмнө Арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

Андеррайтер нь анхдагч зах зээлийн арилжаа явагдаж дууссанаас хойш ажлын 3 (гурав) өдөрт багтаан арилжааны тайланг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлнэ. Санхүүгийн Зохицуулах Хороо нь уг тайланг хүлээн авч анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсан, аливаа зөрчил гараагүй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг тус тус олгох тухай албан бичгийг ажлын 3 (гурав) өдөрт багтаан хүргүүлнэ.

5.7.5. Хязгаарлалт

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 56.6 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 520 дугаартай "Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих журам"-ын холбогдох зохицуулалтад заасан улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамаарал бүхий этгээд арилжаа эрхлэх байгууллагаар арилжаалагдах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг эзэмшихийг хориглоно.

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 56.5 дахь хэсэгт заасны дагуу аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт нээлттэй хувьцаат компани болсон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 4.1.29 дэх заалтад заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно. "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 4.1.29 дэх заалт: *"Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэж тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны 5 (тав) болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг"* хэлнэ.

5.7.6. Тогтоосон үнээр санал болгох арилжааны арга

Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 10 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон үнээр санал болгон арилжих арга гэдэгт Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үнийг тодорхойлж, хөрөнгө оруулагч нь үнэт цаас худалдан авах захиалгыг зөвхөн тогтоосон үнээр өгөх бөгөөд энэ аргыг ашиглах үед үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

5.7.7. Стратегийн хөрөнгө оруулагч

Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.4 дэх хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, үнэт цаасыг 6 (зургаа)-аас доошгүй сарын хугацаанд тусгаарлуулах үүрэгтэй хөрөнгө оруулагчийг стратегийн хөрөнгө оруулагчид тооцдог. Үнэт цаас гаргагч нь дараах хөрөнгө оруулагчдыг стратегийн хөрөнгө оруулагч гэж үзнэ. Үүнд:

- ✓ Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6-аас доошгүй сарын хугацаанд хувьцааг тусгаарлуулах;
- ✓ 100,000,000 (нэг зуун сая) төгрөг ба түүнээс дээш үнийн дүнгээр хувьцаа худалдан авах захиалга өгсөн хөрөнгө оруулагч.

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгож буй хувьцааны 90 (ер) хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилна.

5.7.8. Үнэт цаасны анхдагч арилжаанд оролцох заавар

Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Үнэт цаасыг худалдан авахаар төлөвлөж буй хөрөнгө оруулагч нь хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд дор дурдсан зааврын дагуу оролцоно.

Схем 15. Үнэт цаасны арилжаанд оролцох заавар



Эх үүсвэр: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

5.7.9. Мөнгөн хөрөнгө байршуулах

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд оролцож хувьцаа худалдан авах хөрөнгө оруулагч нь өөрийн үйлчлүүлж буй Үнэт цаасны компаниас өгсөн зааварчилгааны дагуу мөнгөн хөрөнгийг өөрийн дансанд байршуулна.

5.7.10. Арилжааны шимтгэл

Хөрөнгө оруулагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгон үйлчлүүлж буй Үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын болон Үнэт цаасны компанийн шимтгэлийн нийт дүн багтсан байна.

Хөрөнгө оруулагчаас суутгах Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй байдгийг анхаарна уу.

5.7.11. Захиалгын төлбөрийг буцаан олгох

Үнэт цаасны худалдан авах захиалгын хэмжээ нийлүүлэлтийн хэмжээнээс давсантай холбоотойгоор хувь тэнцүүлэн хуваарилалт хийгдсэн тохиолдолд Үнэт цаас худалдан авч буй хөрөнгө оруулагч нь биелэгдээгүй захиалгын үнийн дүнг өөрийн үнэт цаасны дансаа нээлгэсэн Үнэт цаасны компаниар дамжуулан буцаан авах эрхтэй. Биелэгдээгүй захиалгын үнийн дүнг буцаан авахтай холбоотой тухайн Үнэт цаасны компанийн тогтоосон шимтгэл хураамж төлөх шаардлагатай болж болзошгүйг анхаарна уу.

5.7.12. Албан татвар

Үнэт цаас худалдан авч буй хөрөнгө оруулагч нь Монгол Улсад оршин суугч хувь хүн байх тохиолдолд "Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"-ийн 16.1.3 дэх заалтад заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 17.1.3 дэх заалтад заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 21.5 дахь хэсэгт заасан 5 (тав) хувийн хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаас худалдан авч буй хөрөнгө оруулагч нь Монгол Улсад байрладаг хуулийн этгээд буюу "Аж ахуйн нэгж байх тохиолдолд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль"-ийн 18.6.2 дэх заалтад заасан (ногдол ашгийн орлого) нийт дүнгээс, 18.3 дахь хэсэгт заасан (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого) худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 20.2.1 болон 20.2.5 дахь заалтуудын нөхцөлүүдэд заасан хувь хэмжээгээр татвар төлнө.

Гадаад улсын иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх үүрэг хүлээх бөгөөд өөрийн харьяалах улс нь Монгол Улстай давхар татварын гэрээ байгуулсан эсэх болон хэрэв давхар татварын гэрээтэй байх тохиолдолд тухайн гэрээний агуулга нөхцөлүүдийг сайтар судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ

5.7.13. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаас гаргагчийн хувьцааг нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрлөөр Арилжаа эрхлэх байгууллага буюу Монголын Хөрөнгийн Биржийн журамд заасан зохицуулалтын дагуу үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр анхдагч зах зээлийн арилжаанаас хувьцаа худалдан авсан хөрөнгө оруулагчид өөрийн эзэмшилд буй хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээгдэнэ. Хэрэв хөрөнгө оруулагч нь хувьцааг тусгаарлуулах нөхцөлтэйгөөр худалдан авсан бол хувьцаа тусгаарлуулах хугацаа дуусгавар болсны дараа хувьцаагаа худалдах эрх нь нээгдэхийг анхаарна уу.

5.7.14. Валют

Үнэт цаасны арилжаа нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр хийгдэнэ.

5.7.15. Бүхэлчлэх

Зарим мөнгөн дүн болон хувийг тоймлон оруулсан тул зарим хүснэгтэд бүхэл утгаар илэрхийлсэн тоон дүнгүүд нь арифметик бүхэлчлэх аргыг ашигласан дүн болно.

5.7.16. Хэл

Энэхүү танилцуулгыг Монгол хэлээр үйлдсэн бөгөөд гадаад хэл рүү орчуулсан орчуулга нь Монгол хувилбараас утга, агуулга, ямар нэгэн байдлаар зөрсөн тохиолдолд энэхүү Монгол эх хувилбарыг давуу хүчинтэйд тооцно. Танилцуулгад олон улсад тогтсон жишиг, практикийн дагуу нэр томьёоны тайлбарт туссан зарим Англи нэр томьёолол ашиглана.

ХӨРӨНГИЙН БИРЖ
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



MONGOLIAN
STOCK EXCHANGE

VI

ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

6. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

Энэхүү бүлгийн хүрээнд Үнэт цаасыг худалдан авч эзэмшихээр төлөвлөж буй хөрөнгө оруулагчдад Үнэт цаасыг худалдан авч эзэмшихтэй нь холбогдуулан үүсэж болох эрсдэлийн хүчин зүйлүүдийг тусгав. Хөрөнгө оруулагч нь Үнэт цаас худалдан авч эзэмшихийн өмнө энэ бүлэгт тусгагдсан эрсдэлийн хүчин зүйлүүдтэй танилцсан байвал зохилтой. Тус эрсдэлийн хүчин зүйлүүд нь Үнэт цаас эзэмшиж, хөрөнгө оруулалт хийхтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчдад тулгарч болох бүх эрсдэлийн хүчин зүйлүүд дурдаагүй байж болох бөгөөд агуулгын хувьд тэдгээрт хамааралтай тал бүрийн, бүрэн хэмжээний тайлбар биш байж болно. Андеррайтерууд болон Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас эзэмших хөрөнгө оруулагчийг Үнэт цаас худалдан авахын өмнөх шийдвэрээ гаргахад нь болзошгүй эрсдэлийн хүчин зүйлсийн талаар зөвхөн зөвлөмж хэлбэрээр сануулах, мэдээлэл хүргэх байдлаар тусгасан болохыг анхаарна уу.

Үнэт цаас гаргагчийг Үнэт цаасаа санал болгон гаргасны дараа урьдчилан таамаглагдаагүй эрсдэлийн хүчин зүйлүүд үүсэж болзошгүй бөгөөд тэдгээр нь энэхүү Үнэт цаасны танилцуулга бэлтгэгдэх үеийн байдлаар бодитоор мэдэгдээгүй, эсхүл чухал ач холбогдолгүй хэмээн тооцогдсон байж болзошгүй бөгөөд тэдгээр хүчин зүйлүүд нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үр дүн, ирээдүй, хэтийн төлөв, санхүүгийн байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болохыг үгүйсгэхгүй юм. Энэ бүлэгт тусгагдсан, эсхүл урьдчилан таамаглагдаагүй эрсдэл үүсэх, бий болох тохиолдолд хувьцааны үнэ буурч, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа бүхэлд нь эсхүл зарим хэсгийг алдаж болзошгүйг үгүйсгэхгүй бөгөөд Андеррайтерууд болон Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн хүчин зүйлсийг үүсгэхгүй байх талаар аливаа баталгааг гаргаагүй болно. Хөрөнгө оруулагчид энэхүү Үнэт цаасны танилцуулгад агуулагдсан мэдээлэл, бусад шаардлагатай баримт материал болон өөрийн санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан Үнэт цаасанд хөрөнгө оруулах эсэх шийдвэрээ сайтар судалж гаргах нь зүйтэй гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

6.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ЭРСДЭЛ

Улс орны эдийн засгийн төлөв байдал нь санхүүгийн зах зээлтэй нягт хамааралтай, нөлөө бүхий хүчин зүйлд тооцогддог. Монгол Улс нь гадаад эдийн засгийн орчин, түүхий эдийн бүтээгдэхүүний үнээс хамаарсан мөчлөгийн савлагаа өндөртэй эдийн засагтай оронд тооцогддог. Макро эдийн засгийн гэнэтийн хүчин зүйлүүд болох шок, валютын ханш, инфляцын түвшин, ажилгүйдэл, геополитиктой холбоотой хүчин зүйлүүдийн нөлөө нь бизнесийн ашигт ажиллагаа, иргэдийн худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөх боломжтой. Үүнийг дагаад хөрөнгийн зах зээлийн идэвхжил суларч, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд шууд болон шууд

ХӨРӨНГИЙН БИРЖ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

бусаар нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Эдийн засагт томоохон нөлөө бүхий эрсдэлийн хүчин зүйлүүдийг дурдвал:

- ✓ Валютын ханшийн тогтворгүй байдал;
- ✓ Инфляц;
- ✓ Ажилгүйдлийн түвшин;
- ✓ Түүхий эдийн үнийн хэлбэлзэл, эрэлт, нийлүүлэлт;
- ✓ Төсөв, мөнгөний бодлого;
- ✓ Хил гаалийн хорио, хязгаарлалт зэрэг хүчин зүйлс байна.

Дээр дурдсан эдийн засгийн нөлөө бүхий эрсдэлийн хүчин зүйлүүдээс үүдэн бий болох боломжтой сөрөг нөлөөллийг боломжит хэмжээгээр бууруулахын тулд Үнэт цаас гаргагч нь дотоод болон гадаад макро эдийн засгийн өөрчлөлт, төлөв байдал, санхүүгийн зах зээлийн чиг хандлагыг тогтмол ажиглах, судалгаа шинжилгээ хийх, эрсдэлийн удирдлагын бодлого, стратегиа эрсдэлийн хүчин зүйлүүдийн үнэлгээнд үндэслэн шинэчлэн боловсруулж дагаж мөрдөх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ төрөлжүүлэн нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх арга хэлбэрээ боловсронгуй болгох зэрэг бодлогыг барьж энэ төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

6.2. ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагчид тулгарч болох зах зээлийн эрсдэлийн хүчин зүйлст зээлийн хүүгийн эрсдэл, эрэлт нийлүүлэлтээс хамаарах үнэт цааснуудын ханшийн эрсдэл, валютын эрсдэл зэрэг зах зээлд үүсэж болох сөрөг нөлөөллийн хүчин зүйлүүдийн улмаас эрсдэл хүлээх ойлголтыг хамруулна.

Түүнчлэн, Үнэт цаас гаргагч дээрх бүртгэлтэй компаниудын зах зээлийн үнэлгээ болон хоёрдогч зах зээлийн арилжааны эрэлтэд нөлөөлж болох Үнэт цаас гаргагчаас хамааралгүй зах зээлийн олон хүчин зүйлүүд нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлөх боломжтой. Зах зээлийн эрсдэлийн хүчин зүйлүүдэд дор дурдсан асуудлуудыг хамруулан авч үзэх боломжтой юм. Үүнд:

- ✓ Томоохон санхүүгийн байгууллагуудын хөрөнгө оруулалтын бодлого, стратегийн чиг хандлага;

ХӨРӨНГИЙН
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022 оны 12 сарын 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-03

- ✓ Үнэт цаасны зах зээл дэх санхүүгийн хэрэгслүүд, биржээс гадуурх бүтээгдэхүүн болон хөрөнгийн зах зээлийн бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт, нийлүүлэлтийн өөрчлөлтийн нөлөөлөл;

- ✓ Үнэт цаас гаргагч, түүний гишүүн компаниудын зах зээлд арилжаа хийх, оролцогчдын нэвтрэх эрх, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалтын менежментэд шууд болон шууд бусаар хязгаарлалт тавих (эсвэл үүнтэй холбоотой зардлыг нэмэгдүүлэх) хууль тогтоомж, зохицуулалтын өөрчлөлтүүд;

- ✓ Эдийн засгийн хориг арга хэмжээ, эдийн засгийн бусад хязгаарлалтаас үүдэн зах зээлд нөлөө үзүүлэх.

Үнэт цаас гаргагч нь дээрх эрсдэлийн хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг батлан, үйл ажиллагаандаа дагаж мөрдөж буй бөгөөд тус бодлогын баримт бичигт заасны дагуу зах зээлийн таагүй нөхцөл байдлын улмаас үүсэж болох эрсдэлийг хамгийн бага түвшинд тогтоох, эрсдэлийг удирдах, тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

6.3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагчийн мэдээллийн технологийн эрсдэлд Үнэт цаас гаргагчийн техник тоног төхөөрөмж болон программ хангамжийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдах зэрэг эрсдэлүүд хамаарч байна.

Арилжааны үйл ажиллагааг хэвийн явуулах, төлбөр тооцоо, арилжааны мэдээллүүдийг цуглуулах, нэгтгэхтэй холбогдсон процедур ажиллагаанууд нь өндөр хүчин чадал бүхий дэд бүтэц, техник, технологиос ихээхэн хамааралтай байдаг. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээл нь бүтээгдэхүүн, үйлчилгээг илүү боловсронгуй болгох, сайжруулах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлж, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан зах зээлийн хурдацтай хөгжил, цаг ямагт хувьсан өөрчлөгдөж буй техник технологийн өөрчлөлтийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, сайжруулалт хийхийг шаарддаг зах зээл юм.

Үнэт цаас гаргагчийн ашиглаж буй техник технологи, мэдээллийн систем, дэд бүтцүүдэд томоохон хэмжээний эсхүл олон удаагийн доголдол үүссэн тохиолдолд энэ нь Үнэт цаас гаргагчийн арилжаа, төлбөр тооцоо, мэдээллийн үйлчилгээний үйл ажиллагааг тасалдуулж, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй платформ, үйлчилгээнд итгэх харилцагчдын итгэлийг алдагдуулж, нэр хүнд, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТЭХК
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Түүнчлэн, Үнэт цаас гаргагчийн дэд бүтэц, системийн шинэчлэл, сайжруулалт хийхтэй холбоотой хэрэгжих төсөл, хөтөлбөрүүд нь гадаад болон дотоод нөлөө бүхий хүчин зүйлүүдээс шалтгаалан төлөвлөгдсөн цаг хугацаа, төсөв төлөвлөгөөний дагуу хэрэгжихгүй байх эрсдэл үүсэж болзошгүй юм.

Шинээр нэвтрүүлсэн, сайжруулалт хийгдсэн систем, дэд бүтэц, платформууд нь зориулалтын дагуу ажиллахгүй эсхүл арилжааны хэмжээг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардлыг бууруулах зэрэг хүлээгдэж буй үр дүнд хүрэхгүй байж болно.

Үнэт цаас гаргагчийн мэдээллийн технологийн систем, сүлжээ, дэд бүтэц болон бусад гуравдагч этгээд, хамтын түншлэлийн байгууллагууд, үйлчилгээ үзүүлэгчдийн систем, платформ нь цахим халдлагад өртөх, аюулгүй байдалд нь нөлөө үзүүлэх тохиолдлууд гарч болзошгүй юм. Тус үйл явдлууд нь Үнэт цаас гаргагчийн мэдээллийн технологийн доголдолгүй, аюулгүй байдал, хүртээмжид сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Үнэт цаас гаргагч нь энэ төрлийн эрсдэлийг бууруулахын тулд ISO/IEC17799:2005, ISO27001:2013, ISO/IEC38500:2015 стандартуудын дагуу боловсруулагдсан "Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн мэдээллийн технологийн цогц журам"-ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж, хяналт тавин ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь мэдээлэл, технологийн цогц дэд бүтцийг бүрэн бүрдүүлснээс гадна мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангахад ихээхэн анхаарч ажилладаг. Тухайлбал, Монголын Хөрөнгийн Бирж нь олон улсын стандартын дагуу мэдээлэл технологийн үндсэн болон нөөц төвтэй бөгөөд цахилгааны тасалдлын үед ажиллах нөөц цахилгаан генератортай, мэдээллийн нууцлалын баталгааг олон улсын стандартын дагуу хангаж ажилладаг.

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй Миллениум Ай Ти систем нь ISO 9001:2008 олон улсын чанарын стандартад нийцсэн бөгөөд системийн тусламж үйлчилгээг "Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп"-ийн охин компани болох "Миллениум Ай Ти" компани гүйцэтгэдэг. Гэрээний нөхцөлд тус системийн тасралтгүй ажиллагааны доод хязгаарыг 99.6 хувиар тогтоосон байдаг.

Технологийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахад Мэдээллийн Технологийн Алба томоохон үүрэг гүйцэтгэдэг ба техник хангамж, виртуалчлал, дотоод систем, веб технологи, сүлжээ, тусгай зориулалтын программ хангамж, нөөцлөлт, аюулгүй байдал, өгөгдлийн санг тус тус хариуцсан мэргэжилтнүүд ажиллуулдаг байна.

СЭХ
2022 он 12 сар 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

6.4. МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭРСДЭЛ

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлд аливаа мэдээ, мэдээлэл, нууц баримт материал, зэрэг нууцын зэрэглэлтэй мэдээлэл алдагдах, мэдээллийн санд хөндлөнгөөс халдах зэргээс үүдэн аливаа мэдээ мэдээлэл алдагдсанаар дата өгөгдлийн сан устгагдах, харилцагчийн мэдээлэл задрах зэрэг эрсдэлүүд хамаарна. Арилжаа эрхлэх байгууллагуудын хувьд мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалт, эрсдэл хамгийн өндөрт тооцогдох ба байнгын технологийн шинэчлэл хийх, мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах цогц хяналтын тогтолцоо, системийн хамгаалалтууд шаардагддаг.

Үнэт цаас гаргагч нь "Мэдээллийн технологийн цогц журам"-ын дагуу мэдээллийн аюулгүй байдлыг хангахад анхаарч ажилладаг бөгөөд арилжааны үндсэн системийн хувьд "Милленниум Ай Ти" компанийн "Information Security Policy" буюу "Мэдээллийн аюулгүй байдлын бодлого"-ыг хэрэгжүүлэн ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь мэдээллийн аюулгүй байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Нууцын журам", "Архивын үйл ажиллагааны журам", "Албан хэрэг хөтлөлтийн журам", "Мэдээллийн технологийн цогц журам" зэрэг дотоод дүрэм, журам болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд аливаа мэдээллийг стандартын дагуу хадгалах, нууцлах, боловсруулах, архивлах, бүртгэл хяналтыг хөтлөх, сайжруулах зэргээр мэдээллийн аюулгүй байдлын эрсдлээс урьдчилан сэргийлэх/бууруулах чиглэлд өндөр ач холбогдол, анхаарал хандуулан ажиллаж байна.

6.5. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны стратеги бодлого, бизнес төлөвлөгөө, зорилго, зорилтод хүрэх, цаашдын бизнесийн ололт амжилтын үндэс нь чадварлаг боловсон хүчний нөөц юм. Үнэт цаас гаргагчийн хүний нөөцийн эрсдэлийн хүчин зүйлд Монгол Улс дахь хөдөлмөрийн зах зээлд чадварлаг боловсон хүчний нөөцийн хомсдол үүсэх, аливаа шалтгаанаар ажилтнууд үүрэгт ажлаас чөлөөлөгдөх, түүний үндсэн дээр чадварлаг боловсон хүчний дутагдалд орох, зохицуулах байгууллагын хувьд шударга ил тод байж хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд ажилчдын ёс зүй болон мэдлэг, туршлага дутагдах зэрэг эрсдэлүүд багтаж байна.

Үнэт цаас гаргагчийн чадварлаг боловсон хүчнийг татах, авч үлдэх чадвар нь зах зээлийн нөхцөл байдал, өрсөлдөгч компаниудын санал болгож буй цалин, урамшуулал болон Үнэт цаас гаргагчийн зохих цалин хөлсийг үргэлжлүүлэн олгох нөөц, боломж зэрэг олон хүчин зүйлсээс ихээхэн шалтгаална. Үнэт цаас гаргагч нь

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 -12- 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

шаардлагатай боловсон хүчнийг татах, авч үлдэх боломжгүй болох нь Үнэт цаас гаргагчийн бизнес эрхлэх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Тус эрсдэлийн хүрээнд Үнэт цаас гаргагч нь өндөр түвшний мэдлэг, мэргэшил, хариуцлага бүхий боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх, чадавхжуулах, бүтээлч байдлыг бий болгох, чадварлаг залгамж халааг бүрдүүлэхийн тулд оновчтой хүний нөөцийн бодлого, хөдөлмөрийн дотоод журам зэргийг үйл ажиллагаандаа мөрдөн хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан ажиллаж байна.

6.6. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагч нь өөрийгөө зохицуулах байгууллагын хүрээнд зах зээлийн хяналт зохицуулалтыг хэрэгжүүлж, бүртгэлтэй компани болон гишүүнийг тодорхой шалгуурын дагуу бүртгэх, үнэт цаасны ангилал тогтоох, үнэт цаас болон зах зээл дээрх шинэ төрлийн үүсмэл санхүүгийн хэрэгсэл, валют, хадгаламжийн бичгийг бүртгэх, арилжих, зохицуулалттай этгээд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, техник программ хангамж, арилжаа хэвийн явуулах бэлэн байдлыг хангах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Иймд ажилтны санаатай болон санамсаргүй үйлдэл, дотоод үйл ажиллагааны доголдол, алдаатай эсхүл дутуу зохицуулсан үйл явц, журам, заавар, гадаад хүчин зүйлийн сөрөг нөлөөллүүдээс хамааран эрсдэлүүдтэй тулгарах боломжтой.

Үнэт цаас гаргагч нь энэ төрлийн эрсдэлээс сэргийлэхийн тулд "Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн ажилтны ёс зүйн дүрэм", "Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шалгах журам", "Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн дотоод хяналт шалгалтын журам" болон бусад үнэт цаасыг бүртгэх, арилжаалахтай холбоотой дүрэм, журмуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна.

6.7. ХӨРВӨХ БА ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ЭРСДЭЛ

Хөрвөх чадварын эрсдэлд зах зээлийн хэвийн, хэвийн бус нөхцөлд аливаа гуравдагч этгээдийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэж чадахуйц бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрвөх чадвартай хөрөнгийн зохистой нөөцгүй байх эрсдэл багтдаг.

2022 оны эхний хагас жилийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн 1.8 хувийг өр төлбөр эзэлдэг бөгөөд өр төлбөрийн дарамт багатайгаар үйл ажиллагаа явуулж байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020899 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 оны 12 сар 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 14
БҮРТГЭВ-02

6.8. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО БОЛОН ЗАРДЛЫН ТӨСӨӨЛӨЛ БИЕЛЭХГҮЙ БАЙХ ЭРСДЭЛ

Эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдал, зах зээлд Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг орлох бүтээгдэхүүнүүд гарч ирэх, харилцагчдын итгэлийг алдах зэрэг олон төрлийн хүчин зүйлстэй холбоотойгоор борлуулалтын орлогын төсөөлөл биелэхгүй байх, төлөвлөсөн зардал их хэмжээгээр хэтрэх эрсдэлтэй.

Үнэт цаас гаргагч нь төсөөлж буй ашиг, орлогод хүрэхэд тооцоолоогүй хүчин зүйлүүд эсвэл нэмэлт зардалтай тулгарч болзошгүй. Төсөөлж буй ашгийн хэмжээнд хүрэх нь Үнэт цаас гаргагчийн удирдлагын хэрэгжүүлэх стратеги болон ажилчдын чадамж чадвараас тодорхой хэмжээгээр хамаарна.

Үнэт цаас гаргагч нь энэ төрлийн эрсдэлүүдийг бууруулахын тулд жил бүр бизнес төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж, төлөвлөгөө болон гүйцэтгэлийг тайлагнан хянаж ажилладаг байна.

6.9. СТРАТЕГИЙН ЭРСДЭЛ

Стратегийн эрсдэлд оновчтой бус төлөвлөгөө, стратегийг баталж хэрэгжүүлэх, гадаад орчны нөлөөллөөс үүдэлтэйгээр бизнес төлөвлөгөө цаг тухайд нь биелэхгүй, хойшлогдох зэрэг эрсдэлүүд орно.

Үнэт цаас гаргагч нь бизнесийн стратеги, төлөвлөгөөгөө амжилттай хэрэгжүүлэхэд урьдчилан тооцоолсон болон тооцоолоогүй эрсдэлүүд, эрх бүхий байгууллагын хяналт, зохицуулалт, улс төрийн нөлөө зэрэг олон төрлийн хүчин зүйлс сөргөөр нөлөөлж болно. Эдгээр хүчин зүйлсийн улмаас ирээдүйн бизнесийн стратегийг хэрэгжүүлэх боломжгүй болох нь Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Үнэт цаас гаргагч нь дээрх эрсдэлийг бууруулахын тулд тухайн жилийн стратеги төлөвлөгөөг батлахдаа өнгөрсөн жилийн бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж дүгнэн тухайн жилд тавигдах үндсэн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, гарч болзошгүй эрсдэл, тэдгээрээс сэргийлэх төлөвлөгөө зэргийг харгалзан үзэж баталдаг байна.

6.10. КОМПЛАЕНС, ХУУЛЬ ЗҮЙН ЭРСДЭЛ

Комплаенс, хууль зүйн эрсдэл нь хууль тогтоомж, дүрэм журам, стандартын шинэчлэлт, тэдгээрийг мөрдөж ажиллаагүйн улмаас хуулийн хариуцлага, эрх бүхий

MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
INVESCORE CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02

байгууллагын торгууль, шийтгэл хүлээх, санхүүгийн бодит алдагдалд орох зэрэг эрсдэл хүлээхийг хэлнэ.

Үнэт цаас гаргагч нь санамсаргүйгээр эсвэл өөрийн хяналтаас гадуурх хүчин зүйлийн улмаас ирээдүйд хамаарах хууль тогтоомж, зохицуулалтын нөхцөл, үүргээ биелүүлэхгүй байх эрсдэлтэй. Түүнчлэн, эрх бүхий байгууллагаас Үнэт цаас гаргагчид нэмэлт шаардлага, хязгаарлалт болон зардал оноогдуулж болно. Эдгээр нөхцөл, үүрэг даалгаврууд нь Үнэт цаас гаргагчийн орлогыг хязгаарлахгүй, зардлыг нэмэгдүүлэхгүй, зардлын үр өгөөжид хүрэх нөөц, бололцоог бууруулахгүй гэсэн баталгаа байхгүй.

Үнэт цаас гаргагч нь тус эрсдэлийн хүрээнд үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн компаниуд, бүртгэлтэй компаниуд болон бусад оролцогч талуудтай үүсэх харилцааг хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, нээлттэй зохицуулж, холбоотой дүрэм, журмуудыг батлах, шинэчлэх, дагаж мөрдөн ажиллаж байна.

Мөн Үнэт цаас гаргагч нь холбогдох эрх бүхий байгууллагуудаас Улсын Их Хуралд хэлэлцүүлэхээр өргөн барьж буй холбогдох хуулийн төсөл, шийдвэрүүдийг тогтмол анхаарч, мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах, санал боловсруулан өгөх, хууль тогтоомжуудын өөрчлөлтийг цаг тухайд нь хэрэгжүүлж, даган мөрдөж ажилладаг.

6.11. НЭР ХҮНДИЙН ЭРСДЭЛ

Нэр хүндийн эрсдэлд Монголын Хөрөнгийн Биржийн үйл ажиллагаа, удирдлага болон бусад гадаад, дотоод үйл ажиллагаанаас үүдэлтэй олон нийтийн дунд сөрөг сэтгэгдэл үүсэж компанийн нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл багтдаг.

Үнэт цаас гаргагчийн нэр хүндэд учирч болох эрсдэл нь дотоод (технологийн доголдол, хяналт шалгалт, шийтгэл, шүүх ажиллагаа гэх мэт) болон гадаад (өрсөлдөөн, хууль эрх зүйн болон зохицуулалтын өөрчлөлт, эдийн засаг, улс төрийн гэх мэт) хүчин зүйлсээс үүдэлтэй байж болно. Үнэт цаас гаргагчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх нь Монголын Хөрөнгийн Биржийн зах зээлд эзлэх хувь хэмжээ буурах, мэдээлэл нийлүүлэх үйлчилгээ болон арилжааны системтэй холбогдох үйлчилгээнээс олох ашиг орлого багасах, хяналт шалгалтыг нэмэгдүүлэх зэрэгт хүргэж болзошгүй юм.

Үнэт цаас гаргагч нь тус эрсдэлийг бууруулахын тулд иргэн, албан байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлыг тогтмол хүлээн авч шийдвэрлэх, зохицуулагч

ХӨРӨНГИЙН БИРЖ
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02

байгууллагын хувьд бүртгэл, хяналт шалгалтыг батлагдсан хууль, дүрэм журмуудын хүрээнд хийж гүйцэтгэж байна.

6.12. ӨРСӨЛДӨӨНИЙ ЭРСДЭЛ

Хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтэрч, чанар хүртээмж сайжирч, үнэт цаас гаргагч болон хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэхийн хирээр өрсөлдөгч байгууллагуудын тоо нэмэгдэх эрсдэлтэй.

Өрсөлдөгчид зах зээлийн дарамт шахалтад илүү хурдан хариу үйлдэл үзүүлэх, Үнэт цаас гаргагчийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, илүү хямд үнээр санал болгох, дэд бүтцийн хүчин чадлаа сайжруулах, өргөжүүлэх, шинэ болон шинээр гарч ирж буй техник технологийг дотоод үйл ажиллагаандаа түрүүлж ашиглаж болно. Эдгээр нь Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны үнэ цэнэ эсвэл арилжигдсан үнэт цаасны хэмжээг бууруулах эрсдэлтэй бөгөөд цаашлаад Үнэт цаас гаргагчийн арилжааны шимтгэл хураамжийн хэмжээнд нөлөөлж, улмаар Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Үнэт цаас гаргагч нь энэ төрлийн эрсдэлийг харилцагчийн тоо, хямд өртөг, түргэн шуурхай үйлчилгээ, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн системийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа зэргийг урт хугацааны давуу тал болгон ашиглах боломжтой байна.

Мөн төрийн өмчит компаниудыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй компани болгох шийдвэрийг Засгийн газар гаргасан нь Үнэт цаас гаргагчийн бүртгэлтэй компаниудын тоог нэмэгдүүлж өгснөөр бусад өрсөлдөгч байгууллагуудтай харьцуулахад томоохон өрсөлдөөний давуу талыг үүсгэхээр байна.

6.13. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ЭРСДЭЛ

Байгалийн гамшиг, гал түймэр, халдварт өвчин, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн, терроризм, цахим халдага гэх мэт онцгой байдал, гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан үйл ажиллагаа, эрчим хүч, интернет доголдох эрсдэлийн нөлөөлөл нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг алдагдуулах эрсдэлтэй.

Эдгээр эрсдэлүүдийг үнэлж, эрсдэлийн түвшинд тулгуурлан гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө, гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт, дадлага явуулах ажлын журам болон мэдээлэл технологийн албад учирч

ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071006
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

болзошгүй гамшгаас гарах төлөвлөгөө зэрэг давагдашгүй хүчин зүйл тохиолдох үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох төлөвлөгөө болон журамд оруулдаг байна.

6.14. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсвэл хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг нь халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр, байршлыг нь өөрчилсөнтэй холбоотой үүсэж болох эрсдэлүүдийг авч үзнэ.

Үнэт цаас гаргагч нь зохицуулагч байгууллагын хувьд энэ төрлийн эрсдэлд чухал ач холбогдон өгөн хянаж ажилладаг ба "Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн 2022 оны 11 дүгээр сарын 21 өдрийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр"-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

6.15. ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ЭРСДЭЛ

Энэ төрлийн эрсдэлд тодорхой Үнэт цаас эсхүл Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа, зах зээлийн нөхцөл байдал бүхэлдээ муудсанаас хувьцааны үнэ хэлбэлзэж буурах, арилжааны идэвх, хөрвөх чадвар хангалттай түвшинд байхгүй байх, ногдол ашиг олгох эсэх зэрэг эрсдэлүүд багтдаг.

Компанийн үйл ажиллагаа, цаашдын хэтийн төлөвтэй холбоотой аливаа эерэг мэдээ, мэдээлэл олон нийтэд цацагдах үед зах зээлийн зарчмаар хувьцааны эрэлт нэмэгдэж, нийлүүлэлт багасч хувьцааны ханш өсдөг бол үйл ажиллагаатай холбоотой таагүй мэдээлэл, тайлангууд муу гарах, зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдөхөд эрэлт багассанаар зах зээлийн зарчмын дагуу нийлүүлэлтийн илүүдлээс үүдэлтэйгээр хувьцааны ханшийн бууралт явагддаг.

Үнэт цаас гаргагч нь зохицуулагч байгууллагын хувьд холбоотой дүрэм, журам, стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах, өргөжүүлэн ажилласнаар энэ төрлийн эрсдэлийг тодорхой хэмжээнд бууруулах боломжтой байна.

7. ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН ХУУЛИЙН ЭТГЭЭДҮҮДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 44. Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон хуулийн этгээдүүдийн тухай мэдээлэл

Үндсэн андеррайтер	"Инвескор Капитал ҮЦК" ХХК Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян Гүний гудамж 18/1, Даун Таун барилга, 6 давхар, 601 тоот Утас: +976-7755-0077 Цахим шуудан: info@icapital.mn Вэб хуудас: www.icapital.mn
Туслах андеррайтер	"Голомт Капитал ҮЦК" ХХК Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Чингисийн өргөн чөлөө, Парк Плэйс оффис, 4 давхар, 403 тоот Утас: +(976)-7012-1530 Цахим шуудан: mail@golomtbank.com Вэб хуудас: www.golomtbank.com
Туслах андеррайтер	"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, Худалдаа, хөгжлийн банкны байр, 1401 тоот Утас: +(976)-7010-0261 Цахим шуудан: info@tdbsecurities.mn Вэб хуудас: www.tdbsecurities.mn
Хуулийн зөвлөх компани	"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот Утас: +976-330048 Цахим шуудан: info@mdsa.mn Вэб хуудас: www.mdskhanlex.com
Аудитын компани	"Грант Торнтон Аудит" ХХК Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж-31, Далай Тауэр, 9 давхар Утас: +976-7011-0799 Цахим шуудан: info@mn.gt.com Вэб хуудас: www.grantthornton.mn
Үнэлгээний компани	"Гэрэгэ Эстимэйт" ХХК Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай 20-6, Эрдэм Тауэр Эрдмийн ордон, 1004 тоот Утас: +976-7000-5000 Цахим шуудан: gantulga@geregepartners.mn Вэб хуудас: www.geregepartners.mn

7.1. ҮНДСЭН АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ

"Инвескор Капитал ҮЦК" ХХК нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох, дотоодын болон олон улсын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах, үнэт цаасны зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож хөрөнгө оруулагчдад үр шим, өгөөж хүртэх боломжийг өргөн хүрээнд олгох зорилгоор үүсгэн байгуулагдсан компани юм. "Инвескор Капитал ҮЦК" ХХК нь үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааг эрхлэн явуулах тусгай зөвшөөрөлтэй, үнэт цаасны номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй зохицуулалттай этгээд юм. "Инвескор Капитал ҮЦК" ХХК нь банк, банк бус санхүүгийн байгууллага, хууль зүйн салбаруудад ажиллаж байсан чадварлаг туршлагатай мэргэжилтнүүдээр баг хамт олноо бүрдүүлсэн үнэт цаасны зах зээлд хүлээн зөвшөөрөгдсөн, салбартаа тэргүүлэх чиглэлийн үнэт цаасны компаниудын нэг юм. "Инвескор Капитал ҮЦК" ХХК нь тусгай зөвшөөрлийн хүрээнд харилцагч, үйлчлүүлэгчдэд хөрөнгө оруулалтын мэргэшсэн зөвлөгөө өгөх, биржийн болон биржийн бус зах зээлд үнэт цаас гаргах үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргах ажиллагааг зохион байгуулж мэргэшсэн зөвлөгөөгөөр харилцагч үйлчлүүлэгчийг хангах, үнэт цаасны арилжаанд зах зээл үүсгэгчээр оролцох, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагааг эрхлэн явуулж буй хөрөнгө оруулалтын мэргэшсэн зөвлөх юм.

Хүснэгт 45. Үндсэн андеррайтерийн товч танилцуулга

Компанийн нэр	"Инвескор Капитал ҮЦК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011741137
Регистрийн дугаар	6317839
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Жамьян Гүний гудамж 18/1, Даун Таун барилга, 6 давхар, 601 тоот
Утас	+976-7755-0077
Цахим шуудан	info@icapital.mn
Вэб хуудас	www.icapital.mn

Эх сурвалж: Үндсэн андеррайтерийн мэдээлэл

"Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийн андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлуудыг дурдвал:

1. ***Биржийн зах зээл***

✓ 2019 онд "Инвескор ББСБ" ХК-ийн IPO буюу хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргаж 18.6 тэрбум

төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд туслах андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;

- ✓ 2021 онд Монголын анхны нээлттэй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болох "Инвескор Актив ХБҮЦ"-ыг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргаж 4 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;

- ✓ 2021 онд "Инвескор ББСБ" ХК-ийн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргасан хувийн хэвшлийн анхны нээлттэй бонд болох 20 тэрбум хүртэлх төгрөгийн өрийн хэрэгслийг хөтөлбөр болгон үе шаттайгаар арилжаалж нийт үнийн дүнг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;

- ✓ 2022 онд "Инвескор ББСБ" ХК-ийн FPO буюу нэмэлт хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргаж 16.7 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд туслах андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;

- ✓ 2022 онд Монгол Улсын түүхэн дэх хамгийн томд тооцогдох IPO болох "Голомт Банк" ХК-ийн хувьцаагаа Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргаж 174.8 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх түүхэн үйл ажиллагаанд үндсэн андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;

- ✓ 2022 онд "Инвескор ББСБ" ХК-ийн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийтэд нээлттэй санал болгон гаргахаар бүртгүүлсэн нээлттэй бонд болох 50 тэрбум хүртэлх төгрөгийн өрийн хэрэгслийг хөтөлбөр болгон үе шаттайгаар арилжаалах үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

2. *Биржийн бус зах зээл*

- ✓ 2021 онд "Кэй Эй Майнинг" ХХК-ийн биржийн бус зах зээлд "Хишиг Бонд" өрийн хэрэгслийг хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад санал болгон гаргаж 3.2 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;

- ✓ 2022 онд "Шунхлай" ХХК-ийн биржийн бус зах зээлд "Шунхлай Бонд" идэвхтэй үлдэгдэл бүхий давтамжтай үргэлжлэх холимог хугацаат өрийн хэрэгслийг хөтөлбөр болгон хөрөнгө оруулагчдад санал болгон гаргахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлж тус өрийн хэрэгслийн хөтөлбөрийн

СЭХ
2022 -12- 12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ

хүрээнд 2 удаагийн хэсэгчлэн гаргах ажиллагааны үр дүнд 23.9 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлсэн;

- ✓ 2022 онд "Актив Гарден" ХХК-ийн биржийн бус зах зээлд "Актив Бонд" өрийн хэрэгслийг хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад санал болгон гаргаж 3.4 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;
- ✓ 2022 онд "Ай Си Рэит" ХХК-ийн биржийн бус зах зээлд "Рэит Бонд" өрийн хэрэгслийг хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчдад санал болгон гаргаж 7.6 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн;
- ✓ 2022 онд "Инвескор ББСБ" ХК-ийн биржийн бус зах зээлд "Инвескор Хаалттай Бонд" өрийн хэрэгслийг хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгон гаргаж 10 тэрбум төгрөгийг зах зээлээс амжилттай татан төвлөрүүлэх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээг тус тус үзүүлээд байна.

7.1.1. Үндсэн андеррайтерийн танилцуулга, түүнтэй байгуулагдсан гэрээний тухай

Үнэт цаас гаргагч нь "Инвескор Капитал ҮЦК" ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр МХБ2022/201 дугаартай Андеррайтерийн үйлчилгээний гэрээг байгуулсан. Тус гэрээгээр Андеррайтер нь Үнэт цаас гаргагчид хөрөнгө оруулалт, санхүүжилтийг татан төвлөрүүлэх зорилгоор Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн зах зээлд нэмж хувьцаа гаргах ажлыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржээс батлан гаргасан холбогдох дүрэм, журамд нийцүүлэн хийж гүйцэтгэхтэй холбогдон үүсэх талуудын хоорондын харилцааг зохицуулахаар байгуулсан болно.

1. Андеррайтерийн эрх үүрэг

Андеррайтер нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг, үзүүлэх үйлчилгээг "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржийн үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангах, үнэт цаас бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид нийцүүлэн үнэ цаас гаргах ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах, гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт Үнэт цаас гаргагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллаж, гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, түүний ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих, өөр төсөл арга хэмжээ болон өөрийн байгууллагын эрх ашигтай сонирхлын зөрчилд орохоос зайлсхийх, гэрээг

ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ДД 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ДД 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-03

хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж авсан Үнэт цаас гаргагчийн аливаа мэдээллийн нууцлалыг хадгалах, гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээг ямарваа байдлаар доголдолтой үзүүлсэн тохиолдолд тухайн доголдлыг өөрийн зардлаар арилгах, андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ажлын явцын болон эцсийн үр дүнг тайлагнаж мэдээлэх зэрэг үүрэг хүлээхийн зэрэгцээ зөвлөхийн үйлчилгээг үр дүнтэй, шуурхай хэрэгжүүлэхэд шаардлагатай зааварчилгаа, удирдамжийг Үнэт цаас гаргагчаас томилсон ажилтан болон удирдлагад гарган өгөх, үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх зарчмыг тогтоох, хуваарилалтыг хийх, гэрээгээр хүлээсэн үүргээ Үнэт цаас гаргагч нь зөрчсөний улмаас Андеррайтер болон аливаа гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд тухайн хохирлыг барагдуулахыг шаардах, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайланг гаргаж өгөх, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэхийг Үнэт цаас гаргагчаас шаардах зэрэг эрхтэй байхаар зохицуулсан.

2. Үнэт цаас гаргагчийн эрх үүрэг

Үнэт цаас гаргагч нь Андеррайтерт ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн шийдвэр, тогтоол, мэдээ мэдээлэл, анхан шатны баримт бичгүүдийг тогтоосон хугацаанд түргэн шуурхай, бүрэн гүйцэд, шаардлага хангахуйц байдлаар гаргаж өгөх, Андеррайтерийг гагцхүү үнэн зөв мэдээллээр хангах, хамтран ажиллах ажилтан томилох, үйлчилгээ авах явцдаа аливаа нууцлалыг хадгалах, ажлын байр, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд хөрөнгөө үнэ төлбөргүйгээр ашиглуулах, Үнэт цаасны татан төвлөрүүлсэн хөрөнгийн тайланг тогтоосон хугацаанд гаргаж өгөх зэрэг үүргүүдийг хүлээсэн. Андеррайтер нь үйлчилгээг доголдолтой гүйцэтгэсэн тохиолдолд доголдлыг өөрийн зардлаар арилгахыг шаардах, тогтоосон хугацаанд Андеррайтерийн гүйцэтгэх ажлын үр дүнг бэлэн болгохыг шаардах, үнэ тогтворжуулах хөтөлбөрийг гэрээнд заасан хугацаанд чанартай гүйцэтгэхийг шаардах, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан аливаа нууцлалыг хадгалахыг шаардах, гэрээний үүргээ бүрэн хэрэгжүүлэхийг Андеррайтераас шаардах зэрэг эрхийг эдлэхээр гэрээгээр зохицуулсан.

Андеррайтерийн үйлчилгээний гэрээгээр дотоод мэдээлэл эзэмшигчтэй холбогдсон харилцааг зохицуулсан ба дотоод мэдээлэл эзэмшигч гэдэгт Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон тэдгээрийн холбогдох этгээд, мөн албан үүргээ хэрэгжүүлэх, гэрээ, хэлцлийн бэлтгэл болон түүнийг байгуулах, гүйцэтгэх үе шатанд дотоод мэдээллийг олж авсан этгээд, тэдгээрийн холбогдох этгээд, хууль тогтоомжид тусгайлан заасан бусад этгээдүүд хамаарч байна. Дотоод мэдээлэл эзэмшигч нь тус гэрээг байгуулсан өдрөөс эхлэн гэрээний үүргийг бүрэн хэрэгжүүлж дуусах хүртэл эсхүл гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө үнэт цаасны арилжаанд оролцох, бусад этгээдийг

ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 207096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
БҮРТГЭВ-02

арилжаанд оролцохыг санал болгох, ятгах (энэ үүрэг нь гэрээний бусад зохицуулалтаар хязгаарлагдана), хувьцааны үнэ ханшид нөлөөлөхөөр дотоод мэдээллийг бусдад задруулахыг хориглосон бөгөөд дотоод мэдээлэл эзэмшигч нь дотоод мэдээллийг задруулсан, арилжаанд оролцсон зэрэг тохиолдолд аливаа хохирлыг хариуцаж, хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээхээр заасан болно.

7.1.2. Туслах андеррайтерийн танилцуулга, түүнтэй байгуулагдсан гэрээний тухай

1. "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК

Хүснэгт 46. Туслах андеррайтерийн товч танилцуулга

Компанийн нэр	"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011165033
Регистрийн дугаар	5251494
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, Худалдаа, хөгжлийн банкны байр, 1401 тоот
Утас	
Цахим шуудан	info@tdbsecurities.mn
Вэб хуудас	www.tdbsecurities.mn

Эх сурвалж: Туслах андеррайтерийн мэдээлэл

Туслах андеррайтер "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК нь анх "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нэрээр үүсгэн байгуулагдаж, 2011 оноос эхлэн Монгол Улсын хөрөнгийн зах зээлд зохицуулалттай үйл ажиллаагаа эрхлэн явуулж буй тэргүүлэгч үнэт цаасны компаниудын нэг юм. Тус компани нь харилцагчдын эрх ашгийг эрхэмлэсэн, дэвшилтэт технологид суурилсан цогц бүтээгдэхүүн үйлчилгээ, санхүүгийн шийдлийг мэргэжлийн дээд түвшинд хүргэсэн, үндэсний баялаг бүтээгчдийг дэмжигч, харилцагчдын найдвартай зөвлөх байх зорилгыг тавин ажиллаж байна.

Тус компани нь хөрөнгө оруулалтын банкны болон үнэт цаасны зуучлалын үйлчилгээг харилцагчдадаа хүргэн, үнэт цаасны зах зээлийн санхүүгийн хэрэгслүүдийг нээлттэй болон хаалттай зах зээлд гарган санхүүжилт татах, тухайн байгууллагын онцлогт тохирсон санхүүжилтийн хамгийн үр ашигтай хувилбарыг санал болгох зэргээр харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг бүрэн хангах, мэргэжлийн зөвлөгөө, туслалцааг үзүүлдэг компани юм. "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн олон улсын хөрөнгө оруулалтын банкнуудтай хамтарч болон бие даан нийт 3.6 тэрбум ам.долларын санхүүжилтийг харилцагчдад амжилттай татан төвлөрүүлж, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн бөгөөд

ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2022.12.14
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2021 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр нийт 270 орчим тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжааг хийж гүйцэтгэжээ.

Өдрөөс өдөрт хөгжин өөрчлөгдөж буй дэлхийн санхүүгийн зах зээлийн орчинд харилцагчдынхаа хүсэл сонирхолд тулгуурласан өндөр чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхийг зорин ажиллаж, Биржтэй шууд холболт хийгдсэн "Ти Ди Би Брокер" онлайн арилжааны системээ 2018 онд бүрэн шинэчилсэн билээ. Түүнчлэн, 2019 оноос эхлэн гадаад арилжааны үйл ажиллагаагаа эхлүүлж, гадаадын хөрөнгийн биржүүдээс хүссэн хувьцаа, бонд бусад төрлийн санхүүгийн хэрэгслийг худалдан авах боломжийг харилцагчдадаа нээсэн ба гадаад арилжааны үйл ажиллагаа явуулж буй хэмжээгээрээ тус зах зээлд тэргүүлэгчдийн нэг билээ.

Тус компани нь хөрөнгийн зах зээлд оролцогчдын санхүүгийн мэдлэг, боловсролыг дэмжих зорилгоор хөрөнгийн зах зээлийн тухай мэдлэг, арилжаанд оролцох болон үнэт цаас гаргахтай холбоотой интерактив хөтчүүдийг бэлтгэн олны хүртээл болгосноос гадна хөрөнгө оруулагчдыг мэдээлэл, судалгаатайгаар хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахад нь туслах зорилгоор хөрөнгийн зах зээлийн нэгдсэн статистик мэдээлэл, хувьцаат компаниудын тоон шинжилгээ болон долоо хоногийн зах зээлийн тойм цахим товхимлыг уламжлал болгон нийтлэн түгээж, харилцагчдаа зах зээлийн мэдээ мэдээллээр цаг алдалгүй ханган ажиллаж байна.

Туслах андеррайтертай байгуулсан гэрээ

Туслах андеррайтер "Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК болон Үндсэн андеррайтер "Инвескор Капитал ҮЦК" ХХК нар нь нэгдмэл сонирхолтой, холбоо хамааралтай этгээдүүд биш бөгөөд Үнэт цаас гаргагчийн хувьцааг нийтэд санал болгон гаргах ажиллагаанд хамтран ажиллахаар "Хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулсан.

Тус гэрээний хүрээнд Туслах андеррайтер нь Үнэт цаас гаргагчид нэмэлт хувьцааг нийтэд анх удаа санал болгох замаар хөрөнгийн зах зээлээс хөрөнгө татан төвлөрүүлэхэд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх, Үнэт цаасны танилцуулга болон бусад баримт бичиг боловсруулахад зөвлөгөө өгөх, Үнэт цаас гаргагч болон гаргаж буй үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад танилцуулах, санал болгох, худалдах, санхүүжилт татах үйлчилгээг үзүүлэхтэй холбогдсон ажиллагааг гэрээнд заасан нөхцөл журмын дагуу Үндсэн андеррайтертай хамтран үзүүлэхээр тохиролцсон.

Гэрээний дагуу Туслах андеррайтер нь Үнэт цаас гаргагчид Үнэт цаас санал болгон гаргаж санхүүжилт татахад "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", Санхүүгийн зохицуулах хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон "Монголын Хөрөнгийн Бирж"-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон Үнэт цаас

ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-03

гаргах, арилжаалахтай холбогдсон бусад хууль тогтоомжид заасны дагуу Үнэт цаас гаргах төлөвлөгөөний хүрээнд оролцогч талуудтай хамтран ажиллах, боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлж, тэдгээрээс хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, Үнэт цаас гаргагчийг төлөөлөн Үнэт цаасны танилцуулга хийх, хөрөнгө оруулагчидтай уулзалт зохион байгуулах, гэрээ хэлцэл хийхэд зуучлах, оролцогч талуудтай хамтран ажиллах, Үнэт цаасыг олон нийтэд сурталчлах маркетингийн төлөвлөгөөг боловсруулахад санал зөвлөмж өгөх, өөрийн боломжит сувгаар сурталчлах, Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгож байршуулах төлөвлөгөөг Үндсэн Андеррайтертай хамтран боловсруулах зэрэг үүргийг хүлээсэн.

2. "Голомт Капитал ҮЦК" ХХК

Туслах андеррайтер болох "Голомт Капитал ҮЦК" ХХК (цаашид "Туслах андеррайтер" гэх) нь "Голомт Банк" ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2011 онд анх үүсгэн байгуулагдаж, тухайн ондоо Санхүүгийн Зохицуулах Хорооноос үнэт цаасны зах зээлд брокерын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, 2014 онд хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, 2015 онд андеррайтерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг тус тус авсан. "Голомт Капитал ҮЦК" ХХК нь өдгөө хөрөнгийн зах зээлд тэргүүлэгч үнэт цаасны компаниудын нэгт зүй ёсоор тооцогдож буй бөгөөд иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээг үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш үзүүлэн амжилттай ажиллаж байна.

Хүснэгт 47. Туслах андеррайтерийн товч танилцуулга

Компанийн нэр	"Голомт Капитал ҮЦК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011287134
Регистрийн дугаар	5481589
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Чингисийн өргөн чөлөө, Парк Плэйс оффис, 4 давхар, 403 тоот
Утас	
Цахим шуудан	mail@golomtbank.com
Вэб хуудас	www.golomtbank.com

Эх сурвалж: Туслах андеррайтерийн мэдээлэл

"Голомт Капитал ҮЦК" ХХК нь үнэт цаасны зах зээлийн санхүүгийн хэрэгслүүд болох өрийн хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас санал болгон гаргах ажиллагаанд зах зээлээс нийт 180 гаруй тэрбум төгрөг, үнэт цаас гаргагчдын IPO хийх үйл ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлж нийт 192.8 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлээд байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

"Голомт Капитал ҮЦК" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн голлох ажлууд:

"Голомт Капитал ҮЦК" ХХК-ийн нийтэд анх удаа болон нэмж хувьцаа санал болгох ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд:	"Голомт Капитал ҮЦК" ХХК-ийн нээлттэй болон хаалттай зах зээлд бонд гаргах ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд:
2018 онд: ✓ Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй "Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК-ийн давхар бүртгэлийг (FPO) хийх ажиллагаанд хамтран андеррайтер; ✓ Даатгалын зах зээлд тэргүүлэгч "Мандал Даатгал" ХК-ийн IPO хийх ажиллагаанд үндсэн андеррайтер; **2019 онд:** ✓ Шувууны аж ахуйн салбарт тэргүүлэгч "Түмэн Шувуут" ХК-ийн IPO хийх ажиллагаанд үндсэн андеррайтер; ✓ Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэрлэлийн зах зээлд тэргүүлэгч "Монос Хүнс" ХК-ийн IPO хийх ажиллагаанд үндсэн андеррайтер; **2021 онд:** ✓ Конвиниес дэлгүүрийн зах зээлд тэргүүлэгч "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК-ийн IPO үндсэн андеррайтер; **2022 онд:** ✓ "Инвескор ББСБ" ХК-ийн FPO буюу нэмэлт хувьцаа санал болгон гаргах ажиллагаанд үндсэн андеррайтер; ✓ "Голомт Банк" ХК-ийн IPO хийх ажиллагаанд туслах андеррайтераар; тус тус ажилласан.	**2015 онд:** ✓ Монголын анхны даатгагдсан бонд болох Эрчим бонд; **2017 онд:** ✓ Анхны нээлттэй бонд болох Сүү бонд; **2020 онд:** ✓ Анхны хайбрид бонд болох Мастер бонд, анхны банкны баталгаат бонд болох Нөмөр бонд; **2021 онд:** ✓ Анхны биржийн бус зах зээлийн бонд болох Монкон бондын андеррайтераар тус тус ажилласан туршлагатай хамт олон билээ.

Туслах андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

"Голомт Капитал ҮЦК" ХХК болон Үндсэн андеррайтер "Инвескор Капитал ҮЦК" ХХК нар нь 2022 оны 12 дугаар сарын 2-ны өдөр ХАГ_221202/01 тоот "Хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулсан.

Гэрээний дагуу Туслах андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК нь Үндсэн андеррайтертай хамтран Үнэт цаас гаргагчийн нэмж гаргаж буй хувьцааг нийтэд санал болгон арилжаалах ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээг үзүүлэхээр харилцан тохиролцсон. Тус гэрээний дагуу Туслах андеррайтер нь Үнэт цаас

ХӨРӨНГИЙН
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022.12 сар 14 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-12-12
БҮРТГЭВ-02

гаргагчийн Үнэт цаас санал болгон гаргах ажиллагаанд Үнэт цаасны танилцуулга болон шаардагдах баримт бичгийг боловсруулах, Үнэт цаасны захиалгыг бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдыг үнэт цаас худалдан авах тэгш бололцоогоор ханган санхүүжилт татах үйлчилгээг Үндсэн андеррайтертай хамтран үзүүлэхээр тохиролцсон.

Туслах андеррайтер нь Үнэт цаас гаргагчид хувьцаа гарган санхүүжилт татах ажиллагаанд "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Биржээс батлан гаргасан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон Үнэт цаас гаргах, арилжаалахтай холбогдсон бусад хууль тогтоомжид заасны дагуу Үнэт цаас гаргах төлөвлөгөөг хамтран боловсруулах, Үнэт цаас гаргагчаас бүрдүүлэх шаардлагатай төсөв төлөвлөгөө, мэдээ мэдээллийн талаар зөвлөмж өгөх, хамтран ажиллагч байгууллагуудтай хамтран ажиллах боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлох, Үнэт цаас гарагчийг төлөөлөн Үнэт цаасыг стратегийн хөрөнгө оруулагч, олон нийтэд сурталчлан танилцуулах, санал болгох, Үнэт цаасны танилцуулгад шаардагдах аливаа баримт материалыг хамтран боловсруулж бэлтгэх, санал зөвлөмж өгөх үүргийг хүлээж Үндсэн андеррайтертай хамтран ажиллахаар тохиролцсон.

7.2. ХУУЛИЙН ЗӨВЛӨХ КОМПАНИЙН ТУХАЙ

"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд гадаад, дотоодын бизнесийн байгууллагуудад дэлхийн стандартад нийцсэн хууль зүйн зөвлөх үйлчилгээг дотоодын туршлага, ур чадвартай хослуулан хүргэдэг компани юм. "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1 дэх заалтад заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгэгдсэн үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд юм. Хуульч болон хуулийн фирмүүдийн чанар чансааг тогтоодог AsiaLaw сэтгүүл нь "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН-ийг "2021 оны Монгол Улсын шилдэг хуулийн фирм"-ээр шалгаруулсан бөгөөд тус компани нь салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн ТОП хуулийн фирмүүдийн нэг юм. Хуулийн зөвлөх нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн хувьд тус зах зээл дээр хөрөнгө босгож буй олон төрлийн салбаруудад үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтран ажиллаж, хууль зүйн зөвлөх үйлчилгээг үзүүлж байсан арвин туршлагатай компани юм. Тухайлбал:

- ✓ "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа нийтэд анх удаа санал болгох "Wolf" төслийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжтой холбоотой хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан;

ХӨРӨНГИЙН БИРЖ ХХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-02

- ✓ Монголын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100 хувь даатгагдсан Эрчим Бондыг санал болгон гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан;
- ✓ "ЛэндМН ББСБ" ХК-ийн IPO хийх ажиллагаа болон хоёр удаагийн өрийн хэрэгслийг олон нийтэд санал болгон гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлсэн;
- ✓ "Инвескор ББСБ" ХК-ийн IPO хийх ажиллагаа, Монгол Улс дахь анхны 20 тэрбум төгрөг хүртэлх төгрөгийн өрийн хэрэгслийн хөтөлбөр, мөн анхны хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгон гаргах ажиллагаа, 2022 оны "Инвескор ББСБ" ХК-ийн FPO буюу нэмэлт хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөх үйлчилгээ тус тус үзүүлж ажилласан;
- ✓ "Түмэн Шувуут" ХК-ийн IPO гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан;
- ✓ "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан;
- ✓ "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан;
- ✓ "Монголын Ипотекийн Корпораци" ХХК-ийн 1-13, 21, 23, 24, 28, 29 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан;
- ✓ "Сэндли ББСБ" ХХК болон "Төрийн Банк" ХХК-ийн IPO гаргах ажиллагаанд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан;
- ✓ "ЛэндМН Актив ТЗК" ХХК болон "Бэрс Актив ТЗК" ХХК зэрэг компаниудын автомашины фидуци бүхий хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгон гаргах ажиллагаануудад хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан;
- ✓ Түүнчлэн биржийн бус зах зээлд "Ай Си Рэит" ХХК -ийн өрийн хэрэгсэл хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгон гаргах ажиллагаануудад хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан.

ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
БҮРТГЭЛ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭЛ-02

Хүснэгт 48. Хуулийн зөвлөх компанийн товч танилцуулга

Компанийн нэр	"Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН
Улсын бүртгэлийн дугаар	9022001010
Регистрийн дугаар	5495997
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-дугаархороо, Сүхбаатарын талбай, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот
Утас	+976-330048
Цахим шуудан	info@mdsa.mn
Вэб хуудас	www.mdskhanlex.com

7.2.1. Хуулийн зөвлөх компанитай байгуулсан гэрээний тухай

Үнэт цаас гаргагчийн Хуулийн зөвлөхтэй байгуулсан 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Д-С1272231 дугаартай "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ"-ний дагуу Хуулийн зөвлөх нь "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржээс баталсан холбогдох журам болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон Үнэт цаас гаргагчийн хувьцаагаа олон нийтэд санал болгох ажиллагаанд хууль зүйн дүгнэлтийг гаргах, гэрээгээр тохиролцсон ажлын даалгаварт заасны дагуу хууль зүйн зөвлөх үйлчилгээг үзүүлэхээр харилцан тохиролцож байгуулсан байна.

Тус гэрээгээр Хуулийн зөвлөх нь гэрээнд заасан үүргээ гүйцэтгэхийг Үнэт цаас гаргагчаас шаардах, хууль зүйн зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотойгоор шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгийг тухай бүр шаардан авах зэрэг эрхээр хангагдаж, гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, гэрээнд заасан хугацаанд, бүрэн гүйцэт гүйцэтгэх, хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх, үнэн бодит мэдээллээр хангах, нууц хадгалах, үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, мэргэжлийн түвшинд, чанартай үзүүлж, хуулийн дүгнэлтийг аливаа доголдолгүй, бүрэн гүйцэд гаргах, үйлчилгээг үзүүлэхдээ Үнэт цаас гаргагч болон Андеррайтертай үйл ажиллагаагаа уялдуулж, тэдгээрт ажлын явц, үр дүнгийн талаар тогтмол танилцуулж байх, хуулийн дүгнэлт болон зөвлөх үйлчилгээний үнэн зөв, хууль ёсны байдлыг хариуцах зэрэг үүрэг хариуцлага хүлээсэн.

Үнэт цаас гаргагч нь тус гэрээний дагуу гэрээгээр тохиролцсон ажлын гүйцэтгэлийг тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг шаардах, үйлчилгээний талаар санал гаргах, шаардлага тавих, Хуулийн зөвлөх нь гэрээгээр хүлээсэн үүргээ

ХӨРӨНГИЙН
ЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-03

биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах зэрэг эрхийг эдлэхийн зэрэгцээ гүйцэтгэж буй ажил үйлчилгээтэй холбоотой бүхий л мэдээ мэдээлэл, баримт бичгээр Хуулийн зөвлөхийг хангах, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах байраар хангах, нууц хадгалах, Хуулийн зөвлөхийг бүрэн бөгөөд үнэн бодит мэдээллээр хангах зэрэг үүрэг хариуцлага хүлээхээр харилцан тохиролцож байгуулсан байна.

7.3. АУДИТЫН КОМПАНИЙН ТУХАЙ

"Грант Торнтон Аудит" ХХК нь аудитын, татварын зөвлөх үйлчилгээ үзүүлэх цар хүрээгээрээ дэлхийд эхний 6-д тооцогддог компани бөгөөд дэлхийн 140 гаруй оронд ажиллаж буй 62,000 гаруй мэргэжилтнээс бүрдсэн хараат бус зөвлөх үйлчилгээний фирм юм. Монголд 20 гаруй жил үйл ажиллагаа явуулж байсан "Улаанбаатар Аудит Корпораци" ХХК нь 2017 онд "Грант Торнтон Интернэйшнл" дэлхийн сүлжээ байгууллагын жинхэнэ гишүүн болж, тус сүлжээг Монгол Улсад төлөөлж ажиллах бүрэн эрхтэй гишүүн фирмээр хүлээн зөвшөөрөгдөн 2019 оноос эхлэн "Грант Торнтон Аудит" ХХК нэрээр үйл ажиллагаа явуулж байна. "Грант Торнтон Аудит" ХХК нь 2013 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос Үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд бөгөөд Аудитын компанийн хийж гүйцэтгэсэн ажлуудаас дурдвал:

Даатгал, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зах зээлд тэргүүлэгч дор дурдсан компаниудын IPO хийх ажиллагаанд аудитораар ажилласан.

- ✓ "Мандал Даатгал" ХК
- ✓ "Монос Хүнс" ХК
- ✓ "Түмэн Шувуут" ХК
- ✓ "Бодь Даатгал" ХК

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч "Омни Капитал ББСБ" ХХК-ийн тусгай зориулалттай компани болох "Омни Актив ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зээлийн багцад шалгуур үзүүлэлтүүдийн дагуу зээлийн шинжилгээ хийж, аудитын дүгнэлт гаргаж зөвлөх үйлчилгээ үзүүлж ажилласан.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа явуулж буй дор дурдсан компаниудад аудитын үйлчилгээ үзүүлсэн. Үүнд:

- ✓ "Инвескор ББСБ" ХК
- ✓ "Ард Кредит ББСБ" ХК
- ✓ "Нет Капитал ББСБ" ХХК
- ✓ "Жэй Траст Интернэшнл ББСБ" ХХК
- ✓ "БСБ Финанс ББСБ" ХХК

ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

- ✓ "Омни Капитал ББСБ" ХХК
- ✓ "Очир Ундраа ХЗХ ББСБ" ХХК
- ✓ "Ди Би Эм Лизинг" ХХК
- ✓ "Вишнфанд ББСБ" ХХК
- ✓ "Бичил Зээлийн Хөгжлийн Сан" (MDF)
- ✓ "Транскапитал ББСБ" ХХК
- ✓ "Монголын Санхүүгийн Групп ББСБ" ХХК

Түүнчлэн "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК, "Арилжааны Төлбөр Тооцоо ҮЦК" ХХК, "Улаанбаатар Үнэт Цаасны Бирж" ХК, "Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв" ХХК, "Тээвэр Хөгжлийн Банк" ХХК зэрэг компаниудад аудитын үйлчилгээ, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах зөвлөх үйлчилгээ, биет бус хөрөнгийн үнэлгээ гаргаж өгөх зэрэг үйл ажиллагааг хийж гүйцэтгэж байсан.

7.3.1. Аудитын компанитай байгуулсан гэрээ

"Грант Торнтон Аудит" ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2022 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр 2022/56 дугаартай "Аудитын үйлчилгээ үзүүлэх" гэрээ байгуулж "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", "Аудитын тухай хууль", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль" болон бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон Үнэт цаас гаргагчийн 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй зэргийг багтаасан санхүүгийн тайлангууд нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхийг үнэлж аудитын дүгнэлт гаргах шаардлагатай тохиолдолд зөвлөмж өгч ажиллахаар харилцан тохиролцож байгуулсан байна.

Аудитын компани нь аудитын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг Үнэт цаас гаргагчаас хүлээн авч, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, олон улсын стандартын дагуу мэргэжлийн бөгөөд ёс зүйн өндөр түвшинд гүйцэтгэж үнэн зөв, бодитой дүгнэлт үйлдэх, Үнэт цаас гаргагчийн гарган өгсөн санхүүгийн баримт мэдээллийг зөвхөн гэрээт ажлын зорилгоор ашиглах, нууц хадгалах зэрэг үүрэг хүлээсэн.

Үнэт цаас гаргагч нь Аудитын компанид шаардлагатай санхүүгийн болон бусад баримт бичгүүдийг тогтоосон цаг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн гаргаж өгөх, шаардлагатай тохиолдолд аудитын гаргасан аман болон бичгэн санал хүсэлтэд тайлбар өгөх, аудитын үйлчилгээний цар хүрээг хязгаарласан аливаа дарамт шахалт үзүүлэхгүй байх, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай нөхцөл бололцоогоор аудиторыг хангах зэрэг үүрэг хүлээсэн.

ХӨРӨНГИЙН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ᠬᠤ 2071090
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ᠬᠤ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 17
БҮРТГЭВ-02

7.4. ҮНЭЛГЭЭНИЙ КОМПАНИ

"Гэрэгэ Эстимэйт" ХХК нь хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрөлтэй үнэлгээний компани юм. "Гэрэгэ Эстимэйт" ХХК-д Монгол Улсын Сангийн яамнаас олгодог мэргэшсэн үнэлгээчний сертификаттай 3 (гурав) үнэлгээчин ажиллаж байгаа бөгөөд багийн бүрэлдэхүүнд хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний чиглэлээр олон жил ажиллаж байсан, мэргэжлийн өндөр туршлагатай чадварлаг боловсон хүчин ажилладаг. "Гэрэгэ Эстимэйт" ХХК нь үнэт цаасны зах зээлд үнэт цаас санал болгон гаргасан үнэт цаас гаргагч компаниудын хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хийж, үйлчилгээ үзүүлж байсан арвин туршлагатай компани юм. Үнэлгээний компанийн IPO хийх ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хийж, үйлчилгээ үзүүлсэн үнэт цаас гаргагчдыг дурдвал:

- ✓ 2017 онд Монгол Улсын анхны финтек компани болох "ЛендМН ББСБ" ХК-ийн IPO хийх ажиллагаа;
- ✓ 2018 онд "Инвескор ББСБ" ХК-ийн IPO хийх ажиллагаа;
- ✓ 2019 онд "Бодь Даатгал" ХК-ийн IPO хийх ажиллагаа;
- ✓ 2021 онд "Сэнтрал Экспресс Си Ви Эс" ХК-ийн IPO хийх ажиллагаа;

7.4.1. Үнэлгээний компанитай байгуулсан гэрээний тухай

"Гэрэгэ Эстимэйт" ХХК нь Үнэт цаас гаргагчтай 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр МХБ2012/203 дугаартай "Үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулсан байна. Тус гэрээний хүрээнд "Гэрэгэ Эстимэйт" ХХК нь Үнэт цаас гаргагчийн Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржид Үнэт цаасаа бүртгүүлж олон нийтэд нээлттэй арилжаалах үйл ажиллагааны хүрээнд хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх, тайлан гаргах үйлчилгээг үзүүлэх, Үнэт цаас гарагч нь Үнэлгээний компанид гэрээнд заасны дагуу үйлчилгээний төлбөр төлөхтэй холбоотой талуудын хооронд үүсэх эрх, үүрэг, хариуцлага, түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулах зорилгоор байгуулсан байна.

Тус гэрээгээр Үнэлгээний компани нь "Хөрөнгийн үнэлгээний тухай хууль" тогтоомж, үнэлгээний олон улсын стандарт, Санхүүгийн Зохицуулах Хорооны шаардлагад нийцүүлэн Үнэт цаас гаргагчийн зах зээл дэх оролцоо, онцлог байдал стратегийн ач холбогдлыг харгалзан хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хийж тайлан гаргах, Үнэт цаас гаргагчийн нэгж хувьцааны үнэ цэнийг тодорхойлох, Үнэт цаас гаргагчийн 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд тусгагдсан биет болон биет бус ("Милленниум Ай Ти" систем болон бусад программ хангамж) хөрөнгийн үнэ цэнийг бизнесийн үнэлгээнд

ХӨРӨНГИЙН
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

ашиглаж "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 10.5.16 дэх заалтад заасан хөрөнгийн үнэлгээний тайланг боловсруулж өгөхөөр зохицуулсан байна.

Үнэлгээний компани нь гэрээт ажлыг үнэлгээний олон улсын стандарт, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тогтоосон цаг хугацаанд чанартай гүйцэтгэж, үнэн зөв тайлан гаргах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцдаа олж мэдсэн аливаа мэдээллийн нууцлалыг хадгалах, Үнэт цаас гаргагчийн тавьсан үндэслэл бүхий шаардлагыг бүрэн биелүүлж ажиллах, өөрийн гаргасан тайлангийн үнэн зөвийг Үнэт цаас гаргагчийн өмнө бүрэн хариуцах зэрэг үндсэн үүргүүдийг хүлээхийн зэрэгцээ гэрээт ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгээгүй, үйлчилгээг доголдолтой гүйцэтгэсэн тохиолдолд тухайн доголдлыг арилгах, үнэлгээг хийх ажилтан нь үнэлгээчний хариуцлагын даатгалд даатгуулсан байх зэрэг хариуцлага хүлээхээр гэрээгээр зохицуулсан байна.

Үнэт цаас гаргагч нь гэрээт ажлын явцад Үнэлгээний компаниас гэрээгээр хүлээсэн үүргээ өөрийн мэргэжлийн боловсон хүчнийг ашиглан, мэргэжлийн болон стандартын өндөр түвшинд, үнэн зөв, гэрээнд заасан хугацаанд шуурхай биелүүлэхийг шаардах, гэрээний дагуух ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө, гүйцэтгэлийн явц болон гүйцэтгэсэн ажлын талаар бүх талын бүрэн мэдээлэл авах, гэрээт ажлын үр дүнг өмчлөх, гэрээт ажлын цар хүрээнд багтсан аливаа ажлын нэмэлт дүгнэлт, тодорхойлолтыг үнэ төлбөргүйгээр гаргуулах, шаардлагатай тохиолдолд нэмэлт тооцоо судалгаа хийлгүүлэх зэрэг эрх эдлэхийн зэрэгцээ Үнэлгээний компанид шаардлагатай бичиг баримт, мэдээллийг зөвхөн шаардлагатай хэмжээгээр нь гаргаж өгөх, гэрээнд заасан төлбөр тооцоог төлж барагдуулах зэрэг үүргийг гэрээний дагуу хүлээсэн байна.

7.4.2. Оролцогч байгууллагуудын ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх мэдэгдэл

Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч байгууллагууд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Үнэт цаас гаргагчтай холбоотой үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай мэдэгдэл гаргаж, тус тусын тодорхойлох захидал, дүгнэлт тайлангуудад тусгасан болно.

Монголын Хөрөнгийн Биржид ирүүлж байгаа Үнэт цаасны танилцуулга нь Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж байгаа танилцуулгатай адил, ямар нэг зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй болно.

СЭХ
БҮРТГЭВ
№ 21

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

Үнэт цаасны танилцуулга

Гарын үсэг зурах хуудас

Үнэт цаас гаргагч "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК

С.Тулга
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

2022 оны 12 дугаар сарын 08 -ны өдөр

Х.Алтай
Гүйцэтгэх захирал

2022 оны 12 дугаар сарын 08 -ны өдөр

С.Алтаннамар
Ерөнхий нягтлан бодогч

2022 оны 12 дугаар сарын 08 -ны өдөр

Үндсэн андеррайтер "Инвескор Капитал ҮЦК" ХХК

Л.Билгүүн
Гүйцэтгэх захирал

2022 оны 12 дугаар сарын 08 -ны өдөр

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

MONGOLIAN STOCK EXCHANGE

Үнэт цаас гаргагч

ХӨРӨНГИЙН

Андеррайтер

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ



Хавсралт

2022 СЗХ 15
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ ХАВСРАЛТ БАРИМТ БИЧГИЙН ТОВЬЁГ

Дугаар	Баримт бичгийн нэр
1.	Үндсэн Андеррайтерийн тодорхойлох захидал
2.	Аудитын тодорхойлох захидал
3.	Аудитын тайлан
4.	Үнэлгээний тайлан
5.	Хуулийн дүгнэлт
6.	Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар
7.	Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар
8.	Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн нотариатаар баталгаажуулсан хуулбар
9.	Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдүүдийн шийдвэрүүд:
9.1.	Сангийн сайдын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 181 дугаартай “Компанийн нэмж гаргах хувьцааг олон нийтэд санал болгох талаар чиглэл хүргүүлэх тухай” тушаал
9.2.	Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчийн 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дугаартай “Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай” тогтоол
9.3.	Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 37 дугаартай “Нийтэд санал болгох энгийн хувьцааны үнэ, нөхцөл тогтоох тухай” тогтоол
10.	Үнэт цаас гаргагчийн шинэчилсэн дүрмийн төсөл
11.	Үндсэн Андеррайтерийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар
12.	Туслах Андеррайтеруудын улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар
13.	Аудитын компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
14.	Үнэлгээний компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
15.	Хуулийн зөвлөх компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
16.	Үнэт цаас хариуцсан эрх бүхий байгууллагатай харилцах этгээдийн мэдээлэл

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ДТД 2071096
УЛААНБААТАР ХОТ

000266

“ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК” ХХК
InvesCore CAPITAL
6317839 ДТД 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____

Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНД

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
601 тоот, 6 давхар, Даун Таун барилга,
Жамьян Гүний гудамж 18/1, 1-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14240
Утас: 77550077 И-мэйл: info@icapital.mn
Вебсайт: www.icapital.mn

2022.12.08 № А-22/206

АНДЕРРАЙТЕРИЙН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ

"Инвескор Капитал ҮЦК" ХХК (цаашид "**Андеррайтер**" гэх) нь "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК (цаашид "**Үнэт цаас гаргагч**" гэх)-тай 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр МХБ2022/201 дугаартай Андеррайтерийн үйлчилгээний гэрээг байгуулан Үнэт цаас гаргагчийн нэмэлт хувьцаа (цаашид "**Үнэт цаас**" эсхүл "**Хувьцаа**" гэх)-г нийтэд санал болгон гаргах ажиллагаанд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Андеррайтер нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3.1.6-д заасан Андеррайтерийн тодорхойлох захидал (цаашид "**Тодорхойлох захидал**" гэх)-ыг дараах агуулгын хүрээнд гаргаж байна.

1. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулж, хөрөнгө оруулагчдад худалдахад ашиглах арга, хэлбэр;

2. Үнэт цаасны танилцуулга болон бусад баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэн эсэх талаар;

3. Үнэт цаас гаргагчийн хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг амжилттай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэх талаар гаргасан Андеррайтерийн баталгаа.

Андеррайтер нь Үнэт цаасны танилцуулга болон энэхүү Тодорхойлох захидлыг Үнэт цаас гаргахтай холбоотой мэргэжлийн байгууллагуудаас гаргасан тайлан дүгнэлт, шаардлагатай гэж үзсэн мэдээ мэдээлэл, баримт бичгийг Үнэт цаас гаргагчаас гаргуулан авч, тэдгээрт үндэслэн боловсруулсан бөгөөд Үнэт цаас гаргагчаас ач холбогдол бүхий баримт, мэдээ мэдээллийг нуусан, орхигдуулсан, Үнэт цаасны танилцуулга болон энэхүү Тодорхойлох захидлыг бэлтгэх явцад мэдэгдээгүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд Андеррайтер хариуцлага хүлээхгүй. Андеррайтер нь Үнэт цаас гаргагч болон түүний хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэгчээр томилогдсон этгээд болох Сангийн Яам болон Үнэт цаас гаргагч, тэдгээрийн холбоо хамаарал бүхий хуулийн этгээдүүдтэй аливаа байдлаар хамааралгүй хуулийн этгээд бөгөөд бие даасан, хараат бусаар энэхүү Тодорхойлох захидлыг гаргасан болохыг мэдэгдэж байна.

ХӨРӨНГИЙН МОНГОЛЫН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

000267

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore КАПИТАЛ
5317839 1119277128

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2022.12.15
СЭХ
БҮРТГЭВ
2022 №015

1. ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД ХУДАЛДАХАД АШИГЛАХ АРГА, ХЭЛБЭР

Үнэт цаас гаргагч нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 119,157,603 ширхэг хувьцааг нэмж гарган нийтэд санал болгох замаар стратегийн болон жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад арилжаалж нийт 11,915,760,300 төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ны өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон Монголын Хөрөнгийн Биржийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын хүрээнд явагдана.

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасыг олон нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг Үнэт цаасыг бүртгэх тухай Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 (арав) өдөр, хувьцааны захиалгын бүртгэлийг ажлын 5 (тав) өдөрт хийх ба нийтэд санал болгох Хувьцааны арилжааг тогтоосон үнийн аргыг ашиглан зохион байгуулна. Нийтэд санал болгож буй хувьцааны 90 хүртэлх хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад, үлдсэн хэсэг буюу 10 ба түүнээс дээш хувийг олон нийтэд хуваарилахаар төлөвлөсөн болно.

Стратегийн хөрөнгө оруулагчдаас анхдагч зах зээлийн захиалгыг Үнэт цаас гаргагчийн андеррайтерууд, олон нийтээс анхдагч зах зээлийн захиалгыг Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан тус тус авна. Стратегийн хөрөнгө оруулагч нь хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 6 (зургаа)-аас доошгүй сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахгүй байх үүрэг хүлээх нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн 100,000,000 төгрөгөөс дээш үнийн дүн бүхий Хувьцаа худалдан авахаар захиалах хөрөнгө оруулагч байна.

Анхдагч зах зээлийн арилжааг тогтоосон үнийн аргаар, стратегийн хөрөнгө оруулагчид болон жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад нэг үнийн түвшинд явуулах ба стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг бүтэн дүнгээр биелүүлж, олон нийтээс худалдан авах захиалгын тоо ширхэг худалдах захиалгын тоо ширхгээс илүү гарсан тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг ашиглана. Хувь тэнцүүлэх аргаар хуваарилалт хийхэд захиалгын үнийн болон цаг хугацааны ахлах дараалал үйлчлэхгүй.

2. ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА БОЛОН БУСАД БАРИМТ БИЧГИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ БЭЛТГЭСЭН ТАЛААР

Үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахтай холбоотой боловсруулагдсан Үнэт цаасны танилцуулга болон бусад баримт бичгүүд нь "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль", "Компанийн тухай хууль", Монгол Улсын Их хурлын 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаартай "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" тогтоол, болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулагдаж бэлтгэгдсэн болно.

Үнэт цаас гаргагч нь "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН (цаашид "**Хуулийн зөвлөх**" гэх)-тэй 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Д-С1272231 дугаартай "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ"-г Үнэт цаасыг олон нийтэд санал болгон гаргах ажиллагаанд хууль зүйн дүгнэлт гаргуулахаар харилцан тохиролцож байгуулсан. Хуулийн зөвлөх нь "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 10.6 дахь хэсэгт заасны дагуу Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ

InvesCore CAPITAL
6317 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг хянаж энэ талаар Хуулийн дүгнэлт (цаашид "**Хуулийн дүгнэлт**" гэх)-дээ тусгасан болно. Хуулийн зөвлөх нь Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2.6 дахь хэсэгт заасан зохицуулалтын хүрээнд Хуулийн дүгнэлтийг үйлдсэн байна.

Үнэт цаас гаргагч нь "Грант Торнтон Аудит" ХХК (цаашид "**Аудитын компани**" гэх)-тай 2022 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр 2022/56 дугаартай "Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулан Үнэт цаас гаргагчийн 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй зэргийг багтаасан санхүүгийн тайлангууд нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхийг үнэлж хөндлөнгийн аудитын дүгнэлт (цаашид "**Аудитын дүгнэлт**" гэх) гаргасан. Аудитын компани нь Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2.8 дахь хэсэг болон хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргахтай холбоотойгоор хэрэглэгдэх холбогдох хууль тогтоомж, стандартуудын дагуу Аудитын дүгнэлтийг үйлдсэн.

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас санал болгон гаргахтай холбоотойгоор хөндлөнгийн хөрөнгийн үнэлгээний компани болох "Гэрэгэ Эстимэйт" ХХК (цаашид "**Үнэлгээний компани**" гэх)-тай 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр МХБ2022/203 дугаартай "Үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээ"-г байгуулсан. Үнэлгээний компани нь "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 4.1.5 дахь заалтад заасан Үнэт цаасны танилцуулга бэлтгэх, нийтэд нэмж Хувьцаа санал болгон гаргах ажиллагааны хүрээнд үнэлгээний олон улсын стандарт (ҮОУС) болон "Хөрөнгийн үнэлгээний тухай хууль"-ийн дагуу бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийж, тайланг боловсруулан гаргасан байна.

Үнэт цаас гаргагчийн Үнэт цаасаа нийтэд нэмж санал болгон гаргахтай холбогдуулан мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн дээрх компаниуд нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх болохоо баталгаажуулсан ба тус бүрийн хариуцан бэлтгэсэн тайлан дүгнэлтийн үнэн зөв байдлыг хариуцах болохоо илэрхийлсэн. Үнэт цаас гаргахтай холбогдсон ажиллагаанд оролцогч байгууллагууд нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан, мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх эрх бүхий байгууллагууд юм. Үнэт цаас гаргагчид мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдүүд нь Үнэт цаас гаргагчтай аливаа сонирхлын зөрчилгүй, холбоо хамааралгүй этгээд болохоо мэдэгдэж, аливаа сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай мэдэгдлүүдийг хүргүүлснийг Үнэт цаасны танилцуулгад хавсаргасан болно.

Андеррайтер нь Үнэт цаасны танилцуулгыг бэлтгэж боловсруулахдаа Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн цаасан болон цахим хэлбэрийн мэдээ мэдээлэл баримт материал болон хөндлөнгийн Аудитын компани, Үнэлгээний компани, Хуулийн зөвлөхийн гаргасан тайлан, дүгнэлтийг үндэслэж, холбогдох судалгаа шинжилгээг хийж ажилласан болно. Үнэт цаасны танилцуулга дахь мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг Хуулийн зөвлөх, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг Аудитын компани тус тус хянаж, дүгнэлт гаргасан болно. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн холбогдол бүхий мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх талаар Хуулийн дүгнэлтийн Удиртгал хэсэг болон 8 дугаар зүйлтэй танилцаж дэлгэрэнгүй мэдээллийг авч болох бөгөөд Үнэт цаас гаргагчийн Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр хэмээн Хуулийн зөвлөх дүгнэсэн. Андеррайтер болон Үнэт цаас гаргагч нар нь Үнэт цаасны танилцуулгыг боловсруулж бэлтгэхдээ "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжид

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

нийцүүлэн бэлтгэх, хөрөнгө оруулагчийг хөрөнгө оруулах шийдвэрээ гаргахад шаардлагатай гэж үзсэн бүхий л мэдээллүүдийг тусгахыг зорьсон болно.

Үнэт цаасны танилцуулгын бүрдлийн хувьд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3 дугаар зүйл, Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр зүйлд заасан мэдээлэл, баримт бичгийн бүрдлийг хангасан болохыг Андеррайтер нь үүгээр мэдэгдэж байгаа бөгөөд Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх удирдлагын хариуцлагын мэдэгдэлд Үнэт цаас гаргагч нь "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль", Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Үнэт цаасыг олон нийтэд санал болгож бүртгүүлэх, хөрөнгө оруулагчдад танилцуулахтай холбогдсон шаардлагатай бүхий л баримт бичгийг үнэн зөвөөр бүрдүүлсэн болно. Үнэт цаас гаргагч нь энэхүү Үнэт цаасны танилцуулгад хавсаргасан аливаа мэдээ мэдээлэл, баримт материалыг үнэн зөвөөр холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрэн гүйцэд бүрдүүлсэн бөгөөд энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл, баримт бичигтэй зөрчилдсөн эсхүл хуурамчаар бүрдүүлсэн аливаа баримт материал байхгүй болохыг илэрхийлж энэхүү хариуцлагын мэдэгдлийг гарган баталгаажуулж байна" гэсэн байгаа нь "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 9.14 дэх хэсэгт "Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичигт үнэн зөв мэдээлэл тусгах бөгөөд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас бусдад хохирол учруулсан тохиолдолд уг хохирлыг үнэт цаас гаргагч, уг шийдвэрийг гаргасан эрх бүхий албан тушаалтан хамтран хариуцна" гэсэн шаардлагын хүрээнд баталгаа гаргасан болно.

3. АНДЕРРАЙТЕРИЙН ГАРГАХ БАТАЛГАА

"Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 41.4.5 дахь заалтын дагуу Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгосон Үнэт цаасыг худалдан авагүй нөхцөлд тухайн үнэт цаасыг гэрээгээр тохиролцсон үнээр худалдан борлуулах үүрэг хүлээсэн бөгөөд Андеррайтер, туслах андеррайтеруудын хамт Үнэт цаас гаргагчийн хувьцааны арилжаалагдаагүй үлдсэн хэсгээс Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56.5 дахь хэсэг заасан хязгаарлалтын хүрээнд худалдан авах үүрэг хүлээнэ. Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн Хувьцааны үнийн хэт өндөр өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 6 (зургаа) сарын хугацаанд гүйцэтгэнэ.

Үнэт цаас гаргагчийн Хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг амжилттай зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтийг татан төвлөрүүлэхийн тулд Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, төсөөлөл, бизнес үнэлгээ зэрэг мэдээллийг нягтлан үзсэн ба тэдгээрийн үндсэн дээр Үнэт цаас гаргагчийн нэмж гаргах 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 119,157,603 ширхэг Хувьцааг хөрөнгө оруулагчдад санал болгон гаргаж Үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу 11,915,760,300 төгрөгийг татан төвлөрүүлэх боломжтой хэмээн дүгнэж байна.

Санхүүгийн үзүүлэлт, төлөвлөгөө

Үнэт цаас гаргагч нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Кэй Пи Эм Жи Аудит" ХХК-аар, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Грант Торнтон Аудит" ХХК-аар, 2020 болон 2021 онуудын жилийн эцсийн тайланд хөндлөнгийн аудит "Үндэсний Аудитын Газар"-аар

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан. 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд "Грант Торнтон Аудит" ХХК-аар хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан.

Санхүүгийн тайлангийн шинжилгээ

Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлангийн түүхэн үзүүлэлтээс үзвэл Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгө нь 2018 оноос 2021 хооронд жилд дунджаар 4.3 тэрбум төгрөгийн нийт хөрөнгөтэй байсан байна.

2022 оны эхний хагас жилийн байдлаар хөрөнгийн дахин үнэлгээг хийлгэж, дахин үнэлгээний үр дүнд үндсэн хөрөнгө буюу барилгын үнэлгээ 3.0 тэрбум төгрөгөөр, биет бус хөрөнгийн дүн 15.8 тэрбум төгрөгөөр, нийт хөрөнгө 18.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Түүхэн үзүүлэлтээр барилга, газрын үнийн дүн зах зээлийн үнэлгээнээс харьцангуй бага үнэлгээгээр санхүүгийн тайланд бүртгэгдэж байсан ба бодит үнэ цэнийг 2022 оны 6 дугаар сарын 30-ний өдрөөр тогтоолгож, дахин үнэлсэн.

Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө буюу Үнэт цаас гаргагчийн байрлаж буй "Монголын Хөрөнгийн Бирж"-ийн байр нь Хуулийн дүгнэлт гарах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдээгүй болохыг Хуулийн зөвлөх тэмдэглэсэн байна. Учир нь "Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хууль"-д заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг Эрхийн улсын бүртгэлд бүртгэх журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газар батлах зохицуулалттай. Тус зохицуулалтын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яаманд ажлын хэсэг ажиллаж байгаа ба төрийн болон орон нутгийн өмчит компанийн үл хөдлөх эд хөрөнгийг Эрхийн улсын бүртгэлд бүртгэх тухай журам батлагдсаны дараа Үнэт цаас гаргагчийн эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлэх боломжтой болохоор байна хэмээх агуулгаар Хуулийн дүгнэлтэд тусгагдсан. Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь 34 хувийн хувьцаагаа нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй болсноор төрийн өмчит хуулийн этгээд биш, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болох ба үүнтэй холбогдуулан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгөө улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон тусгайлсан зохицуулалт үйлчлэхгүй болж, Үнэт цаас гаргагчийг ердийн журмаар үл хөдлөх эд хөрөнгөө улсын бүртгэлд бүртгүүлэх боломжтой хэмээх агуулга бүхий дүгнэлтийг Хуулийн зөвлөх үйлдсэн байна.

Биет бус хөрөнгөд газар эзэмших эрх хамаардаг ба 2022 оны эхний хагас жилд газар эзэмших эрхийг дахин үнэлснээр биет бус хөрөнгө нийт хөрөнгөд эзлэх хэмжээгээрээ 68.5 хувьд хүрсэн байна. Биет бус хөрөнгийг арилжааны цогц систем болох "Миллениум Ай Ти" систем (7.3 тэрбум төгрөгөөр үнэлэгдсэн) болон газар эзэмших эрх (10.5 тэрбум төгрөгөөр үнэлэгдсэн) бүрдүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн эргэлтийн хөрөнгийн дийлэнх хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө бүрдүүлдэг ба дансны авлага, бараа материал болон бусад эргэлтийн хөрөнгө хэлбэрээр байх нь ховор байдаг нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлогоор тайлбарлагдана. Үнэт цаас гаргагчийн дансны авлагыг гишүүн үнэт цаасны компаниуд болон бүртгэлтэй компаниудын хураамжийн авлага бүрдүүлдэг байна.

2018 оноос 2022 оны түүхэн дунджаар Үнэт цаас гаргагчийн нийт эх үүсвэрийн 68.1 хувийг эздийн өмч, 29.1 хувийг дансны өглөг ба бусад өглөг, 2.2 хувийг бусад богино хугацаат өр төлбөр бүрдүүлж байгаа нь Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн дийлэнх хэсгийг өөрийн хөрөнгөөр

Үнэт цаас гаргагч

000271

Андеррайтер

санхүүжүүлж байгааг харуулж байна. Үнэт цаас гаргагч нь 2018 онд 20.3 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай байсан ба жил бүрийн тайлант үеийн ашиг, алдагдлаар хуримтлагдсан алдагдлыг нөхөж, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 18.7 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай байна. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч нь Монголын Хөрөнгийн Биржид хөрөнгө шилжүүлэх, санхүүжилт олгох зэргээр "Милленниум Ай Ти" арилжааны системийн санхүүжилтэд дэмжлэг үзүүлж байсан ба 2015 онд "Кэй Пи Эм Жи Аудит" ХХК-аар санхүүгийн тайланд аудит хийлгэхдээ "Милленниум Ай Ти" арилжааны системийн санхүүжилтийг Үнэт цаас гаргагчийн балансын бүртгэлд тусгах шаардлагатай хэмээн үзэж, хувьцаа эзэмшигчдийн бусад өмчийг 20.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, нөгөө талаас хуримтлагдсан ашгийг "Милленниум Ай Ти" арилжааны системийн хорогдуулсан дүнгээр бууруулсан нь Монголын Хөрөнгийн Биржийн хуримтлагдсан алдагдлыг 16.7 тэрбум төгрөгт хүргэсэн.

График 1. "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн эх үүсвэрийн бүтэц
Сая төгрөг, 2018-2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн аудитлагдсан тайлан

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлого, ашигт ажиллагаа Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн зах зээлийн идэвхжилээс хамаардаг ба борлуулалтын орлогын дийлэнх хувийг арилжааны шимтгэлийн орлого, тэр дундаа хувьцааны арилжааны шимтгэлийн орлого бүрдүүлдэг байна. 2021 онд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буюу Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компаниудын үнэлгээ 5.9 их наяд төгрөгт хүрч, нийт 1.4 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаас арилжаалагдсанаас 21.6 хувийг хувьцааны, 74 хувийг компанийн бондын арилжаа тус тус бүрдүүлж байв. Үүнтэй холбоотойгоор 2021 онд нийт борлуулалтын орлого 5.5 тэрбум төгрөгт хүрсэн ба энэ нь 2018 онтой харьцуулахад 231.0 хувиар өссөн үзүүлэлт байна.

Үнэт цаас гаргагч

000272

Андеррайтер

График 2. "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн орлогын бүтэц
Сая төгрөг, 2018-2021 он, 2022 оны эхний хагас жил



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн аудитлагдсан тайлан

Үнэт цаас гаргагч нь 2018-2020 онуудад дунджаар 1.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол Ковид-19 цар тахлын үед Засгийн газраас эдийн засгийг дэмжих арга хэмжээнүүд авч, зах зээл дэх зээлийн хүүгийн түвшин бууруулах нөхцөлийг бүрдүүлснээр хөрөнгийн зах зээлийн идэвхжилийг нэмэгдүүлсэн гэж хэлж болох ба үүнтэй холбоотой Үнэт цаас гаргагчийн цэвэр ашиг нь 2021 онд 3.1 тэрбум төгрөгт хүрч, 58.1 хувийн цэвэр ашгийн маржинтай ажилласан байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 447.0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Санхүүгийн дунд хугацааны санхүүгийн төсөөлөл

Монголын эдийн засаг, тэр дундаа хөрөнгийн зах зээл нь дунд болон урт хугацаанд өсөх хандлагатай байгаа бөгөөд Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд 2027 оны эцэст хөрөнгийн зах зээлийн үнэлгээ дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувьд хүрнэ гэж төсөөлсөн нь бодитой хэмээн Андеррайтерийн зүгээс үзэж байна.

Системийн нөлөө бүхий банкнууд болон төрийн өмчит компаниуд Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа нийтэд санал болгож, нээлттэй хувьцаат компаниуд болсноор Монголын Хөрөнгийн Бирж дээрх бүртгэлтэй компаниудын зах зээлийн үнэлгээ хамгийн багадаа 10 их наяд төгрөг, 2021 оны байдлаарх зах зээлийн үнэлгээнээс 2 (хоёр) дахин өсөхөөр байна.

Дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй үнэт цааснуудын арилжааны хөрвөх чадвар гэж үзэх нийт зах зээлийн үнэлгээнд эзлэх үнэт цаасны жилийн арилжааны үнийн дүнгийн хэмжээ 2027 онд 10 хувьд хүрнэ гэсэн төсөөлөлтэй байна.

Хүснэгт 1. Монголын Хөрөнгийн Биржийн зах зээлийн өсөлтийн төсөөлөл

	2018	2019	2020	2021	2022*	2023*	2024*	2025*	2026*	2027*
Зах зээлийн үнэлгээ/ДНБ	7.7%	7.1%	8.1%	13.7%	12.4%	18.0%	20.0%	25.0%	25.0%	25.0%
Зах зээлийн хөрвөх чадвар	8.5%	3.7%	1.7%	3.6%	2.9%	5.0%	7.0%	8.0%	9.5%	10.0%

Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

2022-12-15
БҮРТГЭВ-02
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ
InvesCore CAPITAL
6317839
000273

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

Мөн Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар тогтоолын дагуу батлсан “Засгийн газрын өрийн удирдлагын 2022-2025 оны стратегийн бичиг баримт”-д зааснаар Засгийн газрын үнэт цаас дотоодын нээлттэй зах зээлээр арилжаалахаар байгаа нь Үнэт цаас гаргагчийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүлээлттэй байна.

Үнэт цаас гаргагч нь 5 жилийн стратеги төлөвлөгөөгөө боловсруулж, үнэт цаас гаргагчдад болон хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэхээр стратегийн зорилтуудаа тодорхойлсон бөгөөд санхүүгийн төсөөллөө эдийн засгийн, хөрөнгийн зах зээлийн төсөөлөлтэй уялдуулсан байна.

График 3. “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн орлогын төсөөлөл
Сая төгрөг, 2021 оны гүйцэтгэл, 2022-2027 оны төсөөлөл



Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө

2021 онд Үнэт цаас гаргагч нь 5.5 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан бол цаашид жилд дунджаар 27 хувийн жигнэсэн дундаж нийлмэл өсөлттэй ажиллах төлөвлөгөөтэй байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүн, зах зээл, арилжааны идэвхийн хүлээлт дээр үндэслэсэн болно. Үнэт цаас гаргагч нь арилжааны шимтгэлээ бууруулахаар төсөөлсөн ба орлогын эх үүсвэрээ төрөлжүүлэх, арилжаалах бүтээгдэхүүнээ төрөлжүүлэхээр ажиллаж байна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлог нь хувьсах зардал багатай үйл ажиллагаа явуулдаг ба зах зээл өсөж, арилжааны шимтгэлийн дүн нэмэгдэх тусам цэвэр ашгийн маржин нэмэгдэх төсөөлөлтэй байна. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлого зах зээл өсөхийн хирээр нэмэгдэж, санхүүжилт татах компаниуд болон хөрөнгө оруулагчид ихэссэнээр тэдгээрийн хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн үйлчилгээ явуулахын тулд системийн болон бусад хөрөнгө оруулалтууд тогтмол хийж байхаас өөр их дүнтэй зардлууд гаргах шаардлага байхгүй байна.

МОНГОЛЫН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ

000274

“ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК” ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022 12 15 өдөр
БҮРТГЭВ
№ 07

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ 02

Үнэт цаас гаргагч нь 2022-2027 оны дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөний хүрээнд цаашдын төгтвортой өсөлтийг хангаж, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэхээр төлөвлөсөн ба эздийн өмчийн өгөөжийг ирэх 5 жилүүдэд 12-27 хувьтай байхаар төсөөлсөн байна.

Бизнесийн Үнэлгээ

Үнэт цаас гаргагчийн хөндлөнгийн бизнесийн үнэлгээг "Гэрэгэ Эстимэйт" ХХК (цаашид **"Үнэлгээний компани"** гэх) гүйцэтгэсэн ба бизнесийн үнэлгээг үндсэн 3 хандлагаар тооцож гаргасан байна.

Хүснэгт 2. Үнэлгээний үр дүн

Үнэлгээний хандлага	Үнэлгээний арга	Бизнесийн үнэ цэн
Зах зээлийн харьцуулалтын арга	Үнийн үржүүлэгчийн арга	35.6 - 38.2 тэрбум төгрөг
Орлогын хандлага	Хорогдуулсан мөнгөн урсгалын арга (Эздийн чөлөөт мөнгөн урсгалын загвар буюу Free Cash Flow to Equity)	23.7 тэрбум төгрөг
Хөрөнгөд суурилсан арга	Цэвэр хөрөнгийн өртгийн арга	23.7 тэрбум төгрөг
Эцсийн үнэлгээ		**36.7 тэрбум төгрөг**

Эх сурвалж: "Гэрэгэ Эстимэйт" ХХК-ийн Үнэлгээний тайлан

Үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны онцлог, бизнесийн өнөөгийн нөхцөл байдал, үнэлгээний ажлын зорилготой уялдуулан үнэлгээний эцсийн үр дүнг орлогын хандлагаар хийж гүйцэтгэсэн үр дүнгээр дүгнэсэн болно.

Үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчийн бизнес өмчлөлийн үнэ цэнийг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 36,753,598,659 (гучин зургаан тэрбум долоон зуун тавин гурван сая таван зуун ерэн найман мянга зургаан зуун тавин ес) төгрөг байхаар тооцоолов. Энэхүү үнэлгээ нь 34 хувийн эзэмшлийн хувьцааг нийтэд санал болгож, эх үүсвэр татан төвлөрүүлж, компанийн үйл ажиллагааг өргөжүүлсний дараах буюу Post-money үнэлгээ юм. Бизнесийн үнэлгээний үр дүнгээрх нэгж энгийн хувьцааны үнэ 104.87 төгрөг байгаа ба Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн хурлын 37 тоот тогтоолоор нэгж хувьцааны үнийг 100 төгрөгөөр нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн. Энэхүү үнэлгээ нь Үнэлгээ/Дансны үнийн (Price/Book value) харьцаагаар 1.0 байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь нийт 11.9 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр төлөвлөж байгаа ба татан төвлөрүүлсэн хөрөнгийг техник, технологийн шинэчлэл, сайжруулалт, үйл ажиллагааны цахимжуулалт, сургалт үйлчилгээний төв бий болгохоор төлөвлөж байна. Тодруулбал, татан төвлөрүүлсэн хөрөнгийн 64 хувийг арилжааны системийн сайжруулалтад, 11 хувийг мэдээлэл технологийн аюулгүй байдалд, 6 хувийг дотоод үйл ажиллагааны цахимжуулалтад, үлдсэн 19 хувийг хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгоход зарцуулахаар төлөвлөсөн.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ГЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2022.12.15
он сар өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-12-12
БҮРТГЭВ-02

Эрсдэлийн удирдлагын байдал, учирч болох эрсдэлийн талаар

Үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагын мөрдөх хууль, журмын дагуу холбогдох зохицуулалтын шаардлагыг тогтмол ханган биелүүлж, эдийн засгийн таагүй нөхцөл байдлаас гарах эрсдэлийг бууруулж, бизнесийн тогтвортой хөгжлийг хадгалахыг эрмэлзэж иржээ.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, макро эдийн засгийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хүний нөөцийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, хөрвөх ба төлбөрийн чадварын эрсдэл, борлуулалтын орлого болон зардлын төсөөлөл биелэхгүй байх эрсдэл, стратегийн эрсдэл, комплаенс, хууль зүйн эрсдэл, нэр хүндийн эрсдэл, өрсөлдөөний эрсдэл, давагдашгүй хүчин зүйлийн эрсдэл, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой эрсдэлүүдийг тодорхойлсон.

Үнэт цаас гаргагчийн арилжааг зохион байгуулж, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн өндөр ач холбогдолтой байгууллагын хувьд мэдээллийн технологийн эрсдэл, мэдээллийн аюулгүй байдал нь онцгой ач холбогдолтой байдаг. Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа ISO/IEC 17799:2005, ISO 27001:2013, ISO/IEC 38500:2015 стандартуудын дагуу боловсруулагдсан Үнэт цаас гаргагчийн "Мэдээллийн технологийн цогц журам"-ыг мөрдөж, хяналт тавьж ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь мэдээлэл, технологийн цогц дэд бүтцийг бүрэн бүрдүүлснээс гадна мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангахад ихээхэн анхаарч ажилладаг. Тухайлбал, Үнэт цаас гаргагч нь олон улсын стандартын дагуу мэдээлэл технологийн үндсэн болон нөөц төвтэй бөгөөд цахилгааны тасалдлын үед ажиллах нөөц цахилгаан генератортой, мэдээллийн нууцлалын баталгааг олон улсын стандартын дагуу хангаж ажилладаг.

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй Миллениум Ай Ти систем нь ISO 9001:2008 олон улсын чанарын стандартад нийцсэн бөгөөд системийн тусламж үйлчилгээг "Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп"-ийн охин компани болох "Миллениум Ай Ти" компаниас тогтмол авдаг. Гэрээний нөхцөлд тус системийн тасралтгүй ажиллагааны доод хязгаарыг 99.6 хувиар тогтоосон байдаг.

Технологийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахад Мэдээллийн Технологийн алба томоохон үүрэг гүйцэтгэдэг ба техник хангамж, виртуалчлал, дотоод систем, веб технологи, сүлжээ, тусгай зориулалтын программ хангамжийн аюулгүй байдал, нөөцлөлт, өгөгдлийн сан тус тус хариуцсан мэргэжилтнүүд ажиллуулдаг байна.

Үнэт цаас гаргагч нь "Мэдээллийн технологийн цогц журам"-ын дагуу мэдээллийн аюулгүй байдлыг хангахад анхаарч ажилладаг бөгөөд арилжааны үндсэн системийн хувьд "Милленниум Ай Ти" компанийн "Мэдээллийн аюулгүй байдлын бодлого"-ыг хэрэгжүүлэн ажилладаг.

4. ДҮГНЭЛТ

Андеррайтер нь өөрийн судалгаа шинжилгээ, хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дүгнэлт болон холбогдох бусад баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн нэмж гаргах хувьцааг анхдагч зах зээл дээр нэг бүрийн үнийг 100 төгрөгөөр, нийт 119,157,603 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар санал болгон 11,915,760,300 төгрөгийг стратегийн болон жижиглэнгийн хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлэх боломжтой гэж дүгнэж байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2021096
УЛААНБААТАР ХОТ

000276

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6367839 ... 119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2022.12.15
он сар өдөр
БҮРТГЭВ

Энэхүү Тодорхойлох захидал нь Үнэт цаас гаргагчийн итгэл үнэмшилд тулгуурлан хийгдсэн ба ирээдүйн төсөөлөл, таамаглал, биелэлтийн баталгаа болохгүй бөгөөд хөрөнгө оруулагчид нь компанийн үйл ажиллагаа, Үнэт цаасны танилцуулга, холбогдох эрсдэл, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Л.БИЛГҮҮН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

000277

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Grant Thornton

"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр 9 давхар, ЮНЕСКО гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар 14230, Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 fl, UNESCO street, Sukhbaatar District-1, Ulaanbaatar 14230, Mongolia
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Тодорхойлох захидал

"Инвескор Капитал ҮЦК" ХХК-д

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Улсын Их Хурлын "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" 16 дугаар тогтоол, 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн Засгийн газрын "Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай" 244 дүгээр тогтоолд тус тус үндэслэн нээлттэй хувьцаат компани болохоор хувьцаагаа олон нийтэд санал болгож байна.

Энэхүү хувьцаагаа нийтэд санал болгох үйл ажиллагааны хүрээнд "Грант Торнтон аудит" ХХК нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 2021 оны 06 дугаар сарын 30-ний байдлаарх завсар үеийн санхүүгийн тайланд аудит хийсэн бөгөөд тус компанийн зүгээс хувьцаагаа нийтэд санал болгохтой холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэхээр хүргүүлж буй үнэт цаасны танилцуулга, уг танилцуулгад багтсан нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн мэдээлэл нь аудитлагдсан санхүүгийн тайлангийн мэдээлэлтэй тохирч байгаа эсэхийг Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 6 дугаар сарын 11-ний 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу хяналт хийлээ.

Бидний гүйцэтгэсэн аудитлагдсан санхүүгийн тайлан нь СЗХ-д хүргүүлэх материалд багтсан ба Үнэт цаасны танилцуулгад багтсан дараах санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг бид хянасан. Үүнд:

А. Үнэт цаасны танилцуулгын 1.3-д Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид, тэдгээрийн холбогдох этгээдийн мэдээлэл

Б. Үнэт цаасны танилцуулгын 2.10-д Үнэт цаас гаргагчийн хэлцлийн мэдээлэл

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Grant Thornton

B. Үнэт цаасны танилцуулгын 2.12-д Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, шинжилгээний талаар дурьдсан ба иж бүрэн аудитлагдсан тайлангаас бэлтгэгдсэн Хураангуй санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн тооцсон санхүүгийн голлох ахрьцаа, ашигт ажиллагааны үзүүлэлтүүд

Энэхүү захидалтай холбогдуулж дараах зүйлсийг мэдэгдэж байна. Үүнд:

1. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус, сонирхлын зөрчилгүй бөгөөд хууль болон холбогдох ёс зүйн шаардлагуудын дагуу үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.
2. Бид үнэт цаас гаргагч "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон бусад мэргэжлийн оролцогч нартай аливаа сонирхлын зөрчилгүй бөгөөд үүсэж болзошгүй сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу авч хэрэгжүүлнэ.
3. Үнэт цаасны танилцуулгын Хавсралтад харуулсан аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүгнэлтэд компанийн 2021 оны 06 дугаар сарын 30-наарх завсар үеийн санхүүгийн тайлан нь материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-д нийцсэн гэж дүгнэсэн.
4. Үнэт цаасны танилцуулгын 1.3-д Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, түүний холбоотой этгээдийн мэдээлэл тохирч байна. Бид хувьцаа эзэмшигчтэй холбоотой мэдээллүүдийг шалгахдаа дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:
   - Үнэт цаасны танилцуулгад дурьдсан хувьцаа эзэмшигчидтэй холбоотой түүхэн мэдээллүүдийг аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын хүрээнд цуглуулсан нотлох баримтуудтай тулган шалгасан.
   - Уг түүхэн мэдээллийг боловсруулсан дата мэдээллийг нягталсан.
5. Үнэт цаасны танилцуулгын 2.10-д Үнэт цаас гаргагчийн хэлцлүүдийн талаар дурьдсан ба Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн аливаа гэрээ хэлцэл байгуулаагүй байна гэж хуулийн дүгнэлтээр тодорхойлсон.

   Аудит хийгдсэн 2022 оны эхний 6 сарын байдлаар Үнэт цаас гаргагч нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүд байгуулаагүй тул хуулийн дүгнэлт нь бодит байдалтай нийцэж байна.
6. Үнэт цаасны танилцуулгын 2.12-д Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн шинжилгээ, харьцааны үзүүлэлтүүдийг

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР КАПИТАЛ ТӨК ХК
InvesCore
www.grantthornton.mn
CAPITAL
6317839
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

харуулсан ба Хураангуй санхүүгийн тайлан нь аудитлагдсан санхүүгийн дүнтэй тохирч байна.

Харьцааны болон санхүүгийн зохистой харьцааны үзүүлэлтүүдийг үнэн зөв тооцсон байна.

Үүнтэй холбоотой дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Үнэт цаасны танилцуулгад дурьдсан санхүүгийн түүхэн мэдээллийг аудитлагдсан санхүүгийн тайлангийн тоо мэдээтэй тулгасан.
- Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд дээр үндэслэн тооцоолсон компанийн хөрөнгө, түүний эх үүсвэр, эздийн өмчийн бүтэц, хувь хэмжээ, орлого зардлын бүтэц, хуримтлагдсан алдагдлын талаарх график мэдээллүүдийг давтан шалгасан.
- Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд дээр үндэслэн гаргасан санхүүгийн тайлангийн голлох харьцаанууд, ашигт ажиллагааны харьцааны үзүүлэлтүүдийг давтан тооцоолсон.

7. Үнэт цаасны бүртгэлийн журмаар шаардсан бусад асуудал

Бид 2021 оны 06 дугаар сарын 30-наар дуусгавар болсон завсар үеийн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь СТОУС-д нийцэж буй эсэх, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үр ашигтай байдлыг хангаж чадаж байгаа эсэхийг үнэлэх зорилгоор тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг гүйцэтгэсэн.

Бидний дүгнэлтээр, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг компанийн удирдлага тогтоосон ба 2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар энэхүү дотоод хяналтын дүрэм, журмаар тогтоосон процедурын дагуу санхүүгийн тайлангийн үр дүнтэй дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна гэж дүгнэсэн.

Дотоод хяналтыг шалгах аудитын горимын үр дүнд компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь СТОУС-д нийцсэн, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, түүний үр ашигтай байдлыг хангаж байна гэж дүгнэсэн. Үүнтэй холбоотой дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Компанийн санхүүгийн тайлангийн дотоод хяналт, үүнд хяналтын орчин, эрсдэлийн үнэлгээ, хяналтын үйл ажиллагаа, мэдээлэл болон харилцаа, мониторинг зэргийн талаар ойлголт олж авсан ба эдгээр хяналтуудын талаар даган мөшгих сорил гүйцэтгэсэн.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХӨӨ УДААНБААТАР ХОТ
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК ХХК
www.grantthornton.mn
InvesCore CAPITAL
000280

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

- Эдгээр горимын үр дүнд компанийн санхүүгийн тайлангийн дотоод хяналтад томоохон сул тал илрээгүй ба сайжруулах шаардлагатай зарим нэг асуудлын талаар компанийн удирдлагад зөвлөмж хүргүүлсэн.

8. Гүйцэтгэсэн аудитын горимуудтай холбоотой хязгаарлалтууд

- Үнэт цаасны танилцуулгыг хянаж дүгнэлт гаргах эдгээр аудитын горимууд нь зөвхөн санхүүгийн түүхэн мэдээллийг хамарсан ба дунд хугацааны бодлого, стратеги төлөвлөгөө болон санхүүгийн хэтийн төсөөллийг хамраагүй болно.
- Бид 2021 оны 06 дугаар сарын 30-ы өдрөөс хойших дараа үеийн санхүүгийн тайланд аудит хийгээгүй учир уг өдрөөс хойш энэхүү захидал гарах хүртэлх санхүүгийн мэдээллийг аудитлаагүй болно.
- Дээр дурдсан горимууд нь хууль тогтоомж болон СЗХ-ны дүрэм журмын шаардлагын хүрээнд хийгдсэн ба эдгээр горимуудаар бид үнэт цаасны танилцуулгатай холбоотой бүх асуудлуудыг илрүүлэх шаардлагагүй бөгөөд танилцуулгад орсон бүх мэдээллүүд нь үнэн зөв эсэхэд ямар нэгэн баталгаа өгөхгүй.
- Эдгээр горимын үр дүнд бидний анхааралд өртсөн зөрүүтэй илэрхийлэл илрээгүй боловч үнэт цаасны танилцуулгад дурьдсан хяналт хийгдээгүй бусад мэдээллүүд нь бидний хяналт хийсэн санхүүгийн мэдээлэл болон холбогдох дүрэм, журамд нийцэж байгаа гэдэгт итгэж байна.
- Энэхүү тайланг зөвхөн үнэт цаас гаргахтай холбоотой андеррайтерийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор бэлтгэсэн бөгөөд өөр бусад зорилгоор бэлтгээгүй болно.

GRANT THORNTON AUDIT LLC
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ

Б.ӨСОРГАРАВ
УДИРДАХ ПАРТНЕР

Улаанбаатар, Монгол улс
Огноо: 2022 оны 12 дугаар сарын 08

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277123
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Grant Thornton

Завсар үеийн Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

Монголын хөрөнгийн бирж ТӨХК

2022 оны 06 дугаар сарын 30-наар дуусвар болсон хугацааны хувьд

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCor CAPITAL
000282

Үнэт цаас гаргагч _____

Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	3
Компанийн талаарх мэдээлэл	4
Удирдлагын мэдэгдэл	5
Хараат бус аудиторын дүгнэлт	6
Завсар үеийн санхүүгийн байдлын тайлан	11
Завсар үеийн орлогын дэлгэрэнгүй тайлан	12
Завсар үеийн өмчийн өөрчлөлтийн тайлан	13
Завсар үеийн мөнгөн гүйлгээний тайлан	14
Завсар үеийн санхүүгийн тайлангийн тодруулгууд	15

ХӨРӨНГИЙН БИРЖ ХХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

000283

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
ТЭВ-02

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын олон улсын стандарт
БҮЦАА	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө
БҮЦБДО	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө
МҮЦКТ	Монголын үнэт цаасны клирингийн төв
МХБ	Монголын хөрөнгийн бирж
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББОУСЗ	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮОУС	Үнэлгээний олон улсын стандарт
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

000284

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Компанийн талаарх мэдээлэл

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Компанийн нэр:	"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК	
Үүсгэн байгуулах шийдвэр:	Засгийн газрын 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 22 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдсан.	
Гэрчилгээ ба лиценз	Монгол Улсын Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж 9012001021 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.	
Төлөөлөн удирдах зөвлөл	Дарга	С.Тулга
	Гишүүд	Д.Баянзул
		Д.Энхбаатар
		Ч.Дондогмаа
		М.Санжаадорж
		Л.Наранчимэг
		А.Батпүрэв
		Р.Гандиймаа
		А.Анар
Удирдлагын баг:	Гүйцэтгэх захирал	Х.Алтай
	Захиргаа, санхүүгийн газрын захирал	Н.Дөл-Эрдэнэ
	Үйл ажиллагааны газрын захирал	И.Жавхлан
	Хяналт, зохицуулалтын газрын захирал	А.Мөнхбаясгалан
	Бизнес, хөгжлийн газрын захирал	Т.Хаш-Эрдэнэ
Хаяг:	Монголын хөрөнгийн бирж, Сүхбаатарын талбай-3, Улаанбаатар 15160, Монгол улс	
Регистрийн дугаар:	2071096	
Үйл ажиллагаа:	• Үнэт цаасны арилжаа эрхлэх, брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийг гишүүнээр элсүүлэх, гишүүнийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах үйл ажиллагаа байна.	
Ажиллагсадын тоо:	54	
Аудитор:	"Грант Торнтон Аудит" ХХК, Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага	

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

000285

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, Компанийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаарх завсар үеийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.
- Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.
- Санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.
- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулсан.

Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн ТУЗ-ийн дарга С.Тулга, Гүйцэтгэх захирал Х.Алтай болон Ерөнхий нягтлан бодогч С.Алтаннамар бид энэхүү тайлангийн 15-с 41 дүгээр хуудсанд үзүүлсэн компанийн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх компанийн завсар үеийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон хугацааны үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

ТУЗ-ийн дарга С.Тулга	Гүйцэтгэх захирал Х.Алтай	Ерөнхий нягтлан бодогч С.Алтаннамар
Огноо: 2022.12.05	Огноо: 2022.12.05	Огноо: 2022.12.05

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

000286

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1112227180
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Grant Thornton

"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
T + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

Хараат бус аудиторын дүгнэлт

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК (цаашид "компани" гэх)-ийн 2022 оны 06 дугаар сарын 30-наарх дараах санхүүгийн тайлангууд (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Завсар үеийн санхүүгийн байдлын тайлан,
- Завсар үеийн орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Завсар үеийн өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Завсар үеийн мөнгөн гүйлгээний тайлан болон
- Завсар үеийн нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Завсар үеийн бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 2022 оны 06 дугаар сарын 30-наарх завсар үеийн санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон хугацааны санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL

009287

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

БҮРТГЭВ

Grant Thornton

Аудитын аргачлалын хураангуй

Аудитын гол асуудлууд	•	Компани нь 2022 оны 06 сарын 30-ны өдөр өөрийн эзэмшлийн биет болон биет бус хөрөнгөд дахин үнэлгээ хийж, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн ба энэхүү үнэлгээгээр компанийн хөрөнгө 9 дахин өссөн байна.
Аудитын цар хүрээ	•	Компани нь охин компани болон хараат компани эзэмшдэггүй. Энэхүү аудитын цар хүрээнд компанийн нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан хамрагдсан.
Материаллаг байдал	•	Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 48,719 мянган төгрөг ба материаллаг байдлыг нийт орлогын 3%, татвар төлөхийн өмнөх ашгийн 7%-ийг ашиглан мэргэжлийн шүүн тунгаалтаар тогтоосон.
	•	Татварын өмнөх ашиг болон нийт орлогыг материаллаг байдлыг тооцоолох суурь үзүүлэлтээр сонгохдоо аудитын төлөвлөлтийн шатны судалгаа, өмнөх аудитын тайлан, зөвлөмж зэрэгт үндэслэсэн.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Аудитын гол асуудал	***Аудитын гол асуудалд авсан хариу арга хэмжээ***
Хөрөнгийн дахин үнэлгээ Компанийн удирдлага нь компанийн биет болон биет бус хөрөнгийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дахин үнэлсэн. Дахин үнэлгээгээр компанийн барилга, газрын хамт 15,492,760 мянган төгрөг, Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн суманд байршилтай газар тариалангийн зориулалттай газрын эрх 89,784 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл 12,100 мянган төгрөг, тавилга, эд хогшил 118,731 мянган төгрөг, биет бус хөрөнгө 7,327,757 мянган төгрөгөөр тус тус үнэлэгдэж, компанийн эргэлтийн бус хөрөнгө 9 дахин өссөн байна. Компанийн удирдлага нь зах зээлийн шинжилгээ, орц мэдээлэл, таамаглалууд, ашиглалт болон хязгаарлалтад тулгуурлан үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг зах зээлийн хандлагын нийтэд арилжаалагддаг жиших зүйлсийн арга болон орлогын хандлагын аргаар, хөдлөх хөрөнгө болон биет бус хөрөнгийн үнэлгээнд өртгийн хандлагын аргыг ашиглан, үлэмж хэмжээний тооцоолол, мэргэжлийн шийдэл ашиглан хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоосон тул бид аудитын гол асуудал гэж үзлээ.	***Гүйцэтгэсэн аудитын горим:*** Аудитор нь хөрөнгийн үнэлгээ бодитой эсэхийг шалгахдаа ҮОУС-ын ерөнхий стандарт болон холбогдох бусад стандартын дагуу дараах горимуудыг хэрэгжүүлсэн. Үүнд: • Үнэлгээний тайлан дахь мэдээллийн найдвартай байдал, итгэлтэй байдал зэргийг шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгасан. • Үнэлгээний ашигласан арга аргачлалын хүрээнд үнэлгээний хөрөнгийн онцлог, зах зээлийн нөхцөл байдал, бусад хүчин зүйлсийг харгалзан үзсэн эсэхийг шалгасан. • Үнэлгээний тооцооллын үзүүлэлтүүдийн үнэн зөв байдал, эцсийн үнэ цэнийн сонголт үндэслэлтэй эсэхийг шалгасан. • ҮОУС болон бусад холбогдох стандартуудыг баримталсан эсэхийг шалгасан.

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
MONGOLIAN
STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839
1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Grant Thornton

Аудитын онцлох асуудал

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэгдэж, баталгаажаагүй байгаа нь аудитын эрх ба үүрэг батламж мэдэгдлийн шаардлагыг хангахгүй байгаа хэдий ч энэхүү асуудлаар бид аудитын дүгнэлтээ хязгаарлаагүй болно.

Учир нь Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлэх журмыг батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд ажлын хэсэг ажиллаж байгаа ба уг журам батлагдсаны дараа "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлэх боломж бүрдэхээр байна.

Бусад асуудал

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Үндэсний аудитын газрын нэрийн өмнөөс "Аккаунт траст аудит" ХХК аудит хийсэн бөгөөд зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан,

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020999 рд. 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 рд.4119271128
УЛААНБААТАР ХОТ

009289

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

Санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналт

Бид Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналтыг 2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар Нягтлан бодох бүртгэл (НББ)-ийн тухай хуулийн 19-р зүйлд заасан шалгуур үзүүлэлтэд нийцэж буй эсэхийг шалгасан.

Компанийн удирдлага нь тус хуулийн шаардлагыг биелүүлэх, санхүүгийн тайлагналын дотоод хяналтыг үр дүнтэй байлгах, санхүүгийн тайлангийн дотоод хяналтын үр нөлөөг үнэлэх үүрэгтэй.

Бидний үүрэг бол аудитын үндсэн дээр санхүүгийн тайлагналын талаарх компанийн дотоод хяналтын талаар дүгнэлт гаргах явдал юм.

Бид аудитаа АОУС-ын дагуу хийсэн. Эдгээр стандартууд нь бид санхүүгийн тайлангийн үр ашигтай дотоод хяналтыг бүх материаллаг зүйлсийн хувьд хангасан эсэхэд үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг. Бидний аудитад санхүүгийн тайлангийн дотоод хяналтын талаарх ойлголтыг олж авах, материаллаг сул тал байгаа эрсдэлийг үнэлэх, үнэлэгдсэн эрсдэлд үндэслэн дотоод хяналтын загвар, үйл ажиллагааны үр нөлөөг хянах, үнэлэх, шаардлагатай гэж үзсэн бусад процедурыг хэрэгжүүлэх зэрэг багтсан. Бидний хийсэн аудит бидний дүгнэлт гаргах үндэслэлтэй гэж бид үзэж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
www.grantthornton.mn
Investcore CAPITAL
6317839
УЛААНБААТАР ХОТ

000290

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

СТОУС-ын дагуу санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналт нь санхүүгийн тайлангийн найдвартай байдал, санхүүгийн тайланг гадны хэрэглэгчидэд зориулан үнэн зөв бэлтгэх хяналтыг ТУЗ болон түүнээс томилогдсон гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлэх үйл явц юм.

Компанийн санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналт нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- Компанийн хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээ, хөрөнгийн зарцуулалтыг үндэслэлтэй, үнэн зөв, шударгаар тусгасан бүртгэл хөтлөхтэй холбоотой бодлого, горимууд байгаа эсэх;
- СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэхэд шаардлагатай ажил гүйлгээг бүртгэх, компанийн орлого, зарлагыг зөвхөн компанийн удирдлагын зөвшөөрлийн дагуу хийж байгаа гэсэн үндэслэлтэй баталгааг хангах;
- Санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй компанийн хөрөнгийг зохих зөвшөөрөлгүй олж авах, ашиглах, захиран зарцуулахаас урьдчилан сэргийлэх, цаг тухайд нь илрүүлэх талаар үндэслэлтэй баталгаа гаргах.

Санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналтын уламжлалт хязгаарлалтад хуйвалдах болон удирдлагын хяналтыг давах зэрэг боломжууд байдаг тул аливаа алдаа, залилангаас үүдэлтэй материаллаг буруу тайлагналаас урьдчилан сэргийлэх, цаг тухайд нь илрүүлэх боломжгүй байдаг.

Мөн санхүүгийн тайлагналын дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаарх аливаа үнэлгээний төсөөлөл нь нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас хяналт хангалтгүй болох эсвэл бодлого, журмын хэрэгжилтийн түвшин сулрах эрсдэлтэй.

Бидний дүгнэлтээр, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг компанийн удирдлага тогтоосон ба 2022 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар энэхүү дотоод хяналтын дүрэм, журмаар тогтоосон процедурын дагуу санхүүгийн тайлангийн үр дүнтэй дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байна.

Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хувьцааг олон нийтэд санал болгон гаргахтай холбоотой үйлчилгээ үзүүлж буй мэргэжлийн оролцогчид болон зохицуулах байгууллагад зориулсан болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Н.Эрдэнэцог болно.

GRANT THORNTON AUDIT LLC

Б.ОСОРГАРАВ
УДИРДАХ ПАРТНЕР

2022 оны 12 дугаар сарын 05

Н.ЭРДЭНЭЦОГ
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Завсар үеийн санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 06 сарын 30-ны үлдэгдэл	2021 оны 06 сарын 30-ны үлдэгдэл	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хөрөнгө				
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7	2,511,881	1,154,070	2,729,364
Дансны ба бусад авлага	8	66,718	36,327	97,259
Бараа материал	9	33,049	24,599	26,571
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	10	6,159	11,522	7,666
Бусад эргэлтийн хөрөнгө	11	13,160	13,160	13,160
Эргэлтийн хөрөнгийн дүн		**2,630,967**	**1,239,678**	**2,874,020**
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	12	5,580,749	2,151,762	2,102,230
Биет бус хөрөнгө	13	17,898,745	411,625	382,337
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**23,479,494**	**2,563,387**	**2,484,567**
Нийт хөрөнгийн дүн		**26,110,461**	**3,803,065**	**5,358,587**
Өр төлбөр ба эздийн өмч				
Өр төлбөр				
Дансны болон бусад өглөг	14	39,924	1,089,109	926,821
Урьдчилж орсон орлого	15	192,813	12,193	14,248
Хойшлогдсон татварын өр	16	2,142,367	-	-
Өр төлбөрийн нийт дүн		**2,375,104**	**1,101,302**	**941,069**
Хувьцаат капитал	17	23,130,594	23,130,594	23,130,594
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	18	18,883,199	12,362	12,362
Эздийн өмчийн бусад хэсэг	19	446,322	446,322	446,322
Хуримтлагдсан ашиг		(18,724,758)	(20,887,515)	(19,171,760)
Эздийн өмчийн дүн		**23,735,357**	**2,701,763**	**4,417,518**
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		**26,110,461**	**3,803,065**	**5,358,587**

Уг завсар үеийн санхүүгийн байдлын тайланг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр батлав.

ТУЗ-ийн дарга	Гүйцэтгэх захирал	Ерөнхий нягтлан бодогч
С.Тулга	Х.Алтай	С.Алтаннамар
Огноо: 2022.12.05	Огноо: 2022.12.05	Огноо: 2022.12.05

Хуудас 15-с 41-д харуулсан тодруулгууд нь энэхүү завсар үеийн санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

МОНГОЛЫН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК ХХК
InvesCore CAPITAL
000292

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Завсар үеийн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 06 сарын 30 хүртэлх эхний 6 сар	2021 оны 06 сарын 30 хүртэлх эхний 6 сар	2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жил
Орлого	20	1,474,495	2,585,555	5,483,079
Ерөнхий ба удирдлагын зардал	21	(980,959)	(579,503)	(1,230,600)
Милленниум Ай Ти системтэй холбоотой зардал	22	(37,758)	(537,259)	(938,094)
Тайлант үеийн үйл ажиллагааны ашиг		**455,778**	**1,468,793**	**3,314,385**
Санхүүгийн орлого	23	-	-	19,302
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	24	44,879	(444)	18,603
Татвар төлөхийн өмнөх ашиг		**500,657**	**1,468,349**	**3,352,290**
Орлогын татварын зардал	25	(53,655)	-	(168,186)
Татварын дараах ашиг		**447,002**	**1,468,349**	**3,184,104**
Бусад дэлгэрэнгүй орлого				
Дахин үнэлгээний нэмэгдэл		18,870,837	-	-
Орлогын нийт дүн		**19,317,839**	**1,468,349**	**3,184,104**
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг		**0.08**	**0.01**	**0.01**

Хуудас 15-с 41-д харуулсан тодруулгууд нь энэхүү завсар үеийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ⚓ 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ⚓ 11292712
УЛААНБААТАР ХОТ

000293

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Завсар үеийн өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагд-сан ашиг (алдагдал)	Нийт дүн
2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	**23,130,594**	**12,362**	**446,322**	**(19,171,760)**	**4,417,518**
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	447,002	447,002
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	20,967,597	-		20,967,597
Хойшлогдсон татварын нөлөөлөл		(2,096,760)			(2,096,760)
2022 оны 6 сарын 30-ны үлдэгдэл	**23,130,594**	**18,883,199**	**446,322**	**(18,724,758)**	**23,735,357**
2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	**23,130,594**	**12,362**	**446,322**	**(22,355,864)**	**1,233,414**
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	1,468,349	1,468,349
2021 оны 06 сарын 30-ны үлдэгдэл	**23,130,594**	**12,362**	**446,322**	**(20,887,515)**	**2,701,763**
2021 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	**23,130,594**	**12,362**	**446,322**	**(22,355,864)**	**1,233,414**
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	3,184,104	3,184,104
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**23,130,594**	**12,362**	**446,322**	**(19,171,760)**	**4,417,518**

Хуудас 15-с 41-д харуулсан тодруулгууд нь энэхүү завсар үеийн өмчийн өөрчлөлтийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

000294

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Завсар үеийн мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	2022 оны 06 сарын 30 хүртэлх эхний 6 сар	2021 оны 06 сарын 30 хүртэлх эхний 6 сар	2021 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жил
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн	**1,648,940**	**2,754,831**	**5,699,769**
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлснийорлого	1,612,523	2,097,598	4,951,952
Даатгалын нөхөвөрөөс хүлээн авсан мөнгө	1,121	1,826	10,896
Бусад мөнгөн орлого	35,296	655,407	736,921
Мөнгөн зарлагын дүн	**(1,755,001)**	**(2,147,908)**	**(3,427,313)**
Ажиллагчдад төлсөн	(442,402)	(274,385)	(585,159)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(126,713)	(89,437)	(182,328)
Бараа материал худалдан авахад төлсөн	(20,740)	(7,917)	(23,292)
Ашиглалтын зардалд төлсөн	(33,175)	(24,421)	(46,952)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(3,043)	(4,325)	(8,119)
Татварын байгууллагад төлсөн	(317,827)	(204,409)	(348,441)
Бусад мөнгөн зарлага	(811,101)	(1,543,014)	(2,233,022)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(106,061)**	**606,923**	**2,272,456**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн	**-**	**-**	**19,302**
Хүлээн авсан хүүний орлого	-	-	19,302
Мөнгөн зарлагын дүн	**(156,517)**	**(7,443)**	**(116,984)**
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(156,517)	(7,443)	(116,984)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(156,517)**	**(7,443)**	**(97,682)**
Ханшийн зөрүү	45,095	-	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(217,483)	599,480	2,174,774
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,729,364	554,590	554,590
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,511,881	1,154,070	2,729,364

Хуудас 15-с 41-д харуулсан тодруулгууд нь энэхүү завсар үеийн мөнгөн гүйлгээний тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

000295

ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК ХХК
14
InvesCore CAPITAL
6317838
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Завсар үеийн санхүүгийн тайлангийн тодруулгууд

1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 22 тоот тогтоолоор улсын өмч хувьчлалын ажлыг эхлүүлэх, цаашид үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийг үүсгэн байгуулсан.

Үндсэн үйл ажиллагаа: Үнэт цаасны арилжаа эрхлэх, брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийг гишүүнээр элсүүлэх, гишүүнийг түдгэлзүүүлэх, гишүүнээс хасах үйл ажиллагаа байна.

Компанийн хүний нөөц: Компанийн ажилтнуудын дундаж тоо 2022 оны эхний хагас жилийн байдлаар 54 (2021 онд: 53) байсан.

Бүртгэгдсэн хаяг: Монголын хөрөнгийн бирж, Сүхбаатарын талбай-3, Улаанбаатар 15160, Монгол улс

2. Ерөнхий мэдээлэл, СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагааны таамаглал

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу толилуулах үүрэгтэй.

Эдгээр санхүүгийн тайланг Компани нь тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн.

2022 оны 06 дугаар сарын 30-наар дуусгавар болсон санхүүгийн тайлангууд түүний тодруулгуудыг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Компанийн удирдлага баталсан (Тодруулга 32-г харна уу).

Тасралтгүй үйл ажиллагаа

НББОУС 1-д заасны дагуу удирдлага нь тайлант хугацаанаас хойш багадаа 12 сарын ирээдүйн хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад эргэлзээ төрүүлэх асуудлууд байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай. Ийнхүү үнэлэхдээ одоогийн болон хүлээгдэж буй ашигт ажиллагаа, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, боломжит санхүүжилтийн эх үүсвэр болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадавхи зэрэг өргөн хүрээний хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

Компанийн тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ үүсгэх томоохон үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой тодорхойгүй байдал байхгүй байна.

3. Шинэ болон өөрчлөлт орсон стандартууд болон хэрэглээний тайлбарууд

3.1. 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн шинэ стандартууд

Компанийн санхүүгийн үр дүн болон байдалд томоохон нөлөө үзүүлэх 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх стандартын өөрчлөлт, мэдэгдэл байхгүй байна.

Компанид хамааралтай 2022 онд анх удаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа СТОУС болон нэмэлт өөрчлөлт нь дараах байна. Үүнд:

- Суурь үзэл баримтлалын лавлагаа (СТОУС 3-д орсон нэмэлт өөрчлөлт)
- КОВИД-19 – 2021 оны 6 дугаар сарын 30-наас хойших хамааралтай түрээсийн концесс (СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт)
- Үндсэн хөрөнгө: Зорилтот хэрэглээнээс өмнөх борлуулалт (НББОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт)
- Алдагдалтай гэрээ – Гэрээг гүйцэлдүүлэх зардал (НББОУС 37-д орсон нэмэлт өөрчлөлт)

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ
InvesCore CAPITAL
6317839 ⚓ 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000296

Үнэт цаас гаргалт Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

- Жилийн сайжруулалтууд (2018-2020 цикл):
  - Анх удаа хэрэгжүүлэн мөрдөгч салбар (НББОУС 1-д орсон нэмэлт өөрчлөлт)
  - Өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх "10 хувь" тестийн хураамж (СТОУС 9-д орсон нэмэлт өөрчлөлт)
  - Түрээсийн урамшуулал (СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт)
  - Бодит үнэ цэнийн хэмжилт дэх татвар (НББОУС 41-д орсон нэмэлт өөрчлөлт)

3.2. Хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд

Санхүүгийн тайланг баталсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөх хугацаа болоогүй НББОУСЗ-ийн өөрчлөлт оруулсан стандарт болон түүний тайлбарууд байгаа ба компани нь тэдгээр стандарт болон өөрчлөлтийг урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа юм.

Компанийн удирдлага тухайн өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болох өдөр эсвэл түүний дараагаар мөрдөж эхлэхээр төлөвлөж байна. Тайлант онд дагаж мөрдөх шаардлагагүй тухайн өөрчлөлтүүдийг тодруулаагүй ба тэдгээр нь санхүүгийн тайланд материаллаг нөлөөлөл үзүүлэхгүй.

4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

4.1. Бүртгэлийн суурь

Эдгээр санхүүгийн тайланг аккруэль сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

4.2. Гадаад валют хөрвүүлэлт

Үйл ажиллагааны болон толилуулгын валют

Санхүүгийн тайлангууд нь Монгол төгрөгөөр илэрхийлэгддэг ба компанийн үйл ажиллагааны валюттай ижил юм.

Гадаад валютаарх ажил гүйлгээ болон үлдэгдэл

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монголбанкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монголбанкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2022 оны 06 дугаар сарын 30-нд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3,134.28 байв. (2021 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам.доллар 2,848.80 төгрөг, 2021 оны 6 дугаар сарын 30-нд: 3,134.28)

Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдалд багтаана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн зөрүүний олз, гарзыг шууд өмчид хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд багтаана. Тийм мөнгөн бус зүйлсийн хувьд олз, гарзын аливаа ханшийн зөрүүний хэсгийг шууд өмчид хүлээн зөвшөөрнө.

4.3. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг. Хэрэв мөнгөтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг бол Компани нь хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөөр ангилна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
000297

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

4.4. Санхүүгийн хэрэглүүр

Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт

Компани нь тухайн санхүүгийн хэрэглүүрт хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгөнд хамаарах бүх бодит эрсдэл, өгөөж шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн ангилал ба анхдагч хэмжилт

Санхүүгийн хувьд чухал бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй дансны авлага болон СТОУС 15 "Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого"-ын дагуу ажил гүйлгээний үнээр бүртгэхээс бусад бүх санхүүгийн хөрөнгийг ажил гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр хэмжинэ.

Хейджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Хорогдуулсан өртөг
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БҮЦБДО)
- Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БҮЦАА)

Тайлант онд компанид БҮЦБДО-оор ангилагдах санхүүгийн хөрөнгө байхгүй байна. Ангиллыг тодорхойлохдоо:

- Санхүүгийн хөрөнгийг зохицуулах бизнесийн загвар
- Санхүүгийн хөрөнгийн гэрээлсэн мөнгөн урсгалын шинж чанарыг тус тус харгалзан үзнэ.

Санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого болон зардал нь санхүүгийн зардал, санхүүгийн олз болон бусад санхүүгийн зүйлсээр орлого болон зардалд хүлээн зөвшөөрөгдөх ба харин дансны авлагын үнэ цэнийн бууралтыг бусад зардлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт
Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгө

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжинэ (БҮЦАА-аар ангилагдаагүй үед):

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" (SPPI) байвал.

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг хассан дүнгээр хэмжинэ. Хүүг үр ашигт хүүгийн аргаар тооцоолно. Анхны үнэ цэнийн бууралтын хасагдуулга болон дараа үеийн өөрчлөлтүүдийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БҮЦАА)

Хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх ангиллын шаардлагад нийцэхгүй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэнэ.

Мөн тодорхой тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэхээр тогтож болно. Тухайлбал, компани дараа үед хорогдуулсан өртгөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх сонголт хийж болно.

Ийм сонголтыг зөвхөн нягтлан бодох бүртгэлийн зөрүүтэй байдлыг арилгах эсвэл ихээхэн хэмжээгээр бууруулж байгаа тохиолдолд хийнэ.

Дээрх сонголтыг бүх ижил төстэй ажил гүйлгээнд мөрдөх шаардлагагүй. Харин энэ нь илүү мэдээлэл бий болгож байгаа тохиолдолд компани сонгож болох хувилбар юм.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071000
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000298

Үнэт цаас гаргагч Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БҮЦБДО)

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлнэ:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал "цуглуулах ба борлуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг" бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" (SPPI) байвал.

Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдсөн олз, гарзыг ашиг, алдагдалд дахин ангилна.

Бусад санхүүгийн хөрөнгө

Компани нь дансны болон бусад авлагын авлага, гэрээний хөрөнгийг хялбаршуулсан аргаар нягтлан бодох бүртгэлд тусгадаг бөгөөд алдагдлын нөөцийг хүлээгдэж буй алдагдлын аргаар бүртгэдэг. Эдгээр нь санхүүгийн хэрэгслийн ашиглалтын хугацааны аль ч үед дефолт болох магадлалыг харгалзан үзсэн гэрээний мөнгөн урсгалын хүлээгдэж буй дутагдал юм. Нөөцийн матрицийг ашиглан хүлээгдэж буй алдагдлыг тооцоолохдоо Компани нь өөрийн түүхэн туршлага, гадаад хүчин зүйлс, ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашигладаг.

Санхүүгийн өр төлбөрийн ангилал болон хэмжилт

Компанийн санхүүгийн өр төлбөрт дансны болон бусад өглөг, үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд орно.

Санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-с өөрөөр хэмжих үед ажил гүйлгээний үнэ цэнийг тохируулсан бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Дараа үед санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-р тодорхойлсон санхүүгийн өр төлбөр болон деривативаас бусад тохиолдолд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдсон өртгөөр хэмжинэ. Бодит үнэ цэнийн олз гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бүх хүүтэй холбоотой зардал болон санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг санхүүгийн зардал эсвэл санхүүгийн орлогоор хүлээн зөвшөөрнө.

4.5. Бусад санхүүгийн бус хөрөнгө

Компани нь бусад санхүүгийн бус хөрөнгөд тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулан урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зардлуудыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ.

Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

4.6. Үндсэн хөрөнгө

Барилга, компьютер дагалдах хэрэгсэл болон бусад тоног төхөөрөмж

Тавилга эд хогшлыг хамруулан барилга, компьютер дагалдах хэрэгсэл болон бусад тоног төхөөрөмжийг хөрөнгийг ашиглалтын байршилд авч ирэхэд гарсан зардлууд болон тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай гарсан зардлуудыг хамруулан худалдан авсан өртөг эсвэл үйлдвэрлэлийн өртгөөр анхлан бүртгэнэ.Санхүүгийн түрээсийн хөрөнгүүд нь барилга болон компьютер дагалдах хэрэгслийн адил бүртгэгдэнэ.Ажил үйлчилгээний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн зорилгоор ашиглаж буй [Үндсэн хөрөнгийн ангиллыг газар, барилга гэх мэтээр тайлбарла] зэрэг хөрөнгүүдийг санхүүгийн тайланд дахин үнэлсэн дүн буюу дахин үнэлгээ хийсэн өдрөөрх дүнгээс дараа үеийн хуримтлагдсан элэгдсэн болон дараа үеийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тайлагнана.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхэлнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

ХӨРӨНГИЙН МОНГОЛЫН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020599
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч Андеррайтер

Үндсэн хөрөнгийн төрөл	Хөрөнгийн үнэлгээнээс өмнөх ашиглалтын хугацаа	Хөрөнгийн үнэлгээний дараах ашиглалтын хугацаа
Барилга	60 жил	36 жил
Байгууламж	21 жил	12.5 – 21 жил
Тээврийн хэрэгсэл	6 жил	6 жил
Тавилга, эд хогшил	5 - 10 жил	5 - 10 жил
Компьютер, тоног төхөөрөмж	3 - 10 жил	3 - 10 жил

Ашиглах эрхийн хөрөнгийн ашиглах хугацааг тодорхойлохдоо гэрээний нөхцөл эсвэл өмчлөлд байгаа ижил төстэй хөрөнгийн ашиглах хугацааны аль багаар тогтооно. Материаллаг дүнтэй үлдэх өртөг тооцоолол болон хөрөнгийн ашиглах хугацааны тооцооллыг багадаа жилд нэг удаа шинэчлэнэ.

Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

4.7. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөнд МІТ цогц систем, газар эзэмших эрх хамаарна.

Гаднаас худалдан авсан биет бус хөрөнгийг худалдан авалт хийсэн өдөр өртгөөр нь бүртгэнэ. Өртөг нь төлсөн мөнгөний дүн, өгсөн хөрөнгийн зах зээлийн үнэ, гарсан өр төлбөрт төлөх дүнгийн өнөөгийн үнэ цэнэ эсвэл хувьцаа гаргалтын хувьд хүлээн авсан санал бодлын зах зээлийн үнэ цэнээр хэмжигддэг.

Дотооддоо бий болгосон биет бус хөрөнгийн хувьд судалгаа хөгжүүлэлтийн зардлаас бусад өртөг зардлыг биет бус хөрөнгийн өртөгт капиталжуулдаг. Дотоодод бий болсон гүүдвиллийг хөрөнгө гэж бүртгэхгүй.

Биет бус хөрөнгийг хувьцаа болон өөр бусад мөнгөн бус хөрөнгөөр солилцох замаар олж бэлтгэж болно. Энэ тохиолдолд биет бус хөрөнгийн өртгийг шилжүүлэн өгсөн хөрөнгийн зах зээлийн үнэ эсвэл биет бус хөрөнгийн зах зээлийн үнэ хоёрын аль тодорхой байгаа үнээр үнэлнэ.

Дотооддоо хөгжүүлсэн программ хангамж

Мэдээлэл технологийн, харилцаа холбооны системийн зорилгоор шинээр хөгжүүлж буй программ хангамжийн судалгааны зардлыг гарсан үед нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

Хөгжүүлэлтийн үе шатанд гарсан зардлыг дараах шаардлагыг хангаж байгаа тохиолдолд биет бус хөрөнгөнд хуримтлуулан бүртгэнэ. Үүнд:

- Хөгжүүлэлтийн зардлыг бодитоор хэмжиж болох
- Төслийн техникийн болон арилжааны үр дүн амжилттай болох нь тодорхой
- Компани нь тухайн төслийг хэрэгжүүлж дуусгахад шаардлагатай хангалттай нөөцтэй
- Тухайн программыг ашиглах эсвэл борлуулах боломжтой
- Тухайн программаас ирээдүйн эдийн засгийн өгөөж ирэх нь тодорхой

Дээрх капиталжуулалтын шаардлагыг хангаагүй зардлууд нь зардлаар хүлээн зөвшөөрөгдөнө.

Холбогдох зардлуудад программ хөгжүүлэхтэй холбоотой гарсан ажилчдын зардал, зээлийн өртөг болон нэмэгдэл зардлууд нь хөгжүүлэлтэд хамаарах хэмжээгээр хуваарилагдана.

Дараа үеийн хэмжилт

Ашиглах хугацаа нь тодорхой дотооддоо хөгжүүлэн капиталжуулсан программ зэрэг биет бус хөрөнгүүдийг өртгийн аргаар бүртгэх ба ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргаар хорогдуулна. Үлдэх өртөг болон ашиглах хугацааг тайлант жил бүр дахин тооцно. Мөн үнэ цэнийн бууралтын тест хийнэ.

Холбогдох хүчин зүйлсийн шинжилгээнд үндэслэн биет бус хөрөнгөөс мөнгөн орлого бий болгохоор хүлээгдэж буй хугацааны хувьд урьдчилан харах боломжгүй тохиолдолд компани нь биет бус

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

хөрөнгийг тодорхой бус ашиглалтын хугацаатай гэж үзнэ. Газар эзэмших эрхийн хувьд ашиглалтын хугацаа нь дуусах үед дахин сунгуулах боломжтой ба цаашид хэдэн удаа сунгаж, ашиглах нь тодорхойгүй байгаа тул элэгдүүлэлт тооцохгүй.

Биет бус хөрөнгүүдийн ашиглах хугацаа нь дараах байдалтхай байна. Үүнд:

Биет бус хөрөнгийн төрөл	Хөрөнгийн үнэлгээнээс өмнөх ашиглалтын хугацаа	Хөрөнгийн үнэлгээний дараах ашиглалтын хугацаа
Газар эзэмших эрх	15 жил	Ашиглалтын хугацаа тодорхойгүй
Бусад програм, хангамж	4 жил	0.5 жил
МІТ программын хугацаа	Гэрээний хугацаанд	Гэрээний хугацаанд

Капиталжуулж буй хөгжүүлэлт нь дуусаагүй программ хангамжийг хорогдуулахгүй боловч үнэ цэнэ бууралтын тест хийнэ.

Хорогдуулгын зардлыг санхүүгийн бус хөрөнгийн элэгдэл, хорогдол, үнэ цэнэ бууралтын дансанд бүртгэнэ.

Программ хангамж болон бренд нэртэй холбоотой дараа үед гарах засварын зардлыг зардлаар хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийг борлуулснаас үүсэх олз гарзыг борлуулалтын үнэ болон дансны үнийн зөрүүгээр хүлээн зөвшөөрч, бусад орлого болон зардлын дансанд ашиг болон алдагдлаар бүртгэнэ.

4.8. Биет бус хөрөнгө болон үндсэн хөрөнгийн үнэ цэнэ бууралтын тест

Хөрөнгүүдийг үнэ цэнийн бууралтын зорилгоор мөнгөн бий болгогч нэгжид суурилан боломжит хамгийн жижиг бүлгүүдэд хуваадаг. Үүний үр дүнд зарим хөрөнгийн үнэ цэнийн бууралт дангаараа хийгддэг бол зарим хөрөнгүүд мөнгө бий болгогч нэгжийн түвшинд үнэлэгддэг.

Үнэ цэнийн бууралтын алдагдлыг хөрөнгийн нөхөгдөх дүнгээс давсан дансны үнийн дүнгээр хүлээн зөвшөөрнө. Нөхөгдөх дүн нь ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулалтын өртгийг хассан дүнгийн аль өндрөөр тодорхойлогдоно. Ашиглалтын үнэ цэнийг тодорхойлохдоо удирдлага нь мөнгө бий болгогч нэгж бүрийн ирээдүйн мөнгөн урсгалыг тооцох ба тухайн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцохын тулд зохих дискаунтын түвшинг тодорхойлдог. Үнэ цэнийн бууралтын тестэд ашигласан мэдээлэл нь ирээдүйд гарах зохион байгуулалтын өөрчлөлт, хөрөнгийн сайжруулалтын үр нөлөөг хамруулаагүй Компанийн хамгийн сүүлд батлагдсан төсөвт үндэслэдэг.

Мөнгө бий болгогч нэгжид үнэ цэнэ бууралтын гарзыг хуваарилахдаа тухайн нэгжид хамаарах гүүдвилийн үлдэгдлийг хамгийн эхэнд бууруулна. Үлдсэн гарзыг нь мөнгө бий болгогч нэгжид хамаарах хөрөнгүүдэд тэнцүүлсэн хэмжээгээр хуваарилна.

Биет бус хөрөнгийн өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын алдагдал цаашид байхгүй болох шинж тэмдэг илэрсэн эсэхийг үнэлдэг. Хөрөнгийн болон бэлэн мөнгө үүсгэх нэгжийн нөхөгдөх үнэ нь түүний дансны үнээс давсан тохиолдолд үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаана.

4.9. Өмч, нөөц, ногдол ашгийн төлбөр

Хувьцаат капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнийг илэрхийлнэ.

Халаасны хувьцаа нь Компани гүйлгээнд гаргасан хувьцаагаа зах зээлээс эргүүлэн худалдан авах үед худалдан авсан хувьцааны дүнгээр өмчийн буюу хувьцаат капиталын дүнг бууруулна.

Нэмж төлөгдсөн капиталд хувьцаат капитал гаргаснаас хүлээж авсан аливаа урамшуулал орно. Хувьцаа гаргахтай холбоотой аливаа ажил гүйлгээний зардлыг холбогдох татвар суутгасан цэвэр дүнгээр нэмж төлөгдсөн капиталаас хасна.

4.10. Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлого хүлээн зөвшөөрөхдөө Компани нь дараах 5-н алхамыг мөрддөг. Үүнд:

1. Үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээг тодорхойлох
2. Гэрээний үүрэг хариуцлагын биелэлтийг тодорхойлох

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020690
УЛААНБААТАР ХОТ

000301

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаасны гаргагч Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

3. Арилжааны үнийг тодорхойлох
4. Арилжааны үнийг гэрээний гүйцэтгэх үүргүүдэд хувиарлах
5. Аж ахуйн нэгж гүйцэтгэх үүргээ биелүүлсэн үедээ орлогыг хүлээн зөвшөөрөх

Компани нь бүртгэлтэй ХК, гишүүн ҮЦК-с хураамжийн орлого, арилжааны шимтгэлийн орлогыг олдог. Иймд гэрээний нийт үнийн дүн нь үүрэг хариуцлагын төрөл бүрт тус тусын үнийн дүнд харгалзуулан хуваарилагддаг. Гэрээний үнийн дүнд гуравдагч этгээдэд олгох төлбөрийг хамруулахгүй.

Орлогыг тохиролцсон ажил үйлчилгээг үзүүлэх гэрээний үүргээ биелүүлсэн бол тухайн мөчид эсвэл тодорхой хугацааны явцад хүлээн зөвшөөрнө.

Хэрэгжээгүй үүрэгт хамаарах орлого орох үед гэрээний өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөх ба санхүүгийн байдлын тайланд бусад өр төлбөрөөр харуулна. Үүнтэй адилаар төлбөр ирэхээс өмнө тохиролцсон үүргийг биелүүлэх үед гэрээний хөрөнгө эсвэл авлагаар санхүүгийн байдлын тайланд тусгана.

4.11. Үйл ажиллагааны зардал

Борлуулалт маркетинг, ерөнхий удирдлагын зардал, бусад зардлыг нийт дүнгээр нь толилуулна. Үйл ажиллагааны зардал нь ажил үйлчилгээ гарсан үед ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөгдөнө.

4.12. Ажилчдын богино хугацааны тэтгэмж

Богино хугацааны ажилчдын тэтгэмж

Ажилчдын богино хугацааны тэтгэмжид хамаарах амралтын мөнгө зэрэг тэтгэмжийг тэтгэмж болон бусад үүргийн дансанд дискаунтчлаагүй дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Ажилчдад олгох богино хугацааны тэтгэмж ажилчид холбогдох үйлчилгээ үзүүлсэн жилийн тайлант хугацааны эцсээс хойш 12 сарын дотор олгох тэтгэмж бөгөөд дараахийг багтаана. Үүнд:

- цалин урамшуулал;
- ээлжийн амралтын мөнгө, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;

Урамшуулал

Компани зөвхөн өнгөрсөн үйл явдлын үр дүнд мөн үүрэг хариуцлагын найдвартай тооцоолол хийх боломжтой тохиолдолд тийм төлбөр хийх өнөөгийн хууль ёсны болон үүсмэл үүрэг хүлээсэн бол урамшууллын төлбөрийн хүлээгдсэн өртгийг хүлээн зөвшөөрнө.

Өнөөгийн үүрэг хариуцлага зөвхөн тухайн аж ахуйн нэгжид төлбөр хийхээс өөр бодитой хувилбар байхгүй тохиолдолд л оршино.

4.13. Нөөц, болзошгүй хөрөнгө, өр төлбөр

Шүүхийн маргаан, алдагдалтай гэрээ, зэрэг бусад төлбөрийг үүрэг өнгөрсөн үйл явдлыг үр дүнд бий болж, уг үүрэг хариуцлагыг барагдуулахад эдийн засгийн өгөөжийн гадагш урсгал шаардагдах магадлалтай бөгөөд мөнгөн дүнг найдвартай хэмжих боломжтой болсон үед нөөцөөр зөвшөөрнө.

Нөөцийг тайлангийн өдрөөр мэдэгдэж буй хамгийн найдвартай нотолгоонд үндэслэсэн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардагдах зардлын мэдээлэлд суурилан тооцно. Хэд хэдэн ижил төстэй үүрэг үүссэн үед, үүрэг хариуцлагын төрлөөр нь тэдгээрийг барагдуулахад шаардлагатай гарах урсгалын магадлалыг тооцдог. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөө үзүүлэхүйц бол нөөцийн өнөөгийн үнэ цэнийг дискаунтчлан тооцдог.

Компанийн гуравдагч талаас авах нь тодорхой болсон нөхөн олговрыг тусд нь хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө. Тус дүн нь холбогдох нөөцийн дүнгээс ихгүй байна.

Тухайн үүргийг барагдуулахтай холбоотой эдийн засгийн өгөөжийн гарах урсгал нь магадлалтай биш үед өр төлбөр хүлээн зөвшөөрөхгүй. Эдийн засгийн өгөөжийн гарах урсгал нь бага дүнтэйгээс бусад үүссэн нөхцөлийг болзошгүй өр төлбөрөөр санхүүгийн тайланд тодруулна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 дд. 2021/09/
УЛААНБААТАР ХОТ

009302

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ь1116017128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЭХ 2022.12.15
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022-12-12 БҮРТГЭВ-02

4.14. Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дах хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдох ашгийн тооцоололд ашиглан холбогдох татварын суурь хоорондын түр зөрүүгээр хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өр төлбөрийг ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүнд хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг ерөнхийдөө түр хасагдах зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед бүх хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Ийм хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг гүүдвилийн анхдагч хүлээн зөвшөөрөлт эсвэл ажил гүйлгээн дэх бусад хөрөнгө, өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт нь татвар ногдох орлого ба нягтлан бодох бүртгэлийн ашгийн аль алинд нөлөөлөхгүй байвал хүлээн зөвшөөрөхгүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацаа бүрийн эцэст эргэж харах ба хангалттай хэмжээний татвар ногдох орлогоор тухайн хөрөнгө бүхлээрээ эсвэл тодорхой хэсэг нь нөхөгдөх боломжтой болох үед бууруулна.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эсвэл тайлант оны эцсээр хүчин төгөлдөр болсон татварын хувь хэмжээнд үндэслэн тухайн өр төлбөрийг барагдуулах эсвэл хөрөнгийг хүлээн зөвшөөрөх тайлант онд мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хэмжигдэнэ. Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн хэмжилт нь тайлант хугацааны эцэст Компани хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулахаар хүлээж байгаагаас үүсэх татварын үр дагаварт нөлөөлдөг.

4.15. Нягтлан бодох бүртгэлийн бодлого болон тооцооллын тодорхойгүй байдалд удирдлагын шийдлийг ашиглах нь

Компанийн удирдлага санхүүгийн тайлан бэлтгэхдээ хөрөнгө, өр төлбөр, орлого болон зардал хүлээн зөвшөөрөхтэй холбоотой шийдэл, тооцоолол, таамаглал ашигладаг.

Удирдлагын томоохон тооцоолол, таамаглал

Компани нь нягтлан бодох бүртгэлийн бодлогоо баримтлахад үүсдэг санхүүгийн тайланд томоохон нөлөөлөл үзүүлэхүйц удирдлагын тооцоолол, таамаглалыг доор харуулав. Үүнд:

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнэ бууралт

Зураг 5. Анхдагч, хоёрдогч зах зээлийн арилжаа болон хөрвөх чадвар 14
Зураг 6. МХБ-ын ТОП 20 индексийн стандарт хазайлт 15
Зураг 7. МХБ-ын 2021 оны борлуулалтын орлогын бүтэц 19
Зураг 8. NASDAQ биржийн орлогын задаргаа 25
Зураг 9. EURONEXT биржийн орлогын задаргаа 25
Зураг 10. Болгарын хөрөнгийн биржийн хувьцаа эзэмшигчид 27
Зураг 11. Болгарын хөрөнгийн биржийн хувьцааны ханшийн хөдөлгөөн 28
Зураг 12. Дубайн санхүүгийн захын хувьцааны ханшийн хөдөлгөөн 29
Зураг 13. Наиробийн хөрөнгийн биржийн хувьцааны ханшийн хөдөлгөөн 31
Зураг 14.Нигерийн хөрөнгийн биржийн хувьцааны ханшийн хөдөлгөөн 32
Зураг 15. Пакистаны хөрөнгийн биржийн хувьцааны ханшийн хөдөлгөөн 33

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол улсын эдийн засгийн төсөөлөл, тэрбум төгрөгөөр 11
Хүснэгт 2. Монголын эдийн засгийн ханшийн мэдээлэл 13
Хүснэгт 3. 2022 оны хагас жилийн хамгийн өндөр үнэлгээтэй 15 арилжааны дүн 14
Хүснэгт 4. Монголын үнэт цаасны арилжааны мэдээлэл 15
Хүснэгт 5. МХБ-ийн үндсэн үзүүлэлт 2017-2022 он 18
Хүснэгт 6. МХБ-ийн балансын үзүүлэлтүүд, 2017-2022 он 18
Хүснэгт 7. МХБ-ийн орлого үр дүнгийн үзүүлэлтүүд 2017-2022 он 19
Хүснэгт 8. Хөгжсөн биржүүдийн үнэлгээний харьцаанууд 21
Хүснэгт 9. Дэвшилтэт хөгжиж буй биржүүдийн үнэлгээний харьцаанууд 22
Хүснэгт 10. Хоёрдогч хөгжиж буй биржүүдийн үнэлгээний харьцаанууд 23
Хүснэгт 11. Шинээр гарч ирж буй биржүүдийн үнэлгээний харьцаанууд 24
Хүснэгт 12. Биржүүдийн дундаж P/B харьцааны харьцуулалт 25
Хүснэгт 13. Харьцуулалтад авсан биржүүд 26
Хүснэгт 14. Харьцуулалтад авсан биржүүдийн санхүүгийн харьцаанууд 34
Хүснэгт 15. Харьцуулалтад авсан биржүүдийн үнэлгээний үржүүлэгчид 35
Хүснэгт 16. Зах зээлийн харьцуулалтын үнэлгээний үр дүн, сая төгрөгөөр 35
Хүснэгт 17. МХБ ТӨХК-ийн эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээ 36
Хүснэгт 18. МХБ ТӨХК-ийн эргэлтийн хөрөнгийн үнэлгээ 37
Хүснэгт 19. МХБ ТӨХК-ийн өр төлбөр 37
Хүснэгт 20. МХБ ТӨХК-ийн цэвэр хөрөнгийн хэмжээ 37
Хүснэгт 21. Хөрөнгийн биржийн хөгжлийн төсөөлөл, 2022 – 2027, тэрбум төгрөг 39
Хүснэгт 22. Нүүрсний нээлттэй, цахим арилжааны төсөөлөл, 2022 – 2027, тэрбум төгрөг 40
Хүснэгт 23. ЗГ-ын бондын арилжааны төсөөлөл, 2022 – 2027, тэрбум төгрөг 41

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
9020020699 ... 0096
УЛААНБААТАР ХОТ

InvesCore CAPITAL
6317839 ... 111927710
УЛААНБААТАР ХОТ

000326

Үнэт цаас гаргагч ..... Андеррайтер .....

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Хүснэгт 24. Арилжааны шимтгэлийн төсөөллөл, 2022 – 2027, хувиар 41
Хүснэгт 25. МХБ-ийн орлогын төсөөллөл, 2022 – 2027, сая төгрөгөөр 42
Хүснэгт 26. МХБ-ийн зардлын төсөөллөл, 2022 – 2027, сая төгрөгөөр 42
Хүснэгт 27: МХБ ТӨХК-ийн орлогын төсөөлөл, 2022 – 2027 он 45
Хүснэгт 28: МХБ ТӨХК-ийн үнэлгээний үр дүн 47
Хүснэгт 29: МХБ ТӨХК-ийн үнэлгээний үр дүнгийн муу хувилбарын шинжилгээ 47

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН -	Аж ахуйн нэгж
ДНБ -	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ -	Засгийн газар
ЛХБ -	Лондонгийн Хөрөнгийн Бирж
ЛХБГ -	Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп
МХБ -	Монголын Хөрөнгийн Бирж
СЗХ -	Санхүүгийн Зохицуулах Хороо
ТӨХК -	Төрийн Өмчит Хувьцаат Компани
ҮОУС -	Үнэлгээний Олон Улсын Стандарт
ХК -	Хувьцаат Компани
ЭТТ -	Эрдэнэс Тавантолгой ХК

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
9020020699
УЛААНБААТАР ХОТ

000327

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
ОН сар ӨДӨР
2022 12 15
БҮРТГЭВ
№ 01 15

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ
ЭСТИМЭЙТ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

1. ЕРӨНХИЙ ТОЙМ

Тайлангийн өдөр	2022 оны 12-р сарын 7-ны өдөр
Үйлчлүүлэгч	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК Чингэлтэй дүүргийн 1-р Хороо, Сүхбаатарын талбай-3, Улаанбаатар 15160, Монгол улс
Үнэлгээнд хамрагдсан хөрөнгө	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн 100%-ийн бизнес өмчлөл. Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн хуулбарыг Хавсралт 1-д үзүүлэв.
Үнэлгээний өдөр	2022 оны 6-р сарын 30-ны өдөр
Үнэлгээний стандартын нийцэл	Үнэлгээний Олон Улсын Стандарт 2022 (ҮОУС 2022)
Тайлангийн зорилго / Үнэлгээний ажлын заавар	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн нэмэлт хувьцааг биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгох ажлын хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.15-д заасан үнэт цаасны танилцуулга бэлтгэх зорилгоор Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС) болон Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн дагуу бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийж гүйцэтгэх
Ашигласан үнэ цэнийн суурь	Зах зээлийн үнэ цэн
Бизнес өмчлөлийн тооцоолсон нийт үнэ цэн	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэ цэнийг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 36,753,598,659 (Гучин зургаан тэрбум долоон зуун тавин гурван сая таван зуун ерэн найман мянга зургаан зуун тавин ес) төгрөг байхаар тооцоолов. Зах зээлийн харьцуулалтын аргаар хийсэн үнэлгээний шинжилгээгээр Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн 100% бизнес өмчлөлийн үнэлгээ 2022 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар 35,570.7 – 38,176.7 сая төгрөгийн хооронд байхаар гарсан нь дээрх үр дүнг дэмжиж байна. Бидний үнэлгээ дараах мэдээлэлд тулгуурласан болно. Үүнд: • Санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөө, санхүүгийн загвар гэх зэрэг Үйлчлүүлэгчээс ирүүлсэн мэдээлэл; • Зах зээлийн судалгаанаас боловсруулсан мэдээлэл; • Бидний тооцоолол, таамаглал болон салбарын талаарх мэдлэг зэрэг багтана. Бид Үйлчлүүлэгчээс өгсөн мэдээлэл болон бичиг баримтын

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020698 ... 1096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 ... 1128
УЛААНБААТАР ХОТ

000328

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЭХ
он сар өдөр
2022 12 15
БҮРТГЭВ
№ 12 15

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ
ЭСТИМЭЙТ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

буруу зөвд хариуцлага хүлээхгүй болно.

Таамаглал

Тооцооны нэгж: Олон улсын хөрөнгийн биржүүд нь арилжааны үндсэн үйл ажиллагаанаас гадна өөрсдийн клирингтэй, эсвэл клиринг эзэмшдэг толгой компанийн дор зэрэгцээ компани байдлаар ажиллаж байна. Үнэлгээний өдрийн байдлаарх бодит нөхцөл байдалтай уялдуулан Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл зарим үйл ажиллагааг хэсэгчлэн бусад компанитай нэгтгэх, нийлүүлэхээс үүсэх үр дагаврыг энэхүү үнэлгээний ажилд тооцоолоогүй, бие даасан байдлаар үнэлсэн болно.

Нэмэлт санхүүжилт: Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК нь хувьцаагаа биржээр дамжуулан олон нийтэд санал болгож нээлттэй компани болсноор тус компанийн бизнес төлөвлөгөөнд туссан ажлууд хэрэгжих бодит боломж бүрдэнэ. Түүнчлэн олон нийтээс нэмэлтээр татах санхүүжилтээс хийхээр төлөвлөсөн технологийн шинэчлэл нь тус компанийн бизнес төлөвлөгөөг бодит ажил хэрэг болгоход чухал үүрэг гүйцэтгэхээр байна. Иймд энэ үнэлгээ нь нэмэлт санхүүжилт орж ирсэний дараах үеийн үнэлгээ буюу Post-Money Valuation болно.

Тасралтгүй байдал: Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК нь цаашид бизнесийн үйл ажиллагааг бизнес төлөвлөлтийн дагуу тасралтгүй үргэлжлүүлнэ гэж үзэв.

Газар дээрх үзлэг, шалгалт, баримтын хадгалалт

Бид Үйлчлүүлэгчийн бизнестэй танилцах, мэдээлэл авах уулзалтуудыг 2022 оны 11-р сарын 14-ний өдрөөс үнэлгээний тайлангийн өдөр хүртэл тогтмол хийж ажиллав. Бизнесийн болон бусад холбогдох мэдээллийг үнэлгээний ажлын явцад цахим шуудангаар авч үнэлгээнд ашиглав.

Стандартаас гажсан эсэх

Гажаагүй

Үнэлгээчид

Үнэлгээчид нь Үйлчлүүлэгчээс өгсөн даалгаврын дагуу энэ төрлийн бизнесийн үнэлгээг хийх туршлагатай гэдгээ үүгээр баталж байна.

- Үнэлгээчин Д.Гантулга нь Мэргэшсэн Үнэлгээчдийн Рояал Институтын (RICS) гишүүн, бизнес болон биет бус хөрөнгийн үнэлгээгээр мэргэшсэн үнэлгээчин бөгөөд бизнесийн үнэлгээний ажлыг удирдаж, үнэлгээний тайланг бэлтгэсэн болно.
- Үнэлгээчин Д.Ганбаатар нь Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн гүйцэтгэх захирал бөгөөд үнэлгээний ажлыг зохион байгуулалтыг хангаж ажиллав.
- Тэргүүлэх үнэлгээчин Д.Барсболд нь ШУТИС-д ажилладаг Бизнесийн ухааны доктор бөгөөд Орлогын

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
ХАЛАНБААТАР ХОТ

ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ☎ 1119
ХАЛАНБААТАР ХОТ

000329

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
No.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ
2022-12-12
БҮРТГЭВ 02

хандлагын аргын үнэлгээний багт ажиллав.

- Үнэлгээчин Л.Халиун нь АССА буюу олон улсын Мэргэшсэн нягтлан бодогч бөгөөд Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн зөвлөх үнэлгээчнээр ажилладаг. Энэ үнэлгээний ажлын Зах зээлийн хандлагын аргын багийн ахлагчаар ажиллав.
- Үнэлгээчин Д.Мөнхбат нь Эм Би Ви Си ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилладаг бөгөөд энэ үнэлгээний ажлын Зах зээлийн хандлагын аргын багийн гишүүнээр ажиллав.
- Үнэлгээчин Г.Санжаасүрэн нь CFA буюу олон улсын Мэргэшсэн санхүүгийн шинжээч бөгөөд Зах зээлийн хандлагын багийн гишүүнээр ажиллав.
- Тэргүүлэх үнэлгээчин И.Гүррагчаа нь үнэлгээчин, аудитор бөгөөд Хүлэгтхүннү Аудит ХХК-ийн захирлаар ажилладаг. Энэ үнэлгээнд Хөрөнгөд суурилсан үнэлгээний багийн ахлагчаар ажиллав.
- Тэргүүлэгч үнэлгээчин Ц.Баатар нь үнэлгээний салбарт 20 гаруй жил ажилласан туршлагатай, энэ үнэлгээний ажлын Хөрөнгөд суурилсан үнэлгээний багийн гишүүнээр ажиллав.
- Тэргүүлэх үнэлгээчин Ц.Сэржээ нь Тэнгэрийн Гэрэл Үнэлгээ ХХК-ийн захирлаар ажилладаг бөгөөд үнэлгээний ажлын 25 жилийн туршлагатай. Энэ үнэлгээнд Хөрөнгөд суурилсан үнэлгээний багийн гишүүнээр ажиллав.
- Тэргүүлэх үнэлгээчин Ц.Алтан-Алим нь үнэлгээний ажлын 25 орчим жилийн туршлагатай үнэлгээчин бөгөөд энэ үнэлгээний ажлын Хөрөнгөд суурилсан үнэлгээний багийн гишүүнээр ажиллав.

Үнэлгээчдийн сертификатын хуулбарыг Хавсралт 3-д үзүүлэв.

Ашиг сонирхлын зөрчил	Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд бидэнд аливаа сонирхлын зөрчил байхгүй болно.
Тайлангийн хэрэглэгчид / Нууцлал	Энэхүү тайлан нь зөвхөн Үйлчлүүлэгч болон түүнтэй холбоотой компанид зориулж дээр дурдсан зориулалтаар бэлтгэгдсэн бөгөөд гуравдагч этгээдийн өмнө нийт болон хэсэгчилсэн агуулгын талаар хариуцлага хүлээхгүй болно.
Тайлангийн хэрэглээ	Урьдчилан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн тараахыг хориглоно.
	Урьдчилан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд Үйлчлүүлэгч компани болон түүнтэй холбоотой компанитай холбоотой бусад компани нь олон нийтэд гаргах аливаа баримт, мэдээлэл, мэдэгдэлд энэхүү үнэлгээний ажилтай

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨВӨӨ МОНГОЛЫН
STOCK EXCHANGE
9020020690
УЛААНБААТАР ХОТ

InvesCore CAPITAL
6317839

000330

Үнэт цаас гаргагч Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ Эстимэйт
БҮРТГЭВ-02

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№01

холбоотойгоор Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн болон Үнэлгээчдийн нэрсийг дурдахыг хориглоно.

Энэхүү тайланг бизнесийн үнэлгээний чиглэлээр тодорхой мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс ашиглахад зориулж бэлтгэв. Үнэлгээний үр дүнгийн талаар аливаа санал, дүгнэлт гаргахын өмнө энэхүү тайланг бүхлээр нь уншиж танилцахыг зөвлөж байна. Энэхүү тайлантай холбоотой тайлбар авах, тодруулга хийх шаардлага гарсан тохиолдолд бидэнтэй холбоо барихыг хүсч байна.

Мэргэжлийн хариуцлагын даатгал	Үнэлгээчид нь Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 28-р зүйлд заасны дагуу Үнэлгээчний хариуцлагын даатгалд хамрагдсан болно.
Бусад	Тайланг Монгол хэл дээр бэлтгэсэн бөгөөд нэмэлт материалыг үндсэн эхийн хуулбар байдлаар хавсралтад үзүүлэв.

ХӨРӨНГИЙН МОНГОЛЫН
9020020699 2011096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000331

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ
ЭСТИМЭЙТ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2. АШИГЛАЛТЫН НӨХЦӨЛҮҮД

Үнэлгээний үр дүнг ашиглахаас өмнө үнэлгээнд ашигласан дараах үндсэн таамаглал болон өгөгдлүүдтэй танилцахыг зөвлөж байна.

Тооцооны нэгж: Олон улсын хөрөнгийн биржүүд нь арилжааны үндсэн үйл ажиллагаанаас гадна өөрсдийн клирингтэй, эсвэл клиринг эзэмшдэг толгой компанийн дор зэрэгцээ компани байдлаар ажиллаж байна. Үнэлгээний өдрийн байдлаарх бодит нөхцөл байдалтай уялдуулан Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл зарим үйл ажиллагааг хэсэгчлэн бусад компанийн үйл ажиллагаатай нэгтгэх, нийлүүлэхээс үүсэх үр дагаврыг энэхүү үнэлгээний ажилд тооцоолоогүй, бие даасан байдлаар үнэлсэн болно.

Нэмэлт санхүүжилт: Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК нь хувьцаагаа биржээр дамжуулан олон нийтэд санал болгож нээлттэй компани болсноор тус компанийн бизнес төлөвлөгөөнд туссан ажлууд хэрэгжих бодит боломжтой болно. Тус компани нь олон нийтээс нэмэлтээр татах санхүүжилтээс 5.3 тэрбум орчим төгрөгөөр технологийн шинэчлэл хийхээр төлөвлөж байна. Энэ хөрөнгө оруулалтыг хийснээр тус компанийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Иймд энэ үнэлгээ нь нэмэлт санхүүжилт орж ирсний дараах үеийн үнэлгээ буюу Post-Money Valuation болно.

Тасралтгүй байдал: Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК нь цаашид бизнесийн үйл ажиллагааг төлөвлөлтийн дагуу тасралтгүй үргэлжлүүлнэ гэж үзэв.

Мэдээллийн найдвартай байдал: Энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхэд Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК болон хувьцаа эзэмшигч Сангийн яамнаас гарган өгсөн тоон болон чанарын мэдээллийг ашигласан болно. Бид эдгээр мэдээллийн үнэн зөв байдал болон дотоод зөрчилдөөнтэй эсэхэд тойм шинжилгээ хийсэн боловч өөрсдийн зүгээс аудитын шалгалт, дүгнэлт хийлгээгүй болно. Үнэлгээний үр дүнгийн нарийвчлал нь мэдээллийн чанар, бүрэн бүтэн байдалтай шууд хамааралтай. Иймд энэ тайланд алдаатай мэдээлэл орсон бол бидэнд мэдэгдэхийг хүсье. Нэмэлт мэдээлэлд үндэслэн тайланг засварлан өөрчлөх боломжтой.

Үнэлгээний үр дүнгийн найдвартай байдал: Аливаа бизнесийн зах зээлийн үнэ цэнийн тооцооллын найдвартай байдал нь хязгаарлагдмал байдаг. Энэ нь тус компанийн ирээдүйн ашигт ажиллагааны талаарх худалдагч болон худалдан авагчийн төсөөлөл зөрөх, хүлээж байгаа эрсдэлийн түвшин ялгаатай байх зэргээс хамаарч бизнес өмчлөлийн үнэ цэн нь талуудад өөр өөр байх боломжтой юм.

Цаашилбал, бизнесийн өмчлөлийн үнэ цэн нь ирээдүйд болох үйл явдлуудаас, тухайлбал зохицуулалтын болон хууль хяналтын байгууллагын шийдвэр, инфляцын өөрчлөлт, макро эдийн засгийн үзүүлэлтүүд зэргээс хамаарч өөрчлөгддөг онцлогтой.

Үнэлгээний өдрийн байдлаар Орос Украйны дайнаас үүдэлтэй дэлхийн улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал, дэлхий даяар тархсан КОВИД-19 цар тахлын эдийн засаг, бизнест үзүүлэх нөлөө зэрэг нь Үйлчлүүлэгчийн мөнгөн урсгалын ирээдүйн төсөөллийн тодорхойгүй байдлыг улам бүр ихэсгэж байна.

Үнэлгээний аргачлал, орц, таамаглал: Энэхүү ажилд хэрэглэсэн үнэлгээний аргачлал, орц, таамаглалууд нь үнэлгээний өдрийн байдлаар үнэлгээний ажлын зорилготой нийцэх ба

УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
000332

Үнэт цаас тарган
Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ эстимэйт
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

СЗХ
БҮРТГЭВ

үнэлгээний үр дүн нь үнэлгээнд ашигласан мэдээллүүдийн хүрээнд харьцангуй бодит тооцоолсон гэж үзэж байна.

МХБ ТӨХК-ийн орлогын төсөөллийн хүрээнд: Монгол Улсын Засгийн газар болон холбогдох яамд нь төрийн өмчит компаниудын IPO хийж олон нийтийн компани болгох, нүүрсний цахим арилжааг амжилттай ажиллуулах, жил бүр Засгийн газрын бонд гаргах зэрэг төлөвлөсөн ажлуудаа төлөвлөсөн дүнгээр, төлөвлөсөн хугацаанд хийнэ гэж таамаглав.

Тооцооны аргачлалаас хамаарч тайлангийн зарим үзүүлбэр болон хүснэгтэд орсон тоон үзүүлэлтүүд нь нарийвчлал өндөртэй гарсан болно. Иймд тайланд орсон үнэлгээний үзүүлэлтүүдийг бүхэлчилсэнтэй холбоотойгоор үр дүн бага хэмжээгээр зөрж болохыг анхаарна уу.

Тайлангийн хэрэглээ: Бидний хэрэглэсэн нарийвчилсан таамаглалууд болон бусад хязгаарлалтууд нь тайлангийн зохих бүлгүүдэд дурдагдсан болно. Энэ бүлэг нь тайлангийн зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг ба аливаа бүлгийг дангаар авч үзэн дүгнэлт гаргах нь буруу зөрүүтэй ойлголтод хүргэх боломжтой тул тайланг бүхэлд нь үзэж судлахыг зөвлөж байна.

Урьдчилан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн тараах, Үйлчлүүлэгч компани болон тус компанитай холбоотой бусад компани нь үнэлгээний ажлын зориулалтаас өөр зориулалтаар олон нийтэд гаргах аливаа баримт, мэдээлэл, мэдэгдэлд энэхүү үнэлгээний ажилтай холбоотойгоор Гэрэгэ Эстимэйт ХХК болон Үнэлгээчдийн нэрсийг дурдахыг хориглоно.

Энэхүү тайланг бизнесийн үнэлгээний чиглэлээр тодорхой мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс ашиглахад зориулж бэлтгэв. Үнэлгээний үр дүнгийн талаар аливаа санал, дүгнэлт гаргахын өмнө энэхүү тайланг бүхлээр нь уншиж танилцахыг зөвлөж байна. Энэхүү тайлантай холбоотой тайлбар авах, тодруулга хийх шаардлага гарсан тохиолдолд бидэнтэй холбоо барихыг хүсье.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
9020020699 ⚓ 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ⚓ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч

000333

Андеррайтер

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭЭГЭ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

3. ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Макро эдийн засгийн төлөв байдал

Дотоодын эдийн засаг

Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2015 оны зэрэгцүүлэх үнээр сүүлийн 6 жилийн хугацаанд өөрчлөлт багатай буюу ойролцоогоор 23 - 28 их наяд төгрөгийн хооронд хэлбэлзэж байна. Монгол Улсын ДНБ-ийн бодит өсөлт 2018 онд 7.6%-д хүрч байсан боловч Ковид 19 цар тахлын улмаас 2020 онд - 4.4%-д хүрч, 2021 оноос эргэн сэргэж 1.4%-д хүрсэн байна.

ДНБ-ний 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон дүн болон өсөлт, бууралтыг доор үзүүлэв.[1]

Зураг 1. ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, өсөлт, бууралт



Олон Улсын Валютын Сангаас Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг үнэлгээний өдрийн байдлаар дараах байдлаар төсөөлж байна.[2]

Хүснэгт 1. Монгол улсын эдийн засгийн төсөөлөл, тэрбум төгрөгөөр

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2026
ДНБ, оны үнээр	43,018.6	52,893.5	64,730.2	76,159.8	88,186.9	100,018.1
ДНБ, бодит өсөлт	1.4%	2.0%	7.0%	6.5%	6.0%	5.5%
Инфляци	13.5%	17.5%	11.5%	10.0%	8.0%	7.0%
Ажилгүйдлийн түвшин	6.3	5.7	5.1	5.0	5.0	5.0
Засгийн газрын өр	40,735.3	43,389.1	45,689.7	48,962.5	53,124.0	57,992.4

[1] Үндэсний Статистикийн Хороо, www.1212.mn
[2] https://www.imf.org/en/Publications/WEO/weo-database/2022/April

ХӨРӨНГИЙН
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч 000334 Андеррайтер

ДНБ-д санхүү болон даатгалын үйл ажиллагаанаас олох орлогын эзлэх хувь жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Санхүү болон даатгалын үйл ажиллагаанаас олсон орлого 2016 онд ДНБ-ий 3.8%-ийг эзэлж байсан бол 2021 онд 5.1% хүртэл өсөн нэмэгдсэн байна.[1]

Зураг 2. ДНБ-д санхүү болон даатгалын үйл ажиллагааны эзлэх хувь



Мөнгөний нийлүүлэлт

2022 оны 6-р сарын байдлаар валютын хадгаламж 4.5 их наяд төгрөг болж өмнөх сараас -3.7%-иар, төгрөгийн хадгаламж 13.8 их наяд төгрөгт хүрч өмнөх сараас -8.9%-иар түс түс буурсан байна.

Мөнгөний М2 нийлүүлэлт 2022 оны 6-р сарын эцэст -1.3%-аар буурч 27.6 их наяд төгрөг болсон.[1]

Зураг 3. Монгол улсын мөнгөний нийлүүлэлт



Төгрөгийн ханш

Монголбанкны статистик мэдээгээр төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2021 оны жилийн эцсийн байдлаар 2,849.34 төгрөг, 2022 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар 3,134.1 төгрөгт хүрч, өмнөх оны дүнгээс 10% өссөн үзүүлэлттэй байна.[3]

[3] https://www.mongolbank.mn/liststatistic.aspx?id=3

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ТЭРЭЭС
ЭСТИМЭЙТ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Хүснэгт 2. Монголын эдийн засгийн ханшийн мэдээлэл

Ханш	2019		2020		2021		2022.Q2	
	Нэгж үнэ	Өсөлт	Нэгж үнэ	Өсөлт	Нэгж үнэ	Өсөлт	Нэгж үнэ	Өсөлт
АНУ доллар	2 734.3	3.4%	2 849.9	4.2%	2 849.34	0.0%	3 134.1	10%
Евро	3 063.5	1.3%	3 504.5	14.4%	3 221.2	-8.1%	3 273.6	1.6%
БНХАУ-ын юань	392.4	2.1%	436.23	11.2%	447	2.5%	468.1	4.7%
ОХУ-ын рубль	44.06	16.0%	38.11	-13.5%	38.1	-0.1%	59.33	56%

Инфляци

Монгол банкны бодлогын хүү 2016 онд хамгийн дээд түвшин буюу 15% хүрч байсан ба аажмаар буурсан. Харин КОВИД-19 цар тахлаас хойш инфляцийг бууруулах зорилгоор бодлогын хүүг дахин өсгөсөн ба 2022 оны 6-р сарын байдлаар бодлогын хүү 10%, тайлангийн өдрийн байдлаар 12.0% байна. Инфляци 2022 оны 2-р улирлын байдлаар улсын хувьд 14.5%, Улаанбаатар хотын хувьд 14.6% болсноор инфляцын зорилтот түвшин болох 6% (+/-2%)-аас харьцангуй өндөр хэвээр байна.

Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй бүх хувьцааны зах зээлийн нийт үнэлгээ нь 2021 онд өмнөх оноос 97.5%-иар өссөн байна. Мөн 2016-2021 оны хооронд CAGR 26.3% гарч, тухайн жилийн эцсийн байдлаар 5.98 их наяд төгрөгт хүрсэн байна.[1]

Зураг 4. Монголын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон ДНБ-т эзлэх хувь



Монголын Хөрөнгийн Биржийн зах зээлийн нийт үнэлгээ нь 2021 онд ДНБ-ний 13.7%-д хүрсэн бол Вьетнам, Индонез, Хятад, Чили улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь харгалзан 68.6%, 46.9%, 83.0%, 73.0%-тай байна.

Арилжааны мэдээлэл

2022 оны эхний хагаст анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаа нийт 113.7 тэрбумд хүрсэн байна.[4]

[4] Санхүүгийн Зохицуулах Хороо, http://www.frc.mn/d/s/2

ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL
Үнэт цаас гаргагч
000336
Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭЭГЭЭ
2022 12 12
БҮРТГЭВ-02

Зураг 5. Анхдагч, хоёрдогч зах зээлийн арилжаа болон хөрвөх чадвар



Монгол улсын хувьд хувьцааны хөрвөх чадвар 2021 оны жилийн эцсийн байдлаар 2.25 пунктээр өсөж 3.8 хувьд хүрсэн бол 2022 оны хагас жилийн байдлаар 2.3 хувь болж буурсан байна. Мөн 2022 оны хагас жилийн байдлаар хоёрдогч зах зээлийн арилжааны дүн 113.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хувиар буурсан байна. Арилжаанд эзлэх хувиар гадаадын ААН 1.0%, гадаадын иргэн 1.7%, дотоодын ААН 45.5%, дотоодын иргэд 51.9% тус тус эзэлж байна.[1]

Зураг 6. Монголын үнэт цаасны арилжааны үнийн дүн



2022 оны эхний хагаст 122 удаагийн арилжаагаар 135 ХК-ийн 151.09 сая ширхэг хувьцааг 113.7 тэрбум төгрөгөөр арилжаалагдсан байна. Эдгээрээр 38 компанийн үнэт цаасны ханш өсөж, 91 компанийн үнэт цаасны ханш буурсан үзүүлэлттэй байна. “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн үнэт цаасны ханш 65.5 хувиар буурсан нь хамгийн их буурсан үзүүлэлтэй байна.[4]

Хүснэгт 3. 2022 оны хагас жилийн хамгийн өндөр үнэлгээтэй 15 арилжааны дүн

№	Компанийн нэр	Арилжааны дүн, тэрбум төгрөгөөр
1	“АПУ” ХК	52.53
2	"Ард санхүүгийн нэгдэл" ХК	18.88

ХӨРӨНГИЙН БИРЖ
МОНГОЛЫН
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
000337

Үнэт цаас тараагч _____ Андеррайтер _____

СЭХ
он сар өдөр
2022 12 15
БҮРТГЭВ
№ 02 15

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

3	"Хөсөг трейд" ХК	14.26
4	"Сентрал экспресс Си Ви Эс" ХК	3.64
5	"Түмэн шувуут" ХК	2.66
6	"Монос Хүнс" ХК	2.56
7	"Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн" ХК	2.41
8	"Ард Даатгал" ХК	2.05
9	"Мандал даатгал" ХК	1.86
10	"Бодь Даатгал" ХК	1.47
11	"Говь" ХК	1.43
12	"Улсын их дэлгүүр" ХК	1.03
13	"Ард кредит ББСБ" ХК	0.87
14	"Инвескор ББСБ" ХК	0.84
15	"Талх чихэр" ХК	0.79

Хүснэгт 4. Монголын үнэт цаасны арилжааны мэдээлэл

Үзүүлэлт	2022.01	2022.02	2022.03	2022.04	2022.05	2022.06
Арилжигдсан үнэт цаасны тоо	116	105	98	96	117	95
Зах зээлийн үнэлгээ /их наяд төгрөг/	5.8	5.5	5.4	5.2	4.9	4.8
Зах зээлийн үнэлгээ /тэрбум доллар/	2	1.9	1.8	1.7	1.6	1.5
Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг /сая/	36.3	41.4	21.3	23.5	18.4	16.5

Зураг 7. МХБ-ын ТОП 20 индексийн сарын стандарт хазайлт



Монголын Хөрөнгийн Биржийн Топ 20 индексийн өгөөжийн сарын стандарт хазайлт 2021 онд өсч, 2021 оны 8-р сард 2.1%-иар дээд цэгтээ хүрсэн нь хөрөнгийн зах зээлийн хэлбэлзэл өндөр байгааг харуулж байна. Харин өмнөх 3 жилийн хугацаанд стандарт хазайлт бага байсан байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
STOCK EXCHANGE
9020020699 ☎ 207 096
УЛААНБААТАР ХОТ

ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 ☎ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____ 000338 Андеррайтер _____

СЗХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭЭГЭЭ
БҮРТГЭВ-02

Бусад биржийн мэдээлэл

Монгол Улсад Монголын Хөрөнгийн Биржээс гадна үнэлгээний өдрийн байдлаар үнэт цаасны биржийн үйл ажиллагаа явуулах эрхтэй Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК ажиллаж байна. Харин тайлангийн өдрийн байдлаар Чингис Хаан Хөрөнгийн Бирж ХХК нь СЗХ-оос үнэт цаасны арилжаа эрхлэх түсгай зөвшөөрөл авсан бөгөөд үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж (https://ubx.mn) нь 2015 оны 5 дугаар сарын 1-ний өдөр үүсгэн байгуулагдаж, 2017 онд хаалттай хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөн.

Биржийн үндсэн үйл ажиллагаанд бүртгэл, анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, мэдээлэл нийлүүлэх, арилжааны хяналтыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоо гэсэн үйл ажиллагаа багтдаг. Биржийн болон биржийн бус зах зээл дээр Нэрэн Клиринг ХХК, Харз Трейд ББСБ, Бумбат Алтай ҮЦК-тай клирингийн гэрээг байгуулж арилжааны төлбөр тооцоог хийж гүйцэтгэдэг.

2021 оны эцэст нийт 19 гишүүн үнэт цаасны компани, 5 тооцооны гишүүн, 2 зах зээл үүсгэгчтэйгээр үйл ажиллагаа явуулсан.

Түс биржээр дамжуулж 2021 онд нийт 24.7 сая төгрөгийн 383,300 ширхэг хувьцаа арилжаалагдсан. Тооцооны гишүүдээр дамжуулан нийт 20.7 сая төгрөгийн төлбөр тооцоог гүйцэтгэсэн. Бирж нь 2019 оноос хойш биржийн бус зах зээлийн зарим төлбөр тооцоог гүйцэтгэж ирсэн бөгөөд 2021 онд биржийн бус зах зээлд нийт 6.5 тэрбум төгрөгийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн байна.

UBX платформ нь хувьцаа, бонд, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, фьючерс, опцион зэрэг үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжих, тооцоолол хийх уян хатан бүтэцтэй платформ юм. 2021 онд ҮЦТХТ-тэй үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог тасралтгүй найдвартай хийх зорилгоор гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Түүнчлэн, харилцагчид “Ard app” ашиглан UBX биржийн арилжаанд шууд оролцох боломжтой болсон.[5]

[5] https://ubx.mn

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨРӨХ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЭХ
БҮРТГЭВ
2022 №2015

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

4. МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК-ИЙН ТУХАЙ

Ерөнхий мэдээлэл

"Монголын Хөрөнгийн Бирж" Төрийн Өмчит Хувьцаат Компани нь 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр өмч хувьчлалын ажлыг эхлүүлж, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор үүсгэн байгуулагдсан. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хөрөнгө оруулалтын арилжааг дэмжих зорилгоор өрийн хэрэгсэл, хувьцаа болон бусад санхүүгийн хэрэгслийн арилжааг бүртгэж, өдөр тутмын арилжаагаар хангах явдал юм. Одоогийн байдлаар компанийг Монгол Улсын Сангийн Яамаар дамжуулан Монгол Улсын Засгийн Газар 100% эзэмшдэг. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоолын дагуу Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-ийн 34%-ийг олон нийтэд нээлттэй худалдан нээлттэй хувьцаат компани болгохоор шийдвэрлээд байна..



Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-д 2021 оны 12 сарын 31- ний байдлаар 179 ХК бүртгэлтэй байгаагаас 17 буюу 9.5% нь 100 хувь төрийн өмчит, 9 буюу 5% нь төрийн өмчийн оролцоотой, 153 буюу 85.5% нь бүрэн хувьчлагдсан компани байна. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар I ангилалд 22, II ангилалд 41, III ангилалд 115 хувьцаат компани багтаж байна.

Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй 179 компанийг үйл ажиллагааны чиглэлээр нь ангилахад дараах байдалтай байна. Үүнд санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 20 компани багтаж байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.



МХБ-ийн зах зээлийн үнэлгээ, түүний ДНБ-д эзлэх хувь, ТОП-20 индексийн жилийн дундаж үзүүлэлт, бүртгэлтэй компаний тоо, өдрийн дундаж арилжааг 2017-2021 оны байдлаар доор харуулав. ДНБ-д эзлэх зах зээлийн үнэлгээ дунджаар 8%-тай байсан бол 2021 онд Богд банк, Сэнтрал Экспресс Си Ви Эс компаниуд шинээр бүртгүүлж, Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн нэмж хувьцаа гаргасан, АПУ ХК анхны их наядын үнэлгээтэй компани болсон

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE
000340
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК InvesCore CAPITAL
Үнэт цаас гаргагч
Андеррайтер

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭГЭ
БҮРТГЭВ-02

зэргээс шалтгаалан зах зээлийн үнэлгээ огцом өсч, ДНБ-д эзлэх зах зээлийн үнэлгээ 13.7% болсон байна.[6]

Хүснэгт 5. МХБ-ийн үндсэн үзүүлэлт 2017-2022 он

Үзүүлэлт	Нэгж	2017	2018	2019	2020	2021	2022/06/30
Зах зээлийн үнэлгээ	их наяд, ₮	2.44	2.51	2.69	3.03	5.97	4.8
ДНБ, орлогын аргаар	их наяд, ₮	28.01	32.58	37.84	37.45	43.56	23.00
ДНБ-д эзлэх хувь	%	8.7%	7.7%	7.1%	8.1%	13.7%	
ТОП-20 индекс /жилийн дундаж/	нэгж	15,512	20,155	19,977	17,398	35,046	37,884
Бүртгэлтэй компаний тоо	ширхэг	218	217	198	192	179	178
Өдрийн дундаж арилжаа	Сая, ₮	307	833.3	570	263	5,700	2,261

Санхүүгийн мэдээлэл

МХБ ТӨХК-ийн баланс болон орлого үр дүнгийн гол үзүүлэлтүүдийг 2017-2021 он, 2021 оны 7-р сарын 1-ний өдрөөс 2022 оны 6-р сарын 30-ны өдрийг хүртэл 1 жилийн хугацаагаар дор хураангуйлан үзүүлэв.

Хүснэгт 6. МХБ-ийн балансын үзүүлэлтүүд, 2017-2022 он

Балансын үзүүлэлтүүд, сая төгрөгөөр	2017	2018	2019	2020	2021	2022/06/30
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,306.9	830.4	953.4	554.6	2,729.4	2,511.9
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,434.7	1,187.3	1,050.5	685.7	2,874.0	2,631.0
Үндсэн хөрөнгө	2,264.1	2,172.0	2,083.7	2,210.7	2,102.2	5,585.5
Биет бус хөрөнгө	1,271.9	1,192.7	653.0	561.9	382.3	17,898.7
Нийт хөрөнгийн дүн	4,970.7	4,552.0	3,787.3	3,458.3	**5,358.6**	**26,115.2**
Өр төлбөрийн дүн	373.5	1,214.6	1,605.0	2,205.4	941.1	2,429.2
Хувьцаат капитал	21,884.0	23,130.6	23,131.0	23,131.0	23,131.0	23,130.6
Дахин үнэлгээний нэмэгдэл					12.4	18,887.5
Хуримтлагдсан алдагдал	(18,992.1)	(20,251.9)	(21,407.0)	(22,336.3)	(19,171.8)	(18,778.4)
Эздийн өмчийн дүн	4,597.2	3,337.3	2,182.3	1,253.0	4,417.5	23,686.0
Өр төлбөр ба эздийн өмч	4,970.7	4,552.0	3,787.3	3,458.3	**5,358.6**	**26,115.2**
Хувьцааны тоо ширхэг /сая/	219	231	231	231	231	231
Нэгж хувьцааны дансны үнэ /төгрөг/	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

МХБ нь 2021 оноос эхлэн борлуулалтын орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор ашигтай ажиллаж эхэлсэн. Энэ нь шинээр бүртгэгдсэн хувьцаат компаниудын тоо нэмэгдсэн, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдсэн, хамгийн гол нь компаниуд хөрөнгийн биржээр дамжуулан өрийн бичиг ихээр гаргах болсонтой холбоотойгоор арилжааны орлого эрс нэмэгдсэн байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт арилжааны үнийн дүнгийн 74%-ийг компанийн бондын, 22%-ийг хувьцааны, 4%-ийг хөрөнгө оруулалтын сангийн, 0.3%-ийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа эзэлж байна.[7]

[6] Монголын хөрөнгийн бирж, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.mse.mn
[7] МХБ-ийн 2021 оны жилийн тайлан, www.mse.mn

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
9020020699
УЛААНБААТАР ХОТ
000341
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ГЭРЭЭГЭ ЭСТИМЭЙТ
2022 -12- 12
БҮРТГЭВ

Хүснэгт 7. МХБ-ийн орлого үр дүнгийн үзүүлэлтүүд 2017-2022 он

Орлогын үзүүлэлтүүд /сая төгрөг/	2017	2018	2019	2020	2021	2021/7/1-2022/6/30
Борлуулалтын орлого	1,836.4	1,657.0	1,474.7	1,100.1	5,483.1	4,372.0
Ерөнхий, удирдлагын зардал	1,238.0	1,290.4	2,605.0	2,088.5	2,136.3	2,038.3
Элэгдэл, хорогдуулгын зардал	620.9	631.3	693.1	266.1	239.7	248.2
Орлогын албан татварын зардал	54.9	9.4	6.7	2.0	168.2	275.5
Тайлант үеийн ашиг/алдагдал	**(233.2)**	**(1,259.8)**	**(1,155.0)**	**(1,037.8)**	**3,184.1**	**2,109.2**
ROE	-5%	-38%	-53%	-83%	72%	9%
EPS	(1.07)	(5.45)	(4.99)	(4.49)	13.77	9.12
Цэвэр ашгийн маржин	-13%	-76%	-78%	-94%	58%	48%

Борлуулалтын орлогын 2021 оны бүтцийг авч үзвэл хувьцааны арилжааны шимтгэлийн орлого хамгийн өндөр буюу 51%-ийг, бүртгэлтэй компанийн жилийн хураамжийн орлого 20%-ийг тус тус эзэлж байна. Цаашид хөрөнгө оруулалт хийж хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлснээр шимтгэлийн орлого нэмэгдэх боломжтой.

Зураг 8. МХБ-ын 2021 оны борлуулалтын орлогын бүтэц



ХӨРӨНГИЙН БИРЖ ХХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277139
УЛААНБААТАР

000342

Үнэт цаас гаргагч Андеррайтер

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

5. ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Сангийн сайд болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2011 оны 12-р сарын 30-ны өдрийн 274/240 тоот хамтарсан тушаалаар баталсан "Бизнесийн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу үнэлгээнд Зах зээлийн харьцуулалтын хандлага, Хөрөнгөд суурилсан хандлага, Орлогын хандлагыг авч үзэв.

ҮОУС-д заасан үнэлгээний мэргэжлийн нэр томъёо, тодорхойлолтыг Хавсралт 2-т үзүүлэв.

Зах зээлийн харьцуулалтын үнэлгээ

Зах зээлийн харьцуулалтын шинжилгээг хийхдээ FTSE Russell компаний хувьцааны зах зээлийн олон улсын ангиллыг[8] гол хүчин зүйл болгов. Энэхүү ангилалд нийт 78 улс багтаж байгаа бөгөөд хувьцааны зах зээлийн хөгжлөөр нь улсуудыг "Хөгжсөн" (Advanced), "Дэвшилтэт хөгжиж буй" (Advanced emerging), "Хоёрдогч хөгжиж буй" (Secondary emerging), "Шинээр гарч ирж буй" (Frontier) гэсэн үндсэн 4 ангилалд хуваасан байна. Монголын Хөрөнгийн Бирж нь "Шинээр гарч ирж буй" ангиллын өмнөх "хүлээх жагсаалт"-д бүртгэгдсэн ба 2023 оны 9-р сард "Шинээр гарч ирж буй" ангилалд шилжих төлөвтэй байна. Иймд бид зах зээлийн харьцуулалтын шинжилгээг хийхдээ дараах байдлаар хийв. Үүнд:

- Олон нийтэд нээлттэй арилжаалагдаж буй хөрөнгийн биржүүдийн үнэлгээний гол харьцаануудыг том зургаар харах зорилгоор дээрх 4 ангиллын хүрээнд тус бүр P/E, P/B харьцаанд дүн шинжилгээ хийв.
- "Хоёрдогч хөгжиж буй" болон "Шинээр гарч ирж буй" ангиллаас олон нийтэд нээлттэй арилжаалагдаж буй биржүүдийг харьцуулах компаниар сонгон P/E, P/B харьцаанд дүн шинжилгээ хийлээ.

Олон улсын хөрөнгийн биржүүдийн хөгжлийн ерөнхий дүр зураг

FTSE Russell-ийн "Хөгжсөн" ангилалд 25, "Дэвшилтэт хөгжиж буй" ангилалд 10, "Хоёрдогч хөгжиж буй" ангилалд 14, "Шинээр гарч ирж буй" ангилалд 29 улс багтаж байна.

Дээрх улс орнуудын хамгийн том хөрөнгийн биржүүдийг гол мэдээллүүд дээр нь тулгуурлан харьцуулсан шинжилгээний үр дүнг ангилал тус бүрээр үзүүлэв.

"Хөгжсөн" ангиллын биржүүдийн шинжилгээний нэгтгэлийг үзүүлбэл:

Улс	Хөрөнгийн бирж	Нээлттэй компани эсэх	Хувьцааны симбол	Клирингтэй эсэх	P/E	P/B	Ашгийн өгөөж
Австрали	Australian Securities Exchange	Тийм	ASX	Тийм	27.08	3.62	3.69%
Австри	Vienna Stock Exchange	Үгүй		Тийм			
Бельги	Brussels Stock Exchange	Тийм	EUXTF	Тийм	17.48	1.93	5.72%
Канад	Toronto Stock Exchange	Тийм	TMXXF	Тийм	14.52	1.96	6.89%
Дани	Nasdaq Copenhagen	Тийм	NDAQ	Тийм	28.67	5.47	3.49%
Финланд	Nasdaq Helsinki	Тийм	NDAQ	Тийм	28.67	5.47	3.49%
Франц	Euronext Paris	Тийм	EUXTF	Тийм	17.48	1.93	5.72%

[8] https://research.ftserussell.com/products/downloads/FTSE_Equity_Country_Classification_Paper.pdf

000343

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Герман	Frankfurt Stock Exchange	Тийм	DB1	Тийм	22.05	3.73	4.54%
Хонг Конг	Hong Kong Stock Exchange	Тийм	03388	Тийм	33.95	7.44	2.82%
Ирланд	Euronext Dublin	Тийм	EUXTF	Тийм	17.48	1.93	5.72%
Израил	Tel Aviv Stock Exchange	Тийм	TVAVF	Тийм	38.69	2.93	2.58%
Итали	Milan Stock Exchange	Тийм	EUXTF	Тийм	17.48	1.93	5.72%
Япон	Tokyo Stock Exchange	Тийм	OSCUF	Тийм	21.37	3.32	4.68%
Голланд	Euronext Amsterdam	Тийм	EUXTF	Тийм	17.48	1.93	5.72%
Шинэ Зеланд	New Zealand's Exchange	Тийм	NZX	Тийм	23.6	5.73	4.24%
Норвеги	Oslo Stock Exchange	Тийм	EUXTF	Тийм	17.48	1.93	5.72%
Польш	Warsaw Stock Exchange	Тийм	GPW	Тийм	9.83	1.06	10.17%
Португал	Euronext Lisbon	Тийм	EUXTF	Тийм	17.48	1.93	5.72%
Сингапур	The Singapore Exchange	Тийм	S68	Тийм	22.15	6.29	4.52%
Өмнөд Солонгос	Korea Exchange	Үгүй		Тийм			
Испани	Madrid Stock Exchange	Үгүй		Тийм			
Швед	Nasdaq Stockholm	Тийм	NDAQ	Тийм	28.67	5.47	3.49%
Швейцар	SIX Swiss Exchange	Үгүй		Тийм			
Их Британи	London Stock Exchange	Тийм	LDNXF	Тийм	47.47	1.71	2.11%
АНУ	New York Stock Exchange	Тийм	ICE	Тийм	23.01	2.6	4.35%

"Хөгжсөн" ангиллын 25 хөрөнгийн биржүүд бүгд 100% өөрсдийн клирингтэй байна.

NASDAQ, EURONEXT зэрэг томоохон олон улсын сүлжээ хөрөнгийн биржүүд нь дотроо хэд хэдэн хөрөнгийн биржүүдийг нэгтгэсэн байдаг тул тэдгээр салбар биржүүдийн харьцаа үзүүлэлт нь ижил байна. Эдгээр давхардсан утгуудыг цэвэрлэсэн харьцаа үзүүлэлтүүдийн дүн шинжилгээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 8. Хөгжсөн биржүүдийн үнэлгээний харьцаанууд

Утга	P/E	P/B	Ашгийн өгөөж
MAX	47.47	7.44	10.17%
MIN	9.83	1.06	2.11%
MEAN	25.37	3.68	4.60%
MEDIAN	23.01	3.32	4.35%

Үнэлгээний өдрийн байдлаар "Хөгжсөн" ангиллын биржүүдийн дундаж P/E харьцаа 25.37, P/B харьцаа 3.68, ашгийн өгөөж 4.6% байна.

"Дэвшилтэт хөгжиж буй" ангиллын биржүүдийн шинжилгээний нэгтгэлийг үзүүлбэл:

Улс	Хөрөнгийн бирж	Нээлттэй компани эсэх	Хувьцааны симбол	Клирингтэй эсэх	P/E	P/B	Ашгийн өгөөж
Бразил	B3	Тийм	BOLSY	Тийм	19.24	3.96	5.20%
Чех	Prague Stock Exchange	Үгүй		Тийм			
Грек	Athens Stock Exchange	Тийм	HEHSF	Тийм	26.55	2.07	3.77%
Унгар	Budapest Stock Exchange	Үгүй		Тийм			
Малайз	Bursa Malaysia	Тийм	BSMAF	Тийм	14.08	6.12	7.10%

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Мексик	Mexican Stock Exchange	Тийм	BOMXF	Үгүй	12.04	3.02	8.30%
Өмнөд Африк	Johannesburg Stock Exchange	Тийм	JSE	Тийм	10.65	2.99	7.34%
Тайван	Taiwan Stock Exchange	Үгүй		Тийм			
Тайланд	Stock Exchange of Thailand	Үгүй		Тийм			
Турк	Borsa Instanbul	Үгүй		Тийм			

"Дэвшилтэт хөгжиж буй" ангиллын 10 биржүүд Мексикийн Хөрөнгийн Биржээс бусад нь өөрсдийн клирингтэй байна.

Энэхүү ангилалд багтсан 10 хөрөнгийн биржийн тал нь буюу 5 нь хувьцаагаа нээлттэй арилжаалдаг. Дээрх 5 биржийн харьцаа үзүүлэлтүүдийн дүн шинжилгээг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 9. Дэвшилтэт хөгжиж буй биржүүдийн үнэлгээний харьцаанууд

Утга	P/E	P/B	Ашгийн өгөөж
MAX	26.55	6.12	8.30%
MIN	10.65	2.07	3.77%
MEAN	16.51	3.63	6.34%
MEDIAN	14.08	3.02	7.10%

Үнэлгээний өдрийн байдлаар "Дэвшилтэт хөгжиж буй" ангиллын биржүүдийн дундаж P/E харьцаа 16.51, P/B харьцаа 3.63, ашгийн өгөөж 6.34% байна.

"**Хоёрдогч хөгжиж буй**" ангиллын биржүүдийн шинжилгээний нэгтгэлийг үзүүлбэл:

Улс	Хөрөнгийн бирж	Нээлттэй компани эсэх	Хувьцааны симбол	Клирингтэй эсэх	P/E	P/B	Ашгийн өгөөж
Чили	Santiago Stock Exchange	Үгүй		Тийм			
Хятад	Shanghai Stock Exchange	Үгүй		Үгүй			
Колумби	Colombia Stock Exchange	Үгүй		Тийм			
Египет	Egyptian Exchange	Үгүй		Тийм			
Исланд	Nasdaq Iceland	Тийм	NDAQ	Тийм	28.67	5.47	3.49%
Энэтхэг	National Stock Exchange of India	Үгүй		Тийм			
Индонез	Indonesia Stock Exchange	Үгүй		Үгүй			
Кувейт	Kuwait Stock Exchange	Үгүй		Үгүй			
Пакистан	Pakistan Stock Exchange	Тийм	PSX	Тийм	20.56	0.80	4.86%
Филиппин	Philippine Stock Exchange	Тийм	PSE	Тийм	14.01	2.50	7.14%
Катар	Qatar Stock Exchange	Үгүй		Үгүй			
Румын	Bucharest Stock Exchange	Тийм	BVB	Тийм	22.57	2.53	4.43%
Саудын Араб	Tadawul	Үгүй		Тийм			
АНЭУ	Dubai Financial Market	Тийм	DFM	Тийм	107.17	1.69	0.93%

Үнэт цаас гаргагч _____ 000345 Андеррайтер _____

"Хоёрдогч хөгжиж буй" ангиллын 14 хөрөнгийн биржүүдийн 10 нь клирингтэй байна. Харин дөнгөж 5 буюу гуравны нэг нь хувьцаагаа нээлттэй арилжаалдаг.

Исландын хөрөнгийн бирж нь NASDAQ группын нэг хэсэг, хөгжсөн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг энэхүү ангилалд тохиромжгүй учраас хассан. Үлдсэн 4 биржийн харьцаа үзүүлэлтүүдийн дүн шинжилгээг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 10. Хоёрдогч хөгжиж буй биржүүдийн үнэлгээний харьцаанууд

Утга	P/E	P/B	Ашгийн өгөөж
MAX	107.17	2.53	7.14%
MIN	14.01	0.80	0.93%
MEAN	41.08	1.88	4.34%
MEDIAN	21.57	2.10	4.65%

Үнэлгээний өдрийн байдлаар "Хоёрдогч хөгжиж буй" ангиллын биржүүдийн дундаж P/E харьцаа 41.08, P/B харьцаа 1.88, ашгийн өгөөж 4.34% байна.

"Шинээр гарч ирж буй" ангиллын биржүүдийн шинжилгээний нэгтгэлийг үзүүлбэл:

Улс	Хөрөнгийн бирж	Нээлттэй компани эсэх	Хувьцааны симбол	Клирингтэй эсэх	P/E	P/B	Ашгийн өгөөж
Бахрейн	Bahrain Stock Exchange	Үгүй		Тийм			
Бангладеш	Dhaka Stock Exchange	Үгүй		Тийм			
Ботсвана	Botswana Stock Exchange	Үгүй		Тийм			
Болгар	Bulgarian Stock Exchange	Тийм	BSE	Тийм	12.39	2.58	6.83%
Кот-д'Ивуар	BRVM	Үгүй		Үгүй			
Хорват	Zagreb Stock Exchange	Үгүй		Үгүй			
Кипр	Cyprus Stock Exchange	Үгүй		Тийм			
Эстони	Nasdaq Tallinn	Тийм	NDAQ	Тийм	28.67	5.47	3.49%
Гана	Ghana Stock Exchange	Үгүй		Тийм			
Иордан	Amman Stock Exchange	Үгүй		Тийм			
Казакстан	Kazakhstan Stock Exchange	Үгүй		Тийм			
Кени	Nairobi Securities Exchange	Тийм	NSE	Тийм	19.44	0.96	5.14%
Латви	Nasdaq Riga	Тийм	NDAQ	Тийм	28.67	5.47	3.49%
Литва	Nasdaq Vilnius	Тийм	NDAQ	Тийм	28.67	5.47	3.49%
Мальта	Malta Stock Exchange	Үгүй		Тийм			
Маврики	Stock Exchange of Mauritius	Үгүй		Тийм			
Марокко	Casablanca Stock Exchange	Үгүй		Тийм			
Нигери	Nigerian Stock Exchange	Тийм	NGXGROUP	Үгүй	20.01	1.48	4.87%
Оман	Muscat Securities Market	Үгүй		Тийм			
Палестин	Palestine Securities Exchange	Тийм	PSE	Тийм	29.13	2.34	3.43%

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Перу	Lima Stock Exchange	Үгүй		Тийм
Умард Македон	Macedonian Stock Exchange	Үгүй		Үгүй
Серби	Belgrade Stock Exchange	Үгүй		Үгүй
Словак	Bratislava Stock Exchange	Үгүй		Тийм
Словени	Ljubljana Stock Exchange	Үгүй		Үгүй
Шри Ланка	Colombo Stock Exchange	Үгүй		Тийм
Танзани	Dar Es Salaam Stock Exchange	Тийм	DSE	Тийм
Тунис	Bourse De Tunis	Үгүй		Тийм
Вьетнам	Ho Chi Minh Stock Exchange	Үгүй		Үгүй

Шинээр гарч ирж буй ангилалд багтсан 29 улсын хөрөнгийн биржийн 22 нь клирингтэй байна.

Эдгээрээс 8 бирж нь нээлттэй арилжаалагддаг боловч Эстони, Латви, Литва улсуудын хөрөнгийн биржүүд нь NASDAQ группын нэг хэсэг, хөгжсөн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг энэхүү ангилалд тохиромжгүй учраас хассан. Түүнчлэн, Танзани улсын биржийн мэдээлэл хомс, олон нийтэд нээлттэй биш, одоогийн статус тодорхойгүй, Палестины хөрөнгийн бирж нь нээлттэй компани боловч 23 хувьцаа эзэмшигчтэй, хөрвөх чадвар багатай тул эдгээр биржүүдийг хасаад үлдсэн 3 биржийн харьцаа үзүүлэлтүүдийн дүн шинжилгээг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт 11. Шинээр гарч ирж буй биржүүдийн үнэлгээний харьцаанууд

Утга	P/E	P/B	Ашгийн өгөөж
MAX	20.01	2.58	6.83%
MIN	12.39	0.96	4.87%
MEAN	17.28	1.67	5.61%
MEDIAN	19.44	1.48	5.14%

Үнэлгээний өдрийн байдлаар "Шинээр гарч ирж буй" ангиллын биржүүдийн дундаж P/E харьцаа 17.28, P/B харьцаа 1.67, ашгийн өгөөж 5.61% байна.

Дүгнэлт:

Дээрх 4 ангиллын хөрөнгийн биржүүдийн мэдээллээс дүгнэж үзэхэд ихэнх бирж өөрсдийн клирингтэй, эсвэл клирингийн хувь шууд эзэмшдэг эсвэл толгой компанийн доор зэрэгцээ компани байдлаар ажиллаж байна.

"Хөгжсөн" ангилалд орсон 25 бирж бүгд 100% нээлттэй арилжаалагддаг байхад "Шинээр гарч ирж буй" ангилалд орсон 29 биржийн дөнгөж 8 нь нээлттэй арилжаалагдаж байна. Иймд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшин ихсэх тусам хөрөнгийн биржүүд олон нийтэд нээлттэй арилжаалагддаг, хөгжлийн түвшин бага байх тусам хаалттай байна гэж дүгнэж болно.

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Хөгжсөн зах зээлийн биржүүдийн P/B харьцаа харьцангуй өндөр буюу хөгжлийн түвшин буурах тусам түс харьцаа буурах хандлагатай байна.

Хүснэгт 12. Биржүүдийн дундаж P/B харьцааны харьцуулалт

Хөгжсөн	Дэвшилтэт хөгжиж буй	Хоёрдогч хөгжиж буй	Шинээр гарч ирж буй
3.68	3.63	1.88	1.67

Хөгжсөн зах зээлийн хөрөнгийн биржүүд нь зөвхөн арилжаанаас гадна өөр олон орлогын эх үүсвэртэй болохыг NASDAQ болон EURONEXT зэрэг дэлхийн хэмжээний, олон салбар сүлжээ хөрөнгийн биржтэй байгууллагуудын жишээнээс харах боломжтой.

Зураг 9. NASDAQ биржийн орлогын задаргаа



Зураг 10. EURONEXT биржийн орлогын задаргаа



Зах зээлийн харьцуулалт

Бид "Хоёрдогч хөгжиж буй" болон "Шинээр гарч ирж буй" ангиллын биржүүдээс олон нийтэд нээлттэй арилжаалагддаг, мэдээллийн олдоц сайтай биржүүдийг харьцуулах биржүүдээр сонгов. Харьцуулалтад "Хоёрдогч хөгжиж буй" ангиллын Дубайн санхүүгийн зах, Пакистаны хөрөнгийн бирж, "Шинээр гарч ирж буй" ангиллын Болгарын хөрөнгийн бирж, Наиробийн үнэт цаасны бирж, Нигерийн хөрөнгийн биржүүдийг сонгон дүн шинжилгээ хийв.

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
он 2022 -12- 15 өдөр
БҮРТГЭВ
№ 91
2022.12.15

ГЭРЭГЭ
Эстимейт
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Хүснэгт 13. Харьцуулалтад авсан биржүүд

Биржийн нэр	Код	Нэг хүнд ногдох ДНБ, 2021	FTSE ангилал	ЗЗҮ, тэрбум дол.	Бүртгэлтэй компанийн ЗЗҮ, % ДНБ	Арилжааны дүн, тэрбум дол.	Арилжааны дүн, % ЗЗҮ
Дубайн санхүүгийн зах	DFM	$ 36,285	хоёрдогч	142.3	28.4%	13.31	9.4%
Пакистаны хөрөнгийн бирж	PSX	$ 1,538	хоёрдогч	31.3	11.0%	16.1	51%
Болгарын хөрөнгийн бирж	BSE	$ 11,635	шинэ	16.4	21.1%	0.58	3.5%
Наиробийн үнэт цаасны бирж	NSE	$ 2,007	шинэ	15.7	14.2%	0.003	0.02%
Нигерийн хөрөнгийн бирж	NGXGROUP	$ 595	шинэ	115.4	26.2%	0.003	0.002%
Монголын хөрөнгийн бирж	MSE	$ 4,535	ажиглалт	1.7	13.7%	0.41	23%

Нигери, Кени, Пакистан улсууд нь хүн ам ихтэй тул нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээгээр Монгол улсаас бага байна. Хөрөнгийн бирж дэх бүртгэлтэй компаниудын зах зээлийн үнэлгээг ДНБ-д харьцуулж үзэхэд дунджаар 20.2% байна. Үүнээс харахад Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн зах зээлийн үнэлгээ нь ДНБ-тэй харьцуулахад бага биш бөгөөд цаашид өсөн нэмэгдэх боломж байгааг харуулж байна.

2021 онд эдгээр хөрөнгийн биржүүд дээр арилжаалагдсан үнэт цаасны арилжааны дүнг харьцуулахад Дубай болон Пакистаны хөрөнгийн бирж илт өндөр байна. МХБ-ийн арилжааны дүнг нийт зах зээлийн үнэлгээнд харьцуулсан харьцаа 23% байгаа боловч Эрдэнэс Таван Толгойн бондын арилжааны үнийн дүнг хассан дүнгээр энэ харьцаа 3.63% болно.

Харьцуулж буй бирж тус бүрийн ерөнхий мэдээлэл, санхүүгийн мэдээлэл, үнэлгээний үржүүлэгчдийн мэдээллийг доор үзүүлэв.

Болгарын Хөрөнгийн Бирж (BSE)

Зохицуулагч байгууллага болох Төрийн үнэт цаасны болон биржийн хорооны зөвшөөрлөөр 1991 онд нээлттэй компани хэлбэрээр байгуулагдсан, Болгар улс дахь цорын ганц бирж юм. Европын үнэт цаасны биржүүдийн холбооны гишүүн байгууллага.

Болгарын хөрөнгийн бирж (BSE)-ийн зах зээлийн үнэлгээ, ДНБ-ий харьцаа 2019 онд 23.3%, 2020 онд 23.9%, 2021 онд 24%, 2022 оны хагас жилийн байдлаар 21.13% тус тус байна.

BSE-ийн хувьцаа эзэмшигчид 2022 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар дараах байдалтай байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨК
МОНГОЛЫН
STOCK EXCHANGE
9020020699 2071000
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000349

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ГЭРЭЭГЭЭ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Зураг 11. Болгарын хөрөнгийн биржийн хувьцаа эзэмшигчид



Болгарын хөрөнгийн бирж нь үндсэн бирж, туслах бирж гэсэн 2 үндсэн хэсэгтэй. Хэсэг тус бүрийн бүртгэлтэй үнэт цаасны төрөл болон тоог дор харуулав.

Үндсэн биржийн сегментүүд	
Зах зээлийн сегментүүд	Бүтээгдэхүүний тоо
Өрийн бичиг /Bonds/	85
Нөхөн олговрын бүтээгдэхүүн /Compensatory instruments/	3
Биржийн арилжааны бүтээгдэхүүн /Exchange traded products/	20
Засгийн газрын үнэт цаас /Government securities/	16
Топ хувьцаа /Premium equities/	7
Тусгай зориулалтын бүтээгдэхүүн /Special purpose vehicles/	16
Стандарт хувьцаа /Standard equities/	58
Туслах биржийн сегментүүд	
Хувьцаа	131
Тусгай зориулалтын бүтээгдэхүүн	35

Биржийн үндсэн үйл ажиллагаа нь дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ:

- Арилжааны систем болох санхүүгийн хэрэгслүүдийг арилжих, хянах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Үнэт цаасны арилжааны мэдээллийн системийг зохицуулах, хадгалах;
- Зах зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;
- Клиринг системийг бий болгох, засвар үйлчилгээ үзүүлэх;
- BSE-ийн индексийг тооцох;

BSE-ийн 2021 оны жилийн эцсийн орлогын төрлүүд дараах байдалтай байна. Ихэнх орлого нь арилжааны шимтгэл, бүртгэлийн шимтгэл, мэдээллийн үйлчилгээний шимтгэлээс бүрдэж байна.

2021 оны орлогын бүтэц	BGN'000	Хувь
Арилжааны шимтгэл	900	31%
Бүртгэлийн шимтгэл	848	30%
Мэдээллийн үйлчилгээний шимтгэл	736	26%
Гишүүний хураамж	135	5%
Арилжааны эрхийн сарын хураамж	91	3%
Асуудлын параметрийг өөрчилсний шимтгэл	48	2%
Зайнаас ажиллах станцын засварын хураамж	26	1%
Зөвшөөрсөн хэвлэн нийтлэх шимтгэл	61	2%

ХӨРӨНГИЙН БИРЖ
"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
000350

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Бусад	26	1%
Нийт	**2871**	**100%**

BSE нь Төвлөрсөн хадгаламжийн төвийн 6.21%-ийг эзэмшдэг. BSE, Төвлөрсөн хадгаламжийн төв нь "Clear X" компанийн эрчим хүч, байгалийн хий болон бусад бүтээгдэхүүний арилжааны төлбөр тооцоог хийх зорилгоор хамтран байгуулсан байна. Тухайн компанийн нийт хувьцааны 60%-ийг BSE, 40%-ийг Төвлөрсөн хадгаламжийн төв нь тус тус эзэмшдэг. Түүнчлэн, Санхүүгийн зах зээлийн үйлчилгээ EOOD компаний 100%, Болгарын бие даасан энергийн биржийн 100%-ийг эзэмшдэг. SEE Link DOO компанийн 33.33%-ийг эзэмшдэг.

BSE-ийн хувьцаа 2022 оны 3-р сард 7.45BGN, 5-р сард 10.93BGN хүрч байсан бол 2022 оны 6-р сарын 30-ны өдөр 10.03BGN BGN байна.[9]

Зураг 12. Болгарын хөрөнгийн биржийн хувьцааны ханшийн хөдөлгөөн



Дубайн санхүүгийн зах (DFM)

Dubai Financial Market (DFM) компани нь 2000 онд нээлттэй компани хэлбэрээр байгуулагдсан. DFM-д 2021 оны жилийн эцсийн байдлаар 68 хувьцаат компани, 134 өрийн бичиг, 30 фючерс, 3 индекс фючерс бүртгэлтэй байна.

DFM групп компанийн 80.66%-ийг Борсе Дубай компани, үлдсэн хувийг олон нийт эзэмшиж байна.

Олон улсын хөрөнгө оруулагчид нийт арилжааны 46%-ийг, олон улсын эзэмшилтэй компани нийт бүртгэлтэй компанийн 22.5%-ийг тус тус эзэлж байна.



DFM групп компани нь дараах компаниудыг эзэмшдэг:

Компанийн нэр	Үйл ажиллагаа	Эзэмшлийн хувь
Монгол Улсын хуулийн этгээд болох "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК (цаашид "**Компани**", "**Бирж**" эсхүл "**Үнэт цаас гаргагч**" гэх) нь 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Улсын Их Хурлын "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай" 16 дугаар тогтоол, 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн Засгийн газрын "Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай" 244 дүгээр тогтоолд тус тус үндэслэн нээлттэй хувьцаат компани болох, хувьцаагаа олон нийтэд санал болгохоор ажиллаж байна. Иймхүү Бирж нь хувьцаагаа анх удаа нийтэд санал болгох гэж буйтай холбогдуулан Хууль зүйн дүгнэлт гаргахыг биднээс хүсч, бид 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Д-С1272231 тоот "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ" байгуулан, тус гэрээний дагуу энэхүү Хууль зүйн дүгнэлт (цаашид "**Дүгнэлт**" гэх)-ийг гаргаж байна.

Энэхүү Дүгнэлтийг зөвхөн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, түүний дотор Компанийн тухай хуулийн 4.3-т "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол нээлттэй хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаасыг гаргаж болно" гэж хуульчилсны дагуу Компани нь хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар компанийн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулагдах эрх зүйн үндэслэлтэй гэж үзсэний үндсэн дээр гаргаж байна. Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэгт заасны дагуу нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох эрх зүйн үндэслэлтэй байна. Тус Компани нь Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйл (Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх), 42 дугаар зүйл (Үнэт цаас гаргах тухай шийдвэр), Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйл (Үнэт цаас), 6 дугаар зүйл (Үнэт цаас гаргах) 7 дугаар зүйл (Үнэт цаас гаргагч), 8 дугаар зүйл (Нийтэд санал болгон үнэт цаас гаргах журам), 9 дүгээр зүйл (Үнэт цаас бүртгэх, нийтэд санал болгохыг зөвшөөрөх), 10 дугаар зүйл (Үнэт цаасны танилцуулга), 11 дүгээр зүйл (Үнэт цаасыг нийтэд санал болгох)-д тус тус заасны дагуу нэмж хувьцаа гарган СЗХ, Монголын хөрөнгийн бирж (цаашид "**МХБ**" гэх)-д бүртгүүлж, нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн байна.

Хангагдсанд тооцох нөхцөл

Энэхүү Дүгнэлтийг боловсруулахдаа Бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, тэдгээр дээрх аливаа тэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн;
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн;
3. Бидэнд өгөгдсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцсэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, үнэн зөв;
4. Бидэнд өгөгдсөн баримт бичгийн дагуу үүсэх аливаа үүрэг нь Монгол Улсаас бусад эрх зүйн тогтолцоонд хүчин төгөлдөр байх ба тэдгээр үүргийн хэрэгжилт хууль бус, хүчин төгөлдөр бус, эсхүл хэрэгжих боломжгүй биш байна;

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
InvesCore CAPITAL
000403

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

5. Монгол Улсаас өөр улсад үйлдэгдсэн аливаа баримт бичиг нь тийнхүү үйлдэгдсэн улсын хуулийн шаардлагыг хэлбэрийн болон агуулгын хувьд бүрэн хангасан, хүчин төгөлдөр баримт бичиг ба тэдгээрийн хэрэгжилт нь тийнхүү хэрэгжих улсын хуулийн шаардлагыг мөн хангасан;
6. Загвар хувилбараар ирсэн баримт бичиг нь тухайн хувилбарыг үндэс болгон баталгааждаг;
7. Бирж, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн зөв, бодитой;
8. Шүүх, төрийн эрх бүхий болон бусад байгууллагаас авсан мэдээлэл, баримт бичиг нь үнэн зөв;
9. Үнэт цаасны танилцуулгад тусгасан андеррайтер, аудитор, хөрөнгийн үнэлгээчний хийсэн судалгаа, дүгнэлт, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв;
10. Бидний судалж ашигласан бичиг баримтыг бэлтгэсэн болон түүнд гарын үсэг зурсан этгээд нь тийнхүү уг баримт бичгийг бэлтгэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй.

Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлснээр үнэт цаасны арилжааг нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7 дахь хэсэг, СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн №02 тоот тогтоолоор батлагдсан МХБ-ийн "Арилжааны журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын дагуу явуулна гэж бид ойлгож байна.

Бид Үнэт цаас гаргагчаас Дүгнэлт гаргахад шаардлагатай гэж үзсэн баримтын эх хувь болон хуулбарыг гаргуулан авч, хууль зүйн үндэслэл болон мэдээллийг тулган шалгаж, судалсан болно. Түүнчлэн Компанийн үйл ажиллагааны талаар шүүх, төрийн эрх бүхий байгууллагуудаас шаардлагатай гэж үзсэн хөндлөнгийн лавлагаа, мэдээллийг гаргуулж судалсан болно.

Ийнхүү судалгаа шинжилгээ (due diligence) хийж, Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн дор дурдсан Дүгнэлтийг гаргаж байна:

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
2022 12 15 өдөр
БҮРТГЭВ
2022 12 15

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Компани хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх талаар.

Бүгд найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын 1991 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн "Өмч хувьчлалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 22 дугаар тогтоолоор Өмч хувьчлах арга хэмжээ авч байгаатай холбогдуулан Хөрөнгийн биржийн захиргаа байгуулж ажиллуулахаар тогтоож, Хөрөнгийн биржийн захирлыг томилсноор Хөрөнгийн бирж үүсгэн байгуулагдсан гэж үзэхээр байна[1]. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр бидэнд ирүүлсэн дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл анхны хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм нь 1996 оны 03 дугаар сарын 28-ний өдөр батлагдаж, мөн оны 05 дугаар сарын 10-ны өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна (Улсын бүртгэлийн дугаар: 9012001021, Регистрийн дугаар: 2071096).

Монгол Улсын Үнэт цаасны хороо 1996 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар тогтоолоор хөрөнгийн биржийн тусгай зөвшөөрөл, 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 80 дугаар тогтоолоор үнэт цаасны зэх зээл дээр үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Мөн Үнэт цаасны хорооны 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн "Хөрөнгийн Бирж ХК-ийн хувьцааг үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэх тухай" 77 дугаар тогтоол гаргаж, Биржийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 18677088 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны зах зээл дээр худалдахаар зөвшөөрсөн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд бүртгэхээр шийдвэрлэсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх, онцлогийг зохицуулсан байдаг. Тус хуулийн 21.1 дэх хэсэгт зааснаар Бирж нь төрийн өмчит хуулийн этгээд юм.

Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаанд хувьцаа эзэмшигчийн мэдээлэл тусаагүй ба үүсгэн байгуулагчаар "Төрийн өмчийн хороо" гэж бүртгэсэн байна. Компанийн дүрмийн 3.2-д "Компанийн өмчлөгч нь төр байх бөгөөд түүнийг төлөөлж хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Сангийн яам хэрэгжүүлнэ" гэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.1 дэх хэсэгт зааснаар "Төр" нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 100 хувийн цор ганц хувьцаа эзэмшигч байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг[2], Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн "Монголын хөрөнгийн биржийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 152 дугаар тогтоол, Дүрмийн 1.8 дахь хэсэгт зааснаар Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Биржийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг Сангийн яам хэрэгжүүлж байна.

Үнэт цаас гаргагчийн гэрчилгээ болон 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн, Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөж буй "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн дүрэм (Хавсралт 1)-ээс үзвэл Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны арилжааны болон өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаа эрхэлж байна.

Үнэт цаас гаргагч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.5 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.11, 24.2 дахь хэсэг, СЗХ-ны 2006 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор Үнэт цаасны зах зээл дээр үнэт цаасны арилжааны үйл ажиллагаа эрхлэх 330/01 дугаар тусгай зөвшөөрөл (Хавсралт 6) авсан байна.

---

[1] Тухайн үед Аж ахуйн нэгжийн тухай болон Улсын бүртгэлийн тухай хуулиуд батлагдаагүй байсан.
[2] Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг (1996)
9 дүгээр зүйл. Төрийн өмчийн талаарх Засгийн газрын бүрэн эрх
5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ТЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ... УЛААНБААТАР ХОТ

000405

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Түүнчлэн, Биржийг СЗХ-ны 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор Үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллага (Хавсралт 6) гэж бүртгэсэн байна.

Компанийн мэдээлэл:

Улсын бүртгэлийн дугаар:	9012001021;
Регистрийн дугаар:	2071096;
Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр:	"Монголын хөрөнгийн бирж" Төрийн Өмчит Хувьцаа Компани;
Хугацаа:	Хугацаагүй;
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	1
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /төгрөг/:	23,130,593,600.00;
Хуулийн этгээдийн албан ёсны хаяг:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай 3, өөрийн байранд;
Гүйцэтгэх захирал:	Х.Алтай.
Гэрчилгээ олгосон огноо:	2022.11.30

Дээр дурдсанаас үзвэл, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн байна.

Үнэт цаас гаргах тухай шийдвэрийн талаар.

1. 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Улсын Их Хурлын 16 дугаар тогтоолын 1-р хавсралтаар баталсан Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэлийн 4.1.1 дэх заалт;
2. 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн Засгийн газрын 244 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Төрийн мэдлийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалтын 1 дэх хэсэг;
3. 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Нэмэлт хувьцаа гаргах тухай" 336 дугаар тогтоол, түүний хавсралтаар баталсан "Нэмэлт хувьцаа гаргаж, олон нийтэд нээлттэй арилжих төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт"-ын 1 дэх хэсэгт тус тус заасны дагуу "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн 34 хүртэлх хувийн энгийн хувьцааг нэмж гарган олон нийтэд нээлттэй худалдах, түүнтэй холбоотой арга хэмжээ авахаар шийдвэрлэсэн.

Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай" 15 тоот тогтоол, 2022 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хойшлуулах тухай" тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр хуралдуулсан. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 2022 оны 11-р сарын 09-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын "Компанийн хувьцааг нэмж гаргах, олон нийтэд санал болгох тухай" 01 тоот тогтоолоор дараах шийдвэр гаргасан. Үүнд:

- "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмж хувьцаа гаргах замаар нэмэгдүүлж, компанийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 231,305,936 ширхэг энгийн хувьцаан дээр нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 119,157,603 ширхэг энгийн хувьцааг нэмж гарган "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аар дамжуулан олон нийтэд санал болгох;
- Одоогийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байх;
- Нэмж гаргаж буй 119,157,603 ширхэг энгийн хувьцаа нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн нийт гаргасан хувьцааны 34 хувьтай тэнцэх бөгөөд анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсаны үр дүнд одоогийн хувьцаа эзэмшигч болон

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
БҮРТГЭВ

MDS
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

олон нийтийн эзэмших хувь дор дурдсанаар өөрчлөгдөх:

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
		Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо
1	Сангийн яам	100 хувь	231,305,936	66 хувь	231,305,936
2	Олон нийт	0		34 хувь	119,157,603

Энэхүү тогтоол нь Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 38 дугаар зүйлийн 38.8, 42 дугаар зүйлийн 42.4, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 336 дугаар тогтоол, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Дүрмийн холбогдох хэсэгтэй тус тус нийцсэн.

ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн "Нийтэд санал болгох энгийн хувьцааны үнэ, нөхцөл тогтоох тухай" 37 тоот тогтоолоор дараах шийдвэрийг гаргажээ. Үүнд:

№	Үзүүлэлт	Нөхцөл
1.	**Үнэт цаас нэмж гаргах нөхцөл**	
	Үнэт цаас гаргагч	"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК
	Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
	Үнэт цаасны үсгэн код	MSE
	Нэмж гаргах энгийн хувьцааны тоо	119,157,603 (Нэг зуун арван есөн сая, нэг зуун тавин долоон мянга зургаан зуун гурав) ширхэг
	Энгийн хувьцааны нэрлэсэн үнэ	100 (нэг зуун) төгрөг
	Нэмж гаргаж буй буюу олон нийтийн эзэмших хувь	34%
	Нэмж гаргасны дараах нийт хувьцааны тоо	350,463,539 (гурван зуун тавин сая дөрвөн зуун жаран гурван мянга таван зуун гучин ес) ширхэг
	Нэгж хувьцааг олон нийтэд санал болгох үнэ	100 (нэг зуун) төгрөг
	Арилжаа эрхлэх байгууллага	Монголын хөрөнгийн бирж
2.	**Үнэт цаас нийтэд санал болгох нөхцөл**	
	Анхдагч зах зээлийн арилжааны арга	Тогтоосон үнийн арга
	Хөрөнгө оруулах доод хэмжээ	Байхгүй
	Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	11,915,760,300 (арван нэгэн тэрбум есөн зуун арван таван сая долоон зуун жаран мянга гурван зуу) төгрөг
	Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох хувь, хэмжээ, нөхцөл	Нэмж гаргах хувьцааны 90 хувь хүртэлх дүн буюу 107,241,842 ширхэг хүртэлх энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох; Нэг стратегийн хөрөнгө оруулагчид нийт эзэмшлийн 5 хүртэл хувь буюу хамгийн ихдээ 17,523,176 ширхэг энгийн хувьцааг санал болгох;

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ТҮК" ХХК
InvesCore CAPITAL

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MDS STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ

		Стратегийн хөрөнгө оруулагчид хөёрдөгч зах зээл нээгдсэнээс хойш Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон 6 сараас багагүй хугацаанд хувьцаагаа арилжаанд оруулахгүй байх
	Үнэт цаасыг амжилттай татан төвлөрүүлсэн гэж үзэх хувь (анхдагч зах зээлийг арилжаа хаагдсан өдөр)	100%
3.	**Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт**	
	Техник, технологийн шинэчлэл. Үүнд: - Арилжааны системийн сайжруулалт - 63.7% - Мэдээлэл технологийн аюулгүй байдал – 10.7% - Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт – 6.1% - Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох – 19.5%	

Үнэт цаасны зарим нөхцөл тогтоох тухай ТУЗ-ийн тогтоол нь Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 55 дугаар зүйлийн 55.1, 55.2, 55.6 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.9 дэх хэсэгт тус тус нийцсэн байна.

Дүгнэвэл, Үнэт цаас гаргах тухай ХЭХ-ын тогтоол, ТУЗ-ийн тогтоол нь хууль тогтоомжид нийцсэн байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
БҮРТГЭВ
MDSKhanLex
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Компанийн дүрмийн 9.1-д "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, дэд захирлууд, ерөнхий нягтлан бодогч, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэж Компанийн эрх бүхий албан тушаалтныг тодорхойлсон нь Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3-т "Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна" гэж заасан шаардлагад нийцсэн байна.

Биржийн ТУЗ-ийн 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Монголын хөрөнгийн бирж төрийн өмчит хувьцаат компанийн бүтэц, зохион байгуулалтад "дэд захирал" албан тушаал байхгүй тул Компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцох магадлалтай гэж үзэж, Компанийн газрын захирлуудыг Компанийн эрх бүхий албан тушаалтанд хамруулав.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (цаашид "**ТБОНӨтХ**" гэх), Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд үндэслэн тус Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Газрын захирлууд, Ерөнхий нягтлан бодогч нарыг Эрх бүхий албан тушаалтан гэж үзэв.

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэгт "Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна" гэж заасныг Биржийн дүрмийн 7.2-т тусгасан байна.

Компанийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэгт "Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журмыг ТБОНӨтХ-аар, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох, гүйцэтгэх удирдлагыг томилох, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна" гэж заасан. ТБОНӨтХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт зааснаар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүнийг томилохоор хуульчилсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн талаар.

Биржийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, гишүүдийг шинээр болон улируулан сонгох тухай" 03 дугаар тогтоол гарсан байна. Уг тогтоолын дагуу Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн талаар 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/637 тоот албан бичгээр СЗХ-д мэдээлсэн байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
000409

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Хүснэгт 1.Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний мэдээлэл

№	Овог, нэр	Албан тушаал	Төлөв
1.	С.Тулга	Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга	ТУЗ-ийн Дарга, ердийн гишүүн (улируулан сонгосон)
2.	Д.Баянзул	Монголбанкны Эрсдэлийн удирдлагын газрын албаны захирал	ТУЗ-ийн ердийн гишүүн (улируулан сонгосон)
3.	Д.Энхбаатар	Санхүүгийн зохицуулах хорооны Захиргаа удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	ТУЗ-ийн ердийн гишүүн (улируулан сонгосон)
4.	Ч.Дондогмаа	Засгийн газрын хэрэг эрхлэх газарт Ахлах референт	ТУЗ-ийн ердийн гишүүн (шинээр сонгосон)
5.	М.Санжаадорж	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга	ТУЗ-ийн ердийн гишүүн (улируулан сонгосон)
6.	Б.Наранчимэг	Сангийн яамны Төрийн сангийн газрын Төлбөр тооцооны хэлтсийн дарга	ТУЗ-ийн ердийн гишүүн (улируулан сонгосон)
7.	А.Батпүрэв	"Ашит ассет Менежмент" ХХК-ийн Гүйцэтгэх захирал	ТУЗ-ийн хараат бус гишүүн (улируулан сонгосон)
8.	Р.Гандиймаа	МҮОНРТ-ийн Монголын мэдээ сувгийн гүйцэтгэх захирал	ТУЗ-ийн хараат бус гишүүн (улируулан сонгосон)
9.	А.Анар	СЭЗИС-ийн ТУЗ-ийн гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн (улируулан сонгосон)

С.Тулга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 32 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар, Г.Мөнхзул нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 27 дугаар тогтоолоор ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар тус тус сонгогдон ажиллаж байна. ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын боловсрол, ажлын туршлагыг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт 2.Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын боловсрол, ажлын туршлагын мэдээлэл

№	Нэр	Боловсрол	Ажлын туршлага
ЕРДИЙН ГИШҮҮД:			
1.	Солонгын Тулга **(ТУЗ-ийн дарга)**	2007-2011 онд БНХАУ-ын Гадаад харилцааны их сургуулийг Олон улсын хуульч, дипломатч мэргэжлээр бакалавр; 2017-2019 онд АНУ-ын Корнелийн их сургуулийг Төрийн удирдлага мэргэжлээр магистр.	2011-2013 онд Сангийн яамны Зээл тусламжийн бодлого, хамтын ажиллагааны газарт мэргэжилтэн; 2013-2021 онд Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, шинжээч;

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL

Үнэт цаас гаргагч _____

Андеррайтер _____

СЭХ
БҮРТГЭВ
MDS KhanLeX
2022 -12- 12

			2021 оноос Сангийн яаманд Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга.
2.	Даваагийн Баянзул	1995-1999 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг Банк санхүүч, банкны эдийн засагч мэргэжлээр бакалавр; 2005-2006 онд Австралийн Үндэсний Их Сургуулийг Олон улсын хөгжлийн эдийн засаг мэргэжлээр магистр.	1999-2001 онд Анод банкинд Эдийн засагч; 2001 оноос одоог хүртэл Монголбанкны ахлах эдийн засагч, Монголбанкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын Санхүүгийн зах зээлийн хэлтсийн захирал, Эрсдэлийн удирдлагын газрын албаны захирал.
3.	Доржийн Энхбаатар	1984-1989 онд ОХУ, Эрхүүгийн их сургуулийг түүхч мэргэжлээр бакалавр; 2006 онд Австралийн Латробэ их сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжлээр магистр.	1989-1990 онд Сүхбаатар аймгийн намын хороонд зохион байгуулагч; 1990-1993 онд Лениний музейд зохион байгуулагч; 1994-2000: "Зотол Уул Трейд" ХХК-д ерөнхий захирал; 2000-2016 онд "Зотол Групп" ХХК-д ерөнхий захирал 2020 оноос Санхүүгийн зохицуулах хороонд Захиргаа, удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч.
4.	Чулуунбаатарын Дондогмаа	2003 онд МУИС, Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр бакалавр, 2022 онд ХУИС-ийн харьяа Билиг их сургуулийн хууль зүйн магистр.	2003.10.10-2004.01.15 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт Оператор-бичээч; 2004.01.15-2008.05.01 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт Хяналт шалгалтын байцаагч; 2008.05.01-2015.08.17 онд Хууль зүй дотоод хэргийн яаманд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн; 2015.08.17-2021.04.20 онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Засгийн газрын референт, Засгийн газрын ахлах референт; 2021.04.20-2021.07.22 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд Ахлах референт; 2021.07.22-ноос одоог хүртэл Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт Засгийн газрын ахлах

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ... 207096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ... 1119277128
УЛААНБААТАР ХОТ
• 000411

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
он сар 15 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

			Референт.
5.	Мижиддоржийн Санжаадорж	2003-2007 онд МУИС- Эдийн засгийн сургуулийг Менежмент, Бизнесийн удирдлага мэргэжлээр бакалавр; 2009-2011 онд АНУ-ын Стейр их сургуулийг Төрийн удирдлага мэргэжлээр магистр.	2007-2009 онд "Моннис" ХХК-д Төслийн менежер; 2013-2018 онд Сангийн яамд Гэрээт ажилтан, Мэргэжилтэн; 2018-2022 онд Сангийн яамд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын ТЗХ дарга; 2022 оноос Сангийн яамд Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын төсвийн зарлагын хэлтсийн дарга.
6.	Лувсаншаравын Наранчимэг	2001-2005 онд Санхүү Эдийн Засгийн Дээд сургуулийг нягтлан бодох бүртгэл мэргэжлээр бакалавр; 2010-2012 онд Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Англи хэлний орчуулагч мэргэжлээр бакалавр; 2018-2020 онд Япон Улс Сайтамагийн Их Сургуулийг Эдийн засгийн мэргэжлээр магистр.	2005-2013 онд Сангийн яам Төрийн сангийн газарт мэргэжилтэн; 2013-2018 онд Сангийн яам Төрийн сангийн газарт ахлах мэргэжилтэн; 2018 оноос Сангийн яам Төрийн сангийн газарт Төлбөр тооцооны хэлтсийн дарга.
ХАРААТ БУС ГИШҮҮД:			
7.	Аюушсүрэнгийн Батпүрэв	1999 – 2004 онд СЭЗДС-ийг Бизнесийн удирдлагын мэргэжлээр бакалавр; 2012 – 2013 онд Австрали Улсын Сиднейн их сургуулийг Эдийн засгийн магистр.	2010-2012 онд Юнител группт хэлтсийн менежер; 2013-2014 онд Гадаад харилцааны яамд Сайдын зөвлөх; 2014-2016 онд Санхүүгийн зохицуулах хороонд Газрын захирал; 2017 – 2018 онд Петровис группт Маркетинг эрхэлсэн захирал; 2018-2021 онд “Скайтел групп” ХХК-д Стратеги төлөвлөлтийн албаны захирал; 2021 оноос "Ашит ассет Менежмент" ХХК-ийн Гүйцэтгэх захирал.
8.	Рэнцэндоржийн Гандиймаа	1995-2000 онд Турк Улсын Гази их сургуулийн бакалавр; 2000-2001 онд Удирдлагын академийн Бизнес менежер;	2002 оноос одоог хүртэл МҮОНРТ-д эдийн засгийн сэтгүүлч, МҮОНРТ-д

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2017096
УЛААНБААТАР ХОТ

000412
InvesCore CAPITAL
6317839

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MDS KhanLex
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

		2007-2011 онд БНХАУ Бээжингийн их сургуулийн Сэтгүүлзүйн магистр.	Монголын мэдээ сувгийн Гүйцэтгэх захирал.
9.	Амаржаргалын Анар	2006-2010 онд АНУ-ын Клородагийн их сургуулийг Эдийн засгийн ухааны бакалавр; 2022 оноос Санхүү эдийн засгийн их сургуулийн Хөрөнгө оруулалтын удирдлагын магистр.	2011-2013 онд Хас банк-д Эрсдэлийн бодлогын мэргэжилтэн 2013-2015 онд "Скай Лакть" ХХК-д Үйл ажиллагаа эрхэлсэн захирал 2015-2016 онд "Амаржаргал сан"-д Гүйцэтгэх захирал 2017-2020 онд "МИК ОССК" ХХК-д Үйл ажиллагааны газрын захирал; 2020 оноос эхлэн СЭЗИС-ийн ТУЗ-ийн гишүүн.
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА			
10.	Гантөмөрийн Мөнхзул	2004-2008 онд Монгол Улсын их сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжлээр бакалавр; 2008-2010 онд АНУ-ын Виржиниагийн Олон Улсын их сургуулийг Бизнесийн удирдлагаар магистр;	2013-2016 онд Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газарт гэрээт ажилтан; 2016-2017 онд Дэлхийн банкинд зөвлөх; 2018-2022 онд Азийн хөгжлийн банкинд төслийн зөвлөх; 2022 оноос Дэлхийн банкны төслийн зөвлөх.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно", 81.2 дахь хэсэгт "Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороотой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ" гэж заасан.

Биржийн Дүрмийн 7.3.21, 7.14, Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 3.1-д "Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороо"-той байхаар тусгажээ. 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 33 дугаар тогтоолоор А.Анар, А.Батпүрэв, Д.Баянзул нар ТУЗ-ийн аудитын хороо, Ч.Дондогмаа, А.Батпүрэв, Р.Гандиймаа нар ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо, Л.Наранчимэг, А.Анар, Р.Гандиймаа нар ТУЗ-ийн цалин урамшууллын хороодод сонгогджээ.

Биржийн ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

ХӨРӨНГИЙН МОНГОЛЫН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699
УЛААНБААТАР ХОТ

000413
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА					
№	**Нэрс/Шаардлага**	**Цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх /хараат бус гишүүний хувьд Төрийн болон нутгийн захиргааны байгууллагад алба хашдаг эсэх/**	**Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)***	**Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8)**	**Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)**
1.	**С.Тулга** (ТУЗ-ийн дарга)	Үгүй	Үгүй*	Тийм /2015.04.11-ний өдөр, Дугаар 030346/	Тийм
2.	**Д.Баянзул** (ТУЗ-ийн ердийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2014.10.18-ны өдөр, Дугаар 0430308/	Тийм
3.	**Д.Энхбаатар** (ТУЗ-ийн ердийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2016.11.06-ны өдөр, Дугаар 0730745/	Тийм
4.	**Ч.Дондогмаа** (ТУЗ-ийн ердийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2019.12 сард, Дугаар 0000395/	Тийм
5.	**М.Санжаадорж** (ТУЗ-ийн ердийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2016.04.03-ны өдөр, Дугаар 0520340/	Тийм
6.	**Л.Наранчимэг** (ТУЗ-ийн ердийн гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2022.02.22-ны	Тийм

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MDSKhanLex
2022 -12- 12
БҮРТГЭВ-02
СЗХ
БҮРТГЭВ
№201

				өдөр, Дугаар 0521223/	
7.	**А.Батпүрэв** (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2014.04.13-ны өдөр, Дугаар 0520171/	Тийм
8.	**Р.Гандиймаа** (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2016.05.01-ний өдөр, Дугаар 0520424/	Тийм
9.	**А.Анар** (ТУЗ-ийн хараат бус гишүүн)	Үгүй	Үгүй*	Тийм /2018.04.21-ний өдөр, Дугаар 0130961/	Тийм
10.	**Г.Мөнхзул** (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга)	Үгүй	Үгүй*	Тийм /2022.09.18-ны өдөр, Дугаар 0521202/	Тийм

**Хууль зүйн сайдын 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн №А/195 тоот тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг өмгөөллийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнууд хангаж байгаа эсэхийг бидэнд гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.*

Биржийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

Хүснэгт 4.Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд тавигдсан шаардлагыг хангаж байгаа эсэх мэдээлэл

ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлага				
№	**Шаардлага**	**ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрс**		
		А.Батпүрэв	**Р.Гандиймаа**	**А.Анар**
1.	Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1)	Тийм**	Тийм**	Тийм**
2.	Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж	Тийм**	Тийм**	Тийм**

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
000415

Үнэт цаасны гаргагч _____ Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
MDSKhanLex
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

СЗХ
БҮРТГЭВ

	байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн 3 жилийн хугацаанд аливаа ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх (КтХ-ийн 79.1.2)			
3.	Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх (КтХ-ийн 79.1.3)	Тийм**	Тийм**	Тийм**
4.	Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-ийн 79.1.4)	Тийм**	Тийм**	Тийм**
5.	Компанид нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй байх	Тийм**	Тийм**	Тийм**
6.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй байх	Тийм**	Тийм**	Тийм**
7.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй ханган нийлүүлэгч ба харилцагч биш байх	Тийм**	Тийм**	Тийм**
8.	Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээ хийгээгүй байх	Тийм**	Тийм**	Тийм**
9.	Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, дотоод аудитын ажилтны нэгдмэл сонирхолтой этгээд биш байх	Тийм**	Тийм**	Тийм**
10.	Хувьцаа эзэмшигч эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан биш байх	Тийм**	Тийм**	Тийм**

***Компанийн тухай хуулийн 79.1.1-79.1.4 зүйл, Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг тус Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.*

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын мэргэжил, боловсрол, эрхэлж байсан\байгаа ажлын туршлага зэргээс үзвэл Компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай гэж дүгнэв.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ⚓ 2070096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ⚓ 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000416

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
MDSKhanLex
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Компанийн бусад эрх бүхий албан тушаалтан

Компанийн бусад эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал Х.Алтай нь "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2016 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 2016/04 тоот тогтоол (гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч)-оор, 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 2016/06 тоот тогтоолоор, Ерөнхий нягтлан бодогч С.Алтаннамар Гүйцэтгэх захирлын 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн Б/122 тоот тушаал, 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн Б/19 тоот тушаалаар, Бизнес хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ Гүйцэтгэх захирлын 2022 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн Б/106 тоот тушаалаар, Захиргаа, Санхүүгийн газрын захирал Н.Дөл-Эрдэнэ Гүйцэтгэх захирлын 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Б-17 тоот тушаалаар, Хяналт, зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалан Гүйцэтгэх захирлын 2017 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн Б-62 тоот тушаалаар, Үйл ажиллагааны газрын захирал И.Жавхлан Гүйцэтгэх захирлын 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/116 тоот тушаалаар тус тус томилогдон ажиллаж байна.

Хүснэгт 5.Компанийн бусад эрх бүхий албан тушаалтнуудын боловсрол, ажлын туршлагын мэдээлэл

№	Нэр	Боловсрол	Ажлын туршлага
1.	**Хангайн Алтай** (Гүйцэтгэх захирал)	1999-2004 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч мэргэжлээр бакалавр; 2018-2020 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг Бизнесийн Удирдлага мэргэжлээр магистр.	2004-2007 онд "Бороо Гоулд" ХХК-д Засгийн газартай харилцах ажилтан; 2007-2010 онд МУ-ын Засгийн газарт Ерөнхий сайдын шадар туслах; 2010-2012 онд Монгол Улсын Засгийн газарт Ерөнхий сайдын ажлын алба, Ерөнхий сайдын зөвлөх; 2010-2011 онд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д Тэргүүн дэд захирал; 2011-2014 онд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д Гүйцэтгэх захирал 2015-2016 онд "Би Би Энержи" Компанид Монгол дахь төлөөлөгч; 2016 оноос хойш "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д Гүйцэтгэх захирал.
2.	**Саандарын Алтаннамар** (Ерөнхий нягтлан бодогч)	1994-2000 онд ШУТИС-ХМТС-ийг Радио холбооны инженер мэргэжлээр бакалавр; 2002-2005 онд Монгол бизнесийн дээд сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр бакалавр.	2008-2017 онд "Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв"-д нягтлан бодогч, эдийн засагч; 2017-2018 онд "Цус сэлбэлт судлалын үндэсний төв"-д Ахлах нягтлан бодогч; 2018-2019 онд "Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль"-д Ерөнхий нягтлан

Үнэт цаас гаргагч Андеррайтер

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ДД 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ДД 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000417

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
MDS mnLex
БҮРТГЭВ-02

			бодогч; 2019 оноос "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д нягтлан бодогч.
3.	**Тамираагийн Хаш-Эрдэнэ** (Бизнесийн хөгжлийн газрын захирал)	2001-2005 онд ОХУ-ын РУДН сургуулийг Олон улсын харилцааны мэргэжлээр бакалавр: 2019-2022 онд МУИС-ийн Хууль зүйн сургуульд Эрх зүйч мэргэжлээр бакалавр.	2012-2017 онд "Монгол медиа корпораци" ХХК-д Газрын захирал; 2017-2018 онд Засгийн газрын хэрэг эрхлэх газарт Ерөнхий сайдын Олон нийттэй харилцах бодлого хариуцсан орон тооны бус зөвлөх; 2018-2021 онд ЗГ-ын хэрэг эрхлэх газарт Ерөнхий сайдын дэргэдэх эдийн засгийн бодлогын зөвлөл ажлын албаны дарга; 2021 онд ЗГ-ын хэрэг эрхлэх газарт Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлого хариуцсан зөвлөх; 2021 оноос "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д днд захирал, Бизнес хөгжлийн газрын захирал.
4.	**Нинжийн Дөл-Эрдэнэ** (Захиргаа, санхүүгийн газрын захирал)	1995-1999 онд МУИС-Эдийн засгийн дээд сургуулийг Санхүүч-Эдийн засагч-Мэдээлэл зүйч мэргэжлээр Эдийн засгийн ухааны бакалавр; 2002-2004 онд СЭЗДС-ийг Бизнесийн Удирдлагын магистр; 2012-2019 онд Тайвань Улсын Хятадын соёлын их сургуулийн Бизнесийн Удирдлагын докторант.	1999-2001 онд МУИС-Лицей сургуульд компьютерийн багш; 2001-2002 онд Тээвэр хөгжлийн банк, Эдийн засагч; 2002-2011 онд Чингис Хаан банк, Хөрөнгө зохицуулалт, эрсдэлийн удирдлагын хэлтсийн захирал; 2011-2012 онд "Эм Си Эс Холдинг" ХХК-д Санхүүгийн менежер; 2014-2016 онд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Дотоод аудитор; 2017 оноос хойш "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д Захиргаа, санхүүгийн захирал.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
000418

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

5.	**Анагийн Мөнхбаясгалан** (Хяналт, зохицуулалтын газрын захирал)	1994-1999 онд Франц Улсын Парисын 9 дүгээр их сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр; 1999-2000 онд Франц Улсын Парисын 9 дүгээр их сургуулийг Төрийн удирдлагын магистр.	2004-2005 онд СЭЗДС-д багш; 2005-2006 онд Үйлдвэр худалдааны яамандд мэргэжилтэн; 2006-2015 онд Худалдаа хөгжлийн банкинд Газрын дарга; 2015-2017 онд Сангийн яаманд Газрын дарга; 2017 оноос "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д Үйл ажиллагааны газрын захирал, Хяналт зохицуулалтын газрын захирал.
6.	**Ивановын Жавхлан** (Үйл ажиллагааны газрын захирал)	2009 онд МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийг Олон улсын эдийн засгийн харилцаа мэргэжлээр бакалавр; 2016 онд Австрали Улсын Мельбурн Их сургуулийг Санхүүгийн удирдлагын мэргэжлээр магистр.	2011-2015 онд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д Бүртгэлийн албаны мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн; 2017 – 2020 онд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д Зах зээлийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн; 2020 оноос одоог хүртэл "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д Үйл ажиллагааны газрын захирал.

Компанийн бусад эрх бүхий албан тушаалтан нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

Хүснэгт 6.Компанийн бусад эрх бүхий албан тушаалтнууд Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэх мэдээлэл

КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА				
№	**Нэрс/Шаардлага**	**Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх**	**Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)***	**Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3)**
1.	**Хангайн Алтай** (Гүйцэтгэх захирал)	Үгүй	Үгүй*	Тийм

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЭХ
2022 оны 12 сар 15 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MDSKhanBank
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

2.	**Саандарын Алтаннамар** (Ерөнхий нягтлан бодогч)	Үгүй	Үгүй*	Тийм
3.	**Тамираагийн Хаш-Эрдэнэ** (Бизнесийн хөгжлийн газрын захирал)	Үгүй	Үгүй*	Тийм
4.	**Нинжийн Дөл-Эрдэнэ** (Захиргаа, санхүүгийн газрын захирал)	Үгүй	Үгүй*	Тийм
5.	**Анягийн Мөнхбаясгалан** (Хяналт, зохицуулалтын газрын захирал)	Үгүй	Үгүй*	Тийм
6.	**Ивановын Жавхлан** (Үйл ажиллагааны газрын захирал)	Үгүй	Үгүй*	Тийм

**Хууль зүйн сайдын 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн №А/195 тоот тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг өмгөөллийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бухий албан тушаалтнууд хангаж байгаа эсэхийг бидэнд гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.*

Х.Алтай, Н.Дөл-Эрдэнэ, Т.Хаш-Эрдэнэ, И.Жавхлан, А.Мөнхбаясгалан нар компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан, мөн үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхтэй, компанийн засаглалын болон мэргэжлийн үйл ажиллагаа явуулах талаар зохих мэдлэг туршлагатай.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, бусад эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020599 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
000420

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

МДСХ нь энэхүү асуудлын хүрээнд Биржийн үйл ажиллагааг зохицуулж буй хүчин төгөлдөр дүрэм, журамд дүн шинжилгээ хийлээ. Биржээс МДСХ-д ирүүлсэн материалаас үзвэл нийт 48 дүрэм, журам, заавар, аргачлал хүчин төгөлдөр хэрэгжиж байна (Хавсралт 3). Биржийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам, заавар, аргачлалыг дараах ангиллаар авч жагсаалтын тоог дараах хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

Хүснэгт 7.Биржийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам, заавар, аргачлалын тоон мэдээлэл

№	Дүрэм, журмын төрөл	Нийт
1.	Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам	12
2.	Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаатай холбоотой журам	13
3.	Өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэм, журам	7
4.	Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах журам	5
5.	Хяналт шалгалт, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дүрэм, журам	2
6.	Бусад журам	10
НИЙТ		**49**

Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам

Компанийн дүрэм. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний 02 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж баталгаажуулсан "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн дүрэм (цаашид "**Дүрэм**" гэх)-ээр компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл, үйл ажиллагаа явуулах хугацаа, Компанийн хөрөнгө, хувьцаа, ногдол ашиг, Компанийн удирдлагын бүтэц, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, Компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх хариуцлага, Компанийн хяналтын тогтолцоо, Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан, Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Компанийн хариуцлага, Компанийн бичиг баримтыг хадгалах, Компанийг татан буулгах, дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт батлах тухай нийт 17 бүлэг зохицуулалтыг тодорхойлсон байна. Энэхүү дүрэм нь Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн болно.

ТУЗ-ийн ажиллах журам. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2010 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн тогтоолын хавсралтаар батлагдаж, 2013 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 09 тоот тогтоолын хавсралт, 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 34 дугаар тогтоолоор тус тус өөрчлөлт оруулсан Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмаар Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргах, биелэлтэд хяналт тавих болон ТУЗ-өөс эрх үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн хороод, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн хуралдааны дэг, хурлын шийдвэр, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, нэмэлт өөрчлөлт гэсэн 9 бүлэг 4 хавсралтаас бүрдсэн. Энэхүү журам нь Компанийн тухай хуульд нийцсэн байна.

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журам. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч Сангийн сайдын 2014 оны 06 дугаар сарын 23-ны дөрийн 140 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах, томилох журмаар хараат бус гишүүн нэр дэвшүүлэх, томилохтой холбогдсон үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, ТУЗ-ийн хараат бус гишүүн түүнд тавигдах шаардлага, сонгон шалгаруулалтыг зарлах, сонгон шалгаруулах нэр дэвшүүлэх хороо, түүнийг чиг үүрэг, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, сонгон шалгаруулалтын дүн гаргах, томилох, бусад зүйл гэсэн 8 бүлэгтэй. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журам нь Компанийн тухай хуульд нийцсэн байна.

Ногдол ашгийн бодлого. СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын шаардлагын үндсэн дээр МДСХ-ийн зөвлөмжийн дагуу ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 29 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Ногдол ашгийн бодлогыг баталсан. Уг бодлогоор хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, түүнийг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашиг олгох, түүнийг тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан нь Компанийн тухай хуульд нийцсэн байна.

Эрсдэлийн удирдлагын бодлого. ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 29 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан Эрсдэлийн удирдлагын бодлогоор Биржийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, стратеги зорилтыг хэрэгжүүлэх, урт хугацааны өсөлт, бизнесийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор байгууллагын үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах, арга хэмжээ авах, үр дүнг хянаж, тайлагнах тогтолцоог бий болгох, эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх харилцааг зохицуулсан. Энэхүү бодлого нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.5.8 дахь заалт болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

Засаглалын баримт бичгийн төслүүд

Зарим баримт бичгийн төслийг агуулгын хувьд сайшаах тухай ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 35 дугаар тогтоолоор "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгон нээлттэй хувьцаат компани болж хэлбэрээ өөрчлөх болсонтой холбогдуулан анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсны дараа зарлан хуралдуулах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр дор дурдсан дүрэм, журмын төслийг агуулгын хувьд сайшаасан байна:

1. "Монголын хөрөнгийн бирж" нээлттэй хувьцаат компанийн дүрмийн төслийг 1 дүгээр хавсралтаар;

Дээр дурдсан хувьцаа эзэмшигчдийн хурлын дараа зохион байгуулах Төлөөлөн удирдах зөвлөлийн анхны хурлаар хэлэлцүүлэхээр дор дурдсан компанийн засаглалын журмын төслийг агуулгын хувьд сайшаасан байна:

2. "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын төслийг 2 дугаар хавсралтаар;
3. "Залгамж халааны бодлого"-ын төслийг 3 дугаар хавсралтаар;
4. "Мэдээллийн үйл ажиллагааны журам"-ын төслийг 4 дүгээр хавсралтаар;
5. "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын төслийг 5 дугаар хавсралтаар;

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
2022.12.15 өдөр
БҮРТГЭВ
№ 91

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MDSKhanLex
2022-12-12
БҮРТГЭВ-02

6. "Сонирхлын зөрчлийг зохицуулах журам"-ын төслийг 6 дугаар хавсралтаар;
7. "Шүгэл үлээх журам"-ын төслийг 7 дугаар хавсралтаар.

Төлөөлөн Удирдах зөвлөл нь энэхүү тогтоолыг Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн дүрмийн холбогдох заалтад тусгасан бүрэн эрхийн хүрээнд гаргасан бөгөөд эдгээр төслүүд нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ноос баталсан компанийн засаглалын кодекст нийцсэн байна.

Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн өөрийн үнэлгээний тайлан СЗХ-ноос баталсан аргачлалын дагуу гаргаж 92% гэж үнэлсэн байна.

СЗХ 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Компанийн засаглалын кодексийг шинэчлэн баталсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэгдсэн 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Шинэчилсэн кодексийн 1.2 (залгамж халааны бодлого), 1.4 (ТУЗ-д хүйсийн тэнцвэрийг хангах), 1.5 (чиглүүлэх сургалт), 2.1 (Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байх), 5.3 (байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, хэрхэн удирдаж байгааг тайлбарлах), ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус байх зэрэг болон бусад шинэ нөхцөл, шаардлагыг харгалзан уг кодексийн хэрэгжилтийг хангах талаар тусгай төлөвлөгөө гаргаж ажиллахыг Үнэт цаас гаргагчид зөвлөж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Биржийн Дүрэм болон засаглалд хамаарах дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журам, Компанийн засаглалын кодекст нийцсэн байна.

<u>Үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам</u>

Үнэт цаас гаргагч нь тасалбар болгох өдрийн байдлаар хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй арилжаа эрхлэх үйл ажиллагаанд хамаарах нийт 13 журмыг МДСХ-д ирүүлсэн байна. Үүнд:

Арилжааны журам. МХБ-ийн үнэт цаасны арилжааны төрөл, хэлцэл хийгдэх нөхцөл, арилжааг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдаж, 2015 оны 04 дүгээр сарын 30-ны 2015/06 дугаар 2017 оны 12 дугаар сарын 13-ны 2017/08, 2020 оны 2 дугаар сарын 07-ны 2020/07 дугаар, 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан Биржийн Арилжааны журмыг мөрдөж байна. Уг журам нь нийтлэг үндэслэл, захиалгын төрөл, нөхцөл, арилжааны өмнөх үе, нээлтийн дуудлага арилжаанд захиалга оруулах, энгийн арилжаа, багцын арилжаа, бүгдийн нь биелүүлэх, эсхүл үл биелүүлэх дуудлага арилжааны захиалгын сан, захиалгыг өөрчлөх, цуцлах, арилжааны хаалтын үе, зах зээлийн мэдээллийг нийтлэх, түгээх, хаалтын дараах үе, арилжааг түр зогсоох, хадгаламжийн программ дахь мэдээллийг шинэчлэх, бусад гэсэн 15 бүлэг, Үнэт цаасны арилжааны шимтгэл, үйлчилгээний хөлс гэх нэг хавсралттай.

Арилжааны журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1, 47.2.2, 47.2.4, 47.3, 49.3 хэсэг, СЗХ-ноос баталсан холбогдох журамд нийцсэн.

Үнэт цаасны бүртгэлийн журам. Үнэт цаас гаргагчийн хувьцаа, өрийн хэрэгслийг Биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн ангилал, шалгуурыг тогтоох, үнэт цаасыг нийтэд танилцуулах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталж, 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 2020/06 дугаар, 2022 оны 05 дугаар 10-ны өдрийн 9 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Үнэт цаасны бүртгэлийн журмыг мөрдөж байна. Бүртгэлийн журам нь Нийтлэг үндэслэл, Нийтэд санал болгон анх удаа гаргах үнэт цаасыг биржийн бүртгэлд бүртгэх, Гадаад улсын хөрөнгийн

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӘХК
МОНГОЛЫН
902002069 - 2001096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
000423

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
MDSKhanLex
2022 -12- 12

биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн үнэт цаасны хоёрдогч бүртгэл, Үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэхээс татгалзах, Үнэт цаасны бүртгэлийн ангилал, шалгуур, Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, үнэт цаас гаргагчийн тогтмол биелүүлэх үүрэг, Бүртгэлтэй компанид үзүүлэх үйлчилгээний хөлс, Үнэт цаасыг бүртгэлээс хасах, Хариуцлага, Бусад гэсэн 11 бүлэг, 7 хавсралт (маягт, мэдэгдэл, гэрээний загвар)-тай.

Үнэт цаасны бүртгэлийн журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 10. 11, 12, 18 дугаар зүйл 49 дүгээр зүйлийн 49.1.2, 49.3 дахь хэсэг, СЗХ-ноос баталсан холбогдох журамд нийцсэн.

Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам. ТУЗ-ийн 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл болон үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх бусад мэдээллийг тогтоосон хугацаанд олон нийтэд ил тод, нээлттэй хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан энэхүү журмыг батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, нийтэд мэдээлэх үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдал, хяналт, хариуцлага, маргаан шийдвэрлэх гэсэн 5 бүлэг, нэг хавсралттай.

Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.8 дахь хэсэг, 55, 56 дугаар зүйл, СЗХ-ноос баталсан холбогдох журамд нийцсэн. Үнэт цаас гаргагчаас ирүүлэх Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагааны тайлангийн маягтыг нэвтрүүлж эхэлсэн нь НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангах, компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн өөрийн үнэлгээ хийх шинэлэг алхам болсон гэж үзэж байна.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам. Биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн шинээр болон нэмж гаргасан хувьцаа, өрийн хэрэгсэл болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан бусад санхүүгийн хэрэгслийн анхдагч зах зээл дээр байршуулах, хуваарилалт хийх, арилжих үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, шуурхай явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 2018/15 дугаар тогтоолоор баталж, 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 05 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмыг мөрдөж байна. Уг журам Нийтлэг үндэслэл, Захиалгын бүртгэлийн аргаар хийх арилжаа, Үнэ хаялцуулах дуудлага худалдаа, тогтоосон үнээр санал болгох арилжаа, Бусад гэсэн 5 бүлэг, Анхдагч зах зээлийн арилжаа зохин байгуулах гэрээний загвараас бүрдсэн.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.7-д заасан бүрэн эрхийн хүрээнд баталсан гэж үзлээ. Гэхдээ уг журмыг СЗХ-ны 2021.06.11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журамд нийцүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 7.3-т "Андеррайтер нь үнэт цаас гаргагч, түүний хувьцааны талаарх танилцуулгыг олон нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг ажлын 10 өдрийн дотор, хувьцааны захиалгын бүртгэлийн ажлыг ажлын 5 өдрийн дотор тус тус хийж гүйцэтгэнэ" гэж заасан. Харин биржийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 5.1-д "Захиалгын бүртгэлийн хугацаа эхлэхээс 7-оос доошгүй, 30-аас дээшгүй хоногийн өмнө үнэт цаасны танилцуулгыг олон нийтэд танилцуулсан байна", мөн журмын 6.2-т "Захиалгын бүртгэл нь 3-аас доошгүй, 10-аас дээшгүй ажлын өдрийн хугацаанд үргэлжилнэ" хэмээн заасан нь дээр дурдсан СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 7.3-т заасантай нийцэхгүй байна. Үүнээс гадна СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмаар анхдагч зах зээлийн захиалга, арилжааг андеррайтер төвтэйгөөр зохион байгуулах талаар зохицуулсан зэргийг харгалзан МХБ дурдсан журамдаа нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, шийдвэрлэхийг зөвлөж байна.

Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам. Биржийн гишүүн үнэт цаасны компанийн ажилтанд үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох, түдгэлзүүлэх, сэргээх, цуцлах түүнтэй

ХӨРӨНГИЙН БИРЖ ХХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071006
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6247839 1119277128
000424

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

холбогдсон харилцааг зохицуулахаар зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 2018/20 дугаар тогтоолоор баталж, 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 2019/11 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журмыг мөрдөж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, арилжаанд оролцох эрх оролцох эрх олгох, арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, цуцлах болон бусад гэсэн 4 бүлгээс бүрдсэн.

Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, СЗХ-ноос баталсан "Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам"-ын заалтуудад нийцсэн байна.

Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг Биржийн нэгж эрхийн бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуурыг тогтоох, нэгж эрхийг нийтэд танилцуулах, арилжааг түр зогсоох, сэргээх, бүртгэлээс хасах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шударга, ил тод, шуурхай явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 2019/07 дүгээр тогтоолоор баталж, 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмыг мөрдөж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, нийтэд санал болгон анх удаа гаргах хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг биржийн бүртгэлд бүртгэх, хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэж эрхийн бүртгэлийн шалгуур, шаардлага, сангийн бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүрэг, нэгж эрхийн арилжааг түр зогсоох, бүртгэлээс хасах, үйлчилгээний хөлс, хариуцлага, бусад гэсэн 8 бүлгээс бүрдсэн.

Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай тухай хуулийн холбогдох зүйл заалттай нийцсэн байна.

Биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам. Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хурлын 12 дугаар тогтоолоор энэ журмыг баталсан байна. Биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрхийг үнэт цаасны бүртгэлд бүртгэх, бүртгэлийн шалгуур тогтоох, нэгж эрхийг нийтэд танилцуулах, арилжааг түр зогсоох, сэргээх, бүртгэлээс хасах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Журам нь нийтлэг үндэслэл, нийтэд санал болгон анх удаа гаргах биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрхийг биржийн бүртгэлд бүртгэх, сангийн нэгж эрхийн бүртгэлийн шалгуур, шаардлага, нэгж эрхийг шинээр гаргах, буцаан худалдан авах, сангийн бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүрэг, нэгж эрхийн арилжааг түр зогсоох, бүртгэлээс хасах, үйлчилгээний хөлс, хариуцлага, бусад гэсэн 9 бүлэг бүхий зохицуулалттай байна. Журмыг холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журамд нийцсэн эсэхийг хянавал СЗХ-ны 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр шинэчлэн баталсан Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журамд нийцүүлэх шаардлагатай. Тухайлбал, Журмын 2.2-т "Нэгж эрхийн танилцуулгад Хорооны "Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 7 дугаар зүйлд заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг тусгасан байна" гэснийг Нэгж эрхийн танилцуулгад Хорооны "Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам"-ын 4.2, 16.1-д заасан мэдээллээс гадна дараах мэдээллийг тусгасан байна" гэж өөрчлөх; Журамд заасан үндсэн оролцогч гэсэн нэр томъёог хууль тогтоомж, бусад дүрэм журамд нийцүүлэн тодорхойлохыг зөвлөж байна.

Тус журамд өөрчлөлт оруулахтай холбоотой саналыг СЗХ-оос авч, одоо хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авч байна (Хавсралт 12).

000425

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MDSKhanLex
2022 -12- 12

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК ("МХБ")-ийн бүртгэлд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх, бүртгэлийн шалгуур, шаардлагыг тогтоох, бүртгэлтэй байх хугацаанд ХБҮЦ гаргагчийн хүлээх үүрэг, түүнд хяналт тавих, бүртгэлээс хасахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор ТУЗ-ийн 2020 оны 02-р сарын 07-ны өдрийн 2020/06 дүгээр тогтоолоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмыг мөрдөж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг биржийн бүртгэлд бүртгэх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн шалгуур, шаардлага, бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүрэг, ХБҮЦ-ны арилжааг зогсоох, бүртгэлээс хасах, үйлчилгээний хөлс, хариуцлага, бусад гэсэн 8 бүлэгтэй.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай тухай хууль, СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын холбогдох зүйл заалттай нийцсэн байна.

Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн гишүүн үнэт цаасны компанийг зах зээл үүсгэгчээр бүртгэж гэрээ байгуулах, гэрээг түдгэлзүүлэх, цуцлах болон зах зээл үүсгэгчид тавих хяналт түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах зорилгоор ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журмыг баталсан. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, зах зээл үүсгэгчид тавих шалгуур, шаардлага, зах зээл үүсгэгчээр бүртгэх хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх, , зах зээл үүсгэгчийн хүлээх үүрэг, хариуцлага, зах зээл үүсгэгчийн гэрээг түдгэлзүүлэх, онцгой нөхцөл байдал, хариуцлага, бусад гэсэн 8 бүлэгтэй.

Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын холбогдох зүйл заалттай нийцсэн байна.

Түүнчлэн Бирж нь дараах дүрэм журмыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд батлан мөрдөж байна. Эдгээр нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ноос баталсан холбогдох журмын агуулгатай нийцсэн ба зөрчсөн заалт агуулаагүй байна.

- Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 2017/09 дугаар тогтоолоор баталсан Биржийн үнэт цаасны үнийн индекс тооцох журам;
- Биржийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 165 дугаар тушаалаар баталсан Арилжаа зохион байгуулах заавар;
- Биржийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/79 дугаар тушаалаар баталсан Үнэт цаас гаргагчаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар;
- Биржийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/143 дугаар тушаалаар баталсан Гишүүн компаниудаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам, Биржээр арилжаалагддаг сангийн нэгж эрхийн бүртгэлийн журам батлагдсанаас хойш тэдгээрийн үндэслэл болсон СЗХ-ны журам шинэчлэгдсэнтэй холбоотой зохих өөрчлөлт оруулахыг бид дээр зөвлөсөн. Эрх зүйн хувьд СЗХ-ны журам нь давуу хүчин чадалтай тул Бирж журамдаа зохих өөрчлөлт оруулах хүртэл дурдсан үл нийцлийн хувьд СЗХ-ны журмыг зохицуулалтыг баримтлах нь зүйтэй. Үүнээс бусдаар Биржийн үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан мөрдвөл зохих дүрэм, журамд нийцсэн байна.

<u>Өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэм, журам</u>

Гишүүнчлэлийн журам. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээд биржид гишүүнээр элсэхээр гаргасан өргөдлийг хүлээн авах, гишүүнээр элсүүлэх, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, гишүүний арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах, сэргээх, хасах болон гишүүнд тавих хяналт, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах зорилгоор Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL

000426

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

2018/07 дугаар тогтоолоор Гишүүнчлэлийн журмыг мөрдөж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, гишүүнээр элсүүлэхэд тавигдах шаардлага, гишүүнээр элсүүлэх, татгалзах тухай шийдвэр гаргах, талуудын эрх, үүрэг, хариуцлага, бусад гэсэн 6 бүлэг, гишүүнчлэлийн гэрээний загвар, өргөдлийн маягт, техник, технологийн шаардлага, гишүүнд үзүүлэх үйлчилгээний хөлс гэх 4 хавсралттай.

Гишүүнчлэлийн журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.7 дахь заалт, 49.3 дахь хэсэг, 70 дугаар зүйлд тус тус нийцсэн байна.

Хяналт, шалгалтын журам. Үнэт цаасны арилжаа, гишүүн үнэт цаасны компани, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих, зохих шалгалт хийх, хариуцлага ногдуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 2015/14 дүгээр тогтоолоор Хяналт, шалгалтын журмыг батлан мөрдөж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, хяналт, шалгалтын чиглэл, хяналт шалгалтын зохион байгуулалт, тайлан мэдээ, хамтарсан ажлын хэсэг, хяналт шалгалтын мэргэжилтний эрх, үүрэг, хяналт шалгалтын мэргэжилтэн, хамтарсан ажлын хэсгийн гишүүнд хориглох үйл, ажиллагаа,зөрчлийн төрлүүд, хүлээлгэх хариуцлага гэсэн 5 бүлэгтэй.

Хяналт, шалгалтын журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.5 дахь хэсэг, 70 дугаар зүйлийн 70.1.3-70.1.8 дахь заалтуудад тус тус нийцсэн байна.

Түүнчлэн өөрийгөө зохицуулах байгууллагынхаа хувьд дараах дүрэм журмыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд батлан мөрдөж байна. Эдгээр нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ноос баталсан холбогдох журмын агуулгатай нийцсэн ба зөрчсөн заалт агуулаагүй байна.

- Биржийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 10-р сарын 05-ны өдрийн А/108 дугаар тушаалаар баталсан Биржийн гишүүдийн дагаж мөрдөх ёс зүйн дүрэм;
- Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2003 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан Биржийн мэдээллийн журам;
- Биржийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 12-р сарын 09-ний өдрийн 437 дугаар тушаалаар баталсан Оюутан дадлагажуулах журам;
- Биржийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/58 дугаар тушаалаар баталсан Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх аргачлал;
- Биржийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 17-ны өдрийн 165 дугаар тушаалаар баталсан Иргэн, албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх заавар.

Дүгнэвэл дээр тусгайлан зааснаас бусдаар Биржийн өөрийгөө зохицуулах байгууллагын дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан мөрдвөл зохих дүрэм, журамд нийцсэн байна.

<u>Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журам</u>

Хөдөлмөрийн дотоод журам. Биржийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/138 дугаартай тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмаар Биржтэй хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд оролцож буй ажилтан болон ажил олгогчийн хооронд үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулсан байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, ажилтан сонгон шалгаруулах, ажилд авах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, туршилтын хугацаагаар ажиллуулах, ажилтны хувийн хэрэг бүрдүүлэх, хадгалах, танилцах, ажилтныг шилжүүлэн ажиллуулах, ажил, амралтын цаг, чөлөө олгох, цалин хөлс, шагнал урамшуулал олгох, ажилтны нийгмийн баталгаа, нөхцөл, ажилтны сургалт хөгжил, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, биржийн байранд нэвтрүүлэх, ажилтан болон ажил олгогчийн эрх, үүрэг, ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөрийн гэрээ дуусгавар болгох, цуцлах, ажил хүлээлцэх,

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
2022.12.15 өдөр
БҮРТГЭВ
MDS KhanLex
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-12-12
БҮРТГЭВ-02

хөдөлмөрийн харилцаатай холбоотой маргаан шийдвэрлэхэд баримтлах, дагаж мөрдөх нөхцөл, журмыг тодорхойлсон байна. Журам нь Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Ажилтны ёс зүйн дүрэм. Биржийн ажилтны ёс зүйн дүрмээр биржийн удирдлага болон нийт ажилтны хулиар тодорхойлсон зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, бусад хууль тогтоомжийг биелүүлэх үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, ёс зүйн зөрчилтэй холбогдон үүсэх бусад харилцааг зохицуулах зорилгоор "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2013 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 137 дугаар тушаалын хавсралтаар баталсан Ажилтны ёс зүйн дүрмийг мөрдөж байна. Уг дүрэм нь нийтлэг үндэслэл, ёс зүйн зарчим, ёс зүйн хэм хэмжээ, байгууллагын ажилтны биеэ авч явах зан үйл, техник тоног төхөөрөмжийн хангалт, хэрэглээ, компанийн болон хувийн нууцыг хамгаалах, хариуцлага гэсэн нийт 7 бүлэгтэй. Ажилтны ёс зүйн дүрэм нь Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст нийцсэн байна.

Түүнчлэн дотооддоо хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дараах дүрэм, журам, заавар нь Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомжийг зөрчөөгүй байна гэж үзлээ. Үүнд:

- Биржийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 292 дугаар тушаалын хавсралтаар баталсан Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шалгах журам;
- Биржийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 68 тоот тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан Цалин, урамшууллын хорооны дүрэм;
- Биржийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 236 дугаар тушаалаар баталсан Хүний нөөцийн бодлогын баримт бичиг

Нэгтгэн дүгнэвэл, Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журам нь Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцсэн байна.

<u>Хяналт шалгалт, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дүрэм, журам</u>

Дотоод хяналт шалгалтын журам. Биржийн дотоод хяналт шалгалтын ажлын зохион байгуулалт, чиглэл, дотоод хяналтын ажилтны эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Биржийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийн 167 тоот тушаалын хавсралтаар батлан мөрдүүлж байна. Энэхүү журам нь нийтлэг үндэслэл, дотоод хяналтын ажилтан, түүний эрх, үүрэг, баримтлах ёс зүйн зарчим, дотоод хяналтын шалгалтын хэлбэр, хамрах хүрээ болон дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа, тайлан, хариуцлага гэсэн 4 бүлэгтэй.

Дотоод хяналт шалгалтын журам нь Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журамтай нийцсэн байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр. ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 29 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрөөр үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын үйл ажиллагааны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх хууль бус үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, дотоод хяналтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан. Энэхүү хөтөлбөр нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1 дэх хэсэг, Санхүүгийн

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК МОНГОЛЫН
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 ± 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000428

Үнэт цаас таргагч _____ Андеррайтер _____

Зохицуулах Хороноос баталсан "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтад тус тус нийцсэн байна.

2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А-17 дугаар тушаалаар Арилжааны хяналт хариуцсан мэргэжилтэн албан тушаалд томилогдсон Б.Наранцэцэг нь 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Гүйцэтгэх захирлын Б/161 тоот тушаалаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын ажилтнаар томилогдсон. Б.Наранцэцэг нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.4.11 дэх хэсэг, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийг зохих хууль, дүрэм журмын дагуу хэрэгжүүлж ажиллахаар байна.

Бусад журам

Нууцын журам.Биржийн Гүйцэтгэх захирлын 2011 оны 203 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлаж, 2013 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 86 дугаартай тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан Нууцын журмаар Биржийн үйл ажиллагаатай холбоотой төрийн болон байгууллагын баримт материал, файлын сан зэрэг нууцын зэрэглэлтэй мэдээлэл боловсруулах, нууцлах, хадгалах, архивлах, ашиглах, сэргээх, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгахад илрүүлсэн үл нийцлийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Гүйцэтгэх захирлын "Журамд өөрчлөлт оруулах тухай" А/137 тоот тушаалаар арилгасан байна. Иймд энэхүү журам нь Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Байгууллагын нууцын тухай хуульд нийцсэн байна.

Бараа, материал, ажил үйлчилгээ худалдан авах, ашиглах үйл ажиллагааны журам. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 8-р сарын 04-ний өдрийн 288 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан энэхүү журмаар Биржийн бараа материал, ажил үйлчилгээ худалдан авах, бүртгэх, ашиглах буюу олгох, худалдан авалтын ажиллагаанд хяналт тавих, хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Журам Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгахад илрүүлсэн үл нийцлийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Гүйцэтгэх захирлын "Журамд өөрчлөлт оруулах тухай" А/134 тоот тушаалаар арилгасан байна. Иймд энэхүү журам нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуульд нийцсэн байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам. Биржийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 8-р сарын 04-ний өдрийн 288 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан. Энэхүү журмаар Биржийн үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг зөв зохистой эзэмшиж, ашиглаж, үр ашгийг нэмэгдүүлэхэд хяналт тавих, хөрөнгийн олж, авах, шилжүүлэх, худалдах, актлах, устгах, дүгнэлт гаргахтай холбоотой харилцааг зохион байгуулах чиг үүрэг бүхий өмч хамгаалах байнгын зөвлөлийн эрх зүйн байдал, зөвлөлийн хуралдааныг зохион байгуулах, шийдвэр гаргах болон Зөвлөлөөс эрх үүргээ хэрэгжүүлэх харилцааг зохицуулсан байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна гэж заасныг үндэслэн Компанийн тухай

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
он 2022 оны 12 сар 15 өдөр
БҮРТГЭВ
MDS KhanLex
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

хуулийн 83.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Гүйцэтгэх захирал батлан мөрдүүлж байна.

Архивын үйл ажиллагааны журам. Биржийн Архивын үйл ажиллагааны журмаар компанийн архивын санг бүрдүүлэх, баримт бичиг, хэвлэмэл мэдээ материалыг хүлээж авах, хадгалах, тоо бүртгэл хөтлөх, ашиглуулах төрийн архивын байнгын хадгалалтад шилжүүлэх үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Биржийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 10 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар энэхүү журмыг баталсан. Журам нь нийтлэг үндэслэл, архивын ажлын зохион байгуулалт, байгууллагын архивын үйл ажиллагааны, чиг үүрэг, хадгаламжийн нэгж бүрдүүлэх, архивд баримт хүлээн авах, архивын баримтыг хадгалах ашиглах, устгах, архивын баримтыг төрийн архивд шилжүүлэх, архивын ажилтны эрх, үүрэг, архивын ажилтан болон ажилтнуудад хориглох зүйл, хүлээх хариуцлага болон бусад харилцаатай холбогдсон нийт 11 бүлэг, 3 хавсралтаас бүрдсэн байна.

Журмыг хянахад илрүүлсэн үл нийцлийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Гүйцэтгэх захирлын "Журамд өөрчлөлт оруулах тухай" А/133 тоот тушаалаар арилгасан байх тул Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нийцсэн байна.

Албан хэрэг хөтлөлтийн журам. Албан хэрэг хөтлөлтийн журмаар төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, журмыг чанд мөрдөх, удирдлагын баримт бичгийг зохион бүрдүүлэх, үйл ажиллагааг баримтжуулах, ирсэн, явсан баримт бичгийн бүрдлийг хангах, албан бичгийг стандартын дагуу боловсруулж хөтлөх, бичиг хэргийн эмх цэгц, хадгалалт, ашиглалт, бүртгэл хяналтыг сайжруулах, эрэлт хайлтыг шуурхай оновчтой болгох, асуудлыг цаг хугацаанд нь шийдвэрлэх, албан хэрэг хөтлөх арга, хэлбэрийг боловсронгуй болгох харилцааг зохицуулах зорилгоор Албан хэрэг хөтлөлтийн журмыг Биржийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 10 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан. Энэхүү журам нь хүчингүй болсон хууль, тогтоомжийг удирдлага болгохоор заасан үл нийцлийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Гүйцэтгэх захирлын "Журамд өөрчлөлт оруулах тухай" А/132 тоот тушаалаар арилгасан байх тул холбогдох хууль тогтоомжид нийцсэн гэж үзлээ.

Иргэн, албан байгууллагаас гаргасан өргөдөл гомдлыг хүлэн авч шийдвэрлэх заавар. Иргэн, албан байгууллагаас гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зааврааар мэргэжлийн оролцогчид болон иргэн, албан байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, саналыг хүлээн авч, хянан шийдвэрлэх үйл ажиллагааг зохицуулах зорилгоор "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 17-ны өдрийн 165 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан. Энэхүү заавар нийтлэг үндэслэл, өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, өргөдөл гомдлыг хянан үзэх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, хариуцлага гэсэн нийт 5 бүлгээс бүрдсэн. Зааврыг хянах явцад илрүүлсэн үл нийцлийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Гүйцэтгэх захирлын "Журамд өөрчлөлт оруулах тухай" А/136 тоот тушаалаар арилгасан байх тул холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй гэж үзлээ.

Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрэм. Биржийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 04 дугаар сарын 24-ний өдрийн А/31 тоот тушаалын хавсралтаар баталсан энэхүү Дүрмээр Биржийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, хэрэг бүрдүүлэх, хөтлөгдөж дууссан хэргийг архивт шилжүүлэхэд бэлтгэх явцад баримтын агуулга ач холбогдлыг тодорхойлж, үнэ цэнийг нягтлан шалгах ажлыг зохион байгуулах, хадгалах хугацааг тогтоох болон байгууллагын архив, түүний баримтын бүрэлдэхүүнийг сайжруулах, шилжүүлэх, бэлтгэх харилцааг харилцааг зохицуулсан байна. Дүрмээр нийтлэг үндэслэл, комиссын чиг үүрэг, комиссын эрх, комиссын ажлын зохион байгуулалтыг тодорхойлсон. Энэхүү дүрмийг хянах явцад илрүүлсэн үл нийцлийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Гүйцэтгэх захирлын "Журамд өөрчлөлт оруулах тухай" А/135 тоот тушаалаар арилгасан байх тул 2020 оны 04-р сарын 24-ний өдөр шинээр батлагдсан Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, 2021 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-д тус журмыг нийцсэн байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Түүнчлэн Бирж дотооддоо баталж мөрдөж буй дараах дүрэм, журам, зааварт холбогдох хууль тогтоомжийг шалгахад зөрчил илрээгүй болно. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын 2016 оны 06 дугаар сарын 07-ний өдрийн 224 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Жижиг мөнгөн сангийн үйл ажиллагааны журам;
- Гүйцэтгэх захирлын 2018 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн А/85 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан Харуул хамгаалалтын журам;
- Гүйцэтгэх захирлын 2015 оны 09 дугаар сарын 03-ний өдрийн 261 тоот тушаалын хавсралтаар батлагдсан Мэдээллийн технологийн цогц журам.

Нэгтгэн дүгнэвэл, дээр тусгайлан зааснаас бусдаар Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, СЗХ-ны батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн байна.

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

4. Бусадтай байгуулсан худалдах худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн зэрэг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх

Бид Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Компанийн үйл ажиллагаанд голлох ач холбогдол бүхий дор дурдсан гэрээг хянасан болно.

Хөлсөөр ажиллах гэрээ. Гүйцэтгэх захирал Х.Алтай нь 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 2016/06 тоот Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн тогтоолоор жинхлэн томилогдсон. Компанийн тухай хуулийн 83.7-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдөр 2017/01 тоот "Монголын хөрөнгийн бирж төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хоорондын хөлсөөр ажиллах"-г байгуулсан. Энэхүү гэрээгээр гэрээний ерөнхий зүйл, төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг, гүйцэтгэх захирлын үүрэг, төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, Гүйцэтгэх захирлын эрх, ажлын хөлс, урамшуулал, ажлын нөхцөл, хариуцлага, гэрээнд өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээний хугацаа болон бусад нөхцөлийг тодорхойлсон байна.

Уг гэрээг 2019, 2020 онд тус бүр нэг жилээр сунгаснаас гадна Хөлсөөр ажиллах гэрээнд өөрчлөлт оруулах тухай 2022/02 дугаартай гэрээг 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Гүйцэтгэх захирал Х.Алтайтай байгуулсан байна. Ингэхдээ гэрээний хугацааг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл сунгаж, анхны гэрээг хянахад илэрсэн хуульд нийцээгүй зарим заалтыг хуульд нийцүүлэн өөрчилсөн байх тул Гүйцэтгэх захиралтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээ нь Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.

Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ. Компани нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй үнэт цаас хадгалах, хадгалуулагч хадгалагч талд хадгаламжийн үйлчилгээний хөлс төлөх, хадгаламжийн хугацаа, хадгаламжаас чөлөөлөх, хадгалуулсан үнэт цаастай холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр 01/38, 2022/023 тоот "Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ"-г 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар байгуулжээ. Энэхүү гэрээ нь нийтлэг үндэслэл, хадгалуулах үнэт цаасны нэр, тоо ширхэг, хадгаламжийн үйлчилгээний хөлс, гэрээний хугацаа, үнэт цаастай холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгэх, талуудын эрх, үүрэг, хариуцлага, гэрээ дуусгавар болох буюу түүнийг цуцлах болон бусад гэсэн 9 зүйлээс бүрдсэн байна. Энэхүү гэрээ нь Компанийн тухай хуулийн 3.8 дахь хэсэг, 45.2 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ноос баталсан Хаалттай Хувьцаат компанийн тухай журам, Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журамд тус тус нийцсэн байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/1634 албан бичигт "Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь манай компанитай Үнэт цаасны болон хадгаламжийн төлбөр гүйцэтгэх гэрээ байгуулан ажилладаг бөгөөд гэрээний үүргийн хэрэгжилтийн зөрчилгүй, өр төлбөрийн тооцоогүй" (Хавсралт 10) гэжээ.

Мэдээлэл дамжуулах гэрээ. Бирж болон ҮЦТХТ ХХК нар нээлттэй хувьцаат компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн мэдээллийг Биржид дамжуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар 2021 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 2021/034 тоот Мэдээлэл дамжуулах гэрээг байгуулжээ. Энэхүү гэрээ нь Ерөнхий зүйл, талуудын эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, бусад гэсэн 4 бүлгээс бүрдсэн байна. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ноос баталсан холбогдох журамд тус тус нийцсэн байна.

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК МОНГОЛЫН
9020020699 2021096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000432

Үнэт цаас гаргагч Андеррайтер

Клирингийн үйлчилгээ үзүүлэх хамтран ажиллах гэрээ. Бирж болон Монголын Үнэт цаасны клирингийн төв ХХК нар биржийн үнэт цаасны арилжааны баталгаажсан хэлцлийн клирингийг гүйцэтгэх, төлбөр тооцооны үйл ажиллагаанд хамтран оролцохтой холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахаар 2022 оны 10 дугаар 03-ны өдөр МХБ2022/168 тоот Клирингийн үйлчилгээ үзүүлэх хамтран ажиллах гэрээг байгуулсан. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44, 45-р зүйлд заасанд нийцсэн байна.

Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ. Бирж нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдөр МХБ 2021/100 тоот Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 1 хүртэл жилийн хугацаатай байгуулсан. Гэрээний 1.5-д төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний сунгалтыг тухай бүр хийж баталгаажуулахаар заасны дагуу 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр талууд төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийн дүнг баталгаажуулан дахин нэг жилээр сунгагджээ. Энэхүү гэрээгээр төрийн өмчит хуулийн этгээдийн эзэмшиж байгаа хөрөнгийн ашиглалтын сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн болон өөрийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байдалд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны актын хүрээнд хяналт тавих, өмчийн мэдээллийн сан бүрдүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдон үүсэх талуудын харилцааг зохицуулах, эрх үүрэг, хариуцлагатай харилцааг зохицуулсан. Бирж нь аливаа төлбөрийн үүрэг энэхүү гэрээгээр хүлээгээгүй байна.

Ажлын байрны ашиглалтын гэрээ. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК нар нь 2022 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Ажлын байрны ашиглалтын МХБ 2022/142 тоот гэрээг байгуулжээ. Энэхүү гэрээгээр Түрээслүүлэгчийн өмчлөлийн "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 2 давхрын 3 албан өрөө, 1 заалны зохион байгуулалттай нийт 85 м.кв талбайг ажлын байрны зориулалтаар, 4 давхрын 2 өрөө нийт 11,3 м.кв талбайг архивын зориулалтаар, сервер байршуулах серверийн өрөөний тавиур зэргийг 4 сарын хугацаанд 2022 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл Түрээслэгчид ашиглуулж, нөгөө талаас Түрээслэгч нь гэрээнд тусгасан түрээсийн төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулжээ.

Бирж нь 2017 оноос хойш "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК-тай Ажлын байрны ашиглалтын гэрээ байгуулж байсан байна. Үүнд:

1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон "Арилжааны төлбөр тооцоо" ХХК нар нь 2017 оны 3-р сарын 02-ны өдөр Ажлын байрны ашиглалтын 2017/10 тоот гэрээг байгуулж, Улаанбаатар хот 15160, Сүхбаатарын тайлбай-3, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 2 давхрын 3 албан өрөө, 1 заалны зохион байгуулалттай нийт 85 м.кв талбайг ажлын байрны зориулалтаар түрээсэлсэн байна. Энэхүү гэрээг 2018 оны 2-р сарын 28-ны өдрийг хүртэл 12 сарын хугацаатай байгуулсан бөгөөд гэрээний хугацаа дуусах үед талуудын аль нэг нь гэрээг цуцлах санал гаргаагүй бол гэрээний хугацааг анх байгуулсан хугацаагаар сунгасанд тооцохоор тохиролцсон байна. Дараагаар нь Ажлын байрны ашиглалтын 2017/10 тоот гэрээнд 2020 оны 3-р сарын 06-ны өдөр, 2020 оны 6-р сарын 19-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулснаас "Арилжааны төлбөр тооцоо" ХХК-ийн нэрийг "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК гэж өөрчилсөн байна.
2. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК нар нь 2019 оны 12-р сарын 01-ний өдөр Ажлын байрны ашиглалтын 2019/144 тоот гэрээг байгуулж, Улаанбаатар хот 15160, Сүхбаатарын тайлбай-3, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн 4 давхрын 2 өрөө нийт 11,3 м.кв талбайг архивын зориулалтаар түрээсэлсэн байна. Энэхүү гэрээг 2020 оны 12-р сарын 01-ний өдрийг хүртэл 12 сарын хугацаатай байгуулсан бөгөөд гэрээний хугацаа дуусах үед талуудын аль нэг нь гэрээг

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
2022 -12- 15 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MDSKhanLex
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

цуцлах санал гаргаагүй бол гэрээний хугацааг анх байгуулсан хугацаагаар сунгасанд тооцохоор тохиролцсон байна.

Өгөгдөл нийлүүлэх гэрээ /Data supply agreement/. Бирж болон Exchange data International Компанитай өгөгдөл нийлүүлэх гэрээнд заасан мэдээллийг нийлүүлэгчид нийлүүлэх, нийлүүлэгч нь мэдээллийг нэгтгэн анализ хийж аливаа хязгаарлалтгүйгээр олон нийтэд түгээх, ашиглах, нийлүүлэгч Биржид хөлс төлөх харилцааг зохицуулахаар 2019 оны 6-р сарын 03-ны өдөр Өгөгдөл нийлүүлэх гэрээг байгуулсан. Энэхүү гэрээ нь мэдээлэл ашиглах, шилжүүлэх, төлбөр, хугацаа, гэрээ цуцлах, дуусгавар болгох, төлөөлөл, баталгаа, оюуны өмчийн эрх, нууцлал, нэмэлт, өөрчлөлт, зохицуулах хууль, мэдэгдлийг багтаасан 13 бүлгээс бүрдсэн байна. Энэхүү Гэрээний 4.2-т зааснаар гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан ба хугацаанаас өмнө цуцлаагүй, цуцлах санал гаргаагүй бол 1 жилээр сунгагдахаар зохицуулсан нь Иргэний хуулийн 43.1.2, 196-р зүйлд тус тус нийцсэн ба хүчин төгөлдөр байна. Энэхүү гэрээ нь жил бүр сунгагддаг ба одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй талаар Биржийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно.

Блүүмберг гэрээ. Бирж болон Блүүмберг финанс компанитай байгуулсан гэрээгээр Блүүмберг нь Биржид мэдээлэл, өгөгдөл, программ хангамж тоног төхөөрөмж нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх, Бирж нь холбогдох хөлс төлөхтэй холбоотой харилцааг зохицуулахаар 2009 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр 2813937 тоот Блүүмберг гэрээ байгуулсан. Энэхүү гэрээтэй холбоотой асуудлыг нь АНУ-ын Нью-йорк мужийн хуулийн дагуу Нью-йорк шүүхэд хянан шийдвэрлэхээр байна.

Мэдээлэл нийлүүлэх гэрээ /Information provision agreement/. Бирж болон Thomson Reuters Asia Pte Limited компанитай мэдээлэл нийлүүлэх, мэдээллээр хангах, мэдээлэл ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор 2014 оны 03 дугаар сарын 31-ний өдөр 05 тоот "Мэдээлэл нийлүүлэх гэрээ"-г байгуулсан. Энэхүү гэрээ нь гадаад улсын хууль тогтоомж, шүүх, арбитрын харьяаллыг сонгосон байна.

<u>MIT системтэй холбоотой хэлцэл, гэрээ</u>

Стратеги хамтын ажиллагааны гэрээ.УИХ-ын 2009 оны "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх үндсэн чиглэл" баталсан 79 дугаар тогтоол, 2010 оны "Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах өөрчлөн байгуулах үндсэн чиглэл" баталсан 11 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны "2010 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай" 86 дугаар тогтоол, 2010 оны "Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 115 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Лондонгийн Хөрөнгийн Бирж Групп /ЛХБГ/ болон "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-тэй үйлчилгээ үзүүлэх, дараагийн түвшинд хамтран ажиллахтай холбоотой харилцааг зохицуулсан "Стратеги хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулсан. Энэхүү гэрээ нь 2 жилийн хугацаатай байх ба уг түншлэлийн хүрээнд Ажлын мастер гэрээг байгуулахаар тохиролцсон байна. Ажлын мастер гэрээ нь стратеги хамтын ажиллагааны гэрээний салшгүй хэсэг болно.
Стратеги хамтын ажиллагааны гэрээний 1.1, 10.2, 10.3-д заасны дагуу Англи улсын хууль, арбитрын харьяаллыг сонгосон байна.

Ажлын мастер гэрээ.Стратеги хамтын ажиллагааны гэрээний үндсэн дээр ЛХБГ, Бирж, Төрийн өмчийн хороотой хийгдэх ажлуудыг нарийвчлан тусгасан "Ажлын мастер гэрээ"-г 2011 оны 4

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

000434

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

дүгээр сарын 7-ны өдөр 3 жилийн хугацаатай байгуулсан. Энэхүү "Ажлын мастер гэрээ" нь Үйл ажиллагааны туслалцаа үзүүлэх гэрээ, Лиценз ашиглалт засвар үйлчилгээний гэрээ, Зөвлөх үйлчилгээний гэрээ болон Техник хангамж, сүлжээний үйлчилгээний гэрээ гэх 4 дэд гэрээнээс бүрдсэн.

Ажлын мастер гэрээний 14.3-д хэрэв гэрээний хугацааг сунгавал сунгалтад хамаарах нөхцөл заалтуудыг итгэлцлийн үндсэн дээр хэлэлцэн тохиролцоно гэж заасны дагуу талууд гэрээний хугацааг сунгаж Ажлын мастер гэрээний сунгалт гэрээг 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдөр 3 жилийн хугацаатай байгуулсан[3]. Ажлын мастер гэрээний 22.4-д "Төөрөгдөлд учруулахгүй байх үүднээс, энэхүү гэрээг цуцлах болон гэрээний хүчинтэй хугацаа дууссанаас үл хамааран аль нэг холбогдох гэрээ болон төслийн гэрээнд заагдсан нөхцөлүүдийнхээ хүрээнд хэвийн үргэлжилнэ" гэжээ. Уг сунгалтын гэрээний 5-р зүйлийн төгсгөлд Ажлын мастер гэрээ, түүний дэд гэрээнд өөрчлөлт оруулалгүй үлдээж буй талаар тэмдэглэжээ.

Ажлын мастер гэрээний 22-д гэрээний хугацаа дууссанаар гэрээ дуусгавар болохоор зохицуулсан байна. Дээрхээс хойш гэрээнүүдийг сунгасан материал байхгүй учир Стратеги хамтын ажиллагааны гэрээ, Ажлын мастер гэрээ, түүнд хамаарах 2 дэд гэрээг дуусгавар болсон гэж Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн.

Монголын хөрөнгийн биржээс 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр гэрээний үүргийн гүйцэтгэл, төлбөртэй холбоотой тодруулга асуусан 01/617 тоот албан бичгийг Лондонгийн хөрөнгийн бирж группт хүргүүлсэн. Уг албан бичгийн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хариугаар "Бирж нь 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар төлбөрийн аливаа үлдэгдэлгүйг Лондонгийн хөрөнгийн бирж группээс Грант тронтон Аудит ХХК-д баталгаажуулан байна.

Лиценз ашиглалт засвар үйлчилгээний гэрээ, Үйл ажиллагаа дэмжих үйлчилгээний гэрээ. Лиценз ашиглалт засвар үйлчилгээний гэрээ, Үйл ажиллагаа дэмжих үйлчилгээний гэрээ (License maintenance agreement, Operational service agreement)-г 2011 оны 08 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан.

Лиценз ашиглалт засвар үйлчилгээний гэрээний 2.1-д гэрээний хүрээг тодорхойлж, 4-р зүйлд гэрээний хугацаа 4 жил байх ба автоматаар 2 жилээр дахин сунгагдах нөхцөлтэй байгуулжээ. 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан Сунгалтын гэрээний 3-р зүйлд Лиценз ашиглалт засвар үйлчилгээний гэрээг дуусах хугацаанаас үргэлжлүүлэн 5 жилээр сунгаж, харин Үйл ажиллагааны туслалцаа үзүүлэх гэрээг жил тутам сунгах байдлаар ЛХБГ-тэй хамтран ажиллах нөхцөлүүдийг тусгасан.

Лиценз ашиглалт засвар үйлчилгээний гэрээ нь 2022 онд хугацаа дуусахаар байх ба сунгалтын ажил хэлэлцээрийн түвшинд байна.Үйл ажиллагааны туслалцаа үзүүлэх гэрээний хувьд жил бүр, нийтдээ 4 удаа сунгаснаас гадна 2016, 2018 онд төлбөр болон хугацаатай холбоотой өөрчлөлтүүд орсон байна. Хамгийн сүүлд 2018 оны өөрчлөлтөөр энэхүү Үйл ажиллагааны туслалцаа үзүүлэх гэрээг 2 жилийн хугацаатай сунгахаар тохиролцсон.

Биржээс 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Лиценз ашиглалт засвар үйлчилгээний гэрээ болон Үйл ажиллагааны туслалцаа үзүүлэх гэрээнүүдийн хугацааг сунгах, 2021 оны төлбөрийн асуудлаар харилцан тохиролцохтой холбоотой гэрээний гол нөхцөлийг илгээсэн. Биржээс илгээсэн гэрээний гол нөхцөлийг зарчмын хувьд талууд тохиролцсон байна. Үүний дараагаар

[3] Гарын үсгийг 2014.09.09-ний өдөр зурсан.

СЭХ
он 2022 сар 12 15 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MDS KhanLex
2022 -12- 12
БҮРТГЭВ-02
ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000435

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЭХ
БҮРТГЭВ
MDSKhanLex
2022-12-12
БҮРТГЭВ-02

ЛХБГ, Бирж нар нь 2011 оны 08 дугаар сарын 12-ны өдөр ЛХБГ-тэй байгуулсан Лиценз ашиглалт засвар үйлчилгээний гэрээ, Үйл ажиллагаа дэмжих үйлчилгээний гэрээ (License maintenance agreement, Operational service agreement)-г дуусгавар болгож, шинээр Лиценз ашиглалт засвар үйлчилгээний гэрээ (License and maintenance agreement)-г байгуулахаар болсон байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хэлэлцээрийн түвшинд буйг Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно.

2022 оны Лиценз ашиглалт засвар үйлчилгээний гэрээний хугацаа нь 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаатай байна.

МДСХ нь гэрээний хуулбаруудтай танилцаж МІТ системтэй холбоотой гэрээг дээр тайлбарлав. МДСХ нь гадаад улсын хуулиар байгуулсан гэрээнд аливаа байдлаар дүгнэлт өгөх эрхгүй болохыг анхаарна уу. Түүнчлэн, эдгээр гэрээ, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний загварууд:

МДСХ нь Биржийн арилжаа эрхлэх үйл ажиллагаатай холбоотой дараах гэрээний загвар баримт бичгүүдийг хянасан бөгөөд хууль зөрчсөн явдал илрээгүй ба гэрээний тал, нөхцөлүүдээс хамаарч өөрчлөгдөх боломжтой болно. Үүнд:

Хүснэгт 8. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээний загвар

Баримт бичгийн нэр /загвар/	**Огноо, Дугаар, тайлбар**
Анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах гэрээ	-
Үнэт цаасны бүртгэлийн гэрээ	Үнэт цаасны бүртгэлийн журмын хавсралт 7
Бүртгэлийн гэрээ /өрийн хэрэгсэл/	Үнэт цаасны бүртгэлийн журмын хавсралт 8
Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн гэрээ	Хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн бүртгэлийн журмын хавсралт
Багц үйлчилгээ үзүүлэх гэрээ	-
Багц үйлчилгээ үзүүлэх гэрээ-2 загвар	-
Зогсуур түрээсийн үйлчилгээний гэрээ	-
Мэдээлэл нийлүүлэх гэрээ	-
Миллениум Ай ти системийн орчинд туршилт хийх гэрээ	-
Миллениум Ай ти системийн шууд холболтоор мэдээлэл дамжуулах гэрээ	-
Гишүүнчлэлийн гэрээ	Гишүүнчлэлийн журмын хавсралт
Зах зээл үүсгэгчтэй байгуулах гэрээ	Зах зээл үүсгэгчийн үйл ажиллагааны журмын Хавсралт 2
Үнэт цаасны бүртгэлийн гэрээ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журмын Хавсралт 3

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000436

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

МДСХ нь Биржийн дотоод Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцтэй холбоотой дор дурдсан 4 гэрээний загвар баримт бичгүүдийг хянаж, зарим үл нийцлийг илрүүлж зөвлөмж хүргүүлсний дагуу тэдгээрийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж буй Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэх арга хэмжээ авч буйг Биржийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно.

1. Хөдөлмөрийн гэрээний загвар;
2. Дагалднаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээний загвар;
3. Туршилтаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээний загвар;
4. Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний загвар.

Үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотой гэрээ, хэлцэл

Компанийн ТУЗ-ийн 2022 оны 11-р сарын 11-ний өдрийн 28 тоот Гэрээ байгуулах эрх олгох тухай тогтоолын дагуу аудит, үнэлгээ, андеррайтер компанитай холбогдох гэрээг байгуулсан байна.

Үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээ. Компанийн бизнесийн үнэлгээг Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон Олон улсын үнэлгээний стандарт, Санхүүгийн зохицуулах хороо болон "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-аас баталсан дүрэм, журамд нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхэд үүсэх харилцааг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК болон "Гэрэгэ-Эстимэйт" ХХК-тай 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан МХБ2022/203 тоот Үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээгээр зохицуулсан байна. Энэхүү гэрээнд бизнесийн үнэлгээний зориулалт, үнэлгээний зүйл, талуудын эрх үүрэг, бизнесийн үнэлгээний хөлс, бизнесийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх журмыг тусгасан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.16 дахь заалт, Хөрөнгийн үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн 6.3 дахь хэсэгт нийцсэн байна.

Андеррайтерийн үйлчилгээний гэрээ. Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн зах зээлд санал болгон нэмж хувьцаа гаргах ажлыг зохион байгуулж андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх, үнэт цаас гаргагч нь холбогдох төлбөрийг төлөхтэй холбогдсон харилцааг "Инвескор капитал ҮЦК" ХХК-(РД:6317839, тусгай зөвшөөрлийн дугаар: 301/113 /http://www.frc.mn/o/19665/)-тай 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан МХБ2022/201 дугаартай гэрээ байгуулсан байна.

Андеррайтер нь андеррайтерийн үйлчилгээ[4]-г Үнэт цаасны зах зээлийн тухай 41.4.3-д "хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах", 41.4.4-д "үнэт цаасыг нийтэд санал болгосны дараа түүний худалдагдаагүй үлдсэн хэсгийг бүхэлд нь худалдан авах" хэлбэрээр үзүүлэхээр Үнэт цаас гаргагчтай тохиролцсон байна. Андеррайтерийн үйлчилгээний гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4, 41.5 дахь хэсэг, Иргэний хууль, Монголын Хөрөнгийн Биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-д заасан шаардлагад нийцсэн байна.

"Инвескор Капитал ҮЦК" ХХК нь Үнэт цаас гаргагчтай холбогдох этгээд биш байна.

Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ. "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэсэн

[4] Гэрээний 2.2.3-д "…. анхдагч зах зээлд байршуулж, түүнийг худалдахад шаардлагатай бүхий л хүчин чармайлтыг гаргаж ажиллах ба худалдаагүй үлдсэн хэсгийг нийтэд санал болгосон үнээр бүхэлд нь буюу 100% худалдан авна"

СЭХ БҮРТГЭВ
MDSKhanLex
2022-12-12
БҮРТГЭВ-02
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ
000437

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

2022 оны 6-р сарын 30-ны өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй зэргийг багтаасан Санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийхтэй холбоотой харилцааг "Грант Тронтон Аудит" ХХК (РД: 2577542, тусгай зөвшөөрлийн дугаар: 020-1999, http://www.frc.mn/o/101)-тай 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр байгуулсан МХБ2022/208 дугаар "Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ"-гээр зохицуулсан байна. Уг гэрээнд талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлага, ажлын цар хүрээ, гүйцэтгэх хугацаа, хөлс, үр дүнг хүлээлгэн өгөх, гэрээг дуусгавар болгох журмыг тусгасан нь Аудитын тухай хуулийн 13-т заасан шаардлагад нийцсэн байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6 дахь хэсэг, СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 11.17-д заасан "үнэт цаасны танилцуулгад тусгасан санхүүгийн тайлан үнэн зөв эсэх" гэдэг ажил үйлчилгээг аудитын үйлчилгээ үзүүлэхээр нэмэлт гэрээнд тусгасан нь холбогдох журамд нийцсэн байна.

Хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх гэрээ. Үнэт цаас гаргагч нь 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 8-р зүйлд заасныг баримтлан Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж байгаа хувьцааны үнийг тогтворжуулах харилцааг зохицуулах зорилгоор МХБ2022/218 дугаар "Хувьцааны үнэ тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх гэрээ"-г андеррайтер "Инвескор капитал ҮЦК" ХХК-тай байгуулжээ. Энэхүү гэрээгээр үнэ тогтворжуулах ажиллагааг Үнэт цаас гаргагчийн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс эхлэн 6 сарын хугацаанд хэрэгжүүлэхээр тохиролцсон нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон СЗХ-ноос баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 8.1, 8.2-д нийцсэн байна.

Зээлийн гэрээ.

Компани нь гуравдагч этгээдээс авсан аливаа зээлийн гэрээ байхгүй байна. Сүүлийн 3 жилд байгуулсан бусад бүх зээлийн гэрээ зохих ёсоор хэрэгжиж дууссан болохыг Компанийн Гүйцэтгэх захирлын албан бичгээр мэдэгдсэн болно (Хавсралт 12).

Мөн 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Зээлийн мэдээллийн лавлагаанаас үзвэл Компани нэр дээр зээлийн мэдээлэл бүртгэлгүй байна (Хавсралт 12).

Өрийн хэрэгсэл.

Компани нь нээлттэй, хаалттай өрийн хэрэгсэл гаргаагүй болно (Хавсралт 12).

Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ:

МДСХ нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр (цаашид "Тасалбар болгох өдөр" гэх)-өөр тасалбар болгон Биржийн бусадтай бичгээр байгуулсан, Биржийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээг гаргуулан авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээг авч дүн шинжилгээ хийлээ.

Бирж нь тасалбар болгох өдрийн байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд 1 (нэг) удаа өөрчлөлт оруулж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байх тул хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт тухай бүрд Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (таван) хувьтай тэнцэх дүнг

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

дараах байдлаар тооцож, Биржийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх дүн бүхий гэрээ, хэлцлийн тоон үзүүлэлтийг дор дурдсанаар тодорхойлов.

Хүснэгт 9. Биржийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) хувь болон түүнээс дээш үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцлийн тоон мэдээлэл

№	Улсын бүртгэлийн гэрчилгээ /хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа/	2019.11.01-2022.10.31
1.	Хувь нийлүүлсэн хөрөнгө /төгрөгөөр/	23,130,593,600
2.	Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувь /төгрөгөөр/	1,156,529,680
3.	Нийт байгуулсан гэрээ	0
4.	Хэрэгжиж байгаа гэрээ	0

Үнэт цаас гаргагч нь тасалбар болгох өдрөөс өмнөх 3 жилийн байдлаар Биржийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ байгуулаагүй байна (Хавсралт 12).

Энэхүү хэсэгт тусгайлан дурдсан (гадаад улсын хууль тогтоомжоор зохицуулахаар заасан болон хуулийн нийцлийг хангахаар ажиллаж байгаа гэрээ)-аас бусад Үнэт цаас гарагчийн байгуулсан түүний үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой дээр дурдсан гэрээ, гэрээний загвар нь хууль тогтоомжид нийцсэн, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагаваргүй байна гэж үзлээ.

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

МДСХ нь энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд Биржийн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл дотор их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дуусгавар болоогүй хэрэгжиж байгаа их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа эсэх, байгаа нөхцөлд Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх асуудлыг судалж үзлээ.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар:

Компанийн хувьцаа эзэмшигч нь "Төр" ба хувьцаа эзэмшигчийн чиг үүргийг Сангийн яам хэрэгжүүлж байгаагийн хувьд Бирж нь "Сангийн яам" хувьцааг нь эзэмшдэг 5 компанитай гэрээ байгуулсан эсэхийг хянав. Компани нь сонирхлын зөрчилтэй дор дурдсан хэлцлүүдийг ирүүлснийг хянав.

1) Төрийн банктай 2019 оны 03 дугаар сарын 28-ний өдөр байгуулсан 04/10, МХБ 2019/58 тоот Тусгай нөхцөлт харилцах дансны гэрээ (дуусгавар болсон)
2) Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй байгуулсан Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ *(Дэлгэрэнгүй 4-р хэсгээс үзнэ үү)*
3) Төрийн банктай 2017 оны 03 дугаар сарын 28-ний өдөр байгуулсан 2017/57 ,тоот Байгууллагын тусгай нөхцөлт харилцах дансны гэрээ (дуусгавар болсон)
4) Монголын Үнэт цаасны клирингийн төв ХХК-тэй 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан МХБ2020/23 тоот Клирингийн үйлчилгээ үзүүлэх гэрээ (дуусгавар болсон)
5) Төрийн банктай 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан 2020/40 тоот Тусгай нөхцөлт гэрээ (дуусгавар болсон)
6) Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй 2021 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр байгуулсан 2021/34 тоот Мэдээлэл дамжуулах гэрээ /үнэ төлбөргүй/ *(Дэлгэрэнгүй 4-р хэсгээс үзнэ үү)*
7) Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан 2021/035 тоот Компани хоорондын тооцоогоор төлбөр барагдуулж, хамтран ажиллах гэрээ (дуусгавар болсон)
8) Төрийн банктай 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан 2021/046 тоот Хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээ (дуусгавар болсон)
9) Төрийн банктай 2021 оны 08 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан Хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээ (дуусгавар болсон)
10) Монголын Үнэт цаасны клирингийн төв ХХК-тэй 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан МХБ2022/168 тоот Клирингийн үйлчилгээ үзүүлэх хамтран ажиллах гэрээ *(Дэлгэрэнгүй 4-р хэсгээс үзнэ үү)*
11) Монголын Үнэт цаасны клирингийн төв ХХК-тэй 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр байгуулсан МХБ 2022/142 тоот Ажлын байрны ашиглалтын гэрээ *(Дэлгэрэнгүй 4-р хэсгээс үзнэ үү)*
12) Арилжааны төлбөр тооцоо ХХК-тай 2017 оны 3-р сарын 02-ны өдөр байгуулсан 2017/10 тоот Ажлын байрны ашиглалтын гэрээ (дуусгавар болсон) *(Дэлгэрэнгүй 4-р хэсгээс үзнэ үү)*
13) Монголын үнэт цаасны клирингийн төв ХХК-тай 2019 оны 12-р сарын 01-ний өдөр байгуулсан 2019/144 тоот Ажлын байрны ашиглалтын гэрээ (дуусгавар болсон) *(Дэлгэрэнгүй 4-р хэсгээс үзнэ үү)*

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

14) Төрийн банктай 2020 оны 05 дугаар сарын 29-ны өдөр байгуулсан 240008990107 тоот Үйлчилгээний Ерөнхий гэрээ.

Төрийн банктай байгуулсан гэрээний тухай

Компани нь Төрийн банкны 240008990107 дугаар төгрөгийн харилцах дансанд байршиж буй мөнгөн хөрөнгийн дундаж үлдэгдэлд хүү тооцож олгох тухай гэрээг банкны зарласан хүү шимтгэлийн нөхцөлийн дагуу тооцуулахаар харилцах дансны гэрээг тухайн жилүүдэд байгуулсан. Үүнд дээрх 1, 3, 5-д заасан Тусгай нөхцөлт гэрээнүүд хамаарч байгаа бөгөөд гэрээний хугацааны эцэст банкны үйлчилгээний дагуу хүүгийн орлогыг харилцах дансанд шилжүүлснээр гэрээнүүд дуусгавар болсон (Хавсралт 12).

2020 онд Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд арилжааны банкууд харилцах дансны үлдэгдэлд хүү тооцохгүй болсонтой холбоотой харилцах дансны үлдэгдэлд хүү тооцуулах зорилгоор дээрх 8, 9-д заасан хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээг Төрийн банктай байгуулж, хүүгийн орлогыг хүлээн авснаар гэрээнүүд дуусгавар болсон. Өөрөөр хэлбэл, Төрийн банктай байгуулсан дээрх гэрээнүүд нь Төрийн банкин дахь харилцах дансны үлдэгдэлд банкны үйлчилгээний ерөнхий нөхцөлийн дагуу харилцагчдын дансны үлдэгдэлд хүү тооцох зохицуулалтыг тодорхой болгож баталгаажуулах зорилгоор хийгдсэн, бүгд хэрэгжиж дууссан.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй байгуулсан гэрээний тухай

А. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй байгуулсан Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ, Мэдээлэл дамжуулах гэрээ.

Бирж нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 42.3[5], 45.1[6]-д үнэт цаас бүртгэх, хадгалах, мэдээлэл дамжуулах гэрээг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй байгуулах хуульд заасан шаардлагын хүрээнд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй гэрээ байгуулжээ. Энэхүү гэрээ нь төвлөрсөн хадгаламж, бүртгэл, төлбөр тооцоо гүйцэтгэх, нээлттэй хувьцаат компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг Биржид нийлүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.9-д заасан зөвшөөрлийг авснаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагааг эрхэлдэг байна. Уг хуулийн 45.2-д "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг зөвхөн нэг хуулийн этгээдэд олгоно" гэж заасан. Ийнхүү хуульд заасны дагуу цор ганц байгууллагын хувьд ҮЦТХТ-тэй хуульд тогтоомжид заасны дагуу гэрээ байгуулсан тул Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл аваагүй, зөрчилтэй гэж дүгнэх боломжгүй гэж үзлээ.

Б. Компани хоорондын тооцоогоор төлбөр барагдуулж, хамтран ажиллах гэрээ

Бирж нь 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй 2021/035 тоот Компани хоорондын тооцоогоор төлбөр барагдуулж, хамтран ажиллах гэрээг байгуулсан. Энэхүү гэрээ нь Биржийн хувьцаа эзэмшигч Сангийн яамны 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 8-1/862 албан тоотоор өгсөн удирдамж, ҮЦТХТ ХХК-ийн ТУЗ-ийн 2021

[5] 42.3.Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл нь нэгдсэн тогтолцоотой байх бөгөөд үнэт цаасны төвлөрсөн бүртгэлийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд хөтлөх ба уг хуулийн этгээд нь үнэт цаасны нэгдсэн дугаарыг үнэт цаасны олон улсын нэгдсэн кодын дагуу олгоно.

[6] **Үнэт цаасны зах зээлийн тухай хууль**
45 дугаар зүйл. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа
45.1.Үнэт цаас гаргагч болон бусад оролцогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасыг хадгалах, түүнтэй холбоотой бүртгэл хөтлөх үйл ажиллагаа үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа гэнэ.

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MDSKhanLex
2022 -12- 12

оны 03 дугаар сарын 04-ний 01 дугаар шийдвэр, Биржийн ТУЗ-ийн 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 01 дугаар хурлын тэмдэглэлд үндэслэн Миллениут Ай Ти системийн ашиглалтын зардлыг хуваах хариуцах нөхцөлийг тохиролцсон.

Биржийн хувьцаа эзэмшигчийн чиг үүргийг Сангийн яам хэрэгжүүлдэг ба Сангийн яамны чиглэл, Биржийн ТУЗ-ийн тэмдэглэл бүхий шийдвэрийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулсан нь Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхтэй холбоотой зөвшөөрлийг зарчмын хувьд олгосон гэж үзэхээр байна.

Үнэт цаасны клирингийн төвтэй байгуулсан гэрээний тухай

Үнэт цаасны клирингийн төв нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.7, 24.1.8-д заасан зөвшөөрлийг авснаар Үнэт цаасны арилжааны тооцооны, төлбөрийн үйл ажиллагааг эрхэлдэг байна. Тус хуулийн 43.1.1-д "үнэт цаасны арилжааны дараа арилжаанд оролцогч талуудын гэрээ, хэлцлийн дагуу төлбөл зохих төлбөрийг гэрээ тус бүрээр болон нэгдсэн байдлаар тодорхойлж, холбогдох санхүүгийн бүртгэл, тооцооллыг хийх", 43.1.2-д "төлбөр хийгдэх бэлтгэлийг ханган, төлбөр гүйцэтгэх даалгаврыг эрх бүхий төлбөрийн байгууллагад илгээх" гэж тус тус заасан. Иймхүү хуульд заасны дагуу Үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны үйл ажиллагааг Монголын Үнэт цаасны клирингийн төв ХХК эрхэлдэг байна. Өөрөөр хэлбэл, Үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх цор ганц байгууллагын хувьд тус этгээдтэй хуульд тогтоомжид заасны дагуу гэрээ байгуулсан байна.

Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй 14 хэлцэл хийсэн бөгөөд тус гэрээнүүдээс 9 нь хэрэгжиж дууссан, 5 нь Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хэрэгжиж байгаа, ямар нэгэн зөрчил маргаан гараагүй байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар нийт 5 хэлцэл нь хэвийн хэрэгжиж байгаа болохыг Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно.

Дүгнэвэл Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг нэг удаа авсан, 4 тохиолдолд зах зээл дээр тухайн төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг цор ганц байгууллагатай гэрээ байгуулсан, бусад тохиолдолд байгуулсан ажлын байрны ашиглалтын гэрээнээс бусад гэрээ нь хэрэгжиж дууссан, ямар нэг маргаан гараагүй байна. Цаашид сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахтай холбоотой хуулийн шаардлагыг хангаж ажиллах нь зүйтэй байна.

Их хэмжээний хэлцлийн талаар:

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (Компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй) болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Үнэт цаас гаргагчаас МДСХ-д ирүүлсэн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас балансын нийт активын дүнгээс их хэмжээний гэх дүн дараах байдлаар тооцов. Үүнд:

Хүснэгт 10.Их хэмжээний хэлцлийн тоон мэдээлэл

№	Санхүүгийн тайлан/хэлцлийн хугацаа	Тухайн жилийн балансын актив (төгрөгөөр)	Тухайн жилийн балансын активын 25% (төгрөгөөр)	Гэрээ байгуулагд сан эсэх
1	2018 оны жилийн эцэс (2019 оны хэлцэл)	4,551,963,207,430	1,137,990,801,860	Үгүй

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ
000442
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч Андеррайтер

2	2019 оны жилийн эцэс (2020 оны хэлцэл)	3,787,255,243,540	946,813,810,890	Үгүй
3	2020 оны жилийн эцэс (2021 оны хэлцэл)	3,458,327,881,340	864,581,970,340	Үгүй
4	2022 оны жилийн эцэс (2021 оны хэлцэл)	5,378,573,759,480	1,344,643,439,870	Үгүй

Дээрх хүснэгтэд тусгагдсан Үнэт цаас гаргагчийн хэлцэл хийхийн өмнөх балансын сүүлийн активын 25 хувийн дүнтэй тэнцэх, түүнээс дээш их хэмжээний аливаа гэрээ, хэлцэл байгуулаагүй байна (Хавсралт 12). Энэ талаар Компанийн гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн.

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Үнэт цаас гаргагч нь Бүгд найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын 1991 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 22 дугаар тогтоолын дагуу 1991 оноос хөрөнгийн биржийн үйл ажиллагаа эрхэлж байна[7]. 1994 онд анхны Үнэт цаасны зах зээлийн тухай хууль батлагдсан. Ийнхүү Монгол Улсын Үнэт цаасны хорооны 1996 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар тогтоолоор хөрөнгийн биржийн тусгай зөвшөөрөл, 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 80 дугаар тогтоолоор үнэт цаасны зах зээл дээр үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл тус тус олгосон. Түүнчлэн, Биржийг СЗХ-ны 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор Үнэт цаасны зах зээл дэх өөрийгөө зохицуулах байгууллага гэж бүртгэсэн байна.

Хамгийн сүүлд СЗХ-ны 2006 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор Үнэт цаасны зах зээл дээр үнэт цаасны арилжааны үйл ажиллагаа эрхлэх 330/01 дугаар тусгай зөвшөөрлийг авсан. Үнэт цаас гаргагч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.5 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.11, 24.2 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрөл авах шаардлагыг ханган ажиллаж байна.

СЗХ-ны 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/4605 тоот албан бичигт "Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь СЗХ-ны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам"-ын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахын зэрэгцээ хурлын шийдвэрийг олон нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдуулснаас хойш ажлын гурван өдрийн дотор Хороонд ирүүлэх үүргээ биелүүлэн ажиллаж байна. Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон СЗХ-ны 2021 оны 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" холбогдох хууль тогтоомжийн дагуу Хороонд ирүүлбэл зохих тайлангуудыг ирүүлдэг. 2022 оны байдлаар Хорооноос аливаа хариуцлагын арга хэмжээ авсан талаар мэдээлэл бүртгэгдээгүй болно" гэжээ.

Оюуны өмч.

Оюуны өмчийн газрын барааны тэмдгийн цахим бүртгэлийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хайлт, Оюуны өмчийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 21678 тоот албан бичиг, 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 31682 тоот албан бичиг (Хавсралт 6)-т тус тус зааснаар "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн нэр дээр эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, зохиогчийн эрхийн аливаа бүтээл байхгүй. Компанийн нэр дээр дараах 2 барааны тэмдгийг бүртгүүлсэн байна. Түүнээс 1 нэг хүчин төгөлдөр бус, 1 нь хүчин төгөлдөр бүртгэлтэй байна:

Хүснэгт 11.Барааны тэмдгийн мэдээлэл

№	Утга /тэмдэг/	Мэдүүлгийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Хүчинтэй хугацаа

[7] Бүгд найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын 1991 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн "Өмч хувьчлалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 22 дугаар тогтоол, Монгол Улс Үнэт цаасны хорооны 1996 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар тогтоол, 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 80 дугаар тогтоол

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

1.		40-1998-0002437	40-0002256	Хүчингүй **Бирж уг барааны тэмдгийн хугацааг сунгахаар Оюуны өмчийн газарт хандсан байна.*
2.	mse	40-2016-0018280	40-0016322	2026.05.27

Компанийн дээрх хүснэгтийн 1-д заасан барааны тэмдгийн хуулиар хамгаалагдах хугацаа 2008 онд дууссан байх ба Бирж нь 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр уг барааны тэмдгийг дахин бүртгүүлэхээр Оюуны өмчийн газарт ханджээ. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн дээрх 1-д заасан барааны тэмдгийн хугацааг сунгах, дахин бүртгүүлэх ажиллагаа хийж байна (Хавсралт 6).

Домэйн нэр. Бирж нь Датаком ХХК-тай www.mse.mn домэйн нэр авахаар 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр 05/27 тоот Үйлчилгээний гэрээг 1 жилийн хугацаатай байгуулсан. Энэхүү гэрээний 2.3.1-д "....Гэрээний хугацаа дуусахад талуудын аль нэгээс цуцлах санал гаргаагүй бол гэрээнд дурьдсан нөхцөлөөр сунгагдсанд тооцно" гэж зааснаас харвал домэйн үйлчилгээний гэрээ нь 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр хүртэл хүчинтэй байна. Түүнчлэн 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Биржийн домэйн төлбөрийг төлсөн байх тул домэйн нь хүчин төгөлдөр байна гэж үзлээ.

Дээрх хүснэгтийн 1-д дурдсан барааны тэмдгийг дахин бүртгүүлэх ажиллагаа эхлүүлснийг эс тооцвол Компанийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг (дээр тусгайлан дурдсанаас бусад) нь хүчин төгөлдөр, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээх зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл бий болоогүй гэж дүгнэв.

000445

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Үнэт цаас.

Компани нь аливаа компанийн хувьцаа, үнэт цаас эзэмшдэггүй болохыг тус Компанийн Гүйцэтгэх захирал албан ёсоор бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12).

Үнэт цаас гаргагчийн барьцаанд байгаа хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө. **(**Хавсралт Лавлагаа 7**)**

Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн барьцааны цахим мэдээллийн сангийн 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хайлтаас үзвэл Биржид аливаа барьцааны бүртгэл байхгүй байна.

Тээврийн хэрэгсэл.

Компаниас ирүүлсэн тээврийн хэрэгслийн гэрчилгээ болон Авто тээврийн үндэсний төвийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн тээврийн хэрэгслийн лавлагаанаас үзвэл Компани нь нийт 2 тээврийн хэрэгслийг өмчилдөг бөгөөд эдгээр нь аливаа байдлаар барьцаалагдаагүй байна. (Хавсралт 7)

Газар эзэмших эрх. *(*Хавсралт 7*)*

Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалтын албаны 2022 оны 11 дүгээр сарын 18-ний өдрийн 01-09/5710 дугаар албан бичигт “Чингэлтэй дүүргийн 01 дүгээр хороонд байрлах газар эзэмшигч Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь 2022 оны жилийн эцсийн байдлаар газрын төлбөрийн үлдэгдэлгүй болно” гэж Бирж нь Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэгт газар эзэмшдэгийг тодорхойлсон.

Компанийн эзэмших, ашиглах эрхтэй газруудыг жагсаавал:

Хүснэгт 12.Компанийн эзэмшдэг газрын мэдээлэл

№	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Байршил	Газрын хэмжээ мкв, эсхүл га-аар	Газрын гэрчилгээний огноо, дугаар	Газар эзэмших эрхийн хугацаа	Барьцаалагдсан эсэх
1	1500400134	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо	1055,0 мкв	2019.08.16-ны өдрийн Э-2202001407	15 жил	Үгүй[8]
2	4317001040 (хуучин нэгж талбарын дугаар 1850545301 7518)	Үр тариа, өндөр худаг	Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн сумын	1497593 м2	2015.08.25-ны өдрийн 000315235	15 жил	Үгүй[9]

[8] Газрын гэрчилгээний ард талын тэмдэглэгээ

[9] Газрын цахим сайтаас авсан нэгж талбарын тодорхойлолт

000446

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

3	4317000674	Үр тарианы усалгаатай тариалан	Сэлэнгэ аймгийн Баруун бүрэн сумын Зараагийн хөндий	951350 м.кв	2008.12.17-ны өдрийн 0000138732, Э-1302000494	60 жил	Үгүй[10]

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн дээр дурдсан 3 газрыг эзэмших эрх нь хүчин төгөлдөр, аливаа үүргийн гүйцэтгэлд барьцаалаагүй байна.

Үл хөдлөх эд хөрөнгө.

УБЕГ-ын Эд хөрөнгийн бүртгэлийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн албан бичгээс үзвэл Компанийн нэр дээр аливаа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх бүртгэгдээгүй байна.

Эд хөрөнгийн бүртгэлийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5.1, 8.1-д зааснаар хуулийн этгээдийн нэр дээр эд хөрөнгө өмчлөх эрхийг хуульд заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх үүссэн гэж үзнэ. Гэтэл Биржийн өөрийн хаяг дээр байрлах үл хөдлөх эд хөрөнгө болох 3 давхар байшингийн өмчлөл нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдээгүй байна. 2018 онд шинэчлэгдэн батлагдсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт "Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журмыг энэ хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Засгийн газар батална" гэж заасантай холбоотойгоор дүгнэлт гаргах явцад дараах нөхцөл байдлыг тогтоов. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А-1/2305 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн байна. Уг албан бичигт "Монголын хөрөнгийн бирж төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд бүртгэлтэй Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 1-р хороо, Сүхбаатарын талбай-3 хаягт байрлах хавсралтаар хүргүүлж байгаа барилга байгууламж, газар, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогод хамруулсан. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх журмыг батлуулахаар Хууль зүй дотоод хэргийн яаманд ажлын хэсэг ажиллаж байна. Иймд уг журам батлагдсаны дараа Монголын хөрөнгийн бирж төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшилд байгаа төрийн өмчийн хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлэх боломжтой болно" гэжээ. Уг албан бичгийн хавсралтад Биржийн үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 1-р хороо, Сүхбаатарын талбай-3 хаягт байрлах 3 давхар барилга, байгууламж багтсан байна.

Хуульд заасан холбогдох журам батлагдсанаар Монголын хөрөнгийн бирж төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшилд төрийн өмчийн хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлэх боломжтой байна. Харин Бирж нь IPO хийж 34 хувиа олон нийтэд санал болгосноор төрийн өмчит хуулийн этгээд биш, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болох юм. Тэр үед Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсгийн "Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаас бусад төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэх журмыг энэ хууль болон холбогдох бусад хуульд нийцүүлэн Засгийн газар батална" гэх зохицуулалт Биржид хамаарахгүй гэж үзэж байна. Иймд IPO амжилттай болсны дараа үл хөдлөх эд хөрөнгөө Эд хөрөнгийн бүртгэлийн улсын

[10] Газрын цахим сайтаас авсан нэгж талбарын тодорхойлолт

000447

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

бүртгэлийн тухай хуулийн 5.1, 8.1-д зааснаар хуулийн этгээдийн хувьд нэр дээрээ хуульд заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх боломжтой гэж үзэж байна.

Түүнчлэн, Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотойгоор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А-1/2391 тоот албан бичгийг Биржийн Гүйцэтгэх захирал Х.Алтайд хүргүүлсэн байна. Уг албан бичигт "Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 336 дугаар тогтоолоор Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн нийт энгийн хувьцааны 34 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт хувьцааг гаргах, олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн. Дээрх шийдвэрийн хэрэгжилтийн хүрээнд хувьцаагаа олон нийтэд санал болгох үйл ажиллагаа амжилттай болмогц Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн үйл ажиллагаагаа явуулж буй Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 1-р хороо, Сүхбаатарын талбай-3 хаягт байрлах 3 давхар барилга, байгууламжийг Монгол Улсын Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу өмчлөх эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг үүгээр чиглэл болгож байна" гэжээ. Өөрөөр хэлбэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь Биржийн үйл ажиллагаа явуулж буй Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороонд байрлах 3 давхар барилга, байгууламжийг зохих ёсоор Биржийн өмчлөлд бүртгүүлэхийг зөвшөөрч, холбогдох арга хэмжээ авах чиглэлийг албан ёсоор мэдэгдсэн байна.

Бирж нь хувьцаагаа олон нийтэд санал болгох үйл ажиллагаа амжилттай болмогц дээр дурдсан баримт бичгийг Эд хөрөнгийн бүртгэлийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын чиглэл, албан бичигт тус тус үндэслэн өөрийн үйл ажиллагаа явуулж байгаа барилга, байгууламжийн өмчлөх эрхээ улсын бүртгэлд бүртгүүлж, баталгаажуулсан гэрчилгээ авах боломжтой байна.

000448

Үнэт цаас гаргагч _____

Андеррайтер _____

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3-т заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу тус МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллүүдийг нягталж нийтэд ил болсон мэдээлэл, төрийн болон эрх бүхий байгууллага, Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт харьцуулсан дүн шинжилсний үндсэн дээр Үнэт цаасны танилцуулгад тусгасан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр эсэхийг дүгнэв.

МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий дараах мэдээлэл Үнэт цаас гаргагч, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулж авсан баримт материалтай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагдсан огноо, оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа;
- Үнэт цаас гаргагч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, улсын бүртгэлд бүртгэсэн огноо;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүнд хувьцаа эзэмшигч нарын эзлэх хувь, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ;
- Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн тухай;
- Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тэдгээрийн өмчлөл дэх хувьцааны тоо, хувь хэмжээний талаарх мэдээлэл;
- Үнэт цаас гаргах шийдвэр /үнэт цаасны тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, нийтэд санал болгох үнэ, нөхцөл, татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт г.м/;
- Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын баг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл;
- Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл;
- Нээлттэй хүрээнд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг, үнэт цаасны үнэ тогтворжуулах хөтөлбөр;
- Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай мэдээлэл;
- Компанийн эрх бүхий байгууллагаар батлуулсан ногдол ашгийн бодлого;
- Тухайн үнэт цаасыг нээлттэй хүрээнд санал болгох ажиллагаанд оролцож байгаа зохицуулалттай этгээд, мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй (үндсэн андеррайтер, аудит, хууль, үнэлгээний байгууллага) этгээдийн тухай, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай талаарх;
- Үнэт цаас гаргагч болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдүүдийн хооронд үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар гаргасан мэдэгдэл.

000449

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Дээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээ, зээлжих зэрэглэл, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай болон Үнэт цаас гаргагчийн зах зээлийн судалгаа, төлөвлөгөө зэрэгт агуулагдсан эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлт, санхүүгийн төсөөлөл, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, түүхэн замнал, ололт, амжилт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, үнэлгээ, Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнесийн төлөвлөгөө, дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм, хувьцааг анхдагч зах зээлд байршуулах, захиалга авах, худалдах, арилжих нөхцөл, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө зэрэг мэдээлэлд МДСХ дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна.

000450

Үнэт цаас гаргагч _____

Андеррайтер _____

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн №LWA4-EULZZMTW-JVQW тоот Компанийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагааг судалсан. Дэлгэрэнгүйг (Хавсралт 9) үзнэ үү.

Компанийн дүрмээс үзвэл Биржийн саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг "Төр" эзэмшдэг байна. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн "Монголын хөрөнгийн биржийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 152 дугаар тогтоолоор Биржийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэгчээр Сангийн яамыг томилсон.

Компанийн Дүрмийн 1.8-д "Компани нь 100 хувь төрийн өмчит хувьцаат компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосон этгээд буюу Сангийн яам байна", Дүрмийн 3.2-д "Компанийн өмчлөгч нь төр байх ...", уг Дүрмийн 6.1-д "Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Сангийн яам хэрэгжүүлнэ" гэж тус тус заасан.

Монгол Улсын яамыг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд тэргүүлнэ[11].

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д ."эцсийн өмчлөгч" гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д эцсийн өмчлөгч гэж ".... хүнийг" ойлгохоор заажээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн №22900002004531 тоот Компанийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл Биржийн эцсийн өмчлөгчөөр Сангийн яамыг 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдөр бүртгэсэн байна.

Гэвч 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр УБЕГ "төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд эцсийн өмчлөгчийг бүртгэхгүй гэсэн хариу өгч" эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэлээс хассан байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр ирүүлсэн Компанийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа болон олон нийтэд нээлттэй Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллээс хайлт хийж үзвэл Биржийн эцсийн өмчлөгч бүртгэгдээгүй байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1.14 дэх заалт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар аливаа хуулийн этгээд эцсийн өмчлөгч (хүн)-өө бүртгүүлсэн байх үүрэгтэй. Уг хуульд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаар ямар нэг зохицуулалт байхгүй.

Иймд Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох боломжгүй байна. Энэхүү дүгнэлт нь бусад хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөх боломжтойг дурдаж байна.

[11] **Монгол Улсын Засгийн газрын тухай хууль**
18 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 4.Монгол Улсын яамыг Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд тэргүүлнэ. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяа яам, агентлагийн үйл ажиллагааг сайдын өмнө хариуцах үүрэг бүхий дэд сайд байна.
20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 6. Сангийн сайд:

000451

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Эрүүгийн хэрэг

Цагдаагийн ерөнхий газар мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 13б/2472 тоот албан бичигт тусгаснаар Монголын хөрөнгийн бирж ТӨХК /БД: 9012001021, РД: 2071096/-ыг сүүлийн 3 жилийн хугацаанд эрүүгийн хариуцлага хүлээсэн болон гэмт хэрэгт холбогдон шалгагдсан эсэхийг цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас шалгахад мэдээлэл бүртгэгдээгүй байна.

Иргэний хэрэг

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архиваас 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 1/3287 тоот албан бичигт тусгаснаар Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь сүүлийн 3 жилийн байдлаар Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 182/ШШ2022/01719 дүгээр шийдвэртэй, ХХХ ХХК нэхэмжлэлтэй Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д холбогдох гүйцэтгэх захирлын 2021 оны 11 сарын 8-ны өдрийн А/100 дугаар тушаалын холбогдох хэсгийг хүчингүй болгуулж, хувьцааны бүртгэлийг сэргээхийн хариуцагчид даалгах тухайн иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан байна. Энэ талаар бид Биржээс тодруулахад талууд эвлэрлийн гэрээ байгуулж, хялбаршуулсан журмаар маргааныг шийдвэрлэсэн гэв.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитрын 2022 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 4/1743 тоот Тодорхойлолтод тусгаснаар тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь 2022 оны 11 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.

Багахангай болон Налайх дүүргийн шүүхийн тамгын газрын 2022 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн 01/238 тоот албан бичигт Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь сүүлийн 3 жилийн байдлаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.

Багануур дүүргийн шүүхийн тамгын газрын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 306 тоот албан бичигт Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр 2019-2022 онуудад "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-тай хамаарал бүхий хэрэг маргаан хянан шийдвэрлэгдээгүй байна. Мөн одоо хянагдаж буй хэрэг маргаан байхгүй байна.

Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 779 тоот албан бичигт тусгаснаар Улсын бүртгэлийн 9012001021 гэрчилгээтэй, 2071096 тоот регистрийн дугаартай "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь 2021, 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэлх хугацаанд Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрлэсэн иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцож байсан эсэх бүртгэлийг шүүж үзэхэд 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 101/ШШ2021/00198 дугаар шийдвэрээр шийдвэрлэгдсэн "Монголын хөрөнгийн бирж" ХХК-ийн нэхэмжлэлтэй Хөдөөгийн тээвэр ХХК-д холбогдох бүртгэлийн хураамжид 6,687,700 төгрөг гаргуулах тухай

иргэний хэрэгт нэхэмжлэгчээр оролцсоноос өөр байдлаар нэхэмжлэгч, хариуцагчаар оролцож байгаагүй болно. Энэ хэрэг нь зохигчдын эвлэрлийг баталж хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар 2022 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн 1311 тоот албан бичигт тусгаснаар "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК /РД: 2071096/ нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийг хүртэл Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцсон эсэхийг хэргийн хөдөлгөөний нэгдсэн програмаас шүүж үзэхэд Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 1 хэрэгт нэхэмжлэгчээр, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 1 хэрэгт хариуцагчаар оролцсон байна. *(Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хариуцагчаар оролцсон хэргийн товчоонтой энэ хэсэгт буй Шүүхийн ерөнхий зөвлөлийн тодорхойлолтоос танилцана уу.)*

Баянгол, Хан-уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2022 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн, 1433 дугаартай тодорхойлолтод "Улсын бүртгэлийн 901200121, 2071096 тоот регистрийн дугаартай "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь сүүлийн 3 жилийн байдлаар Хан-уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт нэхэмжлэгчээр оролцож байсан болохыг тодорхойлов" гэжээ. Уг албан бичгийн хавсралтаас харвал Бирж нь нэхэмжлэгчээр оролцсон нийт 4 иргэний хэргээс 3 хэрэг нь зохигчийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож, 1 хэрэг нь хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэрэг байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар өөр хэрэг, маргаанд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцоогүй байна.

Худалдааны танхимын дэргэдэх Үндэсний ба олон улсын арилжааны арбитрын 2022 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 65/2022/064 тоот Тодорхойлолтод тусгаснаар тус ТӨХК нь 2022 оны 11 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар арбитрын хэрэгт нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.

Биржээс ирүүлсэн мэдээллээс үзвэл тасалбар болгох өдрийн байдлаар шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа иргэний нийт 15 хэрэгт Бирж нэхэмжлэгчээр оролцож байгаа ба эдгээр бүх хэрэгт хариуцагчийг эрэн сурвалжлах ажиллагаа хийгдэж байна (Хавсралт 10. шүүхэд хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагаа хийгдэж буй маргааны мэдээлэл).

Захиргааны хэрэг

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн тамгын газраас 2022 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр гаргасан 2860 тоот албан бичигт тусгаснаар Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь сүүлийн 3 жилийн хугацаанд 2 захиргааны хэрэгт хариуцагчаар оролцож байгаа одоогоор шүүхийн шийдвэр гараагүй, анхан шатны шүүхэд хянагдаж байна. Эдгээр нь хөрөнгө оруулалтын сангийн хураамжийг буруу тооцсон, эсхүл үнэт цаасны бүртгэлтэй холбоотой захиргааны актын холбогдох хэсгийг хүчингүй болгохтой холбоотой шаардлага бүхий маргаан байна. (Хавсралт 10. шүүхэд хэрэг хянан шийдвэрлэгдэх ажиллагаа хийгдэж буй маргааны мэдээлэл)

000453

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/1634 албан бичигт "Монголын хөрөнгийн бирж ТӨХК нь манай компанитай Үнэт цаасны болон хадгаламжийн төлбөр гүйцэтгэх гэрээ байгуулан ажилладаг бөгөөд гэрээний үүргийн хэрэгжилтийн зөрчилгүй, өр төлбөрийн тооцоогүй" гэжээ.

Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2022 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр гаргасан 01/1951 тоот албан бичигт тусгаснаар Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2014 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дугаартай тогтоолоор үнэт цаасны зах зээлийн хөрөнгийн биржийн арилжааны үйлчилгээний хүрээнд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоосон байна. Мөн тус газраас Биржид Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн үндэслэлээр сүүлийн 5 жилд захиргааны шийтгэл оногдуулж байгаагүй байна (Хавсралт 10).

Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа шинжилгээ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-иас 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр гаргасан 04/623 тоот албан бичигт тусгаснаар Монголын хөрөнгийн бирж ХК нь өөрийн Үнэт цаасны бүртгэлийн журам болон бүртгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэн ажиллаж байна (Хавсралт 10).

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЭХ
он сар өдөр
2022.12.13
БҮРТГЭВ
2022.12.13
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MDS KhanLex
2022-12-12
БҮРТГЭВ-02

Компани нь 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Монголын татварын албаны тодорхойлолтоор татварын байгууллагад 134,073.40 төгрөгийн илүү төлөлттэй, 26,788.25 төгрөгийн дутуу төлөлттэй байна.

Компанийн зүгээс дээр дурдсан дүн бүхий татварын үлдэгдлийг компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц "их хэмжээний өр" гэж үзэхээргүй байна.

№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх;

(Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан)

7.3.9. компанийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах асуудлыг хэлэлцэж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх;

7.3.10.компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний эрх, үүргийг тогтоох, чөлөөлөх;

7.3.11.компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэмжээг тогтоох, гэрээ байгуулах;

7.3.12.компанийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох, компанийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэр гаргах;

7.3.13.Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

7.3.14.Компаниас хуваарилах ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журам, хугацааг тодорхойлох;

7.3.15.Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;

7.3.16.Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах журам, заавар батлах;

7.3.17.Брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компанийг гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах;

7.3.18.Компанийн шинээр худалдаж авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгөтэй холбогдох асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

7.3.19.Компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах;

7.3.20.Хууль тогтоомжийн дагуу их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

7.3.21.Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороог байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны журмыг тогтоох, шаардлагатай тохиолдолд бусад асуудлаар дэд хороо байгуулах;

7.3.22.Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарахгүй бусад асуудлыг шийдвэрлэх;

7.4. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангасан этгээд байна.

7.5. Хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүрэгтэй:

7.5.1. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашгийг сөргөөр нөлөөлсөн эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэхэд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил илэрвэл уг асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг хүргүүлэх;

7.5.2. Компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

7.5.3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх;

7.5.4. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалт хийх талаар санал боловсруулах;

7.5.5. Гүйцэтгэх удирдлагын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулахад хяналт тавих.

7.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийн дийлэнх олонхи нь оролцсоноор хүчин

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

000481

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
МОНГОЛ УЛС
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЗХ
БҮРТГЭВ
№ 9111

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

төгөлдөр болно.

7.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхийн саналаар сонгоно.

7.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих үүргийг хүлээнэ. Хурлын тэмдэглэлд хуралд оролцсон гишүүд өөрсдийн хэлсэн үг, гаргасан саналын үнэн зөвийг хянан гарын үсэг зурна.

7.9. Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан тэмдэглэл, тогтоол нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдгийг дарснаар хүчин төгөлдөр болно.

7.10. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын, эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.

7.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлыг сард нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хуралдаан хийж болно.

7.12. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэр нь хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хүчин төгөлдөр болно.

7.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг зарлах, хуралдуулах, хурал хүчинтэй байх, гишүүдийн хуралд оролцох, асуудлыг хэлэлцэх, хурлын дэгийг тогтоох, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын эрх болон бусад холбогдох асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

7.14. Төлөөлөн удирдах зөвлөл шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Аудитын, Цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх хороог заавал байгуулан ажиллуулна.

7.15. Хороодын гишүүд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс бүрэлдэх ба түүний 2/3 нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.

7.16. Хороо нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан шийдвэр гаргуулах үүрэгтэй.

7.17. Аудитын хорооны дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:

7.17.1.компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

7.17.2.дотоод хяналтын албаны удирдлага, ажилтнуудыг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

7.17.3.аудитын байгууллагыг сонгох, тэдний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;

7.17.4.их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;

7.17.5.компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;

7.17.6.Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс шилжүүлсэн болон төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

7.18. Нэр дэвшүүлэх хороо нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.18.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

7.18.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүдийн хувьд шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

7.18.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;

7.18.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
МОНГОЛЫН
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР

000492

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12

үнэлэлт, дүгнэлт өгөх;

7.18.5.Гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;

7.18.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

7.18.7.Бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд аливаа хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байх эрхгүй этгээдийн нэрийг дэвшүүлэхээс татгалзах;

7.19. Цалин, урамшууллын хороо нь дараахь чиглэлээр дүгнэлт гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна:

7.19.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

7.19.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;

7.19.3.Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;

7.20. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор төлөөлөн удирдах зөвлөл томилно. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллах этгээд нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

7.21. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасны дагуу ажиллах бөгөөд шаардлагатай бол нэмэлт үүргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд тусгана.

7.22. Төлөөлөн удирдах зөвлөл нь жилд нэгээс доошгүй удаа Хувьцаа эзэмшигчдийн хуралд ажлаа тайлагнана.

НАЙМ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

8.1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

8.2. Гүйцэтгэх удирдлага нь хувь хүн байх бөгөөд компанийн гүйцэтгэх захирал байна.

8.3. Гүйцэтгэх захирлыг энэхүү дүрмийн 7.3.10-д заасны дагуу томилно. Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийн хугацааг Төлөөлөн удирдах зөвлөлөөс байгуулсан гэрээгээр тодорхойлно.

8.4. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна. Гэрээнд төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж түүний дарга гарын үсэг зурна.

8.5. Гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

8.6. Гүйцэтгэх захирал нь компанийн дэд захирал, газрын захирлууд, төлөвлөлт санхүү бүртгэлийн үйл ажиллагаа хариуцсан ажилтан /ерөнхий нягтлан бодогч/-ыг томилох, чөлөөлөх тухай асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөнө.

8.7. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна:

8.7.1. Менежментийн ур чадвартай, энэ чиглэлээр боловсрол, дадлага туршлага, Олон улсын байгууллагуудтай харилцаж байсан туршлага, удирдах ажлыг 2-оос доошгүй жил хийж байсан, удирдлагын зохих дадлага туршлагатай, удирдлагын ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг, дээд боловсролтой байх;

8.7.2. Зээл буюу батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;

8.7.3. Ял шийтгэлгүй байх;

ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020099 2071096
УЛААНБААТАР ХОТ
000483
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317619 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

СЭХ
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

8.7.4. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

8.8. Өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагааны талаар Гүйцэтгэх захиралд зөвлөх үүрэг бүхий Захирлын зөвлөл ажиллаж болно. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг Гүйцэтгэх захирал батална.

8.9. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдож үүссэн маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцоно.

8.10. Гүйцэтгэх захирал нь дараах үүргийг хүлээж, эрхийг эдэлнэ:

8.10.1.төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө Компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жилд хоёроос доошгүй удаа ажлын үр дүнг тайлагнан дүгнүүлэх;

8.10.2.компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцлийг цаг тухайд нь гаргаж, холбогдох этгээдүүдэд тайлагнаж мэдээлэх, түүний үнэн зөвийг хариуцах;

8.10.3.компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан батлуулах;

8.10.4.энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

8.10.5.гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

8.10.6.компанийн эрх ашгийг дээдлэн, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан компанийг удирдах;

8.10.7.гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлоор ашиглахгүй байх;

8.10.8.компанийн үйлдвэрлэл, технологи, бизнесийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэлийг тогтоож, түүнийг хамгаалах тогтолцоог бий болгох;

8.10.9.төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, өөрчлөх, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, шагнаж урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, ажлаас чөлөөлөх, хөдөлмөрийн дотоод журам заавар гарган мөрдүүлэх болон эрх хэмжээний бусад асуудлаар журам батлах;

8.10.10. компанийн шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулан, Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэх;

8.10.11. компанийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

8.10.12. мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;

8.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрлийн дагуу зарим эрх, үүргээ итгэмжлэлийн үндсэн дээр Компанийн холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

ЕС. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

9.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, дэд захирлууд, ерөнхий нягтлан бодогч, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

9.2. Компанийн дэд захирал нь гүйцэтгэх захирлаас олгосон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулна.

9.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанийн дүрэм, төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан журам, хөдөлмөрийн дотоод журам, гэрээнд заасан үүргээ биелүүлж, компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллана.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
InvesCore CAPITAL
6317839 ☎ 1119227158
УЛААНБААТАР ХОТ

000484

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

9.4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирлаас бусад эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээг тогтоох асуудлыг гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээ, компанийн хөдөлмөрийн дотоод журмаар тогтоох бөгөөд тэдгээрийн дагуу шийдвэрлэх боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

9.5. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84, 85 дугаар зүйлд зааснаар үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Сахилгын арга хэмжээ авагдсан явдал нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

9.6. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанитай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй тохиолдолд албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилээс доошгүй хугацаанд компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахыг хориглоно.

АРАВ. КОМПАНИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

10.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

10.1.1. өмчлөгчийн хяналт;

10.1.2. дотоод хяналт;

10.1.3. хөндлөнгийн хяналт;

10.2. Өмчлөгчийн хяналтыг төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо хэрэгжүүлнэ.

10.3. Аудитын хорооны дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна.

10.4. Компанийн аудитын хорооны ажиллах журмыг төлөөлөн удирдах зөвлөл, дотоод хяналтын журмыг төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр гүйцэтгэх захирал тус тус батална.

10.5. Аудитын хороо нь компанийн дүрэм, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, компанийн удирдлагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гарган үйл ажиллагаагаа хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

10.6. Аудитын хороо нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг хянан шалгахдаа энэхүү дүрэм болон холбогдох хуулиар олгогдсон эрхийг эдэлнэ.

10.7. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын ажилтан хэрэгжүүлнэ.

10.8. Дотоод хяналтын ажилтан нь компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэл, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг туршлагатай ажилтан байна.

10.9. Дотоод хяналтын ажилтан нь компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг тавьж, гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт нийцэж байгаа эсэхийг хангаж ажиллана.

10.10. Дотоод хяналтын ажилтан нь шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, дутагдлыг арилгах, компанийн хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн зөвлөмжийг гүйцэтгэх захиралд өгөх, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, мэдээлэх үүрэгтэй.

10.11. Компанийн хөндлөнгийн хяналтыг төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгосон мэргэшсэн аудитын байгууллагаар хийлгэнэ.

10.12. Хөндлөнгийн аудитын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дүгнэлт гаргана. Дүгнэлттэй гүйцэтгэх захирал танилцах эрхтэй.

АРВАН НЭГ. ИХ ХЭМЖЭЭНИЙБОЛОН СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

11.1. Их хэмжээний хэлцэл гэж тухайн хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсүл хоорондоо шууд

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

холбоотой хэд хэдэн хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 87, 88 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

11.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж эрх бүхий албан тушаалтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн компанитай хийж байгаа аливаа хэлцлийг хэлэх бөгөөд түүнийг Компанийн тухай хуулийн 89, 91, 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийнэ.

11.3. Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн энэхүү дүрмийн 11.1., 11.2.-т заасан хэлцлийн талаарх мэдээллийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

АРВАН ХОЁР. КОМПАНИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАЙЛАН

12.1. Компани нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна.

12.2. Компани нь хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргуулсны дараа холбогдох хууль тогтоомжид заасны дагуу жилийн санхүүгийн тайлан, ашиг ба алдагдлын тайлангаа компанийн хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудад танилцуулна.

12.3. Компанийн санхүүгийн жил тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

12.4. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг компанийн ерөнхий нягтлан бодох болон гүйцэтгэх захирал хариуцна.

АРВАН ГУРАВ. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

13.1. Компанийн санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана:

13.1.1. баланс;

13.1.2. үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;

13.1.3. мөнгөн гүйлгээний тайлан;

13.1.4. өмчийн өөрчлөлтийн тайлан;

13.1.5. хуримтлагдсан ашгийн тайлан;

13.1.6. тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүн, удирдлагад олгосон цалин шагнал, урамшуулал;

13.1.7. нэмэлт тайлбар, тодруулга;

13.1.8. санхүүгийн тайлангийн тодруулга;

13.1.9. хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл;

13.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлнэ.

АРВАН ДӨРӨВ. КОМПАНИЙН ХАРИУЦЛАГА

14.1. Компани нь зөвхөн өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.

14.2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын эдлэх эрх болон хөдөлмөрийн хууль зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.

14.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн эрх үүргийг хариуцахгүй, компани нь хувьцаа эзэмшигчдийн хүлээх үүргийг хариуцахгүй.

14.4. Компани нь өөрийн үндсэн үйл ажиллагааны чиглэлийн дагуу олон улсын байгууллагын гишүүн байж өөрийн байгууллагын эрх ашгийг хамтын үйл ажиллагаагаар илэрхийлж болно.

АРВАН ТАВ. КОМПАНИЙН БИЧИГ БАРИМТЫГ ХАДГАЛАХ

15.1 Компани нь дараах бичиг баримтыг хадгална:

15.1.1. Компанийн дүрэм, дүрэмд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулга, компанийг

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, компанийн бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, лиценз

15.1.2.хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлын баталсан компанийн дотоод бичиг баримт

15.1.3 компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм

15.1.4 нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт

15.1.5 хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдөх зөвлөл болон захирлуудын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, Компанийн гүйцэтгэх захирлын тушаал, байгуулсан гэрээ, хэлцэл, түүний биелэлттэй холбогдох баримт бичиг

15.1.6 Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, хөлсөөр ажиллах болон хөдөлмөрийн гэрээ

15.1.7 аудитын дүгнэлт

15.1.8 санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

15.1.9 Хувьцаа болон үнэт цаас гаргах журам

15.1.10 Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн бичиг баримт

15.1.11 Эрх бүхий албан тушаалтан болон нийт ажилчдад олгосон цалин, шагнал, урамшуулалтай холбоотой бичиг баримт

15.1.12 Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн нэрсийн жагсаалт болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны төрөл, тоо

15.1.13 Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хадгалахаар заасан бусад баримт бичгүүд

15.2 Компани нь баримт бичгийг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах газарт хадгална.

15.3 Бичиг баримт хадгалахтай холбоотой журмыг Гүйцэтгэх захирал батална.

15.4 Компани нь өөрийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлтийг байнга, бусад баримт бичгийг 5 жилийн хугацаатайгаар хадгалах бөгөөд хугацаа дууссаны дараа архивт шилжүүлнэ.

15.5. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, компанийн хувьцаа болон үнэт цаас гаргах, компанийн дүрэм, түүний нэмэлт, өөрчлөлттэй холбогдол бүхий баримт бичгийг хүлээн авах, хадгалах, танилцуулах, архивт шилжүүлэх ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дотоод үйл ажиллагааг биечлэн хариуцна.

15.6. Компанийн талаархи мэдээлэл, компанийн нэгдмэл сонирхолтой этгээд түүнтэй холбогдох мэдээлэл авах асуудлыг Компанийн тухай хуулийн 98, 99 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

АРВАН ЗУРГАА. КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАХ

16.1. Компанийг Иргэний хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгана.

16.2. Татан буулгах комисс томилогдсоноор Компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

АРВАН ДОЛОО. БУСАД

17.1 Энэ дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

17.2 Энэхүү дүрэм болон түүнд орсон нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэнээр хүчин төгөлдөр болох бөгөөд үндсэн эрхийг компани дээр хадгална.

17.3 Энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь энэ дүрмийн 17.2-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн уг дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

------o0o------

2022/12 08 ... он ... сар ... өдөр Бүртгэлийн № 1759

Нийслэлийн тойргийн нотариатч

Б.Гандорж би энэ хуулбарын

үнэн зөвийг гэрчлэв

Нотариатч ...

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЭХ
2022 оны 12 сар 15 өдөр
БҮРТГЭВ
№ 2115

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 08 өдөр 181 Улаанбаатар хот

Компанийн нэмж гаргах хувьцааг
олон нийтэд санал болгох талаар
чиглэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 38 дугаар зүйлийн 38.8, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 336 дугаар тогтоол, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.11.6, 6.11.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэмж хувьцаа гаргах замаар "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, олон нийтэд нээлттэй санал болгох асуудлаар хувьцаа эзэмшигчээс тусгайлан өгсөн удирдамжийн дагуу Улсын Их хурлын 2022 оны 16, Засгийн газрын 244 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, заавар, холбогдох үйл ажиллагааны төсвийн батлах эрхийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Сүх-Очир/-д олгосугай.

2. Энэхүү тушаалын 1 дэх хэсэгт заасан журам, заавар болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд андеррайтер, хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч, аудит, хөрөнгийн үнэлгээний компанийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулж, ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Сүх-Очир/-д зөвшөөрсүгэй.

3. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн үнэт цаасыг олон нийтэд санал болгохтой холбоотой бусад ажлыг зохион байгуулж, нарийвчилсан төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Сүх-Очир/, Гүйцэтгэх захирал /Х.Алтай/ нарт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ,

Б.ЖАВХЛАН

МХБ ХК-ийн архив
ХУУЛБАР ҮНЭН
Эрхлэгч: Г.Лхамжин
2022 оны 12 сар 08 өдөр

ХӨРӨНГИЙН
МОНГОЛЫН
БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
INVESCORE CAPITAL
6317839 - 1110211128
УЛААНБААТАР ХОТ

000488

Үнэт цаас гаргагч Андеррайтер

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ТӨХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 11 сарын 09 өдөр **№ 01** **Улаанбаатар хот**

Компанийн хувьцааг нэмж гаргах,
олон нийтэд санал болгох тухай

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2.2, 38 дугаар зүйлийн 38.8, 42 дугаар зүйлийн 42.4, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3 дахь хэсэг, “Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 336 дугаар тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Дүрмийн 3.4, 6.11.3, 6.11.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмж хувьцаа гаргах замаар нэмэгдүүлж, компанийн гаргасан нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 231,305,936 (хоёр зуун гучин нэгэн сая гурван зуун таван мянга есөн зуун гучин зургаан) ширхэг энгийн хувьцаан дээр нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 119,157,603 (нэг зуун арван есөн сая нэг зуун тавин долоон мянга зургаан зуун гурван) ширхэг энгийн хувьцааг нэмж гарган, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-аар дамжуулан олон нийтэд санал болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолоор нэмж гаргасан хувьцааг олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн тул одоогийн хувьцаа эзэмшигч нь нэмж гаргасан хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасны дагуу нэмж гаргаж буй 119,157,603 (нэг зуун арван есөн сая нэг зуун тавин долоон мянга зургаан зуун гурван) ширхэг энгийн хувьцаа нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн нийт гаргасан хувьцааны 34 хувьтай тэнцэх бөгөөд анхдагч зах зээлийн арилжаа амжилттай зохион байгуулагдсаны үр дүнд одоогийн хувьцаа эзэмшигч болон олон нийтийн эзэмших хувь дор дурдсанаар өөрчлөгдөхийг баталгаажуулсугай:

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцаа гаргахаас өмнө		Хувьцаа гаргасны дараа	
		Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо	Эзэмшлийн хувь	Хувьцааны тоо
1	Төр	100 хувь	231,305,936	66 хувь	231,305,936
2	Олон нийт	-	-	34 хувь	119,157,603

4. Энэ тогтоолын биелэлтийг хангаж, зохих мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, нэмж гаргаж буй хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д бүртгүүлэх, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулахтай холбоотой бусад шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл /С.Тулга/, Гүйцэтгэх захирал /Х.Алтай /нарт үүрэг болгосугай.

000489

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЗХ
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ

5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Толоолон удирдах зөвлөл /С.Тулга/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ,
САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ж.2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
МХБ ХК-ийн архив
InvesCore
Эрхлэгч: Т. Ллгсанжин
2022 он 12 сар 08 өдөр
6317839 ж.1119277129
УЛААНБААТАР ХОТ

000490

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 07 өдөр Дугаар 37 Улаанбаатар хот

Нийтэд санал болгох энгийн хувьцааны үнэ, нөхцөл тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 55 дугаар зүйлийн 55.1, 55.2, 55.6 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 7.3.8 дахь заалт, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 01 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хараат бус үнэлгээний байгууллага болох “Гэрэгэ эстимэйт” ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн бизнесийн үнэлгээний тайланд үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн олон нийтэд санал болгох 119,157,603 ширхэг энгийн хувьцааны нэг бүрийн үнийг тогтоосон үнийн аргаар 100 (нэг зуу) төгрөгөөр тогтоосугай.

2. Компанийн нийтэд санал болгон нэмж гаргах 119,157,603 ширхэг хувьцааг нийтэд санал болгон гаргах нөхцөл, татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалтыг энэ тогтоолын хавсралтаар баталсугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж, Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хувьцаагаа бүртгүүлэн арилжаалах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахтай холбоотой бусад шаардлагатай арга хэмжээг түргэн шуурхай зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хорооны дарга /А.Анар/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА С.ТУЛГА

Монголын Хөрөнгийн Биржийн УХА 0163 ТУЗ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ... 1071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
000491
6317839 ... 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч Андеррайтер

СЗХ
БҮРТГЭВ
№91

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-12-12
БҮРТГЭВ-02

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 11 сарын 07-ны өдрийн
11 дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХ НӨХЦӨЛ, ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

№	Үзүүлэлт	Нөхцөл
1.	Үнэт цаас нэмж гаргах нөхцөл	
	Үнэт цаас гаргагч	"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК
	Үнэт цаасны төрөл	Энгийн хувьцаа
	Үнэт цаасны үсгэн код	MSE
	Нэмж гаргах энгийн хувьцааны тоо	119,157,603 (нэг зуун арван есөн сая нэг зуун тавин долоон мянга зургаан зуун гурав) ширхэг
	Энгийн хувьцааны нэрлэсэн үнэ	100 (нэг зуу) төгрөг
	Нэмж гаргаж буй буюу олон нийтийн эзэмших хувь	34%
	Нэмж гаргасны дараах нийт хувьцааны тоо	350,463,539 (гурван зуун тавин сая дөрвөн зуун жаран гурван мянга таван зуун гучин ес) ширхэг
	Нэгж хувьцааг олон нийтэд санал болгох үнэ	100 (нэг зуу) төгрөг
	Арилжаа эрхлэх байгууллага	Монголын хөрөнгийн бирж
2.	Үнэт цаас нийтэд санал болгох нөхцөл	
	Анхдагч зах зээлийн арилжааны арга	Тогтоосон үнийн арга
	Хөрөнгө оруулах доод хэмжээ	Байхгүй
	Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн	11,915,760,300 (арван нэгэн тэрбум есөн зуун арван таван сая долоон зуун жаран мянга гурван зуу) төгрөг
	Стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох хувь, хэмжээ	Нэмж гаргах хувьцааны 90 хүртэлх хувь буюу 107,241,842 ширхэг хүртэлх энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад санал болгох; Нэг стратегийн хөрөнгө оруулагчид нийт эзэмшлийн 5 хүртэл хувь буюу хамгийн ихдээ 17,523,176 ширхэг энгийн хувьцааг санал болгох; Стратегийн хөрөнгө оруулагчид хоёрдогч зах зээл нээгдсэнээс хойш Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаа буюу 6 сараас багагүй хугацаанд хувьцаагаа арилжаанд оруулахгүй байх.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

INVESCORE CAPITAL ИНВЕСКОР КАПИТАЛ ХХК
InvesCore CAPITAL
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

	Үнэт цаасыг амжилттай татан төвлөрүүлсэн гэж үзэх хувь (анхдагч зах зээлийг арилжаа хаагдсан өдөр)	100%
3. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт		
	Техник, технологийн шинэчлэл.Үүнд:	
	- Арилжааны системийн сайжруулалт	63.7%
	- Мэдээлэл технологийн аюулгүй байдал	10.7%
	- Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	6.1%
	- Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	19.5%

---------oOo---------

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 рд. 2071003
УЛААНБААТАР ХОТ

000493

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
CAPITAL
УБ ХОТ

Үнэт цаас гаргагч _____

Андеррайтер _____

СЭХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 02 өдөр Дугаар 35 Улаанбаатар хот

Зарим баримт бичгийн төслийг
агуулгын хувьд сайшаах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 7.3.15 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын 7.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компани нь нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгохтой холбогдуулан анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсны дараа зарлан хуралдуулах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр дор дурдсан дүрэм, журмын төслийг агуулгын хувьд сайшаасугай:
   1.1. "Монголын хөрөнгийн бирж" нээлттэй хувьцаат компанийн дүрмийн төслийг нэгдүгээр хавсралтаар.

2. Энэхүү тогтоолын 1-д дурдсан хувьцаа эзэмшигчдийн хурлын дараа зохион байгуулах Төлөөлөн удирдах зөвлөлийн анхны хурлаар хэлэлцүүлэхээр дор дурдсан компанийн засаглалын журмын төслийг агуулгын хувьд сайшаасугай:
   2.1. "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын төслийг хоёрдугаар хавсралтаар;
   2.2. "Залгамж халааны бодлого"-ын төслийг гуравдугаар хавсралтаар;
   2.3. "Мэдээллийн үйл ажиллагааны журам"-ын төслийг дөрөвдүгээр хавсралтаар;
   2.4. "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын төслийг тавдугаар хавсралтаар;
   2.5. "Сонирхлын зөрчлийг зохицуулах журам"-ын төслийг зургадугаар хавсралтаар;
   2.6. "Шүгэл үлээх журам"-ын төслийг долдугаар хавсралтаар.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо /А.Анар/, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Мөнхзул/-д тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА С.ТУЛГА

Монголын Хөрөнгийн Бирж
УХА-0163
ТУ

"ИНВЕСТОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч 22 12 08 Андеррайтер

000494

СЗХ
сар 13 өдөр
БҮРТГЭВ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 11 сарын 22-ны өдрийн 03 дугаар
тогтоолын хавсралт

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ"
НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ
/төсөл/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Дүрмийн зорилго, компанийн эрх зүйн байдал

1.1. Энэхүү дүрмийн зорилт нь "Монголын хөрөнгийн бирж" нээлттэй хувьцаат компанийн /цаашид "Компани" гэх/ эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, хяналтын бүтэц, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлоход оршино.

1.2. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэл гаргадаг, банканд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээдэг, тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө хуулийн этгээд мөн. Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байж болох бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/ баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлнэ.

1.3. Компани нь өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, оноосон нэр бүхий тэмдэгтэй байна.

1.4. Компани нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

1.5. Компани үйл ажиллагаандаа нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, компанийн засаглалын шилдэг жишгийг удирдлага болгоно.

1.6. Энэхүү дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид үндэслэн боловсруулсан бөгөөд хожим хууль, тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт нь дүрмийн хэсэг, зүйл, заалттай зөрчилдөх тохиолдолд хуулийн зохицуулалтыг мөрдөх ба шаардлагатай тохиолдолд дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

1.7. Компанийн дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

1.8. Компани нь төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани бөгөөд төрийн өмчийн төлөөлөл буюу хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь Засгийн газраас эрх олгосны дагуу Сангийн яам байна1.

1.9. Компани Монгол Улс болон гадаадад өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй болно.

Оноосон нэр, хаяг

1.10. Компанийн оноосон нэрийг Монгол хэлээр "Монголын хөрөнгийн бирж" ХК, Англи хэлээр "Mongolian Stock Exchane" JSC , товчоор "MSE" JSC гэнэ. Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрийнхээ дараа "ХК" гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

1.11. Компанийн төв байрны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Сүхбаатарын талбай 3 болно.

Утас, Факс: 11-310506

MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ УЦК" ХХК
InvesCore CAPITAL

[1] Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 152 дугаар тогтоол

000495

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
БҮРТГЭВ
№ 91

Цахим шуудан: info@mse.mn
Цахим хаяг: www.mse.mn

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

ХОЁРДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА

2.1. Компанийн эрхэм зорилго нь үндэсний үйлдвэрлэл үйлчилгээг сэргээн хөгжүүлэх, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, дэмжин урамшуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж, үнэт цаасны зах зээлийг сонгодог утгаар нь төлөвшүүлэн хөгжүүлэхэд оршино.

2.2. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаа байна.

2.3. Монголын хөрөнгийн бирж бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан зохицуулалттай этгээд болох арилжаа эрхлэх болон өөрийгөө зохицуулах байгууллагын хувьд хуульд заасан дүрэм, журмуудыг баталж мөрдүүлэх, арилжаа зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.4. Компани нь тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулах тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч улсын бүртгэлд бүртгүүлсний үндсэн дээр тухайн үйл ажиллагааг эрхэлнэ.

2.5. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Хувь нийлүүлсэн хөрөнгө

3.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь компанийн нийт гаргасан бөгөөд эргэлтэд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөнд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.

3.2. Компани нь нэг бүр нь 100 (нэг зуу) төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 350,463,539 (гурван зуун тавин сая дөрвөн зуун жаран гурван мянга таван зуун гучин ес) ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 35,046,353,900 (гучин таван тэрбум дөчин зургаан сая гурван зуун тавин гурван мянга есөн зуу) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

3.3. Компанийн хувьцаа эзэмшигчид нь дараах байдлаар компанийн хувьцааг эзэмшинэ:

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны			Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн
		Нэрлэсэн үнэ	Тоо ширхэг	Эзэмшлийн хувь	
1	Төр	100 төг	231,305,936	66 хувь	23,130,593,600
2	Олон нийт	100 төг	119,157,603	34 хувь	11,915,760,300
	Нийт	100 төг	350,463,539	100 хувь	35, 046,353,900

3.4. Компанийн энгийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байна. Хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох ба аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

Өөрийн хөрөнгө

3.5. Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсгийг компанийн өөрийн хөрөнгө гэнэ.

БИРЖ ТӨХК
71096
InvesCore
6317839 ...
ХХБ ХК-ийн архив
ХУУЛБАР ҮНЭН

Үнэт цаас гаргагч ... Р ХОТ

000496

Андеррайтер

3.6.Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг нөхцөл байдал бүртгэгдсэн албан ёсны санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын 10 өдрийн дотор төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй.

Компанийн хувьцаа эзэмшигч

3.7.Хуулиар хориглоогүй бол хувьцаа эзэмшигчид нь хувь хүн, хуулийн этгээд байна.

3.8.Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг үнэт цаасны хадгаламж, бүртгэлийн эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлнэ.

Компанийн болон хувьцаа эзэмшигчдийн хариуцлага

3.9.Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд компани нь эдгээр бүх хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

3.10.Компани нь Хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй.

3.11.Компанийн хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр эрсдэл, хариуцлага хүлээнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний зарлан хуралдуулах

4.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

4.2.Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит ба ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.

4.3.Дараах тохиолдолд ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

4.3.1. ТУЗ-ийн нийт гишүүний 50-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;

4.3.2. ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцааг дангаар эзэмшигч санал, шаардлага гаргасан;

4.3.3. компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн;

4.3.4. аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;

4.3.5. ТУЗ шаардлагатай гэж үзэж шийдвэр гаргасан;

4.3.6. Компанийн тухай хууль болон дүрэмд заасан бусад тохиолдол.

4.4.Хурал хуралдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг заана:

4.4.1. хурал хуралдуулах газар, өдөр, цаг;

4.4.2. хурлын хэлэлцэх асуудал;

4.4.3. хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

4.4.4. хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журам;

4.4.5. хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
ЛАА ИЗААТАР ХОТ
"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore
ХХБХК-ийн архив
БҮРТГЭВ ҮНЭН
Эрхлэгч:
Андеррайтер

СЭХ
он 2022 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 92

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

баримт бичгийн жагсаалт;

4.4.6. саналын хуудсаар санал авах бол тухайн саналын хуудасны агуулга;

4.4.7. саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр;

4.4.8. хурлын дарга;

4.4.9. тооллогын комиссын дарга, гишүүд.

4.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.

4.6. Компани хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.

4.7. Хурлын зард дараах зүйлийг тусгана:

4.7.1. компанийн оноосон нэр, байршил;

4.7.2. хурал хийх өдөр, цаг, газар;

4.7.3. бүртгэлийн өдөр;

4.7.4. хурлаар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх

4.8. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх бүрэн эрхтэй. Үүнд:

4.8.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

4.8.2. нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

4.8.3. компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

4.8.4. компанийн хэлбэрийг өөрчлөх;

4.8.5. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

4.8.6. хувьцааг хуваах буюу нэгтгэх;

4.8.7. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

4.8.8. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;

4.8.9. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлд заасны дагуу гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

4.8.10. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван нэгдүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;

4.8.11. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

4.8.12. хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;

4.8.13. компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

4.8.14. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

4.8.15. Хувьцаагаа үнэт цаасны хадгаламжийн байгууллагын бүртгэлээс хасуулах асуудал;

MONGOLIAN STOCK EXCHANGE
УЛААНБААТАР ХОТ
InvesCore CAPITAL ХУУЛБАР ҮНЭН

000498

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЗХ
БҮРТГЭВ
№91

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

4.8.16. хууль тогтоомжид заасан бусад.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох

4.9. Дараах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхиор батална. Үүнд:

4.9.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах;

4.9.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

4.9.3. Компанийн хэлбэрийг өөрчлөх;

4.9.4. Компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;

4.9.5. Давуу эрхийн хувьцаа гаргах;

4.9.6. Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

4.9.7. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;

4.9.8. Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх;

4.9.9. Хууль болон энэхүү дүрэмд заасан бусад асуудал.

4.10. Энэхүү дүрмийн 3.15-д заасан болон ТУЗ-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр нь хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхи дэмжсэнээр хүчин төгөлдөр болно.

4.11. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмыг баримтална.

4.12. Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгнө. Энэ тухай зааврыг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны журмыг баримтлан тухайн хурлын санал авах хуудсанд тусгана.

4.13. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тоолохдоо тус бүрд нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно.

Хуралд оролцох журам

4.14. Хувьцаа эзэмшигч нь иргэний үнэмлэхтэйгээ ирж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас бүртгэлийн өдрөөр тодорхойлсон хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлтэй тулган бүртгүүлж хуралдаа оролцоно. Хэрэв хуралд биеэр оролцох боломжгүй бол өөрийгөө төлөөлүүлж хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох этгээдэд нотариатаар гэрчлүүлсэн итгэмжлэлийн үндсэн дээр оролцуулж болно.

4.15. Төлөөлөх тухай итгэмжлэл нь тодорхой хугацаа заагаагүй бол гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл хойшлогдсон хуралд хүчинтэй хэвээр байна.

4.16. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл хүлээн авч бүртгэнэ. Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг энэхүү дүрэмд зааснаар тогтоосон бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тодорхойлж, тооллогын комисс эсхүл түүний үүргийг гүйцэтгэхээр ТУЗ-өөс тусгайлан томилсон этгээд гүйцэтгэнэ.

4.17. Хувьцаа эзэмшигчид нь хэлэлцэж буй асуудлын талаар саналаа санал авах хуудсаар ирүүлсэн тохиолдолд түүнийг тухайн хуралд оролцсонд тооцно. Хурлын ирцийг хэлэлцэх асуудал бүрээр гаргах ба тухайн хэлэлцэх асуудалд санал

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ⁂ 2071096
УЛААНБААТАР ХОТ

000499

InvesCore CAPITAL ХХК

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг тухайн асуудал хэлэлцэхэд оролцсонд тооцно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох

4.18. Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.

4.19. Хурлын ирц хүрээгүй тохиолдолд хурлыг хойшлуулах бөгөөд харин хэлэлцэх асуудал хэвээр байна. Хойшлогдсон хурлыг ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын долоогоос доошгүй өдрийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.

4.20. Саналын эрхийн 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно.

4.21. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах; нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах; компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох; компанийн хэлбэрийг өөрчлөх; компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох; хувьцааг хуваах буюу нэгтгэх тухай асуудлыг хэлэлцэх хойшлогдсон хурал нь саналын эрхийн гуравны нэгээс доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно.

Бүртгэлийн өдөр

4.22. Компанийн бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.

Санал авах хуудас, түүнийг хүчинтэйд тооцох

4.23. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлаар саналыг санал авах хуудсаар авч болно. Энэ тухай ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэрт заана.

4.24. Санал авах хуудасны агуулгыг ТУЗ хурал хуралдуулах тухай шийдвэртээ тогтооно. Санал авах хуудсанд Компанийн оноосон нэр, хурал хийх газар, өдөр, цаг, хувьцаа эзэмшигчдийн нэр, эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо хэмжээ, санал хураалтаар шийдвэрлэх асуудлын нэр, хурлаас хэлэлцэх асуудал бүрээр гарах шийдвэрийн төсөл зэргийг тусгана.

4.25. Санал авах хуудсанд (ТУЗ-ийн гишүүнийг сонгохоос бусад тохиолдолд) санал өгөх хувилбарын зөвхөн нэгийг тэмдэглэсэн тохиолдолд хүчинтэй байна. Санал авах хуудсыг хурал зарласан өдрөөс эхлэн тухайн асуудлыг хэлэлцэж дуусах хүртэлх хугацаанд авна.

Цахим хэлбэрээр санал авах

4.26. Компани цахимаар санал авах цахим программыг хөгжүүлж, ашиглах талаар зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж, санал хураалтыг цахим хэлбэрээр явуулж болно. Энэ тохиолдолд хуралд оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, ирцийн мэдээ болон авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр, үнэн зөв илэрхийлэх боломжтой программыг бүтээх үүргийг мэдээллийн технологийн компани хүлээнэ. Түүнчлэн мэдээллийн технологийн компани нь энэхүү үүргээ баталгаажуулсан албан бичгийг компанид хүлээлгэж өгнө.

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЭХ
БҮРТГЭВ
№2.0
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

Хурлын зардал, хурлын тэмдэглэл

4.27. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдох зардлыг компани бүрэн хариуцна.

4.28. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэр гарах бөгөөд хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын тэмдэглэлийг албажуулж, хурлын дарга гарын үсэг зурах бөгөөд хурлын дарга тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.

4.29. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлд тусгах мэдээлэл, санал хураалтын дүнг зарлах болон тэмдэглэлтэй холбоотой бусад харилцааг Компанийн тухай хуульд зааснаар зохицуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ

5.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна.

5.2. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, чиг үүрэг, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хуульд нийцүүлэн "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.

5.3. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 нь хараат бус гишүүн байна.

5.4. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил байна. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг хэдэн ч удаа улируулан сонгож болно.

5.5. ТУЗ-ийн гишүүнд урамшуулал олгож болох бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно. Урамшуулалтай холбоотой бусад харилцааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

5.6. Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэлийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

ТУЗ-ийн бүрэн эрх

5.7. ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.7.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, компанийн бизнес төлөвлөгөө батлах;

5.7.2. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

5.7.3. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

5.7.4. компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;

5.7.5. компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;

5.7.6. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
ҮЛААНБААТАР ХОТ
InvesCore CAPITAL

000501

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

5.7.7. өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
5.7.8. компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
5.7.9. компанийн гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
5.7.10. аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
5.7.11. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
5.7.12. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах;
5.7.13. компанийн салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
5.7.14. компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
5.7.15. хуульд заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
5.7.16. сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
5.7.17. ногдол ашгийн хэмжээг тогтоож, төлөх журмыг батлах;
5.7.18. байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг батлах;
5.7.19. компанийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;
5.7.20. эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
5.7.21. Арилжаа эрхлэх байгууллагын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан журмуудыг баталж, нийтэд мэдээлэх;
5.7.22. Өөрийгөө зохицуулах байгууллагын Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан дүрэм, журмуудыг баталж мөрдүүлэх;
5.7.23. Дүрмийн 5.7.22-т заасан дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээг тогтоох;
5.7.24. Хууль болон компанийн дүрэмд заасан, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.

5.8. ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх удирдлагад хариуцуулан гүйцэтгүүлж болно.

ТУЗ-ийн хурал

5.9. ТУЗ-ийн хурлыг улиралд нэг удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, компанийн Гүйцэтгэх захирлын санаачилгаар эсвэл ТУЗ-ийн дэргэдэх хорооны саналаар ээлжит бус хурал хуралдуулж болно.

5.10. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд бүр саналын нэг эрхтэй байна.

5.11. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болж, хуульд өөрөөр заагаагүй бол хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

5.12. Төлөөлөн удирдах зөвлөл эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

5.13. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын дарга гарын үсэг зурна.

5.14. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:

Үнэт цаас гаргагч

Андеррайтер

5.14.1. тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, бүтэц, зохион байгуулалт, түүний өөрчлөлт;

5.14.2. тайлангийн хугацаанд компанийн эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал удирдлагын зардлын хэмжээ;

5.14.3. хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

ТУЗ-ийн хурлын тэмдэглэл

5.15. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:

5.15.1. хурал хуралдсан газар, өдөр, цаг;

5.15.2. хуралд оролцсон гишүүд;

5.15.3. хурлаар хэлэлцсэн асуудал;

5.15.4. санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн;

5.15.5. гаргасан шийдвэр.

5.16. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлын дарга хариуцна.

5.17. Төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай бичгээр тайлбар гаргана.

5.18. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь тухайн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

ТУЗ-ийн дарга

5.19. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос тэдгээрийн олонхийн саналаар сонгоно.

5.20. Компанийн ТУЗ-ийн дарга нь бусад гишүүдтэй адил эрх эдлэхээс гадна ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих чиг үүргийг гүйцэтгэнэ.

5.21. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн томилсон аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэн сонгох

5.22. Компанийн залгамж халааны бодлогын баримт бичгийг Төлөөлөн удирдах зөвлөл батална.

5.23. Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо нь Компанийн залгамж холбооны бодлогын дагуу ТУЗ-ийн гишүүнд Компанийн тухай хууль болон ТУЗ-ийн зохих журамд заасан шалгуурыг хангасан хүнийг сонгон шалгаруулж нэр дэвшүүлэн ХЭХ-хэлэлцүүлнэ.

ТУЗ-ийн хараат бус гишүүн

5.24. ТУЗ нь хараат бус гишүүнтэй байж болно. ТУЗ-ийн хараат бус гишүүнд дараах шалгуурыг хангасан хүний нэрийг ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо дэвшүүлнэ:

5.24.1. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй;

5.24.2. өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, эсхүл сүүлийн 3 жилийн хугацаанд ажил, албан тушаал эрхэлж байгаагүй;

000503

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

СЭХ
он сар
БҮРТГЭВ
№ 01

5.24.3. төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хащдаггүй;
5.24.4. компанитай бизнесийн аливаа холбоогүй;
5.24.5. хууль тогтоомжид заасан бусад шаардлага.

5.25. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь бусад гишүүдийн адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах нэмэлт үүргийг хүлээнэ:

5.25.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь тухайн компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэх, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж буй эсэхэд хяналт тавих, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдэд тавьж шийдвэрлүүлэх, шаардлагыг эс биелүүлбэл ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шаардлага хүргүүлэх;

5.25.2. компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

5.25.3. хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн зарим шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлэх эрхтэй;

5.25.4. компанийн нөхцөл байдал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултад хариу өгөх, тодруулга хийх;

5.25.5. Компанийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг үр ашигтай зохион байгуулж байгаа эсэхэд хяналт тавих;

5.25.6. Компанийн тухай хуульд заасан бусад эрх, үүрэг.

5.26. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд дараах асуудлыг хэлэлцэхэд заавал оролцож саналаа өгнө. Үүнд:

5.26.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

5.26.2. Санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;

5.26.3. Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

5.27. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.

5.28. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал ба ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх зэрэг ТУЗ-ийн журмаар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.29. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах бөгөөд хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулна.

5.30. Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавина.

5.31. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулна.

5.32. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүний үүргийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.

БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
МХБ ХК-ийн архив
InvesCore
ҮНЭН
Эрхлэгч:
2022 он 12 сар 08 өдөр
6317830 ☎ 1119277128

000504

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

5.33. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааг хариуцан зохицуулна.

ТУЗ-ийн дэргэдэх хороо

5.34. ТУЗ нь дэргэдээ нь (а)Аудитын хороо; (б)Эрсдэл /комплайнс/-ийн удирдлагын хороо; в)Нэр дэвшүүлэх; г) Цалин урамшууллын хороо гэсэн байнгын хороодтой байна.

5.35. Аудитын, Эрсдэл /комплайнс/-ийн удирдлагын, Нэр дэвшүүлэх, Цалин, урамшууллын хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

5.36. Компанийн ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо байгуулан ажилуулж болно.

5.37. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

5.37.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

5.37.2. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;

5.37.3. аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;

5.37.4. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;

5.37.5. компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

5.38. Эрсдэл /комплайнс/-ийн удирдлагын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

5.38.1. компанийн эрсдэлийн удирдлагын бодлого, зохицуулалтын орчныг тодорхойлох;

5.38.2. компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг оновчтой удирдан чиглүүлэх;

5.38.3. компанийн үйл ажиллагааны гүйцэтгэл, эрсдэлийн түвшинд хяналт тавих.

5.39. Нэр дэвшүүлэх хороо нь дараах чиглэлээр, дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулна:

5.39.1. Компанийн залгамж холбооны бодлогыг боловсруулах, үйл ажиллагаандаа чанд мөрдөж, хэрэгжүүлэх;

5.39.2. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

5.39.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд энэ дүрэм болох Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

5.39.4. Компанийн залгамж холбооны бодлогын дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлагад нэр дэвших боломжтой этгээдийн судалгаа хийх, нөөцөд бүртгэх, бэлтгэх, шаардлагатай бол сонгон шалгаруулалт хийх, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;

СЭХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ
БИРЖ ТӨХК
МХБ ХК-ийн архив
Эрхлэгч:
22 он 12 сар 08 өдөр
000505
6317839 1119277128
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____

Андеррайтер _____

5.39.5. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

5.39.6. гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;

5.39.7. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

5.39.8. Компанийн тухай хуулийн 59.5-д заасан үндэслэлээр ТУЗ-ийн бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш гурван жилийн хугацаанд тухайн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дэвшүүлэхээс татгалзах.

5.40. Цалин урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

5.40.1. компанийн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

5.40.2. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;

5.40.3. компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

5.41. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

Гүйцэтгэх захирал

6.1. Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа ТУЗ-д тайлагнана.

6.2. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлэх бөгөөд уг этгээд компанийн Гүйцэтгэх захирал байна.

6.3. Гүйцэтгэх захирал нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шалгуурыг хангаж холбогдох баримт бичгийг бүрдүүлэхээс гадна дараах шалгуурыг хангасан байна:

6.3.1. Банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, санхүүгийн салбарт таваас доошгүй жил эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай;

6.3.2. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

6.3.3. Төрийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

6.3.4. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх;

6.3.5. Хууль тогтоомж, гэрээнд заасан бусад шаардлага.

6.4. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь ТУЗ-ийн гишүүн байж болох бөгөөд ТУЗ-ийн дарга байхыг хориглоно.

Үнэт цаас гаргагч _____ 000506 Андеррайтер _____

6.5. Гүйцэтгэх удирдлага нь төрийн болон хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд, төрийн бус байгууллага болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

6.6. Гүйцэтгэх захирал нь ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, чөлөө авах, өвдөх тохиолдолд өөрийн эрх, үүргийг бүхэлд нь Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу эрх бүхий этгээдэд зөвхөн ТУЗ-ийн зөвшөөрлөөр шилжүүлнэ. Түүнчлэн, Гүйцэтгэх захирал тодорхой бүрэн эрхээ компанийн холбогдох албан тушаалтан, ажилтанд итгэмжлэн хариуцуулж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

6.7. Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ-тэй байгуулсан онцгой нөхцөл бүхий гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

6.8. Гэрээнд Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагын хэмжээ, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин, шагнал, урамшуулал, хугацаа, гэрээ дүгнэх шалгуур зэрэг асуудлыг тусгасан байна.

6.9. Гүйцэтгэх захирал нь дор дурдсан эрх эдэлнэ:

6.9.1. Хөдөлмөрийн тухай хуульд заасан ажил олгогчийн эрхийг хэрэгжүүлэх;

6.9.2. ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах;

6.9.3. Эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж биелэлтийг нь хангуулах эрхтэй.

6.9.4. Компанийн хөрөнгө захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах;

6.9.5. Компанид учруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, эрүү, захиргаа, иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;

6.9.6. ТУЗ-өөс батлагдсан зардлын хэмжээнд багтаан ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;

6.9.7. Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд авах, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох;

6.9.8. Хууль тогтоомж, гэрээнд заасан бусад.

6.10. Гүйцэтгэх захирал нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

6.10.1. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, зохицуулагч байгууллагын шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

6.10.2. Компанийн стратегийн төлөвлөгөө болон эрсдэлийн удирдлага, зохистой засаглалын талаарх дотоод дүрэм, журам, заавар боловсруулж ТУЗ-д танилцуулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулж хангах;

6.10.3. Компанийн үндсэн үйл ажиллагаа болон эрсдэлийн талаарх бүхий л заавар журам болон стандартыг ажилтнуудаар мөрдүүлэн хэвшүүлэх, энэ талаар зохих гарын авлага болон зөвлөмжөөр хангах;

6.10.4. Компанийн дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн жигд ажиллагааг ханган ажиллах, үр дүнг тогтмол үнэлэх;

6.10.5. Дотоод хяналтын тогтолцоонд гажуудал үүссэн, эрсдэлийн удирдлагыг хангах талаар тогтоосон үйл ажиллагааны хязгаарлалт

000507

Үнэт цаас гаргагч _____

Андеррайтер _____

СЭХ
2022 12 15 өдөр
БҮРТГЭВ
№ 01
2022.12.15

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-03

зөрчигдсөн бол холбогдох мэдээллийг цаг тухайд нь авч, зохих арга хэмжээг авах;

6.10.6. Компанийн үйл ажиллагааны онцлог болон хүлээж болох эрсдэлийн нэр төрөлтэй уялдаатай удирдлагын мэдээллийн тогтолцоог бий болгох;

6.10.7. Байгууллагын нууцад хамаарах зүйлийн жагсаалтыг батлах;

6.10.8. Компанийн санхүүгийн тайлан, тэнцэл, бусад төрлийн мэдээний үнэн зөвийг хариуцах;

6.10.9. Компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;

6.10.10. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;

6.10.11. Компанийн ажилтнуудын хувьд өөрт ногдсон үүргээ аливаа ашиг сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх;

6.10.12. Үүргээ гүйцэтгэх явцад олж авсан компани, үнэт цаасны зах зээлд оролцогчийн байгууллагын болон хувь хүний нууцад хамаарах мэдээллийг өөрийн, эсхүл гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;

6.10.13. Хувийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх;

6.10.14. Өөрт нь болон өөрийн нэгдмэл сонирхол бүхий этгээдэд компанитай бизнесийн харилцаанд орсон этгээдийн санхүүгийн үр дүнг сонирхох шалтгаан байгаа бол сонирхлын зөрчил байна гэж үзэж, энэ тухайгаа төлөөлөн удирдах зөвлөл, түүний нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх;

6.10.15. Хууль тогтоомж болон гэрээнд заасан бусад.

6.11. Гүйцэтгэх захирал нь үйл ажиллагааны стратеги, бизнес төлөвлөгөөнд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах талаар хүлээсэн үүргээ санаатай тасалдуулсан, энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, тэдгээрийг ноцтой зөрчсөн тохиолдолд ТУЗ түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг шийдвэрлэж тогтоол гаргана. Гүйцэтгэх захирал нь ажлаас чөлөөлөгдөхдөө хүндэтгэн үзэхээс бусад тохиолдолд үүрэгт ажлаа өөрийн биеэр биечлэн хүлээлгэн өгнө.

6.12. Гүйцэтгэх захиралд компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнд хүлээлгэх хариуцлагын талаар энэхүү дүрэмд заасан зохицуулалт нэгэн адил хамаарах бөгөөд ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан бол гэрээ дуусгавар болсонтой холбоотой үл өрсөлдөх, ажилтан урвуулахгүй байх үүрэг хүлээнэ.

Компанийн эрх бүхий албан тушаалтан, хүлээх хариуцлага

6.13. Компанийн эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн болон тэдгээртэй адилтгах албан тушаалтан хамаарна.

6.14. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:

6.14.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;

6.14.2. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг компанид гаргаж өгнө;

6.14.3. Компанийн нууцад хамаарах мэдээ, тайлан, гэрээ, баримт бичиг, материалыг бусдад дамжуулах, задруулахаас сэргийлэх бөгөөд хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;

ХИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
ҮЛААНБААТАР ХОТ

МХБ ХК-ийн архив
InvesCore CAPITAL
Эрхлэгч:
2022 12 08
6317839 ± 1110377128
УЛААНБААТАР ХОТ

000508

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

6.14.4. Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх баримт бичиг, мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;

6.14.5. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;

6.14.6. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх.

6.15. Эрх бүхий албан тушаалд нэр дэвших үедээ өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

6.16. Эрх бүхий албан тушаалтан нь Дүрмийн 6.12-т заасан үүргээ биелүүлээгүйн улмаас компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

6.17. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг Компанийн тухай хууль, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан онцгой нөхцөл бүхий болон хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.18. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь компанитай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилээс доошгүй хугацаанд компанийн нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, хувийн сонирхлын зорилгоор ашиглахыг хориглоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ. ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Дотоод хяналт

7.1. Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн Аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

7.2. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг ТУЗ-ын дэргэдэх аудитын хорооноос санал болгосноор гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.

7.3. Дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнууддын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд Гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

7.4. Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хуралдаанаар дотоод хяналтын албаны мэдээлэл, шалгалтын дүнг улирал бүр хэлэлцэн, холбогдох арга хэмжээ авч байна.

7.5. Дотоод хяналтын ажилтан албан хаагчдын ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.

Хөндлөнгийн аудит

7.6. Аудитын тухай хуульд заасны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг ТУЗ сонгож, түүнтэй заавал гэрээ байгуулж ажиллуулна.

7.7. ТУЗ –ийн Аудитын хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална.

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

7.8. Дараах этгээдийг компанийн хөндлөнгийн Аудитоор сонгон ажиллуулахыг хориглоно:

7.8.1. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн эрх бүхий албан тушаалтан;

7.8.2. Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсвэл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг;

7.8.3. ТУЗ-өөс тухайн этгээд нь дотоод аудитороор ажиллахад харшилна гэж үзсэн үндэслэл бүхий бусад нөхцөл.

7.9. Аудитын байгууллагатай байгуулах гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заасан байна.

7.10. Аудитын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

7.11. Компанийн санхүүгийн жилийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.

7.12. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, эсвэл нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийж болно.

7.13. Шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан компани болон хувь эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд төлөх ба бусад тохиолдолд компани өөрөө буюу шаардлага тавьсан талууд хариуцна.

Их хэмжээний хэлцэл

7.14. Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно. Үүнд:

7.14.1. хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/;

7.14.2. Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсвэл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

7.15. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн саналын эрхтэй гишүүд санал нэгтэйгээр гаргана.

7.16. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

7.17. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.

7.18. Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо ТУЗ нь Аудитын зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг инфляцийн /мөнгөний ханшны уналт/ түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

Сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийх хэлцэл

7.19. Нэгдмэл сонирхолтой этгээд, түүнтэй хийх хэлцлийг тодорхойлох Компанийн үйл ажиллагаан дахь сонирхлын зөрчил, түүнээс урьдчилан

СЭХ 2022 12 15 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2022 12 12
MONGOLIAN STOCK EXCHANGE 9020020699 2071096 УЛААНБААТАР ХОТ
000510
InvesCore ХУУЛБАР ҮНЭН CAPITAL
Эрхлэгч 2 20 12 08
Үнэт цаас гаргагч
Андеррайтер

сэргийлэхтэй холбогдсон харилцааг тусдаа журмаар зохицуулна. Уг журмыг ТУЗ батална.

7.20. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад санал өгөх эрхгүй байна.

7.21. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар гаргана.

7.22. Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжийг хангах үүрэгтэй.

7.23. Компани тухайн тайлангийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн дүнгийн талаарх мэдээллийг тухайн жилийн тайланд тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй.

НАЙМДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ

Үнэт цаас худалдах, эргүүлэн авах

8.1. Компани давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг зохих хууль журамд заасны дагуу гаргаж болно.

8.2. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

8.3. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болох бөгөөд харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас хэтэрч болохгүй.

8.4. Компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

Ногдол ашиг хуваарилан олгох

8.5. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заана.

8.6. Ижил төрлийн хувьцаа бүрийн хувьд нэгж хувьцааны ногдол ашгийн дүн нь хувьцаа бүрийн хувьд адил байна.

8.7. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

8.8. Төлөөлөн удирдах зөвлөл нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.

8.9. Компани нь хууль тогтоомжид заасан бүх нөхцөл биелэгдсэн тохиолдолд энгийн хувьцаанд хамаарах ногдол ашгийг хуваарилж болно.

8.10. Компани нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна. Энэ хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

8.11. Хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийг ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигч бүрээр түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

СЭХ
2022 .12. 15 өдөр
БҮРТГЭВ
2022-12-15

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭВ-02

эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.

8.12. Компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

8.13. ТУЗ нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана.

8.14. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах буюу бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.

8.15. ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, энэ дүрэмд нийцүүлэн Ногдол ашгийн бодлого батална.

Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан

8.16. Компанийн санхүүгийн жилийн эхлэх, дуусах хугацаа нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл байна.

8.17. Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн Гүйцэтгэх захирал хариуцна.

8.18. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан хамтран хариуцна.

8.19. ТУЗ нь компанийн санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.

8.20. Компани Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт, мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт тогтоосон хугацаанд нь хүргүүлж байх үүрэгтэй.

Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

8.21. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг "Компанийн тухай" хууль, энэ дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.

8.22. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуульд заасан журмаар татан буулгана.

8.22.1. Компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

8.22.2. ТУЗ нь компанийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхи зөвшөөрсөн;

8.22.3. Хуульд заасан бусад үндэслэлээр.

Дүрэм хүчин төгөлдөр болох

8.23. Энэхүү дүрэм нь компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

8.24. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа

БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 ☎ 2071096
УЛААНБААТАР ХОТ

000512

МХБ ХК-ийн архив
InvesCore CAPITAL
Эрхлэгч: 2
2022 он 12 сар 08 өдөр
6317839 ☎ 1122222198
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -12- 12
БҮРТГЭЛ

СЭХ
2022 .12. 15 өдөр
БҮРТГЭЛ

эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батлах бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлт нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

----------oOo----------

МОНГОЛЫН БИРЖ ТӨХК
MONGOLIAN STOCK EXCHANGE
9020020699 2071096
УЛААНБААТАР ХОТ

000513

"ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК" ХХК
InvesCore CAPITAL
МХБ ХК-ийн архив
ХУУЛБАРЛАЛЭН

Үнэт цаас гаргагч _____ Андеррайтер _____

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000171085

2018.06.08
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011741137
/ Хувийн хэргийн дугаар /

6317839
/ Регистрийн дугаар /

Инвескор капитал ҮЦК — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр	01	2018.06.07
/ шийдвэрийн нэр /	/ дугаар /	/ он, сар, өдөр /

6612 — Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

МОНГОЛ УЛС MONGOLIA 375

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

20221208 4567
Нийслэлийн төвгрийн нотариатч
Ю.Баярмагнай би энэ хуулбарын
үнэн зөвийг гэрчлэв.
Нотариатч .....

Хугацаагүй	1	1,300,000.0
/ хугацаа /	/ гишүүдийн тоо /	/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 2-р хороо, сөүл, Твин тауэр 1, 402 тоот, Утас1: 77090077, Утас2: 99906231, Факс.
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2018 он 10 сар 8 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Равжир овогтой Мөнхтөр-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.07.06	Э.Эрдэнэбилэг
2	Дахин гэрчилгээ олгов.	2018.10.08	Ж.Оюумаа
1	Улаанбаатар, Сүхбаатар, 2-р хороо, , сөүл, , гудамж Твин тауэр 1, 13-н давхар тоот, Утас1 77090077, Утас2 99906231, Факс хаягийг шинээр бүртгэв.	2018.10.08	Ж.Оюумаа
2	Гончигдорж овогтой Уянгахишиг -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2019.01.18	[illegible]
3	64990 Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2020.04.17	Д.Гангамарөн
4	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2020.08.27	Э.Мөнхзаяа
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 30000 мян.төг-р нэмэгдэж нийт 1330000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2021.12.21	Г.Батмөнх
11	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2021.12.21	Г.Батмөнх
